

# Лунтангийн Болормаа



Дашинзтай  
СУРВАЛЖЛАГУУД



# Даашинзтай сурвалжлагууд

Зохиогч Л.БОЛОРМАА

Эхийг бэлтгэсэн Р.Эрдэнэдэлгэр  
Зураг чимэглэлийг С.Төгс-Оюун

Эхийг «Өнөөдөр»  
сонины газарт бэлтгэв.

«Мөнхийн үсэг» компанид  
хэвлэв.

# ДААШИНЗТАЙ СУРВАЛЖЛАГУУД



2007 он  
Улаанбаатар хот

# I Хакуна матата

бүлэг



*Барагдахгүй урт замд  
аяны цүнхээ түшээд  
Бодол тээр холд надад  
гүйцэгдэхгүй яарна.*

*Манан зүсч миний зам  
арай ядан үзээгдсэн ч  
Нарыг хаанаас ч олохгүй, улам  
хүйтрэх шиг санагдана.*



ЭРХЛЭГЧ СУУЖ  
ХАРАГДАНА УУ


# II Эдийн засаг

бүлэг



# III Сэтгүүл зүй

бүлэг



Айлчлалын сурвалжлага гэдэг  
албаны хүмүүсийн ажлыг  
тайлагнадаг хөлдүү протокол биш  
билээ

# IV Улс төр

бүлэг

*Хөнгөн шаахайн цэмцгэр  
өгсгий товших тоолонд  
даашинз минь яагаад ч юм  
дэрвэнэ. Дэрвээгүй ч байж  
магад. Зүгээр л зүрх сэтгэл  
нэг тийм хонгор аялгуугаар  
дүүрч, би хурдан хурдан  
алхах ямар дуртай гэж  
санана. Болж өгвөл нэг хоёр  
алхааны хооронд гүйж ч  
мэднэ...*

# V Би

бүлэг





# Тэгээд юу гэж?

**Т**эгээд юу гэж? Энэ доогтой асуулт үзгээ шүүрэх бүрийд намайг ээрдэг. Ийм явдал болоо л биз, эсвэл тийм үзүүлэлт гараад ирсэн байж. Тэгээд юу болчихоо вэ? Хариулт эрсэн зуу зуун цифр, ишлэл, үйл явдал, нэрс, тэдний утас миний дэвтэрт хоцорчээ.

Эдгээр баримтыг би есөн жилийн хугацаанд цуглуулж, нимгэн дэвтрүүдээс минь шороо тоос, эмгэнэл, баяр, их үйл явдал, эгэл амьдрал үнэртэнэ. Тэр нэгэн явдлын цаана бүдэг бадаг ёлгойх учир шалтгаан, зөрчил, хандлагыг зөв ургуулахын тулд «Тэгээд юу гэж?» гэсэн асуулт өмнөө тавьж явна. Томоо цүнх үүрсэн сурвалжлагч болгоны толгойд ийм асуулт үргэлж эргэлддэг гэдэгт эргэлзэхгүй байна.

Хуучин, шинэ дэвтрийн хооронд он жил гялалзан одох цагийн эргэлтэд миний ижил сэтгүүлчид бичих зуураа боловсрол олж, өндийн дээшилж, үзэг нь хүчтэй болж буйг мэдэрч явна. Монголын сэтгүүлчдэд чөлөөт хэвлэлийн тухай дэлгэж харах ном, эргэж тунгаах туршлага байгаагүй. 1990 оноос нааш харван одсон 17 жилийн уртад Монголын сэтгүүлзүйг шинэ цагийн төрхөнд нь чиглүүлж зүгшрүүлсэн том цүнхт, хуруу нь эвэршсэн сурвалжлагчдыг хүндэтгэн мэхийе. Тэд мэдэхгүй чадахгүй, бэрх хэнцүү дундуур туучин байж шинэ цагийн сэтгүүлзүйн түүхийг эхлүүлжээ.

Тэд бичгийн машинаа компьютерээр солихдоо, хатуу залхаалт ноёлсон жагсаалын дэглэмээс задгай зах замбараагүй талбарт өв хөрөнгөгүй унахдаа өөрсдөө тархиа цэнэглэж, нийгмийн оюун бодлыг шинэчлэх давхар давхар ачааг үүрсэн. Тэдний эгнээнд би тун богинохон замд, ердөө есөн жил хөл нийлэн алхав. Бичихийнхээ зэрэгцээ юм юманд суралцах гэж амь тэмцсэн ерээд оны сурвалжлагчдын нэг билээ. Номын санд минь овоорсон тууш шугамтай

тэмдэглэлийн дэвтрүүдийн хуудаснаас шилжилтийн үеийг гэтэлж яваа шинэ монголчуудын алхаа хэмнэл үнэртдэг юм. Үг, ишлэл нь их түүхийн гэрч болон хоцорчээ. Тэгээд юу гэж хэмээх зовлонг асуултад хариулах гэж цагаан цаас ширтэн эхний өгүүлбэрээ эрэн шаналсан өдрүүдийг минь эргэн сануулдаг. Тэнд хоцорсон баримт бүр сэдэв болон ургаж «Өнөөдөр» сонины хуудаснаа үлджээ.

Сонины хуудас шарлаж арай л амжаагүй байна. Тийм болохоор бидний араас алхахаар суралцаж буй оюутнуудад заримыг нь хүргэе. Алдаж, оносон халуун мөрөөр минь яваа залуу чамд энэ ном бяцхан хөтөч болог. Богинохон хэдий ч эргэн харахуйц түүх, туршлага шинэ цагийн Монголын сэтгүүлзүйд хэдийнэ хуримтлагдсан. Эдүгээ өөр өөрийн өнгө төрхтэй нарийн жимүүд нэгдэн нийлсээр тодхон зам мөр гарчээ. Тэдгээр жимийн нэгээхэн нь энэ.

Миний бяцхан зам бусдынхаас юугаараа өөр билээ? Эрхэм Ерөнхийлөгч өө, Монголын өдөр тутмын сонин... Ингэж асуулгаа эхлэх их хүсэл нийтлэл, сурвалжлага, ярилцлага бүрт минь бий. Монголын сэтгүүлчид дэлхийн хэмжээнд сэтгэж, бусдын энд хүрч ажиллах цагийг наашлуулахсан. Тулгаа тойрч гүйхээс цааш түмэн үйл явдлын учир шалтгааныг ухан, тэгээд юу гэж хэмээсэн уншигчийн хорон асуултад бардам хариулж чадахсан. Харь орны ерөнхийлөгчид ч халуун асуулт тавьж чадах Монголын мэргэжлийн сэтгүүлчид ар араасаа олноороо төрөөсэй. Би яарч байна. Мэдэхгүй чадахгүйн зовлон намайг элдэн хөөнө. Уншигчаасаа хоцрохгүйн тулд намхан улт хөнгөн шаахай өмсөөд, том цүнхээ үүрээд гүйж л явна.

# I Хакуна матата I

---

## бүлэг

Барагдахгүй урт замд аяны  
цүнхээ түшээд  
Бодол тээр холд надад  
гүйцэгдэхгүй яарна.

Манан зүсч миний зам арай  
ядан үзэгдсэн ч  
Нарыг хаанаас ч олохгүй,  
улам хүйтрэх шиг санагдана.

/Grand Forks, 2002/



# «Эрхэм Ерөнхийлөгчөө, Монголын өдөр тутмын сонин...»

Шинэ зууны эхэнд дэлхийн удирдагчид нэг дор цугласан юм. Тэр өглөөний үүр хаяарахыг олон сэтгүүлч хүлээж, Нью-Йоркийн Зүүн эргийн 42-р гудамжинд даарч зогсов. Ерөнцийн ерөнхийлөгч нар цугаараа цуглах тул лав 7.00 цаг гэхэд НҮБ-ын Төв байранд сэтгүүлчид байраа эзэлсэн байх учиртай. Өмнө нь камер хэрэгсэл, цүнх хувцсаа хянуулж шалгуулах учир урт дараалалд эртлэн зогсоцгоов.

Бруклин гүүрний бараа бүдэгхэн харагдаж, Ийст голын ус, Нью-Йоркийн тэнгэр хоёр ялгалгүй бараантана. Том том аппарат хэрэгслээ операторууд хямгадаж, түмэн халаастай хантаазныхаа «тасалгаа» болгоныг нэгжин, бүх зүйл жин тан эсэхийг шалгах аж. Ялимгүй ягаан туяа татах шиг санагдав. Эрхбиш үүр хаяарч, шинэ өглөө гэтэн иржээ. НҮБ-ын Төв байрны төмөр хашлаганы зүүн хэсэг рүү харсан өнцөгт сэтгүүлчдийг шалган нэвтрүүлэх цэг байрлуулсан байна.

Дэлхийн түүхэнд үлдэх уулзалт удахгүй энд эхэлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч Grand Plaza хэмээх буудалд байрласан. Тун үнэтэй зочид буудал гэж сонссон.

**-Хоногт ямар үнэтэй байдаг юм бол?** гэж би сониучилсан юм.

НҮБ дахь Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан «Сайн буудал» гэхээс өөр зүйл хэлж өгөх шинжгүй.

2000 оны есдүгээр сарын 6-ны өглөө ядарч даарсан сэтгүүлчдийн цуваанд багтаж түүхэн үйл явдлын хажууд байсандаа баярладаг. Зүгээр л тун азтай тохиолдол болсон. НҮБ-ын шугамаар зохион байгуулдаг тусгай хөтөлбөрийн шалгаруулалтад тэнцсэн тул онцгой өдрүүдэд тэнд байсан билээ. Дэлхийн дийлэнх улсаас сонин, радио, телевиз, агентлагийн сурвалжлагчид нь очсон. Харин Монголоос олон улсын томоохон үйл явдлыг очиж сурвалжилдаг туршлага огт дэлгэрээгүй үе. Төрийн өндөрлөгүүд айлчлалаар мордохдоо цөөн сэтгүүлч дагуулдаг. Түүнийг нь олзуурхан «гадаад томилт» хэмээн нэрлэж асан цаг.

Ерөнхийлөгч Н.Багабандиас би есдүгээр сарын 8-ны өдөр ярилцлага авалгүй зугтаж орхив. Ж.Энхсайхан гуай дараа нь «Чи мөн муухай хүн ээ» гэж билээ. Мянганы хүндэт чуулганд оролцож буй Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тэнд байж таарсан ганц сурвалжлагчийн хувьд ярилцлага авах завшаан олгож, цаг товловсон хэрэг. Гэтэл ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путиний хэвлэлийн хурлын цаг давхцаад, тийшээ явах хорхой гозолзоод яаж ч чадаагүй. Тэр өдөр яг юу бодож байснаа хэлье. «Ерөнхийлөгч Багабандиас ярилцлага авах өөр боломж гарна шүү дээ. Харин Мянганы чуулганы индрээс нэлээд сенсаац бүхий үг хэлснийхээ дараа В.Путин хэвлэлийн хурал зарлажээ. Ийм хуралд суух боломж бол ганц удаа таарч байна». Ингээд би НҮБ-ын Төв байрны Conference room-2 танхимд ирлээ. Орос, Чечений асуудал хурцадсан үе. Америкийн цагдаа нар хэвлэлийн хурал хийх өрөөг шалгаад л байдаг. Үүдэнд нь олон сэтгүүлч бие биеэсээ өрсөж сайн байрлал эзлэх гээд тэмүүлнэ. Оросын телевизийн танил логонууд ч харагдана.

В.Путин хэдхэн алхмын зайд явж өнгөрөв. Түүний бодлогоширсон нүдийг эгцэлж харахдаа, асуулт тавихыг оролдоно шүү гэж шийдсэн билээ. Тэр яасан намуухан ярьдаг юм бэ? Хажууд суусан франц хүүхэн хамраа арчаад л дуу

шуутай гэгч шуухитнах юм. Өглөө даарчихсан юм байлгүй. Оросууд голдуу асуулт тавьсаар. Нөгөө франц хамраа ухсан чигээрээ яаж ийгээд бас асууж амжив. Асуулт хариултыг ингэсгээд таслах шинжтэй. Надад хүрд эргүүлэх боломж олдохгүй нь ээ. «Монголын өдөр тутмын сонин. Ноён Ерөнхийлөгч өө...» би асуултаа амандаа давтаад л амьсгаа давхцаад суув. Манай цөмийн зэвсэггүй статусын ач холбогдлыг Орос улс юу гэж үнэлж байгааг нь асууя... Зүрх түг, түг гээд л, хөөрхий амьтан.

Надад гайхалтай сайхан байсан. Тэр уур амьсгалыг үнэртэх гэж хэчнээн яарч тэмүүлсэн гэж санана. Хэвлэлийн хурал дуусч орхив. Энэ удаа асууж чадсангүй. Гэхдээ юу гэж?! Гадаадын сэтгүүлчидтэй эн зэрэгцэн Монголын хэвлэлийнхэн ажиллах цаг ирсэн. Дараагийн удаа Путинээс ч, Кофи Аннанаас ч, Америкийн Ерөнхийлөгчөөс ч асуух л болно. «Эрхэм Ерөнхийлөгч өө, Монголын өдөр тутмын сонин...» гэж эхэлнэ дээ.

Тэр өдрүүдэд олон сайн материал бичиж чадаагүй л дээ. Гэхдээ 12 цагийн зөрүүг ойртуулах гэж, ядахдаа ганц өдрийн хойно Нью-Йоркоос монгол сэтгүүлчийн тэмдэглэсэн товчхон ч атугай сурвалжлага явуулах гэж яарч бачимдсан. Мянганы чуулганыг сурвалжилж чадах эсэхийг Ерөнхий эрхлэгч маань ч, би өөрөө ч сайн мэдээгүй байсан шүү дээ. Редакц интернэтэд холбогддог ганцхан компьютертэй, электрон шуудангаар харилцдаг цөөхөн сэтгүүлчтэй үе байлаа. Үүнийг мэдээллийн технологийн дэвшил эргэлтгүй нэвтэрсэн өнөөдөр ойлгоход хэцүү. Эргэж ирсний дараа Ерөнхий эрхлэгч «Чиний сурвалжлагыг байрлуулахдаа бид алдсан байж магадгүй» гэсэн юм. Сонины хоёрдугаар нүүрт ч атугай амжиж хэвлэгдсэнд нь л би олзуурхаж баярлаж явсан. Дугаарын гол материалыг эхний нүүрнээс нүднээ ил эхлүүлдэг өнөөдрийн энгийн туршлага болсон тэр аргыг долоон жилийн өмнө сонинууд ер хэрэглэдэггүй байлаа.

НҮБ-ын тусгай хөтөлбөрт орон орноос оролцсон 12 сэтгүүлчийн хэн нь ч тэр өдрүүдэд сурвалжлага хийх гэж над шиг аахилсангүй. Тэдний нутгаас телевиз, радио, сониныхон Нью-Йоркод хангалттай ирсэн гэнэ. Монгол! Хаа холын хөөрхий эх орон минь. Яасан даржин юм. Гэхдээ бас яахав ээ. Хөгжлийн хурдыг чадан ядан гүйцэх цаг айсуй.

2000.09.08

# Б.Клинтон «Би л нэг...» гэсэн шиг орж ирлээ

Таван цаг өнгөрсөн хэдий ч Нью-Йоркт гэгээ орох яагаа ч үгүй. Сэтгүүлчид үүр цайхаас эхлээд НҮБ-ын байрны баруун хаалганы орчим дугаарлалаа. Зургаан цаг өнгөрөхөд тэд сая нэг нэвтрэв. 2000 оны есдүгээр сарын 6-ны өглөөний долоон цагийн дохио дуугарахын алдад Мянганы чуулганд оролцох төрийн тэргүүнүүдийн түрүүч НҮБ-ын төв хаалгаар орж эхэллээ.

Долоон цаг гучин минутад Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди гэргийн хамт хүрэлцэн ирэв. Түүнийг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун дагалджээ. Төлөөлөгчид 20 метр орчим зайд зогсох сэтгүүлчдийн «сүргийн» өмнүүр явж өнгөрөөд урсах шатаар нэг давхар хэртэй дээш өгслөө. Н.Багабанди орж ирүүт сэтгүүлчдийн зүг хяламхийсэнчгүй, харин өргөгч шатаар аажим өгсөх зуураа сая л нэг «Юу вэ» гэсэн шиг эргэж харав. Бөөн камер сэлтийн дунд монгол сэтгүүлч байгаа тухайд түүний санаанд багтаагүй биз ээ. Найман цаг дөхүүлээд Израилийн Ерөнхий сайд Э.Баракийн бараа үзэгдлээ. НҮБ-ын ажилтнууд төлөөлөгчдийг үүдэнд угтан тосох аж. Ерөнхийлөгчид энд бие хамгаалагчгүй явж байна. Зарим нь гэргийгээ дагуулжээ.

Удсангүй Японы Ерөнхий сайд, түүний араас шил даган А.Лукашенко, Н.Назарбаев, Э.Шевардназе нар өнгөрлөө.

Орон орны сэтгүүлчид энд хагас метр хүрэхгүй жаахан талбайг тус бүрдээ өмчилж, түлхэлдэн, аятай байрлал булаацалдаж зогсов. «Кастро, Кастро» хэмээн Латин Америкийн сэтгүүлчид гэнэт сүйд боллоо. Ф.Кастро сэтгүүлчдийн өмнүүр ихэмсэг гэгч нь явж өнгөрөв.



Америкийн цагдаа нар ажлаа өөгүй гүйцэтгэж байна. Дээд хэмжээний төлөөлөгчдийг «ялгаж салган», хэн нь ямар шатаар өгсөх учиртайг ширүүхэн зааж, тайлбар тавибал сонсох янзгүй. Дипломатууд Ерөнхийлөгчийнхөө араас зүтгэцгээж цухалдах боловч цагдаа нар «Би ажлаа хийж байна шүү» гэсэн шиг замыг нь хөндөлдөөд зогсчих аж. Урсдаг шатны дээхнэ К.Аннан өөрийн ажлаа гүйцэтгэж байна. Тэр бүх төлөөлөгчийг хүндэтгэлтэй угтаж авах «зовлонтой» үүрэгтэй. Түүний гэргий шаргал үстэй, сайхан эмэгтэй нөхрөөсөө ялимгүй өндөр юм. Швед бүсгүй гэнэ. Цав цагаан хослолоор гоёж, ийм өнгийн ээмэг, зүүлтээр чимжээ. Ер нь энд ирж буй тэргүүн хатагтай нарын хувцас нь өөр өөрийнхөөрөө содон. Зарим нь гацуур мод шиг л гоёчихсон, тун хичээж биеэ барин яваа нь илт бол нөгөө нь даруу төлөв костюм сонгожээ. Манай тэргүүн хатагтай А.Оюунбилэг цэв цэнхэр хослолдоо цагаан цүнхээр өнгө нэмэн тодруулсан харагдав. Төрийн тэргүүн нөхрөөсөө бараг тохой хэрийн өндөр хатагтай нар ч байх юм. Тэр болгонд сэтгүүлчид хоорондоо доогтой үг хаялцан жуумалзацгаана. «Энэ хэн гэгч вэ» хэмээн өөр зуураа асууцгааж, «Авгай нь юу өмсчихөө вэ» гэх зэргээр хамаа намаагүй ярьж зогсов. Удирдагчид сэтгүүлчидтэй янз янзаар харилцах аж. Нэг хэсэг нь учиргүй гар даллан, арзайсан камеруудын өмнө хором зогсосхийж, популист болохоо нотлоод өнгөрч байна. Мөн ихэмсгээр толгой дохиод, эсвэл бүр хяламхийчгүй чигээрээ алхаад өнгөрөх нь ч олон.

Найман цаг гучин минутад Я.Арафат орж ирэв. Түүнээс 15 минутын хойно, өөрийг нь угтсан болгонтой удаан гэгч ярьж, аажим алхсаар Б.Клинтон орж ирлээ. Хэвлэлийнхэн сүйд болж, зарим нь «Клинтон, Клинтон» хэмээн хашгирч хөөрөв. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайт түүнийг дагалджээ. Бариу хар банзал өмсч, буржгар үсээ сул тавьсан Челси аавыгаа дагаж явна. Б.Клинтон НҮБ-ын Төв байранд охинтойгоо эгээ л зугаалж яваа мэт, манайхны хэлдгээр бол «Би л нэг» гэсэн шиг харагдав. Германы канцлер, БНХАУ-ын дарга нар цөөн минутын зайтай цуварлаа. Есөн цагт найман минут дутуу байхад В.Путиний хөлөглөсөн лимузин НҮБ-ын байрны довжоонд тулж зогсов. Тэр пиджакаа өмсөнгөө гарч ирж харагдана. Сэтгүүлчдийн зүг ичимхий харцаар дохиж мэндлээд, эскалатраар бус ердийн шатаар гүйх шахам гараад явчих нь тэр. Ийнхүү Тони Блэйрээс бусад нь цагтаа цуглаж, Ерөнхий Ассамблейн танхимыг зүглэсэн юм.

Мянганы чуулганы индрээс эхний үгийг АНУ-ын Ерөнхийлөгч хэллээ. Арван цаг гучин минутад В.Путин үгээ эхэлж, цөмийн хаягдлыг устгах асуудлыг онцлон хөндсөн нь анхаарал татав. Энэ асуудлаар Орос улс Олон улсын атомын эрчим хүчний агентлагтай хамтран төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажээ. Мөн сансрын уудмыг энх тайвны зорилгоор ашиглахын чухлыг тэрбээр дурдаад, сансарт хүн төрөлхтөн анх хөл тавих шан татсан Орос улсын нийслэлд уг сэдвээр өргөн хүрээтэй яриа өрнүүлэхийг уриаллаа. Дэлхий дахинаа терроризмтэй хамтран тэмцэх асуудлыг ч мөн хөндөв. Эцэст нь, ОХУ эрх тэгш хамтын ажиллагаанд бэлэн буйг нотолсон юм.

Ерөнхий Ассамблейн танхимд Монгол Улсын Ерөнхийлөгч байраа эзэлж, түүний баруун гар талд Гадаад хэргийн сайд болон НҮБ дэх Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан нар суужээ. Мянганы чуулганы үдээс өмнөх хуралдаанд нийт 33 төлөөлөгч үг хэлэв. Тэд гол төлөв уриа лоозон маягийн ерөнхий зүйл ярьцгааж, хааяа нэгхэн содон санал санаачилга сонсогдох аж. Нэг бодоход уйтгартай гэмээр энэ чуулганы завсарлагаар ээлжлэн зохиогдох хэвлэлийн бага хурал л сэтгүүлчдийн анхаарлыг татаж байна. Хуваарь ёсоор бол Тони Блэйр лхагвад, В.Путин пүрэв гаригт тус тус хэвлэлийн хурал хийлгэнэ. Үүнээс гадна, чуулганы төгсгөлд нийтээрээ үзэглэх баримт бичиг нь улирч буй мянганы түүхийг хүндэтгэн хаах, ирэх цаг үед бүгдээрээ хамтран асуудлаа шийдэж магадгүй нь гэсэн найдлага төрүүлэх түүхэн үйл явдал болох юм.

**2000.09.06**

# Ядуус Мянганы чуулганаас юу хүлээж байна вэ?

Зүүн эргийн гудамжны дагуу үдэш болтол цагаан хоолой тасралтгүй цангинав. Шар өнгийн ижилхэн цамц өмссөн Хятад иргэд, мөн саарал хувцастай, Тайванийн тусгаар тогтнолыг дэмжигчид тус тусдаа бүлэг болоод гудамжны хоёр талаас дуу нийлүүлэн хашгирч байна. Түүнчлэн өлбөрч буй бяцхан хүүхдүүдийн зураг өмнөө бариад Африк гаралтай иргэд бөөгнөрөн зогсжээ. Дэлхийн 150 гаруй орны төр, засгийн тэргүүн хуралдаж буй НҮБ-ын байрны өмнө иймэрхүү үйл явдал болж байна. Гудамжинд цугларагсад ертөнцийн янз бүрийн хэсэг дэх ард иргэдийн хоорондох үл ойлголцлыг арилгах, өлсгөлөн ядуурлыг багасгах чиглэлээр дорвитой ажил хийхийг удирдагчдаас шаардаж, чадлаараа хашгирч буй нь энэ.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан ч гэсэн, ийм олон Ерөнхийлөгч анх удаа нэг дор цугласныг «ашиглан» нэлээд баримт бичигт гарын үсэг зуруулж авахыг хичээж буй юм. 2015 он гэхэд ядуурлын өнөөгийн түвшинг хоёр дахин бууруулахын тулд бүгдээрээ үүрэг амлалт авах ёстой гэж К.Аннан үзэж байна. Мөн бага ангийн боловсролыг бүх хүн ижил нөхцөлд хүртэх учиртай гэсэн санааг дэвшүүлэв. Ингэснээр хүний ядуурал гэсэн ойлголт бага ч атугай хумигдана гэж найджээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабанди НҮБ-ын индрээс ойрын арван жилд дэлхий нийтээрээ бичиг үсэгтэн болох ажлыг өрнүүлэхийг уриалсан нь К.Аннаны саналд дэмжлэг өгсөн тодорхой санаачилга болов.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын ширээн дээр шийдлээ хүлээсэн 500 гаруй хэлцэл тохиролцооны төсөл бий. Эндээс гол 25-ыг нь дэлхийн удирдагчид үзэглээсэй гэж тэрбээр чармайж байна. Эрүүгийн гэмт хэргийн олон улсын шүүхийн статус, газрын минийг бүрэн хориглох болон дэлхийн цаг агаарын өөрчлөлттэй холбоотой зэрэг чухал асуудал эдний дунд бий.

**2000.09.08**



# В.ПУТИН: Оросын улс төрийн ТОМООХОН ХҮЧНҮҮД ЗӨВШИЛЦӨЛД ХҮРЧ ЧАДСАН

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин пүрэв гаригийн үдэш НҮБ-ын Төв байранд хэвлэлийн бага хурал зарлалаа. Мэдээлэл хийхээс нь хагас цагийн өмнө сэтгүүлчдийг хурлын танхимаас гарахыг хүсэв. Америкийн аюулаас хамгаалахын ажилтнууд том гэгч хоёр нохой дагуулсаар В.Путиний мэдээлэл хийх ёстой танхимд ороод явчихав. Хар, шар зүсмийн ноход өрөөний булан тохой, ширээ сандал болгоныг үнэрлэн, тээсэрч дэлбэрэх зүйл байгаа эсэхийг тандаж байгаа бололтой. Хэдхэн минутын өмнө энд Венесуэлийн Ерөнхийлөгч хэвлэлийнхэнтэй уулзах үеэр ийм арга хэмжээ аваагүй билээ. Харин Венесуэлийн удирдагчид дөхүүлж өгсөн кофег бие хамгаалагч нь буцааж буй харагдсан.

***В.Путин хэвлэлийн хурлынхаа эхэнд оршил болгож Мянганы чуулганы ач холбогдлыг тодруулан ярилаа.***

-Манай үеийнхэнд өнгөрч буй зууныг дүгнэн хэлэлцэх сайхан боломж тохиож байна. Мөн цаашид НҮБ-ын нэр хүндийг улам өндөрт гаргаж, үйл ажиллагааг нь үр дүнтэй болгох асуудал тулгарч байна. Орос улс ирэх оны хавар буюу сансарт хүн ниссэний түүхэн ойтой давхцуулж сансрын уудмыг энхтайвны зорилгоор ашиглах асуудлаар Москвад хуралдахыг санал болгосон билээ. Энэ саналыг маань хүлээн авч НҮБ-ын ивээл дор уг арга хэмжээг зохион байгуулахаар боллоо гэж мэдэгдэв.Түүнийг ялимгүй содон хөдөлгөөн хийх бэрийд тоймгүй олон аппарат шажигнан, хурц гэрэл гялсхийж байв.

**-Аюулгүйн зөвлөлийг илүү ардчилах, түүнд өөрчлөлт хийх асуудлыг Та хэрхэн харж байна вэ? гэсэн Японы «Асахи» сонины асуултад тэрбээр,**

-НҮБ-ын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоход түүний Аюулгүйн зөвлөлийн ажил онцгой үүрэгтэй. Тус зөвлөлд өөрчлөлт хийх шаардлага бий. Энэ чиглэлээр тухайлбал Япон улс их зүйл хийж чадна. ОХУ, Японы гишүүнчлэлийн асуудалд эерэг байр суурьтай байна. Гэхдээ бүтцийг яаран эвдэх нь гол ажил биш гэсэн хариулт өглөө.

**-Хятад, Япон болон хоёр Солонгост эрчим хүчний эх үүсвэр бий болгохоор Орос улс тэдэнтэй хамтран том төслүүд хэрэгжүүлэх гэж байна. Гэтэл эдгээр төслийн ашиг тус нь оролцогч орнуудад ялгаатай тусахаар байна шүү дээ. БНСУ-ын хувьд гэхэд илүү онцгой, ашигтай хувилбар байгааг Та юу гэж тайлбарлах вэ?**

-Зүүн хойд Азийн эдгээр улсад эрчим хүчний найдвартай эх үүсвэр шаардлагатай байгаа.Бидний хамтран хэрэгжүүлж буй төслүүдээс хэн нэг нь илүү хожно гэж үзэхгүй байна.Хэрэв аль нэг нь ахиу ашиг олохоор байсан бол төслийн тийм нөхцөлийг хэн ч хүлээн зөвшөөрөхгүй шүү дээ.Би Мянганы дээд хэмжээний уулзалтад ирэхээсээ өмнө Япон улсад айлчилсан.Тэд ийм чиглэлийн төслийг ихээхэн сонирхсоор байна.

**-Б.Березовский сэтгүүлчдэд хувьцаа өгч буйг Та юу гэж үзэж байна?**

-Сэтгүүлчид болон зарим уран бүтээлчид Б.Березовский өөрийн хувьцаанаас өгч буйг сайшаахаас өөр юу гэхэв.Гэхдээ тэдгээр нь бие даасан хүмүүс байгаа тохиолдолд шүү дээ.Хэрэв Б.Березовский өөрийн мэдлийн хүмүүстээ өгч байгаа бол хувьцааны эзний хувьд чанарын ялгаагүй асуудал.Ер нь тэр яг хэнд , ямар нөхцөл,болзолтойгоор хувьцаа тарааж байгааг би сайн мэдэхгүй байна.

**-Курск хөлгийн ослын асуудлаар Б.Клинтон өөрт тань шинэ мэдээлэл өгсөн гэж Нью-Йорк таймс сонины өнөөдрийн дугаарт /2000 оны есдүгээр сарын 7/ бичжээ.Та түүнээс ямар мэдээлэл авсан юм бэ?**

-Курск хөлөг сүйрэх үед тэр районд хийсэн техникийн ажиглалтын талаар зарим мэдээллийг манайд зохих шугамаар нь АНУ-ын тал өгсөн.Ослын шалтгааныг тодруулах явцад иймэрхүү олон мэдээллийг ашиглаж байна.

**- Ноён Ерөнхийлөгч өө, Та ард түмэндээ хайртай.Тэгвэл тэдний амьдралыг яаж дээшлүүлэх вэ? Орос улсын эдийн засгийг хэрхэн сайжруулах вэ?**

-Манай эдийн засагт бэрхшээл байгааг үгүйсгэхгүй.Гэхдээ ОХУ-ын эдийн засаг хөгжингүй орнуудынхаас онцгой ялгарахгүй.Гагцхүү эдийн засгийн үйл явцыг хууль эрх зүйн хүрээнд зохицуулах шаардлага байгаа бөгөөд энэ талаар бага ч гэсэн үр дүн гарсаар байна.Манай эдийн засгийн өсөлт долоон хувьд хүрлээ.Төв банк дахь валютын нөөц өнгөрсөн оныхоос хоёр дахин нэмэгдэв.Инфляц буурч байна.Цаашид бидэнд хийх ажил их бий. Харин яг одоо бидний олж авсан хамгийн гол үр дүн гэвэл, яахав эдийн засгийн сэдэв биш байж болно л доо,гэхдээ Оросын улс төрийн томоохон хүчнүүд тодорхой зөвшилцөлд хүрч чадсан явдал. Уг зөвшилцөлд тулгуурлан эдийн засгийн амьдралыг зохицуулах гол хуулиудыг баталж чадлаа гэв.

Үүгээр асуултаа өндөрлөхийг В.Путиний баруун гар талд суусан түшмэл сануулав.ОХУ-ын Ерөнхийлөгч НҮБ-ын байрны нэгдүгээр давхрын хонгилоор өөрт нь хандсан хүмүүсийн асуултад үргэлжлүүлэн хариулсаар гарч одлоо.

**2000.09.07**

# Филипп Киркоров Лос Анжелест «ХИЙ ҮЗЭГДЭЛ» БОЛЖЭЭ

Бродвейн гудамжны хөл хөдөлгөөн улам нэмэгдлээ. Наранд шарах боломж хумигдах тусам нью-йоркчууд Бродвейг зорьж элдэв шоунд оролцох болов. Харин жуулчид, зочдын хувьд зүгээр л нүд хужирлах гэж үүгээр зугаалах нь элбэг. Эндхийн театруудын намрын тоглолтын улирал саяхан эхэллээ. «Magestic» театрын хөтөлбөрийн тэргүүнд «Дуурийн хий үзэгдэл» дуулалт жүжиг бичигджээ. Театрын тасалбар нь 90 ам.долларын үнэтэй. 20.00 цагийн харанга дэлдэв үү үгүй юу суудлууд цөөн хоромд дүүрэв. Захын суудалд тухалбал арай хямд, 70 ам.доллар төлнө. Үзэгчид үл тасрах энэ театрт зогсох талбайг хүртэл худалддаг. 20 ам.доллар төлбөл хоёр цаг шахам зогсоогоороо тоглолтыг сонирхож болно. Тэглээ гээд ядарч, жүжиг дундуур гарахыг завдсан хүн харагдаагүй. «Дуурийн хий үзэгдэл» дуулалт жүжгийн турш үзэгчид догдолж, сандарч, бас бахдан дуу алдсаар өнгөрөв.

Хэрэв Филипп Киркоровын Лос Анжелест хийсэн тоглолтын бичлэгийг санаж буй бол энэ дуурийн гол аялгуунууд Танд танил гэсэн үг. Үйл явдал бол тун товчхон. Дуурийн театрт хий үзэгдэл шүгэлчхжээ. Хий үзэгдэл Кристинатай яриад эхэлнэ. Кристина бол хосгүй хоолойтой төдийгүй гоё сайхан эмэгтэй. Тэр мөн эндхийн дуучин залуу Раулд хайртай. Тийм болохоор өөрийг нь эргүүлж эхэлсэн хий үзэгдлийн зовлонтой дурлалаас зугтахын хамт бас түүнийг өрөвдөж, элдэв бэрхшээл дундуур явсаар. Хий үзэгдэл Кристинаг өөрийнхөө таг харанхуй ертөнц өөд хөтлөх агшинд Филипп Киркоровын дуулдаг тэр танил аялгуу танхим дүүрэн нүргэлэж аж. Зүрх эгшин зуур шимшрэн

догдолж юу болов оо гэмээр сэтгэл хөдөллөө. Энэ ая дуурсах зуур тайз гайхамшигтай хувирав. Битүү манан. Тээр доор Кристинагийн ертөнц, бодит амьдрал хоцорчээ. Тэр хий үзэгдэлтэй цуг ертөнцийн дээгүүр завиар хөвж явна. Хий үзэгдэл нь цав цагаан багтай юм. Кристина санамсаргүй багийг нь авчихав. Аймшгийн кинонд гардгаас сүрдмээр царай зүс гараад ирнэ. Харин бүсгүй нь үзэсгэлэн төгс юм.

Эсрэг тэсрэг, халуун дурлал, жигшин зугтмаар дүр төрх ээлжлэн солигдсоор.

Кристинад жүжиглэсэн Сара Пфистер нь Америкийн 20 гаруй хотод уг дуурийг амилуулжээ. Сүрдэн дуу алдмаар үзэгдэл олон давтагдах хэдий ч энэ дуурь сайн төгсгөлтэй. Цөхөрсөн хий үзэгдэл дууны сайханд дурласнаа ойлгож, Кристинаг Раулд нь эргүүлж өгнө.

Цав цагаан багаа орхиод тээр хол, бүр тэнгэрлэг өөд хий үзэгдэл явж одов. Тэгээд бүх зүйл байр байрандаа ирж, гэхдээ нэг л чимээгүй оргино. Үзэгчид алтаг ташсангүй, хормын төдийд алмайрсан байлаа. Америкчууд театрт ирэхдээ энгийн хувцасладаг аж. Мөн тайз өөд цэцэг сэлт шидэхгүй. Алга ташилт, уухай, хүндэтгэх ёслол цөөн минут үргэлжилнэ. «Magestic» театрт маргааш «Ховорхон залуу Горе Видах» хэмээх дуулалт жүжиг тоглох юм байна. Бродвей гудамжны үдшийн хэмнэлд би дахин ууслаа. Өнгө гэрэл, дуу шуугиан, үй оlnы



урсгал, театрт зочилсон баячуудын нүд гялбам машинууд, хэнийг ч юм бэ хүлээн шавааралдах хөөрсөн үзэгчид, нарийн бүрээ уянгалуулан харцаараа халаас гар эргүүлдэх гудамжны эр, аппарат зүүж газрын зураг сугавчилсан жуулчид... «Доллар гэхгүй, цөөхөн ч атугай цент өгчих» гэж хатуу цаасан дээр палхийтэл бичээд хажуудаа тавьсан ядуус байсгээд л тааралдана. Алгаа хүлцэнгүй тоссонгүй, бараг их зантай юм гээч, эдний гуйлгачид.

Харин Бродвей шувтрав уу үгүй юу чимээгүй, дүнсгэр гудамж угтана. Нью-Йоркийн ажил хэрэгч хэсэгт бол хэдийнэ шөнө дунд болжээ.

**2000.09.09**

# Есдүгээр сарын 11

Өмнөх үдэш нь телевизээ асааж амжаагүй гэж үү? Тийм л явдал болсон доо. Заримдаа чи өдөржин дуу шуугиантай өрсөн хашгирч, гомдол, санал, сенсац, хэрүүл, сэтгэлийн хөдөлгөөн дунд арван хэдэн цагийг туулна. Тийм нэг үдэш телевизээ асаах чадал дутсан ч юм уу. Гэтэл...


Тэгтэл маргааш нь, 2001 оны есдүгээр сарын 12-ны өглөө хорвоо ертөнцийн амьдрал орвонгоороо эргэсэн мэт утглаа.

9.00 цагт редакцид орж ирэв. Батбаатар эрхлэгчийн ширээний орчим сонин дэлгээд нөгөө хэд маань нэг л хачин царайтай. Юу болоо вэ? Тэд надад «Өдрийн сонин» харуулав. Нью-Йорк, Вашингтоныг довтолж, Америк халдлагад өртлөө гэжээ. Харин «Өнөөдөр» сонины 2001 оны есдүгээр сарын 12-ны өглөөний дугаарт ёжилж тохуурхсан мэт «Хоёр өндрийн» зургийг тавиад, цагаачлалын ногоон картын тухай мэдээллийг эхний нүүртээ нийтэлж орхижээ. Яг өөд болоочийг доромжилсон мэт сэтгэгдэл ёгхийв. Утас шүүрэн компьютерийн инженерийнхээ гэр лүү залгалаа. Тэр ажилдаа аажуухан ирдэг боловч онцгой энэ өглөө «Хүрээд ирээч» гэсэн хоёрхон үгийг маань дахин тайлбарлуулсангүй. Үйл явдлын тухай гол мэдээллийг интернэтээс олж авах болохоор хамгийн түрүүнд толгойд орсон ажил маань тэр байх.

«Инженер интернэтийг холбоно. Дараа нь... Интернэтийг Одбаяр эхлээд холбоно. Дараа нь...» Мэргэжлийн уучлашгүй алдаа хийсний дараа толгойд механикаар тийм л бодол орж ирээд байв. Есдүгээр сарын 12-ны дугаар «Өнөөдөр» сонины уучлашгүй алдаа болон сэтгүүлзүйн түүхэнд үлджээ. Утас дуугарч, дургүйцсэн уншигч бачимдан ярьж байна. «Би танай сониныг дахин захиалахгүй» Эхнийх нь! Чихэнд хангинах орилоо тэр дууг би тэсэлгүй тасалж орхив. Уучлалт гуйгаад нэмэр болохгүй. 9.00 цаг нэлээн хэвийлээ. Ерөнхий эрхлэгчийн хөлийн чимээ тод сонсогдов. Өглөөний шуурхайгаа хийдэг зуйван ширээний ард бид бүгдээрээ дассан суудалтай. Ард минь Ерөнхий эрхлэгчийн товор товор алхаа ойртлоо. Редакц өглөө бүр энэ алхаан дор ажил хэрэгт бэлтгэж, бал, дэвтрээ эрэн, анхаарал төвлөрүүлж эхэлдэг. Бүгд түүний юу гэхийг энэ өглөө амьсгаа даран хүлээлээ. Тэр ядрангуй царайтай харагдав. Шөнө нь унтаагүй ч байж магад хэмээн дараа нь бодогдсон. Хүү нь Вашингтонд сурдаг гэж сонссон юм.

Хагас өдрийн уртаар алслагдсан ертөнцийн баруун хагаст, «Өнөөдөр» сонины шинэхэн дугаар хэдийнэ хэвлэгдэж эхэлсэн мөчид «Хоёр өндөр» үгүй болж, Пентагон уугисан утаанд автжээ. Интернэтийн холболтыг инженер нь ирж байж хийдэг ертөнцийн зүүн хэсгийн алслагдсан энэ нутагт бид тэр өглөө террорист бүлгийн гишүүн байсан юм шиг л өөрсдөөсөө ичиж гэмшин, алгаа улайтал балаа атган суух нь гунигтай.

Есдүгээр сарын 13-ны дугаарыг бэлтгэх төлөвлөгөөндөө орлоо. Интернэтээс гадаад мэдээ орчуулдаг ганц сурвалжлагч маань эмнэлэгт хэвтсэн. CNN-ийн мэдээллийг ойлгож чадах англи хэлтэй хүн бидний дунд хэд билээ? Монголын сэтгүүлзүйн өөр нэг эмгэнэл энэ. Улаанбаатарын хөндийд хаана, юу болов, хов жив юу байна, бүгдэд хутгалдаж, хутгаж дөнгөнө. Түүнээс цааш өнгийх чадал боломж, хүсэл хомс хэвээр. Гэвч хүсэлтэй хүмүүс цөөн ч атугай байдаг нь яамай. Даваадорж ангиар ойлгоно. Рэнчинханд ах орос хэлтэй. Цацрал, Сумъяабазар хоёрыг нь гуйна гэдгээ UB Post -ийн эрхлэгчид хэллээ. «Таван цагариг»-ийн Энхбаяр, Цагаанбаатар хоёр англидаа тун давгүй юм



---

Есдүгээр сарын 11-ний өглөө Нью-Йоркод хэдэн градус дулаан байсан бэ гэж асуухад минь зарим нь гайхан над руу харж байна.

Том, жижиг гэлтгүй сонирхолтой байж мэдэх бүх деталийг шүүрдэж үзмээр санагдана. Маргаашийн дугаар өдөр тутмын бусад сонинхоос огт өөр байх учиртай шүү дээ. Бид уншигчдынхаа итгэлийг нэг алдсан...



байна шүү. Нөөц бололцоо хангалттай. «Таван цагариг» сонинхны суудаг хэсэгт байрлуулсан жижиг телевизийн өмнө «Монгол Ньюс» компанийнхан цуглажээ. CNN-ийн давтан, шинэчлэн, давтан өгч буй мэдээллүүд тун сайн. Юу ч болсон бал, дэвтрээ бариад энд суулаа.

Цацрал CNN, BBC-гээс үйл явдлыг нүдээр үзэгчдийн хэлж ярьсныг авч байна. Нэгэнт бүтэн өдрөөр хоцорсон бидний мэдээлэлд өчигдөр шөнө / Улаанбаатарын цагаар/ болсон гол үйл явдлаасаа илүү шинэ баримтууд хэрэгтэй байлаа. Хүмүүсийн уй гашуут үгс, нүдээр харсан аймшиг хүчтэй мэдээлэл болж чадна. «Цахим өртөө» сүлжээг Цагаанбаатар хэдийнэ нээжээ. Үйл явдлыг харсан монголчуудын аймшиг, нэг нэгийгээ асууж сурагласан, хамт сэтгэл зовсон монгол үгс ертөнцийн хязгаар бүрээс урссаар. Цагаанбаатарын «Цахим өртөөнөөс» шүүрдсэнийг Цэвээнхэрлэн шивж эхлэв. Террорист бүлэглэлүүдийн тухай гучин хэдэн хуудас материалыг Сумъяабазар интернэтээс шүүжээ. Тэр принтерийн өмнө зогсоод нөгөөдөхөө хэвлээд л байлаа. Тэдгээрийг хэрхэн цэгцлэх, ямархуу хэмжээтэй материал болохыг бүү мэд. Даваадоржид гол үүргийг тохов. Тэр нэг ханцуй шамлавал, жинхэнэ үйл явдлын мөрөөр орвол «number one» сэтгүүлч гэдгийг нь мэднэ.

**Бидний  
ажлын хатуу  
хэцүү нь энд л  
бий. Тун сайн  
болжээ хэмээн  
талархах хүн  
ховор. Харин том,  
жижиг, яльгүй  
зүйл дээр ч  
заавал гомдол  
мэдүүлж, хатуу үг  
чулуудна. Тийм  
боловч өглөөний  
сонинг  
дэлгэлгүйгээр  
ажил амьдралын  
шинэ өдрөө  
эхэлдэг хүн  
ховор оо.**

Болсон ерөнхий үйл явдлыг эцсийн эцэст тоймлон хэлэх учиртай тул туршлагатай Рэнчинханд ах цэгцлэхээр барьж авлаа. Тэр, Гадаад хэргийн яам болон холбогдох газруудаас албан ёсны мэдээлэл, манай талын эмгэнэл, хариу зэрэг бүгдийг цуглуулна. Нягт нямбай хүнд даалгасан тул энэ хэсэгт санаа зоволтгүй. Улаанбаатар дахь Америкийн Элчин сайдын яамны байранд юу болж байна, харуул хамгаалалтыг чангатгасан уу гэдгийг тодруулахаар Чулуунцэцэг өглөө гарсан.

Газрын тос, алтны үнэ хөдөлж эхэлсэн, биржүүд дээр үймэлдэж байна, долларын ханш хадлаа гэх чимээг Бэхбаяр дуулгав. «За, энэ зун англи хэлний дамжаанд явсан байх аа?» Бэхээ хариуд нь инээж байна. «Тэгвэл интернэт рүү ороод бүх үнэ ханшийн хөдөлгөөнийг мэдээд ав. Монголбанк болон холбогдох газрын мэргэжилтнүүдээс үр дагаврын тухай асууж сурагла. Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлж болохыг зарим хүнээр таамаглуулахыг оролд». Бэхээ гараад явлаа. Хэдхэн жилийн өмнө Монголын сэтгүүлчдийн хувьд дэлхийн зах зээл дэх үнэ ханшийн савлагаа, хөдөлгөөний хандлагыг тодруулж, дотоодынхоо үйл явцтай холбон бичнэ гэдэг «том гавьяа», хүнд даалгавар байсан гэдгийг өнөөдрийн залуу сэтгүүлчид бүрэн ойлгож мэдрэхгүй дээ.

-Статуском АНУ руу үнэгүй яриулна гэнэ. Хэвлэлийн хуралд нь очих уу? Отгонжаргал ингэж асуугаад, даруйхан Хэвлэлийн хүрээлэнг зорив. Өөр юу дутуу вэ? Нью-Йорк дахь Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан, Вашингтонд суугаа Элчин сайд Ж.Чойнхор хоёртой холбогдох ёстой. Манай нөхцөлд энэ бас л хэцүү асуудал хэвээрээ. Статускомын хэвлэлийн хурлын тухай мартаж орхисон хэрэг! Тэр өдрүүдэд одоогийнх шиг олон улсын ярианы янз янзын карт харагддаггүй байсан даа.

Эхний нүүрт ямар зураг тавих вэ гэдэг гол асуудал. Өөрөөр хэлбэл телевиз, радиогоор бүх үйл явдлыг үзүүлж, уншигчид нэгэнт мэдээлэл авсны дараа гарах «Өнөөдөр» сонин дугаар бусдаас арай өөр байх ёстой. «Хоёр өндрийг» онгоц мөргөж буй агшныг маргаашийн Монголын бүх сонин мэдээж эхний нүүртээ тавина. Телевизээр ч ямагт түүнийг л харуулаад байгаа. Харин бид Америкийн Ерөнхийлөгч аймшигт үйл явдлын тухай эхлэн сонсч буй мөчийн зургийг интернэтээс сонголоо. Асар олон хирдхийм агшин интернэтэд оржээ. Сонгож, фото галерей бэлтгэх үүргийг Одбаяр хүлээв. Яг хаана, чухам юу болсныг график зураг дээр маш сайн харуулж болно. Хүмүүс бөөн утаа л



телевизээр үзээд суугаа. Онгоц хаанаас, ямар замаар ниссэн, Пентагон тэр чигтээ галд автаагүй биз дээ? Яг ямар хэсэг нь эвдэрч сүйдсэн бэ? Бүгдийг график зургаар үзүүлэх нь оновчтой. Үд дунд гэхэд маргаашийн дугаарын ерөнхий өнгө аяс бослоо. Төлөвлөгөөгөө бэлэн болгоод Батбаатар эрхлэгчтэй зөвлөж ярилцав. Дугаар удирдаж буй Баасандорж ч танилцлаа.

Осама бин Ладен! Дараа нь мянгантаа сонссон энэ нэрийг тэр өдөр Даваадорж эхэлж дуулгасан юм. «Түүнийг сэжиглэж байна гэнэ. Би материал хайж байна» гэв. Дараа нь Даваадорж 25 дугаар суваг телевизийн өрөөнд орж, Америкт байсан монгол сурвалжлагчаас утсаар цөөн зүйл асууж амжлаа. Тэр хэрхэн хурдтай ажиллаж байгааг хараад сэтгэл амраад тайвширч орхисон билээ.

Мөн өдөр бид «хоёр өндрийг» ямар эдээр барьсан, яагаад ийм «амархан» унасан тухай материал олж амжив. Террорист халдлагуудын урт түүхийг дахиад л Даваадорж бариад суулаа. Нью-Йорк, Вашингтонд суугаа Байнгын төлөөлөгч болон Элчин сайдтай холбоо барих гээд чадсангүй. Харин и-мэйл явуулав. НҮБ-ын Төв байранд ажилладаг Жоаннад захиа бичлээ. «Та бүхэн зүгээр үү?» Ийм үг 2001 оны есдүгээр сарын 12-ны өдөр интернэтээр тоймгүй олон урсч байсан биз ээ. Маргааш өглөө гэхэд ямархуу утга агуулгатай захидлууд уншихаа ч төсөөлж суув. НҮБ-ын шугамаар зохион байгуулдаг танилцах сургалтад оролцсон орон орны сэтгүүлч танилууд маань бүгд Нью-Йорк руу захидал бичиж буйг мэдэрч суулаа. Бид ганцхан жилийн өмнө шуугиант энэ хотод, өнөөх ихэр өндрийн ойролцоо зургаа татуулж явсан юмсан...

Эхний нүүрний том гарчиг, дараагийн нүүрүүдийг холбох малгай нь ямар байх ёстой вэ? «Шинэ зуун эмгэнэлээр эхлэв» Толгойд ийм эхлэл зурсхийв. Татгалзах өөр хувилбар гарсангүй. Есдүгээр сарын 11-ний өглөө Нью-Йоркод хэдэн градус дулаан байсан бэ гэж асуухад минь зарим нь гайхан над руу харж байна. Том, жижиг гэлтгүй сонирхолтой байж мэдэх бүх деталийг шүүрдэж үзмээр санагдана. Маргаашийн дугаар өдөр тутмын бусад сониныхоос огт өөр байх учиртай шүү дээ. Бид уншигчдынхаа итгэлийг нэг алдсан...

22.00 цаг өнгөрч байлаа. Харин ч их оройтсонгүй шүү. Эхний нүүрийг дахин нэг уншаад ер нь болжээ гэж ойлгов. Үлдсэн нүүрүүдийн өнгө төрх ч тодорчээ. Бусдыг нь эцэслэн хянах үүргийг дугаарын удирдагчид үлдээгээд гэрийн зүг явлаа. Үнэхээр сайн дугаар маргааш нь гарсан. Гэхдээ нөгөө уншигчид эргэж утасдахгүй. Бидний ажлын хатуу хэцүү нь энд л бий. Тун сайн болжээ хэмээн талархах хүн ховор. Харин том, жижиг, яльгүй зүйл дээр ч заавал гомдол мэдүүлж, хатуу үг чулуудна. Тийм боловч өглөөний сониныг дэлгэлгүйгээр ажил амьдралын шинэ өдрөө эхэлдэг хүн ховор оо.

**2001.09.12**

**Subject:** The Millennium Summit  
**Date:** Fri, 7 Sep 2001 16:10:41 +0200

Dear Friends

This time last year we were all very busy reporting the speeches of our leaders during the historic Millennium Summit. Do you still remember having to walk an extra couple of blocks to enter the UN building because of all the security? It's incredible how time flies.

Anyway, some of you have become rusty with using e-mails as most of you have not been in touch for some three months now. I was surprised to receive Ju's message from Thailand. This must have been your first we are now waiting for more.

I guess a lot of things happen during a one year span. On my part, I have resigned from the university radio and taken up a post as a Communications Manager with a company which promotes the restructuring of small and medium sized enterprises in Malta. I've just started this week so I can't tell you a lot about my new venture in life.

On the anniversary of the Millennium Summit, I guess we once again owe a big thanks to Craciela, Joanna, Liza, Elina and Udy for all their helpful tips during those frantic days. I mean going up and down the elevator chasing somebody who is responsible for the radio booth was not an easy task but thanks to your help, our job was made much easier.

It's a pity that not all the members of the group have access to e-mail.

Somebody should take it upon himself or herself to write to our «lost» friends and inform them that they are in our thoughts and communication.

I do not have the time to list each and every member of the group. I just hope that all of you are doing fine and that this year has brought you peace and prosperity. I urge you all to keep contact with each other.

All of us are scattered around the four corners of the globe, but the friendship which we have struck during those six weeks knows no borders.

To all the rest of you, keep those e-mails coming. I rather frown at having an inbox full of messages than stare at an empty list.

I doubt whether we shall ever be able to meet somewhere, somebody-but I'm confident that most of us will be able to engage in a reunion at least on a regional basis.

On the first anniversary of the Millennium Summit, I propose a toast to all of us: to good health, luck, success and prosperity and to the end of all conflicts and diseases across the globe. I'm sure Kofi Annan would drink to that.

And finally, Ju remarked that we were naughty. Had we stayed in New York for a month longer we would definitely have become rascals. But the city which makes you really naughty is Bangkok-right Ju?

**Cheers to all of you  
Pierre**

**From:** «Mongolia-Permanent Mission to the UN/Enkhsaikhan Jargalsaikhan»  
**To:** luntan\_bolormaa@yahoo.com  
**Subject:** Onoodor sonin  
**Date:** Tue, 12 Sep 2001 08:28:45 -0700

Сайн байна уу? Болормаа. Чиний мэйлийг авлаа. Энд байдал ерөнхийдөө гайгүй байна. Аз болж манай иргэдээс хохирч, өртөж үрэгдсэн хүн байхгүй. Харин энэ тэндээс манайхан утасдаж бидний биеийг асууж сураглаж байгаад баярлаж байна.

Манхеттэн руу сүүлийн хоёр хоног машин тэрэг оруулахгүй байгаа. Телевизээр хоёр өндрийн сүйрэл, аврах ажиллагааны талаар зай завсаргүй нэвтрүүлж байна. Өнөө орой л гэхэд нурангинаас найман хүнийг гаргаж авсан. Сайн дурынхан энд тэндээс ирж байна. Цусны донорын асуудал бараг шийдэгдчихсэн. Өнөөдрөөс нэмж цус авахгүй гэсэн яриа гарлаа.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 56 дугаар чуулган өнөөдөр эхэлсэн. Өмнөд Солонгосын Гадаад яамны сайд чуулганы даргаар сонгогдсон. Эхний чуулганаас Нью-Йорк, Вашингтонд болсон үйл явдалтай холбогдуулан тогтоол баталсан. Уг тогтоолдоо алан хядлагыг хурцаар буруушаагаад, Америкийн ард түмэн, Засгийн газарт эмгэнэл илэрхийлээд, цаашид иймэрхүү террорист ажиллагаатай ширүүхэн тэмцэхийг уриаллаа.

Террористуудыг залхаан цээрлүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг яаралтай эрчимжүүлэн нэмэгдүүлэхийг дэлхийн хамтын нийгэмлэгт дахин уриалав. Мөн өнөөдөр НҮБ-ын

Аюулгүйн зөвлөл хуралдаж, мөн иймэрхүү тогтоол батлав.

Хурлын үеэр Азербайджаны төлөөлөгч санал гаргаж, нью-йоркчуудад донорын цус өгөх хөдөлгөөн дипломатуудын дунд өрнүүлэхийг уриалсныг бүгд зөвшөөрөв. НҮБ-ын дэргэдэх эмчилгээний цэг уг ажлыг зохион байгуулахаар болов. Хүүхдийн асуудлаар болох Ерөнхий ассамблейн тусгай чуулганыг тодорхой бус хугацаагаар хойшлуулсан. Харин ээлжит чуулган тохирсон графикаараа хуралдах болсон. Хүүхдийн асуудлаарх тусгай чуулганыг аль болох их хойш тавихгүйгээр хуралдуулах бололтой. Манай энд иймэрхүү сонин байх шив дээ.

Хүндэтгэсэн Энхсайхан

**EVERYONE IS STILL IN  
SHOCK**

**Subject:** Mongolia  
**Date:** Thu, 13 Sep 2001 11:54:48 -0400

Dear Bolormaa  
 Graciela, Liza and I are all okay. The UN was shut down for a couple of days, but we're back to work now. Everyone is still in shock. Thank you for your kind words, and yes, I received your other e-mail.

All best wishes  
**Joanna**

**I WAS AT THE UN AT THE TIME  
OF THE ATTACKS****Subject:** So sad**Date:** Thu, 13 Sep 2001 10:47:47 -  
0400

Hi, Everybody

It has been a long time since I communicated with all of you. Thanks for your warm feeling and concern. Thank god I am fine and so is my family.

I was at the UN at the time of the attacks and we watched in horror the unfolding events on TV live because I came into the office just minutes before the second plane hit the tower.

All of us were told leave the building at about 11 o'clock. I lost track of my husband who works in the building across the street since both regular and cell phones were out of service. We eventually found each other and got home safely.

We live pretty far away from Manhattan so were not really affected except for traffic problems.

On the other note I work in another office now, the one that services meetings in Headquarters. It is a temporary position for three months until the end of the General Assembly session which opened yesterday.

I met with Udy who spent some time in New York in August, I also regularly see Graciella in the building. She and Joanna just started with the new group of journalists. I do not think that anybody can compare with you, you are lot of fun.

And yes, I just met Kyong from Korea at the opening of the GA. He is here with the delegation as an expert!!!

It is really nice to be in touch with you all. **Best regards! Elina**

**Subject:** So sad**Date:** Thu, 13 Sep 2001 13:36:14

I fell the same friends, really so sad, almost because my country for 12 years had this terrible problem. **Alvaro, Peru**

**Subject:** So sad**Date:** Thu, 13 Sep 2001 14:00:44  
+0430

Hi DPI-2000 group,

I know everybody are so sad because of terrorist attack in NY and Washington. I really worried about Graciella, Joanna, Lisa, Elina and other friends.

If you get any information about them, please share it with me.

I hope they all are OK.

**Sami, Cyprus****Subject:** So sad**Date:** Thu, 13 Sep 2001 20:18:12  
+0000**Dear all in NY**

I've just got reply e-mail from Joanna and Elina that all are safe now. I am so shocked while watching the TV. Frankly, I've just realized at the time how much I feel good over there with all of you in NY. Especially the good remembrance city had been attacked.

Although I've worked in many horrible event to report the news but it is so hard to report what I saw from TV.

Luckily, all of you in NY are fine. I would like to sincere sympathy and condolences to you and your country.

**JUDY**

# Онцгой үйл явдлын тухай материал бэлтгэх туршлага

Ассошейтэд Прессийн мэдээллийн машин өдөр шөнөгүй ажиллаж байна. Бүтээгдэхүүнээ таван хэл дээр бэлтгэн цацдаг. «**АР ингэж мэдээлэв**», «**АР-гийн гэрэл зураг**» гэх үгс бөмбөрцгийн хэсэг бүрт хүрэх аж.

Дэлхийн мэдээллийн хамгийн том агентлаг хэрхэн ажилладаг тухай энд цухас өгүүлэе. Ялангуяа онцгой үйл явдлын талаарх цуврал материалыг АР яаж бэлтгэдэг юм бол? Нью-Йоркийн хамгийн хөл хөдөлгөөнтэй гудамжнаа байрладаг Рокфеллерийн сүрлэг төвд мэдээний мангас АР ажиллаж байна. Эдний факсын аппаратууд чөлөөгүй өрнөх их үйл явдлын урсгалыг хөврүүлэх аж. 2002 оны аравдугаар сарын 17-ны өдөр мөнөөх факсын аппаратнаас асгарсан их цаасны дунд «**Улаанбаатар, Кофи, Нейн Аннан нар Монголын хөдөөд зочлов**» гэсэн лид харагдсан юм. Бөмбөрцөг дээр энэ мөчид болж буй бүх үйл явдлыг АР залгидаг. Тэдний сурвалжлагчдаас илгээсэн материал, АР-гийн төвд боловсруулсан мэдээллийг дэлхийн хэвлэлүүд эдүгээ түгээмэл ашиглаж байна.

АНУ-ын Миннесота мужаас сонгуульд өрсөлдөхөөр зэхэж асан Велстон 2002 оны аравдугаар сарын 25-ны өдөр онгоцны ослоор өөд болов. Яг тэр мөчид АР-гийн төв байранд байж, уг үйл явдлын тухай цуврал материалыг мэргэжил нэгтнүүд маань хэрхэн бэлтгэхийг ажиглалаа. Тус агентлаг онгоцны ослын тухай дагнан бичдэг сэтгүүлчидтэй. Хойд Дакота болон Миннесотаг холбосон уудам хөндийд онгоц унасан тохиолдол цөөнгүй бий гэнэ. Тэдгээр ослын талаар эргэн лавлаж харах статистик компьютерийн дэлгэцнээ гараад ирлээ. «Ослоор дагнагчдын» хэсэг жижиг телевизийн дэлгэцнээс бас хараа салгахгүй. CNN уг үйл явдлыг хэрхэн тайлбарлаж буйг анхааралтай ажиглацгаах аж. Өөрөөр хэлбэл энд онцгой үйл явдлын тухай баялаг мэдээллийг бусдаасаа түрүүлж цацах өрсөлдөөн өрнөж байна. CNN биднээс өрсөж орхилоо. Лари Кинг гол хүнээс ярилцлага авч амжсан байна шүү дээ... Ийм ширүүхэн өрсөлдөөний уур амьсгал Америкийн мэдээллийн томоохон редакц бүрээс үнэртэнэ. Тэд үйл явдалд хандах аль нэг өнцгөөр бие биеэсээ ялгарахыг амь тавин чармайх аж.

Монголын өдөр тутмын сонинуудын дунд ч ялгаагүй ийм өрсөлдөөн хүчээ авч эхэлснийг уншигчид төвөггүй анзаарч буй байх. Ялангуяа онцгой халуун, бидний ярьж заншсанаар сенсаац үйл явдлыг хэвлэлүүд ямар өнцгөөс харж, хэрхэн бичих нь вэ, аль сонины мэдээлэл илүү баялаг вэ гэх шалгуурыг хэрэглэгчид маань байнга тавих болжээ. Шинэ зууны эхэнд Монголын сэтгүүл зүйн гол цөм, ноён нуруу нь тогтмол хэвлэлүүд байж, өрсөлдөөн энэ талбарт өрнөснийг үгүйсгэх хүн гарахгүй биз. Шуурхай, тэнцвэрт мэдээлэл түгээгч суваг цэнхэр дэлгэцнээ цөөн байгаа тохиолдолд өдөр тутмын сонинууд тэрхүү орон зайг нь эзэгнэсээр байна. Сэтгүүл зүйн ангийн оюутнууд, багш судлаачдын хувьд ийм нэг нэн сонирхолтой судлагдахуун байгааг давтан хэлье. Тухайн үйл явдлыг тогтмол хэвлэлүүд хэрхэн мэдээлэв гэх харьцуулсан судалгааны ажил, түүнийг дэлгэрүүлэн хандлага тодорхойлох нь Монголын шинэ сэтгүүл зүйн түүхэнд сонирхолтой, өгөөжтэй бүтээл болохсон.

Энэ санаагаа залуу сэтгүүлчдэд үлдээгээд, дэлхийн мэдээллийн томоохон редакцийн гал тогоонд үргэлжлүүлэн саатъя. 2002 оны намар Вашингтон орчимд үл үзэгдэх мэргэн бууч тэнүүлчлэн, арван хэдэн хүний аминд хүрээд

**Хамгийн чухал, онцгой халуун цэг болгонд сэтгүүлч үзэг, дэвтрээ бариад очдог. Ийм этгээд хүсэл тэмүүллийг «амбиц» хэмээн нэрлэнэ үү яана, өөрөө мэд.**

**Шуурхай,  
чанартай,  
сенсаац  
мэдээлэл авч,  
өгөлцөх том  
бизнес  
хэвлэлийн зах  
зээл дээр  
явагдаж байна  
аа гэсэн үг.**



байсныг уншигчид санаж буй биз ээ. Буудуулсан хүмүүсийн дунд бяцхан хүү ч байсан. Цагдаагийнхан барьц алдаж, Вашингтоны Виржиниа хавийн иргэд жинхэнэ айдас хүйдэс дунд амьдарсан билээ. Тэр өдрүүдэд AP-ийн сэтгүүлчид онцгой ачаалалтай ажиллаж байлаа. Жишээ нь, «Нью-Йорк таймс» сонин Вашингтоны мэргэн буучийн талаарх хамгийн сүүлийн шинэ мэдээллийг AP-ийн эх сурвалжаар нийтэлж байсан юм. Ийм үйлчилгээ авсныхаа төлөө «Нью-Йорк Таймс» тун их хөлс төлдөг аж. Шуурхай, чанартай, сенсаац мэдээлэл авч, өгөлцөх том бизнес хэвлэлийн зах зээл дээр явагдаж байнаа гэсэн үг. Харин Америкийн гурав дахь том сонин (2002 оны байдлаар) «Вашингтон Пост»-ынхон бие даан мэдээлэл түгээж байлаа. Үйл явдал АНУ-ын нийслэлийн орчимд өрнөж буй болохоор ингэхээс ч аргагүй. 2002 оны аравдугаар сарын 24-ний өдрийг эргэн саная. Мэргэн бууч чухам хэн болохыг олж тогтоочихоод байсан үе. Мохаммед гэгч тэр эр Ямайкагаас гаралтай. Аав, ээж нь нэгэн цагт Ямайкагаас АНУ-д цагаачлах гээд чадаагүй гэнэ. Энэ шинэ баримт биш гэж үү? «Вашингтон Пост» ийм баримт түрүүлж олоод тавьчихаж. AP-ийн ажилтнууд ингэж ярьцаагаад ханцуй шамлалаа. Маргааш нь буюу аравдугаар сарын 25-ны өдөр AP-ийн сурвалжлагч «Мохаммедийн аав хүүгээ арван хэдэн хүн нухчихсан талаар юу ч мэдээгүй яваа» гэсэн утгатай мэдээ бэлтгэв. Мөн өдрийг хүртэл тус агентлагийн ажилтнууд Мохаммедийн зэвсгийн тухай, салсан гэргийнх нь талаар, алагдсан хүмүүсийн ар гэрийнх нь тухай гэх мэт нийт 15 материал бэлтгэжээ.

25-ны өдөр редакцид дахиад л бөөн бухимдал дэгдэж орхив. «Сиэтл таймс» сонинд Мохаммедийн экс гэргийн ярилцлага нийтлэгджээ. Мөн үдэш тэр эмэгтэй Лари Кингэд ярилцлага өгөх гэнэ. AP түргэн авч, өмнө нь Алабама муж орчимд мөнөөх мэргэн буучийн овоо хараанд өртөн шархадсан эмэгтэйд олж ярилцлага авлаа. Өрсөлдөөн хэрхэн өрнөж байгаа нь сонин. Бараг л өнөөх Мохаммедийг нүцгэлж, бие дээрх элдэв шарх сорви, шивээсийг түрүүлэн олж харахаар уралдацгаах мэт. Энэ яаруу давчуу хэмнэл дунд мэргэжлийн алдаа хэрхэн гарахыг ч үзлээ. AP-ийн мэдээний редактор бүсгүй 25-ны өдөр ингэж ярьсан юм.

-«Мэргэн буучийн унаж явсан цагаан өнгийн фургон машиныг өчигдөр олсон. Дотор нь байсан буу Мохаммедийнх мөн гэдгийг тогтоожээ» гэсэн агуулгатай мэдээ бэлтгээд компьютерийнхээ товчлуурыг дарж орхисон юм. Тэгсэн удалгүй Пентагоноос утасдаж байна. Зэвсэг Мохаммедийнх мөн гэдгийг хэн ч эцэслэн тогтоогоогүй шүү дээ. Танайх ташаа баримт цацлаа хэмээн биднийг буруутгасан. Уг нь бид дор хаяж хоёр эх сурвалжаас тухайн баримтыг тодруулж тавьдаг. Өчигдрийн хувьд тун найдвартай эх сурвалжийн үг учир шууд цацсан хэмээн ярилаа. Энэ нь мэргэжлийн алдаа ч байж болох. Үгүй хэмээн AP-г өмөөрөхөд ч бас болох л зүйл. Монголын сэтгүүл зүйд, бид хэдийн өдөр тутмын ажилд тохиолддогтой ижил явдал. Тэнд онцгой үйл явдлын тухай мэдээ бэлтгэх асар өрсөлдөөн хэрхэн өрнөдгийг мэдэрч, тэр гайхамшигтай уур амьсгал дунд хутгалдах ямар амттай байсныг гүйцэд илэрхийлж чадахгүй нь.

Хорвоо дэлхийн өнгө өнгийн амьдралын дэлгэц дээр түмэн үйл явдал зайгүй өрнөх юм. Хамгийн чухал, онцгой халуун цэг болгонд сэтгүүлч үзэг, дэвтрээ бариад очдог. Ийм этгээд хүсэл тэмүүллийг «амбиц» хэмээн нэрлэнэ үү яана, өөрөө мэд. Ээлжит сенсаац дэгдэх бүрийд халуун цус булгилж, нөгөө муу дэвтрээ шүүрэх «хууч өвчинтэй» улс шүү, бид. Шинэ өглөө болгон нөгөө л замаараа, шуугиант редакция зорин яарахын утга учир энд байгаа ч юм шиг.





Буудуулсан хүмүүсийн дунд бяцхан хүү ч байсан. Цагдаагийнхан барьц алдаж, Вашингтоны Виржиниа хавийн иргэд жинхэнэ айдас хүйдэс дунд амьдарсан билээ.





Би ахмад сэтгүүлч биш. Хангалттай туршлага хуримтлуулсан хашир бурхи ч биш. Гэхдээ сэтгүүлзүйн ертөнцөд хөл тавьж буй залууст хандан хүсэх, зөвлөх зүйл бий.

Энэ бол өөрийн сэдэв. Өөрийнхөө сонирхол, боломжийг мэдэрч буй гэдэгт



чинь эргэлзэхгүй байна. Чиний сэдэв, чиний гэх орон зай ямагт байх ёстой. Багш нар үүнийг мэргэших чиглэл гэж

хэлж өгсөн байж мэднэ. Тэр чиглэл гэгч тоо томшгүй олон. Энэ бол аль нэг салбараар дагнан бичих, нэвтрүүлэг бэлтгэх тухай ерөнхий яриа бус. Ямар нэг үйл явдлын хажууд байж, бусдаас илүү мэдээлэл олж авсан

бол тэр сэдвийг мухарлах хүртлээ өөртөө өмчлөөрэй.

Амьдрал гэгч учир шалтгаануудын торгон үзүүрт түмэн

өнгөөр хувьсч өрнөдөг гайхамшиг болохоор тэр нэгэн өдрийн үйл явдал, түүнийг тойрсон бүхний талаар чиний олж цуглуулсан архив хэзээ ч үнэ цэнээ алдахгүй. Явсаар мөнөөх сэдвээр өөрөөс чинь илүү баримт мэдээлэлтэй хүн цөөн мэт санагдана. Аливаа мэдээ, сурвалжлагад болсон үйл явдлын шинэхэн амт үлддэг. Харин он цаг улирах тусам тэрхүү явдлын эргэн тойронд хандлага тодордог. Эхлэл, төгсгөл хоёрыг холбон харж чадахуйц арвин архив, мэдлэг ганцхан чамд байж ч мэднэ. Уншигчид сануулж, тайлбарлаж, дүгнэлт хийхэд нь туслах хүн бол чи. Өөрийн сэдэв, өөрийн архивтай болоорой. Эхэлсэн сэдвээ бүү хая. Торгон үзүүрээс нь атгасан л бол түүнээ яагаад алдах гэж!

# Монгол Улс цөмийн зэвсгийн агуулах болох эсэхийг хэлэлцэнэ

Мягмар гаригийн өглөө Нью-Йоркт хүйтэн салхитай байлаа. Дүүрэн элс ачсан машинууд НҮБ-ын байрны өмнөх замын хоёр үзүүрт эгнэжээ. КАМАЗ-тай ойролцоо харагдах, тод шар өнгийн эдгээр машиныг давхар эгнээгээр байрлуулсан байна. Цагдаа нар гар гараасаа барих шахам ойрхон зайнд зогсчээ. Ийм хамгаалалт НҮБ-ын Төв байрнаас зүг бүрт нэг км илүү зайд үргэлжилнэ.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 55 дугаар чуулган болон дэлхийн удирдагчдын Мянганы дээд хэмжээний уулзалтыг сурвалжлахаар ирсэн сэтгүүлчид Төв байранд орох гэж хэд дахин «нэгжүүлэв». Давхар давхар «шалган нэвтрүүлэхийг» амжилттай давсныхаа дараа Энхтайвны хонх цохих ёслолыг сурвалжлахаар гүйцгээлээ. НҮБ-ын байрны төв хэсэгт задгай талбай бий. Сүхбаатарын талбайн өмнөх цэцэрлэгт байдаг шиг хонх энд байна. Япон улсаас НҮБ-д бэлэглэсэн уг хонхны дэргэд япон багачууд дуулж, хийл хөгжим тоглосны дараа Ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан товч үг хэлэв.

Жил бүрийн есдүгээр сард нээгддэг Ерөнхий Ассамблейн хуралдаан энэ удаа онцгой үед эхэллээ. 55 дугаар Ассамблейг Мянганых хэмээн тодруулж нэрлэхээр шийджээ. Ерөнхий Ассамблейн зэргэцээ дэлхийн тэргүүнүүдийн уулзалт НҮБ-д эхэлж байна. Мягмар гаригийн байдлаар 104 орны удирдагч, Засгийн газрын 48 тэргүүн энд иржээ. Мөн өдрийн бага үдэд К.Аннан хэвлэлийн хурал зарлав Ассамблей болон Мянганы чуулганыг сурвалжлах тухай нийт 2500 хүсэлт ирээд байгаа аж. Мягмар гаригийн үд гэхэд ийм хүсэлт НҮБ-д үргэлжлэн ирсээр байлаа. Харин К.Аннанийн хэвлэлийн хуралд тэдгээр сурвалжлагчдаас 50 орчим нь оролцох шиг санагдсан. Телевизийн сэтгүүлчдийг энд нэвтрүүлсэн боловч камер оруулахыг зөвшөөрсөнгүй. 11.00 цагт К.Аннан бие хамгаалагчийнхаа хамт хөнгөн гэгч алхсаар Мэдээллийн төвд орж ирсэн юм. Тэр энэ өдөр хар саарал өнгийн костюм өмсч, хөх зангиа сонгожээ. Таван минут орчим зөөлөн дуугаар «ёслолын» гэмээр ерөнхий үг хэлэв. Үлдэх 25 минутад нь сэтгүүлчид асуулт тавилаа. Аюулгүйн зөвлөлийн үйл ажиллагааг илүү ардчилах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны зардлыг хөндсөн ВВС-гийн асуулт, Б.Клинтон, Э.Барак нарын уулзалтын тухай сонирхсон асуултад тэрбээр дэлгэрэнгүй хариулав. Энэ хуралтай бараг зэргэцээд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайт өөр нэг хэвлэлийн төвд мөн л мэдээлэл хийлээ.

## НҮБ-ЫН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН МОНГОЛ УЛСЫН ХУВЬД ЮУГААРАА ОНЦЛОГ ВЭ?

Энэ асуултад наймдугаар сарын 31-ний «THE INQUIRER» сэтгүүлийн дугаарт хэвлэгдсэн өгүүлэл сайн хариулт өгнө. Стив Голдстейн уг сонирхолтой материалыг бэлтгэжээ. Монгол Улс 1998 онд цөмийн зэвсэггүй бүсийн статустай болсныг бид тод санаж байна. Ерөнхий Ассамблейн батламжилсан уг статусыг нэр төдий зүйл бус, бодит ажил хэрэг болгохын тулд Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн таван улсын дэмжлэг хэрэгтэй байгаа билээ. Их таваар хүлээн зөвшөөрүүлнэ гэдэг амаргүй даваа бөгөөд НҮБ дэх манай Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан эхэлсэн энэ үйлсээ гүйцээх гэж бараг гурав

дахь жилдээ «хөөцөлдөж» буй юм. Ийм статус албан ёсоор авсан улс дэлхийд манайхаас өөр байхгүй. Харин цөмийн зэвсгийн агуулах болж буй гашуун туршлага жижиг орнуудын хувьд хаа сайгүй бий. Нутаг дэвсгэрт нь цөмийн зэвсэг байрлуулахгүй байх, түүнчлэн дамжин өнгөрүүлэхийг үл зөвшөөрөх утга бүхий уг статусыг олж авахыг өнөөдөр Шинэ Зеланд, Канад, Непал зэрэг олон орон эрмэлзэж буй юм. Тэдний хувьд Монгол Улсын энэ чиглэлээрх идэвхтэй дипломат бодлого үлгэр жишээ болж байна. 55 дугаар Ассамблейн хэлэлцэх асуудлын 74 дүгээрт Монгол Улсыг цөмийн зэвсэггүй бүс хэмээн бататган зарлахтай холбогдсон асуудлыг оруулжээ.

Ерөнхий Ассамблей нээгдсэн өдрийн үдээс өмнөх ёсорхуу арга хэмжээнүүд өндөрлөж, 15.15 цагт чуулган нээгдэв. К.Аннан эхлэх цагаас 15 минут хожимдон Ерөнхий Ассамблейн танхимд орж ирсэн бол 16.00 цаг болчихоод байхад нийт төлөөлөгчийн тал хувь нь мөн л хүрэлцэн ирээгүй байлаа. Зургаан эгнээгээр хагас дугуй шахам байрлуулсан суудлын төв хэсэгт Монгол Улсын төлөөлөгчдөд зориулсан суудал бий. Ассамблейн эхний өдрийн хуралдаанд лав манай суудал эзгүй байсаар өндөрлөв. Нью-Йоркод бүрэнхий болох алдад НҮБ-ын 189 дэх гишүүн Тувалу улсын далбааг хүндэтгэлтэйгээр мандууллаа.

**2000 он**

# Улаанбаатараас 32 километр цөмийн зэвсэг хадгалж байв

Зөвлөлтийн цэргийн бүрэлдэхүүн 1992 онд манай улсаас бүрэн гарах хүртэл бид цөмийн зэвсгийн шууд аюул дор амьдарч байв. Улаанбаатарын ойролцоо төдийгүй, манай өмнөд хил дээр тийм зэвсгийн агуулах байсан бөгөөд БНХАУ нь ЗХУ-аас өөрийгөө хамгаалах нэр дор мөн л аюулт зэвсгийг Монгол Улсын өмнөд хилийн орчимд, манай зүг онилуулан байрлуулаад байсан билээ. Хэдхэн жилийн өмнөх бодит байдлын талаар НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан ингэж ярих.

-Тухайн үед Зөвлөлт, Хятадын хооронд ямарваа нэг зөрчил мөргөлдөөн гарах юм бол цөмийн зэвсгээр дайтах магадлал байсан. 1969, 1970 оны үед ЗХУ нь Хятадын эсрэг хүч хэрэглэх боломжийг судалж байсан байгаа юм. Хятад улс нь хүчээ авч буй том гүрэн болж байна. Иймээс хүчээ бүрэн авч чадаагүй дээр нь арга хэмжээ авъя гэсэн үүднээс Америктай тухайн үед ЗХУ зөвлөлдсөн байна. Харин АНУ үүнд нааштай хандаагүй. Хэрвээ тэр үед Америк ЗХУ-ын саналыг зөвшөөрсөн бол нэг л юм гарах байсан байх. Гарлаа гэхэд манай улсын нутаг дэвсгэр дээр «юм болох» магадлал байж гэж тэрбээр ярих.

Өнөөдөр бол манай хоёр хөршийн харилцаа урьд байгаагүй сайжирсан болохоор дээр өгүүлсэн баримт тийм ч ноцтой бус санагдаж болох юм. Мөн л Ж.Энхсайханы өгүүлснээс ишлэл авъя.

-Цөмийн зэвсэг гэдэг үгүй болохгүй. Одоо улам нарийн, бүр авсаархан, нягт болоод байгаа. Орос, Хятадын талаас манай нутаг дэвсгэрт дахиад цөмийн зэвсэг байрлуулахыг үгүй гэх газаргүй. Монголын нутаг дэвсгэр дээр дахин цөмийн зэвсэгтэй болчихоод, тэгээд нэг асуудал гарах юм бол Монгол Улс л хохирно шүү дээ. Үүнийг муу санаалан ярьж буй юм биш. Ер нь улс төрийн зүтгэлтэн аливаа юмыг сайн муу талаас нь, мөн зөвхөн өнөөдрийг бус, арав хорин жилийн дараа юу болж болохыг харах хэрэгтэй. Тийм ч учраас 1992 онд П.Очирбат гуай Ерөнхийлөгч байхдаа Монгол Улсыг цөмийн зэвсэггүй бүс болгох санаачлага дэвшүүлж олон улсад зарласан хэрэг гэж тэрбээр үргэлжлүүлэн ярих.

Жижиг улс өөрийгөө ийм тийм бүс болгон зарлах нэг хэрэг. Харин түүнийг нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч тооно гэдэг гол асуудал билээ. Цөмийн зэвсэггүй бүс болохоо тодорхой арга хэмжээгээр баталгаажуулах нь 1992 оноос хойшхи Монгол Улсын гадаад бодлогын нэг зорилго байсаар ирэв. Цөмийн зэвсэгтэй улсууд манай ийм идэвх санаачлагад дурамжхан ханджээ. Гол нь Монгол Улс гэдэгтээ бус, ер нь цөмийн зэвсгээс ангид бүс болгох моод газар авбал эвгүй үлгэр жишээ тархаж магадгүй гэж том гүрнүүд эмзэглэсэн байна. Тухайлбал, нутаг дэвсгэртээ цөмийн зэвсэг байрлуулах дургүй НАТО-гийн гишүүн зарим улсад энэ нь аятайхан дууриал болох нь лав. Түүнчлэн Япон улс гэхэд хөнөөлт зэвсгийн аюулыг хамгийн их амссаныхаа хувьд ийм зэвсэггүй бүс болно хэмээн зүтгэвэл тус арал дээрх АНУ-ын цэргийн баазын ач холбогдол өөрөөр эргэж болох юм. Эсвэл Кипр, Мальт зэрэг Газар дундын тэнгисийн жижиг улсад ийм моод халдвал НАТО-гийн онгоцууд тус бүсэд чөлөөтэй нисч чадахаа болино гэсэн үг. Энэ мэтээр дэлхий дахины хүчний байршил тооцоонд өөрчлөлт гарна гэж болгоомжилсон учир Их Британи, Франц, АНУ, ОХУ, БНХАУ нь Монгол Улсын санаачлагад эхэндээ ийнхүү их л болгоомжтой хандсан байна.

Гэвч 1998 оны өвөл манай улс НҮБ-ын Ерөнхий ассамблейгаар «Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай» тогтоолыг батлуулж чадсан юм. Энд бүс гэдэг үг статус болон солигдсоныг Та анзаарч буй байх. Бусад

улсад ийм халдвар тархахаас сэргийлэн зөвхөн Монголд ийм онцгой статус олгожээ. Тогтоол шийдвэр цаасан дээр үлдэж биелэлт нь мартагдаж хоцрох нь манайд ч, НҮБ шиг дэлхийн улс төрийн том бирж дээр ч гардаг үзэгдэл. Иймээс дараагийн алхам буюу цөмийн зэвсэгтэй мөнөөх таван орноос уг тогтоолын биелэлтэд түлхэц өгөх баталгаа авах шаардлага тулгарав. Энэ нь явдалтай ажил байсан нь мэдээж. Энэ оны аравдугаар сарын 5-ны өдрийн үдээс хойш АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайтын шадар түшмэдийн нэг, Олон улсын аюулгүй байдлын асуудал эрхэлдэг ноён Жон Д.Холум монголчуудын аюулгүй байдалд баталгаа өгсөн үгээ Нью-Йоркод хэлсэн юм. Тэрбээр НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн таван орны нэрийн өмнөөс ингэж мэдэгдэв.

**...Франц улс, БНХАУ, ОХУ, Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс болон АНУ нь хэрэв Монгол Улс түрэмгийлэх үйлдлийн бай болох буюу түрэмгийлэх үйлдэл хийх аюул заналд өртөх аваас.. Монгол Улсад туслалцаа үзүүлэх зорилгоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс даруй арга хэмжээ авахуулахад шийдвэр төгс байгаагаа дахин баталж байна.**

**... БНХАУ, ОХУ нь энэхүү асуудалтай холбогдуулан Монгол Улстай тус тус хоёр талын гэрээ хэлэлцээр байгуулж, Монгол Улсын хувьд хүлээсэн эрх зүйн үүргүүдийг анхааралдаа авч, тэдгээрийг нотолж байна. .. гэжээ.** Ингэж мэдэгдсэний дараа НҮБ-ын Ерөнхий ассамблейн 55 дугаар чуулганы нэгдүгээр хорооны хуралдааныг даргалагч нь ноён Холумд маш чухал үг хэлсэнд талархаж буйгаа илэрхийлсэн юм. Их гүрнүүдээс аюулгүй байдлын баталгаа авч чадсаны учир тэр үү, манай төлөөлөгчдөд янз бүрийн орны дипломатууд энэ өдөр баяр хүргэн гар барьж буй нь олонтаа харагдлаа. Харин маргааш нь буюу аравдугаар сарын 6-ны баасан гаригт НҮБ-д суугаа Монгол Улсын Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан хариу үгээ хэлэв.

-Цөмийн зэвсэгтэй таван гүрний өгч буй аюулгүй байдлын уг баталгаа нь ёс зүйн үүднээс ихээхэн ач холбогдолтой хэмээн тэрбээр талархсан хэдий ч чамлангуй дурдах нь содон сонсогдлоо. Монгол Улс юу хүсээд байгаа хэрэг вэ? Улаанбаатарын ойролцоо дахин хөнөөлт зэвсэг хураасан агуулах бий болох аюул нэгэнт холдсон биш үү? Хэдийгээр Ерөнхийлөгч П.Очирбатын хүсч зарласан шиг **бүс** гэсэн ойлголтыг бидэнд өгөхийг зөвшөөрөөгүй ч, өөр улсууд барьцах эрхгүй, зөвхөн манайд зориулсан онцгой **статусыг** нэгэнт олгосон юм биш үү? Ж.Энхсайхан энэ асуултад хариулж байна.

-Өнөөдөр би үгээ хэллээ. Тэр үгэндээ манай улсын хувьд энэ нь ёс төдий юм даа гэж дурдсан. Бусад улс бол манайхыг Орос, Хятадаас айж эмээгээд л цөмийн зэвсэггүй бүс гэдгээ зарлачихсан. Одоо ийм зэвсэгтэй таван гүрэн баталгаа өгчихөөр сайхан болчихож байгаа юм шиг санаж магадгүй. Харин би юу гэж хэлсэн гэхээр, манай улс хоёр хөрштэйгээ сайн харилцаатай, тиймээс тэдгээрийн зүгээс цөмийн зэвсгээр заналхийсэн, далайлгасан юм байхгүй. Ийм утгаараа манайд аюулгүй байдлын баталгаа өгч буй явдал нь сайшаалтай. Гэхдээ энэ бол символик юм шүү, өөрөөр хэлбэл зөвхөн эхлэл, анхны алхам. Тэгээд ч хамгийн чухал юм биш. Хамгийн чухал нь Монгол Улсын эдийн засаг, улс төрийн төдийгүй экологийн аюулгүй байдлыг баталгаажуулах явдал. Энэ талаар цөмийн зэвсэгтэй таван гүрэнтэй одоо хамтарч ажиллая, НҮБ-ын гишүүн бусад орон, мөн байгууллагуудтай ч ажиллая гэсэн утгатай зүйл ярьсан гэсэн үг. Ийм боломжийг одоо хэрхэн ашиглах вэ гэдэг нь гол асуудал юм. Хамтын ажиллагааны дүнд эдийн засаг, улс төр, экологийн зэрэг чиглэлээр манайд ашигтай олон зүйл хийх боломж байна. Гэхдээ энэ нь донорын хуралд оролцож буй улсууд шиг зүгээр л мөнгө гуйж буй явдал биш. Манай аюулгүй байдал гэдэг зүгээр нэг хөгжлийн асуудал биш юм л даа гэж Ж.Энхсайхан ярилаа.

Том гүрнүүдийн өгсөн баталгааг цааш нь «чулуу болгох» хэрэгтэй гэж тэр үзэж байна. Нэгэнт НҮБ-ын индрээс тэд аюулгүй байдлын баталгаа манайд амласан учир НҮБ-тай хамтран, дэмжлэг аван ажиллах боломжтой гэж мөн тэр үзэж буй юм. Хэрэв НҮБ дэлхийн улс төрийн хамгийн том бирж юм бол, жижиг орны зовлонг хангалттай үзсэн Монгол Улс энд өөрийн ухаалаг нүүдлээ эхлэх зам ийнхүү нээгдэв.

# Цөмийн хаягдлын бизнес ба Монгол Улсын гадаад бодлого

Кофи Аннан гайхаж байна. Тэр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 59 дүгээр чуулган дээр Монголд хандсан хатуухан үг бүхий илтгэл тавьж мэдэх л байлаа. Гэвч Ерөнхий нарийн бичгийн даргын илтгэлд Монгол гэсэн үг энэ удаа ороогүй нь яамай. Манай гуйвж дайвсан гадаад бодлогыг НҮБ төдийгүй, дэлхийн улсууд ч гайхшран харж байна. НҮБ Гадаад хэргийн яаманд хандан удаа дараа сануулж, хүсч, гуйж үзэв. Кофи Аннаны «засаглалын» үед НҮБ Монголыг онцгойлон дэмжсээр ирсэн. Харин монголчууд хэрхэн аягласныг сонсооч.

**1992 он** Зөвлөлтийн цэргийн цувааны сүүлч Монголын тал нутгийг орхин одлоо. Хүйтэн дайны төгсгөл гэх холбоо үгс бодит амьдрал дээр ямархуу харагддаг юм бол? Эзгүйрсэн хуарангууд өдөр хоногоор өнгө зүс гээн сааралтаж, ундуй сундуй орхисон зэвсэг техник хэсэг бусад үзэгдэнэ. Ил үлдээсэн нь иймэрхүү. Тэгвэл арван хэдэн жилийн хойно буюу өнөөдөр ч энд тэнд сум тэсэрч, хүүхэд голдуу гэмтэж бэртсэн тохиолдол дуулдсаар. Монгол нутагт оросууд ямар зэвсэг техник агуулж хадгалж байсныг тов тодорхой хэлж өгөх хүн байна уу? Байгаль экологт учруулсан хор хохирлыг тооцсон судалгаа бидэнд бий бил үү? Улаанбаатараас хориодхон километрийн зайд цөмийн зэвсэг хадгалдаг агуулах байсныг шинэ цагийн монголчууд дуулсан болов уу? Хөнөөлт зэвсгийг ерээд оны эхээр «төрхөмд нь» буцаасан. Харин ийм зэвсэг тээвэрлэх явцад аюул эндэл гараагүй өнгөрсөн нь зол. Цөмийн хаягдал шаарыг газрын гүнд булшлахаас илүү эрсдэлтэй тээвэрлэх ажил нь хүн ам төвлөрсөн Монголын хот суурингуудын дагуу болсныг бид мэддэг бил үү?

**1992 он.** Дэлхий ертөнц харьцангуй нээлттэй оршиж, цөмийн зэвсэг хэмээх нийтийн аюулт дайсныг хамтдаа устгаж эхэллээ. Хүн төрөлхтөн, өөрийн оюун тархиар бойжуулсан гамшгийг хэрхэн далд оруулахаа мэдэхгүй толгой гашилгав. Цөмийн аюулын хамгийн их нягтралтай бүсэд Монгол Улс хүйтэн дайны үед, одоо ч оршоор байна. Улаанбаатар орчимд төдийгүй манай өмнөд хилийн ойролцоо хөнөөлт зэвсгийн том агуулах байсан. Зөвлөлт Холбоот Улс, БНХАУ хоёр өөр зуураа дайсагналцсан тэр өдрүүдэд өмнөд хилийн чанадаас Монголыг чиглүүлэн онилсон цөмийн цэнэгт хошуу байлдааны бэлэн байдалд байсан юм. Ялимгүй үл ойлголцол, ухаанаа гэсэн хэнээрхэл сонсогдох төдийд манай нутагт үй олныг хөнөөх мөргөлдөөн гарч болзошгүй байсан гэдэг. Золоор хүйтэн дайны аюул шувтарчээ. Монгол Улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат, мөн үед гадаад бодлогын чиглэлээр ажиллаж байсан төрийн албаныхан хамгийн түрүүнд нэгэн санааг онцлон хөөцөлдөв. Тэр нь цөмийн зэвсэггүй бүс болох тухай Монгол Улсын шинэ санаачлага. Зөвлөлтийн нөлөөнөөс ангид, бие даасан гадаад бодлого явуулсан мөчөөсөө эхлэн монголчууд цөмийн аюулаас өөрийгөө хамгаалах арга зам хайсан гэсэн үг.

**2000 он.** НҮБ-ын Төв байр. Ерөнхий Ассамблейн 55 дугаар чуулган Нью-Йоркод нээгдээд удаагүй байлаа. Чуулганы нэгдүгээр хорооны хуралдааныг АНУ-ын тэр үеийн Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайтын шадар хүмүүсийн нэг, Төрийн департаментын Зэвсгийн хяналт, олон улсын аюулгүй байдлын асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Ж.Холум даргалжээ. 2000



оны аравдугаар сарын 5-ны өдрийн үдээс хойхно энэ танхимд тодхон сонсогдсон үгсийг дөрвөн жилийн дараа эргэн сануулахыг хүсч байна.

...Франц Улс, БНХАУ, ОХУ, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс болон АНУ нь, хэрэв Монгол Улс цөмийн зэвсэг хэрэглэсэн түрэмгийлэх үйлдлийн бай болох буюу түрэмгийлэх үйлдэл хийх аюул заналд өртөх аваас... Монгол Улсад туслалцаа үзүүлэх зорилгоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс даруй арга хэмжээ авахуулахад шийдвэр төгс байгаага дахин баталж байна.

...БНХАУ, ОХУ нь энэхүү асуудалтай холбогдуулан Монгол Улсын хувьд хүлээсэн эрх зүйн үүргүүдийг анхааралдаа авч, тэдгээрийг нотолж байна...

Ноён Холумыг үгээ дуусгамагц танхимд цугларагсад алга ташив. НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан, Гадаад хэргийн яамны газрын дарга нарт дэлхийн олон орны дипломатууд баяр хүргэн гар барьсан гэгээтэй мөчид тэнд байж, түүхэн агшныг гэрэл зургийн хальсанд үлдээх санаатай яарч явсан билээ. Энэ бол цөмийн зэвсэгтэй таван улс манай аюулгүй байдлын баталгаа өгөхийг зөвшөөрсөн аман мэдэгдэл байлаа. Өөрөөр хэлбэл, дэлхийд цор ганцаар тоологдох статусыг Монголд олгохыг дэмжсэн нааштай алхам юм. Өмнө нь буюу 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаас манай өвөрмөц статусыг баталгаажуулсан тогтоол гаргаад байв.

Дэлхийн улс төрийн бирж хэмээх НҮБ-д, түүнээс халин олон орны төр, засгийн тэргүүнүүдтэй уулзах үеэрээ манай төрийн өндөрлөгүүд, дипломатууд найман жилийн турш тууштай ярьж хөөцөлдсөний үр дүнг аравдугаар сарын налгар тэр өдөр үзсэн юм. Аливаа улсын гадаад бодлого, түүний тэргүүлэх чиглэлийг хэрхэн тууштай барьдаг, хагас алхам ч атугай урагшлуулж ашигтай «наймаа» болгохын тулд хүнд суртлын мянган даваа, ханцуйдаа тохирох олон эгзэгтэй хувилбар дээр «ажилладгийг» манай туршлагатай дипломатууд л сайн мэдэх биз ээ. Мөн онд Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын тухай хуулийг парламент баталлаа. Ер нь ийм нэг тодогтол монголчуудад яагаад тийм чухал болсон юм бэ? Хоёр хөрш маань хоорондоо зайгүй түншилж, хэн нэг рүүгээ цөмийн цэнэгтэй хошуу онилохоо больсон цаг шүү дээ. Хүйтэн дайны он жилүүдэд жижиг, жийргэвч улсын зовлонг амссаны хувьд, басхүү дэлхийн улс төрийн бирж дээр бие даасан тоглолт хийх боломж олсны эцэст Монгол Улс НҮБ-ын тогтоол, цөмийн зэвсэгтэй таван гүрний дэмжлэгийг «чулуу болгох» том бололцоог олж харсан. Энэ бол бага улс томчуудыг түшин эдийн засаг, экологийн аюулгүй байдлаа баталгаажуулах хамтын ажиллагааны эхлэл байсан.

Гэхдээ харамсалтай нь бид бараг юу ч хийж чадаагүй. Монгол Улсын гадаад бодлого дахь гуйвж дайвсан хачирхалтай алхмуудын тод жишээг одоо сонсьё. Юуны өмнө, НҮБ-ын хүндэтгэлт танхимд мэндэлсэн ёсорхуу баримт бичгүүд олон улсын эрхзүйн баталгаагүй байсныг санаарай. Баталгаажуулж, лавхан атгах алхмыг бид өөрсдөө ар араас нь шаргуу хийх ёстой. Ноён Холум Монголын талд дуугарч мэдэгдэл уншсанаас хойш дөрвөн он улирав. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан Төв Азийн жижиг улсад тун элэгтэй хандаж, түүний илтгэлд «зуд» хэмээх үг хүртэл ордог болсон үе. Саппоро хотноо нээгдсэн нэгэн хурлыг нэхэн саная. Цөмийн зэвсэгтэй таван улс хэдэн жилийн өмнө гаргасан мэдэгдлээ хараахан эрхзүйн үндэстэй болоогүйг нотолж, биднийг идэвхтэй ажиллахыг уриалсан юм. Үүний зэрэгцээ манай хилийн эргэн тойронд цөмийн хаягдал булшлах дэлхийн бизнес хэдийнэ яригдаж эхэлснийг Саппород хэлэлцлээ. Монголчууд дахин цөмийн аюулын нягтрал дунд амьдарч эхлэх нь. Ийм төрийн зэвсэг, хаягдал байршуулах, тээвэрлэхээс ангид байх баталгаа буюу нөгөө статус маань яалаа?!

Манай  
гадаад  
бодлогын  
луужин Төв  
Азийн  
авторитар  
дэглэмт  
хэдэн улс руу  
ямагт заадаг  
болов.



**2004 он.** Өнгөрсөн дөрвөн жилд өрнөсөн үйл явц НҮБ төдийгүй дэлхийн олон орныг гайхшруулав. Монголчууд ядаад хөршүүдтэйгээ гурван талт хэлэлцээр байгуулчих боломжийг ч хайхарсангүй. ОХУ, БНХАУ хоёр ийм хэлэлцээр байгуулж болохыг үгүйсгээгүй нөхцөлд шүү дээ. Бараг арваад жил амь тавин хөөцөлдчихөөд гэнэт чимээгүй болчихов. Цөмийн зэвсэггүй статусыг олон улсын тавцнаа эрхзүйн үндэстэй болгох нөр ажил гараандаа өндөрлөсний учир юу байв аа?

Төв Азийн цөмийн зэвсэггүй бүсэд хавсарга маягаар багтах огт өөр, шинэ мэргэн санаа сүүлийн цөөн жилд хүчээ авч орхилоо. Үүний хамт Шанхайн хамтын ажиллагааны байгууллагыг түшихээр сүжирсэн олон үйл явдал өнгөрсөн хугацаанд өрнөв. Манай гадаад бодлогын луужин Төв Азийн авторитар дэглэмт хэдэн улс руу ямагт заадаг болов. Зүүн хойд Азийг чиглэсэн хамтын ажиллагаанаас илүү өнөөх Назарбаев, Акаев, Ниязов, Каримов руу зүтгээд эхлэв. Ингэж бид салаа замаар будилсны эцэст Төв Азийн цөмийн зэвсэггүй бүсэд Монголтой хавсарч ханилахыг гишүүн орнууд нь дэмжсэнгүй. Түүнчлэн Орос, Хятадын хил хоорондын асуудлыг зохицуулах зорилгоор анх байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны түншлэлд монголчууд ажиглагчийн байр сууриасаа хэтрэн, дэндүү ойртон нягтрах гэж улайрах нь зөв бодлого уу? Тус байгууллагын гишүүн болсон тохиолдолд хөршүүдийнхээ амыг үг дуугүй харах гарцыг л бидэнд үлдээх биш үү. Тусгаар Монголын гадаад бодлого дахь ерээд оны бие даасан, зоримог алхмууд замдаа ийнхүү бүдгэрч эхэлжээ. Кофи Аннан хоёр жил тутамд тавьдаг илтгэлдээ Монгол Улсын тухай ямагт дурдаж байсан юм. Судлаачдын багаа НҮБ Улаанбаатарт илгээж, санаачлага чармайлт гаргалаа, биднийг дэмжлээ. Тэгтэл Улаанбаатар өөрөө өөнтөгч хүүхэн адил цаашаа хараад суучих юм. Шинжээчдийнхээ Монголд хийсэн судалгааны дүнг хэлэлцье, танай эдийн засаг, экологийн аюулгүй байдалд тустай ажил эхлүүлье хэмээн НҮБ биднийг «гуйж» эхлэв. Монгол Улсын Гадаад хэргийн яам уг хүсэлтэд хариу өгсөнгүй тун ч удав. Ийм хачин гуйвж дайвсан гадаад бодлогын талаар эрхэм Аннан НҮБ-ын 59 дүгээр чуулганы индрээс «уурандаа» дэлгэж орхиогүй нь яамай даа.

**2004 он**

## «Сайн» бизнес

Тэргээ  
тэргүй хоёр  
хөрш маань  
цөмийн  
хаягдлын  
агуулахаа  
манайтай хил  
залгуулан  
байрлуулах  
гэж буй  
нөхцөлд их  
говвиороо  
бизнес хийх  
учиртай гэсэн  
санаачлага ил  
сонсогдож  
эхэллээ.

Цөмийн зэвсэггүй статус өнөөдөр моодноос гарч орхижээ гэж бодъё. Тэгвэл хөнөөлт зэвсгийн хаягдлын бизнес ид моодонд орчихоод байна. Монгол Улс энэ удаа жийрэг орон бус, бүр бусдын хогийн сав болчихмоор дуулдана. Тайванийн «Алим» сонинд тавдугаар сард нийтлэгдсэн материал сэтгэл түгшээсэн юм. ОХУ-ын ДУМ-ийн депутат, «Нэгдсэн Орос» хөдөлгөөний зүтгэлтэн Р.И.Гималов Тайванийн Ерөнхий сайдын зөвлөхтэй уулзаж, тус арлаас Хабаровскоор дамжуулан Монгол руу цөмийн хаягдал зөөвөрлөх, улмаар манай говьд булшлах бизнесийн талаар маш нууц байдалд ярилцсан. Уг нууц уулзалтад Монголын төлөөлөгч оролцсон гэж тус сонин мэдээлснийг интернэтийн олон сайт цацав. Бүр цөмийн нэгж хаягдлыг 3000 ам.доллараас илүү үнэлэн, шаар булшлах бизнесээс Монгол болоод Орост ямар ашиг унахыг тооцсон байх юм.

Биднийг нөгөө «хэрэгтэй, хэрэггүй» нь мэдэгдэхгүй статусаа нэг хөөцөлдөж, нэг зүүрмэглэн, гуйвж дайван явах зуур эх дэлхий дэх цөмийн зэвсгийн үйлдвэрлэл болоод атомын цахилгаан станцын реакторуудаас гарсан хаягдал уул овоо мэт болоодохов. Зөвхөн Америкт гэхэд 52.000 тонн цацраг идэвхт маш аюултай хаягдал, бохирдсон багаж хэрэгсэл, хувцас сэлт овоорчээ. Тиймээс АНУ, ОХУ зэрэг том гүрэн хаягдлаа үгүй хийх арга чарга сэдэн өөр зуураа хэдийнэ өрсөлдөж эхэллээ. Хэдэн мянган жилийн настай хорт хогийг зэвэрдэггүй ган мэтийн эдээр хийсэн олон давхар нүсэр байгууламжид хадгалах ёстой гэнэ. Асар их дулаан ялгаруулдаг ийм хаягдлын эвдэж идэх хүч, хөнөөлийг нарийн тооцоход бэрх. Юутай ч, ус бороо үл хүрэх хуурай газар түүнийг далдхан булах учиртай юм. Тийм тохиромжтой нутгийн тоонд Монголын говь оржээ. Мөн манай хоёр хөршийн хил дагуух зэлүүд нутгуудад цөмийн шаар булшлах агуулах байрлуулахаар ид ярилцаж байна. Ийм халуун яриа монголчуудын ирээдүй, хувь заяатай холбоотой болохоор бид эрхгүй анхаарал тавьж эхлэв. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ тухай ярилцаж байгаа гэж найдъя. Манай зарим «овсгоотой» улстөрч цөмийн хаягдлаар ашигтай бизнес хийж, эдийн засгаа өөд нь татах санаачлага дэвшүүлж сууна. Тэртээ тэргүй эзгүйрсэн их говио ийм янзаар «эргэлтийн хөрөнгө» болгоё гэнэ. Юуны өмнө, энэ бол олны сонорт хүргэх, ярилцах, сэрэмжлэх ёстой асуудал.

Шинэ бизнес эхлэх гэж яарахынхаа наана бодуштай бас нэг зүйл бий. Казахстаны Семиплатинск болон Хятадын Лоб нуур орчмын полигонд нийтдээ цөмийн 500 гаруй туршилт хийсэн гэдэг. Эдгээр туршилтын үр дагавар Монголын өмнөд, баруун нутгийн ард иргэд, амьтан ургамалд хэрхэн нөлөөлсөн бол? Бүх нутгийг хамарсан судалгааг бид хараахан хийгээгүй байгаа. Харин өнгөрсөн сард МУИС-ийн харьяа Цөмийн лаборатори санаачлан баруун аймгуудад ажиллажээ. Тэнд үүсмэл цацраг идэвхт бодисын тархалт хэвийн хэмжээнээсээ илүү байгаа үзүүлэлт гарсан юм. Казахууд Алтайн нурууны салбар уулсад хаягдал аваачиж булдаг байсан тухай хэдэн жилийн өмнө хэвлэлүүд шуугисан. Үүнийг нотлох гэсэн мэт Алтайн хязгаарын оршин суугчдадаа ОХУ-ын Засгийн газар хохирол барагдуулах мөнгөн төлбөр өгсөн тухай мэдээлэл бий.

Цөмийн шаарыг нутагтаа авчирч булах өнөөдөртөө дуу алдам ашигтай байлаа ч ирээдүй хойчдоо асар хөнөөл дагуулах бизнесийн тухай яриа ийнхүү сонор дэлдээд байна. Мөнөөх унацтай бизнес манай гадаад бодлогыг 180 градус эргүүлж орхисон юм болов уу. Тэртээ тэргүй хоёр хөрш маань цөмийн хаягдлын агуулахаа манайтай хил залгуулан байрлуулах гэж буй нөхцөлд их говиороо

бизнес хийх учиртай гэсэн санаачлага ил сонсогдож эхэллээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс 1992 оноос өмнөх үеийнх шигээ аюул эгзэгтэй орчинд өнөөдөр ч оршсоор байна гэсэн үг. Хожмын ийм байдлыг төрийн зүтгэлтнүүд маань эртнээс мэдэрч, бие даасан статусын санааг 12 жилийн тэртээ дэвшүүлсэн юм биш үү. Гадаад бодлогын залгамж чанар, хар хайрцагны бодлого гэгч нь хэдэн янзаар хувирч өөрчлөгдөөд байвал нэгэн цагт үндэсний аюулгүй байдалд үлэмж хохиролтой. Монгол Улсын хил дагуу хорь гаруй болзошгүй Чернобыль байгааг мэргэжилтнүүд сануулсаар байна.

**2004 он**

# Тони Блэйрийг түүх уучлахгүй

Их Британийн Ерөнхий сайд Иракийн дайны галыг сөрж чадах байлаа. Өнгөрсөн оны есдүгээр сараас эхлэн дэлхийн хүмүүсийн тархи толгойд дайн зайлшгүй тухай бодол санааг АНУ-ын засаг захиргаа аажмаар шургуулан лавшруулсан. Хэрэв өнгөрсөн намар АНУ холбоотонгүйгээ мэдсэн бол байр суурьтаа өнөөдрийнх шиг ингэтэл итгэлтэй байхгүйсэн. Тони Блэйр Арабын ертөнцөд гал дүрсхийлгэх санааг дэмжээгүй бол Европ ганцхан байр суурь дээр нэгдэж чадах байв.

Эдүгээ дэлхий **Франц-Герман-Орос-Хятад** ба **АНУ-Их Британи-Испани-Австрали** маягаар хуваагдсан лидерүүдтэй боллоо. Арабын ертөнц харин хохирогчийн дүрд тоглож, тэндээс цусан өшөөний хорон санаа ил тод дуулдана. Ойрхи Дорнодод халуу шатахаас наана Багдадыг буулгаж авахаар холбоотны цэрэг улайрчээ. Гэвч тэнд байгуулсан ялалт бүр нь ард үлдсэн эх нутгийнх нь энх амгаланг сулруулж байна. Персийн булангийн эхний дайны ялалтын үнэ цэнийг 2001 оны есдүгээр сарын 11-нд гашуунаар төлөөгүй бил үү? Дайн хэзээ дуусах вэ гэсэн асуулт хүн бүрийн толгойд яваа. Гэсэн ч Персийн булангийн хоёр дахь мөргөлдөөний төгсгөлийг «тэдний өдөр» хэмээн хэн ч тодорхойлж чадахгүй. Гагцхүү тарих үр дагавар нь асар их бус байж, өс хонзонгийн шарх түргэхэн аниасай хэмээн залбирахаас өөр аргагүй.

Иракт өрнөж буй үйл явдал бүр ертөнцийн хүмүүсийн амь зуулга, аюулгүй байдалд цахилгаан гүйдэл лугаа богино хугацаанд үйлчлэх жишээг дайн эхэлснээс хойшх 14 дэх энэ өдөр улам бүр мэдэрч сууна. Гуравдугаар сарын 19-ний лхагва гаригийн үдэш Нью-Йоркийн барааны бирж ердийнхөөрөө үүдээ барьж, амьдрал амгалан үргэлжилж байлаа. Тэр үдэш Уолл Стрит гудамж дахь аварга том цахим самбарт нэг баррель нефтийн үнэ 30 ам.доллар гэсэн үзүүлэлт гялалзан урсч байв.

-Гэсэн ч тэр шөнөдөө Томагавк пуужингууд Багдадыг бөмбөгдөж эхлэхэд бид Саддам Хусейн болон түүний ахмадууд амь үрэгдсэн гэж бодоцгоосон. Яг тэр мөчид интернэтийн худалдааны дүнд нэг баррель нефть хоёрхон ам.доллар болж унасан гэж Нью-Йоркийн барааны биржид нефть арилжаалдаг Эрик Боллин өгүүлжээ.

Харин маргааш өглөө нь юу болсон гэж санана. Пүрэв гаригийн бага үдийн 11.30 цагт /Америкийн цагаар/ Саддам амьд төдийгүй Кувейт рүү хариу пуужин харвалаа гэсэн мэдээг телевизүүд дамжуулж эхлэв. Ингэмэгц нефтийн үнэ эргээд өсч, лхагва гаригийн үдшийн заалтдаа хүрлээ. Удсан ч үгүй Иракт нефтийн зарим цооног шатаж эхэллээ хэмээн CNN мэдээлмэгц нөгөө үнийн дүн улам баталгаажив. Ойрхи Дорнодоос ирэх шинэ мэдээ бүрийг биржийн дилерүүд ангайтал сонсч, тасралтгүй хангинах утсаа ч авахаа мартжээ. Тэднээс дутахгүй бухимдсан үйлчлүүлэгчид нь «Яаж байнаа, ямар хандлага харагдана» хэмээн дэмий сандчин зааварлана. Яг энэ хоромд Иракт унаж буй бөмбөг бүр биржийн уур амьсгалыг эвдэх энүүхэнд, цаашлаад дэлхийн аюулгүй амьдралд хөнөөл зөгнөсөөр байна. Амьдрал маань кино шиг хачин гэнэтийн баримтуудаар ч баяжив. Хими, бактерлогийн зэвсгээс өөрийгөө хамгаалах сургалт дамжааны тухай өмнө нь ер сонсч байв уу? Тэгвэл ийм дамжаа Их Британи, АНУ болон тэдэнтэй эвссэн зарим оронд хичээллэж, иргэд нь суралцаж эхэллээ. Хамгийн эхний сонсогчид нь сэтгүүлчид, олон нийтийн байгууллагын ажилтнууд, сайн дурынхан байсан гэнэ. Персийн буланд ажиллах голдуу хэвлэл мэдээллийнхэн багтсан анхны 150 төгсөгч тус бүр зургаахан

Яг энэ хоромд Иракт унаж буй бөмбөг бүр биржийн уур амьсгалыг эвдэх энүүхэнд, цаашлаад дэлхийн аюулгүй амьдралд хөнөөл зөгнөсөөр байна.



**Дайны төгсгөлийг «Хэдний өдөр вэ?» гэж бүү асуугаарай. Элдэв үр дагавар нь бага байгаасай хэмээн бодож сууя. Түүнийг эхлүүлэлгүй хазаарлах боломж уг нь Кофи Аннанд бус, Тони Блэйрт байлаа.**

---

өдрийн сургалтын зардалдаа 3200 ам.доллар төлсөн хэмээн «Herald Tribune» мэдээлжээ. Тэд дамжаагаа хоёрдугаар сард төгссөн бөгөөд байлдааны ажиллагааны явцад, тэр бүү хэл хулгайлагдах аюулд өртсөн үед биеэ яажшуухан авч явсан нь дээр вэ гэдгийг хүртэл заалгасан гэнэ. Одоо үүнээс ялимгүй өөр төрлийн дамжаанд биотерроризмд өртөж болзошгүй том хотын иргэд хамрагдаж байна. АНУ-ыг дэмжин эвсэлд нэгдсэн Монгол Улсын иргэд бид ч юмыг яаж мэдэх вэ, элдэв тохиолдолд биеэ бэлдэхэд илүүдэхгүй ч юм бил үү.

Дайны төгсгөлийг «Хэдний өдөр вэ?» гэж бүү асуугаарай. Элдэв үр дагавар нь бага байгаасай хэмээн бодож сууя. Түүнийг эхлүүлэлгүй хазаарлах боломж уг нь Кофи Аннанд бус, Тони Блэйрт байлаа.

**2003 он**



## **«Өнөөдөр» сонины электрон шуудангийн хаягаар дайн эхэлсэн мөчөөс олон зуун захидал хөвөрсөн билээ.**

### **САН-ФРАНЦИСКОГ ЗҮГЛЭХ ГЭЖ БАЙГАА БОЛ АЗНААРАЙ**

Сайн байна уу? «Өнөөдөр» сониныхон. Гуравдугаар сарын 20-ны өдөр Сан-Франциско хотод дайныг эсэргүүцсэн томхон цуглаан болж хоёр том замын гуч гаруй уулзварыг хаасан. Үүнээс болоод нийтийн бүх тээвэр зогссон тул арван минут яваад очдог ажилдаа 50 минут алхаж хүрлээ. Зам зууртаа жагсаал цуглаан хийж байгаа хүмүүсийн хажуугаар гарахад тэд голдуу залуус, сайн ажиглах юм бол амьдрал нь тийм тогтсон биш болов уу гэмээр хүмүүс харагдав.

Хамар амаа боосон, нэлээд бэлтгэлтэй ирсэн нь харагдаж байлаа. Тэдний зарим нь унадаг дугуйгаараа зам хөндлөн хаажээ. Цагдаа амжиж ирээгүй бололтой. Машинтай улсууд дараа дараагаар сигналдаж, бухимдаж байгаа нь харагдсан. Хүмүүс «Мөнгөө эрүүл мэнддээ заръя», «Дайнд бүү мөнгө зар» гэсэн нэлээд эдийн засгийн угтатой үгс бүхий лоозон барьжээ. Цагдаа нар балмагдсан юм уу, эсвэл сайн зохицуулалт хийж чадахгүй байгаа юм шиг санагдсан.

Орой гэртээ ирээд телевиз харж байхад жагсагчид 20 цагаас хойш улам чангарч, элдэв зүйл эвдэн нэлээд зөрчил гаргасан тул 1400 орчим хүн баривчлагдсан гэж мэдээлэв. Сан-Франциско хотын цагдаагийн удирдах ажилтан ийм том хэмжээний цуглаан анх удаа боллоо гэж байсан. Нэг жагсагч урьд өдөр нь Golden Gate гүүр дээр лоозонгоо тогтоох гэж байгаад далайн ус руу унаад аврагдаж чадалгүй үхсэн юм билээ. Дэлгүүрүүд

болон албан газар хэвийн ажиллаж байв. Бензиний үнэ өдөртөө бараг арван центээр нэмэгдсэн нь их содон харагдаж байсан.

Сан-Франциско хотын Урлагийн музейн нээлт болох үед олон мянган хүн түүнийг үзэхээр ирлээ. Тэнд харуул хамгаалалт маш сайн байсан юм. Монголчууд бид энэ нээлтэд ардын урлагийн тоглолтоороо оролцсон. Цагдаа нар ч их зохион байгуулалттай ажиллаж, хурдны зам руу хүмүүсийг оруулсангүй. Том замууд хаагдаад шальтай юм болсонгүй. Калифорни мужийн олонх хүн цагаачдаас, тэр тусмаа азиудаас бүрдсэн тул энд монголчуудад элдэв шахалт хавчилтгүй. Дайн эхэлсэн гээд эндхийн монголчуудад шууд хохирол учраад байсан юм алга. Гэхдээ ажлын байр цөөрч, гуанз ресторан хаагдан манайхан ажилгүй болсоор байна. Шинээр ирсэн хүмүүст ажил олох нь нэн бэрх байгаа. Тийм учраас Монголоос энэ хотыг зүглэн мордох гэж байгаа хүмүүс жаахан азнахыг зөвлөж байна. Америкт ажил хийхгүйгээр амьдрахад нэн түвэгтэй.

Манайхан энэ дайны учрыг сайн ойлгоогүй ч, өөр хоорондоо түгшин хөөрөлдөж, юу болж байна хэмээн бие биеэсээ сураглаж байна. Дайн эхэлснээс хойш хоёр хоногийн байдал Сан-Франциско хотноо иймэрхүү байна.

**Ш.Баатар /Сан-Франциско/**

## ИРАКИЙН АРД ТҮМЭН АЗТАЙ

Танай сониныг өдөр болгон интернэтээр уншиж мэдээлэл авч байгаадаа маш их баяртай байдгаа юуны түрүүнд хэлье.

Дайн эхлээд долоо хонолоо. Энд амьдрал хэвийн хуучин шигээ л байна. Миний бодлоор Иракийн ард түмэн нэг талаар азтай хүмүүс. Учир нь, Америк, Их Британи зэрэг өндөр хөгжилтэй холбоотнууд Саддамын дэглэмийг устгаж ардчиллыг эхлүүлж байгаагаараа гэд азтай юм. Дөнгөж сая Кэмп-Дэвидэд Буш, Блэйр хоёр уулзсан тухай мэдээ гарлаа. Сүүлийн

таван жилд Иракт таван нас хүртэлх 400.000 хүүхэд Саддамын дэглэмээс шалтгаалж өвчин, өлсгөлөнгөөр үхсэн гэнэ. Үнэхээр Саддамын дэглэм аймшигтай байсан. Мэдээгээр гарч байгаа хүмүүсийн өмссөн хувцас, байр байдал дэндүү ядуу, цэргүүдийнх нь царай зүс гундуу харагдах юм. Иракийн цэргүүдийг зөвхөн талх, усаар л хооллодог гэж сонин дээр бичжээ. Арай худлаа байлгүй. Бууж өгч байгаа цэргүүдийг бид азтай хүмүүс гэж яришдаг.

Тунгалаг Шарая /АНУ/

## ЯНЗ БҮРИЙН ТҮГШҮҮР ЗАРЛАДАГ БОЛСОН

Сайн байна уу? «Өнөөдөр» сонины хамт олон. Миний нэрийг Мөнх-Эрдэнэ гэдэг. Би АНУ-ын Өмнөд Колородагийн Бревард гэдэг жижигхэн хотод дээд сургуульд сурдаг. Танай сонины асуултад өөрийн саналыг бичье.

Миний сурч буй сургуульд нэлээд хэдэн дүрэм шинээр гарсан. Бор түвшний, хар түвшний гэсэн хоёр төрлийн түгшүүрийн байдал шинээр бий боллоо. Үүнээс гадна олон түгшүүр бий. Заримдаа сургуулилалтын зориулалтаар түгшүүр зарладаг. Сургуулийн өмнөх туслах замаар сургуулийн автобус болон багш нарын машин, зөвшөөрөлтэй машинаас бусдыг явахыг хориглосон. Дайн эхэлснээс хойш миний байгаа хотын хүмүүсийн хувьд олонх нь хэтэрхий туйлшран дайныг дэмжиж байна. Энэ хотод зургаан монгол

байдаг. Тэд дайныг эсэргүүцэж байгаа.

Бензиний үнэ буурахын зэргэцээ хийний үнэ хямдарч байгаа болохоор хүмүүсийн хувьд их ашигтай. Зарим төвүүд хийнхээ үнийг арав гаруй центээр буурууллаа. Мөн дайнаас болж хүмүүс бизнесээ алдаж байна гэж дуулдсан. Ялангуяа Калифорни хавийн төвүүд, зарим компани бизнесээ алдсан болохоор хэсэг монголчууд ажилгүй болсон. Гэхдээ тийм ч их өндөр хувьтай биш байх. Хүмүүс дайны сургаар элдэв жижиг зүйлс худалдаж авахаар мөнгөө зарцуулахгүй байгаа.

Би танай вэбийг маш их үнэлдэг шүү. Учир нь мэдээллээ түргэн шинэчилж, шинэ соргог мэдээллээр дүүрэн учраас гадаадад байгаа бидэнд маш их тус хүргэдэг гэдгийг уламжилъя.

Мөнх-Эрдэнэ /АНУ/

## ДАЙН ХУРДАН ДУУСААСАЙ

АНУ-ын Вашингтон хотын дүүрэгт хамрагдах Александра хотоос мэндчилж байна. Энэ хавийн монголчуудын нэг болох бидний хувьд өнөөдөр хаврын урь орсон жирийн нэг өдөр л болж өнгөрлөө.

Байдал ямар байгааг харахаар Вашингтон хотын төвөөр гэр бүлийнхэнтэйгээ явж үзлээ.

Хотын төвд дайныг эсэргүүцсэн бага хэмжээний тайван жагсаал болж өнгөрөв. Цуглаан болж байгаа

газраас холгүй орших газарт нийслэлийн оршин суугчид хүүхдүүдийнхээ хамт амарч, цаасан шувуу нисгэх тэмцээн зохион байгуулж байв. Олон хүн ирсэн байлаа. Анхны Ерөнхийлөгч Вашингтонд зориулсан гэрэлт хөшөөний орчимд хөдөө орон нутгаас ирсэн олон тооны жуулчин хөлхөлдөж, гэрэлт хөшөөг үзэхээр дугаарласан төдийгүй тэр хавийн зүлгэн дээр гэр бүлээрээ тоглож наадацгааж байв. Орой болох үед дэлхийн аварга шалгаруулах уран гулгалтын тэмцээнийг үзэхээр олон хотоос хүмүүс ирсэн гэж телевизээр мэдээлж байсан. Дайны тухай телевизээр дэлгэрэнгүй мэдээлж, Цагаан ордон болон Конгрессын байранд жуулчин орохыг түр хаасан, цагдаагийн байгууллага өндөржүүлсэн бэлэн байдал зарласан, онгоцны буудал дээр автомат буутай хамгаалалтын хүмүүс харагдаж байгаагаас өөрөөр дайны талаар энд илт мэдрэгдэх зүйл

алга.

Амралтын өдрөө хоолны газар руу гэр бүлээрээ хуучны адил явцгаасаар л. Биеийн тамирын заалаар ороход хананд байрлуулсан телевизээр сагсны тэмцээн, дайны явцын талаар мэдээлэл зэрэг явж байсан. Баараар ороход мөн л энэ хоёр чиглэлийн мэдээ гарч байна. Дайны тухай мэдээллийг илт шимтэн үзэж буй хүн алга. Нэгэнт дайн эхэлсэн тул хурдан дуусч, цөөн л хүн амь үрэгдээсэй хэмээн залбирч байна хэмээн ярьцгааж байна.

Энд би зарим монголчуудтайгаа ярилцсан. Тэд өөрсдөд нь нэг их хамаатай зүйл гэж бодохгүй байгаа бололтой сэтгэгдэл төрлөө. Миний хувьд ажлаа хийгээд, амраад байж байна. Хариу цохилт үзүүлж болзошгүй хэмээн үзэж буй газруудаас хол явах нь зөв болов уу гэж гэр бүлийнхэн маань зөвлөсөн.

**П.Энх-Оюун /Александра/**

## **МОНГОЛ УЛС ДАЙНЫГ ДЭМЖСЭНД ХАРАМСЧ БАЙНА**

Танай сонинд дайны тухай санал асуулга гарчээ. Би товч саналаа илгээж байна.

Ямар ч дайныг сайн сайхан, зөв гэж хэлэхгүй. Иракт довтолсон явдал нь улс хоорондын харилцаанд хэвших хандлагатай байсан энх тайванч зарчмуудыг сүйрүүлэх алхам. Цаашид «Хүчтэний өмнө хүчгүй нь буруутай» гэдэг бодлого газар авч магад.

Манай хөрш хоёр улс энэ

дайныг зогсоож, энхтайвны замаар асуудлыг шийдэх, гэмгүй олон мянган хүний амь насанд заналхийлж буй аймшигт аллагыг зогсоохыг АНУ-аас шаардаж мэдэгдэл гаргалаа. Гэтэл үүнтэй яг зэрэгцээд манай Гадаад яам Иракийг «зодож» байгаа нь зүйтэй тул дэмжиж байгаа гэсэн утгатай санаа илэрхийлсэнд харамсч байна.

**Лханаа**

# Вьетнамын шинэ дайнд Монгол Улс «торгуулийн ротоо» илгээв

Трой хотыг эзлэх гэж асар том модон морь бодож олсон түүхийг эдүгээ Европын хэвлэлүүд олонтаа дурсах болжээ. Модон морь дотор польшууд нуугдсан. Европын холбооны бие даасан гэр бүлд нэвтрэх гэсэн америк зорилгыг мөнөөх польшууд морин дотроос шөнө дөлөөр сэм гарч биелүүлэх юм гэнэ дээ. Тааруухан ёгтлолд тэд өргжээ. Унаган тивдээ ийм онигоонд ороод байгаа польшуудтай монгол цэргүүд ирэх долоо хоногоос эхлэн мөр зэргэцэн алхах гэж байна. Тэдний хамт эстон, киргиз, казах, узбек, филиппин, тайланд гээд 19 орны залуус бий. Хэн хэн нь төрсөн нутгаасаа тэргээ холыг зорьжээ. Түүхийн номонд Вавилон хот хэмээн тэмдэглэдэг газарт юуны ч төлөө юм бэ буу агсан ази, европ царайтнууд нэг дивизэд хуваарилагджээ.

Дэлхийн хүмүүсийг үй олноор хөнөөхөөр хураасан Иракийн их зэвсэг хаана байгаа юм бол. Ялалтын үнэ цэнийг ёслолын буудлага, цогтой уран үгс бус, цаг хугацаа шүүж байна. Үйл явдал ингэж эргэх тусам Арабын ергөншөд хорсол зузаарч, өдөр өнжихгүй бөмбөг тэсэрч эхэллээ.

Манай 180 иргэн Иракийг зорьсон нь Польшийн 2500, Их Британийн 13.000, АНУ-ын 146.000 цэргийн албан хаагчтай харьцуулахад их цөөхөн сонсогдож магадгүй. Монголын мотобуудлагын ротын 120 дайчин, 50 хүнтэй барилгын салаа, дивизийн штабт ажиллах дөрвөн офицер, цөөн эмч дээр нэмэгдээд өнөөдөр дахин дайчин эрс явах гэж байна. «Хэдэн хүн нэмж нисэх вэ» гэж асуувал Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч Г.Рагчаа хурандаа «Тоог нь мэдэж яах нь вэ?» хэмээн эргүүлж лавлав. Тэр Энхийг сахиулах ажиллагааны газрыг бас тэргүүлдэг. Сэтгүүлчдэд задруулж болохгүй олон зүйлийг хурандаа мэддэг агаад монгол залуус Иракийн нутгийн яг хаана хамгаалалтын үүргээ биелүүлэхийг тодруулж өгөхийг гуйхад «Багдадаас 100 гаруй километр, дивизийн хангалтын баазад» хэмээн товч хариулав. Байлдааны ажиллагаа, байршлын тухай Г.Рагчаа илүү дэлгэрэнгүй ярих боломжгүй гээд Монголын хэсгийг ахалж яваа хошууч Б.Баярмагнайтай сансрын холбоогоор өдөр тутам харилцдагаа дуулгалаа.

Гэхдээ интернэтэд байнга шинэчлэгдэн тавигдаж буй мэдээллээс Польшийн сектор буюу хариуцлагын бүс нь хаахна байрладгийг багцаалахад төвөггүй. Польшийн «The Christian Science Monitor» сонинд дурдсанаар хэдхэн өдрийн өмнө террорист халдлага болж, олон сүсэгтэн амь алдсан Нажаф хотоос холгүй эртний түүхт Вавилон орчимд эдний хэсгийн командлал оршдог. Одоогоор Нажафын эргэн тойронд америк цэргүүд сонор сэрэмжтэй жижүүрлэж байна. Тэд энэ сарын 21 хүртэл Нажафыг хяналтдаа байлгана. Мөнөөх олон орны цэргүүд адилгүй тоотой шигээ өөр өөр зорилго өвөрлөн энд иржээ.

## ХЭН ЯМАР ЗОРИЛГОТОЙ ВЭ?

Эхлээд манайхантай дивиз нэг польш эрсийн тухай эргэцүүлье. Батлан хамгаалахын сайд нь өөрийн биеэр тэдэнд тонн тонноор хиам зөөж очихыг бодвол 2500 цэрэг чухал даалгавартай бололтой. «Энхийг сахиулах томоохон үйлсэд оролцож үзэх, ингэснээр эх орны нэрийг өндөрт өргөх» гэсэн хоосон лоозон тэдэнд хэлж өгөөгүй. Польш улс «Иракийн энх тайван» ажиллагаанд тооцоотой оролцож байгаагаа нэрэлхэлгүй зарлаж байна. Нэрэлхээгүй учир «төрсөн» тив Европтоо амьтны ярианы бай болж орхив. Бүр Иракийн дайн эхлэх мөчид л тус улсын АНУ-тай ойртсон түншлэлийг «өхөөрдсөн» ёжтой үгс ялангуяа Европын хэвлэлүүдэд нийтлэгдэж эхэлсэн. US тэмдэгтэй том

том танкуудын араас гүйлдэх жижигхэн дайчдаар төлөөлүүлэн шоглон зурж байлаа. Хөгшин Европтой эдүгээ харилцаа суларч, шинэ Европ гэсэн хэллэг түлхүү хэрэглэх болсон америкчуудын хувьд Польш улс чухал хамсаатан болжээ. НАТО-гийн цөм нь төв Европ руу шилжиж, Польш олон улсын тавцнаа нэр хүндээ улам өргөх бодолтой байна. Түүнчлэн Иракийн нефтийг ихээхэн сонирхож буйгаа Гадаад хэргийн сайд нь илэн далангүй ярьсан юм. Энэ бүхний хариуд, Польш ирэх хавар Европын холбоонд нэгдэж чадах эсэх нь эргэлзээтэй харагдаж, улстөрчдөд бие биеэ буруутган хэрэлдэх том сэдэв мөн гарч иржээ. «Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээ тивийнхээ зах зээлд зохицуулж дийлэхгүй мунгинаж байж Иракийг тохинуулах юм гэнэ» хэмээн сөрөг хүчнийхэн шорвог үгс чулуудав.

Польшийн 2500 дайчин хэдий ардаа хэл амтай явсан ч лав хоосон уриагаар цэнэглэгдэж, буу зэвсэг агссангүй. Дэлхийн тавцанд нутгийн нэр хүндийг илтэд өргөж гаргана, нефтьтэй ч болно хэмээн тэвчээр заах итгэл үнэмшилтэйгээр Иракт иржээ.

### ХАРИН МОНГОЛЧУУД?

Том саарал онгоцонд тэд маань зүгээр л суугаад явчихаагүй юм. Батлан хамгаалахын Төрийн нарийн бичгийн дарга С.Баасанхүүгийн хэлснээр «Монгол Улс, түүний зэвсэгт хүчин даян дэлхийд энхтайвныг бэхжүүлэхэд өөрийн бодитой хувь нэмрээ оруулж буй» гэгээн зорилготой. Гэхдээ юуны төлөө залуус уурсан арабуудын цусан өшөөний уриа сонсч явна вэ? Дахиад Төрийн нарийн бичгийн даргын тайлбарыг унш... Бас л ойлгосонгүй. Монгол Улс НҮБ-ын тэмдэг дор энхийг сахиулах бүрэлдэхүүнд оролцон үүрэг гүйцэтгэж яваасан бол Нью-Йоркод намирч буй далбаагаа санаад нэг зүйл сэтгэлд торох байлаа. Гэвч энэ ажиллагаа Аюулгүйн зөвлөлийн шийдвэргүй эхэлсэн тул НҮБ-ын мандатгүй. Холбоотны ариун дайн, эцэст нь эвслийн энхийг сахиулах ажиллагаа гэж нэрлэсэн Иракийн үйл явдлыг дипломат ёсонд хэрхэн томъёолох, цаашид мухардлаас яаж гаргахыг дэлхийн улстөрчид одоохондоо ханцуйдаа тохиролцож байна.

**-НҮБ-ын цэнхэр далбаан дор бус, Америкийн холбоотон болсон учир, зорилгыг Польшийн дарга нар шиг нэрэлхэлгүй тайлбарлаж өгнө үү?**

-Наадах чинь улстөрчдөөс асуух зүйл. Засаг, төрийн шийдвэр гарч тангараг өргөсөн цэргийнхэн Иракт очоод байгаа хэрэг. Засаг, төр биднээс өргөн хүрээтэй бодож буй биз. Хувийн бодлоо хэлэхэд манай улс төсвийн цоорхойгоо өмнө нь ч, одоо ч тусламжаар нөхөж явна. Жилд АНУ-аас арван хэдэн сая долларын дэмжлэг авдаг, дэлхийн санхүүгийн гол байгууллагууд тус улсын нөлөөн дор байдаг зэргийг бодолцох ёстой. Зөвхөн цэргийн чиглэлээр гэхэд АНУ-аас манайд хоёр том хөтөлбөр хэрэгжиж байна. Офицер, дайчид хэл сурах боломж зэргийг эндээс л бид олж байна шүү дээ. Тэгэхээр АНУ-ын тусламжид хариу өгөх манай ганц чадвар маань энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох явдал. Тэгээд ч Таван толгойд хээрийн сургууль хийгээд юухан мэдэж сурах билээ. Хал үзэж байж жинхэнэ цэрэг болдог биз дээ. Манайхан ийм ажиллагаанд оролцох ёстой гэж Г.Рагчаа хурандаа хариулсан юм.

**-Тусламжийн цуваа, объект хамгаалах үүргийг Монголын рот биелүүлнэ гэлээ. Гүйцэтгэх үүрэг болон хуваарилагдах сектороо өөрсдөө сонгох боломж манай талд байсан уу?**

-Сонголт байлгүй яахав. Манайхыг уг нь шал өөр ажилд хуваарилж байсан юм.

**-Анхны хохирол амсвал яах вэ? Цэргүүдээ эргүүлэн татах уу?**

-Ямар хохирлыг хэлээд байна? Олон янзын хохирол бий шүү дээ.

**-Анхны хохирол амсвал яах вэ?**

**Цэргүүдээ эргүүлэн татах уу?**

-Ямар хохирлыг хэлээд байна? Олон янзын хохирол бий шүү дээ...

**-Мэдээж амь насаа алдах вий гэж монгол хүн бүр эмээж байна.**

-Хохирол гарч болно. Үүнийг хэн ч үгүйсгэхгүй. Гүрж, Болгар, Румыны цэргийнхнээс үрэгдсэн тохиолдол бий. Эрсдэлгүй ажиллагаа гэж үгүй. Манайхныг бодвол харьцангуй түгшүүртэй дөрөвдүгээр буюу хойд бүсэд ажиллаж буй Гүржийн дайчдаас амь алдаж, таван хүн шархадсан мэдээ байна. Харьцангуй их хохирол гарвал хүмүүсээ татаж л таарна. Тийм эрх Засгийн газарт байгаа гэв.

Г.Рагчаагийн тайлбарласнаар, хэрэв Иракт НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд оролцож байсан бол Монгол Улсад цэрэг, улс төрийн төдийгүй санхүүгийн ашиг ирэх юм. Энхийг сахиулах нийт зардлынх нь 0.01 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг манайх НҮБ-ын төсөвт төлдөг.

Тиймээс татвар төлснийхөө хариуд улс орнууд зохих санхүүгийн дэмжлэг авах боломжтой гэнэ. Харин өнөөгийн Иракийн тохиолдолд НҮБ орлоогүй байна. Тиймээс Монголд ирэх ашиг тус нь дээр өгүүлснээр зөвхөн «Америкийн жил тутам тусалдаг арван хэдэн сая долларын хариу» маягаар харагдана. Залуусын тухайд, тэд ирээд хамгийн түрүүнд сургалтад хамрагдах гэнэ. Мөн цэргийн мэргэжлийн зэрэг нь ахина. Цалин хөлсний талаар АНУ-тай ярьж буй зүйл ч бий бололтой.

## ӨӨР НЭГ АСУУЛТ

Америк цэргүүдэд Олон улсын эрүүгийн шүүхийн болон байгаа улсынхаа шүүхийн өмнө ял сонсохгүй мултрах боломж олгон бид гарын үсэг зурсан. Сайхан сэтгэлтэй л юм. Гэхдээ 180 дайчин маань яагаад Багдадыг зорьсныг эргээд тодруулах цагт хэн царай өгөх бол? «Олон хүний дотор янз янз байх явдал гарч болох. Цэргийн албан хаагч гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хүнээ яаж ийгээд л татаж авна шүү дээ» хэмээн хариулахдаа Г.Рагчаа ялимгүй эгдүүцэв. Дэлхийн олон оронд ажиллаж, энхийг сахиулах чиглэлээр чамгүй туршлага хуримтлуулсан ясны цэрэг эр түүнээс дайчдынх нь тухай элдэв зүйлийг муу амлан шалгаах аятайхан байгаагүйг өчье. Халуун цэгүүдэд ажиллаж буй монголчуудынхаа хойноос сэтгэл тавьж, бидний санаанд ороогүй зүйлсийг хүртэл хөөцөлдөж явдгийг ярианаас нь ойлгосон билээ. Магадгүй асуултуудаа би түүний хэлснээр улстөрчдөд тавих ёстой байсан биз.

## ГАРЦ ХААНА БАЙНА?

Ёслолын буудлагаа тавьсан америк цэргүүд харихыг яарч байна. Аль тавдугаар сарын 1-нд Ж.Буш Иракийн дайнд ялснаа зарлаж, нэр хүнд нь ч овоо өндөрт намирч байлаа. Түүнээс хойш дөрвөн сар өнгөрөхөд АНУ-ын Ерөнхийлөгчийн рейтинг олны дунд мэдэгдэхүйц унасныг удаа дараагийн судалгаа харуулав. Хөөрхий Тони Блэйр ч сайнгүй царайтай, шүүхэд дуудагдаж яваа нь телевизийн дэлгэцээр үе үе харагдана. Хамгийн ичгэвтэр, эгдүүцмээр баримт нь олон нийтийн дунд явуулж буй судалгааны асуултад «Иракийн дайн шалтгаа олоогүй юу?» гэсэн өгүүлбэр ямагт багтаж, түүнд нь «Тийм. АНУ-ын Засаг захиргаа үүнд буруутай», «Тийм. Ерөнхийлөгч буруутай» гэх хариултууд зонхилжээ.

Аугаа гүрний Ерөнхийлөгчийн хариуцлагатай илтгэлд Тенет, Хэдли хоёрын аль нэг нь худал мэдээлэл «санамсаргүй» хавчуулсан гэнэ. Тагнуулын төв газрын дарга, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдлын зөвлөх хоёр хорвоо дэлхийн хүмүүсээс өдгөө ичихдээ огцорьё халагдъя гэсэн авч эрхэм Ерөнхийлөгч зөрүүд туулай адил «Байсан юм байснаараа» гээд тэднийг өөрчилсөнгүй. Их Британийн Батлан хамгаалах яамны Зэвсгийн шинжээч доктор Д.Келлийн хувьд засаг захиргааныхаа бүдүүлэг алдааг тэсч давах ичгүүргүй зан дутсандаа амиа хорложээ. Т.Блэйрийн парламентдаа уншиж сонгосон Иракийн эсрэг



цогтой үгсэд худал баримт байсан эсэхийг өнөөдөр шүүж буй нь нүүр улаймаар хэрэг. Зүгээр л жаал сүржигнэж байгаад, бие даасан улсын энгийн иргэдийг үндэслэл шалтгаангүй шахам бөмбөгдөж болдог гэж үү. Нөгөө дэлхийн хүмүүсийг үй олноор хөнөөхөөр хураасан Иракийн их зэвсэг хаана байгаа юм бол. Ялалтын үнэ цэнийг ёслолын буудлага, цогтой уран үгс бус, цаг хугацаа шүүж байна. Үйл явдал ингэж эргэх тусам Арабын ертөнцөд хорсол зузаарч, өдөр өнжихгүй бөмбөг тэсэрч эхэллээ. Яг ийм үед буюу дайны оргил дээр АНУ НҮБ-ыг үйл явдалд хутгалдахыг урин залах аж. Welcome to the Iraq! Бөмбөгдөхийг нь бөмбөгдлөө. Одоо залуусаа, та нар учрыг нь олохыг бодоорой гэснээс өөрцгүй санагдана.

Америк, Английн хариуцдаг секторын дунд Польш, Монголын дайчдын хэрэг сэндвич шиг хавчуулагдсан харагдана. Америкийг дэмжиж буйгаа илэрхийлэх бэлгэ тэмдгийн дивиз гэж түүнийг нэрлэе. «Торгуулийн» рот хэмээн ёозгүй хэлж буйдаа төрөл төрөгсдөөс нь хүлцэл өчье. Уурсан арабуудаас тусламжийн цуваа, эмнэлэг, барилга байгууламж хамгаалж яваагийнх нь хариуд холбоотнууд Монгол Улсад ямар дэмжлэг амласныг ядаж эцэг эхэд нь тодруулж өгөхийг хүсье. Аль ч нам Саарал ордонд тухалсан ялгаагүй Америк, Америк хэмээн алга таших нь эргэлзээгүй. Гэвч эхэлсэн шалтгаан нь өнөөдөр олодохоо больчихсон дайны үр дагаврыг арилгах золиосонд тэд мөрдсонд харамсана. Вьетнамын дайн сүрхий дуулианаар эхэлж, ичгэвтэр өндөрлөсөн. Тэр дайны үр дүн болох амь үрэгдсэн америк залуусын нэрс Вашингтонд бий. Үргэлжилсэн урт нэрс бяцхан гудам болтлоо сунасныг харж билээ. Мөнөөх жагсаалт улс төрийн тоглоомын золиос болон түүхэнд үнэ хүндгүй үлдэж хоцорсон аж. Тэгвэл Вьетнамын шинэ дайнд Монгол залуус юуны төлөө явсан юм бол. Дэлхийн энхтайвны төлөө юу? Шударга ёсны тулд уу? Эсвэл эх нутагтаа рейтинг нь унаж, шүүхэд үе үе дуудагдах Тони Блэйр, Жорж Буш хоёрын нэр хүндийг аврахаар хаа байсан холоос Калашников үүрээд, дашмагаа зүүгээд...Эмгэнэлтэй юм.

2005 он

# Хүнд битгий хэлээрэй

## -Зургадугаар сарын 6-ны нууц хэлэлцээр-

Энэ зуур  
АНУ  
«хариуцлагаас  
мултрах»  
хэлэлцээрийн  
урьдчилж  
бэлтгэсэн  
загвараа ийш  
тийш илгээсээр.  
Түүний нэг  
хувийг Монголд  
өгөөд, яах нь  
вэ?! хэмээн  
харзнатал...  
Үдшийн  
бүрийгээр манай  
парламент  
үзэглээд даруй  
хариуг нь  
явуулав. «P.S.  
Хүнд битгий  
хэлээрэй» гэсэн  
зүүлтэй нь цуг.

Энэ хэлэлцээрийг эрхэм гишүүд шөнө дөлөөр гар өргөн баталсан юм. Ийм хэлэлцээр байгуулснаа дэлхий дахинд зарлахгүй байхыг дараа нь АНУ-аас гуйжээ. Гайхалтай гэнэн явдал болов. Дэлхийн олон нийт гэдэг дотор Монголын ард түмэн нь багтсан байлаа. Айхтар нууцалсан боловч маргааш нөгөөдрөөс нь л ертөнцийн хэвлэлүүдэд мөнөөх нууц хэлэлцээрийн агуулга гараад ирэв. Сайн сэтгүүлзүй тэнд хөгжсөн юм хойно. АНУ-тай зарим улсын үзэглэсэн баримтыг «Хариуцлагаас мултрах» хэлэлцээр гэж хэвлэлийнхэн нэрлэлээ. Цолоо дуудуулсан тэдгээр улсын жагсаалтын дунд Монгол тодоос тод бичигдлээ. Манай хөршүүд Албани, Габон, Гамби, Босни, Жибути, Маврики, Сенегал, Сьерра Леон, Тажикстан зэрэг болжээ. Гэхдээ ийм хэлэлцээр байгуулсан зарим орны удирдлага Монгол Улсын Их Хурлын гишүүдээс ялгаатай нь олон түмнээс нууцлаарай гэж АНУ-ын талд хүсэлт тавьж гэнэдээгүй юм. Дээрх орнуудын олонх нь хэлэлцээрийн агуулгыг иргэддээ танилцуулсан. Ингэхгүйгээр шийдвэр гаргаж ер нь болдог билүү дээ!

Мөнөөх «Хариуцлагаас мултрах» баримт бичгийн тухай дэлхийн хэвлэлүүд шуугиж эхлэх үед «Өнөөдөр» сонин энэ явдлын талаар бичиж, уншигчдадаа танилцуулсан удаатай. Хаврын чуулганы шувтаргаар хэлэлцэх асуудлын дунд чимээгүйхэн багтаад, үдэш оройхон сэмхэн баталж орхисон уг баримтын агуулга, байгуулсан нөхцөл, яриа хэлцэл яаж явагдсан, үр дагавар нь ямархан тусахыг задалж тунгаасан өөр тохиолдол үгүй. Тус улс АНУ-тай «нууцын зэрэглэлд багтах» хэлэлцээр байгуулсны дараа үйл явдал үргэлжлэн өрнөв. Монгол дайчид Иракт хэдийнэ хүрч, удаах ээлжийнхэн нь бэлтгэгдэж байна. «Гардиан», «Нью-Йорк таймс» мэт том хэвлэлүүд Чингисийн зурагтай, монгол дайчдын патиар бүхий өгүүлэл нийтэлж эхлэв. Бид ийнхүү Арабын ертөнц дэх экзотик сэдэв болжээ. Эртний түүхт Месопотамид монголчууд очсон болон АНУ-тай манай удирдагчид гэрээ үзэглэсэн баримтууд нь нэг үйл явдлын хоёр өнцөгт өрнөсөн харагдана. Иракт ажиллаж буй дайчид, тэдний дарга нар, ар гэрийнхэн нь 2003 оны зургадугаар сарын 6-ны хэлэлцээрийн учир жанцанг жирийн иргэдийнхээ нэг адил өнөө ч гүйцэд ойлгоогүй яваа юм.

Лав Олон улсын хөгжлийн агентлаг хэмээх Америкийн Засгийн газрын байгууллага 16.6 сая ам.долларын тусламж саявтар амласныг монголчууд сонслоо. Нөгөө 200 орчим цэргээ Багдад руу илгээсний маань хариу талархал байх нь гэж таамаглав. Цаашид их гүрний зүгээс эдийн засгийн төдийгүй цэрэг, улс төрийн дэмжлэг ирэх нь хэмээсэн хүлээлт бий боллоо. Батлан хамгаалахынхан баяртай байгаа нь дамжиггүй. Дайчид туршлагатай болоод ирэх төдийгүй АНУ-аас ирэх цэргийн чиглэлээрх сургалт энэ тэр гээд туслалцаа нэмэгдэнэ шүү дээ.

Өнгөц харж хөөрөлдөхөд иймэрхүү тайлбар хангалттай. Харин зургадугаар сарын 6-ны хэлэлцээр гэгч чухам юу болох, манай дарга нар түүнийг яажшуухан үзэглэсэн, үр дагавар нь ямар байж болохыг сайтар ухвал өөр.

«Нью-Йорк таймс»-ын ишлэлийг дахин татъя. Тус сонин есдүгээр сарын 25-ны дугаарт Жеймс Брукийн бичсэн «Энэ удаа монголчууд энхийг сахиулахаар Багдадад ирлээ» нэртэй нийтлэлийг «Өнөөдөр» сонин уншигчдадаа хүргэсэн. «Цэргээ Ирак руу илгээх тухай Монголын талын санал Америкийн засаг захиргааг үнэхээр гайхшруулсан. Учир нь ингээч гэж гуйгаагүй байсан... хэмээн Вашингтонд төвтэй тус хоёр улсын бизнесийн харилцааг дэмжих бүлгийн дарга,

**ноён Стивен Р.Саундерс өгүүлэв»** гэж уг нийтлэлд дурджээ. Энэ хэсгийг илүү тодруулж ойлгомоор байна уу? Нээрээ дээр өгүүлснээр «монголчууд» буюу манай дарга нар юу хийж орхиод америкауд өөрснөө хүртэл гайхширсан юм бол. Эргээд «нууц хэлэлцээрийн» түүх рүү өнгийх болох нь.

Америкийн цэргийн албан хаагчдыг хамгаалах тухай хуулийг дэлхийн хамтын нийгэмлэгээр дэмжүүлэхээр тус улс өнгөрсөн зунаас хүчтэй ажилласан билээ. Олон улсын эрүүгийн шүүх хэмээх НҮБ-ын удаа орохуйц том, чухал үүрэг зорилготой байгууллага тулга тавьж, үүдээ нээсний дараа ийм чармайлт эрс идэвхжжээ. Мөнөөх хуульдаа Америкийн иргэдийг Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлэн өгөхгүй байх талаар бусад улстай хоёр талын хэлэлцээр байгуулах эрхийг Ерөнхийлөгчдөө өгөв. Хэрэв нөгөө тал (жишээ нь Монгол) ийм хэлэлцээр байгуулахаас татгалзвал цэргийн тусламжаа зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхийг Ж.Бушд олгосон аж. АНУ нь өөрийн ойрын холбоотон улсуудад ийм санал тавиагүй, гол төлөв жижиг, буурай, ялангуяа их гүрнээс цэргийн болон бусад тусламж горьддог орнуудад ханджээ. Жил орчмын хугацаанд 60 улс их гүрэнтэй дээрх байдлаар тохиролцов. Заримынх нь нэрийг түрүүнд дурдсаныг мартаагүй биз дээ. Тэгвэл Швед, Бразил, Колумб, Танзани зэрэг нь АНУ-ын саналыг «**Шүүхийн өмнө бүгд эрх тэгш байх зарчимд харшилна**» гэж үзээд хүлээж авсангүй. Ийм байр суурьтай 39 орон өөрийн бодолтой байсныхаа төлөө АНУ-аас цэргийн тусламж авах боломжгүй болоод байна.

Өнөөдөр дэлхийн халуун цэгүүдэд цэргээ илгээж буй тус улс иргэдээ хамгаалахыг чармайж байгааг ойлгож болох ч ийм дархан эрх олсон Америк цаашид улам зоргоороо загнах вий гэсэн эгдүүцэл хорвоогийн олон нийтэд түгээмэл болжээ. Энэ зуур АНУ «хариуцлагаас мултрах» хэлэлцээрийн урьдчилж бэлтгэсэн загвараа ийш тийш илгээсээр. Түүний нэг хувийг Монголд өгөөд, яах нь вэ?! хэмээн харзнатал... Үдшийн бүрийгээр манай парламент үзэглээд даруй хариуг нь явуулав. «**P.S. Хүнд битгий хэлээрэй**» гэсэн зүүлттэй нь цуг.

Олон улсын гэрээ хэлэлцээрийг бид үзэглэж байгуулж ер сураагүй гэж үү? НҮБ-д аль жараад онд элссэн, тусгаар Монгол орон гэдэггүй билүү? Аливаа талын бэлтгэсэн хувилбарт тэдний эрх ашиг түлхүү тусдгийг мэдэхгүй хэрэг үү. СССР-тэй эрх тэгш бус янз янзын хэлэлцээрийг ард олноосоо нууж хааж байгуулсан талаар аль ч намынхан загнаад яриад байгаагүй билүү? АНУ-ын гардуулсан хувилбар ердөө төсөл. Бид өөрийн байр суурь, нөхцөлөө тэнд нэмж тусгаж гэмээнэ тэр нь эрх тэгш баримт болно гэдгийг мэдэхгүй гэж үү? Ийм яриа хэлцэл явагдсан тухай иргэддээ тайлбарлах нь бүү хэл, зургадугаар сарын 6-нд юу болсныг сайн санахгүй юм гэж хариулж мэдэхээр тэнэг байдал бий болжээ. Монголчууд АНУ-тай түншилсэн юм бол хариуд нь юу хүсч байна вэ? Зүгээр л долигдосон уу? Хэрэв бялдуучлаагүй бол хэлэлцээний нөхцөл дээр ам нээж харилцан тохиролцохыг оролдсон уу? Албан газартай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа шинэхэн төгссөн оюутан хүртэл нөхцөлийг нь хардаг даа. Яагаад элдэв асуулт тавиад байгаа юм гэж дарга нар уцаарлах вий. Монголчууд чухам юугаар дэнчин тавьж, хэлэлцээрт гарын үсэг зуран АНУ-ын өмнө амлалт аваад, дараа нь цэргээ Ирак руу явуулсан юм бэ? Энхийг сахиулах ажиллагаанд байнга оролцож, олон улсын тавцанд нэр хүндээ өргөдөг жижиг орнууд байдаг юм гэж Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч дарга, хурандаа Г.Рагчаа тайлбарласан удаатай. Гэвч Иракийн дайн НҮБ-ын цэнхэр дуулгатнуудын оролцоогүй өрнөж байгаа тул «энхийг сахиулах» тухай ойлголт энд арай өөрөөр томъёологдоно. Манай үзэглэсэн хэлэлцээрийн үр дагаврын талаар туршлагатай дипломатчийн юу гэж өгүүлснийг сонсьё.

«Нууц хэлэлцээр байгуулах нь Монгол Улсын урт хугацааны ашиг сонирхол, олон улсын нэр хүндэд хэрхэн нөлөөлж байгаа, нэн ялангуяа олон улсын эрхзүйг бэхжүүлэх замаар гадаад аюулгүй байдлаа хангахыг эрхэмлэдэг жижиг орны ашиг сонирхолд хэр нийцэж байгаа юм бол доо. Язгуур ашиг сонирхлын буюу зарчмын асуудлаар буулт хийсэн улс даралт шахалтад дахин дахин өртдөгийн дээр нэр хүндээ наймаалцахаас буцахгүй хэмээн тооцогдох болдог. Ийм нөхцөлд тухайн орныг ноён нуруугүй гэж үзэж, түүнийг зарчмын асуудлаар тууштай дэмжих газар ч бараг үгүй болдгийг мартаж болохгүй» хэмээн тэрбээр өгүүлсэн юм.

Терроризмын эсрэг аяны тоосыг дагаж давхиад нэг мэдэхэд өрөөлийн өдөөсөн дайны үр уршиг дээр өөрсдөө үлдэж хоцорвол яахав. «За монголчууд давхиж очоод тусална, айлтгүй» гэх онигоонд орчихмоор харагдана. Монгол Улсын ийм шинэ имиж олон улсын тавцанд түгсний дараа АНУ-аас ирэх тусламжийн хэмжээг өөрийн эрхгүй мэдмээр санагдаж байгаа биз дээ? Манай шинэ имиж ямар үнэтэй юм болоо гэж иргэд ч шийдвэр гаргадаг хүмүүсээс сураглаж байгаа нь лав. Энэ дайны тухай бүтэлгүй мэдээ өдөр бүр сонсогдож, үхэл хагашлын статистик нэмэгдэх тусам тэр хариуг монголчууд хүлээж байна. Гэвч ийм тайлбарыг Засгийн газраасаа бус гадаадын хэвлэлүүдээс олж үздэг боллоо. Ассошэйтэд Прессийн сэтгүүлчид мэргэжил нэгт биднээс хавьгүй хурдтай ажиллаж, баримтуудыг дараах байдлаар ил гаргав.

АР агентлагийн мэдээлснээр, монголчууд 174 цэргийн албан хаагчаа Иракт илгээсний хариуд Америктай хийх худалдааны чөлөөт нөхцөл олж авахыг эрмэлзэж байгаа гэнэ. Уг нь амаа үдэж, нууцлаад байхаар гуйлт биш байгаа биз дээ. Иракт цэргээ илгээсэн орнууд хариуд нь эх нутагтаа ашигтай байх ямар нэг зүйлийг Америкаас нэхэж байна. Иргэдийнхээ амь насаар дэнчин тавьсан тул ийм улаан цайм байх аж. АР-гийн ишлэлээс дахиад зээлдэх болох нь. Турк 10.000 цэргээ Иракт оруулбал 8.5 тэрбум ам.долларын зээл нэхэх төлөвлөгөөтэй. Польш, Серб, Румын, Латви тус бүрдээ л Иракийн дэд бүтцийг сэргээх бизнест гар дүрэх хүсэлтэй. Эдүгээ эртний түүхт энэ улсын нутаг дэвсгэрт «энхийг сахиулах» тодотгол дор яваа америк бус, гадаадын цэргийнхний тоо 20.000 хүрлээ. Америкийн холбоотнууд 20.000 цэргийнхээ хариуд ийнхүү тун тодорхой тоо , наймааны нөхцөл зарлаж буй юм. Дайны дараахь Ирак хэмээх бялуунаас Польшид лав Худалдааны банкны хэсэг оногдоно. Францын 24 компани сэргээн босголтын бизнест хөл тавих эрх олсон бол мөнөөх Польшийн 116 аж ахуйд ийм боломж ирээд байна. Юуны төлөө польшууд тэнд 2400 цэргээ илгээсэн билээ! «Манай эцсийн зорилго бол Иракийн нефть» гэж Польшийн Гадаад хэргийн сайд Влодзимр Симошевич илэн далангүй зарлалаа. «Иракийн дайнд зориулан гаргаж буй хөрөнгийг цэргээ хөдөлгөснийх нь төлөө гадаадын улс орнуудын удирдагчдад атгуулах хахууль маягаар ашиглаж байгаа» хэмээн сенатч Эдвард М.Кеннеди саявтар өгүүлжээ.

Бүгд л өгөө авааны зарчмаар тэнд очсон. Харин Монгол? Бид хэлэлцээр байгуулахдаа хүртэл өөрт ашигтай ганц нөхцөл ганхийлгүй соёрхсон болохоор америкуудад «сайн зан» маань хэдийнэ танил болжээ. Саарал ордонд суугаа хүмүүс юу гээч үзэглэж соёрхоод, үр дүн нь манай нийгэмд хэрхэн тусахыг ам нээн тайлбарлах болоогүй юу. Заавал тоо тохиролцож, их хөрөнгө Америкаас авна гэдэг утгагүй билээ. Том гүрний нөлөө ямар ч байдлаар нөөлгөө өгч чадах нь лав. Гагцхүү алив асуудалд тусгаар улсын зиндаатай хандан, «Битгий хэлээрэй» хэмээх хариугүй зүүлт дагуулалгүй, ард иргэддээ ам нээж сурсан нь дээргүй юу.

# «Монголчууд биднийг хамгаалж чадна гэж үү?»

Дэд хурандаа Б.Баярмагнай энгэртээ «Dog tag» зүүжээ. Цэргийнхэн юу болохыг нь сайн мэднэ. Дайчин эрс амь эрсэдсэн тохиолдолд хэний хэн болохыг түүгээр нь таньж тогтооно. «Ингэж тасалж аваад...» гээд Баярмагнай дүрсэлж харууллаа. Дэлхийн халуун цэг, алхам тутамд амь өрсөн газраас ирээд ганц хонож буйг нь дахин тун ойрхон мэдрэв. «Dog tag»-ны хамт сум харагдана. Энгэрээ ухаад ID буюу цэргийн бүсэд нэвтрэх үнэмлэхүүдээ үзүүлэв. Улаан хүрэн баринтагт ороосон сахиус бас байна. Тэр болгоныг 20 кг жинтэй хантааз, дуулганыхаа хамт байнга тээж явсаар хагас жилийг өнгөрөөжээ. Иракт эхлэн хөл тавьсан монголчуудын нэгтэй аян замын тоосноосоо салж арай л амжаагүй явахад нь ярилцсан маань энэ. Афганы оросууд, Вьетнамын дайныхан гэх хэллэгтэй зэрэгцэн холын Иракт хал үзсэн Монгол дайчдын бүлэг бий болжээ.

-Үүргээ амжилттай гүйцэтгээд ирлээ хэмээн дэд хурандаа Б.Баярмагнай энэ өглөө Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид рапорт өгсөн юм. Хөр цас уяран чийг ханхалсан хаврын тунгалаг агаарт түүний дуу тодхон сонсогдож, «Иракийн эрх чөлөө» ажиллагаанд оролцсон 173 дайчин даргынхаа хойно эгнэн жагссан байлаа.

Гандмал өнгөтэй дүрэмт хувцас шар шурхийн, бөх байрын илгэн гутал цэргийн багийн жагсаал дор жигдхэн товшино. Үлгэр жишээ үлээвэр хөгжмийн аялгуу дор яралзтал алхах гэднийг хараад нэг нь «Анх явснаа бодвол чийрэгжиж биеэрхүү болсон байна шүү» гэх нь сонсогдов.

**-Рапортоо эхлэх үед хоолой тань яльгүй сөөнгөтсөн. Ирээд даарсных биз?**

-Хоолой өвдчихсэн юм. 20 градусын дулаанаас 20 градус хүйтэн өглөө ирээд тэгсэн байх.

**-«Өнөөдөр» сонины «Иракийн тэмдэглэл» буланд Цэргийн багийн ахлагч Б.Баярмагнай гэсэн нэр байнга харагддаг байлаа. Үе үе и-мэйлээр харилцахдаа нас тогтсон хүн л төсөөлсөн шүү.**

-Миний намтар түүх товчоон. 1990 онд Дундговийн нэгдүгээр арван жилийг дүүргээд, дөрвөн жилийн дараа Батлан хамгаалахын их сургууль төгссөн юм. 2000 онд АНУ-ын Хуурай замын цэргийн командлалын коллежид нэг жил суралцаад, дараа нь Швейцарьт НҮБ-ын Цэргийн ажиглагчийн курст номын дуу сонссон.

**-Суралцаад л явжээ?**

-Тайланд, Индонез, Энэтхэгт болсон Энхийг сахиулах хүчний командлалын курст бас багтсан. Ийм ажиллагааны үед штаб ямар үүрэгтэй байх талаар ойлголт авсан гэсэн үг.

**-Тэгвэл манай улс энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох чиг зорилго тавьж эхэлсэн яг тэр үеэс бэлтгэгдсэн анхны боловсон хүчин юм байна.**

-Манай цэргийн салбарын гадаад харилцааг олон нийт тэр бүр сайн мэддэггүй юм билээ. Хилийн чанадад, миний мэдэхээр лав хориод оронд цэргийнхэн маань мэргэжил дээшлүүлсэн. Энхийг сахиулах чиглэлээр бол 1999 оноос сургасан. Ер нь Зэвсэгт хүчний жанжин штабын орлогч дарга хурандаа Г.Рагчаагийн хийсэн зүйл, тулж тавьсан эхлэл энд онцгой ач холбогдолтой.

Элитийн батальоныг 1997 онд бий болгоход би оролцож байлаа. Иракт ажилласан манай бүрэлдэхүүний гол цөм нь элитийнхэн шүү дээ. Яг 100 залуу бий. Эд надтай ижил Зэвсэгт хүчний 150 дугаар ангид бэлтгэгдсэн хүмүүс.

**-Иракт ажиллаж хал үзсэн элитийнхэн одоо ямар үүрэг гүйцэтгэх вэ?**

-Их туршлагатай, мэргэжлийн дадалтай, маш өндөр түвшинд бэлтгэгдсэн хүмүүс хүрээд ирлээ. Эд маань шинэ бүрэлдэхүүнээ сургах, зэвсэгт хүчиндээ чадвар даллагаа өвлүүлэх чухал үүрэгтэй.

**-Бодит орчинд ажилласан хүмүүс гэж та ярилаа. Халуун цэгийн амьсгалыг хажуудаа мэдэрсэн тохиолдол олон уу?**

-Иракт болж буй бүх үйл явдал бидэнд үргэлж сонсогддог байлаа. Багдадад байна уу, Карбаллад уу ялгаагүй дэлбэрэлт, халдлага болгон тодорхой хэмжээгээр мэдрэгдэнэ.

**-Аюулд хамгийн ойрхон ямар тохиолдол байсан бэ?**

-Карбалла хавьд арванхоёрдугаар сарын сүүлээр олон үндэстний дивиз хохирол амсч дайчид амь үрэгдсэн. Манай баазаас 60-70 км зайтай газар. Иймэрхүү үед сургамж авч, хамгаалалт болон үйл ажиллагаагаа улам нягт зохион байгуулах ёстой.

**-Та нарын ажилласан «Чарли» бааз байрладаг Ал Хилла хот юугаараа онцлог вэ?**

-Ал Хилла хот Бабил мужийнхаа өмнөд этгээдэд оршдог.

**-Эртний дурсгалт Вавилонд зургаан сар болсон хэрэг үү?**

-Тийм. МЭӨ 600 жилийн үеэс эхтэй энэ дурсгалт газрын туурь одоо ч байх юм. Бид хэдий дайн тулааны цагт үүрэг гүйцэтгэж явсан ч гэсэн офицер, ахлагч нараа зохион байгуулаад түүх соёлын дурсгалт газруудыг үзүүлээд авсан. Маш үзэсгэлэнтэй байгаль, түүхэн газрууд тэнд бий. Садаммын ордныг ч сонирхсон. 6-7 давхар байшингийн чинээ өндөр, чамин чимэглэлтэй гоёмсог барилга.

**-Нутгийнхантай хэр харилцаж байв. Телевизээр харуулдаг шиг тэд тийм дайсагнасан ард түмэн үү?**

-Нэг их ойр харилцаж байгаагүй ч ард иргэд хэрхэн амьдарч буйг өдөр бүр анзаарч мэдэрдэг байлаа. Шашныхаа заншил ёсоор эрчүүд нэлмэгэр хувцастай, толгойдоо алчуур ороож явдаг, бүсгүйчүүд нь хар нөмрөгтэй. Биднийг Иракт байх үед рамадан болон хаж хэмээх баяраа тэмдэглэсэн. Нийтээрээ л хөөрч, шөнө агаарт хий буудацгаах юм билээ. Пүрэв гариг бүрт гэрлэх ёслол болдог. Дайн тулааны түгшүүртэй өдрүүдэд ч хуримын ёслолоо хийсээр байсан. Америкийн цэргийн албан хаагч сувилагч ирак бүсгүйтэй гэрлэж байлаа. Тэр залуу лалын шашинд орж, заншил ёсоор нь хуримласан.

Иргэдийн олонх Эвслийн цэргийг дэмжиж байгаа нь мэдрэгддэг. Монголчуудыг анх очиход япон эсвэл филиппинчүүд юм болов уу гэж бодсон байх. Сүүлдээ ойлголцож танилцаад «Сайн байна уу» гэж Монголоор мэндэлж сурсан шүү.

**-Манайхны зэвсэг техник олон үндэстний цэргийнхтэй харьцуулахад хуучирч муудсан гэх голомт яриа та бүхнийг явсны дараа гарч байлаа.**

-Манай бүрэлдэхүүн чадварлаг. Миний бодлоор чадварлаг бүрэлдэхүүнд ямар ч зэвсэг гологдохгүй.

**-Вьетнамын дайнд оролцогсод, Афганы оросууд гэдэг шиг Иракийн монголчууд байнгын түгшүүртэй газраас зургаан сарын дараа амар тайван нутагтаа ирлээ. Дасахад хэцүү байх болов уу?**

-Олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоход гурван төрлийн бэлтгэл байдаг юм. Явахын өмнөх үеийн бэлтгэл, сургалт буюу техник хэрэгсэлтэй харьцах гэх мэт бүх төрлийн дадал олж авах явц. Дараа нь ажиллагааны, тэгээд дараах үе гэж ангилна. Хамгийн сүүлийн хэсэгт гол төлөв стресс тайлах, бие сэтгэлийн хувьд почирч ядаргаанд орсон бол тайвшруулах чиглэлийн сургалтууд хамаатай. Одоо манай баг сэтгэцийн тест бөглөх, дурдсан эмчилгээнд орох, «Оргил» рашаан сувилалд амрах зэргээр стресс тайлна. Судалгааны эцэст хүн бүрт ямар хугацааны эмчилгээ, сургалт хэрэгцээтэйг



ТОГТООХ ЮМ.

**-Америкийн цэргүүдийн дунд амиа хорлох тохиолдол нэлээд гарсныг хэвлэлээр мэдээлдэг. Үнэхээр сэтгэл санаа байнгын дарамт дор байхаар тийм уур амьсгал Иракт бий юу?**

-АНУ, Украин, Польшийн цэргүүдийг харж байхад шинэ дайчдыг, өөрөөр хэлбэл байлдагчдыг шууд авчирчихсан. Манайхан бол доод тал нь гурван жил алба хаасан мэргэжлийн ахлагч нар. Шинэ залуу хүмүүс иймэрхүү ажиллагаанд орохоороо цочирдох, сэтгэлзүйн дарамтад орсноосоо болоод амиа хорлох явдал гардаг байх.

**-Манайхан дотор эхний үед балмагдах, хямралд автах явдал гарсан уу?**

-Манай багийнханд тийм явдал тохиолдоогүй. Яагаад гэвэл дарга нар нь сэтгэл санааны хувьд байнга тулж дэмжин, өдөр болгон ойр дотно харьцдаг байсан. Цэргээ ойлгохгүй юм бол тэр дарга биш шүү дээ. Бид сэтгэлзүйн бэлтгэл хичээл төдийгүй, уралдаан тэмцээн зохиодог, караоке хүртэл хийсэн дээ. Арванхоёрдугаар сарын 26-нд манай дивизийн харьяанд багтдаг бусад улсын дайчид Зул сарын баяраа тэмдэглэхэд нь монголчууд харуул хамгаалалтдаа гарсан. Харин 31-нд бид шинэ жилээ ёсолж билээ. Он солигдохын наана манайханд интернэтээр маш их мэндчилгээ ирсэн. Гадаадад байгаа монголчуудаас, бүр Египетээс хүртэл тун сайхан мэндчилгээнүүд илгээдэг байлаа. Ар гэрийнхэн, манай батлан хамгаалахын удирдлагуудаас ч баярын мэнд ирүүлсэн. Тэдгээрийг шинэ жилийн үдэш сюрприз болгоод уншиж дуулгасан.

**-Гэрийнхэнтэйгээ яаж харилцдаг байв?**

-Монголын цэргийн баг Иракт үүрэг гүйцэтгэх хугацаанд **arger2003@yahoo.com** гэсэн шинэ хаяг нээсэн юм. Харин бидний хаяг **tsergiinbag2003**. Зэвсэгт хүчний жанжин штаб дээр гэр бүлийнхэн маань ирж захиагаа өгөхөд нь интернэтээр явуулаад өгөх явдал ч байсан.

**-Гэрээсээ захиа авах сайхан биз?**

-Өө тэгэлгүй яахав. Мөн Улс тунхагласны баяраар буюу арваннэгдүгээр сарын 26-нд Ц.Тогоо генерал, хурандаа Г.Рагчаа тэргүүтэй хүмүүс биднийг эргэх үед сэтгэл санааны том дэмжлэг болсон шүү. Ингэхдээ бие бүрэлдэхүүнд цол олгож, бас багийнханд өдөр бүр 10 ам. доллар өгөх асуудлыг Засгийн газрын шийдвэрээр баталгаажуулсан юм. Харин үндсэн цалин ар гэрийнхэнд маань хүрч байлаа. Ер нь бидний ар талд БХЯ болон Жанжин штаб маш сайн ажиллаж, түшиж тулсныг онцлон тэмдэглэе.

**-Интернэтээс мэдээлэл авах боломж хэр байв?**

-«Чарли» баазад интернэт кафе бий. Монголчуудад зориулан гаргасан цагаар бид өөрсдийн хуваарийн дагуу очдог.

**-Ямар хэвлэл гол төлөв үздэг вэ?**

-mongolnews.mn хаягаар ороод л танай сонин, «Таван цагариг» гээд уншчихна. Манай баг мэдээллийн булантай. Сонины зарим материалыг аваад тэр буландаа байрлуулдаг юм. Харин «Таксины жолоочийг егүүтгэлээ» гэх мэт хар бараан мэдээллийг бол тавьдаггүй гэдгийг ойлгоно биз дээ.

**-Одоо Иракт цаг агаар ямар байгаа вэ?**

-Сэрүүний улирал нь шувтраад хавар буюу цөлийн шуурганы үе эхэлж байгаа. Тэр нь 2-3 сар үргэлжлээд нөгөө айхтар халууны улирал ирнэ дээ. Манай баг анх Кувейтэд шөнө дөлөөр буух үед 38 градусын халуун дүүгэж байлаа. Хөдөлгүүрийн хажууд зогсч байгаа юм шиг л пүнхийсэн агаар бүрхээд авна. Өдөр нь 60 градус болтлоо шатдаг. Эхний хоёр өдөр тэр их халуунд дасгах гэж амраана. Дараа нь хувцас хэрэглэлдээ дадах сургалт үргэлжилдэг. Хамгаалалтын хантааз, дуулга хоёртой нөхөрлөж эхэлнэ дээ.

**-Шантармаар юм аа?**

-Дассаар, яваандаа нөгөө 20 кг жинтэй хантааз, дуулгыг чинь өдөр тутмын ердийн хувцас шиг хэрэглэдэг болчихно.

**-Манай багийнхны дундаж нас хэд вэ?**

-Дунджаар 25 настай.

**-Хоол хүнсний нөөцөө эндээс базааж явсан гэж сонссон?**

-Цэргийн багт зориулан борцтой хоол зэргийг бэлтгэж өгсөн. Ямар ч тохиолдолд хэрэгцээгээ хангах нөөцтэй байсан гэсэн үг. Түүгээрээ арвандөрөв хоногт нэг удаа монгол хоол хийнэ. Бусад улсын цэргийн багийнхныг үндэсний хоолоороо харилцан дайлах арга хэмжээ ч зохиодог байлаа. Бид хэд дундаас сайн тогооч ч тодорч, тэд маань буузаа хийнэ шүү дээ. Бүх зүйлээ өөрсдөө хариуцдаг болохоор мэргэжлийн шахуу үсчид хүртэл тодорсон.

**-Хоёр охиноо их санасан уу?**

-Тэгэлгүй яахав. Гэхдээ олон хүн ахалж яваа дарга нь юм хойно өөрийгөө гэхээс илүү цэргүүдийнхээ төлөө л явахаас аргагүй.

**-Өвдөж зовсон, гэмтэж бэртсэн тохиолдол гараагүй биз дээ?**

-Бид шүд, дотрын, мэс заслын эмч нартайгаа явсан. Чадварлаг таван эмч маань болзошгүй тохиолдолд дээд зэргийн тусламж үзүүлэх шаардлага бүрэн хангасан хүмүүс.

**-Олон үндэстний цэргүүдтэй харилцахад хэлний бэрхшээл учирсан уу?**

-Ахлагч нарын бүрэлдэхүүнд бол хэлний хүндрэл байсан. Офицеруудын хувьд харьцангуй гайгүй. Ер нь манай цэргийнхэн гадаад, дотоодод нэлээд суралцаад энхийг сахиулах ажиллагааныхаа хүрээнд бол ойлголцох түвшинд хэл усны мэдлэгтэй болж байгаа.

**-Цэргийн дэлгүүрт нь ямар бараа байх юм?**

-Электрон бараа, тамхи тариа, цэргийн хувцас гээд янз янзын юм бий.

**-Иракаас гэр бүлийнхэндээ авч ирсэн бэлгээ сонирхуулаач?**

-Би медалион цуглуулдаг хообийтой. Улсын мөнгөн тэмдэгт биш л дээ. Дурсгалын зоос гэсэн үг. Гадаадын ихэнх улсад элдэв төрлийн дурсгалын зоос тун элбэг байх юм. Цэргийн анги хүртэл өөрийн ийм тодотголтой, генерал цолтой хүн бүр хувийн зоостой гэх мэт. Гадаадад элдэв сургалтад оролцож явахдаа 50 гаруй ийм зоосны цуглуулгатай болсон. Сая Иракт цуглуулгаа 11-ээр нэмээд ирлээ. АНУ-ын Батлан хамгаалахын дэд сайд үндэстнүүдийн цэргийн багийн дарга нартай уулзах үедээ надад зоосоо бэлэглэсэн. Гэртээ бол гэргий, хүүхдээ баярлуулахаар Арабын өвөрмөц бэлэг бэлдэхийг хичээсэн.

**-Иракийг зорьсон эхний баг явсны дараа манай сонинд нийтлэл гарч «торгуулийн рот» гэж бичсэн юм. «Торгуулийн» гэдэг үгийг хашилтад авсан л даа. Ингэж нэрлэхэд эвгүй сэтгэгдэл төрж байв уу?**

-Ямар нэг материал хэвлэлд нийтлэгдлээ гээд цэргийн бид гомдоод байх явдалгүй. Үүрэг зорилгоо хатуу ухамсарлаж ойлгосон учраас. Нэг удирдлага, нэг команд дор, өгсөн даалгаврыг чанд биелүүлэхээр Иракийг зорьсон хүмүүс шүү дээ. Монголын цэргийн багийн бусдаас ялгарч товойсон онцлог гэвэл сахилга бат. Үнэхээр зохион байгуулалт, сахилга батаараа монгол дайчид гадаадын цэргийнхнээс давуу байсныг бахархалтай хэлье. Нэг удирдлага дор төвөг чирэгдэлгүй цэгцэрч, ажлын маань үр дүн ч ялгарахуйц байлаа.

**-Гадаадын зарим улсын цэргийн багийнхан архи дарс хэрэглэж, сахилга алдсан, нутаг буцсан гэх мэдээлэл хэвлэлд мэр сэр гарч байсан.**

-Энд Жанжин штабтайгаа, тэнд олон улсын цэргийн дивизэд дагаж мөрдөх журамтай нь танилцаад гэрээнд гарын үсэг зурсан, тангарагтаа үнэнч цэргийнхэн шүү дээ, бид. Ер нь Монголын талаар олон улсын дивизэд тун өндөр сэтгэгдэлтэй байсан. Польшийн бүс дэх «Чарли» баазын дарга, дэд хурандаа эхлээд Монголын цэргүүд энэ баазыг хамгаалж чадна гэдэгт итгэдэггүй байсан. Тэр биднийг очихоос өмнө ийм бодолтой байж. Тэгвэл манай баг үүргээ гүйцэтгээд ганц сар өнгөрөхөд л ийм бодол өөрчлөгдсөн тухай олон хүн хэлж урамшуулсан. Кувейтээс манай бүрэлдэхүүн «Чарли»-д ирэх үед хамгаалалтад нь олон орны цэрэг гардаг, бааз дотроо дайчид хантааз, дуулгатай бэлэн байдалд явдаг их түгшүүртэй байсан. Тэгвэл Монголын рот хамгаалалтын үүргийг аваад нэг сар өнгөрөхөд бааз дотроо дуулга, хантаазгүй явах болсон. Айх аюул үнэхээр багассан гэж ярьцгаадаг.

**-Ирэх зургадугаар сарын 30 гэхэд иракчуудад Засгийн эрх мэдлийг шилжүүлэх боломж байгаа гэж боддог уу?**

-Эвслийн цэргийг толгойлж буй АНУ-д энэ асуудлаар тусгай хөтөлбөр бий. Хөтөлбөр ёсоор Иракийн нутаг дэвсгэрт засаг захиргааны анхан шатны нэгжүүд байгуулагдаж байна. Цэрэг, цагдаагийн өөрийнх нь бүтцийг бий болгох ажил маш эрчимтэй хийгдсээр. Одоо Иракийн шинэ арми эмхлэгдэж байна. Ингээд цаашдаа өөрийн засаг захиргааг шат дараатайгаар сонгон бэхжүүлэх нөхцөл бүрдсэн.

**-Бөмбөг тэсэрч, өдөр бүр хүний амь эрсдэн, оршуулгын ёслол тасрахгүй байгаа энэ улсаас үй олноор хөнөөх зэвсэг олоогүй л байна шүү дээ. Та тангараг өргөсөн цэргийн хүн. Гэхдээ «Дайныг яах гэж эхлүүлсэн юм бэ» гэх асуулт хааяа төрдөг үү?**

-АНУ-ын Жанжин штабуудын нэгдсэн хорооны дарга генерал Р.Майерс Монголд айлчилна гэдэг манай хоёр улсын цэргийн харилцаа хэчнээн шат ахисныг гэрчилнэ. Эвслийн үйл ажиллагааг цэргийн талаас дэмжих амлалтаа л Монгол Улс биелүүлж явна. Ирак улс хөгжлийн шинэ замдаа орно гэдэгт эргэлздэггүй.

**-Саддам Хусейн баригдсаныг анх яаж мэдэв?**

-CNN, BBC гээд телевизүүд маш шуурхай мэдээлсэн. Иракууд болохоор гадаа гарч хий буудаж, хөөрөөд л.

**-Нутгийн Али Бабанууд гэж хэн бэ?**

-Байшин барилга нураагаад, дээрэм тонуул хийгээд явдаг хүмүүсийг тэгж нэрлэдэг юм. Биднийг очих үед эзгүй байшин барилгын доторхийг дээрэмдэх явдал маш их байсан. Бабил дахь Саддам Хусейний ордныг америкчууд хамгаалалтдаа авахаас өмнө амжаад дээрэмдэж орхисон юм билээ.

**-Иракийн талд эрх мэдэл шилжүүлэхээс наана буюу зургадугаар сарын эцэс хүртэл эвслийн цэрэгт дайсагнасан хүчний террор ажиллагаа гаарах бололтой. Хоёрдугаар ээлжийнхэн маань илүү хүнд нөхцөлд алба хаах нь ээ?**

-«Чарли» баазад бидний хийж үлдээсэн зүйл их. Дадлага туршлагаа ч дараагийн ээлжийнхэндээ «өвлүүлсэн». Харин халууны хэцүү улирал тэднийг хүлээж байгаа. «Цагийн байдалдаа түргэн дасаарай» гэж би тэдэнд хамгийн түрүүнд захисан. Хүн бүр үүргээ чанд биелүүлсэн цагт баазын үйл ажиллагаа хэвийн байх боломжтой.

Өөрийн чинь хэлснээр Иракийн монголчууд гэсэн хэсэг хүн бий болоодожжээ. Бид ингээд цаашдаа ч зовлон жаргалаа хуваалцах, бие биеэ түших, гэр бүлээрээ нөхөрлөх нэг хувь заяа, ижил дурсамжтай боллоо.

**-Хэрэв Иракт ажиллаж байх үед ямар нэг хохирол амссан бол Та хамгийн түрүүнд юу хийх үүрэгтэй вэ?**

-Яах ёстойгоо сайн мэдэж байсан. Ямар нэг хохирол амсахгүйн тулд л бүх хүчээ дайчлан зохион байгуулалттай ажиллах учиртай. Муу зүйл тохиолдлоо гэхэд хэн нэг нь буруудах ёсгүй юм. Бүгд үүргээ ухамсарласан цэрэг эрс.

**-Аав тань явах үед юу гэж захисан бэ?**

-Аав надад шүдээ өгсөн. Ээж бол нутгийн чулуу хадгалуулсан. Тэднийг нь авч яваад эсэн мэнд, үүргээ биелүүлээд ирлээ. «Олон аавын хүүгийн амь насыг хариуцаж явлаа, хүү минь. Хичээгээрэй» гэж аав захисан.

**-Дундговийн чулууг Вавилонд хадгалж байгаад иржээ дээ. Иракийн дурсамж бичих үү?**

-Дурсамжаа бичээд эхэлчихсэн. Тэнд ажилласан гурван сарынхаа тэмдэглэлийг хөтөлсөн. Ном гаргана аа.

**-За баярлалаа. Дурсамжаа түргэн хэвлүүлээрэй. Олон хүн тэмдэглэлийг тань уншихаар яарч байгаа байх.**

# Иракийн мухардлыг хамгаалах Монголын дайчид

Ал Хиллаг зорин Монголын цэргийн багийн тавдугаар ээлж саяхан хөдөллөө. Иракийн монголчуудын тэмдэглэл зузаарсаар байна. Эхний ээлжийг ахалж явсан дэд хурандаа Б.Баярмагнайн дурсамжийн ном ч өдийд хэвлэгдээ биз ээ. Эдүгээ манай 700 орчим дайчин ийм тодотгол зүүжээ. «Иракийн эрх чөлөө» хэмээх ажиллагааны нэр хаяг ч өөрчлөгдөөгүй. Харин нунтаг цагаан шороогоор үлээсэн нозоором халуун Месопотамын хөндийд цагийн зүү ягаад ч юм ухарч хойшлох адил үйл явдлын өрнөл эх захаа алдав. 2003 оны тавдугаар сарын 1-ний тунгалаг өглөө Иракийн дайныг өдөөгч ялалтаа зарлан, ёслолын буудлагын сүр жавхлант дэлгэц дээр зүрхэн тушаа баруун гараа аван зогсч харагдсансан. Дайн дууссаныг Жорж Буш хоёр жилийн өмнө ийнхүү зарласан. Гэтэл өнөөх дайны эцэс төгсгөл өдгөө үл харагдана. Иракийн баруун хэсэг Ал Каидагийн мэдэлд орлоо гэх тэс өөр мэдээлэл энэ өдрүүдэд урсч, үйл явдлын учиг зангилаа холион бантан болов. Мөнөөх бантанг Иракийн мухардал хэмээн нэрлэе.

**Дайн  
дууссаныг  
Жорж Буш хоёр  
жилийн өмнө  
ийнхүү  
зарласан. Гэтэл  
өнөөх дайны  
эцэс төгсгөл  
өдгөө үл  
харагдана.  
Иракийн баруун  
хэсэг Ал  
Каидагийн  
мэдэлд орлоо  
гэх тэс өөр  
мэдээлэл энэ  
өдрүүдэд урсч,  
үйл явдлын  
учиг зангилаа  
холион бантан  
болов. Мөнөөх  
бантанг  
Иракийн  
мухардал  
хэмээн нэрлэе.**

Холбоотны цэрэг энд ирснээсээ хойш буюу хоёр жил хагасын хугацаанд хийсэн хамгийн нүсэр байлдааны ажиллагаа нутгийн баруун хэсэгт өрнөж байна. Мөн л дайны гал дэгдсэнээс хойших хамгийн их хохирол бүхий эмх замбараагүй явдал саяхан болов. Иргэний дайны гал буурал түүхт энэ улсын дурсгал болоод хөгжил дэвшлийн ололтуудыг үнсэн нурам болгож байна. Иракийн Засгийн газар хяналтаа тогтоож чадсан уу, эсвэл эвслийн цэрэг эзэн суусан хэвээр үү, суннит, шийтүүдийн аль нь хүч түрэнгүй вэ, Ал Каида гэгч хаанаас гараад ирэв? Ийм асуултад хэн ч итгэл төгс хариулж чадахгүй болсон ба мухардлын эхийг эндээс хайлтай.

Удаах асуулт нь холбоотон, эвслийн цэргийнхний гал цоггүй харцнаас харагдана. Испанийн Засгийн газар цэргээ гаргахаар шийдсэн мөчөөс эргэлзээ тээнэгэлзэл газар авсан юм. С.Берлускони цэргээ гаргах тухай ам нээж, польшууд дивизийн бие бүрэлдэхүүнээ цөөлөх чимээ гарав. Явсаар, Иракаас дайчдаа гаргах шийдвэр нь дотоодлоо улс төр хийдэг моодны сэдэв болж орхив. Персийн булангийн хоёрдугаар дайн Америкийн холбоотнуудад зөөлөн хэлбэл мухардал, цааш даамжраад үхлийн гогцоо бэлтгэж байна.

## МУХАРДЛЫН ЭХЭН

«Саддам Хусейний цэргийн баазад цохилт өгөх дайны төлөвлөгөө» нэртэй материал «Вашингтон Пост» сонины 2002 оны есдүгээр сарын 22-ны дугаарт нийтлэгдсэн нь америкчууд төдийгүй дэлхий нийтийг цочирдуулав. Уг материал Персийн булангийн шинэ дайны эхний утааг тавих шиг санагдаж, цуст мөргөлдөөн зайлшгүй гэж үү хэмээх амь тэмцсэн асуултыг тод зарласан билээ. Арабын ертөнцийг өдөөн турхирахын үр урхгийн тухай тэгэхэд хүмүүс түгшин бодож эхэлсэн. Тэр өдрүүдэд Пентагоны түшмэд улсын нууц задруулсны дайтай бухимдан «Вашингтон Пост» сониныг зүхсэн юм. Энэ л үед хэрэв Америкт холбоотон олдоогүйсэн бол Иракийн хямрал эхлэхгүй байлаа. Гэвч Тони Блэйр Ж.Бушийн дайны төлөвлөгөөг дэмжив. Ийм дэмжлэгийг өгөө авааны ердийн зарчмаар наймаалцаж олсныг дэлхийн хүмүүс хожим мэдсэн. Саддам Хусейний үй олноор хөнөөх зэвсэг, бактерлогийн аюулын тухай илтгэлүүдэд зон олон итгэж байсан үе.

**2003 оны гуравдугаар сарын 19.** XXI зууны хоёрдугаар дайн дэгдэнэ гэдэгт нийтээрээ бараг эргэлзэхээ больсон цаг. Америкийн нисэх хүчин, хуурай зам, тэнгисийн цэргийн нүсэр цуваа Багдадыг онилон зэвсэг хэрэгслээ нэгэнт бэлтгэжээ. Есдүгээр сарын 11-ний халдлагыг Ж.Буш шинэ зууны эхний дайн хэмээн нэрлэлээ. Удаахийг нь өөрөө зарлахаар товчлуурын өмнө зогсов. Гуравдугаар сарын 19-ний шөнө Томагавк пуужингууд Багдадыг бөмбөгдөв. Бөмбөгдөлтийн сүр хүчинд сохроор ховсдуулсан биржийн дилерүүд нэг баррель нефтийн үнэд хоёр ам.доллар өгөхөө зарлан бархиралдаж эхэлснийг яана. С.Хусейн, түүний генералууд үгүй болсон, Томагавкууд Багдадын гоёмсог харшуудыг газартай тэгшилсэн хэмээн их л эрт баярласан нь тэр. Гэсэн ч өнөөдрийг хүртэл Иракийн нефтийн цооногуудыг холбоотны цэрэг аюулгүй хамгаалж чадсангүй ээ. Чухам энэхүү нефтийн цооногууд эвслийн цэрэг гэгчийг бүрдүүлэх өгөөш, тохиролцооны хөзөр болж байлаа. Польшууд хар алтанд санаархаж буйгаа ил зарлаад 2500 цэргээ их цөлийн шуурганаар илгээж орхив. Хүйтний улирал өндөрлөж, алдарт цөлийн шуурга тавьж эхэлсэн үе.

**Tsergiinbag@yahoo.com**

Шуурганы хүч намжин, улмаар халууны улирал залгасан өдрүүдэд Монголоос 174 хүнтэй эхний баг хөдөллөө. Тэднийг 60 градусын халуун галт хэлээр ороох адил угтав. Харин АНУ-ын том хотынхон «Энэ удаа монголчууд энхийг сахиулахаар ирлээ» гарчигтай материал нийтэлсэн «Нью-Йорк таймс» сониныг уншиж суулаа. Гайхалтай нь тэрхүү материалд «Цэргээ илгээх тухай Монголын талын санал Америкийн засаг захиргааг үнэхээр гайхшруулсан. Учир нь ингээч гэж гуйгаагүй байсан» хэмээн Вашингтонд төвтэй тус хоёр улсын бизнесийн харилцааг дэмжих бүлгийн дарга, ноён Стивен Р.Саундерс ярих» хэмээн цүл пал өгүүлсэн байлаа. Монгол Улс холбоотны цэргийн эгнээнд нэгдсэний учир шалтгааныг хайсан үгс бөмбөрцгийн баруунтаа сонсогдож эхэллээ. Олон улсын эрүүгийн шүүхийн болон байгаа улсынхаа шүүхийн өмнө ял сонсохгүй мултрах боломжийг Америкийн цэргүүдэд олгох тухай хэлэлцээрт Монгол Улс нэгдэн бусад 60 орны хамт гарын үсэг зурсан юм. Гол төлөв АНУ-аас тусламж горьддог ядуу буурай 60 улсын дунд монголчуудын нэр багтжээ. Энэхүү хэлэлцээр манай цэргийнхний Иракийг зорих зам мөрийг заслаа. Tsergiinbag@yahoo.com хаягаар бид дайчидтайгаа харилцаж, халуун цэгийг зорьсон анхны хэдийнхээ араас чих тавьж суусан.

Эдүгээ цахим шуудангийн танил хаяг тавдугаар ээлжийнхэнд буухиалав. Эр цэргийн тангаргаа залуус нэр төртэй биелүүлж, гавьяа шагнал ч хүртэв. Монголчуудад талархаж буйгаа илэрхийлсээр АНУ-ын Жанжин штабуудын нэгдсэн хорооны дарга, генерал Р.Майерс Улаанбаатарт ирж, хоёр улсын харилцаа цэргийн салбарт чамгүй урагшиллаа. Ал Хилла орчимд бурхны авралаар амгалан тайван байж, Иракийн мухардалд цөхрөх сэтгэлзүй хараахан халдварласангүй. Гэвч...

### **МУХАРДЛЫГ ХАМГААЛАХААР**

Персийн булан дахь цэргийн ажиллагааны үр дүнд иргэний дайны гал хүрээгээ тэлэн авалцаж байна. Лондон халдлагад өртөв. Терроризмыг үүрэнд нь багалзуурдах төлөвлөгөө эргээд холбоотнуудад аюул занал тарилаа. Мухардлыг мэдэрсэн эвслийн цэргийнхэн золигийн Иракаас гарахаа дараалан мэдэгдэв. Өнөөх өгөө авааны тохироо ч биелэх бүтэл муутай. Иракийг зорин манай цэргийн шинэ баг мордох бүрийд толгойд энэ л асуулт зурсхийдэг. «Чарли» баазын хамгаалалтын үүргээ гүйцэтгэхээр тэд хөдөлж байна. Польшийн дивизийн эзэмшлийн секторт «Чарли» байршжээ. Харин польшууд нэг өдөр ганзагалаа юугаа бэлтгэхийн цагт хамгаалалтын хэд маань хэндээ харьяалагдаж, хэнээс юуг хаацайлан хоцрох бол? Иракийн мухардлыг хамгаалан үлдсэн сүүлчийн рот гэсэн «гавьяа»-г америкчууд л бидэнд шагнаж магадгүй юм.

...Дулааныг зорьдог  
шувуудын зам энэ  
нутгаар дайран  
өнгөрдөг.

Машины гэрэлд  
сандчин яг өмнө давхих  
жижигхэн туулай,  
«Арван хэдтэй охинтой,  
сонины эрхлэгч гэхэд  
чи яасан залуухан  
харагдах юм» гэх  
хөгшдийн үг, сүрэл

өвсний анхилуун үнэр  
хамар цоргин, оч үсэрч  
оддын зүг аниргүйхэн  
холдох зуур улаан,  
алтан шар навчсыг  
гэрэлтүүлсэн  
гайхамшигт агшин,  
түүдэг галд шарсан  
хөөсөнцрийн содон  
үнэр сэлт тэр л  
янзаараа сэтгэлд  
үлджээ. Америкийн

фермер ургацын  
баяраа тэмдэглэж  
байлаа. Жүчээнд  
уясан морьд зөөлөн  
тургих мөчид яагаад ч  
юм бараантах тэнгэр  
өөд удтал харлаа. И-  
мэйлээ шалгахсан.  
Түүнээс минь нисэн  
ирдэг халуухан үгсийн  
амтанд бурхан хүртэл  
атаархах байх даа.

2002 он





# Дайн эхлээгүй биз?

Энэ өглөө лав дайн эхлээгүй. Цагаан ордны эргэн тойронд тоймгүй олон хэрэм гүйлдэж, хүмүүс ажил төрөлдөө очдог замаа дагаад, юу ч өөрчлөгдөөгүй мэт. Гэвч өглөө бүр аяндаа санаанд буух дайны тухай түгшүүрт асуулт нээлттэй хэвээрээ.

«Есдүгээр сарын 11-нээс хойш бидэнд ойлгомжгүй зүйл тун олон болсон. Түмэн асуулт хариу нэхэж байна. Осам Бин Ладен амьд уу? Тэр хаана байгаа юм бэ? Америк Ирак руу үнэхээр довтлох уу? Хэрэв довтолбол хэзээ? Ямар зэвсэг хэрэглэх вэ? Энэ мэт уншигчдынхаа олон асуултын нэгэнд нь бид тоймлон хариулахыг хичээсэн юм» гэж «Вашингтон Пост» сонины манайхаар бол хариуцлагатай нарийн бичгийн даргын орлогч Милтон Колеман ярьж байна. Тус сонин **2002 оны есдүгээр сарын 22-ны өдрийн дугаартаа «Хусейний цэргийн баазад цохилт өгөх дайны төлөвлөгөө»** нэртэй материал нийтэлсэн билээ. Уг нийтлэл тэр даруйдаа асар шуугиан дэгдээж, Цагаан ордон «Вашингтон Пост»-ыг үндэсний аюулгүй байдалд хохирол учрууллаа хэмээн зэмлэв.



Тус сонины хамгийн чухал өрөө энэ болов уу. Ханцуйгаа шамлаж, зангиагаа ялимгүй сулласан эрхлэгч нар жижигхэн өрөөнд «Budget» гэсэн том хаягтай олон хуудас ноорог өмнөө дэлгэн суулаа.

Пентагоны чандлан нууцалж байсан мэдээлэл «Вашингтон Пост»-ын эхний нүүрт хэвлэгдэн 750.000 ширхэг тарж одсон төдийгүй интернэтийн хязгааргүй орон зайгаар цацагдав. «Вашингтон Пост»-ын зөвхөн онлайн хувилбарыг мөнөөх есдүгээр сарын 11-ний ад зэтгэрийн халдлагын өдөр гэхэд 22 сая хүн уншсан гэдэг. Тиймээс Иракт довтлох төлөвлөгөөг гардан боловсруулж буй Пентагоноос холгүй байрладаг тус сониныг нууц задруулсан, бараг «урвагч» хэмээн загнагчаалаа. Ноён Милтон «урвагч» биш болохоо дээр өгүүлсэн ишлэлээрээ тайлбарласан юм. Иракийн эсрэг дайны тухай яриа сүүлдээ Америкт улс төрийн хэрүүлийн гол сэдэв болж, өнгө аясаа эрс өөрчилж

эхэллээ. Сенат дахь Ардчилсан намын тэргүүн Том Дачле Ж.Бушд хэрхэн гоморхохыг бүгдээрээ л телевизээр харсан даа. «Ардчилсан намынхан үндэсний аюулгүй байдалд санаа зовохгүй байна гэж Буш хэллээ. Ийм үгнийхээ төлөө тэр биднээс, Америкийн ард түмнээс уучлалт гуйх ёстой» хэмээн ноцтой царай гарган ярих аж. Сонгуулийн үнэр Иракт довтлох төлөвлөгөөтэй хамт ханхалж байна. Энэ зуур Америкийн төдийгүй дэлхийн хэвлэлүүдийн эхний нүүрт дайны сэдэв цаг агаарын мэдээтэй ижил тогтмол харагдах болов.

**Есдүгээр сарын 24-ний 14.00 цаг.** «Вашингтон Пост» сонины эрхлэгч нарын уулзалт эхэллээ. 12 эрхлэгч байраа эзлэв. Маргаашийн дугаарын эхний нүүрт ямар шуугиант материал гарах бол? Америкийн үндэсний хэмжээний гурван том сонины нэг, Вашингтон хотын гол хэвлэл асуудалд хэрхэн хандахыг бүгдээрээ анхааралтай ажиглаж байна. Тус сонины хамгийн чухал өрөө энэ болов уу. Жижигхэн өрөөнд ханцуйгаа шамлаж, зангиагаа ялимгүй сулласан эрхлэгч нар «Budget» гэсэн том хаягтай олон хуудас ноорог өмнөө дэлгэн суулаа.

**-Майк чи эхлээд ярь.** Эрхлэгч нарын шуурхайд Фил Беннетт уригдаж байна. Түүний хажууд Милтон Колеман суусан харагдана. Энэ хүний нэрийг «Вашингтон Пост»-ын дугаар бүрээс харж болно доо.

**-Иракт довтлох Америкийн төлөвлөгөөний талаар Тони Блэйрийн ярьсныг эхний нүүрт санал болгоё.** Майк ингэж хэлээд Блэйрийн хэлсэн үгний агуулгыг товч илэрхийлэв. Майк манайхаар бол мэдээний редактор бололтой.

**-Ойлголоо. Том чамд юу байна?**

-Хүүхдүүд осолд оржээ.

**-Хэдэн хүүхэд, яг юу болсон бэ? ...** Асуулт хариулт энэ мэтээр үргэлжлэв.

«Budget» нэртэй нөгөө олон хуудас төлөвлөгөөг юу ч үгүй болтол нь «шиншилж» дууслаа. Ойлгомжтой. Маргааш нь буюу 25-ны өглөөний «Вашингтон Пост»-ын эхний нүүрт дахиад л дайны сэдэв, гэхдээ Тони Блэйрийн зурагтай гарах нь. Оройхон, 18.00 цагийн үед эрхлэгч нар дахиад эхний нүүрээ эцэслэн ярилцах гэнэ.

«Хажууханд Цагаан ордон байдаг, тэнд манай сониныг хамгийн түрүүнд уншдаг болохоор ямар хэцүү гээч» хэмээн Милтон тоглоом шоглоомоор ярив. Дайн энэ өдрүүдийн гол сэдэв болжээ. АНУ-ын нийслэлийн төв хэсэгт тоймгүй олноороо гүйлдэх хэрэмнүүд л энэ тухай мэдээгүй байна. Тэд өвөлд бэлтгэж боргоцой зөөгөөд ер завгүй мэт. Телевизийн сувгууд сав л хийвэл судалгаа явуулна. Иракийн эсрэг Америк дайтах нь зөв үү хэмээн үзэгчдээсээ асуух аж. Есдүгээр сарын 11-ний халдлагыг Жорж Буш XXI зууны эхний дайн хэмээн нэрлэжээ. Тэгвэл энэ зууны II дайныг Буш өөрөө өдөөх үү? Дэлхийг сүүдэрлэх дайны шийдвэрийг Буш ганцаараа гаргах нь зөв үү? Хими, бактериологийн зэвсгийг Багдад хариу болгон хэрэглэвэл түүнээс улс үндэстнээ хэрхэн хамгаалах вэ хэмээн америкчууд тасралтгүй хэлэлцээр байна.

Хэрэм, Буш, Хусейн гурав налгар намрын энэ өдрүүдэд хоорондоо нэг л авцалдаж өгөхгүй сэдэв аж.

2002 он

# Америкийн индианууд

Нэг, хоёр, нэг, хоёр. Баруун, зүүн... Америкийн индианууд бүжиглэж байна. Бүргэдийн өд сөдтэй сүртэй өмсгөл дороо учиргүй халууцаж байгаа ч тэд урьд шөнийн турш тасралтгүй бүжлээ. «Ийм өмсгөл дор хаяж 400 ам.долларын үнэтэй» гэж Доррээн ярив. Доррээн Еллоу Берд ( Yellow Bird буюу Шар өнгөт бүргэд гэж орчуулж болмоор) хэмээх содон нэртэй энэ бүсгүй өөрөө Америкийн индиан.

Умард Дакотагийн Sioux Falls хотод хүйтэн байлаа. Манан татаад зэврүүн оргино. Америкийн уугуул иргэд хойд нутгийнхаа хамгийн гунигтай хэсэг рүү шахагдсан мэт санагдав. Тэд жил бүр энд урлагийн наадам зохиож, уулзаж учирдаг.

Том бөмбөр хүчтэй цохин, эртний индиан дуугаа сэтгэл сэрхийтэл хүчлэн дуулалдах аж. Орчин цагийн Америкийн индианууд төрөлх хэлээ бараг мартсан боловч зөнгөөрөө тэр зэрлэг аялгууг даган дуулж, нэг хэмнэлээр зүүн, баруун, нэг, хоёр хэмээн тоолох адил дор дороо бүжиглэнэ. «Доррээн, чи босч бүжиглэхгүй юм уу?». Тэр миний асуусныг сонссон шинж алга. Уртын дуутай төстэй уянгалсан гунигтай аялгууг дагаад бодол болжээ. 180 орчим бүжигчин энд байгааг би өмсгөл дээрээ хадсан дугаараас нь ойлгов. Өндөр настан төдийгүй бяцхан жаалууд ч байна. Хонх зүүсэн арьсан хувцас нь содон аж. Том тойрог болж, элээ, бүргэд лугаа дэвэн явахаас гадна охид, хөвгүүдийн бүжгийг тусад нь зарлаж байна. Индиануудын наадмыг үзэхээр өнгөрсөн бямба гаригт энд олон хүн цугласан байв. Тэд бас өөрийн гүнжтэй нь гайхалтай. Гүнжтэйгээ зургаа авахуулж сүйд болцгооно. Индианчуудын мисс л гэсэн үг юм даа.

Хойд Дакота нутгийн нийт хүн амын 4.9 хувь нь америкийн индианууд юм. «Онгон байгалийн үлдэгдэл» гэж тэд өөрсдийгөө өргөмжилдөг. Энд нээгдсэн үзэсгэлэнд гараар урласан арьсан эдлэлүүд, байгалийн тухай, индиануудын амьдралыг харуулсан зураг олон. Зарим бүтээлээ тэд 4000 хүртэл доллараар борлуулах юм. Үзэсгэлэнгийн том танхим дүүрэн тунгалаг аялгуу түрүүнээс хойш эгшиглээд байлаа. Өндөр том биетэй, монхор хамартай, урт хар үсээ хоёр салаа сүлжсэн индиан залуу хөгжим тоглож байсан нь тэр. Брайан Акира гэж өөрийгөө танилцуулав. Анхилуун үнэрт модоор урласан хөгжим нь лимбэ, бишгүүртэй адил уулын голын тунгалаг аялгуу түгээх юм. «Бүргэдийн мөрөөдөл» нэртэй CD-гээ надад дурсгал болгоод, Монголын тухай асууж байна.

Америкийн индиануудыг ялгаж танихад ер ядах юмгүй. Хамаагүй хайш яйш хувцаслана, бүдүүлэгдүү, гол төлөв учиргүй том биетэй. «Тэд монголчууд шиг байгалийн гаралтай хоол хүнс хэрэглэдэг, хүнд хүчир ажил хийдэг байсан. Харин одоо цагаан арьст америкчуудтай адил бэлэн хоол идэж, бие зовоох хүнд ажлаа хийхээ больчихоор бүгдээрээ л хэт таргалж эхэлсэн. Эндхийн хүн амын 90 хувь нь чихрийн шижин өвчтэй» гэж Доррээн ярив. Доррээн өөрөө бас сүмогийн бөх шиг том биетэй. Түүний охид ч ялгаагүй.

Америкийн индиануудын амьдрал дахь өөр нэг сонин зуршил нь бүгдээрээ олон хүүхэдтэй. Доррээн эхээсээ 16-уулаа бол түүний охин таван хүүхэдтэй, Нөхрийнх нь ах 13 ам бүлтэй өнөр бүлийг тэргүүлдэг гэнэ. Гэхдээ тэднийг ядуу хэцүү амьдардаг гэж болмооргүй. Доррээний охиных заримдаа жижиг автобусаа

Доррээн ач хөвгүүдийнхээ үсийг самнаж суув.

Бүсэлхийгээ шүргэсэн урт гээгтэй хоёр хөөрхөн ач хүүтэй юм.

**-Хөвгүүдийн- хээ үсийг яагаад тайрдаггүй юм?**

-Юу гэсэн үг вэ? Эд чинь индиан залуучууд шүү дээ. Аав нь хүртэл урт үстэй байгаа биз дээ.

хөлөглөөд аялалд явдаг. Хүү нь, нөхөр нь бас сүүлийн үеийн загварын сайн унаатай харагдлаа. Алим, чавганы модод суулгасан сайхан цэцэрлэгт нь гишгэх зайгүй улаан, шар, ногоон жимс унажээ. Доррээн ач хөвгүүдийнхээ үсийг самнаж суув. Бүсэлхийгээ шүргэсэн урт гэээгтэй хоёр хөөрхөн ач хүүтэй юм.

**-Хөвгүүдийнхээ үсийг яагаад тайрдаггүй юм?**

-Юу гэсэн үг вэ? Эд чинь индиан залуучууд шүү дээ. Аав нь хүртэл урт үстэй байгаа биз дээ.

Нээрээ аав нь ч бас сайхан урт үстэй, сүртэй том бие хаатай залуу байна. Хүчирхэг хөгжлийн хажууд урт үсээ тээж үлдсэн тэдний сэтгэлийн үгийг нүргэлэх бөмбөр, тэнхээ мэдэн түрэх гунигт аялгуунаас нь мэдэрч болно. Хүйтэн сэрүүн Дакота нутгаас шувууд буцаж, дулааныг зорьсоор байлаа. Бүүдгэр тэнгэрийн дор хаашаа л харнав шувууд зэллэн холдоно.

**2002 он**

# Америк бууз

Монгол эзэгтэйн хийдэг буузанаас ялимгүй томыг тэд бэлтгэдэг. Харин жигнүүрт хийж «25 минут» болгохгүй. Хөнгөхөөн шарж орхино. Үхрийн махан хачиртай, нямбай чимхсэн бууз өнгө алаглуулан амттан өрсөн ширээнээ учиргүй танил харагдав. Америкийн хөдөөд фермерийн аж ахуй эрхлэгчийн барьсан оройн зоогийн үнэр, амт бидний хувьд огт өөр байж мэднэ. Тэдний ердийн амьдрал ч өвөрмөц өнгө амттай.

Дөрвөлжлөн боосон сүрлээр Брэйи Григор суудал засаад том гэгч чиргүүлд зочдоо тавтай морилохыг урив. Тод ногоон трактор нь түжигнэн асах зуур содон сайхан үнэртэй сүрлэн суудалдаа бүгдээрээ шигдлээ. Брэйний гэргий Энн нь Гранд Фокс хотын өдөр тутмын сонинд ажилладаг. Өнгөрсөн бямба гаригийн амралтаараа «Grand Forks Herald» сонинхоо ажилтнуудыг хөдөө байдаг гэртээ урьсан юм. Эннийн ээж, аавын эдлэн газрыг сонинхоон надад зам зуур зааж өгсөн билээ. Төмс, элсэн чихрийн манжин, наранцэцэг, буудай тариалдаг уужим талбайнуудад нь энэ намрын их ажил шувтарчээ. Нэг ёсондоо тэднийх ургацын баяраа хийж байна.

Шингэх нарны зөөлөн туяа тариалангийн талбайг хучжээ. Ирэх хавар хүртэл чийг хураан, «нуруу амраах» цаг ирсэн болохоор ногоон трактортой хэдэн хүн зугаалахыг чимээгүй ажиж буй мэт санагдав. Үржил шимээрээ Гранд Фокс хот орчмын газар гайхуулдаг.

Америкийн Хойд Дакота мужийн гол хот нь Рэд Ривер буюу Улаан голын чийглэг хөндийд төвхнөсөн юм. Сургуулийн хөл бөмбөгийн талбайгаас жижиг хэмжээтэй газраас ургац хураахад лав 1400 ширхэг талх хийх хэмжээний буудай авна гэж надад тайлбарлалаа. Хойд Дакота нь чихрийн манжин, төмс, зөгийн бал хамгийн их хураадаг, чанараараа ч гайхуулдаг Америкийн дөрвөн мужийн нэг ажээ. Тийм болохоор эндхийн түргэн хоолны газруудын шарсан төмс илүү амттай санагдаж магадгүй.

Бүр 1800-гаад оны дунд үеэс энд газар тариалан эрхлэх болсон тул хөдөө аж ахуйн техник хэрэгслийн үйлдвэрлэлээрээ нэгдсэн улсдаа дээгүүрт ордог. Авсаархан, найдвартай тэдгээр техникийг хийдэг мэргэжилтнүүдийг манай фермерүүд лав сонирхох биз ээ. Хойд Дакота мужийн тэргүүн Эд Скафертай Монголын тариалангийн бүсийнхэн яагаад холбоо тогтоож болохгүй гэж. Цаг агаар нь ч манайтай ойролцоо юм. Атаархмаар ганц зүйл нь ус чийг. Хар шороон үржилт хөрсөнд соёлсон буудайгаар төрөл бүрийн гурил үйлдвэрлэж байна. Буузны амт гурилынхаа чанарыг хэлээд өгдөг хойно.

Орой нь бид түүдэг гал тойроод хөөсөнцөр шарж эхлэв. Том гэгч хөөсөнцөр чихрийг мөчирт хагган шарж суух хэчнээн зугаатай байсан гээч. Ялимгүй шармагцаа тэр дор нь шоколад дээр наагаад үзээрэй. Нимгэн жигнэмэг завсар нөгөө «хайлмаг» эдээ хийгээд амтлаарай. Тэгээд түүдгийн дэргэд очис үсрэхийг харж, ажилсаг фермерүүдийн зугаатай яриаг сонсон зогсвол Америкийн хөдөө нутгийн амт, үнэрийг хэзээ ч мартажгүй сэтгэлдээ шингээх нь лав. Арвин ургац хайрласан үржилт талбай сарны гэрэл дор цайран харагдаад, жүчээнд адуу зөөлөн тургих нь сонсогдов. Их ажлын дараах ийм нэг амгалан мөч сэтгэлд хоногшжээ.

# Хакуна Матата

Элтон Жоны хөгжим, уран сэтгэмжээр энэ шоу амилсан юм. Аравдугаар сарын 24-ний үдэш Нью-Йоркийн Бродвейн гудамж үймсэн олны хөлд улам дарагджээ. Шинэ Амстердамын театрт «The Lion King» шоу эхлэх гээд догдолсон хүмүүс дүүрэн. Бүр гуравдугаар сард буюу «The Lion King» тоглолтоос долоон сарын өмнө тасалбарыг минь захиалж өгсөн найзууддаа энд талархаж зогслоо.

Симба, Муфаса, Элтон Жон гурвыг мэдэхгүй хэн байх билээ. Телевизийн дэлгэцээс том, жижиггүй үзэж харсан «The Lion King» хүүхэлдэйн киног алдарт Бродвейн шоу ертөнцөд дуурь, балет, цирк, өнгө гэрэл хамтагасан сүрлэг баяр болгон тавьжээ. Амстердамын театрын таазанд бараг тулсан, хамгийн өндөрлөг дэх суудал 35 ам.долларын үнэтэй. Хамгийн хямд тасалбарын ханш ийм. Илүү тохитой суудалд тухлахын тулд 100 гаруй ам.доллар төлнө.

1903 онд байгуулагдсан тус театрыг Уолт Дисней компани хоёр жилийн турш сэргээн засварласан юм. Ингээд өнгө зүс нэмсэн театрт 1997 оны намар «Арслан хаан»-ыг (The Lion King) тайзнаа зориулсан шив шинэ хувилбараар найруулан амьдруулав.

Америкийн африк амьсгал ямар үнэртэй вэ? Африкийн онцгой содон хөгжим

дуу, хурц өнгө, хэмнэл хөдөлгөөн дээр Америк шоуны хүчийг нэмээд мэдэрч чадвал «Арслан хаан»-аар амьсгална. Элтон Жон, Тим Райс нарын өвөрмөц сэтгэмж багачуудын дуртай хүүхэлдэйн киног томчуудын жинхэнэ шоу болгон хувиргасан байна. Тоглолтын нэмэлт хөгжмийг Лебо М, Марк Мансина нар зохиож, бүжиг дэглээчээр Гард Фаган ажилласан аж.



20.00 цагийн харанга цохиод удаагүй байтал шаргал, бор, ногоон өнгө ялгарсан тайз дээр Рафики гарч ирвэ. Симбаг толиндоо, Муфасаг тэнгэрийн уудамд оддын дунд харуулж чаддаг шидэт Рафикиг бүгдээрээ мэднэ дээ. Тэр Африкийн аль нэг хэлээр хашгичин дэвхцэж байх зуур тайзны хажуугийн тагт дээрээс гэнэтхэн бөмбөр дэлдэн урт уянгалсан уриа

дуудлага сонорт хүрлээ. Зэргэцэж суусан бүсгүйг маань Кладис Кимонто гэдэг. Тэр Кенийн Найробын өдөр тутмын том хэвлэл болох «East African Standard» сонины эрхлэгч юм. Мөнөөх шидэт эмгэний хашгичаад байгаа африк үгсийг Кладис орчуулж өгөв. «Энэ нутагт том баяр эхлэх нь. Их хаан Муфаса хүүтэй болсоон, таминь ээ». Ийм сүржин зар дээр удалгүй хөгжим, хөдөлгөөн нэмэгдэж, анааш, ирвэс, гөрөөс, заан тугалтайгаа, тогь шувууд бас цуглалаа. Жүжигчид халуун орны өвс ургамлын дүрд хүртэл хувирчээ. Амсхийх зайгүй дүрслэл, хөдөлгөөн солигдоно. Тайз аажим эргэж төв хэсэгт нь өндөр цохио алгуур босохыг тээр дээр, 35 долларын «муу» суудлаасаа сайтар ажиглав. Арслангуудын хаан, энэ нутгийн эзэн Муфаса алтлаг шар эрээн хувцас, баг сэлттэй. Харин түүний муу санаат үеэл Скар хүрэн улаан дээлтэй, урт гэгч сүүлтэй харагдана. Дөнгөж төрсөн Симбаг зөөлөн өхөөрдөм тоглоомоор орлуулсан, түүнийгээ эцэг Муфаса дээр гэгч өргөхөд нь эхлээд инээд хүрээд байлаа. Хүүхдүүдийн сэтгэлийг эзэмдсэн хүүхэлдэйн киног томчууд тайз дээр яажшуухан амилуулна даа хэмээн бодсон. Гэвч төсөөлж үнэмшихэд бэрх жинхэнэ шоуны «дарамт» дор дөрвөн цагийг өнгөрүүлсэн билээ. Тимон, Пумбаа хоёрын зугаатай дуунууд, гуниггүй амьдралыг үзүүлсэн хэсэг бүгдээрэнд нь таалагдаж,



**Толгой өвтгөж гуних зүйлгүй  
Тун зугаатай амьдрах сайхан  
Хакуна матата!  
Амьдралын маань философ энэ**

гэсэн хөгжилтэй дууг нь томчууд дор дороо аялахаас буцсангүй. Тэгсэн хормын дараа сэг зэмээр дүүрсэн хавцал хясаа харагдан, цөөвөр чононууд зэвүүн хахир хоолойгоор өөдгүй орилолдов. Ганц минутын чөлөө өгөлгүй анхаарал барьж чадахаар хөгжим, бүжиг, гэрлийг ээлжлэн зохиомжилжээ. Нийт 20 удаа тайз солигдов. Шигтгээ болгож Африкийн зарим хэлээр үе үе дуулж, ярих боловч Симба, Муфаса, Скар, Зазу бүгдээрээ мэдээж англиар хүүрнэнэ.

Театрт хурсан олон Европын үзэгчдээс огт өөр. Гоёлын даашинз, жижиг цүнх сэлтгүй. Америк үзэгчдийн олонх нь жийнс, хэлхгэр цамцаа театрт ч сонгосон байна. Ялимгүй шоглол бүрийг андахгүй чангаар инээн, гайхамшигт үзэгдэл бүрийн эцэст тэд сэтгэлийн хөдлөлөө харамгүй илэрхийлнэ.

«Симба, чи хэний хүү болохоо мартаа юу?»

Одот тэнгэрт Муфасагийн дүр гэв гэнэт тодорч, залуухан эрч хүчтэй Симба итгэж ядан тэнгэр өөд харж зогсоно. Хүнгэнэсэн тэр дуу Амстердамын театр дүүрэн олныг эзэмдэв. Жүжигчид нь хүчирхэг хоолойтой, бүжиглэх, жүжиглэх төдийгүй циркийн хялбар үзүүлбэрүүдийг хөнгөхөн гүйцэтгэнэ. Шоу асар үнэд орсны нууц нь жинхэнэ авьяасыг үнэлснийх аж. Тимоны дүрийг бүтээсэн жүжигчин Дэни Рүтиглиано нь мюзиклийн төрлөөр Америкийн оны шилдэг авьяастнаар тодорсон байх юм.

«Энэ үдэш дурлалаа мэдэрч байна уу» хэмээх Элтон Жоны дууны зүрхэнд нэвчсэн танил аялгуу үе үе эгшиглэж байна. Үгийг нь бүрэн ойлгодоггүй ч бидний хүүхдүүд тэр дууг тун сайн мэддэг. Хажууд охин маань хэрэв байсан бол дагаад л аялах байсан даа. «Арслан хааны» хөгжмийг хамтран бичсэн Лебо «Барууны болон Африкийн хөгжим нэгдэж хуримласан учраас л энэ тоглолт хязгааргүй баялаг, түмэн өнгөтэй болсон» гэж тэмдэглэжээ. Шоу бизнесийн амтыг мэдэрч, эцсийн эцэст их урлагийн үзэгчид ирээдүйд хаашаа урсахыг харья гэвэл 212-282-2907 утсанд залгаарай. Бродвейн гудамж дахь Шинэ Амстердамын театрт тоглолт үзэхийн тулд олон сарын өмнө тасалбараа энэ утсаар урьдчилан захиалдгийг битгий мартаарай.

Амьдрал гэгч төвөгтэй эд. Гэхдээ бухимдаад яахав. Хакуна Матата! Амьдралын ийм философтой байхад тэр бүр бүдэрч унаад байхгүй шүү гэж Тимон, Пумбаа хоёр үргэлжлүүлэн дуулсаар байна. Магадгүй ийм өөдрөг санаа, эерэг эрч хүч нь бяцхан багачууд төдийгүй томчуулыг байлдан дагуулдаг биз ээ.

Арслангийн хаан Муфасагийн дүрийг өнгөт арьст сайхан эр чадварлаг бүтээжээ. Сэмюэл И. Райтын өөр нэг мюзиклд дуулсан «Тэнгисийн дээгүүр» хэмээх дуу түүнийг Оскарын эзэн болгосон билээ. Бяцхан Симбад хар арьст, сэргэлэн хүү тоглосон бол хаан ширээ залгамжлагч залуу Симбагийн дүрийг Клифтон Оливер амьдруулсан аж. «Гэр бүл, найзуудынхаа хайр халамж, дэмжлэгт баярлалаа» хэмээн Оливер тоглолтын дараа тайзнаас талархал илэрхийлсэн билээ. Алга ташилт, уухай Амстердамын театрын танхимыг эзлэв.

# «Нью-Йорк таймс»-ын эрхлэгч Монголд ирэхийг хүсч байна

-Би Монголын тухай маш бага зүйл мэднэ. Үзэсгэлэнтэй нутаг болов уу гэж бодож байна. Очиж үзэхийг хүсдэг. Монгол хүмүүсийг үү? Өөрөөр тань төсөөлж байна шүү. «Нью-Йорк Таймс» сонины Гадаад мэдээлэл хариуцсан эрхлэгч Рожер Кохен ингэж ярих. Тэр бидний талаар бага зүйл мэднэ. Гэхдээ дэлхийн том сонинд Монголын тухай мэдээлэл илгээдэг сурвалжлагч хараахан байхгүй болохыг дурдаад, «Танайд заавал очиж үзнэ» хэмээн давтан өгүүлэв. «Нью-Йорк Таймс» сонин 20 эрхлэгчтэй. Тэдний нэг Рожер энэ албанд ирээд удаагүй. 2001 оны есдүгээр сарын 11-ний тэр хар өглөө хувь заяаны тохиолоор шинэ ажилдаа оржээ. Тэрбээр өдөр бүр 150 хуудастай хэвлэгддэг мэдээллийн аварга машины Гадаад мэдээний хэсгийг толгойлохоор ирсэн юм.

Хэн ч мэддэггүй, хүн тоодоггүй улсын иргэн гэж гоморхоод яахав. Хязгаар нутгаа дэлхийд танилцуулах нь өөрсдийн маань, ялангуяа сэтгүүлчдийн үүрэг. Гэхдээ Ассошейтэд Пресс агентлаг хэмээх нүсэр байгууллагад монголчуудын анд нөхөр ажиллагчийг дуулгая. Сюзэн хэмээн өөрийгөө танилцуулсан бүсгүй дэлхийн хамгийн ууган агентлагийн Шуурхай мэдээний хэсгийг ахалдаг. Надад сонирхуулах гээд хэд хэдэн гэрэл зураг бариад иржээ.

Хэвлэлийн хүрээлэнгийн ажилтан Б.Одсүрэн, орчуулагч Л.Номин, мөн монгол багачуудтай хамт авахуулсан зургаа үзүүлж «Танай хүүхдүүд интернэтийг тун их сонирхож байсан шүү» хэмээн ярих. Сюзэнээс «Монголын тухай юу мэдэх вэ?» гэж асуух хэрэг гарсангүй. Тэр өөрөө бүгдийг үзэж харсан юм байна.

*Нью-Йорк, Вашингтон, Гранд Фокс хотуудын гудамжинд  
«Өнөөдрийн асуулт» булангаа би бэлтгэж яваа юм аа. Монголын  
тухай америкчууд юу мэддэг юм бол?*

-Танай орны тухай ер нь мэдэхгүйтэй адил. Анх харсан монгол хүн гэвэл өөрөө гэсэн хариултыг байнга сонсож явлаа. Харин тэргэнцэрт суусан хөл муутай эр хүүтэйгээ хамт интернэтээс манай орны талаар сонирхож үзсэн гэнэ.

-Жижигхэн улс гэж ойлгосон. Нэг удаа интернэтээс уншсан юм. Цаг агаар нь эндхийнхээс их өөр гэж Брэд Габриэлсон өгүүлэв. Тэр өөртэйгээ ижил тахир дутуу хүмүүст зориулсан тэргэнцрийн шат хийдэг «Roll-a-Ramp» компанид ажилладаг.

Юм юм сонирхож явдаг сэтгүүлчдээс асуугаад үзвэл яах бол? Хойд Дакота мужийн өдөр тутмын ганц сонин «Grand Forks Herald»-ийн сурвалжлагч Крис Женсен сандарч «Монгол чинь Хятадын ойролцоо байдаг байх аа?» гэхээс цааш хэтэрсэнгүй. Говийн байгалийг харуулсан зураг бэлэглэж, Монгол Ньюс компанид бэлтгэсэн, монголчуудын тухай бүх төрлийн мэдээлэл бүхий CD үзүүлсний дараа тэр бага ч атугай мэдлэгтэй болсон байх аа гэж найдна. Тэгвэл мөнөөх «Grand Forks Herald» сонины эрхлэгч Майк Жакобст хэлэх зүйл бий.

-Хэдэн жилийн өмнө танай сонины Ерөнхий эрхлэгч манай редакцид зочилж, монгол морьдыг дүрсэлсэн уран зураг бидэнд бэлэглэснийг санаж байна гэж Майк ярилаа.

-Манай орныг хэрхэн төсөөлдгөө хэлж өгөөч?

-Маш өргөн уудам нутагтай. Ихэнх хэсгийг нь говь эзэлдэг. Эртнээс

улбаатай баялаг түүхтэй. Хятад, Оростой хиллэж, түүхийн өөр цаг үеүдэд энэ хоёр их гүрэнд монголчууд ээлжлэн харъяалагдаж байсан. Нутгийн зарим хэсэг нь их үзэсгэлэнтэй, жуулчдын анхаарлыг татдаг гэж ойлгосон. Миний төсөөллөөр, манай Хойд Дакота мужтай байгаль цаг агаарын хувьд төстэй зүйл нэлээд бий байх. Хүн ам нь ч манай мужийнх шиг цөөн. Нэг том хоттой. Түүнийг нь Улаанбаатар гэдэг. Энэ нь мөн худалдааны чухал төв гэсэн.

Хүмүүсийнх нь тухайд гэвэл өөрийг чинь мэдэх боллоо. Таваас зургаан жилийн өмнө манай Гранд Фокс хотод монгол оюутнууд суралцаж байсан болохоор би зохих төсөөлөлтэй. Эелдэг, нөхөрсөг, Америкийн тухай ихийг ойлгож мэдэх, туршлага солилцох эрмэлзэлтэй хүмүүс. Би монголчуудын талаар үнэхээр сайн сэтгэгдэлтэй явдаг хэмээн тэрбээр нэмж хэлэв.

Монголд төрөл бүрийн төсөл хэрэгжүүлж, сургалт зохион байгуулсан америк мэргэжилтнүүд нутагтаа очоод бидний талаар үнэгүй сурталчилгаа хийдэг. Хүүе яадаг билээ хэмээн уулга алдаж зоволтгүй. Тэдний олонх нь Монголын тухай дулаахан дурсамжтай буцаж, эргэн тойрондоо ийм уур амьсгалыг түгээдэг.

Вашингтонд төвтэй Үндэсний радиогийн редактор Кори Флинтоф өнгөрсөн оны зургадугаар сард Улаанбаатарт ирээд манай хэд хэдэн аймгийнханд хичээл заасан юм. Арванхоёрдугаар сарын жавар сэнгэнэтэл тэр орон нутгаар хэсч, бэрхшээлээс илүүтэйгээр хөгжил дэвшилд яарсан хүсэл зоригийг монголчуудаас олж хараад урамшжээ. Говийн элсэн дунд Ерөнхийлөгч асан Жимми Картертай Флинтоф тулгараад «Даланзадгадын радиогоос явж байна. Таны аяллын талаар цөөн асуулт тавихыг зөвшөөрнө үү» хэмээн асуусан, тэгэхэд нь Картер, түүнтэй хамт явсан Монголын ноолуурын үйлдвэрлэлийг сонирхогч тэрбумтан Ричард Блам болон Ерөнхий сайд Н.Энхбаяр нар ялимгүй гайхсан байж магадгүй хэмээн тэмдэглэлдээ өгүүлжээ. Яг тэр үеэр өөр нэгэн тэрбумтан Жорж Соросыг Монголын их элсэн дунд бас харж болох байлаа гэж Флинтоф бичсэн байна.

Флинтофын дүрслэлээр Монголтой танилцсан хүмүүсийн нэг нь Патрик Батлер. Патрик эдийн засаг, бизнес, эрэн сурвалжлах сэтгүүлзүйн төрлөөр бичиж байсан хүн. Одоо Олон улсын сэтгүүлчдийн төвд ажилладаг.

-Миний бодлоор америкчуудын олонх нь Монголын тухай Чингис, Хубилай хаанаар дамжуулан төсөөлдөг. Харин танай шинэ үеийн талаар бид дөнгөж ойлгож, судалж эхлээд байна. Өмнө нь тун олон жил хаалттай, юу ч олж мэдэх аргагүй байсан бол одоо аажмаар нээлттэй болж буй. Монголд янз бүрийн сургалт явуулсан мэргэжилтнүүдээсээ шинэ зүйл сонсч, ойлгодог. Флинтоф гэргийтэйгээ танайд зургаан сар болоод ирснийхээ дараа их сонин сонсгосон. Гэр, монгол хоол зэргийн тухай тэд ярьж өгсөн. Ер нь би Монголд очих төлөвлөгөөтэй байгаа. Монголчуудын өмсдөг хувцас, бас эрэгтэйчүүдийнх нь спорт гэх бөх, морины уралдаан, нум сумны тэмцээний талаар сонссон. Гэхдээ тэнд эмэгтэйчүүд бас оролцдог гэж Флинтоф ярьж өгсөн юм байна. Хамгийн анх танилцсан монгол сэтгүүлч маань чи. Цаашид өөрөөс чинь шинэ сонин байнга сонсоно гэж найдаж байна гэв. Гэрэл зураг дээр Патрикийн хажууд харагдах бүсгүйг Кристал Уилиамс гэдэг. Америкийн сонины эрхлэгч нарын холбооны ажилтан тэрбээр Монголын сэтгүүлчдэд ажлын амжилт хүссэн юм. «Монголын тухай би их зүйл мэдэхгүй л дээ. АНУ болон Оростой өргөн хамтарч ажилладаг. Жижиг, гэхдээ ирээдүйтэй улс гэж төсөөлдөг. Гол нь бахархах зүйл ихтэй. Хэл, соёлын хувьд Оростой илүү ойр байж магадгүй. Сэтгүүлч та нар их урт зам туулахгүй, амжилттай явагдана гэдэгт итгэлтэй байна» хэмээн ерөөлөө.

Өөрсдөө бид бараг тоодоггүй болохоос Монголын талаарх шинэ мэдээллийг дэлхийн том агентлагууд идэвхтэй цацдаг Аравдугаар сарын 16-нд

**Говийн элсэн дунд Ерөнхийлөгч асан Жимми Картертай Флинтоф тулгараад «Даланзадгадын радиогоос явж байна. Таны аяллын талаар цөөн асуулт тавихыг зөвшөөрнө үү» хэмээн асуусан, тэгэхэд нь Картер, түүнтэй хамт явсан Монголын ноолуурын үйлдвэрлэлийг сонирхогч тэрбумтан Ричард Блам болон Ерөнхий сайд Н.Энхбаяр нар ялимгүй гайхсан байж магадгүй хэмээн тэмдэглэлдээ өгүүлжээ.**

Кофи Аннан Улаанбаатарт ирсэн тухай Ассошейтэд Пресс агентлагийн мэдээ өмнө байна. Түүнийг Бээжингээс Кристофер Боден илгээжээ. Далай ламын айлчлалын талаар өнгөрсөн долоо хоногт AP мөн л шуурхай мэдээлж, Франс Пресс ч өрсөлдөн материалаа цацсан. Энэ мэтээр бие биеэсээ түрүүлж шинэ мэдээлэл цацах өрсөлдөөн хэрхэн ширүүн өрнөж буйг аравдугаар сарын 24, 25-ны өдрүүдэд AP агентлагийн төвд үзсэн юм. Монголд ирж байсан мөнөөх Сюзен бүсгүй тун сандарсан явахыг олж харлаа.

-Вашингтоны ойролцоо Мэрилэндэд 13 хүн буудсан Мохамедын машинаас өчигдөр өглөө (2002 оны аравдугаар сарын 24-ний) олдсон зэвсэг аллага үйлдсэн буу мөн болох нь шинжилгээгээр нотлогдлоо гэсэн мэдээг AP түрүүлж авсан юм. Түүнийгээ тэр дор нь бэлтгэж цацахаар яарлаа. Компьютерийн товчлуур дарж ядах юу байхав, илгээж орхилоо. AP-гийн мэдээллийг дэлхийн олон оронд, Америкийн бүх мэдээллийн хэрэгслийн 99 хувь нь гэрээгээр худалдаж авдгийг санаарай. Уг нь бид мэдээллийг дор хаяж хоёр эх сурвалжаас тодруулж байж цацдаг журамтай. Гэхдээ энэ өдрийнх онцгой тохиолдол. Ийм мэдээ авсан ганц эх сурвалж маань тун найдвартай газар гэж үзсэн. Гэтэл намайг товчлуур дараад удаагүй байгал Пентагоноос утасдаж «Тэр буугаар буудсан гэсэн шинжилгээний эцсийн хариу гараагүй шүү дээ» гэж хэлдэг байгаа хэмээн ярив.

Энэ өдрүүдэд зөвхөн мэргэн бууч-алуурчны тухай сурвалжлага дээр AP-гийн 20 сурвалжлагч ажиллаж байлаа.

-Мохамедыг баривчилсан тухай мэдээг хэн нь эхэлж цацсан бэ? гэсэн асуултад AP-гийн **Барбара Кин Лорд**:

-Бид түрүүлсэн. Дараа нь NBS. Түүний хойно CNN «AP-гийн иш татсанаар...» гэж байгаад мэдээлэхэд нь таатай байсныг нуугаад яахав. Харин Мохамедын хуучин гэргийгээс «Сиэтл Таймс» түрүүлж ярилцлага авсан. Дараа нь Лари Кин тэр эмэгтэйтэй өчигдөр орой ярилцсан. Алабама мужийн нэг дэлгүүрт есдүгээр сард хоёр эмэгтэйг буудсан хэрэгт мөнөөх Мохамедыг бас сэжиглэж буйг та нар мэднэ. Шархадсан эмэгтэйгээс бид түрүүлж ярилцлага авч чадсан. Өнөөдрийн тухайд (аравдугаар сарын 25-ны) алуурчны төрсөн газар Ямайкагаас мэдээ хүлээж байна. Түүний аав хүүгээ телевизээр хараад ихэд цочирдсон гэнэ. Тэдний аав, ээж Ямайкагаас АНУ-д цагаачлах гээд чадаагүй юм билээ. Тэдэнд цагаачлах эрх яагаад өгөөгүйг манай сурвалжлагч одоо тодруулж байгаа.

Ийнхүү ярилцах зуур AP-гийн сурвалжлагчид өөр нэг халуун мэдээг яаралтай цуглуулж эхэллээ. Миннесота мужийн сенатч Веллстон гэргий, охин, гурван ажилтан, онгоцны багийнхны хамт осолджээ. Зөвхөн онгоцны осол дагнан сурвалжилдаг хэсэг AP-д бий. «Өмнө нь Мизури мужийн сенатч яг ийм ослоор амь үрэгдсэн. Холбож бичих өөр баримтуудаар материалаа баяжуулах хэрэгтэй» хэмээн редакторууд зааварчилгаа өгөх нь сонсогдов. AP агентлаг бүхий л осол, гамшигт үйл явдлыг даган сурвалжилдаг. Жишээ нь «Нью-Йорк Таймс» үйл явдал бүрийг дагаж, өөрсдөө бичихгүй байж мэднэ. «Нью-Йорк Таймс» AP-д чамгүй мөнгө төлж зарим чухал мэдээллийг худалдан авдаг. AP агентлагийн том том танхимууд саруулхан гэрэл гэгээтэй, тэнд хаа сайгүй жижиг телевизүүд өлгөсөн үзэгдэнэ. Сенатч Веллстоны тухай телевизээр тасралтгүй мэдээлж, онгоц унасан газрыг байн байн харуулж байлаа. Хэдхэн хоногийн өмнө миний дадлага хийгээд явж байсан Хойд Дакота муж Миннесотатай хил залгаа. Индиан бүсгүй Доррэн бид хоёрын давхиж өнгөрсөн эцэс төгсгөлгүй мэт урт зам байна шүү дээ. Тэр хавьд л онгоц осолдсон бололтой. Усны шувууд халуун дулаан орныг зорин буцдаг нүүдлийн зам яг энэ нутгаар дайрдаг гэсэн. Сүрэглэн нүүдэллэх шувууд хаа сайгүй зэл татуулан одож буйг хэдэнтээ харсан билээ.

**Индиан  
бүсгүй Доррэн  
бид хоёрын  
давхиж  
өнгөрсөн эцэс  
төгсгөлгүй мэт  
урт зам байна  
шүү дээ. Тэр  
хавьд л онгоц  
осолдсон  
бололтой.**

Нью-Йоркийн сүрлэг сайхан барилгуудын нэг болох Рокфеллерийн төвд байрладаг АР-гийн мэдээний машин дотор Монголын тухай үгс ч урсан ирсээр байна. Эдгээр мэдээллээс дэлхий дахин бидний талаар төсөөлөл авдаг. Газар нутгийн ойрыг сонгож уншигч үйл явдлыг сонирхох нь жам ёсны зүйл. Хагас өдрийн зөрүүтэй холын жижиг орон америкчуудын анхаарлыг бага татдаг нь гарцаагүй. Гэхдээ бөмбөрцгийн баруун хагаст бидний талаар огт юу ч мэддэггүй гэвэл худлаа. Мексикийн сэтгүүлч Норовбанзад гуайг дуурайн дуулж үзүүлснийг сонирхуулъя. **Луис Мигэл Гонзалес Мехикогийн өдөр тутмын «Publico Milenio» сонины эрхлэгч.**

**-Монголын тухай дуулж сонссон зүйлээсээ яриач?**

-Танай үндэсний дууг сонссон. Монголын алдартай дуучны бүтээл гэж надад хэлж өгсөн юм. Бас ноолууран хувцас их өмсдөг гэсэн. Монголчуудыг чамаар төсөөлж байна. Ноолууран эдлэл хэрэглэдэг хүмүүс дулаан зөөлөн зантай, эрхэмсэг болов уу. Байгаль нь сайхан гэж ойлгосон.

Дуу хураагчаа дараагийн сэтгүүлчид дөхүүлж тавив. **Доган Сатмис Туркийн хамгийн том сонин «Hurriyet Gazetesi»-ийн орлогч эрхлэгч.** Энэ сонин 500.000 хувиар хэвлэгддэг. Үүний нэлээд хэсгийг Европт амьдардаг турк иргэд уншдаг ажээ.

-Турк, Монгол хоёр түүхэн холбоотой, ах дүүс. Бидэнд ижил зүйл олон бий. Ойролцоо үг хэллэг, хөшөө дурсгал байна. Манай Ерөнхийлөгч танайд айлчилсан. Товчхондоо бол бид ахан дүүс гэв.

Дуу хураагчийн маань хальс дундаа ч ороогүй байна. Авч явсан хэдэн зураг, CD, эсгий шаахай, гэр, Чингистэй номууд харин дуусчээ. Шинэ цагийн монголчуудыг эртний түүхтэй нь хослуулан ойлгох гэсэн их хүслэн гадаадынхны нүдэнд илхэн харагдана.

**2002 он**

# КОФИ АННАН: Байгалийн бэрхшээлийн өмнө Монголын ард түмэн ганцаардах учиргүй

*Хэдхэн хоногийн өмнө дахин сонгогдсон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга «Өнөөдөр» сонины асуултад хариулж байна. НҮБ-ын гишүүн 189 орны олон нийтийн дэмжлэг Кофи Аннаныг энэхүү албанд улируулан үлдээсэн билээ.*

*Ноён Аннан, Нью-Йорк хотноо зохиогдсон Монголын соёлын өдрийн арга хэмжээнд амжилт хүссэн дотно үгтэй мэндчилгээг энэ оны тавдугаар сард илгээсэн төдийгүй манай улсад хүрэлцэн ирэх хүсэлтэйгээ илэрхийлсэн. «Өнөөдөр» сонинд өгсөн ярилцлагадаа тэрбээр Монголд гэргийн хамт ирнэ гэдгээ давхар нотоллоо. Манай улс НҮБ-д гишүүнээр элссэний 40 жилийн ойг тэмдэглэж буй өдрүүдэд Ерөнхий нарийн бичгийн дарга тус сониноор дамжуулан Монголын ард түмэнд сайн сайхныг хүсэв.*

-Америкийн нэг сэтгүүлийнхэн саяхан надаас дэлхийн ямар улсад очиж үзээгүй вэ, аль улсад очихыг онцгойлон хүсч байна вэ гэж асуусан. Би Монголд гэж хариулсан юм. Өвөг дээдэс нь хязгааргүй нутагт хэрэн нүүдэллэж явсан монголчуудын бахархам түүх миний сэтгэлийг хэдийнэ эзэмдсэн. Гэргий Нейн бид хоёр танай тал нутгийг нүдээр үзэж, зочломтгой түмэнтэй нүүр тулан уулзахыг ихэд хүсч байна.

**-НҮБ-ын үйл ажиллагаанд Монгол Улс шиг жижиг орнууд ямар дэмжлэг өгч чадах вэ? Ийм улсууд зөвхөн тусламж дэмжлэг хүссэн байдлаар НҮБ-ын үйл ажиллагаанд өнөөдөр оролцож байна гэж Та үздэг үү?**

-Хөгжиж буй улсууд Аюулгүйн зөвлөл, НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн хорооны үйл ажиллагаанаас эхлээд энхийг сахиулах хүчний ажиллагааг хүртэл бүхий л үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд энхийг сахиулах бие бүрэлдэхүүнд хөгжиж буй орны төлөөлөгчид хамтран ажиллалаа. Ерөнхий Ассамблей болон манай хороодын хуралдаанаар дамжуулан НҮБ-ын гишүүн нийт улс хэлэлцүүлэг, сонгууль зэрэг бүхий л үйл явцад оролцдог.

Монгол Улсын хувьд нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудал, зэвсэглэлд хяналт тавих, далайд гарцгүй орнуудын байдлыг өөрчлөх чиглэлээр ажилладаг. Түүнчлэн Монгол Улс хүний аюулгүй байдлын асуудлаар идэвхтэй ажил өрнүүлж байгаа. Нотолгоо нь өнгөрсөн жил танай нийслэлд зохион байгуулсан олон улсын хуралдаан юм. Хүн төвтэй хөгжлийн тухай концепц нь хүний эрх, сайн засаглал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх, эрүүл орчинд амьдрах тухай ойлголтуудын нэгдсэн илэрхийлэл билээ. Улаанбаатарт болсон энэхүү уулзалт бол НҮБ-ын гишүүн бүх улсын ашиг сонирхолд нийцсэн асуудлаар Монгол Улс идэвхтэй хамтран ажилладгийн нэг тод жишээ мөн.

**-НҮБ-д төлж буй гишүүн орнуудынх нь татварын ялгааны тухайд Та ямар бодолтой байдаг вэ? Монгол шиг орнуудын төлж буй татварын хувь хэмжээ чамлалттай санагддаг уу?**

-Гишүүн орнуудын санхүүгийн дэмжлэг өөрсдийнх нь боломж бололцоонд нийцсэн байх зарчмыг НҮБ ямагт удирдлага болгодог. Орон бүрийн эдийн засгийн байдалтай татварынх нь хэмжээг уялдуулах асуудлыг удаан хугацаанд ярилцсаны эцэст өнгөрсөн оны эцсээр зөвшилцсөн. НҮБ-ын гишүүн орнууд татвараа цаг хугацаанд нь бүрэн төлж байх нь чухал, хэмжээ оролцооны хувьд бол би энэ талын хамтын ажиллагааг чамладаггүй.

Энд онцлон тэмдэглэхэд, Монгол Улс энэ оны хоёрдугаар сард татвараа бүрэн төлж, НҮБ-ын гишүүн дийлэнх орныг тэргүүлсэн явдалд баяр хүргэе.

**-Глобалчлал нь буурай орнуудын, түүний дотор Ази дахь хөгжиж буй улсуудын амьдралыг хэрхэн өөрчилнө гэж Та үзэж байна вэ? Даяаршлаас зөвхөн**



**дэлхийн том компаниуд, хүчирхэг гүрнүүд ашиг хүртэх үү? Буурай улсуудад даяаршлаас тусах сөрөг үр дагаврыг багасгахын тулд НҮБ юу хийж чадах вэ?**

-Бид дэлхий дахинаа харилцаа, худалдаа, хөрөнгө оруулалт улам өргөжсөн цаг үед амьдарч байна. Эдгээр үйл явц нь эдийн засгийн өсөлтөд тусгалаа олсоор. Гэвч дэлхийн иргэдийн олонх нь нийт баялгаас хүртэлгүй хоцорч байгаа. Тиймээс бидний амьдарч буй цаг үеийн гол өөрчлөлт нь, глобальчлалын ашиг тус зөвхөн цөөнхөд бус, нийт хүмүүст хүрэх явдлыг хангахад оршино. Үүний тулд НҮБ төрөл бүрийн арга замыг эрэлхийлж буй бөгөөд хөдөлмөрийн стандарт, хүний эрхийн хэм хэмжээг баримтлах, хөгжлийг дэмжсэн аливаа үйл ажиллагааг илүү үр дүнтэй явуулах, технологийн өндөр болон буурай хөгжилтэй улсуудыг хооронд нь холбох зэрэг санаачлагыг бүрэн дэмжинэ.

**-Дэлхийн баялгаас нийт улс ижил тэгш хүртэх бололцоог НҮБ хамгаалж чадах уу? Далайд гарцгүй Монгол шиг улсууд далай тэнгисийн ашиг тусыг хэрхэн хүртэх вэ?**

-Байгаль орчин, ус далай, дэлхийн бусад нөөцийг хамтран ашиглах тухай гэрээ хэлэлцээрүүдийг мөрдөх үйл явцыг НҮБ нэгтгэдэг. Тэнгисийн тухай хууль зэрэг баримт бичиг нь далайн баялгийг бүх үндэстэн хамтран эзэмших боломжийг хангахад чиглэгдсэн юм. Түүнчлэн дэлхий дахины дулаарал мэт асуудлаар хамтран ажиллахад НҮБ дэмжлэг үзүүлж байна.

**-Ядуу буурай орнуудын өрийг хөнгөлөх талаар Та ямар байр суурьтай байна вэ?**

-Олон улс, ялангуяа нэн ядуу орнууд өрийн дарамт дор байгаа. Тэднийг хүнд ачаанаас нь салгах ёстой гэсэн ойлголт газар авсаар байна. Гэвч баян орнууд өрийг хүчингүй болгох хэмжээний хангалттай нөөц хараахан гаргаагүй. Дэлхийн банк, Олон улсын валютын сангаас гаргасан нэн их өртэй орнуудын жагсаалтад багтаад буй улсууд эрүүл мэндийн үйлчилгээнд зориулах хөрөнгөнөөсөө илүү их мөнгийг өр дарахад зарцуулсаар байгаа юм. Өрийн асуудлаар Брюссельд энэ оны эхээр болсон НҮБ-ын гуравдугаар хуралдаанд оролцогчдоо хандан өрийг богино хугацаанд, далайцтай шийдвэрлэхийг би дахин уриалсан. Тус хуралдааны үеэр донорууд нэн их өртэй улсуудад зориулж санхүүгийн нэмэлт эх үүсвэр гаргахаар болсон. Ийм нэмэлт эх үүсвэрт зориулж бодит хөрөнгө оруулах зайлшгүй хэрэгцээ бий.

**-Та Монголын ард түмэнд хандаж юу хэлэх вэ?**

-НҮБ-д элссэний 40 жилийн ой тохиож буйтай холбогдуулан энэ боломжийг ашиглан та бүхэнд баяр хүргэхийг хүсч байна. Байнгын төлөөлөгч Жаргалсайханы Энхсайханаар дамжуулан Монгол Улс НҮБ-д маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн монголчууд шаардлагатай үед НҮБ-ын дэмжлэгт найдаж болох юм. Ард иргэдийн амьдрал, мал аж ахуйд сүрхий нөлөөлсөн зудын бэрхшээлд танай улс жил дараалан өртжээ. Монголчууд байгалийн бэрхшээлийн өмнө ганцаараа биш гэдгээ мэдэж байгаасай хэмээн би хүсч байна. Өнгөрсөн нэгдүгээр сард НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах байгууллагын зүгээс гаргасан санаачлагыг дэмжин нэгдэхийг дэлхийн хамтын нийгэмлэгт миний бие уриалсан билээ. Өнгөрсөн жилээс НҮБ-ын эхлүүлсэн уг тусламжийн үйл ажиллагааны үеэр Увс аймагт онгоцны осол болж, есөн хүн харамсалтайгаар амь эндсэн. Энэ эмгэнэлт явлын үеэр амьд үлдсэн хүмүүст Монголын Засгийн газар цаг алдалгүй тусламж үзүүлж чадсан юм. Үрэгдсэн хүмүүсийн гэгээн нэрийн өмнөөс, түүнчлэн Монголын ард түмний өмнөөс дэлхийн хамтын нийгэмлэгт дахин хандахыг хүсч байна. Зудын үр дагаврыг гэтлэн давахад нь өгөөмөр гараа сунгахыг дэлхийн хамтын нийгэмлэгт би дахин уриалъя.

**-НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга зөвхөн халуун цэг, мөргөлдөөн болж буй бүс нутагт ажилладаг уу? Дэлхийн бусад хэсэгт, тухайлбал Төв Азид очих шаардлага Танд бий юу?**

-Мөргөлдөөн бүхий бүс нутагт явуулж буй бидний үйл ажиллагааны тухай

**Өнгөрсөн жилээс НҮБ-ын эхлүүлсэн уг тусламжийн үйл ажиллагааны үеэр Увс аймагт онгоцны осол болж, есөн хүн харамсалтайгаар амь эндсэн. Энэ эмгэнэлт явлын үеэр амьд үлдсэн хүмүүст Монголын Засгийн газар цаг алдалгүй тусламж үзүүлж чадсан юм. Үрэгдсэн хүмүүсийн гэгээн нэрийн өмнөөс, түүнчлэн Монголын ард түмний өмнөөс дэлхийн хамтын нийгэмлэгт дахин хандахыг хүсч байна. Зудын үр дагаврыг гэтлэн давахад нь өгөөмөр гараа сунгахыг дэлхийн хамтын нийгэмлэгт би дахин уриалъя.**

мэдээлэл түлхүү гардаг нь үнэн. Гэхдээ ийм ажиллагааныхаа зэргэцээ НҮБ нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн арга хэмжээндээ дийлэнх хөрөнгө хүч цагаа зарцуулдаг билээ. Харамсалтай нь иймэрхүү үйл хэрэг халуун үйл явдлын мэдээлэлд ордоггүй юм. Жишээ нь, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газар танай Засгийн газартай Монголын зүүн бүсийн тал нутгийн экологийн давтагдашгүй тогтолцоог хамгаалах талаар урт хугацааны хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа.

Уг бүс нь дэлхийд ховордсон, мөхлийн ирмэгт хүрсэн ан амьтдын үлдэж хоцорсон өлгий нутаг юм. Энэ утгаараа хөтөлбөрийн ач холбогдол орон нутгийн хүрээнээс хальж, дэлхийн чанартай болж байна. Энэ нь НҮБ-ын хэрэгжүүлдэг том, жижиг олон хөтөлбөр, төслийн нэг жишээ.

**-Та Төв Азийн бүс нугаар өмнө нь аялж байв уу? Монгол орон Таны анхаарлыг ямар талаараа татдаг вэ? Манай түүх, монголчуудын талаар Та юу мэдэх вэ?**

-Америкийн нэг сэтгүүлийнхэн саяхан надаас дэлхийн ямар улсад очиж үзээгүй вэ, аль улсад очихыг онцгойлон хүсч байна вэ гэж асуусан. Би Монголд гэж хариулсан юм. Өвөг дээдэс нь хязгааргүй нутагт хэрэн нүүдэллэж явсан монголчуудын бахархам түүх миний сэтгэлийг хэдийнэ эзэмдсэн. Миний гэргий Нейн бид хоёр танай уудам тал нутгийг нүдээр үзэж, зочломтгой түмэнтэй нүүр тулан уулзахыг ихэд хүсч байна.

**2001 он**

# Кофи Аннан өнөөдөр Монголд ирнэ



Фотог Б.Тощка

*Тэрбээр манай улсыг зорихынхоо өмнөхөн АНУ-д томилолтоор ажиллаж буй манай сонины орлогч эрхлэгч Л.Болормаад ярилцлага өглөө. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Монголын хэвлэлд өгч байгаа хоёр дахь ярилцлага энэ юм. Эдгээр ярилцлага зөвхөн «Өнөөдөр»-т хэвлэгдэж байна.*

*Монгол Улсын Засгийн газрын урилгаар манай оронд албан ёсны айлчлал хийхээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан гэргийн хамт өнөөдөр Улаанбаатар хотноо хүрэлцэн ирнэ.*

Тэрбээр бага үдийн алдад Буянт-Ухаад газардана. Дараа нь Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөөд Төрийн ордонд морилж, Ерөнхий сайд Н.Энхбаяртай хэлэлцээ хийх юм. Үүний дараа Н.Энхбаяр, Кофи Аннан нар Төрийн ордны хоёрдугаар давхарт сурвалжлагчдад товч мэдээлэл хийнэ.

УИХ-ын дэд дарга Ж.Бямбадоржтой цөөн хором танилцах уулзалт хийгээд «Даяаршлын эрин үе дэх жижиг улсууд» сэдвээр УИХ-д үг хэлнэ. Энэ өдөр УИХ нэгдсэн хуралдаангүй ч эрхэмсэг зочныхоо айлчлалд зориулж хүндэтгэлийн чуулган хийх юм.

Ноён Ерөнхий нарийн бичгийн дарга энэ өдөр Ерөнхийлөгч Н.Багабандид бараалхана. Орой нь Кофи, Нэйн Аннан нарт Ерөнхий сайд Н.Энхбаяр гэргийн хамт зоог барьснаар энэ өдрийн арга хэмжээ өндөрлөх аж. Маргааш нь Улаанбаатар дахь НҮБ-ын нэгдсэн байрны нээлтийн ёслолд оролцож, малчин айлд зочилно. Үд дундад хүндэт зочин Улаанбаатараас мордох агаад өмнөхөн нь Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун түүнтэй үдэлтийн уулзалт хийх юм.

**НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан Вашингтонд байгаа манай сурвалжлагч Л.Болормаагийн тавьсан асуулгад өгсөн хариултыг нийтэлж байна.**

## **БИД МОНГОЛД ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ТУСАЛСААР БАЙХ БОЛНО**

**-Ноён Ерөнхий нарийн бичгийн дарга аа, сүүлийн хагас зууны туршид энэ ертөнцийн хамгийн их дайн дажинтай бүс нутаг болоод байгаа Ойрхи Дорнодол энхтайван, тогтвортой байдлыг бий болгоход НҮБ-ын гүйцэтгэх үүргийн тухайд Та юу хэлэх вэ? Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд зөрчилдөгч талуудыг оролцуулахгүй байгаа юм шиг ойлголт байдаг. НҮБ-д итгэх итгэл дутмаг байна уу?**

-Ойрхи Дорнодол энх тайван бий болгох энэ асуудал өнө эртнээс НҮБ-ыг эзэмдэж ирсэн. Тэгээд ч улс төр, хүмүүнлэг, эдийн засгийн хийгээд бусад олон талт үйл ажиллагааг явуулсаар байна. Хэдийгээр тус бүс нутагт сүүлийн үед дайн дажин, хүчирхийллийн айдас, түгшүүртэй тойрог бий болсон ч улс төрийн тогтвортой байдлыг бий болгох явцад ахиц гарна гэдэгт би итгэсээр байна. Хамгийн сүүлд гэхэд Израиль, Палестины харилцан аюулгүй, хил залган



зэргэцэн орших бүс нутгийн төлөвийг Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор баталлаа. НҮБ нь АНУ, ОХУ, Европын холбоотой хамтран ойрын гурван жилийн дотор эцсийн тохиролцоонд хүрэхэд нөлөөлөхүйц гурван үе шаттай төлөвлөгөөг боловсруулах ажлаа үргэлжлүүлсээр байна.

**-Гишүүн орнууд өөрсдийнх нь эрх ашигт хамгийн сайн үйлчилж чадна хэмээн итгэсний үндсэн дээр НҮБ-ыг сонгож ханддаг уу, үгүй юү гэсэн асуулт байнга яригддаг. Тийм явдал үнэхээр байна уу?**

-Магадгүй энэ асуудал өөрсдийнх нь эрх ашигт үйлчилсэн тохиолдолд НҮБ-тай хамтран ажиллахыг сонирхдог зарим улстай холбоотой байх. Үүнд би гишүүн бүх орны тухай ярихгүй байна. Харин НҮБ-ын тухайд бол, олон талт арга замыг дагах, эс дагах нь зүгээр л нэг улс төрийн сонирхол агуулсан шалтгаан байх ёсгүй гэдэгт би тууштай итгэдэг.

Улс орнуудыг хөгжүүлэх, бие биеэ харилцан хүндэтгэх, шаардлагатай тохиолдолд олон улсын хууль дүрмийг дагаж мөрдүүлэх зэрэг олон талт ажиллагаанд хамтран зүтгэх явцдаа өөр хоорондоо итгэх итгэл, бусад асуудлаар илүү эрч хүчтэй, үр дүнд хүрэх хамтын ажиллагааг бий болгож байдаг юм. Аливаа улс орон хамтын үйл ажиллагаанд оролцоно гэдэг бусад нь түүнийг хүндэлж, түүнд итгэнэ гэсэн үг. Товчхондоо, НҮБ-тай хамтран ажиллана гэдэг аль нэг орон өөрийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлж байдаг үйл явц биш. Энэ бол



Фотог Б.Тошка

бүх улс орны хувьд хамтын ажиллагааны хамгийн шилдэг сургууль.

**-Хүний аюулгүй байдлыг хамгаалах үйлсэд тус нэмэр болох үүднээс НҮБ юу хийж байна вэ?**

-Энэ бол НҮБ-ын хийж буй бүх үйл ажиллагааны гол цөм нь. Дайн самуунтай газар оронд энх амгаланг бий болгох, халдварт өвчинтэй тэмцэх, байгалийн доройтлыг сааруулах гээд аль нь ч бай эцсийн дүндээ хүний төлөө, хүний амьдралын илүү аюулгүй тохь тухтай орчны төлөө зориулагдаж байгаа ариун үйлс юм.

Өөрийн эх оронд хүний аюулгүй байдлыг бий болгохын төлөө тодорхой хүчин чармайлт гаргаж буй Монголын Засгийн газар, Монголын ард түмэнд би талархал илэрхийлэхийг хүсч байна. Хүний аюулгүй байдал, сайн засаглал бол энэ талаар дэлхий дахинаа хамтран хийсэн, үндэсний хэмжээний анхны хүчин чармайлт юм. Шийдэх арга замыг улам боловсронгуй болгоход энэ нь хувь нэмэр оруулна гэдэгт ч би итгэдэг.

**-Монгол Улс 2003 оны зургадугаар сард НҮБ-ын дэмжлэгтэйгээр Ардчиллыг шинээр хөгжүүлж буй улс орнуудын олон улсын хурлыг эх орондоо зохион байгуулна. Дэлхий дээрх ардчиллын өөрчлөлт, шинэчлэлийг бэхжүүлэхэд энэ хурал ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ?**

-Ирэх жил Улаанбаатарт болох энэ хурлын гол сэдэв нь Мянганы тунхаглал хийгээд түүний зорилтод тусгасанчлан ардчилал, сайн засаглал, иргэний нийгмийн асуудлууд байх болно. Уг хурал зөвхөн ардчиллын үйл явц, түүний уриа дуудлагыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулаад зогсохгүй НҮБ, түүний түншүүдэд нь ардчилал зайлшгүй хэрэгтэй байгаа болон ардчиллыг хүсч мөрөөдөж буй улс орнуудыг дэмжих арга замыг улам боловсронгуй болгоход нь тусална. Нөгөөтэйгүүр, ардчиллын үйл явц, сайн засаглалын өсөлт хөгжилтөд НҮБ-ын үүргийг илүү өргөн болгох нэг замыг нээх болно.

**-Олон улсын эрүүгийн шүүх өнгөрсөн зун байгуулагдсан. Томоохон, нөлөө ихтэй гүрнүүдийн зарим нь тус байгууллагын гишүүн бус байгаа тохиолдолд энэ шүүх аль хэр үр дүнтэй ажиллаж чадах вэ?**

-Олон улсын эрүүгийн шүүх урьд өмнө төсөөлж байснаас ч илүү их тусламж дэмжлэг, амжилт олоод байна. Шүүхийг байгуулах тухай Ромын тогтоол өнгөрсөн долдугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. Одоогоор энэ тогтоолд 81 улс нэгдээд байгаа. Эдгээр улс дээрх тогтоолд зүгээр л нэг гарын үсэг зурах гэж бус өөрсдийн эрхийн төлөө нэгдсэн гэдэгт би итгэлтэй байна. Түүнчлэн уг шүүхийг хүчирхэг, үр дүнтэй болгоход нөлөөлөх маш өргөн хүрээтэй тусламж дэмжлэг, ард түмнүүд, Засгийн газрууд энэ дэлхийн хаа сайгүй бий гэдэгт эргэлзэхгүй байна. Нөгөө талаар, шүүхийг хэрхэн шударга, үр дүнтэй ажиллаж байгааг хараад өөр олон улс орон түүнд нэгдэж, өөрсдийн тусламжийг үзүүлэх болно гэдэгт ч итгэж байна.

**-НҮБ болон Монгол Улсын харилцааны талаар Та юу хэлэх вэ?**

-НҮБ, Монгол Улсын харилцаа 40 илүү жилийн түүхтэй. Энэ харилцаа улам бүр хүчирхэг болж байгаа. Ардчилал, зах зээлийн эдийн засгийг бий болгохын төлөө сэтгэл хөдлөм тууштай замнаж байгаа Монгол орон НҮБ-ын өнөр бүлд багтдагт би бахархаж явдаг.

Засгийн газар болоод иргэний нийгэмтэй үнэнчээр хамтран ажиллах явцдаа бид засаглал, хүйсийн тэнцвэртэй харьцаа, ДОХ, байгаль орчин гээд маш олон чухал асуудлаар хамтран ажиллаж байна. Цаашдаа ч зорьж буй бүхэндээ амжилт олохыг тэмүүлсэн хүнд бэрх замд нь бид Монгол Улсад үргэлжлүүлэн тусалсаар байх болно.

Арвин баялаг түүх уламжлалтай ч зүрх сэтгэлээрээ залуу Монгол орон НҮБ-ын замналд хамтдаа байна гэдэгт би итгэдэг. Танай сонины нийт уншигчдад аз жаргал, сайн, сайхан, хөгжил цэцэглэлтийг хүсч байгааг минь дамжуулаарай.

**Арвин баялаг  
түүх  
уламжлалтай ч  
зүрх сэтгэлээрээ  
залуу Монгол  
орон НҮБ-ын  
замналд хамтдаа  
байна гэдэгт би  
итгэдэг. Танай  
сонины нийт  
уншигчдад аз  
жаргал, сайн,  
сайхан, хөгжил  
цэцэглэлтийг  
хүсч байгааг  
минь  
дамжуулаарай.**





-----  
Doc: 00060683 DB: research\_d\_2002\_4 Date: Wed Oct 16 06:07:59 2002  
Alert Categories: def  
Profiler Categories: Defense

\*\*\* Version history. (\* = this story, F = final, S = semifinal) \*\*\*

ED7MMJKVOO 10-16-2002 06:07:59\*F BC-UN-Mongolia:Annan, in Mongolia,  
calls f

Copyright 2002 By The Associated Press. All Rights Reserved.

-----  
EEE9825#-----

r ibx

87 233 intjw mos uni bej

^BC-UN-Mongolia<

^Annan, in Mongolia, calls for help so small countries can reap globalization's  
benefits<

^By CHRISTOPHER BODEEN=

^Associated Press Writer=

%meta(ap\_topic:Politics;ap\_topic:General;%)

Q BEIJING (AP) \_ U.N. Secretary-General Kofi Annan, making his first  
visit to **Mongolia** on Wednesday, praised the role of small countries in the  
United Nations system, saying larger nations should recognize their  
contributions and ensure they share in the benefits of globalization.

Q Annan flew to **Mongolia**, one of the world's most thinly populated  
countries, after a two-day visit to China, the most populous. In China, Annan  
met with top leaders and highlighted the country's looming AIDS epidemic,  
urging more efforts to educate the public on prevention.

Q In remarks prepared for presentation at the *Great Hural*, **Mongolia's**  
parliament, Annan said the contributions of small nations to international  
cooperation were "crucially important."

Q "What we need more than ever today is a fundamental compact between

**АССОШЕЙТЭД  
ПРЕСС  
МЭДЭЭЛЖ  
БАЙНА**



# Сурвалжлан бичихийн гайхамшиг

Бүтэн нүүр дүүрэн ярилцлагыг зөвхөн монгол уншигч амтархан таашаадаг. Бичлэгийн сэтгэл татсан энэ төрөл зүйл гагцхүү манай сонин хэвлэлийн хуудаснаа хамгийн эрэлттэй байх аж. Монгол уншигчийн өвөрмөц сонголт ийм.

Харин дэлхийн хэвлэлүүдийн хуудаснаас тэрхүү нулимс дуслуулсан гайхамшигт ярилцлагыг олж үзэхгүй дээ. Ярилцлага гэдэг телевизийн сэтгүүл зүйн үндсэн талх хэмээн мэргэжил нэгт нөхдүүд маань ч, үзэгч, уншигчид нь ч нийтээрээ хүлээн зөвшөөрсөн байх юм. Туульс хайлан уярч, тойрч суугаад үлгэр сонеч, хоршин дуулж, хос чавхдаст хуурын эгшиг дор өсч өндийдөг монголчуудын сэтгэлийн утас гэдэг магадгүй хамгийн өвөрмөц, онож хөндөхөд амаргүй эд байх.

Сайхан ярилцлага, аян замын тэмдэглэл, сэтгэл хөглөсөн шад шүлэг гээд аажуу тайвуу хэмнэлт бичлэгийн төрөл зүйл сонины хувьд өдгөө ч эрэлт ихтэй хэвээр байна. Монгол хүний эл менталитетийг сөрөн, орчин цагийн амьдралын хурд хэмнэл эрээгүй довтлох аж. «Бага бич. Материалаа жижиглэ» хэмээн Балдорж эрхлэгч ямагт шахна. Шинэ цагийн салхи «Өнөөдөр» сонинд түрүүлэн хүрдгийн учир энэ шахалт, ирээдүйг тоссон мэдрэмжтэй шууд холбоотой. Монголын онцлогийг дэлхийн стандарттай холбож хослуулах бас нэгэн ажил гараад ирснийг анзаарав уу.

Бидний ажлын хурд бага багаар нэмэгдсээр байна. Аажуу тайвуу монгол занд



ажил хэрэгч чанар давхар шингэж эхэлжээ. Яг үүний илрэл нь сэтгүүл зүйн хувьд сурвалжлага хэмээх халуухан төрөл зүйл. Хачин гоё төрөл зүйл гээд тодотгочих уу. Газар дээр нь очиж, гар хурч, нүдээр харан, үйл явдлын агаараар амьсгалан, үймээн шуугианы дунд алхсан сурвалжлагчаа эрхлэгч нар илүүтэй хүндэлдэг биз ээ. Магадгүй яг өнөөхөндөө сурвалжлагын төрөл зүйл Монголын сонин, сэтгүүлийн талбай дээр харьцангуй цөөн үзэгдэж, үнэлгээ ханш өндөргүй байж мэднэ. Яваандаа дэлгэрэнгүй мэдээлэл болоод сурвалжлага өдөр тутмын хэвлэлд зонхилох эрин цаг ирэх биз.

Яагаад сурвалжлагыг онцолж буйгаа төвөггүй тайлбарлая. Дүрслэл, бүр шүлэглэл, хальж «хадуурах» бүх боломж ганц энэ төрөл

зүйлд цогцоороо бий. Хажуугаар нь болсон үйл явдлын талаарх тоо баримт, ишлэл яриа бүгдийг шигтгэх хязгааргүй орон зайг сурвалжлага нээж өгдөг. Харин сонин хуудаснаа нийтлэгдсэн сурвалжлага телевизийн дүрстэй мэдээллээс өөр байх учиртай. Хүссэн хүсээгүй бид цэнхэр дэлгэцийн мэдээллийн хурд болоод дүрсээр бүгдийг нэвт шувт харуулах хүчирхэг давуу талд ялагдаж явдаг. Гэхдээ...

Гэхдээ ялах боломж байдгийг анд минь чи ямагт санаж яваарай. Өмнөх үдэш нь дуу, дүрстэйгээр үзэгч хүлээн авчихсан тэр үйл явдлын тухай маргааш өглөөний сонинд шал өөрөөр мэдээлэх үүрэг, дарамт тогтмол хэвлэлийн сурвалжлагчид оногддог.

Чихэнд чинь шивнэе. «Телевизийнхэн өнгөцхөн мэдээлдэг юм. Тэр ганган амьтад микрофоноо барьчихаад баахан ярьж байгаад одохдоо ардаа баахан үйл явдал, баримт, шигтгээ гээчихдэг юм... Харин тэдний тоож хараагүй, ултай сонирхоогүй, бусад статистиктай

харьцуулахаасаа залхуурсан «үлдэгдэл» дундаас л бичлэгийн жинхэнэ сэдэв босдог билээ. Сонин сэтгүүлчид камер байх биш. Тэр тусмаа сайн. Бичлэг мичлэг хийж сүржигнэлгүй чи зүгээр л үйл явдлын эргэн тойронд байсан хүмүүс дээр яваад оч. Телевизийнхэн бол гол баатраас л хоёр гурван зүйл асуучихаад арилаад өгсөн байж таарна. Эгэл хүмүүсийн үг үнэнтэй. Сэтгэгдэл хуучраагүй байгаа дээр нь, урд хойноо орсон уймраа сандруу, уурлаж бачимдсан, халагласан эсвэл хөөрч онгирсон бүх сэтгэлийн хөдөлгөөнүүдийг хав халуунаараа байгаа дээр нь цуглуулаад авбал сайн сан. Сурвалжлагын амт шимт чухам тухайн цаг үеийн уур амьсгал гэгчид бий. Камер байхгүй, чи зөвхөн үзэг, дэвтэртэй. Тиймээс залуу минь чи баяр, нулимс үнэртэл дүрслээрэй. Телевизийн камер тороогүй өнгөрсөн тэр сайртай гар, чичигнэсэн уруул, толботой дээл ер нь юу л байна вэ үйл явдлыг тодотгож, хүч нэмэж чадах деталиудыг ашиглаарай.

Монгол уншигчийн сонирхлыг мартаагүй биз дээ. Дээр дээрээс нь давхцуулсан баахан тоо, баримт бичээд эхэлбэл нөгөөдүүл чинь дуустал нь уншихгүй. Өнгөтөөр дүрсэл. Нулимс гүйлгэнэтэл нь уяраа. Хэрэгтэй бол шад шүлэг шигтгэгч. Ингэлээ гээд би л лав сурвалжлагчаа зэмлэхгүй. Хамгийн гол нь тэр тэвчээргүй этгээдийн анхаарлыг бүү алдаарай. Хуурай үгэнд монгол уншигч тун дургүй. Барууны сэтгүүл зүйн шилдэг туршлага Монголд нэг л сайн идээшиж өгдөггүйн зовлон энэ. Материал томроод сунаад эхэлдгийн гол учир шалтгаан энэ дээ. Галт тэрэг мөргөлдөж хүний амь эндсэн халуун сурвалжлага тэмдэглэж явлаа ч хажуугаар нь хурц дүрслэл нэмж, үйл явдлыг илүү тодотгож өгөхийг уншигч хүлээж суудаг.

Товчхондоо бол бид маш их сэтгэлийн хөдөлгөөнтэй, торгон мэдрэмжтэй уншигчид зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тэдэнд тоогдох материал нийлүүлэхийн тулд халуун үйл явдал руу ханцуй шамлан хүрэх зоригтой, зүрх сэтгэлийн утсыг хөндөн бичих ур дүйтэй, хажууханд харагдах нулимстай нүднээс баяр гунигийг нь тайлж унших мэдрэмжтэй яваарай.



# ЧИМЭЭГҮЙ АЮУЛ

**That's why?** Тод хар үсгээр тэмдэглэсэн ийм асуулт өмнө харагдана. Америк цэргүүд хоолонд орох бүрдээ мөнөөх асуулттай тулгардаг. Дэлхийн худалдааны төвийн ихэр цамхаг үгүй болсноос хойш бараг гурван жил болох нь. Гэвч эх нутгаасаа хэтэрхий алсад үдийн хоолоо идэхээр хөнгөхөн цаасан тавиур бариад дугаарлаж зогссон америк цэрэгт ихэр цамхгийн сүйрлийг дахин дахин сануулсаар байна. Хаа холын Афганистаны томилолт өвөрлөсний чинь утга учир энэ шүү. Америкт халдсан террористуудын үүрэнд чи цэг тавихаар ирсэн... гэх шиг. «Феникс» баазын хаа нэгтээ нөгөө л асуулт, дүрслэлтэй заавал дайралдана. Тэгвэл монгол залууст «That's why?» хамаатай юу? Тэд төв Азийн өндөрлөгт, харь шашин, заншлын дунд ямар зорилго тээж ирсэн юм бол?

Кабулын төвөөс арав гаруй километр зайтай байрлах Camp Phoenix буюу олон улсын цэргийн сургалтын «Феникс» төвд үдэш бүр элгэн нутгийн төрөлх аялгуу сонсогдож, тэд арван гурвуулаа эгнэн жагсаад дуулах аж. Монголын хэвлэлүүдэд Афганы анхны арван гурвын тухай товчхон мэдээлэл цухалзаад өнгөрсөн санагдана. Иракийн тэмдэглэл, Иракийн монголчууд гэх холбоо үгсийн сүүдэр дор мартагдсан Афган гэдэг арай «диваажин» юм биш байгаа?

## ЭЛСЭН ЭНГЭСЭГ

Тэнгэр бүүдийж сааралтаад, бороо орохын даваан дээр Кабулд газардлаа даа гэж бодсон юм. Тэгвэл тэр бараан хөшиг хур борооных биш зүгээр л тоосонцор гэнэ. Нунтаг цагаан элс энгэсэгний эхний давхарга тавьж орхилоо. Америкийн цэргийн СА-30 хэмээх аварга хөлгийн хөдөлгүүр хүнгэнэнэ. Таван цагийн турш цэргийн онгоцонд сэгсчүүлж явах нь аятайхан аялал ч биш л дээ. «Боевик» киноноос л ийм онгоцонд десантынхан суухыг өмнө нь харсан билээ. Чихэнд хийсэн хөөсөнцөр төвөг удаж аваад шидчихмээр санагдавч хэсэг азнахаас аргагүй. «Баграм» нэртэй энэ буудал олон жилийн тэртээ оросуудын мэдэлд байв. Өнөө Америкаар толгойлуулсан олон үндэстний цэргийнхэн бууж суудаг гол түшиц болжээ.

СА-30-ын «ходоодноос» мултраад удаагүй байтал дараагийн хөсөг хүрээд иржээ. Цагаан өнгийн Ford Renger ирийтэл эгнэчихэж. Хожим «Феникс»-ийн хашаан дотор энд тэндээ бишгүй хонхойсон Ford олныг үзсэн билээ. Суманд сийчүүлж, шил нь хага үсэрчихээгүй, харин автын осолд олноороо нэрвэгдсэнийг хараад гайхшрав. Нэг бүр нь 11.000 ам.долларын үнэтэй ийм унааг Тайландаас нийлүүлж байна. Аюулгүй байдлын улмаас асар хурдтай давхих цэргийн цувааныхан автын осолд өртөх нь их гэнэ.

Сум үл нэвтрэх хантааз 11 кг жинтэй. Монгол офицеруудыг Афганистанд газардсан эхний мөчид л Америкийн тал ийм хамгаалах хэрэгсэл өгчээ. Мөнөөх хуяг дуулганаас хамгийн бага хэмжээтэй нь надад оногдсон болов уу гэж найдахаас. Улаанбаатараас ирсэн найман хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдөд хантааз сэлт өмсгөж орхиод Америкийн цэргийн хамгаалалтын цуваа тоос татуулан авч одлоо.

## ДАРГА РУУ БУУ ШАГАЙГААД МУУХАЙ ХАШГИРАХАД НЬ ХҮЙТ ДААСАН

Цэргийн цуваа даган тэнхээ мэдэн гүйлдэх жаалууд эхний танил маань. Сэргэлэн хар нүд гялсхийн, бяцхан эрхийгээ гозойлгоод чадал шавхан хэсэг

гүйсэн боловч тэртээд торойн үлдчихэв. Замын хоёр талаар наймаачдын элдэв өнгийн лангуу жирэлзэн урсаад амьдрал ер амгалан тайван ч юм шиг. 28 сая хүн амтай гэж дэд хурандаа К.Кози тайлбарлаж байна. Гэвч Афганистанд хүн амын тооллого явагдалгүй олон жил өнгөрсөн, хэдүүлээ болохыг нь хэн ч яг таг хэлж чадахгүй хэмээн НҮБ-ын ажилтан ярьсан санагдана. Цөөхөн миль туулах зуур эхний танк нүдэнд туслаа. Ялимгүй цаашлахад хоёр дахь нь. Явсаар энэ дүр зураг ердийн зүйлс болов. Оросуудын орхиод явсан уул овоо шиг их зэр зэвсгийн зарим нь хаягдсан газартаа олон жилийн турш хөшөө чулуу адил дүнсийн хоцорчээ. Энэ зам ч бас оросуудын бэлэг. Өдгөө энхэл донхол ихтэй болж, суудлын даруулгаа хийгээгүйсэн бол булдруу цуглуулж мэдэхээр юм. Цэргийн цуваа руу халдах магадлал их. Тиймээс цагт 80-100 км-ын хурдтай галзуу юм шиг давхина. Ийм тийм явдал тохиолдлоо гэхэд хохирол бага байлгах гэж нэг машинд жолоочоос гадна дээд тал нь гурван хүн тээнэ. Гэхдээ энд аюул үнэхээр бий гэж үү?

## ҮХЛИЙН ТОЙРОГ

Цав цагаан булцгар чулуугаар гэр барьж тоглосон юм болов уу хэмээн эндүүрэв. Мина бүхий газруудыг тод өнгийн чулуугаар ингэж тэмдэглэжээ. Хаашаа л харна мөөгөн хүрээ шиг үхлийн тойрог үзэгдэх юм. Тус улсын нутаг дэвсгэр дээр хэдэн мина, хэрхэн булж орхисныг хэн ч яг таг мэдэхгүй. Үхлийн дарь нуучихаад газрын зурагт түүнээ ядаад тэмдэглэж үлдээсэнгүй. Талибуудын үед ч, түүнээс өмнө, хойно ч дайснаа чадах гэж тойруулаад булаад л байсан гэдэг. Бүх минийг аюулгүй болгоход хагас зуун жил шаардагдана гэсэн урьдчилсан тооцоог НҮБ-ын мэргэжилтнүүд хийгээд байна. Цэргийн болоод энгийн иргэд өдөр бүр минад өртдөг гэсэн мэдээлэл биднийг угтсан юм.

Үе үе тохиолдох харуулын пост орчимд хоёр гурван афган цэрэг уйдсан янзтай зогсч байна. Автомат, аягатай цай хоёроо хажуудаа тавьчихжээ. «Дайн байлдаан тэдний хувьд зүгээр л ердийн зугаа. Аж ахуйн жирийн ажилтай нь ижил» гэсэн ишлэл санаанд буув. Хачин юм, энэ ишлэл Ф.Энгельсийнх. Дайны хөлд гучаад жил нэрвэгдсэн хүмүүс үл итгэсэн, өнгө жавхаагүй харцаар биднийг тоомжиргүй үднэ. 1979 оны арванхоёрдугаар сарын 25-ны өдөр Москвагийн цагаар 15.00 цагт Зөвлөлтийн танк тусгаар улсын хилийг анх нэвтэрчээ. Бүтэн хоёр өдөр Афганы тэнгэрт цэргийн онгоцууд дүнгэнэсэн гэдэг. Тэгвэл 22 жилийн дараа буюу 2001 оны аравдугаар сарын 7-ны өдөр Гринвичийн цагаар 16.25 цагт Жорж Буш «Цаг боллоо» гэж мэдэгдсэн юм. Энэ удаа Америкийн бөмбөгдөгч онгоцууд Кабулын тэнгэрт хүнгэнэж байлаа. Орос, америкуудын завсар талибууд дураар дургижээ. Одоо туйлдаж, дөжирсөн ард түмэн энэ замаар сүнгэнэн өнгөрөх гадаадынхныг тоохгүй. Эх орондоо жинхэнэ эзэн суусан өдрүүд түүхийн хуудсанд нь ховор үзэгдэнэ. Монгол, болгар, румын, япон, франц... зүсэн зүйлийн хэл яриа өндөр уулсын дунд сонсогдоно.

Кандагар хүрдэг энэхэн замд халдлага гарах нь цөөнгүй. Цуваа руу нэгдүгээр сард амиа золиослогч халдаж, Канадын цэргийн хоёр алба хаагч амь үрэгдэн, олон хүн шархадсан аж. Мөн Английн цэргийн машиныг тэсрэх бөмбөг бүхий такси мөргөснөөс нэг хүн амь алдсан тухай мэдээ бий. «Феникс» баазад хүрэх үест хаанаас ч юм буун дуу тасхийв. Нэг нь буу алдаж орхисон юм байж.

## БҮСГҮЙГ НЬ БҮҮ ШИРТЭЭРЭЙ

Наранд гандаж борлосон манай офицерууд Улаанбаатараас ирсэн дарга нараа жагсч угтлаа. Хошууч генерал М.Борбаатар, хурандаа Л.Төмөрбат, Ц.Цогтжаргал, Р.Канад нар офицеруудтайгаа цэргийн ёсоор мэндлэв. Арай

**Хүн бүр  
жижүүртэй байнга  
холбоотой байх.  
Хувийн зэвсэг,  
хуягт хангааз авч  
хоргодох байранд  
ороход бэлэн  
байх»** гэсэн  
сэрэмжлүүлэг  
манай штабын  
байранд харагдав.  
Дээр нь  
хурандаагийн  
сануулж хэлсэн  
зааварчилгыг  
нэмье. «**Нуггийн  
эмэгтэйтэй  
ярихыг оролдох,  
удаан харж  
ширтэхгүй байх.**  
Тэсэлгүй  
жуумалзаж  
орхисон ч энэ  
улсын зан  
заншил дэндүү  
төвөгтэй  
болохыг  
төдөлгүй  
мэдэрсэн юм.

ойр дотно уулзаж болмоор доо гэж бодогдсон шүү. Иракт хагас жил болсон дайчидтайгаа Зэвсэгт хүчний ерөнхий командлагч уулзан мэндчилэх мөчид мөн л ийм бодол төрж билээ.

Афганистаны үндэсний армийг төвхнүүлэхээр олон үндэстний цэргийнхэн АНУ-ын Төв командлалын удирдлага дор ажиллаж байна. 715 ам бүлтэй «Феникс»-т 12 улсын төлөөлөл бий. Бусдаасаа ялимгүй бараан өнгийн хувцастай, биеэр харьцангуй жижиг залуус бол монголчууд. Ази царайгаараа энд төвөггүй танигдана. Харин тэд маань «US Army» гэсэн тодхон бичиг бүхий бэлтгэлийн хувцас өмсөөд, мөн л америк цэргүүдийн ижил зөөлөн бор өнгийн богино цамцтай, бас шар илгэн гутлыг нь өмсчихсөн харагдвал Монголын армийн албан хаагч гэж ялгахад хэцүү. Харуулын байранд дайралдсан вьетнам гаралтай америк байлдагчаас ялгарахгүй л гэсэн үг. Орон орны цэргийнхэн ижилхэн, биед эвтэйхэн хувцас хэрэгслээрээ танигддаг бол манайханд дүрэмт хувцаснаас өөр илүү гарах элдэв хэрэглэл үгүй юм. Зөөлөн, биед амрыг бодоод цэргийн дэлгүүрээс америк албан хаагчдын богино цамц худалдаж авсан хүн манайхан дотор олон бий. Нэг иймэрхүү зовлон нүдэнд ил харагддаг.

Харин сахилга, зохион байгуулалт, мэргэжлийн чадвараараа олон үндэстний цэргийнхнээс монголчууд тодхон торойж явна. Тус баазад очсон эхний өдөр л ийм үнэлгээг цөөнгүй хүнээс сонссон юм. «Феникс»-ийн командлагч, бригадын генерал Мансино Монголын төлөөлөгчдөд мөн оройдоо мэдээлэл хийлээ. Афганы эхний ээлжийг ахалж яваа (Албаны үгээр бол Сургалтын хөдөлгөөнт бүлэг гэж томъёолдог аж) хурандаа Ж.Ванчинсүрэн дараа нь дэлгэрэнгүй тайлангаа тавилаа.

19.00 цаг өнгөрөв үү, үгүй юу харанхуй нөмөрч, элс шороогоор тургиад байх нь ч аядав. Хээрийн баазад оройн хоолны цаг эхэлжээ. М 16 маркийн автомат мөрөвчилсэн америкауд зөрж өнгөрөх бүрийдээ заавал мэндэлнэ. Олон орны цэргийнхэн ч ялгаагүй найрсгаар толгой дохино. Ахлах дэслэгч Т.Батбор «Энэ миний сайн найз, тэр хуурай ах шиг» гээд баруун солгойгүй мэнд мэдэн, бүгдийг танимхайрахыг ажвал найзархуу эр боллолтой. Хээрийн бааз гэлтгүй энд наад захын хэрэгцээт бүх зүйлийг америк стандартаар сайхан бэлтгэжээ. Чанартай хоол унд, ариун цэврийн өрөөнүүд, чийрэгжүүлэх танхим, юм юмтай дэлгүүр бий. «Internet down» гэсэн «гашуудлын» бичиг харагдахгүй л бол интернэт өрөө нь дажгүй. Үе үе холболт тасардаг болохоор ар гэр, хайртай хүмүүсээсээ сураг чимээ хүлээсэн цэргүүд байж ядна.

-Ийм том газар шөнөдөө ганц гэрэл асааж болдоггүй юм болов уу гэж Батбороос асуулаа. Миний мэддэггүй зүйлсийн нэг энэ ажээ. Цэргийн баазад шөнө гэрэл гаргахыг хориглодог. Цэнхэр, ногоон өнгийн бүдэгхэн тусгал бүхий гар чийдэнг өөрсдөө авч явна. Өмнөх замаа дажгүй гэрэлтүүлчих юм аа.

Нээрээ энд аюул байгаа гэж үү? Нөгөө л асуулт толгойд эргэлдээд салдаггүй. Мөн үдэш хурандаа Ж.Ванчинсүрэн аюулгүй байдлын сэрэмжлүүлэг-зааварчилгаа өгөх үед орчин тойрныхоо амьдралд арай ойртсон юм.

«Тагнуулын мэдээгээр ойрын өдрүүдэд «Феникс»-т пуужингийн цохилт өгч болзошгүй. Амиа золиослогчид цэргийн цуваа руу явганаар, дугуй болон тээврийн хэрэгсэл ашиглан дайралт хийж болзошгүй. Эвслийн цэргийн цуваа, байрлал руу тэсрэх бодис бүхий тээврийн хэрэгсэл ашиглан дайралт хийж болзошгүй байна. Тэсрэх бодис бүхий машинуудын дугаар: хар өнгийн Corolla, 075194 дугаартай... Хүн бүр жижүүртэй байнга холбоотой байх. Хувийн зэвсэг, хуягт хантааз авч хоргодох байранд ороход бэлэн байх» гэсэн сэрэмжлүүлэг манай штабын байранд харагдав. Дээр нь хурандаагийн сануулж хэлсэн зааварчилгыг нэмье. «Нутгийн эмэгтэйтэй ярихыг оролдох, удаан харж ширтэхгүй байх». Тэсэлгүй жумалзаж орхисон ч энэ улсын зан заншил дэндүү төвөгтэй болохыг төдөлгүй мэдэрсэн юм.

**-Ийм том газар шөнөдөө ганц гэрэл асааж болдоггүй юм болов уу гэж Батбороос асуулаа. Миний мэддэггүй зүйлсийн нэг энэ ажээ. Цэргийн баазад шөнө гэрэл гаргахыг хориглодог. Цэнхэр, ногоон өнгийн бүдэгхэн тусгал бүхий гар чийдэнг өөрсдөө авч явна. Өмнөх замаа дажгүй гэрэлтүүлчих юм аа.**



## ОРГОДЛУУД

Афганы үндэсний армийн (АҮА) Төв корпусыг сургаж бэлтгэх ажил өндөрлөх шатандаа явна. Энэ оны зургадугаар сар буюу сонгуулийн өмнө армийн эхний ээлжийг «цэгцлэх» гэж яарч байгаа бололтой. Товчхондоо, Афганистан улсын арми нийт 70.000 хүнтэй, таван хэсгээс бүрдэх учиртай. Монголчууд Төв корпусын артиллерчдийг бэлтгэж дадлагажуулах амаргүй ажилд гар бие оролцож явна. Өөрөөр хэлбэл, өндөр уулсын ард түмэн дахиад л армитай болж байна. Талибаны цэргүүд бус, Орост бэлтгэгдсэн офицеруудаас ч бүрдэхгүй, шив шинээр зохион байгуулах гэнэ. Бригадын генерал Мансино энэ тухай дэлгэрэнгүй танилцуулав. «Тусгаар улсын армийг шив шинээр бий болгосон туршлага Америкт бий юу?» гэсэн «Өнөөдөр» сонины асуултад генерал,

-Нэгийг оргүй устгаад, өөрийг зохион байгуулах тухай яриа биш юм. Афганистаны армийг шинэчлэн бэхжүүлэх хүнд төвөгтэй ажил өнөөдөр ид өрнөж байгаа гэж тайлбарлалаа. Ярвигтай гэдгийг ойлгоход ядах юмгүй. Төсөөлөөрэй. Оросуудын үлдээсэн «хогон» овоолго дундаас монголчууд их буу босгож байна. Түүгээрээ афган цэргүүдэд яаж буудахыг зааж өгдөг. Дари хэлний орчуулагч нь 1980-аад онд Одесс хотын Цэргийн их сургууль төгссөн хурандаа. Аль засгийн үед хэн хаана, юу хийж явсан, одоо хэрхэн амьдрал залгуулж байгаа, хэний гар дамжиж ирсэн зэвсэг техник вэ гээд бүгдийг ухаж эргэцүүлбэл учир замбарааг нь ойлгоход амаргүй. Нөгөө их буунуудын сумыг хаанаас авах юм? Оросуудаас уу? «Ах нар»-ын үлдээсэн зэвсэглэлээр Афганы армийг хангана гэвэл сумаа нээрээ яах билээ? Энэ бүх төмрийг нулимж орхиод, америк зэвсгээр шинэчлэн хангая гэх байр суурь ч сонсогдож байна. Тэгвэл тэр их мөнгө хөрөнгийг хаанаас гаргах вэ?

Юутай ч, монголчууд арван их буу засварлан ажиллагаанд оруулж, хичээл сургалтаа мэргэжлийн түвшинд явуулж байгаад бригадын генерал Мансино төдийгүй АҮА-ийн Төв корпусын командлагч, хошууч генерал Моен талархал илэрхийлсэн юм. Кабулд ажилласан хоёр дахь өдрийн өглөө нар ээж, нөгөө шороо тоос ч сураггүй. Хошууч генерал Моений албан тасалгаанд Монголын төлөөлөгчид эртлэн ирсэн байлаа. АҮА-ийг зохион байгуулах ажил тун удаашралтай байгаа, америкауд мөнгөөр их гачигдаж эхэлсэн, афган цэргүүд оргосоор байна гэсэн мэдээллийг Ройтерс мөн өглөө цацсан юм.

**-Генерал Моен, Төв корпусын байлдагчдаас хэдэн цэрэг оргосон бэ? Ер нь үндэсний арми бүрдүүлэх ажил ихээхэн бэрхшээлтэй байгаа гэдэг үнэн үү?** гэсэн асуултыг «Өнөөдөр» сонин түүнд тавив.

-Сайн асуулт байна. Гэхдээ АҮА-ийг үүсгэн байгуулах ажил тийм удаашралтай байгаа биш шүү. Яагаад гэвэл энэ үйлсэд тун олон орны цэргийн туршлагатай төлөөлөгчид хүчин зүтгэдэг. Армиас тодорхой тооны албан хаагч оргосон. Гэхдээ чөлөө зөвшөөрөлгүй явсан 430 хүн эргэж ирсэн. Оргох явдлыг таслан зогсоох бүхий л арга хэмжээг авч байгаа гэж тэрбээр хариуллаа. Түүний мэдлийн Төв корпусын 10.000 орчим цэргээс 3000 нь оргосон тухай генерал тодорхой яриагүй юм. Ер нь оргодлуудын статистикийг хаана ч очсон дарж хэлэх зуршилтайг анзаарав.

Дараа нь манай артиллерчдийн сургалтаа явуулдаг «Пол-И-Чарки» нэртэй баазад хүрлээ. Тэндээс хийсэн дэлгэрэнгүй сурвалжлага «Өнөөдөр»-ийн дараагийн дугааруудад нийтлэгдэх юм. Харин энд таарсан афган цэргийн «70 долларын цалинг бидэнд америкауд өгдөг. Жаахан мөнгөтэй болж байгаад оргоно оо» гэсэн доожоогүйхэн хариулт санаанд тод үлджээ.

## ХҮН БИШ ЦЭРЭГ ГЭВ ҮҮ?

Афганы армийн асуудлыг хээрийн сургуулийн талбайд нь түр орхиё доо.

«Тусгаар  
улсын армийг  
шив шинээр бий  
болгосон  
туршлага  
Америкт бий  
юу?» гэсэн  
«Өнөөдөр»  
сонины асуултад  
генерал,  
-Нэгийг  
оргүй устгаад,  
өөрийг зохион  
байгуулах тухай  
яриа биш юм.  
Афганистаны  
армийг  
шинэчлэн  
бэхжүүлэх хүнд  
төвөгтэй ажил  
өнөөдөр ид  
өрнөж байгаа  
гэж  
тайлбарлалаа.



Өөрсдөд маань ямар бэрхшээл учирч, цаашид бодож засмаар санаа юу байгаа билээ. «Өнөөдөр» сонины сурвалжлагчид редакцийнхаа зардлаар, АНУ-ын талын дэмжлэгтэйгээр томилолт аван аялсны гол зорилго энд бий.

Монгол Улс 2000 оноос олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож эхлэв. Тэр цагаас уг үйл явцыг баталгаажуулах эрх зүйн орчин үгүйлэгдсэн. Одоо генерал М.Борбаатарын ярианаас иш татъя. «Цэргийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улс нь мэргэжлийн, цомхон, чадварлаг армитай болох зорилт дэвшүүлсэн. Сүүлийн арван жилийн хугацаанд энэ чиглэлд манай бодлого, бүх үйл ажиллагаа хандсан. АНУ-д суралцсан, сурч буй, Ирак, Афганистанд алба хаасан манай хүмүүс мэргэжлийн, чадварлаг армитай болох үйлсэд их том түлхэц өгнө. Эд бол асар туршлага хуримтлуулсан боловсон хүчин» гэж тэрбээр онцлон тэмдэглэлээ. «Феникс»-ийн 13 офицер, ирэх дөрөвдүгээр сард «Жулиен» баазад ажиллах хоёрдугаар ээлжийн мөн 13 хүнд дээрх үгс хаяглагдаж буй юм. Монгол Улсын түүхэн дэх шинэхэн армийн сайн эхлэлийг тэд тавьж явна. Харин бор зүрх, даргын тушаал, хатуу сахилга бат, эр цэргийн тангараг, эх орны нэр төр гэсэн ярианаас гадна дайчдын ахуй нөхцөлд анхаарал тавьсан явдал байна уу? «Монгол Улсынхаа төлөө зүтгэе» гээд Афганистаны элсэн дунд ирж орхисон гэвэл Та итгэх үү? Тэдэнд «That's why» гэсэн америк ухуулах хуудас хамаагүй шүү дээ.

Ар гэрийнхнээсээ гадна эх орондоо тэд хэрэгтэй, халамжинд нь байх учиртай иргэд нь. Үе үе тасалдаж бухимдуулах интернэтээр л офицеруудад халуун дулаан үг илгээдэг гэж үү? «Ердөө тийм шүү дээ» гэж цэргийнхний өмнөөс хэлье. Мэргэжлийн, цомхон, чадварлаг армийн тухай ярианы нөгөө талд хүмүүнлэг гэсэн үг дагалдах учиртай. Тэр хэсгийг орхигдуулаад байгаа цөөхөн баримтыг Кабулд ажилласан хэд хоногт үзсэн билээ.

Улс орны нэрийг өргөж, Америк-Монголын цэрэг, улс төрийн харилцааг үлэмж эрчимжүүлэхэд тус нэмэр болж яваа нөгөө хэдийн аяны цүнх доторхийг нэг анзаараарай. Хагас жил шахмын өмнө гэрээсээ авч гарсан оо, савангийн нөөцөөрөө тэд аргацааж байна. Энэ халуун газар хугацаа дуусах, чанар муудах энэ тэрийн талаар бүү асуу. Дээр би америк цэргүүдийн бэлтгэлийн хувцас, богино цамц, гуталны тухайд дэмий нэг цухуйлгаагүй юм. Дэд хурандаа М.Сүхбаатарыг ногоон эрэн бэлтгэлийн хувцсаар нь, хошууч М.Атарсайханыг улаан хүрэн хослолоор нь холоос таньж болно. Эрэн мяраан манайхныг энгийн хүмүүс гэж эндүүрмээр. Харин дэслэгч Д.Мөнхбатыг Америкийн армийн албан хаагч гэж андуурав аа. Зүгээр л тэр цэргийн дэлгүүрээс биед эвтэйхэн америк форм худалдаад авчихаж.

Монгол цэргүүд өнгөрсөн жилийн сүүлчээс Ирак, Афганы халуун цэгт ажиллаж, хувцас хэрэглэлийнхээ чансааг давхар тодруулж байна. Иракийн эхний ээлж нутагтаа буцаж ирсний дараа манай эрэн хувцасны халаас том болж, тэнд бас цус тогтоох уяа боолт байнга хийдэг болсон гэнэ. Бага сага өөрчлөлт хийж л байна. Гэвч цөлийн нөхцөлд үл тохирох материалтай хувцасныхаа энд тэнд хэдэн нүх гаргах төдий засварууд нь нэг даргаас бүр том даргын өрөөнд хүрч «зөвшөөрөгдөх» замдаа сар улирлыг өртөөлнө. Энэ зуур монгол дайчид халуун цэгийн амьдралыг бор зүрхээрээ туулан «Бид цэргийн хүн» хэмээн дэмий нэрэлхэх юм.

«Феникс» баазын ядуус нь гэгдэх болгарууд өдөрт 60 ам.долларын тэтгэмжийг Засгийн газраасаа авдаг. Тэгвэл нэн ядуу монголчууд ганц долларын цалингүй тул амьдрахын эрхээр арга сийлжээ. Цэргийн дэлгүүрт нь блок тамхи 26 ам.долларын үнэтэй байхад ер юм юм сэтгэхээс ч аргагүй болдог биз. Анхны 13-ын маань дөрөв нь орчуулагч «статустай». Афган орчуулагч

**Мэргэжлийн,  
цомхон,  
чадварлаг  
армийн тухай  
ярианы нөгөө  
талд хүмүүнлэг  
гэсэн үг  
дагалдах  
учиртай. Тэр  
хэсгийг  
орхигдуулаад  
байгаа цөөхөн  
баримтыг  
Кабулд  
ажилласан хэд  
хоногт үзсэн  
билээ.**

хүртэл сард 380 ам.долларын цалин авдаг байхад Монголын эрхэм офицер-мэргэжлийн сургагч нар улаан мөнгөгүй хагас жил хүний нутагт, хүнд нөхцөлд амьдарна гэдэг утгагүй. Ингээд орчуулагч дөрөвтөө дээрх жишгээр цалин олгохыг Америкийн талаас хүсэв. Өгөхөөс өөр аргагүйг америкууд ойлгосон нь мэдээж. Гэхдээ бусад улсын цэргийн орчуулагч нар бас америкуудаас цалин авах гэж «барьцах» магадлалтайг манайханд сануулаад, ам хамхихыг захисан гэнэ. Нөгөө дөрвийн тус бүр 380 ам.долларыг хэдүүлээ тэнцүүхэн хуваана. Батбор лав арай хямд үнэтэй хамрын тамхи үнэрлэх болж, бас ч үгүй манай гэрэл зурагчин Тошка бид хоёрыг буцах үед замдаа хэрэглээрэй хэмээн элдэв зүйл бэлдээд өгсөн шүү.

Афган дахь 13 дайчны асуудлыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабынхан холбогдох газруудад тавьсаар байна. «Торгуулийн рот» гэсэн үгийг би нийтлэлдээ өмнө нь хэрэглээд дарга нарт хэдэнтээ зэмлүүлж билээ. Ирак явсан дайчдаа ингэж цоллосон учраас шүүмжлүүлсэн юм. Гэвч торгууль гэх тааруу үг буу үүрч, манаанд зогссон дайчинд бус, шийдвэр гаргаж дэлхийн халуун цэгт иргэнээ мордуулсан удирдагчдад хаяглагдсан. Иракийн эхний ээлжийнхэн «сайн дурын» тодотголтой явсан боловч тэдний халуун цэгийн томилолтын нөхцөл эхэндээ мөн л тодорхойгүй, Америкийн талтай байгуулсан гэрээндээ манайхан хайнга хандсаныг бүгд мэднэ.

Афганы нэгдүгээр ээлжийнхэн санаа авмаар зүйл олныг ярьж байна. Удаах ээлж мордохын наана шуурхай шийдмээр зүйлүүд ч бий. Улаанбаатараас ирэх төлөөлөгчдөд урьдчилан хүргүүлсэн хурандаа Ж.Ванчинсүрэнгийн хүсэлтийг санамсаргүй олж үзсэн юм. **«Офицерууд ар гэрээсээ авч ирсэн хувийн хэрэгцээний эд зүйлс болон мөнгөө зарцуулж дуусаад байгаа бөгөөд үүрэг гүйцэтгэлийн хугацаа өндөрлөх дөхөж байгаагаас (ар гэртээ бэлэг дурсгалын зүйлс болон хувийн хэрэгцээний эд зүйлс худалдан авах) мөнгөний хэрэгцээ нэлээд байгааг харгалзан үзэхийг хичээнгүйлэн хүсье»** гэжээ.

Ирак, Афган ижилхэн дэлхийн халуун цэг. Иракт сайн дураар, Афганд тушаалаар явсан гэх том ялгааг «Өнөөдөр»-ийн сурвалжлагчид лав олж харсангүй.

## БУЙЛНЫ ҮЗЛЭГ 60 ЕВРО

Афганы монголчуудтай ярилцаж байна. Ахмад Б.Амар, хошууч М.Атарсайхан, ахлах дэслэгч Т.Батбор, дэслэгч Д.Мөнхбат, дэслэгч С.Касипхан, дэд хурандаа М.Сүхбаатар, дэслэгч Б.Төмөрпүрэв бид хэд тойрч суугаад элдвийг хөөрлөө. «Халуун цэгт хагас жил шахмыг өнгөрүүлсний дараа өөрт тань үлдсэн хамгийн чухал зүйл юу вэ?» гэсэн асуултад маань бүгд дургатайяа хариуллаа. Афган тэдэнд асар том сорилт болж, хувь хүнийхээ хувьд өсч өндийн, өөрийгөө ялцгаажээ. Ийм сэтгэлийн үгийг бид дараагийн дугаарууддаа үргэлжлүүлэн нийтэлнэ. Харин энэ удаа эхэлсэн сэдвээ эцэслэх цөөхөн баримтыг тэдний ярианаас түүвэрлэн сонголоо.

-Аюулд хамгийн ойрхон байгаага мэдэрсэн үе тохиолдсон уу?

-Сарын өмнө юм байна. «Поли-И-Чарки» баазад өдрийн хоолонд орж байлаа. Гэнэт америкууд орж ирээд хамгаалах хэрэгслээ өмсөөд даруйхан гарах команд өгсөн. Хэсэг байзнасны эцэст эргээд орохыг зөвшөөрсөн боловч дахин хооллох сонирхолгүй болчихсон. Юу болсныг сонирхвол, ойрхон орших цэргийн гурван баазад нэг зэрэг цохилт өгсөн, «Поли-И-Чарки»-г мөн харвах магадлалтай гэж ярьцгаалаа. Гадагш гарахыг хориглосон тул гурван цаг гаруй хүлээв. Удалгүй хөдлөх зөвшөөрөл аваад, манай сургалт явуулдаг талбайгаас холгүй эхний шалган нэвтрүүлэхийг өнгөрөөсөн. Дараа нь ISAF-ийнхний шалгах цэгээр нэвтрэх гэтэл зөвшөөрсөнгүй. (ISAF нь Германы удирдлага дор Афганистанд аюулгүй байдлыг сахиулдаг олон үндэстний цэрэг цагдаагийн хүчин юм) Бид биеийн байцаалтаа

үзүүлсэн. (ID) Түүнийг маань хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрөхгүй байлаа. Эргээд явахаас аргагүй болж, азаар афган орчуулагч маань өөр тойруу газраар замчилж «Феникс»-дээ ирсэн.

Монгол офицеруудын биеийн байцаалт буюу ID нь ердийн цагаан үнэмлэх. Жишээ нь Америкийн цэргийн албан хаагчдынх соронзон карт байдаг. Түүнийг хаа ч явсан хүлээн зөвшөөрч нэвтрүүлдэг. Тухайн үед хамгийн түрүүнд төрсөн сэтгэгдэл гэвэл ийм ноцтой нөхцөл байдал үүсэхэд өөрсдөө амиа авч гарахаас өөр гарцгүй юм гэж бодогдсон. Бид үүгээр л нэвтэрч байнгын байрлалдаа хүрэх учиртай гээд хөдлөх гэтэл ISAF-ийн цэргүүд буугаа бэлэн байдалд авч, дарга руу шагайгаад муухай хашгирсан. Тэгэхэд л нуруу руу хүйт даах шиг болсон. Эргээд огт мэдэхгүй, аюултай замаар тойрч явлаа. Бидэнд аюулгүй байдлын баталгаа үнэхээр байгаагүй. «Феникс»-тэй холбоо барих хэрэгсэлгүй явсан юм. Манай баг бааздаа тойрч хүрсэн тэр зам дээр өмнөхөн нь маш том дэлбэрэлт болчихсон хэмжилт хийж байгаатай таарсан.

**-Амь нас, эрүүл мэндийн даатгал хийлгэсэн үү? Ер нь Монголоос гарахын өмнө ямар утгатай гэрээ байгуулсан бэ?**

-«Өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж амь насаа алдвал гомдолгүй» гэсэн утгатай зүйл байсан. Энд ирээд харахад өөрийн буруугаас болоод элдэв юманд өртөх магадлал үнэхээр хомс. Дандаа гадны аюул байна шүү дээ. Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа Монголын цэргийн албан хаагчдын биеийн байцаалтыг найдвартай, баталгаатай болгох ёстой. Тэр үед ядаад нэгэнд маань тийм соронзон карт байсан бол биднийг нэвтрүүлчих байлаа.

-Хамгийн анх ирээд цэргийн онгоцноос бууж «КАМАЗ» машины тэвшинд суугаад хөдөлсөн. Тэвшнийх нь ёроолд шуудайтай элс шороо шигүүхэн тавьчихжээ. Энэ зам минатай учир аюулгүй байдлын үүднээс ингэж байгаа юм гэж тайлбарласан.

-Хориод хоногийн өмнө замаас хоёр метрийн зайтай Оросын танк эсэргүүцэх минийг ухаж гаргаад тавьчихсантай таарсан. Замаасаа жаахан л хазайвал минад өртчих байж шүү гэж бодохоор дотор зарсхийлээ. Замын хөдөлгөөний дүрэм гэх юмгүй, хаанаас л бол хаанаас дугуйтай хүн гараад ирэх магадлал их ийм газар хоёрхон метр гэдэг эвгүй зай шүү дээ.

-Францын цэргийн албан хаагчдад гэхэд халуун цэгт ажиллаж байхад ямар нэг явдал тохиолдвол хүүхдүүдийг нь арван жил төгстөл үнэ төлбөргүй сургана, авч байсан цалинг нь дахин нэмж өгнө гээд олон л зүйл байх юм. Улс орны эдийн засгийн хүчин чадлаас хамаарна л даа. Цалин өгч дийлэхгүй юмаа гэхэд өөр анхаарч бодмоор зүйл бий. Цаг агаар, хоол ундны өөрчлөлттэй холбоотой манай хоёр ч хүний буйл үрэвсч өвдлөө. Эндхийн эмнэлэгт буйлны үзлэг хийгээд 60 евро нэхэж байна. Хагас жил болоход эрүүл мэндийн хувьд ноцтой хүндрэл гараагүй нь яамай.

Анх байгуулсан гэрээний нөхцөл ч эргээд өөрчлөгдөж байгааг аль аль талдаа анхаармаар юм. «Поли-И-Чарки» баазад монголчуудыг байрлуулна гэж эхлээд танилцуулж байр сууц үзүүлж харуулсан. Хэрэв анх Америкийн талтай тохиролцсоноороо тэндээ байсан бол одоогийнх шиг ингэж аюултай замаар өглөө, орой бүр хол газар давхих шаардлагагүй. Гэтэл ирээд л өөр газарт байрлах болчихсон.

**-Гэрээнд чинь эмнэлгийн зарим үйлчилгээ төлбөртэй гэж тусгаагүй байсан гэж үү?**

-Шүднээс бусад үйлчилгээ, үзлэг үнэгүй гэсэн.

**-Тэгвэл 60 евро нэхэх нь зөв биз дээ?**

-Тийм. Гэхдээ энд бид хэд чинь нэг ч еврогийн цалингүй гэдгийг Засгийн газар мэдэж байсан байлгүй. Ер нь бид тийм нарийн ширийн зүйлийг сонирхоогүй гараад ирсэн улс. Аюулгүй байдал, бүх юмыг Америкийн тал бүрэн даана гэж ойлгоод нэг их тоогоогүй.

**-Тэгвэл та нар өөрсдөө их бүдүүн халуун улс юм аа?**

-...

Тэгэхэд л нуруу руу хүйт даах шиг болсон. Эргээд огт мэдэхгүй, аюултай замаар тойрч явлаа. Бидэнд аюулгүй байдлын баталгаа үнэхээр байгаагүй. «Феникс»-тэй холбоо барих хэрэгсэлгүй явсан юм.

# Афганд хэн, юу үлдээсэн бэ?

Капитализм, социализмыг хоёуланг нь алгасан харайж чадвал цаана нь гэрэлт коммунизм бий. Энэ бол ХХ зууны афгануудын гэгээн мөрөөдөл, тэмүүлсэн цэг нь байлаа. Ийм амтат зүүдийг нүүдэлчин ард түмний тархи толгойд оросууд шингээж чадсан билээ. Тэгээд тэр нь 2000 жилийн түүхтэй дайнч, нүүж буух дуртай афганууд шүү дээ. Төв Азийн энэ улсын түүхийн өөдрөг хуудсуудад ч, сүүдэртэй мөрүүдэд ч ОРОС хэмээх нэр тодхон хоцорчээ.

Бараан царайтай, ширүүн харцгай, хир даг болсон туранхай эрчүүд гадны хүмүүсийг анхааралтай харна. Үл итгэсэн дайсагналын оч нүдэнд нь гялалзаж байна уу даа гэж эхлээд болсон. Хэсэгхэн зуур ажаад, нас тогтсон эрчүүд нялх хүүхэд адил сониуч загнахыг үзэв. Гэрэл зургийн аппаратны бараа харуугаа «Намайг, намайг, миний зургийг аваач» хэмээн яаран дохиж зангана. Аягатай цай оочиж суусан буурал хүртэл хэдэн хоромд «хөшөө» болж дурангийн өмнө зайгаж өмсөгч шиг аашлахыг яана. Хүүхдүүд! Хямдхан эрээн даавуугаар хийсэн хөнгөхөн хувцас нь салхи даган салбаганаж, халтар хөл жирэлзэн, ээ афган жаалууд гүйгээд ирлээ. Тоос татуулан давхих цэргийн цуваа даган гар гозгонуулаад ер хаширсан шинжгүй. Шороо тоосны цаанаас сэргэлэн хар нүд зурсхийж, эрхийгээ харуулав. Америк цэргүүд хариуд нь мөн л эрхий хуруугаа гаргаж, тэд хэзээний найзууд шиг санагдах юм. Андууд өөр зуураа мэнд мэдэн, мөр мөрөө зөөлөн алгадаад өнгөрөх адил афган багачууд, америк цэргүүд хоорондоо ингэж дохилцдог. Үзээд өнгөрөх төдийд бол энд бүх зүйл эв зүйдээ орж буй мэт.

**Хүүхдүүд!  
Хямдхан эрээн  
даавуугаар хийсэн  
хөнгөхөн хувцас  
нь салхи даган  
салбаганаж,  
халтар хөл  
жирэлзэн, ээ  
афган жаалууд  
гүйгээд ирлээ.**

Цэнхэр болоод хар өнгийн гивлүүртэй хүүхнүүд л талибаны дэглэмийн хатуу цагийг сануулж байна уу даа. Үе үехэн хөнгөн тэрэг зөрж өнгөрнө. Ачаа хавиар нь мөнөөх гивлүүрүүд бөртөлзөж, хонь малаа хойноо бөөгнүүлээд яваа юм уу гэлтэй эхнэрүүдээ шоовдорложээ. Хөнгөн тэрэгний тохитой суудлыг эзэгнэдэг эр нөхөр орон гэртээ ч нэгдүгээр хүн. Орос амьдралын үлдэгдэл, америк түрлэг, талибаны үеийн хорио цээр, юм юм өнөөгийн Афганистанд хутгалдсан. Энэ улсыг эмх цэгцэнд нь төвхнүүлээд, шинэ замд дөхүүлнэ гэдэг тун ч бэрх даваа шиг санагдав.

Ингэж эх толгойгоо алдах хүртлээ ямархан зам туулж өнгөрүүлснийг нь нэхэн саная. Түүхийн буурал хуудасны зөвхөн сүүлийн мөрүүдийг уншаарай. XIX зууны хоёрдугаар хагас гэхэд Афганистанд том гүрнүүдийн сонирхол аль хэдийнэ мөргөлдчихсөн байлаа. Орос, Английн эрх ашгийн зөрчилдөөн дунд жийрэг буфер болсоор иржээ. Большевик хувьсгалын салхи Монголоос түрүүнд хүрсэн улс бол Афганистан. Улаан Орос, тэр хоёр бие биеэ хүлээн зөвшөөрч, нийгмийн шинэ туршилтын хүрдийг элбэн эргүүллээ. Тэр цагаас Монгол, Афганистан гэсэн нэрс түүхийн хуудсанд зэрэгцэн үзэгдэх болсон. Хожим капитализмыг алгасан харайсан үлгэр дууриалаараа бидний хайртай эх орон мөн л уулсын улсыг хажуудаа дагуулсан юм. «Монголын жишээгээр хөгжүүлэх» мастер төлөвлөгөөг Кремль боловсруулжээ. Эдүгээ манай артиллерчдийн сургаж буй афган цэргүүдийн 45 хувь нь хазарууд. Монгол мах цусны үлдэгдэл болох тэдний царай төрх өнөөдөр ч удам судартайгаа дөхүү харагдана. Биднийг Афганистантай холбосон ийм шижмүүд бий.

Хрущевын үед орос хүн бүр афган айлын хүндтэй зочин байсан. Кабулын их сургуульд орос эрдэмтэд багшилж, ах дүүгийн харилцаа бодь замаараа бат бөх болсон гэдэг. Магадгүй, 1930-аад оны үед Монголд өвчигнөсөн хэт







хувьсгалчдынх шиг туйлширсан алхмууд хийгээгүй бол Афганд оросууд нэр хүндээ хадгалах л байв. Паштун болоод тажикуудын талын хоёр намын зэрэгцээ исламууд гурав дахь хүч болоод өндийжээ. 1978 оны дөрөвдүгээр сарын улаан хувьсгалын тухай сонсоогүй хүн цөөн биз. Зориуд зохион байгуулсан юм шиг мөнөөх хувьсгалын давлагаа тод улаан өнгөөр туяарч, исламуудын уур хилэнг улам шагаалаа. Ингээд XX зууны хоёрдугаар хагас болоход Зөвлөлт, Америкийн үзэл суртлын эрх ашиг Афганистанд мөргөлдөв. Америкууд Иранд цэргээ төвлөрүүлж эхэллээ.

«Өнөөдөр» сонины сурвалжлагчид гуравдугаар сарын 18-ны үдэш Кабулаас холгүйхэн нэгэн баяр тэмдэглэж билээ. Ардын армийн 83 жилийн ойн өдөр хошууч генерал М.Борбаатар офицерууддаа баярын мэндчилгээ дэвшүүлэн, медаль зүүж өгсөн мөчид... Яг 25 жилийн өмнө 1979 оны гуравдугаар сарын 18-ны өдөр Кремльд Улс төрийн товчоо хуралдан Афганы хувь заяаг орвонгоор нь эргүүлэх шийдвэр бэлтгэсэн юм. Зүгээр л тохиолдол. Гэхдээ их түүх үнэртэж, бас хажууд минь шинэ мөрүүд нэмэгдэж байх үед Афганы элсэн дунд Монголын төрийн дуулал түрж зогсоно гэдэг сонин тохиолдол. ЗСБНХУ-ын Гадаад явдлын яамны сайд А.Громыко «Хэрэв Афганд цэргээ оруулбал бид түрэмгийлэгчид болох уу?» гэж 25 жилийн өмнөх энэ өдөр асуужээ. Улс төрийн товчооны гишүүдийн олонх «Үгүй. Биднийг хэн ч түрэмгийлэгчид гэж хэлэхгүй» хэмээн эрс хариуллаа. Мөнөөх хариулт есөн жил үргэлжилсэн дайн эхлэх цэг болсон.

**Зүгээр л тохиолдол. Гэхдээ их түүх үнэртэж, бас хажууд минь шинэ мөрүүд нэмэгдэж байх үед Афганы элсэн дунд Монголын төрийн дуулал түрж зогсоно гэдэг сонин тохиолдол.**

Түүнийг түрэмгийлэх дайн гэх үү? Эсвэл Оросын тусламжийн үе гэх үү? Хэрэв дайтаж байлдсан юм бол хэн ялсан юм бэ? Оросуудыг явснаас хойш Афганистан иргэний дайны давлагаанд дахин автсан. Зүрх сэтгэлээс нь нөгөө коммунизмын алтан алимны мөрөөдөл оргүй арилжээ. Талибаны дэглэмийн үлдээсэн айдас хүйдэс, харанхуй өдрүүдийг тэдний зан байдлаас үзээрэй. Үл итгэсэн дүрлэгэр нүд, эвгүйхэн зан нь хөдөлбөл нударга зөрүүлж, хүйтэн зэвсгээ сугалж мэдэх жижүүн амьсгал үе үе мэдрэгдэнэ.

Гивлүүртэй бүсгүйчүүдийн зургийг хамаагүй авч болохгүй гэсэн сэрэмжлүүлэгт бид хүлэгджээ. Бавгар сахалтай эрчүүдийн дүнсгэр дүрслэлээс баахан залхаж явсан бидэнд тунгалаг нүдтэй, өтгөн сайхан хөмсөг нь дугуйрсан бяцхан охид онцгой содон харагдав. Эр нөхөрт гарч, гивлүүр дор нүүрээ нуух хуртлээ тэд сүүдэр зовлонгүй, хараацай адил зугаатай амьдарна. Тас хар үс нь элс тоосонд «зунгааралдаж» орхисон ч ер давгүй царайлаг. Гадны хүмүүсийг тэсгэлгүй сониучлан харж байснаа нөгөө айхтар ёс заншил эрхбиш үйлчлэв бололтой, алгаараа нүүрээ таглаад хөгжилтэй инээлдэв. Цэцгэн цоохор даашинз нь дэрвээд нэг л гэгээн.

Гэвч тэмдэглэлийн дэвтэрт минь цугласан хар баримтууд гэгээлэг дүр зургийг дарж байна. 2001 оны намар Кабулыг Америкийн сөнөөгч онгоцууд бөмбөгдөж эхэлснээр талибуудын эзэрхэл өндөрлөлөө. Охид эргээд сургууль соёлдоо орох эрхтэй болсон. Харин эрх чөлөө нь одоохондоо зөвхөн цаасан дээр том үсгээр бичигддэгийг харж байна. Охидын сургуулийг шатаах, хорлон сүйтгэх ажлыг хуучин дэглэмийнхэн зохион байгуулсаар. 2001 оноос хойш 30 сургуулийг галдан шатаасан аж. Залуухан бүсгүйчүүд өөрсдийгөө галд өрдөж байна гэвэл үнэмших үү? XXI зууны эхэнд, төв Азийн энэхэн улсад цэцэг шиг бүсгүй амь тэмцэж, амьдралаас мохохдоо өөрийгөө зольж байна.

Энэ оны хоёрдугаар сард Афганистаны Засгийн газрын төлөөлөгчид Херат мужид ажиллалаад иржээ. Хуучны ёс жаягийг хатуу дагадаг нутгуудын нэг Хератад ганц сарын дотор 52 эмэгтэй амиа хорлосон гэсэн баримтыг тэд дуулгасан юм. Эр нөхрийнхөө боол адил амьдардаг хүүхнүүд сурч боловсрохоо байя гэхэд төрсөн гэр орондоо өөрийн зоргоор харих, орж гарах ч эрх чөлөөгүй



олон он жилийг үддэг. Төрөл бүрийн дарамт шахалт, хүчээр гэр бүл болсон гуниг зовлон нэгдээд амиа егүүтгэх гол шалтгаан болж байна. Өөрсдийгөө галд өрдөгсдийн олонх нь бие давхар байсан тухай дээрх мэдээлэлд дурджээ.

Америкийн засаглалын үед афган хүүхнүүд сурах, ажил төрөл хийх эрх олж авсан. Харин амьдрал дээр өөрчлөлт, шинэ амьсгал тун удаан нэвтэрч байна. Ёс заншлыг хатуу дагагч талынхан, эсвэл зүгээр л хорлон сүйтгэгчид элдэв дарамт байнга үзүүлдэг. Гуравдугаар сарын 17-ны өдөр Кабул дахь НҮБ-ын байранд хийсэн хэвлэлийн хуралд «Өнөөдөр»-ийн сурвалжлагчид суусан юм. Энэ өдөр НҮБ-ын Хүүхдийн сангийн хэвлэлийн төлөөлөгч охидын боловсролын асуудлаар, мөн UNAMA буюу НҮБ-ын Афганистан дахь Тусгай төлөөлөгчийн газраас сонгуулийн сэдвээр мэдээлэл өглөө. Тус хэвлэлийн хурал дээр ВВС-гийн Кабул дахь сурвалжлагчийн тавьсан асуултыг дамжуулъя.

**-НҮБ-ын Хүүхдийн сангийн энэ онд зарцуулах нийт төсөв хэд вэ? Афганистанд эргэн ирж буй дүрвэгсдийн хүүхдүүдийг сургуульд хамруулах боломж ямар байна? Сургуулийг шатаах зэрэг хорлон сүйтгэх ажиллагааны улмаас танай санхүүжилт бэрхшээлтэй байгаа гэдэг үнэн үү?**

-Хорлон сүйтгэгчдийн хувьд хамгийн хялбар объект нь сургууль болдог. Тиймээс хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, цэвэр усны түгээлтийг сургуулиудад сайжруулах гээд олон ажилд цаг хугацаа, хөрөнгө их шаардагддаг. Хүүхдийн сангийн 2004 оны нийт төсөв 90.000 ам.доллар. Тэгвэл Афганистаны Засгийн газрын хийсэн тооцоогоор 2500 сургууль шинээр байгуулах хэрэгцээ бий. Ойрын гурван жилд энэ чиглэлээр маш том ажил өрнүүлэх болоод байгаа. Олон сургуулийг сэргээн засварлах хэрэгцээтэй. Нэг дэвшилтэй зүйл нь афганчууд боловсролыг, тэр тусмаа охидыг сургуульд явуулахыг их дэмждэг болсон. Өнгөрсөн оны байдлаар дөрвөн сая хүүхэд сургуульд хамрагдсаны 1.2 сая нь охид гэж хэвлэлийн төлөөлөгч хариуллаа.

«Поли-И-Чарки» дахь цэргийн хээрийн сургуулийн талбайд Даргош Кашкаб хэмээх афган эртэй ярилцсан юм. Тэр Афганы үндэсний армийн албан хаагч. Мөдхөн гэрлэх гэж буй.

**-Даргош, гэргий тань заавал гивлүүртэй явах ёстой юу? Танай зарим бүсгүй гивлүүрээ авчихсан явж харагдах юм?**

-Би паштун үндэстэн. Тийм болохоор уламжлал ёс заншлаа хатуу баримталдаг. Гэргий маань бурга өмсч, гивлүүрээ зүүж явах ёстой гэж бодож байна.

**-Тэр сургуульд явъя гэвэл зөвшөөрөх үү? Ер нь охидыг сургуульд оруулах нь зөв үү?**

-Охид боловсрол эзэмших хэрэгтэй. Гэргий маань юм суръя гэвэл татгалзахгүй ээ гэж их буучин эр өгүүлэх юм. Кабул хотын төвөөр машинтай явах зуураа цөөнгүй эмэгтэй гивлүүрээ гээж орхисныг анзаарав. Боловсролтой болов уу гэмээр арай л чанартай, эв донжтой хувцасласан хүүхнүүд нүүрээ нуулгүй, зөвхөн үс толгойгоо алчуураар ороожээ.

Эмэгтэйчүүдийн боловсрол шинэ Афганистаны шийдэх гол зүйл болоод байна. Тиймээс ч тус улс Эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн яамтай. Яамны сайд нь НҮБ-ын Афганистан дахь Тусгай төлөөлөгчийн газрын Жендер хариуцсан зөвлөхтэй өдөр тутам хамтран ажилладаг. Харин ийм зөвлөхийн албыг монгол эмэгтэй хашиж байгааг дуулгахад сонин байх болов уу. Л.Баярмаагийн өдөр тутмын ажил энэ өдрүүдэд чөлөөгүй ундарч байгааг харлаа. Тус улсын иргэд түүхэндээ анх удаа сонгуульд санал өгөхөөр бэлтгэж байгаа. Ардчилсан улс болох эхний алхам буюу чөлөөт сонгуульд ялангуяа бүсгүйчүүд идэвхтэй оролцож чадвал энэ орны түүхэнд гэгээтэй мөр үлдэх юм. Сонгуулийн насны иргэдийг бүртгэхээр НҮБ-ын ажилтнууд хөдөө орон нутагт очсоор байна. Энэ сарын 18-нд Пактия мужид бүртгэл хийж явсан НҮБ-ын ажилтнуудын машин руу тэсрэх бодис шидсэн мэдээллийг Ройтерс

За, за...  
эхлээд түүнтэй  
хамт зураг  
татуулж сайхан  
зан гаргав. Одоо  
зөвхөн бид хэд,  
Афганд уулзсан  
цөөхөн монгол  
зургаа авахуулах  
гэж байна шүү  
дээ. Дохио  
зангаагаар  
тэйлбарласан  
боловч ойлгох  
хүсэл түүнд  
үнэхээр алга  
бололтой.

цацлаа. Бүсгүйчүүдийг бүртгэхэд тун төвөгтэй аж. «Энэ сонгуулийг хүсэхгүй хүмүүс бий. Гэхдээ Афганы хүн амын олонхийн хүсэл сонирхол бидэнд чухал» гэж НҮБ-ын төлөөлөгч хэвлэлийн хурлын төгсгөлд мэдэгдсэн билээ.

Mosque буюу сүмд орж зураг авах гээд Тошка байж ядна. Кабулын гудамжинд ердийн дүрслэл хальсанд буулгахад хүртэл аюултай шүү гэсэн сэрэмжлүүлийг бидэнд өгсөн. Гэтэл бүр ариун дагшин сүмд нь орох гэж зүгээд гэрэл зурагчин маань мэргэжлийн өвчнөөр гүн гүнзгий өвдчихжээ. Цэргийн баазаас гадагш, тэр тусмаа Кабул руу хамгаалалтгүй гарахыг хэвлэлийн бид хоёрт зөвшөөрөөгүй. Тиймээс «Өнөөдөр»-ийн сэтгүүлчид Зэвсэгт хүчний жанжин штабынханд аюулгүй байдлын баталгаа гаргаж өгөн, НҮБ-ын машинаар хотын төвд хүрсэн. Уг баталгаандаа «Цэргийн үйл ажиллагаа явагдаж буй орчин, байрлалд ажиллах үед амь эрсэдвэл миний ар гэр, хууль ёсны төлөөлөгч нар гомдолгүй байх болно» хэмээн бичсэн билээ.

Афганууд ариун сүмдээ орохын өмнө улавчаа тайлаад хөлөө нямбайлан угаах байна. Тошка мөн л гутлаа тайлж эхлэв. Түүнийг дагаад афган жолооч сүмд орлоо. Юмыг яаж мэдэх вэ, эвгүйдвэл зурагчинд маань туслаг. НҮБ-ын Афганистан дахь Тусгай төлөөлөгчийн газрын унаа тэргийг англи хэл гадарладаг нутгийн хүмүүс барьдаг. Сүмийн гадна хориод минут хүлээх зуур нөгөө адтай жаалууд амар заяа үзүүлсэнгүй. UN гэсэн том цэнхэр тэмдэглэгээ бүхий машиныг хоёр банди сайн дураараа учиргүй зүлгэж эхлэв. «Хэрэггүй» хэмээн ойлгуулахыг оролдоод ч нэмэргүй. Пад хар самбайгаар хэд шударч орхиод «One dollar» хэмээн алга тослоо. «One dollar» буюу америк амьсгал энд хэдийнэ нэвтэрчээ. Мөнөөх гозойлгох дуртай эрхий нь хайртай сайных гэхээсээ илүү лонхтой цэвэр уснаасаа нэгийг шидчихэж магадгүй хэмээх горьдлогын зангаа гэж америк цэрэг ярьж байна.

Афган жаал болгон шахам 00-ын цаасны наймаачин болчихжээ. Талыг, эсвэл бүр хариугүй жаахан, талын тал ариун цэврийн цаас өөдөөс сарвайгаад «One dollar»-аа шаргуу нэхнэ. Америкийн цэргийн бааз, олон улсын байгууллагуудын байранд зүгээр хэвтэх үнэгүй барааг аав, ах нь бодвол цөөн цөөнөөр гэртээ зөөдөг биз. Ер нь гадаадынхны хамаг хар бор ажлыг афганууд хийдэг. Тэд ариун цэврийн өрөө угаан, хог хаягдал зөөвөрлөнө. Машин тэрэг барина. Харин орчуулагч афганууд бол нутагтаа бараг дээгүүр зиндааныханд тооцогдох юм. Англи хэл гадарладаг, гайгүй ярьдаг тэд 2001 оноос «үнэд орж» эхэлжээ. Олон ч хүн Пакистанаас нутаг буцаж ирээд америкаудад орчуулга хийх болов. Сард 200 гаруй ам.долларын орчуулагчийн цалинг голсоор байгаад 380 ам.доллар хүргээд нэмүүлчихэж. Ер нь америкауд энд бүгдийг мөнгөөр зодон хөдөлгөсөөр муу зан дэлгэрүүлсэн юм уу гэмээр. Хоёр ч орчуулагчийг талибаны талынхан нухаж орхисон гэж манай цэргийнхэн ярьж байлаа.

Улаанбаатарын саарал хорооллуудын ижил хрущевканууд Кабулд бас бий. Барууны стандарттай «Метрополитен» буудал ч байгаа. Замын хөдөлгөөний дүрэм гэдгийг энэ насандаа сонсоогүй амьдралын хэмнэл үргэлжилж л байна. Эсрэг тэсрэг, шив шинэ, өгөршиж хуучирсны ялгарал зөрчил дунд энэ улсын ирээдүйг гадаадынхан томъёолж сууна. Бодит амьдрал, түүнийг өөрчлөх гэсэн яаруу давчуу төлөвлөгөөнүүд мөргөлдөж үзэгдэнэ. Дөрөвдүгээр сард Лора Буш Кабулд ирэх гэнэ. Биднийг байх үед Төрийн нарийн бичгийн дарга Колин Пауэлл мөн л нэг өдрийн айлчлал хийв. Хаа холын Афганистан хүртэл АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулиар аль хэдийнэ амьсгалаад эхэлчихэж. Арваннэгдүгээр сарын эхний долоо хоногт бага Буш дахин сонгогдох эсэх нь элс шороо нургисан Афганистанаас ихээхэн хамаарах гээд байна. Терроризмын үүрэнд ардчилсан сонгууль явуулчихаж чадвал... Ай даа сайхан

Тиймээс  
«Өнөөдөр»-ийн  
сэтгүүлчид Зэвсэгт  
хүчний жанжин  
штабынханд  
аюулгүй байдлын  
баталгаа гаргаж  
өгөн, НҮБ-ын  
машинаар хотын  
төвд хүрсэн. Уг  
баталгаандаа  
«Цэргийн үйл  
ажиллагаа явагдаж  
буй орчин,  
байрлалд ажиллах  
үед амь эрсэдвэл  
миний ар гэр, хууль  
ёсны төлөөлөгч нар  
гомдолгүй байх  
болно» хэмээн  
бичсэн билээ.

үлгэрийн төгсгөл шиг сонсогдож байгаа биз. «2004 оны зургадугаар сар гэхэд афганууд Ерөнхийлөгч болон хууль тогтоох байгууллагаа сонгох учиртай». Энэ бол Вашингтоны хүсэл. Гэвч товлосон хугацаа хойшлох нь одоо тодорхой болж, есдүгээр сар гэсэн шинэ төлөвлөгөө ярьцгааж эхэллээ.

Ерөнхийлөгч Хамид Карзайг ердөө Кабул хотын мэр гэж хэвлэлийнхэн дооглож байна. Түүний ордныг олон улсын цэрэг цагдаагийнхан давхар давхар хамгаалжээ. Сонгууль хаяанд тулсан юм бол Карзайн зурагтай ганц хуудас ч атугай гудамжинд харагдмаар даа. Х.Карзай элдэв өнгийн эсэргүүцлээс эмээн чимээгүйхэн дахин сонгогдохыг хичээж буй бололтой. Сонгуулийн кампанит ажлаа Монголын улстөрчид шиг дуулиантайхан хийж орхивол тажик, паштунуудын, талибын үлдэгдлийн аазгайг хөдөлгөчих биз. Х.Карзай англи хэл сайтар эзэмшсэн, элдэв бүлэглэлд холбогдоогүй, гар, нэр цэвэр эр. Тиймээс ч барууны орнууд түүнийг, тэр холбоотнуудыг харилцан түшжээ. Уг гарал нь паштун үндэстэн боловч тажик, паштунуудынхаа зөрчлийн хооронд халиуны зулзага шиг барьцаалагдчихсан. Олон улсын хамтын нийгэмлэг Афганистан улсыг ийнхүү шөфлэн аваад байна.

Кабулын төвд орших «Метрополитен» зочид буудалд зөвхөн гадаадынхан байрладаг. Их үд хэвийж, мөнхийн тоос шороо ялимгүй татарлаа. Манантсан саарал тоосонцор «тайвшрах» үес сиймгэр бүрхүүл нэвтлэн сүрлэг уулсын бараа тодров. Кабулыг хүрээлсэн шовх оргилууд эртний сайхан дурдатгалаар үлээх шиг. «Метрополитен»-ий зоогийн газарт хүрэх гэж хэдэн давхар хамгаалалт нэвтэрснээ тэр дороо мартаж орхив. Байгалийн сайханд тайвширсан юм байлгүй. Өндөрлөгөөс ажвал амьдрал буцалсан том хот. Эгцхэн уулын бараг оройг шахуулан барьсан шавар тагзнууддаа хэрхэн хүрдэг юм бол доо. Жимс, ногоогоо тарьж, борлуулаад эхэлбэл мөнгө олж амьдарч болмоор л ард түмэн. Энэ их элс шороонд яаж боловсорсон юм гэмээр алагласан сайхан жимсийг хараач. Уулын салхи үсээр оролдоод, гайхалтай юм, Афганистан надад тун ч таалагдах шиг.

«Метрополитен»-ий оройн зоогны цэс ч дажгүй. Бараг барууны жишигтэй газар юм аа. Харин энд ажилладаг афган залуус нөгөө шилдэг үйлчилгээнд хараахан суралцаагүй. Энгийн зүйлийг ч тэдэнд тэвчээртэй удаан тайлбарлах хэрэг гарна. Тээр дор, уулын бэлд шахуу зогсох харуул залуу гэрэл зургийн аппарат харуутаа хүүхэд адил баярлаж билээ. Харуулын постоо хаяад бидэн дээр хүрээд ирлээ дээ. За, за... эхлээд түүнтэй хамт зураг татуулж сайхан зан гаргав. Одоо зөвхөн бид хэд, Афганд уулзсан цөөхөн монгол зургаа авахуулах гэж байна шүү дээ. Дохио зангаагаар тайлбарласан боловч ойлгох хүсэл түүнд үнэхээр алга бололтой. Цайлганаар инээгээд бид гурвын бүр дунд ороод зогсчихлоо. Дижитал камер, төрөл бүрийн гоё аппарат санжигнуулсан сонин гадаадынхнаас холдох дургүй юм гээч. За, за...

Уулын  
салхи үсээр  
оролдоод,  
гайхалтай  
юм,  
Афганистан  
надад тун ч  
таалагдах  
шиг.



2004 он

Кабул орчимд тэмдэглэсэн цуврал сурвалжлагад маань нэр дурдах төдий үлдсэн хүн бий. Төрсөн эгчтэйгээ Афганы элсэн дунд уулзана гэдэг ховор тохиол биш гэж үү.

Том хар алчуур нөмрөөд, эгээ л афган бүсгүй лугаа нэлмэгэр хувцас өмссөн эгч маань энэ улсын Эмэгтэйчүүдийн яамны сайдад өдөр тутам зөвлөгөө өгдөг байсан юм. НҮБ-ын Афганистан дахь төлөөлөгчийн газрын жендер хариуцсан зөвлөх монгол бүсгүй байлаа.

Түгшүүр аюул нүүрлэсэн өдрүүдэд Афганы хамгийн эмзэг сэдэв болох эмэгтэйчүүдийг анхны ардчилсан сонгуульд оролцуулахаар тэр ажиллаж байсан юм. «Өнөөдөр» сонинд нийтлэгдэх болон 25 дугаар суваг телевизээр цацах



Фотор Б.Тошка

сурвалжлагадаа намайг бүү дурдаарай гэсэн нь даруухан загнасных биз.

UN хэмээх том цэнхэр тэмдэглэгээ бүхий түүний машин байгаагүй бол Кабул руу гэрэл зурагчин бид хоёрыг хэзээ ч нэвтрүүлэхгүй байлаа. Тэр тусмаа НҮБ-ын Төв байранд хүрч, хэвлэлийн хуралд суух санааг маань цэргийнхэн тас хориглосон билээ.

Нэг нь нэлмэгэр хар хувцастай, нөгөө нь сум үл нэвтрэх хантаазтай... Эгч, дүү хоёр уулсын дунд ингэж уулзаад бие биедээ ээмэг сэлт бэлэглэж... Дурсгалтай байгаа биз!

-Энд өөр монгол хүнтэй уулзсан уу?

-Анхных нь чи л байна ш дээ... Бид хоёр ингэж яриад инээлдэв.

Эгч маань Афганистанд анхны ардчилсан сонгууль болох хүртэл Кабулд ажилласан. Түүнийг Женевт гэр бүл дээрээ очсоны дараахан НҮБ-ын гурван ажилтныг барьцаалсан хэрэг явдал сонсогдож билээ.

# -Афганы томилолт чамд юу өгсөн бэ? -Өөрийгөө ялсан

*Энэ асуултыг Афганы анхны арван гурваас ганцад нь л тавьж амжаагүй юм. Түүнийг Ш.Амарбаясгалан гэдэг. Гэрэл зургийн хальсанд харин тодхон үлджээ. Монголын сургалтын хөдөлгөөнт бүлгийн ахлагч, хурандаа Ж.Ванчинсүрэн болон америк офицер нарын дунд тэр зогсч байна. Амараа тун завгүй явнаа. Орчуулга, танилцуулга, Монгол руу илгээх материал, зураг хөрөг бүгдийг хөөцөлдсөөр. Уулзалт, арга хэмжээ болгоны төгсгөлд «Good job!» гэсэн талархлыг тэрбээр «Феникс»-ийн удирдлагаас сонсохыг анзаарав. Ахмад Ш.Амарбаясгалан Ардын армийн 83 жилийн ойн баярын өдөр хошууч цолтой болсныг дуулгая.*

Гуравдугаар сарын 18-ны өглөө «Феникс» баазын төв штабын байрны өмнөх талбайд америк, монгол офицерууд жагссан байлаа. 12 орны далбаа намирсан бүдэг саарал тэнгэрийн дэлгэц дээр шагнал гардуулах арга хэмжээ эхлэв. «Ахмад дайчин» цол, Батлан хамгаалах яамны жуух бичиг, «Дайчин алдар» медаль, Зэвсэгт хүчний жанжин штабын жуух бичгээр шагнуулан, зарим нь энгэр мялааж, нөгөө нь цол ахиж байна. Дэслэгч Д.Мөнхбат «Дайчин алдар»-аа нямбайлан боогоод ээждээ явуулсан юм. Пүрэвсүрэн гуай Улаанбаатарт ирсний маргааш л гэрт минь яаран ирээд бяцхан медалийн хүндэд дарагдан хөөрч билээ.

Иракт ажиллаж байгаа 2000 дайчиндаа Польшийн Батлан хамгаалахын сайд нутгийн хиам авч очсон тухай мэдээлэл уншиж байсан санагдана. Монгол сэтгэл, заншил ялимгүй өөр. Дээрх шагналуудын заримыг арван мянган төгрөг дагалддаг. «Гэргийд чинь 10.000 төгрөгийг нь өгсөн шүү» хэмээн Улаанбаатараас ирсэн хурандаа офицерууддаа уламжилж байна.

Дэд хурандаа Ч.Баттулгын энгэрт «Цэргийн нэр төрийн төлөө» хэмээх медаль гялалзана. Бригадын генерал Мансино ийм шагналыг энгэрт нь зүүж өгөв. Афганд өнгөрүүлсэн халуухан хагас жилийг гэрчлэх бяцхан медаль. Харин тэдгээр өдрүүд амьдралын том даваа, өөрийгөө ялж, итгэж эрдэх их алхам болсон хэмээх бодлыг сэтгэлдээ сэмхэн хадгалжээ. Сэтгэлийнхээ үгсийн зах зухаас дайчид бидэнтэй хуваалцсан юм. Афганы монголчууд ярьж байна.

**-Мөнхбат аа, энд хагас жил шахам хугацаанд ажиллаж, амьдарлаа. Чи өөрчлөгдсөн үү?**

-Надад үлдэж, шингэсэн зүйл маш их. Нэг дор бүгдийг томъёолоод илэрхийлэхэд хэцүү юм. Гүйцэтгэж байгаа үүрэгтэй маань холбоотойгоор хамгийн түрүүнд англи хэлний маш сайн дадлага боллоо. Хүний хэлснийг ойлгох, өөрөө санаагаа илэрхийлэх, бусдын ярьсныг зөв дамжуулах, харилцах чадвар маань хамаагүй дээшилсэн. Хоёрдугаарт, анх удаа Америкийн цэргийн баазад амьдарч үзлээ. Гадаадын цэргийн албан хаагчид биеэ яаж авч явдгийг өөрсөдтэйгээ харьцуулж, баазын зохион байгуулалт амьдрал ямар байдгийг мэдэж авлаа. Өмнөх төсөөлөл маань тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн.

Бас 24 жилийн турш гэр бүлийнхэнтэйгээ хамт үдсэн халуун дулаан баяруудыг энд хамт олныхоо дунд өнгөрүүллээ.

**-Төмөр өө, чамд үлдэж байгаа зүйл юу вэ?**

-Олон л юм байна. Гол нь гадаадын найз нөхөдтэй болсон. Танилтай хүн талын чинээ гэдэг шүү дээ. Энд учирсан эр цэргийн танилуудтайгаа эргээд



хаана ч дайралдаж болох юм. Арай илүү ойр дотно байсан нь румын, болгар цэргүүд.

**-Яагаад?**

-Хуучин социалист орныхон болохоор арай элэг нэг байдаг юм болов уу.

**Дэслэгч С.Каспхан:**

-Миний хувьд орон орны цэргийн тамирчидтай өрсөлдөж үзлээ. Өмнө нь нутгийнхантайгаа, эсвэл ангийн офицер ахлагч нартай л хүч сорьдог байсан. Монголын маань тамирчид олон улсын тэмцээнд оролцдогтой жиших юмгүй л дээ. Гэхдээ би энд өрсөлдөөд ялахыгаа ялсан. Хүч сорьчих чадал байгааг мэдэрч, өөртөө итгэсэн. Монголд байнга дасгал хийх спорт танхим, чийрэгжүүлэлтийн иж бүрэн хэрэгсэл ховор болохоор харьцангуй бэлтгэл тааруу байсан. Гэхдээ тэднийг хар л даа. (Монголын цэргийн багийнхны авсан цомуудын зүг заалаа) Бид хэд бааздаа оройхон ирсэн ч гэсэн зав гаргаад заавал бэлтгэл хийдэг.

**Дэслэгч Б.Төмөрпүрэв:**

-Би тамхи их татдаг байлаа. Энд ирээд муу зуршлаа хаяж чадсан. Бага гэлтгүй энэ бол надад гарсан өөрчлөлт. Мөн хэл ус мэдэхгүй афган цэргүүдэд алив зүйлийг яаж тайлбарлавал хялбархан ойлгуулчих вэ гэж ямагт мэрийдэг. Би ямар дари хэлээр, паштунаар ярьж чадах биш. Яваандаа заах аргын дадалд суралцсан гэх үү дээ. Нутагтаа бол ахлагч нарт хичээл заадаг байсан. Харин энд огт өөр орчин бий. Үйлдэл, дуу хоолойныхоо өнгө аяс, дохио зангаагаар хүртэл санаагаа илэрхийлэх чадвартай боллоо. Гуравдугаарт, англи хэлний түвшин мэдэгдэхүйц сайжирсан. Америкууд найзархуу улс болохоор ярих гэнэ. Эхлээд буруу хэлчих вий гэж зовоод зугтаагаад явсан улс чинь одоо бараг араас нь элдэх шахуу. Мөн бичгийн орчуулга хийгээд ирэхээр үгийн баялаг ч нэмэгддэг юм байна.

**С.Каспхан:**

-Нутагтаа байхдаа нэг их тоодоггүй, анзаараагүй зүйлээ холоос мэдрэх юм. Монгол хүн гэдгээрээ өнөөдрийнх шиг бахархаж явсангүй. Яаж Афганд төрчихөөгүй юм. Ийм том алчуур толгойдоо ороочихоод л явж байсан бол яана!

**-Гурав, дөрвөн эхнэр аваад зүгээр юм биш үү?**

-Хэцүү ш дээ. Ер нь Афганистанд амьдрал аймаар хүнд. Тэгэхэд монголчууд бид нутагтаа тайван сайхан амьдардгийг эндээс л илүү мэдэрдэг. Америк, Орост очвол баян, дажгүй л гэнэ. Тэнд ч түгших зүйл их бий шүү дээ.

**Ахмад Б.Амар:**

-Би ирэх арваннэгдүгээр сард 50 нас хүрэх хүн. Өнгөрсөн жилийн дөрөвдүгээр сард тэтгэвэртээ гарсан юм. БНСУ-д ах маань бий. Тэр хүрээд ирээ гээд би ч бүх материалаа бүрдүүлж орхилоо. Тэгсэн манай дарга дуудав. Армид олон жил алба хаасан хүн одоо Афганистанд очиж мэдэх чадахыгаа зааж өгвөл ямар вэ. Нэр төрийн асуудал шүү гэж байна. Эхлээд эргэлзэж, гэр рүүгээ утсаар ярилаа. Тэгээд л газар дээр нь шийд гаргаад зөвшөөрчихсөн юм.

**-Энд хийж гүйцэтгэсэн ажилдаа сэтгэл хангалуун байна уу?**

-Хамгийн сайхан нь олон залуустай зэрэгцээд ажиллахад урамтай. Хоцрохгүй, дутахгүйг хичээж явна. Энд ирээд ажигласан зүйл гэвэл жишээ нь америкууд нэг зүйлээр дагнаад сурчихсан, түүндээ эзэн болдог. Тэгвэл манай нэг хүн гэхэд олон төрлийн ажлыг чанартай хийж чаддагаараа давуу юм.

**Дэд хурандаа М.Сүхбаатар:**

-Манай хөдөлгөөнт бүлгийн сургалтдаа хэрэглэх буу зэвсгийг Амар ах бид хоёр засварлан бэлэн болгодог албатай. Хэдэн жил болсон, ямар хүний гараар



ороод хаягдаж орхисон, ямар дайнд «оролцсон» эд болохыг нь бүү мэд. Арваад жил оросуудын гарт байгаад, дараа нь иргэний дайнд дайчилсан буу зэвсэг гэж сонссон. Тэгэхээр дор хаяж зуугаад сум гаргасан байгаа. Ийм буун дээр бид өмнө нь ажиллаж үзээгүй, манай зэвсэг чинь эднээс чанарын хувьд хамаагүй илүү шүү дээ. Би зэвсгийн инженер мэргэжилтэй л дээ. Засварчин Амар ахын тусалцаа байгаагүй бол ийм бууг «босгох» тун ярвигтай юм.

**Б.Амар:**

-Хог дээр хаягдаад зэвэрч моралийн элэгдэлд орсон бууг өнөөдөр заслаа, ашиглаж боллоо гэхэд дараагийн сургалтын үед гэмтэл гарч ч болзошгүй. Их засвар хийх учиртай эдийг хээрийн нөхцөлд янзалж байна. Манайхны сургалтдаа ашиглаж байгаа найман их буунд дахин гэмтэл гарахгүй гэх баталгаа үгүй.

-Дадлага хийх сумгүй болсон гэв үү?

-Зарим улсаас тусламжаар сум өгч магадгүй юм.

-Хамгийн анх Афганд ирсэн өдрөө санаач?

**М.Сүхбаатар:**

-Шууд л Зүүнбаян санагдсан. Би тэнд дөрвөн жил алба хаасан юм аа. Есдүгээр сард Кандагарт анх буухад хачин халуун байлаа.

**С.Каспихан:**

-Онгоцноос буугаад «Борц болж мэдэх нь» гэж бодож билээ.

**Д.Мөнхбат:**

-Би ч бор хүн дээ. Бүр пад хар юм болох нь гэж төсөөлөөд.

**Ахлах дэслэгч Т.Батбор:**

-Энд үхчихгүй л юмсан гэж эхлээд бодсон.

-Түгшүүртэй санагдсан уу?

-Онгоцноос буумагц бид хэдэд сум үл нэвтрэх хантааз өмсгөөд аюулгүй байдлын зааварчилгаа өгч эхэллээ. Дуулгагүй ирсэн юм уу гэж асуусан. Замын хажууд зогсч байсан нутгийнхны харц жихүүцэл төрүүлсэн. Иймэрхүү онцгой нөхцөл гэдгийг киноноос л өмнө нь харж явсан юм чинь. Манай Тавантолгой дахь хээрийн сургууль дадлага гэдэг эндэхтэй зүйрлэмгүй эд гэдгийг шууд мэдэрсэн.

**-Чимээгүй аюулын дунд бараг зургаан сар хамт амьдрахад бие биеэ түших, нөхөх тохиолдол олон гарна биз?**

-Бие биедээ бүр дасчихсан. Байрандаа ганцаараа үлдэх тун эвгүй, нөгөөдүүлээ эрээд эхэлнэ. Яваандаа гэр бүлийнхэн маань ч өөр хоорондоо харилцдаг болчихож байгаа юм. Интернэтийн холболт тасраад гэр рүүгээ захиа бичиж чадалгүй долоо хоног. Зарим нь бүр сэтгэлээр уначихсан. Өмнөговийос ирсэн Намсрайн авгай манай гэр рүү, Улаанбаатар руу утасдаад, и-мэйл болохгүй байгаа шүү, мессенжерээр харилцаарай гээд хэлсэн гэсэн.

Афганд алба хааж буй монгол офицерууд ингэж ярьцгааж байна. Сар шинийн буузны багийнхан харин сонин зургууд үзүүлэв. Захаас хонины бүтэн мах 70 доллараар худалдаж аваад, афган гурил зуурч бууз хийснийг нотлох баримтууд гэнэ. Нутгийнхны зардаг хөнгөн цагаан түмпэнг хэрхэн жигнүүр болгосноо дэлгэрэнгүй ярихаас ичив. Тэгээд Амар гуайн хараа хяналт дор хадгалдаг хийн бяцхан зуух дээр битүүний үдшийн нандин зоогоо болгожээ.

Төдөлгүй ахмад Амар мөнөөх зуухаа тэвэрч ирээд сайхан аагтай сүүтэй цай чанаадахлаа. Настай хүн цайгаа санадаг ч биз. Танил үнэр хамар цоргиж гэрээсээ гараад хэдхэн хоносон би хүртэл аяга бариад дөхөөд суух чинь. Хурандаа Ж.Ванчинсүрэн үе үехэн ингэж цайлах дуртай гэнэ. Тэр мөн л тавь гарсан хэдий ч хөнгөн шингэн алхаатай, хальт уулзахад хатуухан үгтэй. Өнгөрсөн таван сар гаруйн хугацаанд 12 офицертоо дарга, түшиг, эцэг эхийг нь орлож, өөрийнхөө зовлонг умартаж явсан нэгэн биз ээ. Түүнтэй ярилцлаа.

## Ж. ВАНЧИНСҮРЭН: АНУ-ТАЙ ХИЙЖ БУЙ ГЭРЭЭНД ИЛҮҮ АНХААРАЛ ХАНДУУЛАХ УЧИРТАЙ

### -Анх ирэхэд хэр тохижуулж базаасан газар угтав?

-2003 оны есдүгээр сард ирээд энд хийх ажлын багтаамжаа төсөөлж, орчин байдалтай танилцлаа. Монголоос засварын ямар багаж хэрэгсэл авч ирэхийг судалж үзсэн. Энд ирсэн эхний үед тохь тух тааруу л байсан. Зүгээр нэг хөндий байртай байсан бид одоо бодоход нэлээн зүйл хийчихжээ.

### -«Феникс» баазын мужаан байдаг гэсэн?

-Тэдэнд хэлбэл бүтэн сар хүлээлгэнэ шүү дээ. Бид бол гурав хоногийн дотор байраа тохижуулаад янзалчихсан, америкиуд гайхаж л байлаа. Эхний бэрхшээл гэвэл орчиндоо зохицно гэдэг хүнд юм билээ. Цагийн ялгаа гарч өгөхгүй, хоол унд тэс өөр. Манайхан чинь халуун цай, шөлтэй хоолонд дасчихсан улс юм. Энд элдэв шүүс, хүйтэн ус уугаад л, сам хорхой, хавч энэ тэр идэхээр харшил өгч тууралт гарах явдал бий. Анхны нэг сар иймэрхүү байдалтай нэлээн ядарсан шүү. Тэгж байгаад монгол хүний нэг онцлог юм даа, орчиндоо дасаад, мах мяраа суугаад ирсэн.

### -Хагас жил болоход бүтээсэн гол ажил юу вэ?

-Афганистаны үндэсний армид мэргэжлийн артиллерийн салбар бэлтгэж өгөөд, байлдааны буудлага хийлгээд, дээр нь зэвсэг техник засч өөрийн хэрэгсэлтэй болгож чадлаа. Товчхондоо үүрэг гүйцэтгэх чадвартай нэг салбар бэлтгэлээ. Хоёрдугаарт, манай офицеруудын мэргэжил мэдлэг маш их өссөн. Бие бялдар хөгжиж, гадаадынхнаас олон зүйл сурсан. Гуравдугаарт, гадаадын нэг улсын ахлагч, офицеруудыг Монголын армийнхан сургаж бэлтгэнэ гэдэг олон улсын түвшинд манай цэргийнхний мэргэжлийн ур чадвар өндөр түвшинд очсоныг илтгэнэ. Эцэст нь, дайны хөлд нэрвэгдсэн ард түмэнд тусална гэдэг буянтай үйлс.

### -Америкийн талтай анх байгуулсан гэрээнд энд ирээд өөрчлөлт орсон уу?

-Бараг өөрчлөгдсөн зүйлгүй. Гэхдээ Монголын зэвсэгт хүчний түүхэнд гадаадын улс оронд мэргэжлийн сургалт явуулсан эхний тохиолдол юм болохоор алдаж оносон, цаашид сайжруулмаар зүйл харагддаг.

**-2002 онд батлагдсан Зэвсэгт хүчний тухай хуулиар энхийг сахиулах үйл ажиллагааг эрх зүйн хувьд баталгаажуулжээ. Харин уг хуулийн утга санааг дагасан бусад журам үгүйлэгдээд байна уу? Халуун цэгт ажиллах цэргийнхний хувьд санхүүжилтийг нь тухай бүрд нь Санхүү, эдийн засгийн яамнаас гуйж гувших байдлаар шийдэх утгагүй юм.**

-Зэвсэгт хүчний тухай хуульд холбогдох заалтууд тодорхой орсон. Гэхдээ анхаармаар зүйл бий. Үүрэг гүйцэтгэхийн өмнө АНУ-тай хийж буй гэрээ бий. Тэр гэрээний заалтуудад илүү анхаарал хандуулах ёстой. Тухайлбал, энд ажиллах үед бидний аюулгүй байдлыг АНУ-ын тал бүрэн даадаг гэж итгэлтэй хэлж чадахгүй нь. Мөн Афганистанд үүрэг гүйцэтгэх явцад манай цэргийнхэнд тодорхой урамшуулал өгдөггүй. Иймэрхүү утгаар нь харвал Америктай байгуулж буй гэрээнд шинэ заалт оруулах, хуульдаа зохих санаа тусгах шаардлагатай.

### -Иракийн эхний ээлж гэрээгүй шахам л явчихсан шүү дээ?

-Иракийн анхны багт туршлага дутсан зүйл бий. Бид тэдний дараа буюу 2003 оны аравдугаар сард хөдөлсөн болохоор гэрээ байгуулсан. Цаашдаа улам л чамбай болно гэдэгт эргэлзэхгүй байна. Монгол Улс Афганистанд тусламж үзүүлж байгаа гэдэг утгаараа Америкийн талаас юм болгоныг нэхээд байх боломжгүй зовлон бас бий.

### -Офицеруудаараа бахархах үе бий юү?

-Байлгүй яахав. Монгол офицерууд хэчнээн харь хол газар ч гэсэн орчиндоо хурдан дасан зохицдог. Манай хэдийн зааж сургаж буй байдлыг харахад үнэхээр чин сэтгэлээсээ, хүнд заавал нэг юм ойлгуулчих гээд бүх нөөц бололцоогоо шавхдаг. Мэргэжлийн хувьд ч чадварлаг.

Гуравхан өдөрт  
аль болох олныг  
үзэж, Монголын  
уншигчдад түүнээ  
дамжуулах гэсэн  
эрмэлзлэл маань  
хатуу чанд  
сахилгатай  
цэргийнхний  
гайхшийг барсан  
байж мэднэ.  
Хулгайгаар шахам  
Кабул руу «оргож»,  
хулгаж эмээн  
гудамжаар яарсан  
хоёр сурвалжлагч  
бол Галибаны  
дэглэмийн дараах  
Афганистанд хөл  
тавьсан Монголын  
хэвлэлийнхний  
түрүүч. Хожим  
олон сэтгүүлч  
уулсын улсад очих  
биз. Харин тэдэнд  
маань Тошка бид  
хоёр шиг  
хамгаалалтын том  
хангаазанд түүргэх  
явдал гарахгүй,  
сайн цаг  
цэцэглэнэ гэж  
найдна.

**-Иракийг бодвол Афган аюул бага газар уу?**

-Иракт бол өдөр болгон дайралт хийж байгаа. Тиймээс хаашаа ч явсан асар том хамгаалалттай гардаг. Манайхан бааз дотроо хэдий хамгаалалттай боловч гадагшаа явахаараа өөрөө өөрсдийгөө хариуцдаг болохоор дайралт хийсэн тохиолдолд хохирол амсах магадлал өндөр. Иракт алба хааж байгаа нөхцөлтэй ямар ч ялгаагүй гэж ойлгодог. Аюул, цаг агаар бүгд ижил. Монгол цэргийнхний хийж буй үйлдэл буюу энд хүн сургадаг, тэнд манайхан хамгаалалтад гардаг үүргээрээ өөр. Харин ажиллаж буй орчин маань адилхан.

**-12 офицер ахалж яваа дэд хурандаа гэлгүй хувь хүнийхээ хувьд Афганы томилолт Танд юу үлдээсэн бэ?**

-Би эднийхээ дунд хамгийн ахмад настай хүн л дээ. Сая хоёрдугаар сарын 16-нд 50 нас хүрлээ. Англи хэлээр «а»-гүй шахам л ирсэн. Одоо бол хүний хэлж ярьсны 40, 50 хувийг ойлгоно оо. Орос хэлний мэдлэг ч дээшилсэн. Нутагтаа байхдаа тэр бүр биеийн тамираар хөөцөлдөж чадах биш. Харин энд ирээд зав гаргаж зааланд очсоор хэдэн насаар залуужих шиг болсон. Хичээл сургалтын технолог, олон орны цэргийнхний хувцас форм, зан харьцаа, баазын тохижилт гээд юу эсийг олж харж, санаа авсан гэх вэ.

**-Ар гэрийнхэнтэйгээ яаж харилцаж байна?**

-Интернэтээр захиа зангаа авна. Гэргий маань бас цэргийн хүн болохоор намайг сайн ойлгож ар талаа тун сайн аваад явж байгаа гэв.

Ж.Ванчинсүрэн тэргүүтэй монгол офицерууд дөрөвдүгээр сарын сүүлээр нутагтаа ирнэ. Тэдний араас дэд хурандаа Р.Канадаар ахлуулсан мөн 13 хүнтэй баг Афганистаныг зорихоор бэлтгэж байна. Цөлийн ид халуунд, ярвигтай цаг агаар манай хоёрдугаар ээлжийг угтах нь. Хорхой шавьж, хорт могойноос өгсүүлээд тэдэнд өгч буй аюул сэрэмжлүүлгийн төрөл нэмэгджээ. «Феникс»-т бус, «Жулиен» нэртэй цэргийн баазад Р.Канадын баг очих юм. Илүү аюултай зам харгуйгаар явж байж сургалтын талбайдаа хүрнэ, модон байшин бус майханд амьдрах гээд «од буурсан буудал» тэднийг хүлээж байна. Гэвч эхний арвангурвын хуримтлуулсан туршлага нөмөр түшиг нэмэх нь мэдээж.

Энэхүү цуврал сурвалжлагаараа хөндсөн санаа бодол ч дараагийн ээлжийнхэнд бага гэлтгүй тус болох болов уу гэж найдна. Манай цэргийн багийн хоёрдугаар ээлж хөдлөхийн өмнө Засгийн газар зайлшгүй шийдэж өгөх учиртай асуудлуудын зах зухаас тэмдэглэхэд ийм.

«Өнөөдөр»-ийн сурвалжлагчид Кабул орчимд гурав хоноод хөдөллөө. **Кабул-Бишкек-Алматы-Бээжин** маршрутаар цэргийн онгоцонд сэгсчүүлэн, хөнгөн тэргээр үргэлжлүүлэн, дахин агаарын хөлгийн нислэгийн цаг хүлээх урт аян өмнө сунайна. Гэвч зам зуур урсан өнгөрөх өнгө өнгийн амьдрал Афганистаны тухай сэтгэгдлийг бүдгэрүүлж чадаагүй юм.

*Гуравхан өдөрт аль болох олныг үзэж, Монголын уншигчдад түүнээ дамжуулах гэсэн эрмэлзлэл маань хатуу чанд сахилгатай цэргийнхний гайхшийг барсан байж мэднэ. Хулгайгаар шахам Кабул руу «оргож», хулгаж эмээн гудамжаар яарсан хоёр сурвалжлагч бол Талибаны дэглэмийн дараах Афганистанд хөл тавьсан Монголын хэвлэлийнхний түрүүч. Хожим олон сэтгүүлч уулсын улсад очих биз. Харин тэдэнд маань Тошка бид хоёр шиг хамгаалалтын том хантаазанд түүртэх явдал гарахгүй, сайн цаг цэцэглэнэ гэж найдна.*

НҮБ-ын Афганистан дахь Тусгай төлөөлөгчийн газрын Цэргийн зөвлөх, Испанийн армийн генерал Энрике Рескетэй бид мөн уулзаж ярилцаж амжсан. Тэрхүү ярилцлага «Өнөөдөр»-т нийтлэгдэнэ. Харин Афганистаны телесурвалжлага маань ирэх долоо хоногийн даваа, мягмар гаригуудад «MN-25 дугаар суваг» телевизээр цацагдах юм.





Фотог Б.Ташка

# Алчууртай аялал

*«Үүнийг хараач. Монголын паспорт гэнэ» хэмээн араб бүсгүй нөгөөдөө хэлж буй бололтой. Ижилхэн тас хар алчуураар хүзүү толгойгоо битүүлсэн иран хүүхнүүд зорчигчдын паспортыг нягтлан шалгаж байна. Дүрлэгэр том нүд, монхор хамар, мөн гар хуруугаа эрхиш ил гаргасан тэд хоорондоо тун адилхан харагдана. Зарим нь нүдний шил зүүж улам ч зожиг хөндий дүр төрхийг олжээ. Тегераны нисэх буудалд нэвтрэхийн тулд урт урт дараалалд байн байн зогсч, үймж бужигнасан олны дунд хутгалдах хэрэг гарна. Яах вэ, буцах гэж буй цагт бол яаж ч түлхэлдсэн шантрах юм алга. Харин энд анх хөл тавьсан эхний мөч ямар байсан гэж санана!*

## ВИЗНИЙ ХҮЛЭЭЛТ, МЭДЭХЭД ИЛҮҮДЭХГҮЙ ЗҮЙЛС

Үүр цайхын өмнөх түнэр харанхуйд тээр дороос түмэн гэрэл анивчин Тегеран дэлхийн том хотуудын өнгө төрхтэй угтсан билээ. Гурван цаг гаруйн өмнө Москвагаас хөөрөх үед онгоцны цонхоор мөн л ийм гэрлэн цуглуулга үзэгдэж, улаан, цагаан зураас урсан одох нь тод харагдсан. Үнэхээр Москвагаас дуутуугүй аварга хот. Арван сая хүн Тегеранд амьдардаг.

Аэрофлотын үйлчлэгч бүсгүй онгоц газардах дөхсөнийг дуулгах агшинд эргэн тойронд минь эрээн цэцгүүд тун олон болов. Энэ хөлөгт явсан бүх эмэгтэй өнгө өнгийн алчуураар хүзүү толгойгоо битүүлж орхилоо. Алтан шаргал үсээ хаялсан европ бүсгүй гэв гэнэт тосгоны ажилсаг эмэгтэй адил алчуур зангидан харц доошлуулж, нэлмэгэр цамц давхарлан хөл гараа халхлаад эхлэх нь хачин. Гэтэл миний аяны цүнхэнд юу байгаа билээ? Тегеранд ойрын хэдэн өдөртөө 40 градусын халуун байна гэж интернэт сайтууд мэдээлсэн болохоор хөнгөн нимгэн хэдэн даашинзаа чемоданы ёроолд хийсэн юмсан. Тохой үл далдлах, тэр бүү хэл өвдөг дөнгөж шүргэсэн төдий «аальгүй» даашинзаа санаад эмээж орхив. Юутай ч том гэгч алчуураар үсээ сайтар ороолоо. Тийм бүгчм халуунд хүрэм, цамц энэ тэр аваад яахав хэмээн эндүүрснийг, бүр тод торгомсог хослол зориуд сонгож гэнэдсэнийг яана. Уг нь Lonelyplanet.com сайтаас зөвлөгөө авч уншиж харсан л юмсан. Гивлүүр, алчуур нөмөрсөн хүүхнүүдийн гунигийг хуваалцах шахлаа. Заавал тас хар алчуур нөмөр гэж шаарддаггүй нь бас яамай даа.

Тегераны нисэх буудалд хөл хөдөлгөөн харьцангуй бага. 01.30 цагт газардсан болохоор биднийг нойрмог хот угтсан ч байж мэднэ. Иранд өнгөрүүлсэн цөөн өдөр «Өнөөдөр»-ийн Guide book буланг сонирхогчдод хэрэгтэй санаа өгч магадгүй юм. Тус улсад нэвтрэх визийг яг энд авдаг. Гэхдээ жигтэйхэн хойрго үйлчилнэ шүү. Яаруулж шахах бараг илүүц. «Виз олгох чинь цаг хугацаа шаарддаг ажил шүү» хэмээн хариуцсан ажилтан нь нүүр царайдаа өчүүхэн ч хувирал үзүүлэлгүй тайлбарлана. Тэр эр гэрийн гэмээр ууглаа шаахайтайгаа, үе үе зөөлөн буйдан дээр зүүрмэглэн телевиз үзэх унтахын хооронд нойрмоглох аж. Энд хоёр цаг гаруй тэвчээр заан хүлээх зуур цөөнгүй онгоц газардаж зорчигчид нь өмнүүр цувраад өнгөрөв. Хилийн хяналтын ногоон хувцастай ажилтнууд паспортыг минь зүгээр л эргүүлж тойруулан сонирхож, хоорондоо элдвийг ярин цаг нөхцөөх аж. Ганц хүн хөнгөхөн гүйцээчих ажлын ард гурав, дөрвөөрөө цуглаад дэмий холхих дүр зурагтай дараа нь ч энд цөөнгүй тохиолдсон. Олон улсын нисэх буудлын ажилтнуудын олонх хамгийн энгийн зүйлсийг англиар тайлбарлаж барахгүй. Хэрэв ямар нэг шалтгаанаар виз олгохгүй гэвэл байдал эвгүйдмээр ч юм шиг.

Гадаадынхан голдуу буудаг том зочид буудал дотор ингээд явахад гайгүй биз гэж санасан минь алдаа байж. Буудлын ажилтан нутгийн эр хилэнтэй харцаар ширвээд ямар нэг зүйл хэлэхэд нь «түргэн авч» үс гээгээ битүүлэв.



Ирантай хийх худалдаандаа АНУ хориг тавьсныг уншигчид сайн мэднэ. Тиймээс энд American Express авч очих шаардлагагүй. Түүнчлэн Америкаас авсан Visa, Master картууд тань ч хэрэгцээгүй эд болох вий. Хэдэн доллар халаасандаа авч яваа бол Bank Melli хэмээх нэрийг л сайн тогтоогоорой. Хотын төвд ч эдний салбарууд харагддаг. Нэг доллар 7900 риалтай тэнцэх ба хагас кг ногоон үзэм аваад 12 мянган риал төлсөнтэй минь харьцуулж багцаалаарай. Нисэх онгоцны буудал дахь Bank Melli-гийн салбар цөөн доллар хариулж өгч дийлэхгүй байсан юм болов уу даа. Нэг ажилтан нь цамцаа нөмрөөд гараад явав. Хагас цагийн дараа түүний барааг харсан билээ. Шөнө дөл цаг болохоор нэг иймэрхүү хойрго дүр зурагтай учирсан байж магадгүй юм аа.

Дамжин өнгөрөх нислэг хүлээн Шереметьевод арван цаг суусан алжаал хөл гар тушиж, Ираны виз хүлээсэн хоёр цаг хагасын уртад бүр сульдаж орхив. Ногоон хувцастай хилийн албаныхан юу ч юм бэ хүлээн хий холхиод л. Чухам юу хүлээгээд паспортыг минь өгөхгүй байгааг лавлавал мөрөө хавчисхийнэ. Хүнд суртал, хөшүүн нүүр царай хаа сайгүй л амьдрах юм даа.

Эцэст нь өнгө үзэмж даруу, цөөхөн бичлэг тэмдэглэл бүхий нэвтрэх виз даруулж авлаа. Харин хураамж нь хэд юм бол? Эхлээд 50 ам.доллар нэхэж, дараа нь 32 болгож бууруулах зэргээр ашигласан учир яг таг ойлгож чадсангүй. Хэлснийг нь даруйхан төлөөд ачаа тээшээ олж авах минь.

### ШАВАР ХЭРЭМНИЙ ЦААДАХ ОНЬСОГО ШИГ АМЬДРАЛ

Шөнийн Тегеранд хамгийн түрүүн телевизийн цамхаг нүдэнд тусна. Гэрлэн чимгээр эмжсэн аварга бамбар адил хэлбэртэй. Харин маргааш өглөө анзаарвал бусад барилга байшингуудын ижил нүсэр шавран төхөөрөмж гэлтэй. Эндхийн юм болгон эв хавгүй, этгээд санагдсан гэвэл хилс болно. Esteghlal нэртэй зочид буудалд гадаадын зочид тухлах нь элбэг. Үйлчилгээгээ барууны стандартад дөхүүлэх гэж бас л чармайжээ. Европын авиакомпаниудын экипажийнхан Esteghlal-д хоноглодог бололтой. Усыг нь уувал ёсыг нь дага гэсэн шиг стюардесс хүүхнүүд ижилхэн хар алчуур зангидсан харагдлаа.

Өнөөгийн Иран улс Америкийн дайснуудын жагсаалтын эхний гуравт багтаж нүд үзүүрлэгджээ. Түүхийн нэгэн цагт тэд Америкийн хувьд ашигтай түнш явсан. Тэгвэл одоо Ж.Бушийн тодорхойлсон мөнөөх хорон санаатны тэнхлэгийн нэг үзүүрт тус улсын нэр усыг зүүж, олон улсын тавцнаа шахаж, ганцаардуулахыг их гүрэн чармайсаар байна. Цөмийн хөтөлбөрөөсөө татгалзахыг АНУ Иранаас шаардаж буй юм. Тус улсын асуудлыг НҮБ-д оруулан хэлэлцүүлэхийг шахаж байгаа тухай мэдээллийн хэрэгслүүд шуугисаар. Газрын тос, байгалийн хий, жимс ногоо, хивсний экспортоороо Иран мөнгө олж, 70 сая хүн ам нь Зөвлөлт маягийн гэмээр хэмнэлээр амьдарч байна. Орос, Чехийн хуучин загварын машин тэрэг гудамжинд нь тун олон харагдана. БНСУ-д үйлдвэрлэсэн хөнгөн тэрэг цөөнгүй, эндхийн хамгийн ганган унаанд Пежо тооцогддог бололтой.

Тегеран том хот. Гэхдээ энд ганцхан өнгө зонхилох нь залхуутай. Шавраар босгосон нүсэр байгууламжууд оньсого шиг ойлгомжгүй. Зузаан хананы цаадах араб амьдрал, перс соёлын нарийн нандин руу аяллынхаа богинохон хугацаанд өнгийж чадаагүй. Харин элдэв төрлийн жимсний дэндүү сайхан амтанд түргэн орж, байн байн халаас талтай хийн жимсний дэндүү сайхан хэмхний тийм үнэр, шимийг өмнө нь лав амтлаагүй санагдана. Эдний тоор гэж хэлэн дээр хайлав уу гэлтэй алга болчихно. Хатаасан жимс, самар, хушга тэргүүтэн савласан том том сагснууд сүртэй, атгаад авмаар харагдахыг яана.

Нэлмэгэр  
алчуур нөмөрсөн  
ээжийнхээ дэргэд  
ёс төдийхөн үс  
гээгээ халхалсан,  
жижигхэн  
алчууртай шинэ  
цагийн охин  
алхана. Уран гоё  
биенийг нь өнөөх  
өмсгөл далдалж  
яаж чадах вэ. Уг  
нь нүгэлт харцнаас  
хол байлгах гэж  
хүүхнүүддээ  
нэлмэгэр хувцас  
сэлт өмсүүлдэг  
байлгүй.



Юм юмнаас нь амталж үзмээр санагдаад байх чинь, нар хамба, нандин чавга авдрандаа хадгалдаг эмээгийн охины муу зан юм болов уу. Иранд ирсэн жуулчид перс хивс, эртний эдлэл голдуу сонирхдог. Манай эриний V зуунаас эхтэй хивсэн урлалаараа гайхуулдаг улс.

Алдарт перс хивсний музейг гаднаас нь харахад жаахан тиймхэн санагдаж магадгүй юм. Нөгөө л айхтар том шавар байгууламж дээрээс дүнсийжээ. Музейн тайлбарлагч эмэгтэй үзмэрт гар хүрэхгүй байхыг үзэгчдээс хүсээд, эрт галавын түүх ханхалсан яриандаа орсон юм. 400 жилийн тэртээ нэхсэн эдийг энд хадгалсан болохоор гар хүрэхийг хориглох нь аргагүй. Ираны муж болгон өөрийн онцлог бүхий хээ угалзат хивс урладаг. 150х200 см хэмжээтэй хивсийг бүтэн жилийн турш нэхдэг гээд бодохоор энэ нь гар урлалын давтагдашгүй бүтээл, өнгө, чанарын өндөр шалгуурыг давжээ. Хивсний машин хэмээх модон хүрээ бүхий утсан сүлжээ нь том гэгч ятга хөгжмийг санагдуулна. Сантиметр тутамд өнгө, дүрслэл солигдох нарийн чимхлүүр хөдөлмөр тул тусгай хүн зургийн дагуу ингэ тэг хэмээн нэхмэлчдэд зааварлан хэлж өгдөг гэнэ. Ганц эгнээ утас явуулаад л элдэв багажаар бөхөлж чангалан товшино. Сурвалжлагч бидэн шиг гэвчээргүй улсууд сууж хийх ажил лав биш ээ. Ийм тайлбар сонсох зуураа л ядарч, хивсчдийг өрөвдөх шахав.

Хээ хуарынх нь учир утга гэж гүн гүнзгий. Ираны бэтмэн юм уу гэмээр баатар эрс хатдаа дагуулаад явж байна. «Монголын нэг өдөр»-ийн өгүүлэмж лугаа түмэн дүрслэлтэй аварга хивсийг хаана өлгөдөг байсан юм бол доо. Өөлбөл музейн өрөө тасалгаа гэрэл гэгээ тааруу, хорго, тайлбар сэлт нь болхидуухан. Энэ л хивсээрээ голдуу Европын улсуудтай наймаа хийдэг аж. Тус улсын худалдааны түншүүдийн тэргүүнд Япон, Герман, Франц, Итали, Их Британи, Бельги зэрэг орон жагсчээ.

## БУРХНЫ НЭРИЙН ӨМНӨӨС

Ийм бичигтэй хаа сайгүй тааралдах вий. Хүн амын 89 хувь нь шийтүүд. Их эзэн, өвөг дээдэстэй итгэх сүсэг бишрэл онцгой хүчтэй юм. Хүүхнүүд! Хатуу дэг жаяг дор амьдардаг хэдий ч тэд ертөнцийн гэгээн сайхны илэрхийлэл-бүсгүй хүн. Хотын төв хэсэгт хүрэх үе мөнөөх битүү бараан өмсгөлүүд хүртэл шинэ цагийн моодонд «идэгдэж» буйг анзаарлаа. Дуу алдам тод ногоон, нүд гялбам улаан шаргал өмд, хүрэм өмсч түүндээ өнгө нийцүүлэн нимгэн алчуур, цэмцгэр өсгийт углааш, бяцхан цүнх сонгосон охид олон. Нэлмэгэр алчуур нөмөрсөн ээжийнхээ дэргэд ёс төдийхөн үс гээгээ халхалсан, жижигхэн алчууртай шинэ цагийн охин алхана. Уран гоё биесийг нь өнөөх өмсгөл далдалж яаж чадах вэ. Уг нь нүгэлт харцгнаас хол байлгах гэж хүүхнүүддээ нэлмэгэр хувцас сэлт өмсүүлдэг байлгүй.

Тегеранд өнгөрүүлсэн эхний өглөө алчуургүй гараад ирсэн юм. Гадаадынхан голдуу буудаг том зочид буудал дотор ингээд явахад гайгүй биз гэж санасан минь алдаа байж. Буудлын ажилтан нутгийн эр хилэнтэй харцаар ширвээд ямар нэг зүйл хэлэхэд нь «түргэн авч» үс гээгээ битүүлэв. Ёс заншил, шашны дэг жаяг гэдэг харь нутгийнханд ойлгомжгүй, хөгийн мэт санагдаж мэднэ. Гэсэн ч шүтлэг заншилдаа ингэтэл үнэнч байгааг хүндлэхээс өөр үгүй. Өөр нэг жишээ сонс л доо. Нисэх буудалд нэвтрэх хоёр хаалга бий. Нэгээр нь хүүхнүүд, нөгөөгөөр нь эрчүүд ордог. Цаана нь гараад арван алхмын дараа жендерийн ялгавар үгүй болж, эрэгтэй, эмэгтэй хоёр хамт алхаж болно. Тэгж байгаад ачаагаа хянуулж онгоцонд суухын даваан дээр дахиад л тус тусын хаалгаар нэвтрэх шаардлагатай. Бүсгүйчүүдийн мэдлийн хаалганы орчим эгнүүлсэн сандал дээр эрэгтэй хүн сууж орхивол хар нөмрөгтэй хүүхнүүд муухай харж, амандаа ямар нэг зүйл ууртай хэлэн босоод ирж ч магад. Мэдээтэй

л явмаар юм билээ. Иран эрчүүд афганчууд шиг бавайсан сахал тавихгүй. 40 градусын халуунд үс, хүзүү хоолойгоо баглаж явахдаа эндхийн жендерийн «шударга бус» байдалд цухалдах шахав. Эрчүүд өөрсдөө наранд ээсэн шигээ агаар салхин дор эрх чөлөөтэй алхах юм гээч.

Гадаадынханд сануулдаг өөр нэг зүйл бол тус улсын Афган, Ирак, Пакистантай хиллэдэг нутаг орчмоор аялахгүй байх. Үнэхээр Иран дэлхийн халуун цэгүүдийн яг төвд, хил залган оршдог. Ирактай 1458 км газраар хиллэдэг аж. Өмнөд этгээддээ Газын зурваст ойр, хойд хэсгээрээ ч ялгаагүй, дундад Азийн нөхцөл байдал тайвангүй улсуудтай хаяа нийлэн амьдрах юм. Хөрш Ирактайгаа байлдсан урт дайны гэрч болох эвдэрч хэмхэрсэн барилга, буурин дээр нь босгож буй бүтээн байгуулалт харагдана. АНУ-ын ЭСЯ байрлаж асан сууц Тегераны төвд бий. Оюутнууд энэ барилгыг хэрхэн бүсэлж эсэргүүцэл илэрхийлсэн тухай нутгийн залуу ярив. Нийслэл хотоо ногооруулах гэж үнэхээр чармайж яваа улс бололтой. Эко парк нэртэй асар том ногоон дүүрэг байгуулж байна. Гэм нь жаахан бүдүүн хадуун зохион байгуулалттай л юм даа. Европын нарийн нандин мэдрэмж, Америкийн чөлөөт, зовлонгүй сэтгэлгээ энд илт үгүйлэгдэнэ. Аяатолла Хомейний хөргийг хаа сайгүй залж, лалын шашны хатуу дэг жаяг дээр Зөвлөлт маягийн амьдралын хэмнэл нэмж орхижээ. ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан төв Азийн хэдэн улсаар аялахад мөн л нэг иймэрхүү уур амьсгал ханхалж байсансан.

Үүх түүхээ сөхөн харвал бидний цус нэгтнүүд энэ гудамжаар яваа гэдэгт эргэлзэх зүйлгүй. XIII зууны сүүл, XIV зууны эхээр Төмөр хаан Иранд засаглаж байлаа. Төмөрийн дараа Отман Турк, Их Британи, бүр афганууд хүртэл Ираныг эзлэн түрэмгийлсэн байх юм. Давхраатай алаг нүд, өтгөн хөмсөг, монхор хамартай, биерхүү тэднээс өвөг дээдсийнхээ уг сурвалжийг одоо хайгаад яахав. Гагцхүү бусдын адил дэлхийд нээлттэй болж, битүү хатуу орчноо ялимгүй зөөллөөсэй гэж хүсмээр. Иргэдийнхээ интернэтийн хэрэглээнд хязгаар тавих зэрэг хориг саадыг Засгийн газар нь тавьсаар байх аж. Иран улс удахгүй ийм утга бүхий хууль батлахаар зэхэж байгаа гэж Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагын сайтад мэдээлжээ. Хууль бус, хориотой мэдээллийг интернэтээр цацсан, түүнчлэн хэрэглэгчдэд үзэх боломж олгосон хүмүүсийг тав хүртэл жил хорих ял шийтгэхээр уг хуулийн төсөлд тусгаад байна. Мэдээллийн эрх чөлөөг шаардаж Ираны сэтгүүлчид үе үе жагслаг. Энэ оны гуравдугаар сард, мөн саяхан наймдугаар сарын 7-нд сэтгүүлчид цуглаан зохион байгуулжээ.

Бидэн шиг хонь, хурганы мах хоолондоо түлхүү хэрэглэдэг газар ирсэн хэдий ч гэрээдээ яарах шалтаг мундах биш. Яарах тусам онгоцны буудал хүрэх зам сунаж, энд тэнд дугаарлаж зогсох хэрэг мандсаар. Дэлхийн авиа буудлуудын жишгээс ялимгүй өөр орчинд төөрч будилуузай хэмээн «Guide book» танд сануулж байна. Нислэгийн тань дугаар, цаг, нэвтрэх хаалга зэргийг мэдээлсэн самбар үзэгдэхгүй байх үе тохиолдоно. Асууж сураглаж, ялангуяа гадаадын зорчигчидтой өөр хоорондоо ярьж лавлаж явахгүй бол шинэхэн аялагчид гэнэдэх зүйл зөндөө. Ядаж явахад өнөөх алчуур минь гулгаж унаад ер тогтох биш. Над шиг алчууртайгаа ноцолдсон эмэгтэй ер харагдахгүй л юм.

# Сөөсгөр тэнэгхэнийг Америк амьдралд бэлдсэн үү

Жижиг ууттай нунтаг эд гаргаад нөгөө залуу арай л Америкийн Элчин сайдын яамны Консулын албаныхан өөд цагчихсангүй. АНУ-д нэвтрэх зөвшөөрөл буюу визийг «надад саадгүй өгөөрэй, өгөөрэй» хэмээн тарнидаж байгаа нь тэр юм болов уу даа. Тэр жижигхэн тасалгаанд монголчуудын өнгө өнгийн авир харагдана. Удалгүй мөнөөх залуу «Орой 5 цагт ирээрэй» гэсэн авралын үг сонсов. Баярлалаа, баярлалаа гэсээр гарч одоодоо, амьсгал даран салгалсаар тэр тасалгаанд хоцорч буй хүмүүст хандан «За амжилт хүсье» гэв. Түүний нүүр ялимгүй улайн бүр догдолчихож. Шившлэгтэй арц хүж нь тусаллаа гэж бодсон ч байж магад. Лав л ээлжээ хүлээгсэд түүнийг атаархлын харцаар үдэв.

17.00 цагт ирээрэй гэдэг нь виз олгох магадлалтайг илэрхийлнэ. Паспорт, бас бус баримт бичгийг чинь эргүүлж өгөлгүй, ингэж хэлэхээр «За аа, болоод явчихлаа» гэж монголчууд ойлгоно. Гүйх шахам гарахад нь Элчингийн үүдэнд дугаарласан зуу зуун хүн дахиад л атаархлын харц шидэх вий.

Энэ оны долдугаар сарын 22-ны даваа гаригийн үдээс өмнө виз хүсч ярилцлагад орогсдын дунд хөгшин, залуу, хүүхдээ дагуулсан янз янзын хүмүүс харагдав. Төв аймгаас ирсэн залуухан бүсгүй сандрангүй царайтай. Мэдүүлэг дээр байх учиртай зургаа нааж амжаагүй, яанаа, хайч байна уу гэнэ. Консулын албаны эмэгтэй чихэвчээ зүүгээд зузаан шилний цаанаас ярилцахад бэлэн болов. Хөдөөний бүсгүй харилцуур аваад мэндийг нь мэдэж байна.

**-Англиар ярьж чадах уу?**

-Үгүй, би орчуулагч авъя.

**-АНУ-ыг яагаад зорих болсон бэ?**

-Сурах гэж.

**-Англи хэл мэдэхгүй байж тэнд сурч болно гэж үү?**

-Би энд дамжаанд суусан юм аа.

**-Тэгсэн хэрнээ ярьж чадахгүй байх юм.**

Товчхон ярилцлагын өнгө аяс иймэрхүү. «Та АНУ-д суралцах хэлний бэлтгэлгүй юм байна» Бичиг баримтыг нь буцаагаад өглөө. Бүрэг бүсгүй олон тайлбар нэмж хэлсэнгүй, дуугүй л гараад явав.

Нас тогтсон өөр нэг эмэгтэй и-мэйлээр америк танилтайгаа удтал харилцсан, тэгээд найз нь урьсан юм аа хэмээн тайлбарлаж байна. Ээлжээ хүлээн суугаа хүмүүс «Итгэл үнэмшил төрүүлэх тайлбар биш л байна даа» гэх аясаар бодоцгоов. Хөөрхий эмэгтэйн хормой чичрээд байгааг бүгд анзаарч байлаа. Монголын радиод олон жил ажилласан гэв. Мэдээж энэ бас л виз олгох үндэслэл болохгүй нь. Консулын ажилтан эмэгтэй ярилцагчаа хормын төдий л харах шиг санагдана. Зузаан шилэн хаалт, бас нүдний шилнийхээ цаанаас туршлагатай харцаар монголчуудыг ажиглаж байна. Виз хүссэн мэдүүлэг, түүнийг дагалдах баримт бичиг, асуултуудад өгөх хариулт энэ бүхнийг цөөхөн минутад гярхай шинжиж амжина. Үд өнгөрч байлаа. И-мэйлээр харилцдаг танилынхаа тухай радиод ажилладаг эмэгтэй тайлбарласаар.

**-АНУ-д үлдэхгүй гэх баталгаа Танд алга байна.**

-Хаанаас даа, би чинь эндээ бүх насаараа амьдарсан, олон жил ажилласан газар маань байна. Арай ч дээ гээд хоолой нь чичрэв.

**-Уучлаарай. Виз олгох боломжгүй.**

Багцаалбал таван минутын хугацаанд энэ ярилцагчийн асуудал шийдэгдлээ. Түрүүний хөдөөний охин шиг тэр шууд чимээгүйхэн гараад явчихсангүй. Дахиад

харилцуурыг шүүрэв.

**-Миний бүрдүүлсэн бичиг баримтаас юу нь болохгүй байгааг тайлбарлаж өгнө үү?**

Консулын ажилтан эмэгтэй өмнө нь хэлснээ хөндийдүүхэн давтаж, орчуулагч нь тэвчээртэй намуухан дуугаар дамжуулж өглөө. Монголчуудын элдэв зан энэ цонхны өмнө өдөр бүр тод гарч, тэр болгоныг нь америк ажилтандаа «цэгцлэн» орчуулж өгөх ажил тун амаргүй харагдах аж.

Дараа нь англиар цэвэрхэн чөлөөтэй ярих багш эмэгтэгийн ээлж ирлээ. Дээд сургуульд англи хэл заадаг гэнэ. Явах болсон шалтгаан, АНУ-д байх хугацаанд түүнд санхүүгийн дэмжлэгийг аль байгууллагаас өгөх зэрэг асуултад цэгцтэй хариуллаа. Ярилцагчийн дуу хоолойны өнгө зэрэг бүх зүйл нийлээд олон жил визийн асуудал эрхэлсэн туршлагатай ажилтанд худал, үнэн өгүүлж буй эсэхийг өөрөө хэлээд өгдөг гэмээр.

...Хариугүй зөвшөөрөх нь ээ. Паспорт, баримт бичгийг авч үлдээд маргааш гэв үү, виз ээ авахаар ирэхийг нь хэлэв. Харин багш бүсгүй «Уучлаарай, өнөөдөр визээ авмаар байна. Би маргааш Бээжин нисэхээр тийзээ авчихсан юм» Ийм тулгалт америк эмэгтэйд үл таалагдав бололтой. Тэгвэл, уучлаарай гэсэн шиг материалыг нь буцааж түлхэв. Багш эмэгтэй ч «Болино л биз» гэсээр гарч одлоо.

АНУ-д суралцахаар явж буй залуугийн ээлж. Англиар торох юмгүй цэвэрхэн ярина. Түүний суралцах тухай бичиг баримт ч жин тан байсан биз. Таван минут хэртэй ярилцлаа.

-17.00 цагт ирээрэй.

-Баярлалаа. Энэ бичгүүдийг маань хил нэвтрэх үед дахин шалгах болов уу?

-АНУ-ын хил дээр дахин үзүүлэх шаардлагагүй.

-Ойлголоо. Баяртай гэв.

«Ач төрсөөн. Түүнийгээ очиж харах гээд» хэмээн 50 эргэм насны эр баяртай нь аргагүй хэлж байна. Орчуулагч бүсгүй дамжууллаа. Шинэхэн өвөөгийн бичиг сэлт мөн л эргэлзээ төрүүлэх зүйлгүй байсан биз. Нас тогтсон эр тэр хол хүний нутагт үлдэж орхих нь юу л бол. Тэгэхээр энэ хүнд виз олгоход татгалзаад байх зүйл алга.

-Та орой ирнэ үү

-Баярлалаа. Баяртай.

Их үд хэдийнэ хэвийсэн ч энэ өдөр ярилцлагад орохоор дугаар авагсад арай л дуусаагүй байна. «Дугаар авах» хэмээх тун хэцүү, тамын дараалал наадмын дараа Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ-ны үүдэнд бий болжээ. Наадмын өмнө ийм аймаар байгаагүй гэнэ. Харин шинэ, хуучин оюутнууд, үр ач нар дээрээ очих гэсэн өвөө, эмээ нар, бүлэг хэсгээрээ аялах арван жилийнхний урт дараалал долдугаар сарын төөнүүр нартай хамт гэв гэнэт л унжран сунжирчихсан билээ.

Долдугаар сарын 22-ны даваа гаригийн өглөө ярилцлагад орох зөвшөөрлөө би долоо хоногийн өмнө буюу 16-ны мягмар гаригт авсан. Харин ч нэг их зовлонгүйгээр «номер» гэх жижигхэн марк шиг цаасыг паспорт дээрээ наалгасан шүү. Тэр өглөө 7.00 цагаас эхлэн дугаарлаж зогсоод 11.00 цагийн үед «номертой» болсон тул азтай нэгэнд тооцогдох аж. Наадмаас хойш гурван өдөр зогсоод ярилцлагад орох дугаар авч чадаагүй хэмээн зарим нь энд ундууцаж байлаа. Машин унаатайгаа хонож өнжих шахам Элчингийн үүд сахих хүмүүс өглөө нь ирмэгцээ танилынхаа ард шууд ороод зогсчих залуусыг бараг л тасдаад хаяхна уу гэмээр харааж загнан уурсана. ЭСЯ-ны хамгаалалтын албаныхны байрнаас хэдхэн алхмын наана Монголын цагдаа нар 200 гаруй хүнтэй дарааллыг зохицуулан хэл аманд бариулах шахан, түлхэлцэж үзэлцэж байна. Цаахна нь зогсоод тэр бүх бухимдлыг тайван гэгч ажиглах Элчингийн

хамгаалалтынхан буюу «өндөр цалинтай монголчуудын» төрх нэлээд ихэмсэг.

Долдугаар сарын аравдын үед 200 хүрч байсан уг дараалал хорьдын эцэс гэхэд 400 хүнтэй болж нэмэгджээ. Аргаа бараад элчингийнхэн ирэх есдүгээр сарын «номероо» халуун зунаар түгээж эхлэв. Виз хүссэн ярилцлагад есдүгээр сарын сүүлээр орох дугаар наймдугаар сарын 10 гэхэд дууссан байлаа. Үүнээс долоо хоногийн хойно аравдугаар сард явах хүмүүсийн ярилцлаганы эрхийг өгч эхлэв.

Америкийн хилийг нэвтрэхийн өмнө ийнхүү ЭСЯ-ных нь өндөр хашлаганы цаана хүрэх өөр нэг «виз» хэрэгтэй болох нь тэр.

Ес, аравдугаар сард ажил албаар яаралтай АНУ-ыг зорих учиртай, «номер»-ны тухай мэдлэггүй яваа иргэд яах бол гэсэн асуулт ч гараад ирлээ. Радио, телевизээр өнөөдөр шинэ маягийн зар яваад байгаа нь мөнөөх ярилцлагад орох дугаар авах, зарах тухай, яаралтай тодотголтой зарлалууд. Нэг «номерт» 20 мянган төгрөгийн ханш хэдийнэ тогтжээ. Эрэлтээ дагаад өнгө өнгийн бизнес тэр дороо гараад ирэх аж.

### МОНГОЛ ЗАН 65 АМ,ДОЛЛАРЫН ҮНЭТЭЙ

Америк гэдэг аялахад аюултай газрын нэг болсон цаг. Хоёр өндрийн нуранги гэгээн мөрөөдлийн гунигтай төгсгөлийг санагдуулсан үе. Гэвч монголчууд 2002 оны есдүгээр сарын 11-нд ч болтугай бөмбөрцгийн баруун хагасыг зүглэхсэн хэмээн улайрсаар. Телевизийн дэлгэцнээс Нью-Йоркийн тэнгэр баганадсан өндөрлөгүүдийн зөвхөн оройг нь бид хардаг. Тээр өндрөөс юутай бахдам, яваад очих хүслийг төрүүлдэг гээч. Эсвэл зул сарын гоёл чимэгтэй, дуу алдмаар гудамжууд нь сэтгэлд байнга хадаатай. Харин чи дэлгэцнээс үзсэн мөнөөх Америктаа очоод мөнгөлөг барилгуудын үүд довжоо хавиар алхахын цагт тэртээд тэнгэр баганадан хөвөх гэгээн мөрөөдлөө өөр өнгөөр харна.

Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ-ны хаалгаар нэвтрэх даваа нэг хэрэг. Хүссэн газартаа өөрийн хүн болохын тулд олон бэрхшээлийг давах хэрэгтэй болно. Монголд чамд хэлж өгсөн шиг «Авхаалж самбаатай байхад л барав» хэмээх бүдүүн бараг зөвлөгөө юу ч биш, муу залинаас илүү тэнд чамд чадалтай тархи толгой хэрэгтэйг мэдэрч эхэлнэ. Арван жилийн ахлах ангид суралцдаг болов уу гэмээр хүүхдээ дагуулсан эцэг эхчүүд ЭСЯ-ны үүдэнд тун олон байх аж. Хүүхдээ Америк л явууллаа бол эрхэм үүргээ биелүүллээ гэх шиг гангийн халуун наран дор аав, ээж нар аахилан зүтгэсээр. Харин тэр нэвсгэр цамц, хип хоп өмд, малгайтай сөөсгөр тэнэгхэнийг америк амьдралд хэр бэлдсэн юм бол?

Тус ЭСЯ-ны Консулын алба долоо хоногийн дөрвөн өдөр виз олгоод ч монголчуудын их урсгалыг дийлэхгүй байна. Өмнө нь зөвхөн даваа, лхагва, баасан гаригт ийм үйлчилгээ үзүүлдэг байлаа.

Англиар насаа хэлэх төдий сөөсгөр хүү миний өмнөхөн зогсоод ярилцлаа. Визийн мэдүүлэгтээ мэдээж «Сурахаар» гэж тэмдэглэсэн. Хэлний иймэрхүү бэлтгэлтэй бол зөвхөн Монголдоо үлдэхээс өөр замгүй гэж түүнд ойлгуулав бололтой. Толгойгоо илээд мань хүү нэг их гуньсан шинжгүй холдов. Аав, ээжийн хэтэвчнээс 65 ам.доллар энэ удаа гарчээ. Аль нэгнийх нь сарын цалин байж ч мэднэ. Гоо засалч, үсчдийн тэмцээнд оролцоно гэж ярьсан эмэгтэй харилцуур авав.

**-Англиар ойлгох уу?**

-Ойлгоно оо.

**-Таны АНУ-д байх хугацааны зардлыг хэн гаргах вэ?**

-Би орчуулагч авъя.

**-Та англиар ойлгодог гэсэн шүү дээ.**

Байдал бишдэж баримт бичгийг нь буцааж харагдав. Хэрэв тэр эмэгтэй чимээгүй гараад л явчихсан бол араас нь дахиж дуудахгүй нь лав.

-Би орчуулагч авъя. Англиар ойлгодог. Харин ийм асуултад хариулах хэмжээнд ярьж чадахгүй болохоор... (Одоо тэд орчуулагчтай ярилцаж байна)

**-Америкт очоод тэмцээнд оролцохын тулд яаж хэл нэвтрэлцэх хэрэг вэ?**

-Хамт явах эмэгтэйн маань виз гарчихсан юм аа. Тэр англиар ярьдаг. Надад тусална.

**-Түүний виз хэзээ гарсан бэ? Овог, нэрийг нь хэлнэ үү.**

Ингээд консулын ажилтан хамт явна гэсэн хүнийг нь овог, нэрээр нь шүүж эхлэв. Ашгүй олов бололтой. Эмэгтэй нааштай хариу сонсоод гарлаа.

«Би гурван хүүхэдтэй. Өрх толгойлсон хүн» гэсээр өөр нэг бүсгүй хоолой чичрүүлж байна. Энэ бол мөнөөх долдугаар сарын 22-ны үдээс өмнө визний ярилцлагад ороод «17 цагт ирэх» сайн үг дуулсан цөөн хүний нэг. Орой болжээ. Дахиад л нөгөө өрөөндөө «азтай» хэд цуглав. Хэдийнэ танил болсон царай зүс, юм л бол номхон зогсч «оочерлох» түгшүүр давтагдлаа. Энд хэн нь ч хэнийгээ айлгаагүй атал юм юм аяндаа аймаар болоод биеэ барьж орхих нь утгагүй. Сандарч тэвдсэн монголчуудын айдас нэг нэгэндээ дороо л халдварлах юм. Гар утсаа унтрааж үүдэнд үлдээгээд, цүнхээ камераар хянуулж, өөрөө шалгуулсны эцэст өглөө ярилцлага өгсөн өрөөндөө дахин ирцгээв.

**-Та хуурамч баримт бичиг бүрдүүлсэн тул АНУ-ын ЭСЯ виз олгох боломжгүй.**

-Яагаад хуурамч гэж? Би өрх толгойлсон ядарсан эмэгтэй. Би тийм юм хийж үзээгүй. Тэр газар нь дахиж очно. Надад хуурамч бичиг өгөх ёсгүй.

Ингэж хэлээд нөгөө эмэгтэй нус нулимс болов. Өөр нэг залууд мөн л банкнаас авсан бичиг нь хуурамч болохыг тайлбарлаад виз өгөхөөс татгалзлаа.

Консулын албаныхны нэг өдрийн ажил өндөрлөж байна. Өглөөний 9.00 цагаас тэд иймэрхүү өнгө аястай үргэлжлэх ярилцлагаа эхэлж 14.00 цаг хүргэсэн. Үдийн хоолоо жижүүртээ захиж авчруулж харгадсан. Гэвч тайван хооллох боломж гараагүй нь ойлгомжтой. Учир нь 17.00 цаг гэхэд мөнөөх эхний шаардлага хангасан хүмүүсийн бүрдүүлсэн баримт бичиг үнэн зөв эсэх гээд магадлах зүйл олон бололтой. Консулын ажилтан америк эмэгтэйн дэргэд хоёр монгол бүсгүй өдөр тутам ажиллана. Арай эгчмэд нь орчуулга хийн, виз хүсэгчдийн шаардлага, хүсэлт, тайлбар болгоныг цэгцэлж дамжуулна. Тэвчээртэй, тайван байхыг оролдох аж. Арай залуу бүсгүй нь ярилцлагад орогсдоос 65 ам.доллар болон бичиг баримтыг нь хүлээн авна. Тэвчээр барсан янзтай хяламхийн, царай нь үе үе хувьсхийх аж.

Бидний араншин тэр жижигхэн өрөөнд ээлжилсээр. 2000 оны намрыг эргэн саналаа. УИХ-ын сонгуулийн дараахь тэр намар ялагдсан намынхан гадагшаа явах суух нь нэмэгдсэн билээ. АНУ-д хуралд оролцохоор олны танил улстөрчид зэхжээ. Тэгэхэд нэг намын хоёр зүтгэлтэн визний ярилцлагын үеэр гэргий, нөхөр хэмээн өөрсдийгөө танилцуулан эвлэгхэн жүжиглэж байсан нь санагдав. Америк явах моод жил ирэх тусам залуужиж байна. Сөөстөр жаалуудын аав, ээж нь Америкийг киногоор төсөөлдөг. Тэгээд тэд өөрсдийнхөө мөрөөдлийг биелүүлэхээр чамаас асуулгүй зүтгэцгээнэ. 65 долларыг хэд хэдэн ч удаа хэтэвчнээсээ гаргаж өгч охин, хүүдээ тусалж чадна. Харин тэр мөнгийг яаж олдгийг хэлж өгөхөө мартчихсан болохыг нь мөрөөдлийн Америкт очоод чи нэгэн цагт ойлгоно.



# «Бөхөг» ихэр дэгдээхэйгээ мэддэг үү

Японыг мэдэрье гэвэл Токиогоос заавал гараарай. Наран улсын нийслэлээс Нью-Йоркийн шуугиан, Бродвейн гэрлэн урсгал, Швейцарийн өндөр өртөг, Бээжингийн нүргээнийг давтан харж болно. Харин давтагдашгүй япон ахуй, байгаль, уламжлал, сэтгэлийн хөг Токиогоос олон километрийн цаадтайх уулсын дунд, тунгалаг урсгалт голын дэргэд бий. Хэдэн километр замыг хэрэн туулснаа үл мэднэ. Хойд нутагт нь цасаар шуурч, өмнөд этгээдэд харин цоохор эрвээхэй хөгжин нисэх өвөрмөц байгаль Японд заяажээ. Токио, Киото, Осака, Нагоя хотуудыг дамнан хурдан галт тэрэг, автобусаар арав гаруй хоног аяллаа. Хойноос өмнө зүгт сунайн тэгнэсэн арлын орны байгалийн хачин сониныг цагт 200 км даван хурдлах шинкансэний цонхоор гүйцэд харж яахин амжих билээ. Номхон далайн мандал нэгэнтээ хальт харагдана. «Далай, далай...» хэмээн эх газрын бид хэдэнтээ хашгираад барааг нь алдав.

Японы жижиг, дунд үйлдвэрүүдтэй танилцаж яваа Монголын бяцхан баг шинкансэнд тухалсан нь энэ. Товчхондоо бол эд захирлууд. Цуврал сурвалжлагын явцад тэдэнтэй жич танилцана биз ээ. Яриа хөөрөө, хүсэл тэмүүллийг нь ойлгоё гэвэл Монгол орны хөгжилд хүч оюунаа зориулж буй залуус. Бизнесийнхний дунд байж, тэдний бэрхшээл, баярыг сонсч, мөн Японы ажил хэрэгч хүмүүстэй ярилцах зуур аравхан хоног хэрхэн урсч одсоныг үл анзаарав. Зул сарын баяраар амьсгалсан их хотууд ард хоцорсоор. Үдлэх газар, уулзах хүмүүсийн жагсаалт талдаа ч ороогүй... Үзэг дэвтрээ бариад аялсаар явна.

Эртний галт уулсын хөндийд хүрлээ. Хоржигнон жирэлзэх бяцхан голын ус тагнай хага ташим. Лонхонд савласан цэвэр уснаас ч амттай юм. Уулын голоос аравхан алхмын цаахнаас нэг л дотно үнэр ханхийв. Зууханд гал өрджээ. Элдэв илүүц чимэггүй сайхан модон байшинд биднийг урилаа. Чанасан өндгөнд давс үрээд, бас шинэхэн жимс, амтат боовноос нь идлээ. Аж ахуйгаасаа авсан бүтээгдэхүүнээр эзэгтэй дайлж буй болохоор идэж ууснаа ингэж тодорхой бичлээ. Эд бол жилд 400-500 сая иений ашигтай ажилладаг фермийн эзэн, эзэгтэй хоёр. Тун энгийн харагдах ийм хүмүүсийн алтан гарт орчин цагийн Японы гайхамшигт хөгжлийн түлхүүр бий. Үндэстэн дамнасан аварга корпорациудынхаа нэрийн хуудсаар Наран улс дэлхийд алдарших боловч нийт үйлдвэрлэлийнх нь 87 хувь яг ийм жижиг, дунд бизнес дээр тогтдог. «Курофужу» фермийн эзэд уйгагүй хөдөлмөрлөнө. Бизнесээ дурлаж, баялаг бүтээн, дараагийн алхмуудаа энэ авсаархан байшинд төлөвлөж сууна. Мукояма сан зочлод зориулан ийм модон сууц барьжээ.

Эндээс холгүй, ердөө хэдхэн алхмын цаана «Курофужу» фермийн оффис болон Мукояма сангийн гэр, цаашлаад тахианы байр, гэжээл бэлтгэх цех, өндөг ялгаж савлах дамжлагууд үргэлжилдэг. Дээрээс өнгийх лугаа эргэн тойронд хүглийх их уулсын дунд бяцхан аж ахуй төвхнөжээ. Биднийг «Курофужу» фермд хүрэхээ өмнөхөн буюу бага үдийн алдад Токиогийн дэлгүүрүүдэд шинэхэн өндгөө хүргэчихээд ирж. Урт түрийтэй резинэн гутал, ажлын өмд цамц өмсөн Мукояма санг анхааралтай ажиг. Зүгээр л хөдөө нутгийн нэгэн бизнесмэн үү, эсвэл уулсын хөндийд цоо шинэ технолог туршиж яваа эр үү? Чанасан өндөг ийм амттай байдгийг гайхан дахин нэгийг тавагнаас авах зуураа түүнээс ингэж асуув.

Уулын  
голоос аравхан  
алхмын  
цаахнаас нэг л  
дотно үнэр  
ханхийв.  
Зууханд гал  
өрджээ.

Сүлжмэл  
сагсанд боргоцой  
дүүргээд тавьсан  
нь үнэт болоод  
болор эдлэлээс  
илүү тохь тух  
түгээх ч шиг.  
Гэхдээ энэ  
энгийн гэмээр  
орчинд бактер  
үржүүлж, шинэ  
технолог  
туршиж байна.

**-Мукояма сан, шувууны томуу өвчин хаа сайгүй дэгдээд байна. Японд ч эхний тохиолдлууд гарсан. Таны бизнест аюул учрах вий гэж боддог уу?**

-Үгүй шүү. Ханиад шуухнаа амархан тусчихдаг хүн байдаг. Тэр болгонд өвдөөд явдаггүй хүн ч бий. Яг л үүнтэй адилхан манай тахианууд өндөр дархлаатай, элдэв өвчнөөс маш сайн хамгаалагдсан. Шувууны ханиаднаас аж ахуйгаа хамгаалах гэж их зүйл хийж байна. Тиймээс уг өвчин миний бизнест одоогоор нөлөөлсөн юм алга аа. Ер нь япончууд нэг хэсэг америкчуудыг дуурайгаад их хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх моодыг дагасан. Ийм хандлагын үр дагаварт үхрийн галзуу, шувууны ханиад мэтийн өвчин гарлаа. Тэгэхээр хүнсний үйлдвэрлэлд улс орны зөв бодлого нэн чухал юм. Одоо манай салбарт эсвэл аль болох хямд үнэтэй, их хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үгүй бол нэмүү өртөг бүхий чанартайг хийх гэсэн хоёр хандлага тогтоод байна. Би бол хоёр дахь чиглэлийг нь баримталж яваа хүн гэв.

Энэ ярианаас «Курофужи»-гийн тахианы өндөг онцгой амттай байсны учрыг ухаж болно. Бас ганц ширхэг өндгийг 100 иен буюу мянган төгрөгөөр борлуулдгийн нууцыг мэдэх вий.

**-100 иен гэсэн бусдаас өндөр үнийг яагаад тогтоосон юм бэ?**

-Тийм ээ, би ийм үнээр өндгөө борлуулдаг. Бүс нутагтаа ганцаараа 100 иенээр бүтээгдэхүүнээ зарж байна...

Мукояма сан бидэнд бизнесийнхээ ноу хауг илэн далангүй ярьж өгсөн юм. Японы жижиг, дунд үйлдвэрийн олон төлөөлөгчтэй уулзах завсар зарим нь технологийн нарийн ширийн зүйлсийг нууцалж, нөгөө нь харамгүй ярьж тайлбарласан билээ. «Курофужи»-гийн эзэн сониуч асуултуудад зөөлөн, тайван дуугаар дэлгэрэнгүй хариулсаар байлаа. Цонхоор ганган намрын өнгө өнгийн гоёл үзэгдэж, халуу дүүгсэн модон байшинд илэн далангүй яриа өрнөсөөр. Сүлжмэл сагсанд боргоцой дүүргээд тавьсан нь үнэт болоод болор эдлэлээс илүү тохь тух түгээх ч шиг. Гэхдээ энэ энгийн гэмээр орчинд бактер үржүүлж, шинэ технолог туршиж байна.

\* \* \*

Бактер, вирус гэх үгсээс бүгд цэрвэдэг биз. Харин фермийн эзэн бактертай усаар гараа угаахыг санал болгов. Таван тоннын багтаамжтай том торх дүүрэн бактер үржүүлж байна. За яадаг юм, айдсыг ардаа орхиод торхонд гар дүрлээ. Гар чинь одоо гайхалтай цэвэрхэн боллоо шүү гэж байна. «Ээ тэгвэл энд бүх биеэ угаачих уу?» «Өгөөж» компанийн гүйцэтгэх захирал Д.Энхбаяр ингэж наргилаа. Үнэхээр гар минь зөөлхөн, урьдынхаасаа өөр болсон ч юм шиг. Эднийд бактер үржүүлдэг арван том торх бий. Өөрөөр хэлбэл, бактериар бордоо исгэж, түүгээрээ эрдэнэ шиш борддог, чанарлаг эрдэнэ шишээр тахиагаа тэжээдэг гэсэн үг. Тахианы зоогийг бэлтгэх гэж «Курофужи» фермд нүсэр судалгаа, туршилт хийж байна. Игсэсэн тэжээл амтархан зооглосон тахиануудаас түрүүн бидний «амаа олохгүй» идсэн онцгой өндгийг авдаг аж. Химийн гаралтай элдэв бордооноос татгалзах ийм технологийг BMW гэх агаад дэлхийн олон оронд эдүгээ моодонд ороод эхэлжээ. Байгалийн гаралтай, органик хүнсний хэрэгцээг дагаад мөнөөх 100 иений өндөгний эрэлт үл тасрах аж. Товчоор илэрхийлбэл «Курофужи» нэмүү өртөгтэй өндөг үйлдвэрлэдэг. BMW технологид түшиглэн Мукояма сан мөн жимс, цэцгийн аж ахуй эрхэлдэг. 20 жилийн өмнө худалдаж авсан энэ газартаа бактер судлалд жинтэй хувь нэмэр оруулахуйц туршилтууд хийж суудаг гэвэл даваадуулсан яриа болохгүй биз. Эрхэлж буй бизнесийнхээ амтанд орсон, өрсөлдөөн дунд бусдаас ялгарах гарц хайн, бүр «донтсон» гэмээр ийм хүмүүсийн амьдрал, яриа хөөрөө үнэхээр сонин.





Фотог Л.Болор





«Японы хөдөө аж ахуй хөгжлийнхөө тодорхой түвшинд нэгэнт хүрсэн учир экологийн аюулгүй байдал гэх мэт өөр үнэт зүйлсийг бизнес эрхлэгчид хайж байна» хэмээн тэрбээр ярилаа. Тахианыхаа тэжээлд тараг хольж үзжээ. Иогурттай эрдэнэ шишээр бойжуулсан өндгийг хулганад өгч туршиж байна. Хорт хавдрын үед хэрхэн үйлчлэхийг судалж буй юм байх. Тарагнаас гадна бордоондоо далайн ургамал, сармис, цайны ханд хольж туршдаг. Ийнхүү баяжуулж, исгэсэн бордоогоор сайн чанарын эрдэнэ шиш бэлтгэх аж. Шингэц сайтай зоогонд дассан эдний тахианууд «юу чаддагийг» үзэх мөч ирлээ.

\*\*\*

Өнөөх нандин өндгийг угааж, хатаагаад, жинлэнэ. Том, жижгээр ялгаж, хайрцаглаад ер тун ч их бөөцийлөх аж. 1000 төгрөгийн үнэтэй юм болохоор тэр байлгүй, ялгаж хайрцаглах ажлыг гараар хийж нямбайлах аж. Хуруундаа зөөлөвч угласан шалмаг хүүхнүүд өндгийг сурамгай шүүрэн, нааш цааш зөөн сортлох юм. Энүүхэнд байрлуулсан үүрэнд онцгой том өндгүүд тавьжээ. Ихэр дэгдээхэйтэй юм гэнэ шүү. 60.000 өндөг дотор нэг ихэр тохиолддог аж. Ердөө 30 орчим ажилчинтай авсаархан аж ахуйн ерөнхий дүр төрх нэг иймэрхүү. Японы жижиг, дунд бизнесийнхэн томрох дургүй гэсэн албаны хүний яриа санаанд буув. Тэд тогтсон зах зээлдээ үнэнч байж, хэрэглэгчдэд таалагдах өөрийн гэсэн үнэт зүйлсийг бий болгон, тэрхүү давтагдашгүй чанараа хадгалж хамгаалахын тулд уйгагүй хөдөлмөрлөж байна.

**Энүүхэнд  
байрлуулсан  
үүрэнд онцгой том  
өндгүүд тавьжээ.**

**Ихэр  
дэгдээхэйтэй юм  
гэнэ шүү. 60.000  
өндөг дотор нэг  
ихэр тохиолддог  
аж.**

«Курофужи»-гийн ямбатай сүрэг уулсын цэнгэг агаар дунд бараг л чөлөөтэй «бэлчдэг». Цэлгэр хашаа дүүрэн хүрэн бор өнгийн тахиа харагдана. Эзэн нь тэдэнд өгөх тэжээлээ өөрөө эхэлж амсах нь холгүй. «Шувууны тухайд ч, хүнд ч ялгаагүй өндөр газар биологийн хувьд тайвшруулдаг, сайн нөлөөтэй юм шүү. Өндөрлөг нутгийн хүмүүс амгалан, даруухан байдгийг анзаараа байлгүй дээ» хэмээн Мукояма сан ярьсан юм. Хөлөө олж зүгширсэн бизнесийг сурвалжлахад мэдээж урамтай.

Харин энэ бүхэнд 20 жилийн уйгагүй хөдөлмөр хөлс шингэснийг тооцвол бүр амттай санагдах вий. Японы жижиг, дунд бизнесийнхэнд тохиолддог бэрхшээлүүдээс хамгийн хэцүү нь газрын асуудал юм. Үйлдвэрлэл эрхлэхэд тохиромжтой газар гэдэг энд асар үнэтэй. Тэгвэл Монголын жижиг, дунд бизнесийнхэнд толгой дараалан тохиолддог зовлон нь хөрөнгө оруулалт. Бага бизнесийг дэмжих төрийн бодлого үгүй болохоор улаан гараараа мөнгө босгож, түүнээс эргэлтийн хөрөнгө олох бэрхшээл манай бизнесийнхэнд байнга тулгардаг. Хэрэв ийм зовлонгүйсэн бол, төрөөс жижиг бизнесийг бодлогоор дэмждэгсэн бол жишээ нь «Бөхөг» компани «Курофужи»-гийнх шиг орчин үеийн техник төхөөрөмж оруулаад ирж чадна. Хэрэв зээлийн дэмжлэг байдагсан бол үйлдвэрлэл эрхэлнэ гэдэг «үйлийн лай» бус, эндхийн бизнесмэнүүдийнх шиг баяр, кайф, хообий, амьдралынх нь утга учир болох билээ. Жижиг, дунд бизнестээ Япон улс хэр анхааралтай хандан, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, улмаар энэ салбар эдийн засгийнх нь хөдөлгөгч хүч болсон тухай удаах сурвалжлагууддаа үргэлжлүүлье.

# 45 насандаа амьдралаа өөрчилж, бадамлянхуагаар утас ээрэх нь ОПТИМИЗМ МӨН ҮҮ?

Зул сарын Киото үлгэрийн юм шиг өнгө гэрлээр анивчина. Киотогийн галт тэрэгний төв буудлын барилгыг ХХ зууны байгууламж хэмээн нэрлэх агаад энд байрлуулсан аварга гацуурын өмнө бяцхан харагдах зон олон хэдийнэ шинэ жилийн баяраар амьсгалан, бүр хөөрчээ. Хотын хамгийн нүсэр барилга энэ. Харин Киотогийн бусад хэсэгт намхан, хуучны голдуу байр сууц зонхилдог. Японы эртний нийслэлийн дүр төрхийг бусад хотын шуугиант амьдралаас ялгах гэж зориуд навтгар архитектурыг сонгосон хэрэг. Энэ хотынхон зөөлөн ялдам хүмүүс гэж Озки сан тайлбарлалаа. Бүр VII зуунаас энд төвхнөсөн Киото хотын уугуулууд буурал түүх, дурсгалт газрынхаа буяныг хадгалжээ гэмээр. Хэдийгээр төв вокзалд нь зул сарын дуу хуур тасралтгүй цуурайтах авч Киотогийн олон сүмийн эргэн тойронд амгалан ахуй идээшжээ. Алтан шаргал намар энд гоёлоо гүвж амжаагүй юм байна. Өнгө будгийн эрс тэс хувирал дунд Наран улсын анхны нийслэлийг сонирхов.

Очих газар энүүхэнд. Хатгамлын бизнес эрхэлдэг Вакоёша сангийн урланд хүрээд ирлээ. Үйлдвэрлэл, аж ахуй, бизнес гэх үгсийн аль нь ч энд үл авцалдах мэт ээ. Урлан хэмээх томъёолол арай дөхүү юм болов уу. Киотогийн хатгамалчин маань 57 настай эр. Түүний эрхэлж буй үйл бусад бизнесээс өвөрмөц учир тэмдэглэлийн дэвтрээсээ үзэг салгаж чадсангүй. Япон улсын эдийн засаг 1980-аад онд цэцэглэн хөгжиж, чухам тэр өдрүүдэд мөнөөх галт тэрэгний том буудал мэтийг босгох авангард санаанууд төрж байлаа. Уулзаж ярилцсан олон бизнесмэн салбарынхаа ашиг орлого арвижсан алтан үеийг өнгөрсөн зууны 80, 90-ээд онтой холбосон юм. Тэгвэл өнөөдөр тус улсын эдийн засаг зогсонги болж, үйлдвэрлэлийн зарим салбарт өрсөлдөгч цөөрөн, аж ахуйнууд үүд хаалгаа барьжээ. Харин Киотогийн хатгамалчин эрийн амнаас огт өөр үгс сонсогдох. «Японы эдийн засаг зогсонги болсон нь миний бизнест сайнаар нөлөөлсөн. Хэрэв эдийн засаг хүчтэй байсан бол хүмүүс хуучин эдлэл сэргээж засуулна гэхгүй, шинийг авахаар дэлгүүрт очих байсан биз» гэж тэрбээр яриу. Өөрөөр хэлбэл, түүний урланд бүр 100 гаруй жилийн өмнөх гар урлалыг сэргээн засварлаж байна. Хажуугаар нь ламын хувцас, сүм хийдийн элдэв нандин хэрэглэлийг шинэчлэн хийдэг.

-Техник технолог өндөр түвшинд хөгжсөн цагт машинаар хатгамал бэлтгэх хялбар бөгөөд харьцангуй хямд бизнес л дээ. Гэхдээ машинаар урлаад эхлэхээр үнээ буулгах өрсөлдөөн аяндаа гарна. Гараар хийнэ гэдэг хамаагүй чанартай, давтагдашгүй, чимхлүүр ажил. Тийм тусмаа үнэд хүрч байдаг эд гэж Вакоёша сан ярилаа. Түүний урлан 19 хүнтэй. Таван хатгамалчин байнга ажиллаж, захиалга нэмэгдсэн үед уран гартай дөрвөн эрхмийг нэмж дууддаг аж. Ахмадууд голдуу сууж харагдана. Шинэхэн даавуун дээр эрт цагийн чамин хээ хуарыг шилжүүлэн зөөх аж. Зуун жилийн өмнөх хатгамлын технолог дахин урлах чадвартай хүн өнөөдөр үгүй болохоор хуучныг цэвэрлэн, нөхөж цойлдох, суурь дэвсгэрийг солих захиалга гол төлөв ирдэг. Түмэн өнгийн торгомсог утастай дамруудыг цэгцтэй хураажээ. Энд солонгорох өнгө эртний эдлэлд тэр бүр тохирохгүй нь элбэг. Тиймээс шинэ, бөх утсыг дахин ээрч томж байна. Японы сүм хийдийн лам нарын хувцсыг уншигч авхай телевиз,

**Түүний  
эрхэлж буй  
үйл бусад  
бизнесээс  
өвөрмөц учир  
тэмдэглэлийн  
дэвтрээсээ  
үзэг салгаж  
чадсангүй.**

хэвлэлээс үзэж харсан байлгүй. Тэрхүү уужим өмсгөлийг сайн чанарын материалаар, ном журмын дагуу оёулж авна гэвэл 200.000 гаруй иен буюу хоёр сая төгрөг болно. Тиймээс Вакоёша сангийн урланд ламын хуучин өмсгөлийг засч сэлбүүлэх захиалга тун их ирдэг аж.

1.2 сая хүн амтай Киотод 3000 сүм бий. Зэргэлдээх Осака мөн ийм тооны сүм хийдтэй. Эдгээртэй хаяа нийлсэн хоёр мужаас бас л чамгүй захиалга ирдэг болохоор мань хатгамалчны бизнест зах зээл хангалттай бололтой. Японы шашин, соёлын өлгий нутагт Вакоёша сангийнх шиг урлан саяхан болтол байгаагүй юм. Тэрбээр 12 жилийн өмнө буюу 45 настайдаа ийм цоо шинэ бизнест зориглон оржээ. 45 гэдэг барагтай бол дасч дадсанаа өөрчлөхийг үл хүсэх даруулгатай нас зүс байлтай. Тэр тусмаа өрсөлдөх чадвар муутай, өртөг ихтэй бизнес рүү хальтраад орчихлоо шүү гэдгийг түүнд танилууд нь хэлж сануулж байсан гэдэг. «Чи шатна аа» гэсэн үгийг тэрбээр 12 жилийн тэртээ олонтаа сонсчээ. Түрээсийн байр хэсч, найман ч удаа үйлдвэрлэлийн байраа өргөтгөж. Ингэлээ гээд итгэл алдралгүй уйгагүй зүтгэх хүчийг түүнд дурласан ажил нь өгөө биз ээ. Даатгалын компанид «насаараа» ажилласан Вакоёша сан хатгамалчин болохоор шийдсэн учраа хүсэл сонирхол, хообийтойгоо холбон тайлбарлаж байна. «Эхлээд хэцүү зүйл олон тохиолдсон. Анхны захиалга болох ламын хувцсыг цэвэрлэж засчихаад яаж эвхэх ёстойг ч мэдэхгүй, өөрөөр нь заалгаж сурсан» хэмээн яриу. Ламын хувцас оёход хүртэл нэмүү өртгийн талаар үг хавчуулах нь содон. Бадамлянхуа цэцгэн дүрслэлийг сүм хийдэд олонтаа үзэж болдгийг манай сүсэгтнүүд андахгүй. Тэгвэл мань хатгамалчинд Бирмээс өвөрмөц захиалга ирж. Бадамлянхуа цэцгийн үрнээс утас ээрч, ламын өмсгөл оёулахыг хүссэн гэнэ. Үр дүн нь гэвэл ердийн, хальт харахад бүдүүн бараг, торгоор урласан өмсгөлөөс чанар тааруу хувцас. Гэхдээ ийм өмсгөл чамин материалаар хийснээсээ хамаагүй үнэтэй юм. 350.000 иен буюу 3.5 сая төгрөгөөр ганц «дээл» авна гэсэн үг. Шашны хүндэтгэлт бэлгэ тэмдэг бадамлянхуагаар хийсэн учраас тэр шүү дээ. Ийм өмсгөл оёх захиалгыг жилд 25 орчмыг авдаг гэнэ. Борлуулалт, ашгаас гадна өөрийн хообий, өмчлөх үнэт зүйлээ дээгүүрт тавьдаг бизнес Японд энэ мэт байнга тохиолдоно.

**Борлуулалт,  
ашгаас гадна  
өөрийн хообий,  
өмчлөх үнэт  
зүйлээ дээгүүрт  
тавьдаг бизнес  
Японд энэ мэт  
байнга  
тохиолдоно.**

-Жилд 165 сая иенийн борлуулалт хийгээд таван саяын ашиг олдог... Сонин сонсогдож байгаа биз? Үнэмшил муутай ч юм шиг. Жижиг, дунд бизнесийнхнээс ашиг орлого, зарлагын тухай асуух болгондоо татвар гэх үгийг өөрөө ч анзааралгүй хүлээсээр. Гэвч тэдний нэг нь ч татварын дарамт, ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэлийн ачааны тухай шогширч ярьсангүй. Түүхий эдийн зардал, өрсөлдөөн, технологийн хөрөнгө оруулалт, эрэлтийн өөрчлөлт гэх хүчин зүйлүүд бизнест нь голлон нөлөөлдөг болохыг анзаарав. Жижиг, дунд бизнесийг зээлээр дэмжих төрийн бодлогын зэргэцээ татварын таатай орчин бүрдүүлээд өгснийг ажил хэрэгч хүмүүсийн ярианаас ойлгож болно. Төр нь бизнест саад бололгүй, чимээгүйхэн тэтгэж байна. Вакоёша сан өнөөдөр өөрийн гэсэн байрандаа үйлдвэрлэлээ эрхэлж жилийн багахан ашигтаа сэтгэл хангалуун суух аж. Арваад жилийн өмнө «Чи шатна аа» гэж хэлж байсан хүмүүс одоо өвөрмөц бизнесээс нь санаа аван түүнийхтэй ойролцоо урлан байгуулаад эхэлжээ.

-Энд дандаа настай хүмүүс ажиллах юм. Манайд ч ялгаагүй. Сайн хатгамалчин олоход их хэцүү. Залуус ийм бизнес рүү хошуурахгүй нь мэдээж. Цаашид боловсон хүчний асуудлаа хэрхэн шийдэх бодолтой байдаг вэ гэж «Монгол хатгамал» компанийн захирал Т.Оюунчимэг түүнээс асуулаа.

-Манай ажилтнуудын дундаж нас 57. Ахмад хүмүүс хийж буй зүйлдээ сэтгэлээ бүрэн зориулж ажилладаг. Харин залуусын тухайд тэд өртөг өндөр,



өрсөлдөх чадваргүй үйлдвэрлэл гэж ойлгодог тал бий. Хатгамлын чиглэлээр мэргэжлийн хүн бэлтгэж буй сургууль ч алга. Тийм ээ, бидний бэрхшээл ижил юм байна. Гэхдээ би өөдрөг хүн. Өнөөдөр болж бүтээд, бага ч гэсэн ашиг орж ирээд байхад маргааш миний бизнес ирээдүйгүй гэж хэн хэлэх юм бэ. Ер нь газар газрын залуус боломж олж харахдаа хойрго. Бүтэхгүй эд гээд л орхичихож байна. Тэгвэл өнгөрсөн жил бид хамгийн их орлоготой ажилласан. Цаашид ч боломжууд гарч ирсээр байх болно. Бизнес маань бага багаар тэлж байна. Харин боловсон хүчний тухайд, гарц олж чадвал би тантай туршлага солилцоно оо гэв.

Даатгалын компанийн ажилтан гэнэт л хообийгоо дагаад шинэ бизнест орохдоо үнэнийг хэлэхэд ирээдүйн тухай «ноцтой» бодоогүй гэсэн. Одоо бол нэгэнт хөл дээрээ боссон бизнесээ үргэлжлүүлэхийн тулд болгож бүтээхээр хөдөлмөрлөж явна. Өөдрөг үзэлгүйгээр бизнес эрхлэх аргагүй гэж энд уулзсан олон хүн давтаж байлаа. Ингэхдээ Асашёорюүгийн хэлснийг ямагт дурдана. «Ялалтын тань нууц юу вэ» гэсэн сурвалжлагчийн асуултад их аварга «Би үргэлж өөдрөг байж, зөвхөн урагш тэмүүлж явдаг юм аа» хэмээн хариулжээ.

**2005 он**

# Будааны боовноос «Өгөөж»-ийн авах санаа

-Би романтик хүн. Хүн болгонд өөрийн гэсэн роман, амьдралын тууж байх учиртай. Өөд болсны минь дараа ч хүмүүс намайг дурсаасай гэж боддог. Аливаа бизнес баяр баясгалан авчрах эцсийн зорилготой. Харин ашиггүй бизнес хэрхэн аз жаргал өгөх билээ гэж Арай сан ярьж байна. Эрхэлж буй ажлаасаа эрч хүч аван урамшиж амьдардаг тухай Японд уулзсан олон хүн өгүүлсэн. Тэд янз бүрийн салбарт бизнес эрхэлдэг. Аж ахуйгаа хөтлөх арга менежмент нь ч гэс ондоо. Авир араншин өөр. Гэхдээ ойр төстэй чанарууд бас бий. Өнөөгийн амжилтад хүрэхийн тулд дор хаяж 15-20 жил уйгагүй хөдөлмөрлөсөн, алхам алхмаар урагшилсан тухайгаа бүгд ярьцгаана. Ийм урт зам нь залхаалт бус, дуртай хайртай ажлынхаа төлөө өөдрөг сэтгэлээр зүтгэсэн амьдралын тууж болжээ. «Мөрөөдөлтэй амьдраарай. Түүнийхээ захад нэг л мэдэхэд хүрэх хэчнээн сайхан» хэмээн Арай сан яриагаа үргэлжлүүлсэн юм. Зуугийн талыг насалсан бизнесмэнүүд хөвгүүд лугаа цэнхэр мөрөөдлийн тухай өгүүлэх аж.

Өдөр тутам тулгарах бэрхшээл, асуудлууд, хатуу чанга шаардлагын цаана тэд бодит байдлаас амсхийх хийсвэр ертөнцтэй. Зах зухаас нь сонсч, ажиглаж анзаарч л явлаа. Киотогд уулзсан Арай сан зөөлөн эдлэл буюу дэр, хөнжил, сандлын зөөлөвч зэргийг онцгой технологээр үйлдвэрлэдэг. Гурван хүүгээ бизнестээ татан оролцуулжээ. Загвар зохиогч, эдийн засагч, техникийн мэргэжилтэй гурван залуу тус тусын чиглэлээр гэр бүлийн бизнесээ тэтгэж байна. Өөрөөр хэлбэл энэ хүн залгамжлагчдаа хэдийнэ бэлтгэжээ. Харин Соока мужийн «Соока Аой» боовны үйлдвэрийн эзэн Адачи сан компанийнхаа хувьцааны 87 хувийг өөрөө эзэмшдэг. «Үгүй дээ. Би бизнесээ хүүдээ өвлүүлэх бодолгүй. Миний ах дүү, хамаатан садны хэнд ч хувьцаа байхгүй. Манай компанийн ажилтнууд бизнесээ үргэлжлүүлэх ёстой» гэж Адачи үздэг. Менежментийн арга барилаар нь харьцуулбал мөн л ялгаатай. Боовны үйлдвэрийн эзэн «Би өөрөө бүх асуудлыг шийддэг. Манайх шиг жижиг үйлдвэрийн хувьд доод шатны хүмүүсээсээ санаа оноо авах явдалгүй. Том бизнест бол өөр. Янз бүрийн санал бодлыг харьцуулж байж далайцтай шийдвэр гаргадаг. Миний бодлоор, ер нь маркетинг дээр хүний олноор бус, техник технологийн дэвшилтэй хүч хамсрах нь зөв» гэж үздэг.

Киотогийн дэрний үйлдвэрийн эзнээс менежментийн ийм ялгааны талаар сонирхлоо.

-Бүтээгдэхүүний төрлөөс шалтгаалаад менежмент янз бүр байж болох юм аа. Жишээ нь, хүнсний тухайн бүтээгдэхүүний амт тогтмол нэг янз байх шаардлагыг дагаад «Соока Аой»-гийн эзэн ганцаараа толгой мэдэн шийддэг биз ээ. Бас залгамж үеийнхнээ хэрхэн бэлтгэх тал дээр бизнес бүр өөрийн онцлогтой. Миний хувьд үйлдвэрийн шат болгонд ажилтнууддаа зааварлаж сургах нь бүтээгдэхүүний чанарт сайнаар нөлөөлдөг гэв.

Японы жижиг, дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагаанаас авах санаа, «хаях» төвөгтэй зүйлс ч бий. Юуны өмнө бүтээгдэхүүний сав баглаа боодлоор худалдан авагчийн сонирхлыг өдөөх, улмаар аюулгүй, чанартай хадгалан хамгаалдаг технологийг нь олзуурхав. Соока мужийн «Соока Аой» боовны үйлдвэрт гол төлөв жижиг савлагаатай, эсвэл ширхгийн бараа хийдэг. Магадгүй өрхийн гишүүдийн тоо энд Монголын дундаж ам бүлээс цөөн болохоор хэрэглээ дагасан савлагаа ийм авсаархан байдаг биз. Япончууд будааны боов амтархан иддэг. Түүнийгээ сэмбэй гэж нэрлэнэ. Гол төлөв давсархуу амттай, элдэв хольцтой.

Ийм урт зам нь залхаалт бус, дуртай хайртай ажлынхаа төлөө өөдрөг сэтгэлээр зүтгэсэн амьдралын тууж болжээ. «Мөрөөдөлтэй амьдраарай. Түүнийхээ захад нэг л мэдэхэд хүрэх хэчнээн сайхан»

Бид бол «Яаж хоол болдог байна аа» гэмээр хатуу, шарвин шиг «хариугүй» эд. Будааны боовонд юу эсийг хольдог гээч. Загастай, халуун ногоотой, далайн байцаанд ороосон гээд түмэн жорын нарийн боовыг тус бүр ганган хээнцэр уутанд савлана. Борлуулалтын зардлын 15 хүртэл хувийг зөвхөн савлагаанд зориулдаг аж. Савлагааны зардлын хувь хэмжээг үүнээс илүү гаргахгүй байхыг Засгийн газар хянаж, шаардлага тавьдаг. Нээрээ, том гэгч хайрцагтай сэмбэй боов аваад задлаад л байлаа, элдэв чамин цаас хаяад л байлаа. Тэгж тэгж олон давхар боолтны дундаас жаахан сэмбэй олж авсан шүү. Сав, баглаа боодлын дизайн дээр онцгой анхаарч ажиллана. Харц булаах ид шидээс гадна амархан мууддаг боовыг аль болох урт хугацаанд хадгалахуйц чанартай технолог байх ёстой. Тиймээс сэмбэйг гол төлөв хатуу шажигнасан уутанд савладаг. Хаврын улиралд бол сакураны дүрслэл бүхий ялдам ягаан, цагаан уутанд, зун тоор жимсний өнгөтэй уут голдуу хэрэглэдэг гэж Адачи сан ярилаа. Ингэхдээ хадгалалтын хугацааг уртасгах гэж уут доторх хүчилтөрөгчийг соруулан авдаг аж.

Японд ялангуяа хүнсний аюулгүй байдалд онцгой анхаарч байна. Бүтээгдэхүүнээс нь хүн хордлого авсан ганцхан тохиолдол үйлдвэрийг дампууралд хүргэх тун ойрхон гэгцээнэ. Үнэнийг хэлэхэд будааны боов этгээд амттай. «Өгөөж»-ийн чихэрлэг бүтээгдэхүүнд дассан болоод ч тэр үү давстай боов шаржигнуулах тийм ч таатай биш. Тэгвэл япон сэмбэйний дөнгөж 10 хувь нь чихэрлэг. Тус улсын боовны нийт зах зээлд жилд 3.2 триллион иен эргэлддэг гэж бодохоор давстай шаржигнууртаа аргагүй дурладаг улс юм. Адачи сан 27 жилийн турш сэмбэй үйлдвэрлэжээ. 128 ажилчинтай «Соока Аой» эдүгээ мужийнхаа хэрэгцээний 40 хувийг хангадаг, энэ нутгийн урдаа барьдаг брэнд бүтээгдэхүүн болсон байна. Адачи үйлдвэрийн дарга нартаа сонин шаардлага тавьдаг. Сар бүр тэднийг гоо зүйн хичээлд суулгадаг гэнэ. Уран зураг үл ойлгодог бол амттай боов хийх, ялангуяа түүний сав, баглаа боодлыг шинээр сэтгэж, мэдэрч ажиллаж чадахгүй гэж үздэг. Сав, баглаа боодлоос гадна дэлгүүрүүдийнхээ шилэн хоргонд бүтээгдэхүүн байрлуулах ур дүйг гойд анхаарна. Сар тутам үзмэрийг шинэчилнэ. Үнэхээр төрөл бүрийн сэмбэйг эвлэгхэн өрсөн, өнгө гэрлийн тусгалыг ч зөв бодолцсон байх аж. Адачи сан биднийг дагуулаад өөрийн лангуу бүхий дэлгүүрүүдээр явж, шилэн хорго болон шинэ бүтээгдэхүүнээ үзүүлж харууллаа.

Сав баглаа боодол, шилэн хоргоор хэрэглэгчээ татдаг бизнесийн ур дүйгээс гадна өөрийн гэх ноу хау бий болгох гэсэн уйгагүй зүтгэл бидэнд санаа өгөх учиртай. Дээр өгүүлсэн Арай сангийн дэр болоод бусад зөөлөн элдэлийн үйлдвэрлэлийн хувьд өөрийн гэсэн ноу хаут бий болгожээ. Полистр өдийг тусгай технологээр преслэн бараг нимгэн хавтасны төдий авсаархан эд бэлтгэнэ. Хэрэглэгч гялгар уутны амыг хайчлан онгойлгомогц полистр өд сэвсийн томорч, дэр болон хувирах аж. Монголоос ирсэн бидэнд ийм «хавтас» бэлэглэсэн агаад зам зуур уут савыг нь гэмтээв ээ хэмээн санууллаа. Үнэхээр зузаан гялгар уутны амыг сулламагц өнөөх хавтас амилан гоёмсог дэр болоодохов. Японы Улаан загалмай нийгэмлэгийн захиалгаар «Arai» үйлдвэрийнхэн хадгалах, зөөхөд авсаархан ийм хөнжил, гудас, дэр үйлдвэрлэж байна. Харин ямар хэмжээний даралт дор хэрхэн пресэлж буйгаа тайлбарлах тун дургүй. 20 жил туршсан технологийн нууцаа Арай сан хөвгүүддээ л хэлдэг биз ээ.

Эндхийн аж ахуйнуудаас авмаар өөр нэг санаа нь үйлдвэрлэлүүд бие биеэ дэмжин ажилладаг. «Arai» компани дэр үйлдвэрлэж, уут савыг нь харин өөр газар захиалгаар хийлгэнэ. Олон жилийн турш түншлэн, бие биеийнхээ үйл ажиллагаанаас амжилт, ашиг орлого нь шууд хамаардаг болцгоосон байна. Ийм үйлдвэрлэлийн сүлжээний бүтэц Монголд хараахан бий болоогүй. Одоогоор хэн хэндээ өндөр үнэ хэлэн тунирхсан салангид бизнесүүд хөл дээрээ тогтох гэж амь тэмцсээр байгаа.

**Харин ямар хэмжээний даралт дор хэрхэн пресэлж буйгаа тайлбарлах тун дургүй. 20 жил туршсан технологийн нууцаа Арай сан хөвгүүддээ л хэлдэг биз ээ.**

# Ерөнхийлөгчийн айлчлал гэнэтийн ашгийн татварын «хувь заяаг» шийдэж болзошгүй

Ройтерс агентлагийн сурвалжлагчийн Монгол Улсын Ерөнхийлөгчид тавих асуулт бэлэн болжээ. Нэг иймэрхүү хүрээнд ярилцана гэдгээ тэд урьдчилан танилцуулахаар асуулт илгээсэн байх юм.

«Рио Тинто» компанийн удирдлагатай эрхэм Ерөнхийлөгч та биечлэн уулзсан уу, «Айвенхоу Майнз»-тай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээг танай Засгийн газар ойрын үед үзэглэх үү, уул уурхайн компаниудад ногдуулах Гэнэтийн ашгийн татварын талаар хөрөнгө оруулагчид таагүй бодолтой байгааг юу гэж үзэж байна вэ гэх зэргээр асуулт өрнөж, хариу нэхэх бололтой.



Фотог Л.Болор

**Аль хэдийнэ алаг цэцэгстээ умбасан хаврын Лондонд тэрбээр хамгийн түрүүнд охинтойгоо уулзсан нь мэдээж. Улаанбаатарт орос сургуульд сурч байсан охин нь энэ жилээс Их Британид боловсрол эзэмших болжээ.**

---

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсад хийх айлчлал хараахан эхлээгүй байна. Цагийн зөрүүг тооцон бодвол айлчлалын албархуу арга хэмжээнүүд Улаанбаатарын цагаар өнөөдөр үдээс хойш эхлэх юм. Намбарын Энхбаяр ням гаригт гэргий, дагалдан яваа хүмүүсийн хамт Лондонгийн Heatrow нисэх буудалд газардсан агаад Ritz хэмээх өндөр зэрэглэлийн буудалд байрлаад байна.

Түүнийг Ritz буудалд Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсыг Монгол Улсад төлөөлөн суугаа Элчин сайд Кристофер Осборн болон зочид буудлын ерөнхий менежер зэрэг хүн угтан авсан юм. Дээрх нь албан ёсны айлчлалын өмнөх явдлууд. Аль хэдийнэ алаг цэцэгстээ умбасан хаврын Лондонд тэрбээр хамгийн түрүүнд охинтойгоо уулзсан нь мэдээж. Улаанбагарт орос сургуульд сурч байсан охин нь энэ жилээс Их Британид боловсрол эзэмших болжээ. Ritz буудлын хувьд дээд зэрэглэлийн өрөөнүүд нь хоногт 3000 ам.долларын үнэтэй.

Айлчлалын үеийн гол яриа хэлэлцээ ямар хүрээнд өрнөхийг Ройтерс агентлагийн тавихаар бэлтгэсэн асуултын өнгө аясаас эрхэм уншигч та анзаарсан биз ээ. Н.Энхбаяр уул уурхайн сэдвээр түлхүү ярихаар энд иржээ. Бүр тодруулбал Монголын баялгийг эзэмших хувьцааг худалдаж авах саналыг дэлхийн уул уурхайн «толгой» компаниудад тавих яриа хэлэлцээний эхлэлийг энд тавина. Даваа гаригийн өглөө түүнийг Ritz буудлаас «хамраа цухуйлгاماгц» ВВС барьж авах төлөвлөгөөтэй. Тус агентлагийнхан радиодоо зориулан ярилцлага авахаар тусгай техник хэрэгслээ өмнөх шөнө нь бэлтгэсэн байх юм. Ritz-ийн үүдэнд хүлээж байгаад өглөө 6.00 цагт яриа аваад эхлэх гэнэ.

Манай албаны хүмүүс ВВС болоод Ройтерсын цацах мэдээллийг Монголын уул уурхайн салбарын талаар дэлхий дахинд таниулсан цараатай сурталчилгаа болно хэмээн олзуурхаж байна. Чухам юу болохыг цаг хугацаа харуулах биз. Юутай ч энд Н.Энхбаяр «Танай улс хөрөнгө оруулагчаас гэнэтийн ашгийн 68 хувийн татвар авах гээд байгаа нь зөв үү» гэсэн асуулттай байнга тулгарах бололтой.

Айлчлалын сүүлийн өдөр буюу 18-ны лхагва гаригт бизнесийнхэнтэй хийх уулзалтын үеэр Рио Тинтогийн удирдлага үг хэлэхээр төлөвлөжээ. Харин мягмар гаригт Н.Энхбаяр Тони Блэйртэй уулзана. Шүтэн биширдэг улстөрч минь хэмээн Тони Блэйрийн талаар дуу алдах шахуу ярьсан удаатай болохоор Ерөнхийлөгчийн хувьд эл уулзалт албан ёсны талаасаа ч, хувь хүнийх нь тухайд ч онцгой ач холбогдолтой бололтой.

Айлчлалын хөтөлбөрийг эцэслэн бэлтгэх гэж энд ч, Улаанбагарт ч хөөрхөн бужигнаж байна. Одоогоор сэтгүүлчид болоод албаны хүмүүсийн гар дээр тавсан бэлэн хөтөлбөр алга. Юутай ч тэргүүн хатагтай О.Цолмон Лондонд байх гурван өдрийг музей үзсэн шиг өнгөрүүлэх нь. Хатан хаантай манай төрийн тэргүүн уулзахгүй юм байна. Нас сүүдэр 80 гарсан Хатан хаан тэр бүр төрийн тэргүүнүүдтэй уулзаад байж чаддаггүй гэж Элчин сайд Д.Даваасамбуу ярилаа.

2007.04.15



# Ерөнхийлөгч «бөөрөнхий» байр сууриа тодруулах нь

Лондон хот зуны хэмнэлдээ хөтлөгдөж, 26 градусын халуунд, цэцэгсийн анхилуун үнэрт нозоорч эхэллээ. Өнгөрсөн жилийн өдийд цас унаж байсан шүү дээ хэмээн ВВС-гийн цаг агаарын мэдээний тоймч дуу алдав. Улирлын сайхныг мэдрэх сөхөөгүй яваа хүмүүс энд бас байна аа. Парламентын танхимд өнөөдөр Батлан хамгаалахын сайд үг хэлнэ. Ерөнхий сайд Тони Блэйр өчигдөржин ВВС-гийн дэлгэцнээс уяатай өнжлөө. Энэ өдрүүдийн хамгийн халуун мэдээ болоод байгаа Иракт Их Британийн хоёр нисдэг тэрэг мөргөлдсөн хийгээд тусламж үйлчилгээний хоёр ажилтан амь насаа алдсан явдал олон нийтийн дунд шуугиан тариад байна.

Дээрх үйл явдлын талаар ВВС радиогийн дөрөвдүгээр суваг даваа гаригийн өглөө шинэ мэдээ цацаад, дараа нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн шууд ярилцлагыг дамжуулаа. Тус радиогийн «Өнөөдөр» нэртэй мэдээллийн хөтөлбөрт Н.Энхбаяр уригджээ. Тони Блэйрийн танхимын хувьд амаргүй, халуун өдрүүдтэй Ерөнхийлөгчийн айлчлал давхацсан аж. Н.Энхбаяр Ритз зочид буудал дахь өрөөнөөсөө 07.00 цагт хөнгөн алхсаар гараад ирэв. Ритзийн үүдэнд түрүүнээс хойш хүлээсэн радиогийн ажилтан тусгай төхөөрөмж бүхий авсаархан машиндаа түүнийг суулгаад авлаа. Явуулын дамжуулах техник хэрэгсэл байрлуулсан, манай «микроны» дайны тэргэнд Ерөнхийлөгч бараг чихээд суулаа даа.

Ярилцлага хэрхэн өрнөж байгааг сонсох гэж Элчин сайд Д.Даваасамбуу, Гадаад бодлогын зөвлөх Д.Цогтбаатар хоёр жижигхэн FM барьчихсан, хөвгүүд шиг чихэвчээ булаалдаад зогсч харагдана. ВВС-гийн дөрөвдүгээр сувгийн долгионыг нөгөө айхтар эдээрээ олигтой сонсч чадсангүй дээ, янз нь. Уг нь энэ радиогийн нэвтрүүлгийг Англи даяар 60 сая гаруй хүн сонсдог юм гэсэн.

Ритзийн эргэн тойронд Монголоос ирсэн албаны хүн цөөнгүй үзэгдэнэ. Харин айхтар хамгаалалт сэлт алга. Өндөр дээд хэмжээний зочид хүлээн авч сурсан буудлынхан эелдэг харилцсан ч, сэрэмжтэй нүдээр орчныг шинжих аж. Р.Раш, Р.Амаржаргал, М.Энхсайхан, Н.Баяртсайхан нар өглөөний цайгаа уугаад, элдэв уулзалт төлөвлөсөн шиг явж байна. С.Оюун гишүүний өрөө рүү дэндүү эртлэн ярьж, бараг орноос нь хөөгөөд босгосондоо хүлцэл өчив.

Энэ өдрийн үдэд Ерөнхийлөгч «Рио Тинто» компанийн гүйцэтгэх захиралтай зоог барих болохоор гишүүн Оюунаас асууж тодруулмаар зүйлс гараад байлаа. Тэрбээр 1996-1998 онд тус компанид ажиллаж байжээ. «Айвенхоу Майнз» болон «Рио Тинто»-той Монголын Засгийн газрын байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар болон Гэнэтийн ашгийн татварын талаарх түүний байр суурийг дараагийн сурвалжлагууддаа өгүүлье.

Ерөнхийлөгчийн айлчлалын албан ёсны хөтөлбөрт орсон анхаарал татмаар өөр нэг уулзалт үдээс хойш болно. Энэ нь Арчер Металл группын захиралтай хийх уулзалт. Уул уурхайн чиглэлийн дэлхийн томчуудын нэг. Энэ мэт манай албаны хүмүүсийн урьдчилан төлөвлөсөн уулзалтуудаас гадна Монголын баялагт «хүрэхийг» хүссэн Их Британийн уул уурхайн компаниудын төлөөллийн бараалхалт олон. Даваа гаригийн турш Н.Энхбаяр ашигт малтмалын талаар «дагнан» ярих нь. Гэнэтийн ашгийн 68 хувийн татварын сэдвээр ч цөөнгүй асуулттай тулгарах бололтой.

Жилийн өмнө УИХ-аар хэлэлцэн баталсан уг хуульд тэрбээр хориг тавиагүй, байр сууриа тодорхой илэрхийлээгүй өнгөрсөн билээ. Нэг талаас 68 хувийн татварын «заналт дайсан» О.Чулуунбат анд нь уг нь Ерөнхийлөгчид «болохгүй татвар шүү» гэж зөвлөсөн байлтай. Нөгөө талаас олон нийтийн санаа бодолд хэтэрхий «мэдрэмжтэй» ханддаг Ерөнхийлөгч маань тухайн үеийн нийгмийн ууртай уур амьсгалыг нэмж хурцлахаас эмээгээд таг дуугүй өнгөрсөн биз ээ. Лав энэ удаа бизнесийнхний тодорхой саналуудад ойлгомжтой хариу өгөх хэрэгтэй болох нь.

Айлчлалын эхний өдөр Ритз буудлаасаа бараг холдоогүй Ерөнхийлөгч өнөөдөр үдэд Тони Блэйртэй хагас цаг орчмын хугацаанд уулзахаар хөтөлбөрт тусгасан байна. Downing street-д 10 жил амьдарсан Тони Блэйрийн «тэтгэвэртээ гарах» өдрүүд дөхжээ.

2007.04.16

---

**Тэндээс арваадхан алхмын цаана байрласан  
Монголын сэтгүүлчид хоёр даргын уулзах эхний  
агшны дүрсийг хальсанд ахиухан буулгаад авах  
гэсэндээ гадаадын сэтгүүлчид шиг «Тони» хэмээн  
чангахан хашгирав. Мань Блэйр ч иймэрхүү зүйлд  
лассан болохоор «сургуультай амьтан» шиг бидэн  
рүү хараад гар даллалаа.**



Фотог Л.Болор

# Луис Аяала ба шашны лекц

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсад хийж буй айлчлалын хөтөлбөрт багтсан «содон» үйл явдал гэвэл Луис Аяалатай Лондонд тавьсан болзоо хийгээд бурхны шашны тухай лекц нь болой. Социалист интернационалын Ерөнхий нарийн бичгийн дарга Ritz зочид буудалд маргааш бага үдэд ирж Н.Энхбаярт бараалхана.

«Бараалхана» гэдэг үг энэхүү уулзалтын хувьд содон сонголт юм. Айлчлалын хөтөлбөрт аргагүй төр төмбөгөр, ёс ёмбогор болохоор ингэж тэмдэглэжээ. Уг нь хэдхэн жилийн өмнө намын дарга Н.Энхбаяр өөрөө Аяала эрхэмдээ бараалхдаг байлаа. Эртний андуудын уулзалт хориодхон минут үргэлжилнэ.

Өөр нэг содон арга хэмжээ нь Ерөнхийлөгч маань Оксфордын их сургуульд лекц уншина. Сэдэв нь «Монголын соёлын сэргэлтэд бурхны шашны үүрэг». Зэрвэс харахад гэм зэмгүй арга хэмжээнүүд шиг атлаа нам, шашин, төрийн ажил холилдоод явчих мэт өөрийн эрхгүй санагдав. Эрхэм Ерөнхийлөгч ийнхүү тал бүрийн авьяас чадлаа гайхуулж явах зуур Royal Garden зэрэг Лондонгийн үнэтэй буудлуудад тухалсан манай бизнесийнхэн түнштэйгээ уулзах нь уулзаж, зарим нь алдарт Hyde паркаар зугаалсан шигээ алхаж явна.

## С.ОЮУН: АЛТАН БОЛОМЖИЙГ АШИГЛАХ ЁСТОЙ

Дэлхийн зах зээл дээр зэс, алтны ханш ийм өндөр байх мөчлөгийг дүүрэн ашиглах тухай УИХ-ын гишүүн С.Оюун ярьж байна. Өөрөөр хэлбэл тамга хэнтэ гарт байгаа мөчид санаачилгыг ав гэсэн санаа. Энэ онд багтаагаад Рио Тинто болоод Айвенхоу майнзтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, ингэхдээ өөрсдөдөө хамгийн ашигтай хувилбар дээр зоригтой «зогсох» боломж байгаа тухай тэр ярьж буй юм. Лондонд хүрэлцэн ирсэн манай төлөөлөгчид Рио Тинтогийн гүйцэтгэх захирлын зохион байгуулсан үдийн зоогт орохын өмнө С.Оюунтай уулзав.

**-Ерөнхийлөгч Рио Тинтогийн удирдлагад тодорхой санал тавих уу?**

-Рио Тинто болон Айвенхоу майнзтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл УИХ-д хараахан танилцуулагдаагүй болохоор энд тодорхой зүйлийн талаар талууд ярилцахгүй биз ээ. Энэ уулзалт хоёр талын байр суурь улам ойртож байгааг л нотлох юм. Оюутолгой Монгол Улсын хувьд хамгийн том, итгэл найдвар тавих учиртай төсөл болохоор ингэх нь аргагүй.

Яриа хэлэлцээний дүнд зөв хувилбар гарвал цаг алдалгүй гэрээнд гарын үсэг зурмаар байгаа юм.

**-Гэнэтийн ашгийн татварын талаар хөрөнгө оруулагчид их сонирхох бололтой. Үнэхээр энэ буруу шийдвэр байсан юм бол УИХ уг хуулийг яагаад баталчихсан юм бэ?**

-Буруу шийдвэр байсан. Тухайн үед М.Энхсайхан, Н.Баяртсайхан гээд цөөнгүй гишүүн ийм татвар ногдуулахын эсрэг байр суурьтай байсан боловч түүнийгээ олигтой хамгаалаагүй шүү дээ. Манайх шиг хатуу ашигт малтмалаас гэнэтийн ашгийн татвар авдаг улс байхгүй. Яахав, газрын тосонд ийм татвар тавих нь бий.

Гэхдээ газрын тосны хувьд өрөмдлөгөөр баялаг гарсан л бол цаашдаа үйлдвэрлэлийн өртөг харьцангуй хямд байдаг. «Эрдэнэт» үйлдвэр өнгөрсөн жилийн гэнэтийн ашгийн татварын орлогын 98 хувийг дангаараа төсөвт өгсөн байна. Өнгөцхөн харахад ийм татвараас төсөвт тухайн үедээ ихээхэн хөрөнгө орж ирээд сайхан ч юм шиг. Гэхдээ хөгжлийн дараа дараагийн алхамдаа дөтлөн орох, ирээдүйн талаар ярих болоход огт өөр дүр зураг харагдаж байгаа юм.

Зэрвэс  
харахад гэм  
зэмгүй арга  
хэмжээнүүд шиг  
атлаа нам,  
шашин, төрийн  
ажил холилдоод  
явчих мэт өөрийн  
эрхгүй санагдав.  
Эрхэм  
Ерөнхийлөгч  
ийнхүү тал  
бүрийн авьяас  
чадлаа гайхуулж  
явах зуур Royal  
Garden зэрэг  
Лондонгийн  
үнэтэй  
буудлуудад  
тухалсан манай  
бизнесийнхэн  
түнштэйгээ  
уулзах нь уулзаж,  
зарим нь алдарт  
Hyde паркаар  
зугаалсан шигээ  
алхаж явна.

# Еврогоор зээл авах хэрэг байна уу, Сайд аа?

Энэ асуултын хариуг Сангийн сайд Н.Баяртсайханаас гадна уулзсан төлөөлөгч болгоноос нэхэж явлаа. Монгол Улс Европын сэргээн босголт, хөгжлийн банкны гишүүн болоод удаагүй байна. Одоо бүр зээлжих эрх бүхий гишүүн нь болоотохжээ. Ерөнхийлөгчийн айлчлалын хоёр дахь өдөр төлөвлөгдсөн нэг чухал уулзалт тус банкны төв байранд болсон юм.

Европын баян тарган 31 улсыг эгнээндээ нэгтгэсэн санхүүгийн энэ том төв манай улсыг сонирхох нь сүүлийн үед эрс нэмэгджээ. Банкны захирлуудын зөвлөл хуралддаг дугуй танхимд албархуу хувцасласан эрхмүүд суудлаа эзэлсэн харагдана. Аз жаргалтай инээх Сангийн сайдаа хараад ажил төрөл нь бүтжээ гэж таамаглалаа.

Тэрбээр энэ өглөө ЕСБХБ-ны захирал Ж.Лемьер болон гүйцэтгэх захирлуудтай цайлж, тэр зуураа гурван асуудал шийдээд авчээ.

Юун тухай ярилцаж тохиролцсоныг нь үдийн алдад сайдаас сонирхож хариулт авсан билээ. Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн корпорацитай хамтран Монгол Улсад техникийн туслалцаа үзүүлэх гэнэ. Ингэхдээ уул уурхайн салбарт шинжээч мэргэжилтэн ажиллуулах маягаар туслах бололтой дог. Тусламж, зээл гэхээр иргэд маань маш ерөнхий ойлголттой хоцордог шүү дээ.

Харин түүнийг буцаан төлөхийн цагт хамаг ачаа иргэдийн нуруун дээр буудаг болохоор энд манай дарга нарын олзуурхан хөөцөлдөөд яваа зээлийн тухай тодорхой ойлголт өгөхийг «Өнөөдөр» сонин чармайж байна. Мөн тусламжийн хүрээнд том оврын 150 автобус орж ирэх гэнэ. Тохиролцож чадсан хоёр дахь асуудал нь энэ. Ц.Батбаяр дарга зайлуул албан ёсны айлчлал болох бүрийд автобус, троллейбус хөөцөлдөөд явдаг юм. Энэ удаа нийслэл хот 15 жилийн хугацаатай зээл авч, нийтийн тээврийн унаагаа юүлэхээр боллоо.

Гэхдээ арилжааны нөхцөлтэй зээл болохыг нь нийслэлийн иргэдэд сануулъя. Өөрөөр хэлбэл эхний дөрвөн жил хүү, үндсэн өрөө төлөхгүй, цаашдаа жилд таван хувийн өндөр хүү өгч, улмаар богино хугацаанд зээлээ барагдуулах учиртай. Гурав дахь тохирсон асуудал нь хувийн хэвшлийнхэнд зээл өгөх юм. Энд давуу тал нь Засгийн газар зээлийн баталгаа гаргахгүй. Одоогоор ЕСБХБ-ны Улаанбаатар дахь төлөөлөгч 20 төслийг сонгоод нийт 150 сая евро олгоно гэж урьдчилан тооцжээ.

Еврогийн зээл хэр эрсдэлтэй вэ гэсэн асуулт гарах нь дамжиггүй. Америк доллараар асар их хэмжээний зээл аваад эргүүлэн төлөхийн цагт эдийн засаг нь дампуурсан Азийн орнуудын гашуун сургамж өмнө байна. Сайд Н.Баяртсайхан «Евро америк доллараас илүү найдвартай валют» хэмээн итгэл алдахгүй сууна. Дэлхийн зах зээл дээр ханшийн савлагаа өчүүхэн үйл явдлын хаялга даган өрнөж байгаа энэ цагт бодмоор асуудал биш гэж үү, Сайд аа?

**Аз  
жаргалтай  
инээх  
Сангийн  
сайдаа хараад  
ажил төрөл  
нь бүтжээ  
гэж  
таамаглалаа.**

## «Тони, наашаа хар»

-Аав, ээж минь намайг жаахан байхад орос цэцэрлэгт явуулдаг байлаа. Төдөлгүй орос сургуульд элсч, Москва хотод дээд боловсрол эзэмшсэн. Мөн Лийдсийн их сургуульд суралцлаа. Харь улсын хэлээр тэдгээрийн соёл, түүхийг үзэж судлаад л явжээ. Гэсэн ч энэ бүх жилүүд минь эх Монгол орныхоо өнгөрсөн түүх, агуу хэл соёлыг улам бүр гүнзгий мэдэх юмсан гэсэн хүслийн галыг давхар өдөөж байсан. Тиймээс ч би залуу цагаасаа буддын шашны талаар судалж, хэл соёлынхоо өв уламжлалыг шимтэн сонирхох болсон юм хэмээн Ерөнхийлөгч яриу.

Оксфордын их сургууль, дараа нь Волфсон коллежид Монгол Улсын Ерөнхийлөгч зочилж тэндхийн багш, оюутнууд, буддын шашны төвийн төлөөлөгчидтэй уулзлаа. Тэрбээр уулзалт болгоны өнгө аяс, цугларсан хүмүүсийн нас, сонирхлыг төвөггүй мэдрэн чөлөөтэй ярилцах аж. Залуус голдуу цугласан танхимд ч, буддын шашны төвийнхөн, ахимаг насны хүмүүс уригдсан хүлээн авалт дээр ч энгийн яриа хөөрөө дэлгэн, анхаарлыг нь татаж чадаж байна. Ер нь тэгээд орчуулга гэгч нь амьд харилцааны хамаг амт шимтийг аваад хаячихдаг эд шүү дээ.

**Бидний телевизийн дэлгэцнээс харж дассан Downing Street дэх Блэйрийн албан өрөөний өмнө тэд яг 13.00 цагт уулзсан. 10 дугаартай хаалга сэвхийтэл нээгдээд Блэйр ганцаараа гараад ирлээ.**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсад хийж буй айлчлал өндөрлөх дөхөж байна. Тэрбээр айлчлалын хөтөлбөрт төлөвлөсөн ёсоор мягмар гаригийн үдэш Оксфорд хотноо ирсэн боловч лекцийнхээ сэдвийг дор нь өөрчилж орхисон байлаа. Н.Энхбаяр буддын шашны сэдвээр лекц унших тухай дуулаад Оксфордын хичээлийн танхимд цугларсан хүн ч гэж олон.

Багавтар, тохитой өрөөнд Ерөнхийлөгчийг хүлээж байсан хүмүүс өөр тасалгаанд шилжихэд хүрэв. Дэлхий нийтийн мэдлэг боловсролын өлгий Оксфордын номын сан, хичээлийн танхим, царс модон ширээ сандлууд, явган хүний чулуун зам... ер юм болгон нь гүн хүндлэл төрүүлмээр. Цугларсан олон Оксфордын буурал түүх үнэртсэн өөр нэг томхон танхимд очиж суудлаа эзэлцгээлээ.

Ерөнхийлөгчийг ороод ирмэгц алга ташин угтав. Лондонд ажиллаж амьдардаг монголчуудын төлөөлөл ч танхимд үзэгдсэн. Н.Энхбаяр Монгол Улсын гадаад харилцааны сэдвээр товч яриу. Дараа нь асуулт өрнөлөө. Буддын шашны Монголын соёлд үзүүлсэн нөлөөний талаар ярина хэмээн дуулаад сонирхон ирсэн хүмүүсээс зарим нь лекцийн явцад гарч харагдлаа. Харин англи залууст лекц таалагджээ. Тэд, биднийхээр бол гэнэн гэмээр асуулт тавих нь сонсогдоно. Н.Энхбаяр залуу зандан цагтаа Англид сурч байсан тухайгаа, тэр үед харилцаа хүйтэн байсан, Монголын тухай мэдэх хүн энд ховор байж, одоо байдал огт өөр болжээ гэхчлэн өгүүлэв. Завсар чөлөөнд нь хөгтэй тохиолдол, дурсамж хавчуулаад танхимыг хөгжөөж байна.

Мөн өдөр Н.Энхбаярын хувьд сэтгэл өндөр байх хангалттай шалтгаан бий. Мягмар гаригийн үед тэрбээр Тони Блэйртэй уулзсан билээ. Бидний телевизийн дэлгэцнээс харж дассан Downing Street дэх Блэйрийн албан өрөөний өмнө тэд яг 13.00 цагт уулзсан. 10 дугаартай хаалга сэвхийтэл нээгдээд Блэйр ганцаараа гараад ирлээ. Энэ мөчид Монгол Улсын далбаа бүхий хар «Yaguag»-аас манай Ерөнхийлөгч мөн л шаламгайхан гараад ирэв. Тэд 2003 онд анх уулзаж байсан. Одоо бол эртний андуудын ёсоор гар барьж байна. Уулзалт цаг гаруй хугацаанд үргэлжилснийг бодвол, Н.Энхбаяр сонирхолтой ярилцагч байх чадвартайг тооцвол энэ яриа хөөрөө Тони Блэйрт таалагдсан



нь лавтай.

Тэндээс арваадхан алхмын цаана байрласан Монголын сэтгүүлчид хоёр «даргын» уулзах эхний агшны дүрсийг хальсанд ахиухан буулгаад авах гэсэндээ гадаадын сэтгүүлчид шиг «Тони» хэмээн чангахан хашгирав. Мань Блэйр ч иймэрхүү зүйлд дассан болохоор «сургуультай амьтан» шиг бидэн рүү хараад гар даллалаа. ТВ 9-ийн Жавхаа тэсэлгүй «Тони бидэн рүү дахиад хар» хэмээн хашгирч байна. Ерөнхийлөгч инээмсэглээд, «наадуул чинь манайхан» гэж тайлбарлав бололтой.

Ерөнхийлөгчийн хамгаалалтад цагаан мотоцикл хөлөглөсөн зургаан бадриун залуу гарчээ. Манай төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтсан томчуул болох Их хурлын гишүүд, Тамгын газар, зарим агентлагийн удирдлага мөн л «Yagua» хөлөглөн давхина. Харин тэргүүн хатагтайн барааг цөөхөн харж явлаа. Гэргий, нөхөр хоёр бараг уулзалдахгүй шахам явсан шүү.

Тэргүүн хатагтай О.Цолмон заншил ёсоороо пиджак, өмдний хослол голдуу өмсөв. Энэ л сонголтоороо өмнөхөн нь Японы парламентын танхимд «эр хүн шиг» хувцаслаад очсон харагдсан. Уг нь их түүх ханхалсан эрхэмсэг Лондон хотын номын сан, музей зэргээр аялахдаа ялимгүй өөр сонголт хийж болох байсан даа. Аль ч улсын төрийн тэргүүний айлчлалаас сонирхох нэг зүйл нь нэгдүгээр хатагтайн тухай яриа хөөрөө билээ. Тэр эмэгтэйн өнгө төрх, намба ухаанаар нутгийн хүүхнүүдийнх нь тухай ерөнхий төсөөлөл авчих сонин хэмжүүр ч бий.

Айлчлал өндөрлөх дөхөх үест энэхүү нүсэр арга хэмжээний үр дүн юу байв аа гэсэн бодол хүн бүхний толгойд зурхсайдэг биз. Төрийн өндөрлөгүүдийн айлчлал бүрийг ёс юм шиг дагалддаг бизнес групп гэх хүмүүсийн талаар урьдын адил бүрхэг ойлголттой үлдэв. Танхимын даргыг дагасан энэхүү «сүргийн» дотор Лондонд дөрөв хоног хий гиоүрсэн хүн ч байна. Мөн хайран цаг аа! Уйдсан зарим нь хаа хол Оксфорд хотод очоод Монголын гадаад харилцаа сэдвээр лекц сонсчээ. С.Дэмбэрэл даргад энэ талаар дараагийн айлчлалуудын үеэр бодмоор зүйл гарч ирсэн биз.

Албаны төлөөлөгчдийн хувьд тэднийг мөн л хоёр дахин цөөлчих боломж байх шиг. Харин энд зохион байгуулж буй ажлуудынх нь чанарыг хоёр байтугай хэд дахин сайжруулах хэрэгтэй санагдана. Лондонд болсон загварын шоу зэрэг арга хэмжээ зохион байгуулалт муутай болсны бурууг Элчин сайдын яамныханд хаягламааргүй байна.

Элчин сайдын яамны хэдэн хүн эрвийх дэрвийхээрээ зүтгэж байгааг хэвлэлийнхэн бид харж л явлаа. Тэд гагцхүү айлчлал үр дүнтэй болоход хувь нэмрээ оруулах албатай хүмүүс болохоос биш, Улаанбаатараас ирсэн дарга болгонд үйлчилдэг орон тооны зараалууд биш билээ.

**2007.04.18**

## Н.Энхбаяр: Үдшийн Лондонгоор жаахан алхацгаах уу?

Ерөнхийлөгч Н. Энхбаяр өнгөрсөн мягмар гаригийн үдэш бараа бологсдодоо ингэж хэлээд хамт салхилсан тухай яриа маргааш өглөө нь чих дэлсэв. Монгол Улсын төрийн тэргүүн Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсад манай шинэ цагийн түүхийн хувьд онцгой цаг үед айлчилсан агаад дэлхий нийт, тэр дундаа хөгжлөөр тэргүүлэгч орнууд биднийг сонирхсон халуун дулаан уур амьсгал дунд ажил хэрэг хэлэлцсэн билээ. Тэрхүү найрсаг хандлага Намбарын Энхбаярын залуу цагийн дурсамжтай нэгдээд сэтгэлийг нь догдлуулсан байхаас зайлахгүй. Юутай ч Оксфорд хотоос Лондонд оройхон ирсэн сэтгүүлчдийн унаа Ritz зочид буудлын ойролцоо өнгөрөх үес Их хурлын гишүүд үдшийн зугаалгад оролцохоор гадагшилсан харагдсан.

Шөнийн Лондон хот Токио, Нью-Йорк лугаа нүсэр гэрлэн урсгалд гялбахгүй юм. Гэсэн ч эрхэмсэг энэ нийслэлийн хуучинсаг загвар төрхөд тохирсон өвөрмөц өнгө гэж бий. Оксфордын гудамж даган эгнэсэн үнэ ихтэй бараа таваар зардаг дэлгүүрүүдийн шилэн хорго гэрэлтэнэ. Өдөржин олны хөлд талхиулсан гудамж нуруу тэнийсэн аятай. Английн түүхэнд нэрээ мөнхөлсөн лорд, ван, гүн, цэргийн жанжин, улстөрчдөд зориулан босгосон хөшөө дурсгалууд тэрүүхэндээ бүүдийж харагдана. Усан оргилууруудын хөгжилтэй цацраг хүчээ ялимгүй хумиад, шөнийн гэрэлд зөөлөн ойж буух мэт. Үдшийн Лондонгийн аль нэгэн гудамжаар зүгээр л бодлогошрон алхахыг, 21 жилийн тэртээ хүний нутагт анх ирсэн дурдатгал нь сэтгэлд сэвэлзэхийг, өнөөдөр эх орноо энд таниулж яваадаа хангалуун байгаагаа мэдрэхийг Ерөнхийлөгч хүсээ биз. Албан ёсны айлчлал дагалдан цөөн хоног явахдаа бид дарга цэрэг, сурвалжлагч гэлтгүй аливаа зүйлийг ганц өнцгөөс хараад байхыг анзаарлаа. Хамгийн том дарга хэдий ч хүний л ижил догдолж яагаад болохгүй гэж. Тэр хүчтэй мэдрэмжийг зүгээр ил гаргачихад буруу муу нь юу байх вэ. Харин сэтгүүлч сурвалжлагч гэхээр албан ёсны бүх протоколд дөрлүүлэн, үйл явдал болгоныг ганцхан цонхоор шагайх албагүй байлтай. Редакц болгонд өөрийн бодлого хандлага бий шүү дээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлал өндөрлөлөө. Товчхон илэрхийлбэл энэ нь томоохон гэрээ хэлэлцээр үзэглээгүй айлчлал. Их Британийн хувьд Монголын уул уурхайн салбарт хөрөнгө хаяхыг хүссэн том компаниудаа лообийдох зорилготой манай Ерөнхийлөгчийг урьжээ. Тиймээс ч Н. Энхбаяр айлчлалын өнгө аясыг «Хэлбэр талаасаа даруу боловч агуулга өндөр айлчлал» хэмээн нэрэлхэлгүй гэмдэглэсэн юм. Манай хувьд, 1996 оноос хойш буюу П.Очирбат Ерөнхийлөгч тус улсад ирснээс даруй 11 жилийн дараа Монгол орноо дахин сурталчлах шинэ боломжийг эрэлхийлэв. Ингэхдээ дэлхийн зах зээл дээр металлын үнэ өндөр байгаа нөхцөлийг таацуулан, уул уурхайн салбараа «рекламдах», орд газруудынхаа хувьцааг зарах үүд хаалга нээх зорилго өвөрлөжээ. Үр дүнд нь юутай ч «Рио Тинто»-гийн араас «Арселор Миттал» мөдхөн Монголын зах зээлд орж ирэх нь тодорхой боллоо. Тус компани төмөрлөг, гангийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдгийн хувьд манай төмөрлөгийн салбарт өрсөлдөгчгүй ноёрхохыг санаархав бололтой. Их Британийн Засгийн газар томоохон компаниудаа ийнхүү дэмжихдээ Монголын уул уурхайн салбарт шинэ цагийн мэргэжилтэн бэлтгэх тал дээр түлхүү туслах, ер нь англи хэлний сургалтыг эрчимжүүлэхэд том дэмжлэг үзүүлэхээ

илэрхийллээ. Айлчлалын гол үр дүн энэ. Гэхдээ чамлах зүйл биш.

Ерөнхийлөгчийн тэмдэглэсэн лугаа Лондонд хийсэн уулзалт болгон Монголыг гэсэн сонирхлуудыг холбосон, мэдээлэл түгээсэн, агуулга сайтай яриа хөөрөө байлаа. Ялангуяа уул уурхайн салбарын компаниудаа санхүүгийн том группууд нь дэмжих санаатай байна. Мөн тус салбарт шинжээч мэргэжилтнүүдийг буцалтгүй тусламжийн хүрээнд Монголд оруулж ирэх нь. Ийм санаачлагыг Европын сэргээн босголт, хөгжлийн банк гаргажээ. ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөл гэж «хөмсөг зангидсан» 21 эрхэм байх. Тухайн улсад зээл өгөх үү, хүү болоод хугацаа нь ямар байх вэ гэдгийг тэд шийддэг. Ерөнхийлөгч айлчлалынхаа хоёр дахь өдөр Захирлуудын зөвлөлийн хуралдаанд хүрэлцэн ирсэн билээ. «Манай Ерөнхийлөгчөөс их олон зүйл сонирхож асуусан» гэж уг уулзалтын дараа Санхүү, эдийн засгийн сайд өгүүлсэн. Сэтгүүлч биднийг бол мөнөөх уулзалтын эхний ёсорхуу хэсэгт байлцуулаад «хөөгөөд» гаргав. Ер нь төрийн томчуудын аливаа айлчлалыг сурвалжлах хэсэг гэгч байнга л инээмсэглэсэн, гар барьсан сайхан зантай зангиатай эрхмүүдийн тухай бичих, дүрсийг нь харуулах учиртай хүмүүс болж хувирах гээд байна. Гадаадад ч, дотоодод ч ийм зүйлийг л биднээс хүсэх аж. Үнэн хэрэгтээ, айлчлалын бүрэлдэхүүнд багтсан дарга нар хийх ёстой ажлаа хийхээр төсвийн хөрөнгөөр гадаад томилолт бичүүлсэн хүмүүс. Сэтгүүлч бид ч уншигчийн эрх ашигт нийцсэн сурвалжлага бэлтгэхээр томилолт өвөрлөсөн улс болохоор дарга нарын багийг дагаж тэгтлээ гүйгээгүй билээ.

ЕСБХБ-наас монголчууд их хэмжээний зээл авахаар боллоо. 150 сая еврогийн зээл гэдэг тоглоом биш агаад манай 20 орчим компани зээл авна. Хамгийн түрүүнд тэд ХАС банкинд мөнгө өгөхөөр «тоочиглоод» байна. Монголын Засгийн газар тэдгээр компанид баталгаа гаргаж өгөхгүй. Энэ нь сэтгүүлчдэд түгээсэн мэдээлэл. Өөрөөр хэлбэл уулзалтаас биднийг хөөгөөд гаргахаасаа өмнө хэлж өгсөн баримтууд нь. Тэгвэл өдрөөс өдөрт ханш нь чангарч буй хүчирхэг еврогийн зээл авч эхлэхийн давуу, сул тал нь юу байх вэ? Монгол Улсын хувьд дээрх нь «амьдралдаа анх удаа» их хэмжээний еврогийн зээл авч байгаа тохиолдол. Энэ асуултад хариулт авахаар Ritz зочид буудалд Н.Баяртсайхан сайдын тухалсан 518 дугаар өрөөний хаалгыг тогшлоо. Гэхдээ би сайдаас олигтой хариулт сонсч чадаагүй юм. Олон зүйлийн тухай, «Рио Тинто»-той байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний талаар гэхчлэн сонирхохоор очсон билээ. Гэсэн ч төдхөн, цаг гаруйхны өмнө ЕСБХБ-ны удирдлагуудтай ярьж тохиролцоод ирсэн зээлийнхээ дүнг «Ам.доллар бил үү, еврогоор бил үү?» хэмээн ажилтнаасаа лавлаж суугаа сайдыг хараад цааш нь асууж ярилцах хүсэл унтарсан юм.

**Паундийн ханш өдрөөс өдөрт чангарч, их хотод амьдрах гэдэг улам бэрх болсоор байгаа нь анзаарагдана. Капитализмын хамгийн хатуу зарчим зуу зуун жилээр идээшсэн Лондонд замын хүн зүг чигээ олно гэдэг хэцүү. Дүү минь байгаагүй бол би энд мөн ч түүртэх байв аа.**

Монгол Улс Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улстай өнгөрсөн жил 47.6 сая ам. долларын худалдаа хийжээ. Ерөнхийлөгчийн айлчлалын дараа худалдаа наймаа эрчимжинэ гэдэгт талууд эргэлзэхгүй байна. Ардчиллын жилүүдийн эхэнд монголчуудыг хамгийн түрүүнд дэмжсэн барууны том гүрэн бол бидний ярьж давсаанаар Англи. Одоо зөвхөн улс төрийн түвшинд төдийгүй бизнесийн салбарт тус улсын ашиг сонирхол гарцаагүй хил нэвтрэх нь. «Рио Тинто» компанийн Гүйцэтгэх захирал Лэй Клиффорд «Цаг алдалгүй хамтарч ажилла» хэмээн санаагаа шулуухан илэрхийлжээ. Түүнчлэн ЕСБХБ-ны төлөөлөгч энэ сард багтан Монголд ирэхээр болов. Тус банк Улаанбаатар хотын нийтийн тээврийг шинэчлэхээр сонголт хийсэн байх юм. Нидерланд улс том оврын 150 автобус нийлүүлэх гэнэ. Буцалтгүй тусламж хэлбэрээр эдгээр автобусыг авч байна. Улаанбаатар хотод зориулан зээлэх өсөн сая еврогийн зээлийн үлдэх таван саяыг 15 жилийн дараа эгүүлэн төлөхөөр тохиролцжээ.

Ерөнхийлөгч Лондонд ирсэн нь Их Британийн бизнесийнхэн төдийгүй тэнд ажиллаж амьдардаг нутгийнхны маань хувьд сонирхолтой үйл явдал болжээ. Айлчлалын сүүлийн өдөр Лондонгийн монголчууд Элчин сайдын яамны байранд цуглалаа. Багавтар тасалгаанд багтахгүй чихэлдэж, зарим нь гадаа бөөгнөрөн ярьж хөөрөх аж. Улс төр ярьцгаан, танай сонины вэб сайт сүүлийн хэдэн өдөр ажилласангүй хэмээн зарим нь гомдоллов. Эх нутгийнхаа тухай мэдээлэл хүсч, энд Ерөнхийлөгчтэй уулзан «юм» асуухаар олуулаа цугласан зэрэг нь Монголыг гэх сонирхол хүний, өөрийн гэлтгүй бүгдэд байна даа гэсэн сэтгэгдлийг лавшрууллаа. Айлчлалын гол үр дүн чухам энэ байж ч мэднэ. «Ням гариг» сонинд ажиллаж байсан Урнаа охиноо дагуулаад хүрээд ирж. Мөн л манайд ажиллаж байсан охин мэнд мэдлээ. Нэрийг нь би мартсан ч тэр «Өнөөдөр» сониноо мартаагүй байна. Лондонгийн монголчуудын холбооны Цэрэнбат уулзалт зохион байгуулаад завгүй харайлгаж явна. Арван жилийн нөгөө ангийн залуу дүрээрээ зогсч байна. Магадгүй энэ уулзалт айлчлалын хамгийн сонирхолтой хэсэг байж мэдэх. Гэсэн ч сэтгүүлчдийн хэсэг онгоцондоо амжиж суухын тулд аргагүй түрүүлээд хөдөллөө. Бүр автобус хөдөлтөл телевизийнхэн дүрсээ авсаар л явна. Энэ хэдэн өдөр хамгийн завгүй ажилласан баг гэвэл сэтгүүлчид байсан биз ээ.

*Лондонгийн давхар улаан автобус дээрээс унаад өгөх нь үү гэмээр суналзаад хоцорлоо. Хорхой шиг хар тэрэг буюу такси нь зам дагуу үй түмээрээ харагдана. Их хотын нэг өнгө төрх болдог энэ хуучинсаг таксийг Лондонгийн нэрийн хуудас гэлтэй. Паундийн ханиш өдрөөс өдөрт чангарч, их хотод амьдрах гэдэг улам бэрх болсоор байгаа нь анзаарагдана. Капитализмын хамгийн хатуу зарчим зуу зуун жилээр идээшсэн Лондонд замын хүн зүг чигээ олно гэдэг хэцүү. Дүү минь байгаагүй бол би энд мөн ч түүртэх байв аа.*

2007 он

# Ерөнхийлөгчийн айлчлалын ёсорхуу ХӨШИГНИЙ цаана

Парламентын 2008 оны сонгуулийн өрсөлдөөнөөс дутахгүй зодоон Монголын газар нутагт өрнөх гэж байна. Ийм өнгө аясыг Ерөнхийлөгч Н.Энхбаярын Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсад хийсэн айлчлалын үеэр болсон яриа хөөрөөний агуулгаас анзаарч болно.

Зэсийн концентрат болон алтанд ногдуулах 68 хувийн гэнэтийн ашгийн татварыг цуцалж болох эсэхийг «Рио Тинто», «Би Эйч Пи Биллитон» компанийн удирдлагууд, түүнчлэн санхүүгийн байгууллагын төлөөлөгчид Ерөнхийлөгчөөс онцгойлон лавлажээ. Хариуд нь тэрбээр «Бид энэ асуудлыг эргэн харж болзошгүй. Ингэхдээ томхон хөрөнгө оруулагчдынхаа эрх ашиг хийгээд нийгмийн салбарт авах арга хэмжээ хоёрын хооронд тэнцвэр хангах тохиромжтой хувилбар хайх болно» хэмээн албархуу тайлбар өгсөн аж. Тэгэхээр эл асуудлаар манай Ерөнхийлөгч мөд санаачлага гаргаж мэдэх нь.

Ашигт малтмалын салбарыг анхааралдаа онцгойлон авсан Н.Энхбаяр цаашлаад Тавантолгойн шинэ эзэнд найр тавьсан алхам эхлүүлснээ өөрөө анзаарсан байлгүй дээ. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Захирлуудын зөвлөлийн хуралдаан дээр тэрбээр Монголын эдийн засгийн талаар мэдээлэл хийн, асуултуудад сонирхолтой хариу өгч эх орноо сурталчилсан. Энд Монгол орны ашигт малтмалд анхаарал хандуулсан 21 эрхэм сууж байсан юм. Тус банктай манай улс ямар хэлцэл хийснийг «Өнөөдөр» сонин хангалттай тэмдэглэсэн. Харин ЕСБХБ Тавантолгой төсөлд өөрсдийн компаниудаа оролцуулах, тэдэндээ санхүүгийн дэмжлэг үзүүлэх хэтийн төлөвлөгөөтэй болохыг хэвлэлүүд хараахан дурдаагүй байна. Үүний зэргэцээ үндэсний хэдэн компани нэгдээд, «Энержи ресурс» консорциум байгуулж, Тавантолгой төслийг гартаа авахаар санаа шулуудсаныг монголчууд мэднэ. Тус консорциумынхан Тавантолгой монголчууддаа үлдвэл юутай сайхан бэ гэх агуулга бүхий сурталчилгааны кампанит ажил эхлүүлээд удаагүй байна. Тэгвэл Ерөнхийлөгч эх нутгийн өмнөд дэх коксжих нүүрсний баялаг ордоо дэлхий дахинд рекламдаад явна.

Энэ бүх ашиг сонирхлын дунд хэрүүл маргаан хэзээ л бол хэзээ дэгдэхэд бэлэн болоод байна. Монгол Улсын Засгийн газар гадаадын дор хаяж таван компани оролцсон консорциумыг Тавантолгойн ордын төлөөх өрсөлдөөнд оролцуулна гэж Ерөнхийлөгч Лондонд сурталчилж явав.

Оюутолгой төслөөс ч ахиу хэмжээтэй буюу хоёр тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татаж чадах Тавантолгой бол Монголын түүхэн дэх хамгийн том «мөнгөний сав» гэсэн санааг тэрбээр «Ройтерс» агентлагт өгсөн ярилцлагадаа дурджээ. 1.5 тэрбумын өртөгтэй Оюутолгой төслийн тухайд ИБУИНВУ-ыг Монголд төлөөлөн суугаа Элчин сайд Осборн өөрийн биеэр Хөрөнгө оруулалтын гэрээний хувь заяанд санаа тавих даалгаврыг төвөөсөө авчээ. Английн «Рио Тинто» Канадын «Айвенхоу Майнз»-ын эзэмшдэг хувьцааны бараг 10 хувийг худалдаж авсан, энэ хэмжээгээ цаашид нэмэгдүүлэх санаатай байгаа болохоор Тони Блэйр ингэж сэтгэл тавихаас аргагүй.

**Төр, засгийн  
бодлого болохоор  
ордуудаа гадагш  
нь үнэ хүргэж  
борлуулах  
чиглэлээр зам  
засаад эхэллээ.  
Гэтэл лиценз  
эзэмшигч  
дотоодын  
сонирхогчид  
баялгаа  
гадныханд  
алдахгүйг  
чармайж байна.**



Монголын уудам нутагт мөргөлдөж мэдэх өөр нэг ашиг сонирхол нь ураны орд газруудад болох нь. Ерөнхийлөгч Францад айлчлах үеэрээ урьж залсан «Ageva» компанийн төлөөлөгчид мөдхөн Улаанбаатарт ирэх гэж байна. Хажуугаар нь ОХУ-ын компаниуд манай ураны ордуудын лицензийг авахаар «ажиллаад» эхэлжээ. Төр, засгийн бодлого болохоор ордуудаа гадагш нь үнэ хүргэж борлуулах чиглэлээр зам засаад эхэллээ. Гэтэл лиценз эзэмшигч дотоодын сонирхогчид баялгаа гадныханд алдахгүйг чармайж байна. Түүнчлэн Ерөнхийлөгч өөрөө ашигт малтмалын ордуудын хувьцааг дэлхийн том компаниудад борлуулахаар санаачлагыг гартаа авсан нь үндэсний хөрөнгөтнүүд төдийгүй Засгийн газрын гишүүдэд гайхшрал төрүүлж, ээлжит шуугианы эхийг тавиад байгаа нь нууц биш. Уул уурхайн томоохон биржүүд дээр тухайлсан ордын үнэт цаасыг гарган заръя гэвэл үнэ ханш нь ямар байх вэ гэдгийг Монголбанк болон Сангийн яам нэгдэж тохирох учиртай. Тэгэхээр ийм чиглэлээр эрхэм Ерөнхийлөгч үүрэг өгөх болоод байна уу? Ерөнхий сайдыг танхимаа торгоох гээд нойрмоглож суух зуур ийм нэг халуун сэдвийн сэжүүр Лондонгоос эхлээд хөвөрлөө.

**2007 он**

# Аргагүйн эрхэнд сонгосон Аэрофлот



**«Аэрофлот компанийн SU 564 дүгээр нислэгийн зорчигчид онгоцондоо сууна уу, онгоцондоо сууна уу...»** «Чингис хаан» нисэх буудлын зорчин явагсдын хэсэгт даван түгээх энэхүү зарлал дуулдсаар нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Гэсэн ч онгоцондоо суухаар яарсан хүн бараг үгүй. Герман бололтой нэгэн бүсгүй л хий сандран «Энд Москва явах нислэгийг бүртгэж байгаа нь үнэн байгаа даа. Би Монгол руу ирэх замдаа онгоцноосоо хоцорсон болохоор одоо бүр санаа зовоод...» хэмээн үглэнэ.

Тийз дээр тэмдэглэсэн онгоц хөөрөх хугацаа ч боллоо. Ачаа тээшээ өгөхөөр дугаарласан зорчигчдын дараалал харин шингэрэх шинжгүй. Гурван газар тээш хүлээн авч, суудал тэмдэглэж байснаа гэнэт ер нь цаг оройтсоныг ойлгов бололтой, дахин нэг бүсгүй ашгүй хүч нэмэгдэн бүртгэл хийж эхэллээ. Аэрофлот компанийн агаарын хөлгөөр зорчих бүрийд ямар нэг «юм» тохиолдоод байдаг болохоор би ч яарч зогсов. Ингэж хоцорч хөөрвөл ч дараагийн нислэгийн маань цаг эвгүйдэх нь дээ. «Чингис хаан» нисэх буудалд бүртгэлийн цаг унжирч сунжирч байгаагийн буруутан нь Аэрофлот компани уу, манай зохион байгуулалттай холбоотой юм уу, эсвэл зорчигчид бүр эрт ирэх ёстой байв уу, сайн ойлгосонгүй. Юутай ч аравдугаар сарын 7-ны өглөөний нислэг бүтэн цагаар хоцорлоо. Жилийн өмнө мөн л Аэрофлотын нислэгээр зорчсон билээ. Тийзээ бүртгүүлэхээр сарвайхад минь «Энэ суудал захиалгад бичигдээгүй байна шүү» хэмээн хэв нэг хэлж хэсэг сандаргасан удаатай болохоор элдэв асуудалд орооцолдож мэдэх сэтгэл зүйн бэлтгэлтэй явлаа.

Монголчууд Аэрофлотын үйлчилгээнд дассан улс. Эх орныг Европ болоод Америктай агаарын замаар холбох гол гүүр болсон тус компанийнхантай бидний араншин бүр ижил дасал болж, ингэж л байдаг юм аа зайлуул гэсэн шиг хүлээцтэй нь аргагүй ханддаг. Манай МИАТ-ийн үйлчилгээтэй харьцуулахад нэг их ялгарахгүй дээ хэмээн «өөриймсөг» хандах шахна. Москва хүрэх таван цагийн нислэгийн уртыг унтаж амран хугахлах хүн олон. Бараг үүр цүүрээр гэрээсээ гарсан зорчигчид өглөөний унд хоолыг нь зооглоод л хэсэг унтаад авахыг яарах ажээ. Онгоцны танхимд жиндүү хүйтэн байснаа удалгүй халуу дүүгэж Москвад газардах хүртэл улаа бутарсаар суулаа. Өглөөний ундны дараа агаарын хөлгийн үйлчлэгч бүсгүйчүүд газрын гаваар орсон шиг алга болж орхисныг зорчигчид халууцаж сэрэх үедээ сая нэг анзаарна. Хүйтэн юм уумаар байвал тэдний байрладаг хэсэг рүү очоод гуйгаарай. Ундааг уриалгахан аягалаад өгнө. Олон улсын нислэгийн чанартай үйлчилгээнд дассан европчууд харин суудалдаа суугаад л бүсгүйчүүдийн ирэхийг, элдэв хүсэлт байгаа эсэхийг эелдэгхэн асуухыг нь хүлээгээд байх аж.

Түүх сөхвөл, Аэрофлот компани 1932 онд байгуулагджээ. Орос улсад Иргэний нисэх газар тулгын чулуугаа тавьсан тэр жилээс хойш үйл ажиллагаа нь өргөжин тэлсээр эдүгээ 47 улсын 87 хот руу нислэг үйлдэж байна. Мөнөөх хотуудын нэг нь болох Улаанбаатарыг зорьдог маршрутаа орон нутгийн

**Хэрэн тэнэж  
сурсан  
сурвалжлагч  
бидэнд сандал  
хайж самгардах  
хэрэг байхгүй.  
Нөгөө хоёр  
бүсгүй ч хээгүй  
хүмүүс.  
Зузахан картон  
цаас олж аваад  
хөлөө жийж  
суухаас яахав.**

нислэг лугаа үл тоомсорлоод байхыг олонтаа анзаарлаа. «Аэорфлотыг болж өгвөл битгий сонгож бай» гэх нөхөрсөг зөвлөгөөг мөн л цөөнгүй хүнээс сонссон билээ. Олон улсын авиа компаниудынхтай ойролцоо жишгийн үнээр эднийх тийзээ борлуулдаг. Тэгэхээр зорчин явагсад чанартай үйлчилгээг хүлээх нь дамжиггүй. Улаанбаатар дахь Аэрофлотын тийз борлуулдаг салбарт өнгөрсөн есдүгээр сард хавтас тасарсныг хачир болгон дуулгая. Тийз хавчуулдаг уламжлалт хавтас нь ийнхүү түр «тасарсан» учир нимгэн хуудсууд бүхий билетээ салбагануулаад явалтай биш, би л лав дугтуйд хийж орхисон шүү.

## МАНАН ДУНД

Уудам Орос орны зүрхэн тушаа газардах цаг болжээ. Гэвч SU 564-ийн азгүй зорчигчид Шереметьевод бус, Ярославльд буулаа. Буулаа ч гэж дээ, хоёр цаг хэртэй энд саатан, дэмий л хөлгийн цонхоор Ярославлийн бяцхан буудлыг харж суув. Шадар сайд тэргүүтэй манай албаны хүмүүс өнгөрсөн хавар бас ингэж хашигдсан тухай телевизээр мэдээлж байсан санагдана. Бидний онгоц Шереметьевод аравдугаар сарын 7-ны өглөө газардаж чадаагүй нь хүндэтгэх шалтгаантай байлаа. Москва орчимд энэ өдрүүдэд сиймгэр манан хөшилдөөд, хүйтэн зэврүүн байгаа шинжтэй. «Шереметьево, Домодедово, Внуковогийн нисэх буудал бүгд хаагдсан. Онгоц хүлээн авахгүй, хөөрөхгүй байгаа. Санкт Петербургийн буудлууд ч ялгаагүй, нислэг үйлдэхгүй байна» хэмээн үйлчлэгч бүсгүй учрыг асуусан хүмүүст эчнээ тайлбарлав. Түүний ярьсныг монголчууд ойролцоо суусан гадаадынханд орчуулж өгөх аж. Нөгөө герман бүсгүй, бас Америк руу явж буй дөрвөн эмэгтэй гээд юу болоод байгааг гайхсан зорчигч энд олон.

Цаг агаарын үзэгдэл гэдэг хэлж сануулж ирэх биш, нэг л өдөр элдэв явдал тохиолдоно. Тэр бүрийд аюулгүй байдлын үүднээс авиакомпаниуд нислэгийн цагийг хойшлуулах, цуцлах нь ердийн хэрэг. Ингэж бодоод, Ярославлийн буудалд өнөөдөр цөөнгүй онгоц газардах нь гэж хүлээлээ. Гэсэн ч нэмж буух хөлөг үзэгдсэнгүй ээ. Хөөрхий бид хэд л тэнд «манангийн шалтгаанаар» хоригдсон юм биш байгаа даа. Төдөлгүй орон нутгийн чиглэлийнх бололтой онгоц ойролцоо ирж байраа эзэллээ. Хоёр цаг орчим саатсаны эцэст шатахуун цэнэглэж аваад хөөрөв. Москвагаар дамжин өнгөрөх нислэгтэй залуу дараагийн онгоцноосоо хожигдчихлоо хэмээн гасалж эхэллээ. Ойр хавьд нь суусан хүмүүс өнөөдрийн бүх нислэг саатсан юм чинь чиний рейс ч бас хойшилсон байж таарна гэж түүнийг тайвшруулах аж.

Аль өглөө юм идсэн зорчигчид өлссөн шинжтэй. За өлсөх ч дүүрч. Дараагийн нислэгийн маань цаг болоход 30 минут дутуу байлаа.

## ЕР БУСЫН ХАНШТАЙ ЕРДИЙН ЗҮЙЛС

Бага үдийн хэрд Москва манан будангүй үзэгдэнэ. Шереметьево 2 гэж нэрлэх энэхүү буудлыг 1980 онд ашиглалтад оруулжээ. Их Олимпийн тэр жил майжиг Миша, шинэхэн Шереметьево хоёр оросуудын хувьд дурсгалтай үйл явдал болсон юм. Өмнө нь зөвхөн Шереметьево 1 нэртэй аэродромд олон улсын нислэг хүлээн авдаг байлаа. Манай муу онгоцонд зорчигчдоо буулгах сул терминал олдоогүй учир хөөрхий бид дэмий л энд өрнөж буй өргөтгөлийн их ажлыг ажиглан суув. Шереметьево 1-ийг өргөтгөн шинэ гарцууд нэмж байгаа гэнэ. Бидний буух учиртай 2-ыг ч өөрчлөн сайжруулж байна. Эцсийн эцэст, Шереметьево 3 нэртэй жинхэнэ олон улсын жишиг хангасан буудал ч бас байгуулж буй аж. Барилгын ажил энд тэнд эхэлчихсэн, дээр нь манангаас болоод нислэгүүд будилсан бужигнаан дунд арайхийж SU-гаас мултарлаа. Хажууд минь сууж ирсэн Иран, Бельги хоёр бүсгүй «Алив түрүүлээд гүй. Чи

дараагийн нислэгээсээ хоцорчихлоо» гээд араас шавдуулна. Дамжин өнгөрөх зорчигчдыг бүртгэн нэвтрүүлдэг энэ хэсгийг монголчууд мэдэхээрээ нэг болсон биз ээ. Энд суудлаа бичүүлээд, үргэлжлүүлэн хилийн хяналтаар орох гэж хөөрхөн цаг авдаг шүү дээ. Ямар нэг тэмдэглэл хийгээд л байна. «Миний дараагийн нислэгийн онгоц арай хөөрөөгүй байгаа. Ганц хоёр минут хүлээлгэж болно биз?...» Аэрофлотын ажилтан эмэгтэйн царайнд хувирал ер харагдсангүй. Тэгж тэгж «Нью Йоркийн онгоц сая нисчихсэн» хэмээн уйтгартай гэгч сунжруулдаг юм байна. Улаанбаатараас дамжин ирэх цөөнгүй зорчигчоо тэр нислэг хүлээх боломжтой байсан. Шереметьевод шинэ байшин барьж буйг дэмий харсан шиг хамаг цагаа барж зогсоогүй бол, ер нь л энэ том буудалд багахан зохион байгуулалт байсансан бол олон хүн дараагийн онгоцондоо амжаад суучих байлаа.

**Transfer desk** гэсэн тэмдэглэгээ бүхий цонхны өмнө дараагийн үйл явдал өрнөж байна. Оросууд голдуу уурлаж бухимдацгаан хашгиралдах аж. Олон улсын нислэгүүдээс бол «Улаанбаатарын» онгоцныхон л энд үзэгдэнэ. Ер нь ийм шоовдорлол түгээмэл явдал болсныг тэмдэглэе. Эгээ л Оросын орон нутгийн рейсийнх шиг ингэс тэгсхийсэн хөлдүү үйлчилгээг монголчуудад санал болгодог гэвэл хэтрүүлсэн болохгүй. «Улаанбаатарын» экипажийнхан ч Ярославлийн нөөц буудалдаа үе үехэн газардаж дасчээ. Ингээд нөгөө Иран, Бельги хоёртойгоо дахин «айлсаж» аваад хөл амраан суулаа. Суулаа гэхээр тохитой сандал төсөөлөх вий дээ. Одоо бидний Аэрофлотын онгоц доторх асуудал Шереметьево 2 дахь бэрхшээлээр солигдчихоод байна. Замын андууд маань тэр оройдоо нутгийн зүг нисэх рейстэй юм. Харин миний онгоц маргааш нь яг өдийд буюу бүтэн хоногийн дараа хөөрнө. Ийм тохиолдолд авиакомпаниуд зорчигчдоо үнэгүй буудалд байрлуулан, хоол ундыг нь хариуцдаг. Харин Аэрофлотыг сонгосон хүмүүст бол элдэв явдал тохиолдлоо гэхэд зочид буудлын өрөө олдох эсэх нь эргэлзээтэй. Магадгүй цаг агаарын шалтгаанаар цөөнгүй нислэг саатсан болохоор хэдэн буудал нь пиг дүүрэн байгаа ч юм болов уу.

Юутай ч Шереметьевод тухлахаас аргагүй. Хэрэн тэнэж сурсан сурвалжлагч бидэнд сандал хайж самгардах хэрэг байхгүй. Нөгөө хоёр бүсгүй ч хээгүй хүмүүс. Зузахан картон цаас олж аваад хөлөө жийж суухаас яахав. Дэлхийн хамгийн тохь тух муутай буудлуудын нэгэнд хоног төөрүүлэх хүнд үүнээс өөр сонголт үгүй. Дамжин өнгөрөх зорчигчдод үйлчилдэг бүсгүйчүүд ууртай хүмүүст загнуулах нь сонсогдсоор л байлаа. Бадриун том биетэй тэр залуу Америк явах онгоцноос хоцорсон юм. Ар гэрт маань зовлон тохиолдоод би харихаар яарч явааг та нар мэдэж байна уу гээд царай нь чинэрэн , хариугүй уйлах нь гэмээр харагдав. «Энд ямар ч манан алга. Ямар шалтгаанаар онгоцыг маань хүлээлгэсэн юм бэ...» хэмээн тэрбээр тайлбар нэхсээр л байлаа. Бухимдсан хүмүүст өдрийн хоол идэх талон болон гэр рүүгээ хэл чимээ дуулгачих боломж олгож утасны карт өгөх аж. Гэхдээ үүнийг нь мэдэж шаардсан зорчигчдод л өгнө. Ийм үйлчилгээнд үл тайвшрах, ардаа яаралтай ажил асуудалтай хүн цөөнгүй байх шиг. Энд алтан цагаа үрж байгаадаа хэн баярлах билээ дээ.

Одоо Шереметьевогийн амьдралаас хамтдаа сонирхоцгооё. Бүтэн хоног төөрүүлэх сурвалжлагчид сонинчлах зүйлс байна аа. Европ тийш үе үе зүглэдэг манайхан аяны цүнхэндээ ундаа, ойр зуур идэх хүнс базаан авч явж бүр сурчээ. Дээр өгүүлсэн утасны карт мэтийн хөнгөлөлтийг мэддэггүй над шиг туршлагагүй хүн бол энд дороо «дампуурч» магадгүй шүү. Бяцхан охиндоо санаа зовж явсан би хамгийн түрүүнд утасны карт худалдаж авлаа. Transfer desk-ээс карт авч болох тухай эхлээд санаанд орсонгүй. «10 unit» хэмээн тэмдэглэсэн карт 18 ам. долларын үнэтэй. Түүгээр гурван минут хүрэхгүй хугацаанд яриад дуусаа. За яахав, ямар ч байсан ярьж санаагаа амраалаа. Аль

**Бадриун том биетэй тэр залуу Америк явах онгоцноос хоцорсон юм. Ар гэрт маань зовлон тохиолдоод би харихаар яарч явааг та нар мэдэж байна уу гээд царай нь чинэрэн , хариугүй уйлах нь гэмээр харагдав. «Энд ямар ч манан алга. Ямар шалтгаанаар онгоцыг маань хүлээлгэсэн юм бэ...» хэмээн тэрбээр тайлбар нэхсээр л байлаа.**

өглөө цайлсан болохоор амттай гэгч хоолломоор. Тахиа, кофе захвал мөн л 18 ам. доллар. Эндхийн бүх үйлчилгээ ийм ханштай юм биш байгаа даа. Санаанд таарсан үдийн зоог баривал ч үнэ нь яах вэ гэхсэн. Харин ийм тахиа авбал лав эрэгтэй хүн хооллосон болохгүй дээ. Шереметьевогийн бүх үйлчилгээний төлбөрийг уг нь рублиэр хийдэг. Хүсвэл ам. доллараар тооцоо хийж болно. Гэвч валютыг хөрвүүлж буй ханш нь үйлчлүүлэгчдэд дэндүү ашиггүй харагдана. Москвагаар дамжин өнгөрч буй хүмүүс халаасандаа рубль авч явна гэдэг ховор тохиолдол атал мөнгө солих газар энд байдаггүй нь гачлантай. Жижиг савтай ус дөрвөн ам. долларын үнэтэй. Тэгвэл Нью Йоркийн Ж.Ф.Кеннедийн нэрэмжит буудалд ийм ус хоёр дахин хямд байлаа. Хоол болоод бусад үйлчилгээ нь Америкийн нисэх буудлуудад дэлхийн дундаж стандартын жишигтэй байдаг бол Шереметьевод л хүний ердийн бүх хэрэглээ ер бусын үнэтэй санагдсан шүү.

**-Ачаагаа авч болох уу?**

-Ачаа тээшийн хэсэг тусдаа байдаг болохоор бид юугаар ч тусалж чадахгүй нь.

**-Долоо хоногийн өмнө үүгээр дайран өнгөрөх үед ачааны маань кодыг эвдэж, онгичиж орхисон болохоор дахин хоёр хоноход тэндээс юу ч үлдэхгүй байлгүй дээ.**

-Та санаа зовох хэрэггүй. Тээш хадгалдаг газарт камер суурилуулдаг юм...

### **«НАДЮША, ГҮЙЖ БАЙНА ШҮҮ»**

Жилд 12 сая зорчигч Шереметьевод урт, богино хугацаанд саатан, хүчирхэг Орос орны тухай эхний сэтгэгдлийг авч байна. Дэлхийн 70 авиакомпани тогтмол нислэг үйлддэг их хөлийн газар боловч энд шинэ оросуудын хөлдүү араншин түлхүү мэдрэгддэг байх юм. Гэхдээ орос хүний уужим, найрсаг зан ор мөргүй алга болчихоогүйг бас анзаарч л явлаа. «Надюша, гуйж байна шүү. Хүүхэдтэй гэр бүлийг буудалд оруулах хэрэгтэй. Алив хонгор минь яаж ийгээд нэг өрөө олоодохооч...» Дамжин өнгөрөх зорчигчдод үйлчилдэг хэсгийн эмэгтэй «Новотел» буудлын бүсгүйгээс утсаар ийн гуйх нь сонсогдоно. Ер нь бол оройхон тийшээ буюу 23.00 цагийн орчимд зочид буудлын цөөхөн өрөөндөө хэдэн хүн оруулдаг бололтой. Их ачаалалтай үед шүү дээ. Аян замын уртад хүнд юу эс тохиолдох билээ дээ. Аэрофлотоос өөр сонголт олдоогүй үед санаж явахад илүүдэхгүй хэмээн ийм зүйлсийг нуршиж байна.

«Новотел» дундаж буудлын жишигтэй. Ганц хоноод өнгөрөхөд бол дажгүй. Харин араас чинь тасралтгүй дагах учиртай «бие хамгаалагч» нараас залхах вий. Нэгэнт ОХУ-ын визгүй, дамжин өнгөрөгч болохоор паспортыг чинь буудлын жижүүр хураагаад авна. Өрөөнөөсөө гарч болохгүй. / Оргочихвол яана!/ Нью-Йоркийг зорьсон нөгөө хэдэн америктай хамт бадриун «бие хамгаалагч» дагуулсаар оройн хоолонд оров. Дараа нь цахилгаан шатаар өгсөн өрөөндөө хүрэх хүртэл «бие хамгаалагч» биднийг дагалдсан билээ. Шереметьевогийн барилгын нөхцөл бололцоо ийнхүү харгалзагчтай дамжин өнгөрөгч зорчигчдыг бий болгожээ. Хэрэв дэлхийн нисэх буудлуудын стандартын барилга байгууламжтайсан бол заавал харуул хамгаалалт гадагш гарган хэдэн зорчигчоо цагдаж явах шаардлага алга. 2007 оны сүүлчээр ашиглалтад оруулахаар шамдаж буй шинэ Шереметьево орчин үеийн нисэх буудлын бүх стандартыг хангаж чадна гэж оросууд найдаж байна. Одоохондоо бол «Надюша гуйж байна шүү», «Саша туслаад өгөөрэй» гэх маягаар ажлаа зохион байгуулж сурчээ.

«Новотел»-ийн адал явдал маань буцах замд давтагдана гэж яахин төсөөлөх билээ. Аравдугаар сарын 15-ны өдөр Нью-Йоркоос Москвад буун, танилууд болохоо шахсан дамжин өнгөрөх хэсгийн хэдэн хүүхэн дээр дахин ирвэл «Улаанбаатарын нислэг хоёр өдрөөр хойшилсон» тухай сонин дуулгалаа. Хамгийн гайхалтай нь, ямар шалтгаанаар бүтэн хоёр өдөр нислэг цуцалж буйгаа тоймтой тайлбарлачих албан тушаалтан энд олдоогүй юм.

**-Ачаагаа авч болох уу?**

-Ачаа тээшийн хэсэг тусдаа байдаг болохоор бид юугаар ч тусалж чадахгүй нь.

**-Долоо хоногийн өмнө үүгээр дайран өнгөрөх үед ачааны маань кодыг эвдэж,**



**онгичиж орхисон болохоор дахин хоёр хоноход тэндээс юу ч үлдэхгүй байлгүй дээ.**

-Та санаа зовох хэрэггүй. Тээш хадгалдаг газарт камер суурилуулдаг юм...

Нэг иймэрхүү үр дүнгүй яриа болсны дараа нөгөө л «Новотел» рүүгээ «харгалзагчаа» дагуулаад явж өгөв. Зам зуураа «Transfer deck»-д ажилладаг эмэгтэйтэй зовлонгоо хуваалцлаа. «Тиймээ Аэрофлотыг бүгд л ийм тийм гэж шүүмжилдэг. Би эх оронч хүн. Аэрофлотоо хамгаалдаг. Гэхдээ бод л доо. Би гэхэд сард 5000 рублийн /160 ам. доллар/ цалинтай. Ийм цалинтай хүмүүсээс илүү сайн ажиллахыг шаардаад ч нэмэргүй. Бухимдаад яах юм. Хоёр өдөр дороо л өнгөрнө» гэж тэр бүсгүй ярьсан юм. Ундууцсан голдуу зорчигчдыг буудал, Шереметьево хоёрын хооронд дагуулж явсаар байгаад хаширчихсан ч юм уу гэмээр харагдана. Эндхийн зохион байгуулалт нь өнөөгийн зорчигч тээврийн их урсгалд үйлчилж дийлэхээ больсныг, дэндүү гологдож буйг ажилтнууд нь өөрсдөө хүлээн зөвшөөрч байна. Дээр нь шинэ оросуудын шунал Шереметьевод алхам тутамд ханхална. Хүн суучих сандалгүй шахам атлаа ижилхэн бараа өрсөн, бие биеэсээ үл ялгарах дэндүү олон дэлгүүр зайгүй эгнэжээ. Бүгдийг еврогоор үнэлж, хүмүүсийн ая тухыг бодохоосоо илүү дамжин өнгөрч яваа зорчигчдын аргагүй хэрэгцээгээр бизнес хийж байна.

Аэрофлот нээлттэй хувьцаат нийгэмлэгийн 51 хувийг ОХУ-ын Засгийн газар эзэмшдэг. Тэгэхээр засгийн ажил Орос оронд бас нэг иймэрхүү замбараагүй байгаа гэсэн сэтгэгдэл эрхгүй төрнө. Тус компанийн өмнөө тавьдаг дөрвөн гол зорилгын нэгэнд, эх газарт ч, нислэгийн явцад ч өндөр чанартай үйлчилгээг зорчигчдооо үзүүлнэ гэсэн өгүүлбэр бий. Амьдрал дээр энэ сайхан уриа хоосон зүйл болж орхисныг Аэрофлотоор ниссэн олон хүн нотлох биз ээ. Америкчуудын дунд явуулсан нэг санал асуулгын тухай танил маань ярьсан юм. Хамгийн шилдэг үйлчилгээтэй авиакомпанийг нэрлэнэ үү гэсэн асуулгад Сингапурын авиакомпанийн нэр бичигдэж, харин муу үйлчилгээтэйгийн жагсаалтыг Аэрофлот тэргүүлсэн байх аж.

Зөвхөн Улаанбаатар руу нисдэг агаарын хөлгөө анхаардаггүй, тоодоггүй юм болов уу гэхээр бас өрөөсгөл дүгнэсэн болох гээд байна. Нью-Йоркийг зорин Аэрофлотоор есөн цаг ниссэн хүмүүс телевиз үзэж ч чадсангүй. Нөгөө л хөлдүү харилцаа анзаарагдсаар байлаа. Бас хараад байхад оросууд голдуу өөрийнхөө авиакомпанийг сонгодог юм байна. Харин гадаадын зорчигчид болж өгвөл Аэрофлотоос өөр сонголт хийхийг хичээдэг аж.

Тэвчээр шалгасан хоёр хоног шувтарч SU 563-т суудлаа эзэллээ. Монгол руу явж байгаа бид хэд онгоцондоо «хоолой моолойгоор» орсон ч үгүй. Угаасаа дэндүү цөөхөн зорчигч энэ нислэгийг сонгосон бололтой. Бага шиг онгоц руугаа автобусаар хүрч, хурдхан харихын мөн боллоо. «Чингис хаан» нисэх буудалд газардсаны дараа SU 563-ын экипажийнхан «Манайхыг сонгож үйлчлүүлсэнд баярлалаа. Суудал дээрх бүтээлэг болон дэр Аэрофлот компанийн өмч тул үлдээнэ үү» хэмээн эвлэгхэн зарлав. Манай онгоцонд лав тэр жижиг дэр харагдаагүй. За тэр дэр, тохь тух яамай. Гэртээ ирлээ.

2006 он

# ГАРЧИГ

## 1 БҮЛЭГ

### «ХАКУНА МАТАТА»

1. Эрхэм Ерөнхийлөгч өө, Монголын өдөр тутмын сонин.....	7
2. Б.Клинтон «Би л нэг...» гэсэн шиг орж ирлээ .....	9
3. Ядуус Мянганы чуулганаас юу хүлээж байна вэ? .....	11
4. В.Путин: Оросын улс төрийн томоохон хүчнүүд зөвшилцөлд хүрч чадсан .....	12
5. Филипп Киркоров Лос Анжелест «хий үзэгдэл» болжээ .....	14
6. Есдүгээр сарын 11 .....	16
7. И-мэйл .....	20
8. Онцгой үйл явдлын тухай материал бэлтгэх туршлага.....	23
9. Өөрийн сэдэв .....	26
10. Монгол Улс цөмийн зэвсгийн агуулах болох эсэхийг хэлэлцэнэ .....	27
11. Улаанбаатараас 32 километрт цөмийн зэвсэг хадгалж байна .....	29
12. Цөмийн хаягдлын бизнес ба Монгол Улсын гадаад бодлого .....	32
13. «Сайн» бизнес .....	35
14. Тони Блэйрийг түүх уучлахгүй .....	36
15. И-мэйл .....	39
16. Вьетнамын шинэ дайнд Монгол Улс «торгуулийн» ротоо илгээв .....	42
17. Хүнд битгий хэлээрэй .....	46
18. «Монголчууд биднийг хамгаалж чадна гэж үү?» .....	49
19. Иракийн мухардлыг хамгаалах Монголын дайчид .....	54
20. Дайн эхлээгүй биз .....	57
21. Америкийн индианууд .....	59
22. Америк бууз .....	61
23. Хакуна Матата .....	62
24. «Нью-Йорк таймс»-ын эрхлэгч Монголд ирэхийг хүсч байна .....	64
25. Кофи Аннан: Байгалийн бэрхшээлийн өмнө Монголын ард түмэн ганцаардах учиргүй .....	68
26. Кофи Аннан өнөөдөр Монголд ирнэ .....	71
27. Сурвалжлан бичихийн гайхамшиг .....	75
28. Чимээгүй аюул .....	77
29. Афганд хэн, юу үлдээсэн бэ? .....	84
30. -Афганы томилолт чамд юу өгсөн бэ? -Өөрийгөө ялсан .....	91
31. Алчууртай аялал .....	97
32. Сөөгөр тэнэгхэнийг Америк амьдралд бэлдсэн үү? .....	101
33. «Бөхөг» ихэр дэгдээхэйгээ мэддэг үү .....	105
34. 45 насандаа амьдралаа өөрчилж, бадамлянхуагаар утас ээрэх нь оптимизм мөн үү .....	109
35. Будааны боовноос «Өгөөж»-ийн авах санаа .....	112
36. Ерөнхийлөгчийн айлчлал гэнэтийн ашгийн татварын «хувь заяаг» шийдэж болзошгүй.....	114
37. Ерөнхийлөгч бөөрөнхий байр сууриа тодруулах нь .....	116
38. Луис Аяала ба шашны лекц .....	118
39. Еврогоор зээл авах хэрэг байна уу, Сайд аа .....	119
40. Н.Энхбаяр: Үдшийн Лондонгоор жаахан алхацгаах уу .....	122
41. Ерөнхийлөгчийн айлчлалын ёсорхуу хөшигний цаана .....	125
42. Аргагүйн эрхэнд сонгосон Аэрофлот .....	127

# II

## Эдийн засаг

# II

---

## бүлэг

Хөгийн санагдаж болох юм. Гэвч 1999 онд Лондонгийн металлын биржийн ханшийн мэдээллийг интернэтээс хэрхэн хайж авахаа мэддэггүй л байлаа. Берлин хотноо мөн онд зохион байгуулагдсан сургалтад оролцохоор эдийн засаг, бизнесийн чиглэлээр бичдэг орон орны сэтгүүлчид цугласан юм. Германы Олон улсын сэтгүүлчдийн сургуулийн / ПУ/ албан ёсны вэб сайтад тэр үед Монголын сэтгүүл зүйн талаар «Зүйрлэвэл, чулуун зэвсгийн үедээ яваа сэтгүүл зүй» хэмээн бичиж байлаа. ПУ-ийн жилийн ажлын тайланд бидний талаар «Сонирхолтой мэдээлэл, хүнд хэцүү сэдвийг хөндөн бичсэн материал сонинуудад нь тун хомс нийтлэгддэг. Эдийн засгийн сэдвээр ПУ-ийн Улаанбаатарт зохион байгуулсан сургалтад оролцсон сэтгүүлчид зах зээлийн эдийн засгийн талаар ямар ч ойлголтгүй байлаа. Жишээ нь тэд Монголын хөрөнгийн бирж ямар зарчмаар

ажилладгийг мэдэхгүй, түүнчлэн Сангийн сайдтай уулзаж асуулт тавих нь бараг хэзээ ч бүтэшгүй явдал гэж ойлгодог. Бид Сангийн сайдыг нь уриад хэвлэлийн хурал хийлгэхэд сэтгүүлчид ихэд гайхаж байлаа» хэмээн бичжээ.

Тус байгууллагын захирал Питер Пруферт Улаанбаатарт цөөн өдөр ажиллахдаа Монголын сэтгүүлчдийн мэдлэг чадвар тааруухан, ялангуяа зах зээлийн эдийн засгийн харилцааны талаар боловсрол тун ч нимгэн болохыг дор нь анзаарсан юм байж. 1999 оны долдугаар сарын бүгчим үдэш Берлинд анх уулзсан даруйдаа л Питер газар газраас цугласан сэтгүүлчдийг хөгжөөх маягаар дээрх «Монголын тохиолдлыг» хуучилсан билээ. Онигоо болгон олныг инээлгэх жишээнд манай сэтгүүлчдийг ийнхүү оруулсанд нь ялимгүй эвгүйцэв. Үүний хамт бас Питер гашуун боловч үнэнийг өгүүлж байгааг ойлгож л суулаа.

Сэтгүүл зүйн бакалавр болохоор дөрвөн жил суралцах хугацаандаа 250 цагт нь зөвхөн уран зохиолын хичээлээр балбуулсан МУИС-ийн «бүтээгдэхүүн» миний шар тэгэхэд хөдөлсөн юм. Эдийн засгийн онолын хичээлийг дээрхээс тав дахин бага буюу ердөө 50 цаг заалгасан байлаа.

Би зах зээлийн эдийн засгийн тухай «А» ч байхгүй, гэхдээ «Өнөөдөр» сонины Эдийн засаг, бизнесийн албыг хариуцдаг. Берлинд би өөрөөсөө ичиж, ингэхийнхээ хэрээр бас эрмэлзэн тэмүүлж билээ. Олон мундаг профессорууд эдийн засгийн лекц уншсан. Тэнд цугласан гадаадын сэтгүүлчдээс англи хэлдээ хамгийн муу нь би. Лекцийн 20-30 хувийг л ойлгож байсан. Үдэш болохоор том гэгч толь бичиг бариад өрөөндөө баахан сууна. Шумуул шунгинаж, бүгчим халуунд нозоорсон тэр үдэш В.Путинийг ОХУ-ын Ерөнхий сайдаар томилсон тухай Б.Ельциний шийдвэрийн талаар Берлиний радиогоор мэдээлж байсан санагдана.

Өмнө нь энэ сургалтад Монголоос Санжаасүрэнгийн Баяр, мөн Л.Номин гээд дандаа англи хэлэндээ ус цас болсон хүмүүс оролцсон юм байж. Яг сурвалжлагчийн хар бор ажил эрхэлдэг, бичиж нийтлүүлдэг хүмүүсээс анхны

томилолт надад оногдсон нь тэр байх. Дараа нь харин манай Х.Энхтуяа, Ч. Сумьяабазар нар явсан юм. Эдний араас мөн л сэтгүүлч андууд маань, залуус явж мэргэжлийн түвшнээ харьцуулж, сайжруулаад ирэх биз ээ. Хоёр сар номын дуу сонсон, Их сургуульд сурч мэдэж чадаагүй зүйлсийнхээ зах зухаас жаахан ч атугай дуулаад ирлээ. Толь бичиг тэвэрч суусных бага сага зүйлийг ойлгож, хамгийн гол нь эдийн засгийн сэдвээр эрээчих хүсэл оргилоод ирсэн билээ. Эндээс л аливаа редакц сэтгүүлчдээ байнга сургаж, аль нэг чиглэлээр мэргэшүүлж байхын ач холбогдлыг гадарлах болсон.

Ирмэгцээ «Ноён Брауны санаачлага холын Монголын төсвийг хөдөлгөв» нэртэй материал бичив. Б. Пүрэвдаш эрхлэгч маань тийм ч хайлсан тугалга шиг зантай хүн биш. Хатуу шаарддаг, өөрөө ясны сонины хүн. «Герман яваад чи их өсчээ» гэх үгийг Пүүжээ эрхлэгчээс сонсоно гэдэг томоо шагнал, их баяр. Урамтай гэдэг нь. Гадаад томилолт бүрийн дараа үр дүн харагдах ёстой гэж боддог. Сурвалжлагчийн ур чадварт төдийгүй редакцийн нэг өнгийн хэмнэлд шинэ, өөр амьсгаа нэмэх зүйл ганзагалж ирэхгүй л юм бол «гадаад явах» гэсэн гоё үгсийн утга учир юусан билээ.

Берлинд  
би өөрөөсөө  
ичиж,  
ингэхийнхээ  
хэрээр бас  
эрмэлзэн  
тэмүүлж  
билээ.

# Ноён Брауны санаачилга холын Монголын төсвийг хөдөлгөв

Лондонгийн металлын биржийн өглөөний арилжаа эхлэв. Хамгийн эхэнд алт худалдах, худалдан авах үнийн хэлцэл таван минут хэртэй үргэлжиллээ. Дараа нь дилерүүд хагас цаг гаруй завсарлага авч, өгсөн үнэдээ шинжилгээ хийх, хэлцлийн хэмжээгээ эргэн харах, улмаар баталгаажуулан үзэглэх ажил өрнөв. Арилжаанд орох хоёр дахь металл нь мөнгө. Дилерүүд мөн л таван минутын дотор үнэ хаялцаад хэлшлүүддээ шинжилгээ хийхэд гучин минут орчим зарцуулав. Хөнгөн цагаан, зэс, никель, хар тугалга удаа нь арилжигдав. Дилерүүд үдийн хоолондоо орж, хэсэг амсхийсний дараа дээрх металлуудын худалдаа дахин нэг удаа явагдлаа. Долоо хоног тутмын ажлын таван өдөрт ЛМБ-ийн амьдрал ийм маягаар нэг хэвийн юм шиг үргэлжилнэ. Гэвч тавхан минутын хэлцлийн дүнгээс шалтгаалан дэлхийн олон орны төсөв их, бага хэмжээгээр савладаг. Эдгээр хэлцлийн явцаас хамаарч улстөрчид, Засгийн газруудын рейтинг өгсч, уруулсаар ирэв.

Экспортын орлогынхоо гол хэсгийг зэс, алтны арилжаанаас бүрдүүлдэг монголчууд өнөөдөр «Найман шарга» гэхээсээ дутуугүй ЛМБ-ийн мэдээг анхаарах болжээ. Энэ мэдээнд шинжилгээ хийж чадвал «Найман шарга»-д валютын ханш хэрхэн өөрчлөгдөхийг урьдаас багцаалж чадна. Жаахан ахиулаад бодвол Засгийн газруудын хэтэвчний байдлыг «үзмэрдэх ч» боломжтой. Ийм төсөөллийг өгөх үечлэлийг эрдэмтэд хийжээ. ЛМБ-д худалдаалж буй үндсэн болон үнэт металлын ханш ойролцоогоор 10-15 жил тутамд хамгийн дээд, доод, дахин дээд цэгтээ хүрдэг аж. Энэ муруй шугамыг эрдэмтэд тооцож гаргахдаа алив ашигт малтмалын ордыг судалж илрүүлэн олборлох, шинэ ордууд нь ашгаа өгч эхлэх дундаж хугацаагаар багцаалсан байна. Олз хуримтлагдаж зах зээлд бий болох цэгээс нийлүүлэлт нь ханаж, үнэ доошлох, цаашид нөөц багасч дахин ханш өгсөх явц 10-15 жил тутамд давтагддаг гэсэн үг. Ийм үечлэлээр авч үзвэл өнгөрсөн онд зэс болон алтны дэлхийн зах зээлийн үнэ зэрэг унасан доод цэг таарлаа. Үнийн уналт энэ оны эхний сөн сарын турш үргэлжилсэн. Эдийн засгийн хямралын улмаас Азийн зах зээлд өнгөт металлын эрэлт багасч хуримтлал бий болсон нь үнэ урт хугацаанд унах нэг шалтгаан болжээ.

Их Британийн Сангийн сайд Гордон Браун өнгөрсөн тавдугаар сард нөөцийн алтнаасаа 25, 25 тонноор тасалж, дөрвөн удаа борлуулах гэж буйгаа зарласан нь шижир хэмээн бидний шүтдэг металлын ханшийг бүр унагав. Британичууд евро мөнгөн тэмдэгтийн орон зайд нэгдэхийн тулд Европын төв банкинд гишүүнээр элсэх учиртай гэнэ. Энэ банкны гишүүн больё гэвэл зохих хэмжээний валют эсвэл алтаа Франкфурт руу илгээх ёстой. Алт нь тэдэнд хайран, харин зарчихаад цаасан дэвсгэртээр хувь нийлүүлэх нь дээр санагдсан бололтой. Ингээд эхний ээлжинд Английн Төв банк 25 тонн алт худалдмагц нэг унци алтны дэлхийн зах зээлийн үнэ 257.6 ам.долларт хүрч доошлов. Хоёр дахь удаагаа мөн хэмжээтэйг арилжихад нь унци алт 255 ам.долларын ханштай боллоо.

Харин Монгол Улсын 1999 оны төсөвт, нэг унци алтыг 290 ам.доллараар борлуулахаар тусгасан байв. Ингээд унци буюу 31.1 грамм тутмаас 35 ам.доллар хасагдах болж төлөвлөгдсөн төсвийн орлогыг дундаллаа. Ноён Брауны санаачилга холын Монголын төсвийг хөдөлгөж байх юм. Гадаад шалтгааны

**Харин  
Монгол Улсын  
1999 оны  
төсөвт нэг  
унци алтыг  
290  
ам.доллараар  
борлуулахаар  
тусгасан байв.**



улмаас үнэ ийнхүү үсчихэд харьцангуй бага цохилт авахын тулд авсаархан төсөв нь алт, зэс зэрэг экспортын цөөн бүтээгдэхүүнээс хамаардаг орнуудад дотоодын давхар хамгаалалт хэрэгтэй. Тэгвэл манай Засгийн газар алтны үнийн уналт доод цэгтээ хүрсэн жил ямар хамгаалалт хэрэглэснийг санацгаая. Өнгөрсөн жилийн эцсээр алтны экспортын татварыг арван хувь болгож өсгөсөн. Энэ нь хамгаалалт бус, бүр давхар цохилт болсон юм. Мөн онд манайд 122 аж ахуй алт олборлож байсан бол ганц жилийн дараа тэдний тоо 80 болж цөөрөөд байна. Канад зэрэг орны хөрөнгө оруулагчид Монголын Засгийн газрын хоосон амлалтад хууртсанаа гайхаад явцгаасан гэж алтны бизнес эрхлэгчид ярьж байв. Ямар амлалтын тухай тэд өгүүлэв ээ?

**Шинэ мянганы хоёр дахь сонгуульд ялагсад / 2004 он/ манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ харьцангуй өсч тогтворжсон үед Засгийн эрхэнд байх нь. Гэхдээ тэд зэсийн хэрэглээний ирээдүйг бодолцоход гэмгүй.**

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт 1997 оны хавар Улаанбаатарт болсон билээ. Уулзалтын индрээс гадаадын хөрөнгө оруулагчдад сайн нөхцөл, хүнд сурталгүй дардан зам амласан. Гэвч энэ амлалт талаар болжээ. Дэлхийн зах зээлд үнэ нь унаж буй металлыг тэртээ Монголоос, тэгэх тусмаа арван хувийн татвартай олборлох бизнест гэрэлт ирээдүй харагдаагүй нь мэдээж. Өөр шалтгаан ч бий. Ашигт малтмалын тухай хуульд үндсэн ба шороон ордуудыг ялгаж тусгаагүй юм. Үндсэн ордоос алт олборлоход уул геологийн хүнд нөхцөлд ажиллах машин техник гээд хамаагүй их хөрөнгө, цаг, хүч зарцуулдаг. Үндсэн орд ашиглах хөрөнгө оруулалтыг гадаадын томоохон компаниуд л хийж чадах юм. Тэгвэл шороон ордын хувьд харьцангуй хялбар, зөөлөн өнгөн хөрсийг хуулаад угаах маягаар алтаа ялгана. Хуульдаа эдгээр технологийг ялгаж салган тусгах шаардлага гарч байна. Ажлын далайцынхаа хэрээр урт хугацаанд тодорхой хэмжээний орлого өгөх боломжтой учир үндсэн ордуудын үйл ажиллагаа улсын төсөвт илүү унацтай. Эрдэмтдийн урьдчилан таамаглаж байгаагаар ЛМБ-д худалдаалдаг гол металлуудын ханш 2000 онд нэмэгдэж, өнгөрсөн хоёр жилийн дунджаас өсөх төлөвтэй. Ирэх жилийн сонгуульд ялах улс төрийн хүчний хувьд энэ нь аятайхан мэдээ. Үнийн таатай байдал бүрдвэл хөрөнгө оруулагчдыг үндсэн ордын хайгуулын ажилд татах нөхцөл бэлтгэж өгөх шаардлагатай болно.

Харин шинэ мянганы хоёр дахь сонгуульд ялагсад / 2004 он/ манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ харьцангуй өсч тогтворжсон үед Засгийн эрхэнд байх нь. Гэхдээ тэд зэсийн хэрэглээний ирээдүйг бодолцоход гэмгүй. Никелийн үнэ энэ онд 12 хувиар нэмэгдсэнтэй харьцуулахад зэсийн хувьд ийм огцом өсөлт цаашид ч ажиглагдахгүй байж магад. Зэс утсаар цахилгаан дамжуулах нь өртөг ихтэй учир хөнгөн цагааны хайлш, шил зэргээр орлуулах технологи шинэ зууны эхний арван жилд хүчтэй нэвтрэх бололтой. Ер нь зэсийг өөр материалаар орлуулах боломж 35 хувьтай гэсэн тооцоог судлаачид хийжээ. Энэ нь бусад металлыг орлуулах боломжийг бодвол өндөр үзүүлэлт. Ийм ирээдүйг анзаарсан дэлхийн томоохон зэс үйлдвэрлэгчид хоорондоо нэгдэх үйл явц өнөөдөр ажиглагдаж байна. Тиймээс «Эрдэнэт» үйлдвэрийн хувьчлал, цаашдын үйл ажиллагаанд дэлхийн томоохон компаниуд оролцож ч болох юм.

# Төсөв гэгч том үгний цаана

Сангийн сайдад уур хүрээд болдоггүй ээ. Жил жилийн намрын сүүл сард төсөв хэлэлцэх үеэр аль ч Засгийн газрын, ямар ч мундаг Сангийн сайд байсан дандаа уур хүрээд байх боллоо. Ирэх оны төсвийн төслийг Их хурлаар хэлэлцүүлж байнаа гээд л таг чиг. Удалгүй, сар орчмын дараа санал нэгтэй баталлаа л гэнэ. Төсвийн хэлэлцүүлэг гэдэг зөвхөн УИХ, Засгийн газрын танхимд хамаатай биш ээ. Татвар төлөгч иргэн болгонд танилцуулах ёстой баримт бичиг. Тиймээс энэ хэлэлцүүлгийг аль болох нээлттэй хийгээсэй гэж олон нийт хүсдэг. УИХ-ын 76 гишүүний үзэмжээр төсөв хуваадаг болчих вий гэж сэтгүүлчид эмзэглэн бичдэг. Ялангуяа эдийн засгийн чиглэлээр бичдэг сурвалжлагч бид бол төсвийн төслийг хэвлэсэн бяцхан эмхэтгэл олж авах их аянд юуны түрүүнд мордох хэрэг гарна даа. Гэтэл тэр төслөө ердөө 100 гаруйхан хувиар хэвлэчихээд Сангийн яамныхан харамлаад эхэлнэ.



Төсвийн төсөлд туссан тоо бүрийг материалдаа багтаах гэж зүтгэх хэрэггүй. Хэдхэнийг нь сугалаад ав. Тэдгээр баримт дээр ажилла. Харьцуул. Хандлага гарга. Энэ чинь эрдмийн зэрэг горилсон айхавтар том бүтээл биш, энгийн иргэд уншаад шууд ойлгох танил үгс, талх тарианы тухай яриа шүү дээ.

Уг нь аль болох олон хувийг тарааж, вэб сайтдаа байрлуулан нийтээр хэлэлцүүлэх ёстой хуулийн төсөл шүү дээ.

Өнгөрсөн есөн жилийн намар бүр төсвийн төсөл олж авахаар сураглаж, ингэх тоолондоо Сангийн сайдуудад уур хүрч байлаа. Төслийг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэх учиртай гэж цөөнгүй бичиж, сайдын сонорыг дэлдсэн. Хүмүүс өгсөн мөнгөнийхөө араас ядаад сонирхдог сэтгэлгээнд суралцах ёстой биш гэж үү, Сайд аа.

Хэлэлцүүлгийг нээлттэй явуулж өгнө үү. Улс төр, эдийн засаг гээд аль ч чиглэлээр бичдэг сэтгүүлчдэд уриалах зүйл бас байна. Төсвийн төсөл дэх иргэдэд ойлгомжгүй, мэргэжлийн гэх «хатуу» үг өгүүлбэр болгоныг уншигчдадаа «орчуулаад» хүргээрэй.

Тоо баримтыг материалдаа «нүцгэн» чигээр нь битгий ашиглаарай. Ирэх онд хүрэхээр төлөвлөсөн үзүүлэлтийг өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулбал хамаагүй ойлгомжтой. Цалингийн нэмэгдлийг мах, сүүний үнээр харьцуулан илэрхийлбэл хүртээмжтэй мэдээлэл



болно. Тоо бүрийн ард хандлага бий. Түүнийг ажиглан, өөрийн тооцоог гаргаж тавибал сэтгүүлч ажлаа хийжээ гэсэн үг. Хүнд сэдвийг энгийн , ойлгомжтой хэлнээ хөрвүүлэх их хөдөлмөрт эдийн засаг, бизнесийн чиглэлээр бичдэг сэтгүүлч болгон нухлагддаг. Төсвийн төсөлд туссан тоо бүрийг материалдаа багтаах гэж зүтгэх хэрэггүй. Хэдхэнийг нь сугалаад ав. Тэдгээр баримт дээр ажилла. Харьцуул. Хандлага гарга. Энэ чинь эрдмийн зэрэг горилсон айхавтар том бүтээл биш, энгийн иргэд уншаад шууд ойлгох танил үгс, талх тарианы тухай яриа шүү дээ.

# Сайхан төсөв батлагдана

Шинэ теорем хэлж өгье. «Дөрвөн жил тутамд төрийн албан хаагчийн цалин 25 хувиар нэмэгдэнэ». Мөн «Дөрвөн он тутамд сайхан төсөв батлагдана». Тэр өндөр жил нь 2004 онд тохиож буй юм. Ч.Улаан сайд арванхоёрдугаар сарын 1 хүртэл ер уурлахгүй ээ. Учир нь тэр УИХ-ын сонгуулийн өмнөх жилийн төсөв батлуулах гэж байна. Их зөөлхөн, дотно төсөв гараад ирэх нь. Тэтгэврийг 20 хувиар нэмнэ. Төрийн албан хаагчдын цалинг өсгөөрэй, эмнэлгийнхнийхийг бол бүр 41 хувиар шүү. Ер нь нийгмийн салбарын зардалд нийт мөнгөнийхөө 53 хувийг зарцуулъя. Боловсролын сайдын мэдэлд «юм» өг, өг. Салбарынх нь зардлыг 12 тэрбумаар өсгөж төлөвлөлөө. П.Нямдаваа сайд хаана байна. Түүнд бас нэм, нэм.

Ингэсээр Монгол Улсын Төсвийн тухай хуулийн төсөлд зардал данхайсан харагдана. 636 тэрбум төгрөг. Ч.Улаан Токиогоос энэ мөнгөний бараг талыг олоод ирэх нь. Хилийн чанадыг барагтай бол зүглэх биш дээ, дэлхийн Сангийн сайдууд. Харин манай сайд бол арай өөр нөхцөлд ажилладаг. Тэр төсвийн эх үүсвэрийн үлэмж хэсгийг гаднаас хардаг тул Хандивлагчдын уулзалтыг балжинням, дашням бүхий өдөр нээгдээсэй хэмээн шаналах шахна. 335 сая ам.доллараар бидэнд туслах боллоо. Гэхдээ хашир хандивлагчид, ялангуяа америкауд лоббидсоор зээл биш, буцалтгүй тусламж болгон өнгө зарчмыг нь өөрчилж орхилоо. Санхүү, эдийн засгийн яамныхан сайдаа харуулдаж, Их хурлынхан болохоор хурдлаасай, төсвийн гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлгийг сүнгэнүүлээд баталж орхиё гээд хүлээнэ. Хэлэлцэх, тохиролцох гол асуудлаа энэ сарын дундуур ярилцаад шийдчихсэн тул давгүй ээ. Тэртээ 1999 оны шинэ жилийн өмнө бас иймэрхүү амлалтууд давтагдаж байсан нь сонин. Эвслийн буюу Р.Амаржаргалын танхим төсвөө хэлэлцүүлж, Я.Очирсүх сайд «Төрийн албан хаагчийн цалинг 2000 оны эхний өдрөөс 25 хувиар нэм, нэм» гээд байлаа. Дөрвөн жил тутамд амлалтын аятайхан төсвүүд батлагдах болж. Сонгуулийн өмнөх, бөмбөлөгтэй төсөв хэмээн түүнийг өхөөрдье. Хуримласан хосууд өнгө өнгийн бөмбөлөгтэй гоёсон машинд суугаад явах нь сэтгэл хөдлөм харагддаг даа. «Баярын» төсвийн сул муу тал нь зарлага дэндүү өндөр үзэгдэх юм. Гэвч цаг цагийн Засгийн газрууд сонгуулийн наана ийм «бөмбөлөгтэй» тооцоог өөрийн эрхгүй хийж орхино.

Ирэх жил Монгол Улс ямархуу орлого олох юм бол. Нийгмийн салбартаа зориулан их мөнгө үрэх болохоор татвар нэмэгдэж таарах биз. Гэвч, үгүй шүү. Бизнесийнхнийг сонгуулийн өмнөхөн уурлуулах зоригтон байна уу? Харин ч ашгийнхаа 40 хувийг татварт өгдөг том аж ахуйнханд «баярын» төсөв гэрлэн чимгээ анивчуулж харуулав. Тэдний ачааг хөнгөлж, ирэх оноос 30 хувийн татвар авна. Яагаад гэвэл эдгээр цөөн компани татварын нийт орлогын 95 хувийг өгсөөр ирсэн. Одоо бага зэрэг амсхийг. Тэгвэл нөгөө талд нь жижиг, дунд бизнесийнхэн нөхөөс хийх юм болов уу? Жижгүүдэд татварын орлогын ердөө таван хувь оногддог. Тэднийг ч бас гомдоохгүй гэнэ. 15 хувийн татвараа өгч сурснаараа л үргэлжлүүлэн төлөөрэй. Нэг л сайхан. Урт амьсгаа авмаар ч юм шиг санагдана. Импортын тамхинаас, угсарсан автомашинаас татвар нэмж авах гэснээ больж орхилоо. Шинэ төрлийн татвар гарч ирсэнгүй. Үндсэн хөрөнгөнөөс «юм» авах цаг болсон гэж хэсэг ярилцаж байснаа сонгуулийн өмнөх өвөл учир азнав бололтой. Өнтэй, өндөр жил айсуу юу даа.

2000 оны өвөл буюу сонгуулийн дараа бол тун эвгүй байсан. Тэгэхэд Ч.Улаан сайд «Монгол орны өнөөгийн нөхцөлд ирэх оны хувьд нийгмийн хамгааллыг туйлын зорилгоо болгох, нэгдүгээрт тавих хөрс алга» гэж хэлдэг

**Дөрвөн жил  
тутамд  
амлалтын  
аятайхан  
төсвүүд  
батлагдах болж.  
Сонгуулийн  
өмнөх,  
бөмбөлөгтэй  
төсөв хэмээн  
түүнийг  
өхөөрдье.**

байлаа. Тэр ууртай хүн шиг санагдсаныг яана. Татварууд шинээр бий болж, реформ хийж байна гэж сайд сануулсан юм. Магадгүй өмнөх намар нь Я.Очирсүхийн батлуулсан хулхи төсвөөс болж уурласан биз. Эвслийнхний тэр үед санал болгосон «баярын» төсвийг дахин тодотгох гэж Хувьсгалт намын Засгийн газар наадмын өмнө зовсон билээ. Энэ удаа ч үйл явдал давтагдах вий гэж төрийн албан хаагчид болгоомжилж байна. Төсвийн албан хаагчдын цалинг Р.Амаржаргалын амласан 25 хувиар нэмэх боломж улсын сан хөмрөгт байгаагүй юм. Эргэж уулзахгүй нүүр шиг ийм хоосон тооцоо хэнд хэрэгтэй байсан юм бол. Тэгвэл энэ удаа ч яг дөрвөн жилийн өмнөх шиг «бөмбөлөгтэй» тооцоо хийж байна. Ирэх оны хоёрдугаар сарын 1-нээс нэмж өгөх цалингийн сан Н.Энхбаяр, Ч.Улаан нарт байгаа юм болов уу.

Улс орны эдийн засаг 2000 оныхоосоо илт дээрдсэн болохоор МАХН-ын Засгийн газар «Тангараглая, цалин, тэтгэврийг нэмнэ» гээд байгаа бололтой. Дөрвөн жилийн өмнөхөөсөө өнөөдөр амьдрал тань илт сайжирсан байгаа биз дээ. Худлаа гэвэл наад ганган гутлаа хараач гэх яриа ид моодонд ороод байна. УИХ-ын сонгуулийн сурталчилгааны өнгө аяс ийм янзтай сонсогдож эхлэв. Гэвч шинэ гутлаа иргэд цалингаа цуглуулж авсангүй. Тийм ч болохоор хүмүүс улс төр бага сонирхож, 2004 оны Төсвийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг бүр тоох шинжгүй. «Хоёрдугаар хэлэлцүүлэг хэзээ дууссаныг мэдэх үү?» гэж гудамжинд таарсан танилаасаа асуугаарай. «Юун хэлэлцүүлэг, охиноос ирэх хэдэн долларыг л хүлээж байгаа шүү» гэж хариулах биз.

Он шувтарч, олз гарзаа бүгдээрээ тооцож буй цаг. Ирэх хавар хүүдээ хүрэм авна, гэртээ засвар хийнэ гээд өрх болгон өнгө өнгийн төсвөө багцаалж байгаа үе. Компанийн алтан менежерүүд 2004 оны бизнес төлөвлөгөөгөө төсөөлж эхэлсэн. Хэвлэлийнхэн хүртэл «Сонгуулийн жил реклам сурталчилгааны орлого ахиухан байх учир...» гэх зэргээр давхар бодол тээж яваа. Улсын төсөв ч тэр аяараа бөмбөлөг биш нь лав. Иракт ажиллаж буй дайчдад зориулах хөрөнгө мөтийн шинэ зарлагууд харагдаж байна. Эдүгээ баглагдахаа хүлээж буй баримт бичигт «Зарлагын үзүүлэлт нь орлогын өсөлтөөсөө түрүүлж явна» гэсэн үнэлгээг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Үндэсний аудитын газрын мэргэжилтнүүд хийжээ. Зарлага хэмнэх, орлого нэмэх хувилбаруудыг ч тэд хэлж өгчээ. Дээр нь дэлхийн зах зээл дэх алт, зэсийн ханш дажгүй үзүүлэлттэй харагдана. Бүр 1995 оны П.Жасрайн Засгийн газрын үеийнх шигээ график дээр алтны үнийн муруй амжилтын цэг дээр очоод байна. Нэг унци алт 400 ам.долларт дөхөв. Газрын тосны олборлолтоос Монгол Улс муугүй ашиг олох цаг хаяанд ирлээ. Гэвч төсвийн төсөлд Санхүү, эдийн засгийн яамныхан их л хашир хандаж, зарим боломжит орлогыг «дарж» тооцоолсон бололтой юм. Хоёр дахь хэлэлцүүлгийн явцад газрын тосноос олох ашгийг 300 сая төгрөгөөр нэмэх, мөн зэсийн баяжмалыг төлөвлөснөөс ялимгүй үнэтэй зарах бололцоо бийг УИХ яамныханд «илрүүлж» өглөө.

Түүнчлэн, Хувьсгалт нам сонгуулийн мөрийн хөтөлбөртөө онц дүн тавиулахын тулд төсвийн хөрөнгө нэхдэг байгууллагын тоог цөөлж, хэмнэсэн мөнгөө нийгмийн хамгаалал руу хаяхаар шийдэв. Төрийн мэдлийн их, дээд сургууль, коллежууд төсвөөс юу ч бүү горьдоорой. Одоо бие даагаад, өөрийгөө санхүүжүүлэх цаг болсон.

Гэсэн ч сонгуулийн өмнөх жилийн төсөв нэг л сонирхолгүй. Ирэх зуны эхэн сар гэхэд аль нам ялаад гараад ирэхийг төсөөлөх аргагүй. Тэгээд нөгөө Ч.Улаан сайд «Я.Очирсүх надад хоосон цүнх шилжүүлсэн шүү» гээд татварын бодлогоо чангалж орхисон дөрвөн жилийн өмнөх шиг явдал давтагдвал яана. Төсвийн хэлэлцүүлгийн үеэр төрийн байгууллагынхны зардлын тухай баахан яриа өрнөж, хамаг хөрөнгөө тийш цацдаг болохоор иргэд ч сонирхох урамгүй



болжээ. Түшмэдийн орон нутагт ажиллах томилолтын тооцоо өсчихсөн харагдана. Бодвол сонгуулийн сурталчилгаандаа мордох биз. Нийт ажил эрхэлдэг хүмүүсийн бараг 20 хувь нь төсвийнхөн. Тэдний зардлыг татвар төлөгчид барагдуулдаг. Хариуд нь иргэд хүнд сурталтай, хөшүүн, чанаргүй үйлчилгээг төрөөс авдаг шүү дээ.

Ирэх оны зөөлөн төсөв ойрын жилүүдийн татварын дарамтыг зөгнөнө гэдгийг сонгогчид эрхбиш гадарлах болжээ. Тиймдээ ч хэлэлцүүлгийг сонирхон телевизийн өмнө шимтэн суухгүй. Тэрний оронд харин мөнгөн гуйвуулгын шинэ үйлчилгээний тухай яривал өөр хэрэг. Гаднаас ирдэг хэдэн доллараар л өнөөх шинэ гутлаа авдаг шүү дээ. Төрийн албан хаагч цалингаа 25 хувиар нэмүүлээ гээд юухан хийж чадах вэ? Өнөөдөр манай улсын төсөвт бодитой хүчин зүйл болсон гадаадаас орж ирж буй валютын урсгалыг тооцохгүйгээр эдийн засгийн нөхцөлийг хэрхэн бодитой төсөөлөх билээ. Албан бус тооцоогоор 200 мянган монгол хүн хилийн чанадад ажиллаж байгаа гэж Үндэсний статистикийн газрын дарга П.Бямбацэрэн өгүүлсэн. «Эдгээр хүмүүс манай дотоодын нийт бүтээгдэхүүний 10-20 хувьтай тэнцэх хэмжээний валютыг ганц жилд нааш нь шилжүүлдэг» гэж Сангийн сайд асан П.Цагаан тооцоолж байна. Тэгвэл Санхүү, эдийн засгийн дэд сайд А.Энхтайван «Дотоодын зах зээлд 300 гаруй тэрбум төгрөг сул эргэлддэг» гэсэн юм. Тооцоонд ороогүй ийм их хэмжээний валют инфляцийг тогтвортой барихад чимээгүйхэн тусалж байна. Инфляцийг их мэргэн бодлогоороо зохицуулаад байгаа гэсэн магтаалыг түшмэдүүд харин өөртөө хаяглах аж. Магадгүй тийм болохоор далд эдийн засгийг судлахаар томилогдсон хүмүүс эрч сул ажилладаг биз. Далд эдийн засгийг судлах ажлын хэсгийн хэрэглээнд зориулж төлөвлөсөн хөрөнгийг төсвийн хэлэлцүүлгийн үеэр хасч орхисныг анзаарсан хүн байгаа болов уу. Үндэсний статистикийн газрын хүсэлтээр байгуулсан уг ажлын хэсэг олон газраар явж, төрөл бүрийн судалгаа хийх учиртай байлаа. Тэр ажлын зардал батлагдсангүй. Бодвол, Засгийн газар инфляцийг итгэлтэй барьж байгаа гэх рекламьг цаашид ч үргэлжлүүлэх сонирхолтой биз. Монголчуудын Монголдоо илгээж буй хөрөнгө оруулалтыг анхааралдаа авч, эдийн засгийн үзүүлэлтүүдээ бодитой гаргахыг оролдох цаг болжээ.

**Учиргүй төвлөрсөн, сонирхолгүй төсвийг томоотой сайхан баталж байна. Харин тэрхүү тооцооны бодит алдагдлын тухай бид сонгуулийн дараа, наадмын наана хийх тодотголын үеэр сонсох байх аа.**

Хандивлагчдын өгөх мөнгийг бид ялангуяа төсөв батлах үеэр тод томруунаар зарласаар байна. Гэхдээ буцалтгүй тусламжаар юу хийснээ Засгийн газрууд иргэддээ мэдээлж тайлагнадаггүй болохоор хүмүүс тэр туслалцааг аяндаа тоохоо больсон. Явсаар улсын төсөв хүртэл иргэнд нь хүртээлгүй санагдана. Санхүү, эдийн засгийн яамнаас Төсвийн тухай хуулийн төслийг эмхэтгэж хэвлүүлсэн гэнэ. Зуу хүрэхгүй хувиар тун цөөхнийг хэвлэж, улсын хөрөнгийг хэмнэжээ. УИХ-ын гишүүдээс өөр бусад нь олж үзэх боломжгүй тэр баримт бичиг ч хэнд хүртээлтэй болж орхив оо. Төсөвт хүртэл ардчилал баймаар. Учиргүй төвлөрсөн, сонирхолгүй төсвийг томоотой сайхан баталж байна. Харин тэрхүү тооцооны бодит алдагдлын тухай бид сонгуулийн дараа, наадмын наана хийх тодотголын үеэр сонсох байх аа.

Батлагдаж байж үнэн болбол теорем гэдэг дээ. Туршлагаас харахад дөрвөн жил тутамд цалин нэмэгдэхгүй байж мэдэх нь. «Олонх болж төсөв баталсан хүмүүс засгийн эрхээс хэрэв буувал дөрөв биш, найман жилийн дараа цалин 25 хувиар нэмэгдэнэ» гэсэн шинэ гаргалгаа бас бий шүү.

# Төсөвт туссан нүцгэн тоо ба түүнээс улбаалах улстөржсөн явдлууд 2006 онд

УИХ-ын гишүүд хоёр зүйл дээр санал нэгджээ. Эхнийх нь 2006 оны төсвийн төсөл «юмгүй», уйтгартай, ер нь л шал дэмий гэж бүгдээрээ голов. Удаах нь 10 сая төгрөгийг 76-гаар үржүүлээд, ирэх жилийн зарлагын жагсаалтад өөрсдөдөө зориулан шингээлээ. Улс төрийн намуудын тухай хуульд нэгэнт өөрчлөлт оруулсан болохоор ичих юм алга. Улсын төсвөөс хуулийн хүрээнд идэж ууж болно гэсэн үг.

Арванхоёрдугаар сарын 1-ний өдөр хүртэл эргүүлж тойруулан гоочлох нэг нэг ногоон ном тэд сугавчилж явна. «Шинэ юмгүй, уйтгартай, ер нь л шал дэмий» гэх тодотголууд уг нь 2006 оны төсвийн төсөл болоод Үндсэн чиглэлд бус, энэ Их хурлын ажил хэргийн өнгө аясыг илэрхийлэх дүр зураг юм. Татварын хуулиа шинэчилж чадаагүй тул төсөвт «гоё, гоё» санаа яаж тусах билээ. Арван хэдэн жил шинэчлээгүй Татварын тухай багц хууль өнөөгийн бизнесийн орчин, эдийн засгийн хөгжлийн хөрсөнд хугацаа нь дууссан бордоотой ижил «үйлчилж» байна.

УИХ-ын Сонгуулийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэг яст мэлхийний хурдаар хөдөлж ядна. Яая гэхэв, мөлхөө өөрчлөлтийн өмнө Намуудын тухай хуульд хийх нэмэлт намуудын өөрсдийнх нь захиалгаар үсрээд орчихов. Ингээд 760 сая төгрөг улсын төсвөөс жил бүр хоосон зарлагдах хуульчилсан дээрэм ёсоор боллоо. Дээр нь засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийн хэлэлцүүлэг зуны эхэн сард амьсгал хураажээ. Энэ бүхний эцэст нөгөө 76 гишүүн 4-5 сумын дайны жижигхэн тойрогтоо хөрөнгө оруулалт нэхсээр арванхоёрдугаар сар гаргах нь. Арайхийн нэг төслөө баталсан ч араас нь Татварын багц хуульд өөрчлөлт оруулах ажил ундрах вий. Тэгээд татварын орлогоос сох дутах 40 гаруй тэрбумын цоорхой гарахаар нь юу яагаад... Яахав дээ, төсвийг нэхэж тодотгох хэрэг гарнаа гэсэн үг. Нэг иймэрхүү зунгааралдсан бантангийн жор үргэлжилнэ. Энэ УИХ-аас их юм хүлээсний шанд ядаж төсвөө хугацаанд нь баталчихаасай гэх аргаа барсан хүлээлттэй л хоцров. Нийгмийн амьдралд тулгамдаад байгаа дорвитой шинэчлэлүүдийг хийх эрч хурд дутсан Их хурлын ажиллагаа өөрөө «уйтгартай, шал дэмий» болсныг 2006 оны төсвийн хуулийн төсөлд тольдож, байгаа царайгаа тэндээс үзмээр юм.

Н.Алтанхуяг сайд зангиа, цүнхээ хэд ч солиод түүний мэдэл дэх хөрөнгийн бололцоо, зардлын жагсаалт өнгөрсөн оныхоос, Ч.Улаан сайдын үеийнхээс ч онц ялгарахгүй. Сангийн сайдын цүнхэнд яваа төслийг эрс шинэчилж гэвэл гол хуулиуддаа өөрчлөлт хийх гэж ханцуй шамлавал дээрсэн. Назгайрал, хэт улстөржилт нийгмийн бухимдлыг ар араас нь дагуулж мэдэх юм. Юутай ч, 2006 оны төсвийн төслийн өнгө дээр ирэх жилийн ая занг илэрхийлж болмоор.

## ТӨСВИЙГ ТАЙЛЖ УНШИХ ТАМ

Том ногоон ном жил жилийн өдийд эрэлт ихтэй, олдоц ховор бараа болдог. Төсвийн төслийг цөөн хувиар хэвлээд, ордон хавиар «чухал» хүмүүст тараадаг зуршил уламжлал болжээ. Намар бүр л энэ номыг эрж суран байж олохдоо «Төсвийг олон нийтэд хүртээмжтэй хэлэлцэх» тухай үлгэр давхар сонсдог. Сангийн яам энэ товхимлоо дугтуйд хийгээд ядаад хэвлэлийн редакциудад

илгээчихдэг бол нөгөө олон нийт нь төсвийн хэлэлцүүлгийг сонирхох, оролцох магадлал жаахан ч гэсэн нэмэгдэнэ дээ. Нууцын зэрэглэлд орох шахсан ногоон товхимлыг дэлгэвэл тайлж унших явдал ундрах вий. Сайдуудын мэдэлд тэрбум тэрбумаар нь төсөв хуваажээ. Үүнийг багц гэж нэрлэх агаад Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу ингэж хуваарилах нь хамгийн сонирхолтой атлаа битүү асуудал болчихов. Зүй нь, төсвийн хэлэлцүүлэг хэмээх энд тэндээс тоо зулгаасан, «сум дундын» чанартай маргааны оронд хуваарилсан хөрөнгийг сайдууд юунд, яаж зарцуулахаа яривал манай парламент арай далайцтай, сонирхолтой ажилтай байх биз.

УИХ дахь ажил хэргийн уур амьсгал жижгэрч жол болсны нэг нотолгоо нь «АН-ын гишүүн сайдуудын төсвийн багц МАХН-ын гишүүн сайдуудынхаас их» байгаа тухай гоморхол. Угаас нийгмийн чиглэлийн яамдад түлхүү мөнгө хуваарилдаг өнөөх л арваад жилийн загвараас Н.Алтанхуяг өөрийг сэднэ гэх биш дээ. Хоосон улстөржилт хоёрыг дөрөв болгон сүүдэртүүлж байна.

### ӨРИЙН ДАРАМТ

2006 оны төсвийн төслийг муулахаасаа илүү ирэх жил амь амьжиргаа минь ямархан байхыг төсөөлөхийг оролдъё. Гадаад, дотоод өрийн дарамт жил ирэх тусам нэмэгдэж байна. Дэд бүтэц, эрчим хүчний салбарт ерээд онд авсан зээлийн хүү дээр үндсэн өрийн төлбөрүүд жин нэмсээр. 2006 онд 71.6 тэрбум төгрөг төлж, цаашид энэ дарамт улам хүндэрнэ. Зээл тусламжийн гэрээ хэлцлийг еврогоор хийж буйг шүүмжилсэн үг хэл УИХ-ын танхимд олзуурхууштай сонсогдов. Дээр нь дотоод өр буюу төрийн байгууллагуудын хоорондох авлагын сүлжээ улам бүр торлосоор байна.

**Хоосон  
улстөржилт  
хоёрыг дөрөв  
болгон  
сүүдэртүүлж  
байна.**

### МӨНГӨНИЙ БОДЛОГО

Мөнгөний бодлого урсгалаараа явж буй мэт санагдана. Монголбанк, Үндэсний статистикийн газар инфляцийн хэмжээг хэзээ ч үнэнээр нь зарладаггүй. 2005 оны эхний хагаст 12 хувьтай байлаа гээд таг чиг. Инфляц 15 хувиас дээш гарвал эдийн засагт бодит аюул нүүрлэдгийг шинэ цагийн монголчууд мэдэх болжээ. Хэрэглээний сагснаас мах, махан бүтээгдэхүүнийг хасаж тооцоод 12 хувь болгон дарж яваа болохоор өдийд «жинхэнэ» инфляц хэд хүрснийг хэлэхээс бүгд л зайлсхийх нь аргагүй биз ээ. 2006 онд баримтлах мөнгөний бодлогоо Монголбанк тодорхойгүй томъёолж, бензин шатахууны импортын үнээс хамаарна гэх шинэ итгэлцүүр бодож олжээ. Нефть бүтээгдэхүүний үнэ дахин өсвөл инфляцийн жолоог алдах тухай учирлал ч юм уу гэлтэй.

Ашгүй харин Г.Батхүү сайд Москвагаас нааштай амлалт дайж ирж. «Роснефть»-ээс шатахуун шууд импортлох, нефть бүтээгдэхүүний Монголын импортод Оросын тал харьцангуй тогтвортой үнэ барих тухай ярилцаж байхаар тохиролцжээ. Одоогоор яриа хөөрөө төдий зүйл боловч цаашид монголчуудын амьдралд нэн чухал тохиролцоо юм. Ирэх оны хэрэглээний сагснаас гурил, гурилан бүтээгдэхүүнийг Үндэсний статистикийн газрынхан хасаж тооцох нь дээ гэсэн таамаг өнөөдөр бугаад байна. Энэ намар тааруухан ургац авсан, үр тариа импортлохоос аргагүй тухай сураг ийм хар дагуулав. Мах, гурилын үнэ өсвөл манай, танай гэдэг айл яах билээ. Инфляц 2006 онд тавхайгаа гялалзуулаад гүйцэгдэлгүй зүгтчих вий.

## ТАЯГНЫ АМТ

Төрийн ордонд байнга орж гардаг хүмүүс 2006 онд таягны амт байн байн үзэж магадгүй. Хэрэглээний сагсны орц дээр өгүүлснээр хэцүүдвэл хөгшдөд хуваарилаад буй 12.2 тэрбум төгрөг юу болох вэ дээ. Тэтгэврийнхэн ирэх оны төсвөөс дор хаяж 35 тэрбумыг нэхэж байна. Өвөө, эмээ нарын жишээгээр төсвийн байгууллагад данстай 140.000 хүн бухимдаад эхэлж болзошгүй. Учир нь тэдний цалинг 10 хувиар нэмнэ. Ердөө найман тэрбум төгрөгийг төрийн албан хаагчдад зориулан хуваарилсан болохоор амьдрал сайхаан гэж ярихгүй нь лав. Төрийн албан хаагчдын бухимдлыг Сангийн сайд зөөллөх гэж мэдээж оролдоно. Ингэхдээ хүн амын орлогын албан татвар яваандаа багасна гэж тайвшруулах биз. Татварын хуулиудад өөрчлөлт оруулахаар иргэдийн гар дээр үлдэх хэдэн төгрөгийн хэмжээ өнөөгийнхөөс ялимгүй нэмэгдэнэ.

Гэхдээ улсын хэмжээнд нийт дүнгээрээ тэрхүү өсөлт нь тэрбум тэрбумаар тоологдох авч, миний гэр бүлийн төсөвт бол дорвитой мэдрэгдэх зүйлгүй. Тэтгэврийг жилийн жилд бага багаар нэмдэг боловч тэр нь ганц хоёр килограмм махны үнэтэй тэнцэх арга хэмжээ болсоор өдий хүрчээ.

**Харин 2006  
оны ялимгүй өөр  
өнгө аяс гэвэл  
нефтийн  
эрэлтийн  
хөөрөгдөл дунд,  
мах, гурил зэрэг  
өргөн  
хэрэглээний  
бараа өрхийн  
төсөвт  
харьцангуй  
үнэтэй тусч,  
улмаар инфляц  
аюултай  
хэмжээнд очих  
магадлал өндөр.**

## ТӨСВИЙН ЦООРХОЙ

Татварын шинэчлэл зайлшгүй хийх ёстой. Гагцхүү хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд 44 тэрбум төгрөгийн цоорхойг төсөвт нэмэх нь. Харьцууль. Төсвийн байгууллагынхны халаалтын зардалд нэг жилд яг ийм хэмжээний хөрөнгө урсдаг. Мөнгөний уугандаа томоохон цоорхойтой амьдарна гэсэн үг. Тэгэхээр татварын шинэчлэл гэдэг зөвхөн цифртэй хөөцөлдсөн төдий реформ байвал бүтэхгүй нь. НӨАТ-ын хувь хэмжээг бууруулна, ахиухан орлогод ногдуулдаг татварыг багасгана. Харин нөгөө талд нь татвар төлөгчдийн эгнээг тэлэх арга хэмжээ үгүйлэгдэж байна. Далд эдийн засгийг ил гаргах алхмууд ор тас орхигджээ. Түүнчлэн, төсвийн цоорхойг нөхөх боломжуудаас эрэл хайгуул хийгээгүй залхуу төсөл болсон гэдэгтэй санал нийлмээр байна. Хэрэв орон нутгийн төсвийн орлого, зарлагын байдлыг тандаад үзвэл тэнд элдэв хураамжаас ихээхэн мөнгө орж ирдгийг анзаарч болно. Татварын албад тэмтэрч чаддаггүй иймэрхүү боломжуудаас реформын үр дүнг олж хармаар санагдах юм.

Ирэх оны хувьд оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс орж ирдэг орлого хасагдаж, төмөр замын транзит тээврээс багахан хуримтлал нэмэгдэн, «Эрдэнэт» үйлдвэр төсвийн ачааны хүндийг үүрч гарах дүр зураг харагдана. Урьд жилүүдийнхээс онцгой ялгарах зүйлгүй, гал унтраадаг төсөв Сангийн сайдын цүнхэнд явна. Харин 2006 оны ялимгүй өөр өнгө аяс гэвэл нефтийн эрэлтийн хөөрөгдөл дунд, мах, гурил зэрэг өргөн хэрэглээний бараа өрхийн төсөвт харьцангуй үнэтэй тусч, улмаар инфляц аюултай хэмжээнд очих магадлал өндөр. Энэ нь дээр өгүүлсэн цалин, тэтгэврийн багахан нэмэгдлээс хамаагүй түргэн өсч томрох нь мэдээж. Элдэв итгэлцүүрт үл торох инфляц 2006 онд нийгмийн бухимдал дагуулан, Төрийн ордны үүд хаалгыг хэдэн хөгшдөөс илүү хүчтэй балбаж мэдэх юм.

2005 он

## Орос чихэртэй 2006 оны төсөв

Сайхан ширээ засах дуртай эзэгтэй нар наашаа суугаарай. Баярын ширээ бэлтгэх хообийтойгоо нуугаад яахав. Яаруу давчуу, догдолсон амьсгал дунд сонин хачин засал чимэг, өрөлт тавил бодож олохын амтыг эзэгтэй нараас асуугаад үзээрэй. Шинэ жилийн ширээнийхээ өнгө төрхийг бүр одоо л сэтгэлдээ зурж яваагаа нууж чадахгүй нь. Харин энэ зураглалыг хэтэвчтэй хэдийнхээ чансаанд нийцүүлэх учиртай. Өнгөрсөн оны шинэ жилийн баярын ширээнээс энэ удаагийнх ялгарч чадвал маш сайн. Цалин нэмэгдэж базаагаагүй нь үнээн. Гэхдээ элдэв боломжуудыг бодож олох эзэгтэйн ур ухаан энд л гарна. Өрхийн төсвөөсөө боломж хайн, толгойд зурсхийх энгийн санааг баяр болгон амилуулдаг эзэгтэйн ухаанаас суралцахад илүүдэхгүй шүү.

2006 оны тааруухан, үрэлгэн, устай төсвийг УИХ баталсан талаар хангалттай мэдээлэл өнгөрсөн долоо хоногийн турш цацагджээ. Тэгвэл энэ төсвөөс боломж олж харахыг бүгдээрээ оролдоё. Ирэх жилийн төсвийн үзүүлэлтүүдээр идээ ундаа бэлтгэх гээд үз л дээ. Тоонд толгой нь эргэсэн татвар төлөгчдийг улсын төсөв сонирхдог болгох арга чарга хайж байна гэх үү дээ. Яагаад «устай төсөв» хэмээн өөлсөн бэ гэдэг юуны өмнө сонирхол татав. Зардал хэмнэх боломж хайгаагүй гэж Сангийн яамны мэргэжилтнүүдийг буруутгажээ. Төсвийн байгууллагууд зөвхөн халаалтын зардалдаа 40 гаруй тэрбум төгрөг үрж байна. Хэрэв цахилгаан, дулааны үнэ нэмэгдвэл уг тоо цаашид ч хэмжээ хязгааргүй хавагнана. Ганцхан жишээ ийм байх бөгөөд төрийн нүсэр бүтцийг эрс шинэчилж, олон мянган албан хаагчийг ажлаас халахаас нааш зардал хэмнэх, төсвийн усыг шахах арга хэмжээ хэзээ ч хэрэгжихгүй. Тэгэхээр төсвийг ийм тийм хэмээн хий өөлж суух нь УИХ-ын гишүүний ажил лав биш. Яагаад гэвэл эдийн засгийн тулгуур хуулиуддаа нэмэлт өөрчлөлт оруулах, гажигтай тогтолцоог эрс шинэчлэх, тэтгэмж өглөгийн төсвийг хөгжлийн, хөрөнгө оруулалтынх болгох эрх мэдэл гишүүдэд өөрсөд нь бий. Эрс шинэчлэлийн ийм алхам хийх зориг УИХ-д дутсаар байгаа. Тиймээс 2006 оны төсвөөс боломж, нөөц бололцоо олж харах, түүнийг оновчтой ашиглахыг оролдоод үзье.

Баярын ширээнд амт нэмэх сайн түүхий эд энд бий гэж эзэгтэй үзжээ. Гацуурын соньхон үнэр сэтгэл гижигдсэн энэ өдрүүдэд айсуу шинэ жилийн тухай дандаа баргар дүр зураг төсөөлөх хэрэггүй ээ.

БОЛОМЖ	БЭРХШЭЭЛ
<p>- Хэд хэдэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт мөнгөний шинэ эх үүсвэр бүрдүүлнэ. Ашигт малтмалын тухай хуульд оруулах өөрчлөлтийн дүнд лицензийн болон байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөр өмнөхөөс нэлээд хэмжээгээр нэмэгдэж болзошгүй.</p> <p>Харин нөөц ашигласны төлбөрийг огцом өөрчлөхгүй бололтой. Орлогын дээрх эх үүсвэрүүдээс орон нутгийн төсвийг санхүүжүүлэх юм. Хөдөөгийн иргэдийн амьжиргааг өөд татахад энэ хөрөнгийг оновчтой зарцуулаасай.</p> <p>Өөр нэг хуулийн тухай давхар өгүүлбэр. Байгаль орчны тухай хуульд</p>	<p>-Бэрхшээл зовлон мэдээж хангалттай. Хамгийн хэцүү нь өрийн дарамт. 71 тэрбум төгрөг буюу 2006 оны төсвийн алдагдлыг бараг дангаар нь «бүрдүүлсэн гавьяатай» гайт өр. Төрийн байгууллагуудын хооронд бий болсон өрийн сүлжээ үлэмж нэмэгдэх хандлагатай бол манай гадаад өр үүнээс бүр долоон дор болоод байна. Зээлийн үндсэн төлбөрт ирэх жил бид хэтэвчнээсээ тэрбум тэрбумаар нь зарцуулах юм.</p> <p>Хамгийн ихийг буюу 13 тэрбум төгрөгийг ОХУ-д, Япон улсад 11 тэрбумыг төлөх ёстой. ОУВС болоод Азийн хөгжлийн банкинд тус тус 6-7</p>



нэмэлт, өөрчлөлт оруулбал өнөө мөрдөж буй торгуулийн багахан хэмжээ үлэмж нэмэгдэх магадлалтай. Экологийн хохирлыг барагдуулах тухай шинэ хуулийн талаар хэн хүнгүй ярилцацгаах болов.

Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлтийн ажлыг чанд хянах механизм ийнхүү амьдралын шаардлагаар бүрдээд эхэллээ. Тэдгээр орлого, дээр нь усны болоод газрын төлбөр хөдөөгийн шальдар бульдир амьдралд гэрэл гэгээ өгнө. Энэ нь ирэх жилийн төсвийн ширээн дэх гол амттан биш гэж үү. Орон нутгийнхан татаас нэхэхгүй бол төвлөрсөн төсөв ч «нуруу тэнийх» биз.

-Татварын хуульд өөрчлөлт оруулснаар татвар төлөгчдийн хүрээ тэлэх магадлалтай. Ингэвэл татвар хураалтын эрүүл систем бүрдэх эхлэл болно.

-«Бензиний үнэ дээр биднийгээ бодоорой» хэмээн Г.Батхүү сайд саяхан Москвад очоод байхдаа ОХУ-ын түшмэдэд тал засчээ. Ингэж аминчлах шалтгаан ч гарч.

Дотоодын нефтийн компаниуд өдгөө «Сибнефть»-тэй гэрээ хийж байгаа. Хувийн зуучлагч компанитай харилцаж байгаа гэсэн үг. Харин «Газпром» компани «Сибнефть»-ийн хувьцааны үлэмжхэн хувийг худалдаж авсныг манай гярхай эзэгтэй анзаараа байлгүй.

«Газпром»-ын хувьцаанд ОХУ-ын Засгийн газар хяналт тавьж буй энэ үед «Сибнефть»-тэй хэл амаа ололцох, бага зэрэг хөнгөлөлт эдлэх боломж бий гэж сайд найджээ. Одоогоор хийсвэр эд боловч ийм найдлагаар амтат зууш бэлтгэх урамтай юм гээч.

- Одоо баярын ширээний гол зоогийг байрлуулах цаг. Идээ шүүсний дээд нь тэр болой. Зэс, алтны экспортын орлогын тухай л ингэж «шүлс гоожуулан» ярьж байна. Дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнэ 2006 оны турш өндөр байх таамаг бий.

Гэхдээ эдгээрийн борлуулалтын үнийг 2006 оны төсөвт бараг ханасан түвшинд тооцож авсан болохоор илүү гаргах боломж хомс. Их хурлын гишүүд чухам алт, зэсийн орлого дээр л ийнхүү онцгой «харгис» хандаж билээ. Н.Алтанхуяг сайдаас «Энэ орлогыг

тэрбум төгрөг өгнө. Зээлийн хүүгийн төлбөр дээр нь нэмэгдэнэ. Дахиад л ОХУ, Япон, Азийн хөгжлийн банк, мөн Дэлхийн банкинд ахиухан хүү төлөх хуваарьтай. Зөвхөн ирэх он гэлтгүй, монголчуудын хувьд айсуу жилүүдийн хамгийн том зовлон гадаад өрийн дарамт болно.

- Татварын хуульд оруулах нэмэлт төсөвт хүндхэн тусна. 40 гаруй тэрбум төгрөгийн цоорхойг хэрхэн нөхөх учиртайг улстөрчид бодохоос ч айж суугаа. Шинэ жил, дараа нь цагаан сар, тэгээд Мартын 8-ны баяр өндөрлөхөөр аажуу уужуу тунгаах юм байлгүй.

- Нефть бүтээгдэхүүний, тэр дундаа дизель түлшний үнэ өсөх айдас баярын ширээнээс холдох дургүй. Дэлхийн зах зээлийн хөдөлгөөнийг дагаж үнэ ханш нь хувирах болохоор энд биднээс хамаарах зүйл бага. Гагцхүү Эрсдэлийн сан байгуулах замаар үнэ ханштай хэсэг «зууралдах» боломжтой. Одоогоор Засгийн газар санаачилсан зүйлгүй сууж байна.

- Зарим импорт ирэх жил нэмэгдэж болзошгүй гэсэн айдас эзэгтэйд байна. Эх орны буудай хомслож, Хятад, Орост үйлдвэрлэсэн, эвлүүлж зуурч дадаагүй гурил хэрэглэх магадлал их. Хэдийгээр цагаан сарын үеэр гурилын интервенц хийнэ, айлтгүй хэмээн яамны мэргэжилтэн түүнийг тайвшруулсан ч тэр нь үнэ ханшид нэг их нөлөөлдөггүйг бид мэднэ.

Эхлээд махны интервенц хийдэг байлаа. Одоо дээр нь гурилаа нэмэх нь. Интервенц гэх үг цаанаа л нэг аймаар сонсогдох аж.

- Интервенцүүд үр дүнгээ өгөхгүй бол ирэх жил инфляц улам өснө. Дээр нь Хятад улс юанийн ханшаа улам бүр «чангалах» санаатай. Ж.Буш Бээжинд байх хугацаандаа юанийг зах зээлийн ханшид нийцүүлэн бодитой үнэлэхийг шаардсаар байлаа. Хямд юаниас болоод АНУ-ын худалдааны алдагдал улам өсч буйг тэр сэтгэл түгшин тэмдэглэсэн юм.

Тэгэхээр Ж.Бушийн шаардлагын «хаялга» монголчуудад бэрхшээл тарина. Юанийн ам.доллартай харьцах ханш чангарвал манай импортын бараа бүтээгдэхүүний үнэ өсч таарах билээ. Таагүй мэдээ байгаа биз.

- Болзошгүй зардлууд нэлээд гарч

төсөвт гүйцэд өгөөд орхи» хэмээн шаргуу шаардаж нэхсэн юм.

- Эзэгтэй тавгандаа тавихаар орос чихэр ахиухан сонгожээ. Яагаад энэ билээ хэмээн түүнээс асуулаа. Дэлхийн худалдааны байгууллагад элсэх гээд ОХУ-ын дарга нар сайхан ааштай байгаа гэнэ. Тарифын хөнгөлөлтийн хэлэлцээрийг хөршүүдтэйгээ тэд тун уриалгахан хийж байна.

Он удтал хойд хөрш маань худалдааны өндөр тарифаар биднийг боосон доо. Харин одоо алтан боломжийг ашиглахаас яахав. Орос чихэр аваарай.

- Бас нэг муугүй мэдээ бий. Монголын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын тээврийн тарифыг хямдруулахыг оросууд зөвшөөрөх бололтой. Төсөвт орж ирэх бага ч гэсэн орлого гэсэн үг.

- Цааш нь төсвийн орлого нэмэгдэх сайн боломжуудыг тоймлоё. Европын холбооны улсуудын зах зээлд хөнгөлөлттэй нэвтрэх эрх манай оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ой тохиох тул аялал жуулчлалын салбарынхан ашиг арвин байх биз.

Мянганы сорилын сангаас тусламж авах найдвар ч өндөр гэнэ. Дээр нь БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл орж ирэх бололтой. Гагцхүү 300 сая ам.долларын зээлийг Монголд үр ашигтай зарцуулах талаар янз бүрийн байр суурь сонсогдож байна.

мэдэх юм. Юуны өмнө шувууны ханиад дэлгэрэх аюулаас урьдчилан сэргийлэх ажилд чамгүй хөрөнгө шаардлагатай. Халдварт өвчин, байгалийн элдэв аюулт үзэгдлээс сэрэмжлэх нөөц хөрөнгийг Засгийн газар 2006 онд өөртөө нэмүүхэн төсөвлөжээ.

- Баруун аймгийнханд санаа зовох бас нэг асуудал бий. Эрчим хүч хэрэглэсний төлбөрөө урьдчилан өгөх ёстой болсон. Хэдийгээр нэг квт.цаг цахилгааны үнийг ялимгүй хямдруулсан боловч оросууд дээрх болзлыг тулгажээ. Харин манай сайдууд Дөргөн болоод Тайширын цахилгаан станцыг даруй ашиглалтад оруулна хэмээн найдаж байна.

Ирэх оны төсөвт туссан, тусах магадлалтай сайн хандлагуудыг, мөн гарч болзошгүй бэрхшээлүүдийн талаар өгүүллээ. Бондын арилжаа идэвхжин, хөрөнгийн зах зээл сэргэх төлөвийг нэмж дурдъя. Арилжааны банкуудын зээлийн хүүг «захиргаадалтын аргаар» буулгах сураг ч сонсогдов. Нэг үгээр, ашиглаж чадвал нөөц бололцоо салбар бүрт харагдана.

2006 он бүхэлдээ Монгол Улсын эдийн засаг, бизнесийн салбарт том том өөрчлөлт, шинэ алхам амласан бүтээлч жил болох нь гэдэгтэй санал нийлэх буй за. Юуны өмнө элдэв сонгуулиас ангид, дараагийн сонгууль хол харагдах харьцангуй эрүүл саруул сэтгэлгээний жил байх юм. Манай эзэгтэй, бизнесийнхэн, УИХ-ын гишүүн, сайд ялгалгүй эдийн засаг дахь шинэ боломжуудыг хамтдаа эрэлхийлэх өдрүүд иржээ.

# Төсвийг тэлж, инфляцийг онилсон нь

Монголбанкныханд баяр хүргэе. Мөнгөний бодлогын жолоо цулбуур алдагдсан тухай хэвлэлүүдээр хэдэнтээ бичиж, иргэд мянгантаа бухимдсаны эцэст Төв банк ямар нэг алхам хийж эхэлснийг анзаарч болохоор байна. Төгрөгтэй харьцах ам. долларын ханшийг оны эхнээс барьж чадсан 1184-1186 орчимд дахин тогтоох оролдлого хийж буй бололтой. Ийнхүү наймдугаар сараас хойш ганц ам.доллар 1195 төгрөгтэй тэнцэж галзуурч байсан савлагаанд мөнгөний нөөцийн эзэд жаахан даруулга өгөв.

Валютын ханшид анхаарал тавиад зогссонгүй улсын мөнгөний бодлогын өнөөгийн өнгө төрх болоод ирэх онд баримтлах чиг хандлагаа ил тод, иргэдэд ойлгомжтой мэдээлэхийг оролдож эхэлжээ. Төв банкны иргэдэд хаалгаа нээх гэсэн эдгээр алхамд талархахын ялдамд төсвийн хэлэлцүүлэг юу юугүй эхлэх гэж буй энэ цагт ирэх оныхоо хэтэвчний байдлыг тандъя. Монголбанк төсвийг тэлж, инфляцийг онилох шинэ бодлого зарласныг юуны өмнө дуулгая. Харин энэ хэцүү нэр томъёогоо банкирууд тайлбарлах гэж яараагүй байна.

## МОНГОЛБАНК ШИНЭЭР СЭТГЭХИЙГ...

Төсвийг тэлэх буюу мөнгөний нийлүүлэлтийг өнөөгийнхөөс илүү уян хатан барих бодлогоо тэд зарлаж буй бололтой. Монгол Улсын эдийн засагт мөнгө урсан орж ирсэн ийм тохиолдол урьд өмнө бидний амьдралд таарч байсангүй. Улсын сан хөмрөгт экспортоос асар орлого хуримтлагдахын зэргэцээ төрөл бүрийн чиглэлээр хөрөнгө оруулалт хувийн хэвшил болоод өрх бүлийн дансанд ирсээр байна. Өсөн томорч буй эдийн засгаа удирдан залах мөнгөний бодлогын цоо шинэ хандлага үгүйлэгдлээ гэсэн үг.

Өмнөх 16 жилийн туршлагаар намартаа мах, гурил, ногоо цагааны үнэ өртөг унадаг тухай хүлээлт өдгөө үгүй болжээ. Эрэлт, нийлүүлэлтийн уламжлалт тойрог алдагдлаа. Их мөнгө дагасан том бүтээн байгуулалтууд импортын дийлдэшгүй урсгалыг даллаад байна. Тэгэхээр улирлын чанартай бизнес, улирлын чанартай үнийн өсөлт, ийм эрэлт, түүнийг хазаарладаг улирлын чанартай арга хэмжээнүүд хэдийнэ үеэ өнгөрөөжээ. Эдийн засгийн хурдацтай өсөлт мөн тийм шуурхай, уян хатан мөнгөний бодлогыг үгүйлж байна. Улирлаар нь бус, өнөө маргааш, өдөр шөнөгүй хийх бодлогын зохицуулалтыг Монголбанкнаас амьдрал шаардаж байгаа билээ.

Ирэх оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтыг өмнөх жилийнхээс долоо дахин нэмэгдүүлэхээр заасан харагдана. Монгол орон даяар бүтээн байгуулалт ундарч, амьдрал богино хугацаанд өөдлөн дэвжиж эхэллээ. Энэ утгаараа өөдрөг сайхан төсөв батлагдахыг бид хүлээж байна. Харин бүтээн байгуулалт бүр импортын урсгалыг, улбаалаад валютын эрэлтийг нэмэгдүүлэх нь. Валлот эрхмийн өмнө мэхийе. Та бидэнд юутай их хэрэгтэй байна вэ. Гэхдээ таны гэдгэр занг дараад байхуйц нөөц хөрөнгө манай Батсүх даргад бий. Гагцхүү тэр хүн мөнгөний бодлогоо бараг ченжүүд шиг мэдрэмжтэй шуурхай залуурдах буй за хэмээн найдах үлдлээ.

Төв банк бодлогын хүү гэгч ганц арга хэрэгслээр зүтгүүлэхээ больж, бусад алхамтай хослуулан ирэх жил мөнгөний бодлогыг барина гэдгээ зарласан

Их мөнгө дагасан том бүтээн байгуулалтууд импортын дийлдэшгүй урсгалыг даллаад байна. Тэгэхээр улирлын чанартай бизнес, улирлын чанартай үнийн өсөлт, ийм эрэлт, түүнийг хазаарладаг улирлын чанартай арга хэмжээнүүд хэдийнэ үеэ өнгөрөөжээ.

билээ. Энэ нь мөн л шинэ алхам агаад бас л яг юу яахыг олон түмэндээ ойлгомжтой тайлбарлах биз ээ хэмээн хүлээцгээж байна. Инфляц гэгч цадахыг мэддэггүй мангас ямар ч ухаантай бодлогын үр дүнг залгиж чадах учир түүнийг онцгой анхааралдаа авах гэнэ. «Инфляцийг онилох» бодлого гэж шинэ маягаар зарлаад байна. Одоогоор 13 хувьтай галзуурч яваа инфляц таныг манай банкирууд овоо хараандаа онилсон тул 2008 онд 5.9 хувиас таргалахгүй байх шахалтад орноо гэсэн үг.

### **БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧИД ШИНЭЭР СЭТГЭХИЙГ...**

Монголбанкныхан инфляцтай дангаараа хөөцөлдөөд явах нь утгагүй болжээ. Сангийн яам, Засгийн газар ямар шийдвэрүүд үзэглэхээс, УИХ хэрхэн шийдвэрлэхээс мөн л олон зүйлийн үр дүн харагдахаар байна. Эдүгээ бид төсвийн ажилтны цалинг нэмэгдүүлнэ гэх арга хэмжээний үр дүнг өмнөх 17 жилийнхээсээ өөрөөр ойлгох цаг болсон. Төсвийн ажилтнууд болох 130.000 хүн гэдэг хөдөлмөр эрхэлж буй үлдэх хүн амын тооны дэргэд өчүүхэн хэсэг. Гэтэл тэдний цалинг ялимгүй нэмсэн төдийд бүгдийнх нь иддэг талх тарианы үнэ өснө гэдэг төр, засгийн бодлогын хувьд том алдаа.

Ерөөс төсөв , төсөв хэмээн нэр барьж хэдхэн хүн хувааж үрэх тухай ойлголтыг өөрчлөх өдөр ирсэн байна. Хэрэв цалингийн доод хэмжээг тогтоож, төсвийнхөнд мөнгө төгрөг ахиухан хуваарилахаар шийдсэн юм бол нөгөө талд нь хувийн хэвшилд ажиллаж буй олон зуун мянган хүний хөдөлмөрийн хөлсийг өсгөх механизмыг давхар нээж чөлөөлж өгөх ёстой. Өдгөө нийгмийн даатгалын шимтгэл нэрээр компаниудын дансыг цөлмөж байгаа 19 хувийн татварын дарамтыг бууруулахгүйгээр зөвхөн төсвийнхөнд зориулсан бодлого явуулах нь нийт эдийн засагт ямар ч сайн үр дагавар авчрахгүй билээ. Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ багассан цагт хувийн хэвшлийнхэн ажилтнуудынхаа цалинг нэмэх, хөрөнгө оруулалт хийх эх үүсвэртэй болно. Дээрх арга хэмжээг давхар хэрэгжүүлж гэмээнэ төсвийнхний дундаж цалинг 250.000 төгрөгт хүргэсэн арга хэмжээ олон түмэнд илүү ойлгогдох биз ээ.

Төсвийн төслийн хэлэлцүүлгийг иргэд яагаад тоодоггүй юм бэ? Эндээс олон түмэн татвар ирэх жил нэмэгдэх эсэхийг, татварт хураалгасан мөнгийг нь УИХ-ын гишүүд өөрөө олсон хөрөнгө мэт хэрхэн дураараа цацахыг хянах гэж л хаяахан сонирхдог. Монголын нийгэм бүтээн байгуулагчдын , баялаг бий болгогчдын олонхтой болсон байна. Энэ том үзэгдлийг бодлого тодорхойлогчид эрхбиш ухаарах учиртай болжээ.

**Монголын нийгэм бүтээн байгуулагчдын, баялаг бий болгогчдын олонхтой болсон байна. Энэ том үзэгдлийг бодлого тодорхойлогчид эрхбиш ухаарах цаг болжээ.**

# Төсвийн хэлэлцүүлгийн үеэр түгээх SOS

-Улаанбаатарт сонин юутай байна даа хэмээн Сакс мэндлэх зуураа асуулт хавчуулав. Танилууд нь түүнийг зүгээр л Жеф гэж авгайлах аж. Санасныг бодвол жижиг биетэй, харин илтгэх урлагийг төгс эзэмшсэн энэ эрхмийн дуу хоолой танхим дүүрэн цуурайтна. Жефри Саксыг дэлхийн хүмүүс андахгүй. Нэртэй эдийн засагч, 2005 онд «Time» сэтгүүлийн зарласнаар, гариг дэлхийд хамгийн нөлөө бүхий зуун хүний нэгд багтсан тэрбээр ядуурал, зээл тусламжийн зарцуулалт, даяаршил, НҮБ-ын Мянганы зорилтуудын талаар ярьж байна. Түүний байр суурь монголчуудад юугаараа сонин байж болох вэ?

Нью-Йоркийн налгар намар дор нэртэй эдийн засагчдын өөр байр суурь шуугиан дэгдээж байна. Тэд ОУВС, Дэлхийн банкнаас буурай орнуудад хэрэгжүүлж ирсэн бодлогыг шүүмжилж, ядуурлын буруутныг улстөрчдөөс хайхыг шаргуу шаардах аж. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болоод төсвийн төслийг хэлэлцэж буй өдрүүдэд «баруунаас» үлээх өөр салхи юу өгүүлэхийг чагнаад үзье.

Монгол Улсын 2007 оны төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэж буй явц болоод иргэдийн анхаарал хандуулж байгаа гол сэдэв нь нийгмийн хамгаалалд зарцуулах мөнгөний тухай яриа. Дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнэ өндөр байна, дүнд нь цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгө нэмэгдэнэ гэсэн үгс тархинд шингэж, амнаас аяндаа унах боллоо. Өнөөдрийн өөхийг хэсэглэн хувааж буй мөчид өөр нэг чимээг хажууханд тань «хаямаар» санагдав.

Донор орнууд болон олон улсын санхүүгийн байгууллагаас 1990 оноос хойш авсан үндсэн зээл, хүү төлөлтийн оргил жилүүдийн гараанд монголчууд иржээ. 2007-2010 онд зээл төлөлтийн оргил үе таарч байгаа юм. Ирэх жилийн төсвийн орлогоос бид 76.8 тэрбум төгрөгийг үндсэн зээл болоод хүүгийн төлбөрт шилжүүлэх хатуу үүрэг хүлээсэн улс. Энэ тоо 2006 онд 71.5 тэрбум төгрөг байлаа. Жил ирэх тусам өрийн дарамт улсын төсөвт жин дарж буйг сануулъя. Хэрэв дэлхийн зах зээл дэх үнэ ханшийн таатай мөчлөг таараагүй бол монголчууд ОХУ-ын их өрөөс дутуугүй, магадгүй илүү хатуу нөхцөлтэй зээлийн төлбөрт дарамтлуулах байлаа. Хэдийгээр экспортын гол нэрийн бүтээгдэхүүний ханш чанга байгаа боловч орж ирэх ашигтай нь тэнцэх хэмжээний зээлийн төлбөр биднийг хүлээж байна. «Эрдэнэт» үйлдвэрээс төсөвт 80 орчим тэрбум төгрөг орж ирэхээр тооцоо гарчээ. Тэгвэл энэ нь ирэх онд төлөх гадаад өртэй маань дүн нэг болохыг анхааралдаа авна уу. Хүүхдийн мөнгийг өсгөх тухай намуудын бие биеэ давах гэсэн тоглоомын тойрогт бидний толгой бүр эргэчихжээ.

Нийгмийн хамгаалалд зориулан энэ мэтээр янз бүрийн сайхан тодотголтой зардал төсөвлөхийнхөө хажуугаар макро эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээ авахаа мартаагүй хэмээн Засгийн газар тайлбарлаж байгаа юм. Тогтвортой байдлын, Эрсдэлийн, Монгол Улсыг хөгжүүлэх нэртэй элдэв санг байгуулснаар олзны урсгалыг нөөцөлж, улмаар эдийн засгийг зөв жолоодно гэсэн итгэл бий. Тэгвэл Монгол Улсыг хөгжүүлэх санд хуримтлагдана хэмээн тооцоолоод байгаа хөрөнгөтэй дүйцэх хэмжээний мөнгийг доноруудад буцааж төлөх болоод байна. Жил ирэх тусам үндсэн зээлийн өр төлөлтийн хувь нэмэгдэхээр харагдана. Ийм SOS дэлдэхийн хажуугаар дэлхий дахинаа ядуу

**Намрын Нью-Йоркод сонссон олон сонин байр суурь нэг л зүйлийг өгүүлээд байхыг анзаарлаа. Дэлхий дахинаа ядуу орнуудын өр зээлээр улс төр хийх шинэ хандлага бий болжээ.**



орнуудын өр зээлийг хэрхэн улстөржүүлж буйг анхааралдаа авахыг хүсье.

Колумбын их сургуулийн буурал танхимд Жефри Сакс юунд ч юм бэ ундууцан, ууртай үгс чулуудсаар байлаа. «Улстөрчид бол дэлхий дахин дахь ядуурлын гол буруутан»... НҮБ-аас дэвшүүлсэн Мянганы зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын гол удирдагч, К.Аннанын зөвлөх тэрбээр буурай ядуу олон орны Засгийн газарт мөн л зөвлөхөөр ажиллажээ. 2001 оны Нобелийн эдийн засгийн салбарын шагналт Жозеф Стиглиц ч ялгаагүй баахан бухимдсан үгс «нүүлгэлээ». Энэ хүн глобальчлалыг эсэргүүцдэг. Өөрөөр хэлбэл, дэлхийн худалдаа болоод глобальчлалаас баян орнууд ашиг хүртдэг, ядуус улам доройтсоор байгаа тухай тун ч цогтой ярина. Өөр нэг эдийн засагчийн сонирхолтой байр суурь бас сонсогдлоо. Нью-Йоркийн их сургуулийн профессор Уильям Ийстерли жийнс өмсчихсөн, зангиа мангиа тоодоггүй эр болохоо ойлгуулсаар их л энгийн чөлөөтэй ярих аж. Дэлгэцийн өмнөх ширээн дээр сандайлчихаад, Жефри Саксыг шүүмжилж билээ. «Сакс энд, Нью-Йоркод суучихаад ядуурлыг 2015 он гэхэд одоогийнхоос хоёр дахин бууруулна гэж ярих юм. Үүнд би итгэдэггүй» хэмээн үгүйсгэв.

Намрын Нью-Йоркод сонссон олон сонин байр суурь нэг л зүйлийг өгүүлээд байхыг анзаарлаа. Дэлхий дахинаа ядуу орнуудын өр зээлээр улс төр хийх шинэ хандлага бий болжээ. Тэртээ тэргүй буурай улсууд донороос авсан мөнгөө буцаан төлж чадахгүй. Ийм тохиолдолд найдваргүй өрийг хүчингүй болгодог, ингэхдээ өөрт ашигтай байхаар тэглэх моод дэлгэрээд байна.

Ойрхноос жишээ авъя. ОХУ 2004 оноос өр, зээлийн шинэ бодлого баримталж эхэлсэн. «Тэнгэрт нисэх тогоруутай хөөцөлдсөнөөс энүүхэнд жиргэх болжморыг» гэсэн санаагаар оросууд шинэ бодлогоо тайлбарлаж байна. Алжираас ОХУ-д төлөх 4.7 тэрбум ам.долларын өрийг хүчингүй болгоод оронд нь 7.5 тэрбум ам.доллараар үнэлэгдэх зэвсгийн наймааг тус улстай хийчихэв. Сирийн өрийг мөн л өршөөлөө. Хариуд нь 2005 онд «Стройтрансгаз» компани Сири улсын нутагт байгалийн хий боловсруулах үйлдвэр бариад зогсохгүй хий дамжуулах хоолой «татах» гэрээнд гарын үсэг зуржээ. Энэхүү шинэ бодлогын хүрээнд Монгол Улсын их өрийн асуудал мухардлаас гарсныг тэмдэглэе. 2000 оноос илт сэргэсэн манай хоёр улсын найрсаг хөршийн харилцаа ийнхүү 2004 онд улам баталгаажсан билээ. Одоо В.Путин 2004 оны зул сарын бэлгээ манай Ерөнхийлөгчид эргэн сануулах мөч ирээд байна.



**Колумбын их сургуулийн буурал танхимд Жефри Сакс юунд ч юм бэ ундууцан, ууртай үгс чулуудсаар байлаа.**

Хойд хөршийн төрийн өмчийн оролцоотой компаниуд Монголд хөрөнгө оруулах сонирхолтойгоо сүүлийн хоёр жилд цөөнгүй нотолсон. Оросууд хувиараа хөрөнгө оруулахаар зах зээл судалсан эрэл хайгуулын жилүүд гэж ойлгож ч болно. Ийм нөхцөлд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын их хөршдөө хийх айлчлалын үеэр оросууд бидэнд бодитой санал цөөнгүй тавина гэдэгт эргэлзэхгүй байна.

Эдүгээ «Debt policy» гэдэг үг дэлхий дахинаа түргэн халдварлах боллоо. Энэ нь зээл, тусламжийн үр дүнг сайжруулах гэхээсээ илүү ашигтай газраа тусламж өгөн гар сунгах шинэ хандлагаар тодорхойлогдож байна. Нэртэй

**Эдүгээ «Debt policy» гэдэг үг дэлхий дахинаа түргэн халдварлах боллоо. Энэ нь зээл, тусламжийн үр дүнг сайжруулах гэхээсээ илүү ашигтай газраа тусламж өгөн гар сунгах шинэ хандлагаар тодорхойлогдож байна.**

эдийн засагч У.Ийстерли сонин статистик бэлтгэжээ. Сүүлийн 42 жилийн турш баячуудаас ядуудаа өгсөн зээл, тусламж дэлхийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 16 хувьтай тэнцсэн. Харин үр дүн нь нийт үйлдвэрлэлийн дөнгөж 0.4 хувьд хүрэхээр байна гэж тэрбээр тэмдэглэлээ. Өөрөөр хэлбэл, тусламжийн үр дүн бүгдэд падгүй асуудал болжээ гэж Ийстерли ярив. Өр зээлээр «улс төр хийх» үзэгдлийн зэрэгцээ ядуурлаар рейтингээ өсгөх моод мөн л дэлгэрсэн шиг санагдах юм. Ж.Сакс Африкийг ногоон төгөл болгоно хэмээн зарлаж байна. Түүний гал цогтой үгс ядуурал нүүрлэсэн Африк тивийнхэнд бага ч болов итгэл өгч эхэлснийг үгүйсгэхгүй. Африкт хэрэгжүүлж буй «Мянганы тосгод» нэртэй төсөл нь хоосон хийрхэл гэж хэлэхгүй. Гэхдээ Анжелина Жоли Сакстай хамт хар тивээр аялан, Мадонна Малавигаас бяцхан хүү үрчилж аван, У2 хамтлагийн гоцлол дуучин группээсээ гараад «Мянганы тосгод»-оор овоглосон шинэ хамтлаг байгуулсан гээд сенсаац ер тасрахгүй юм. Ээлжит сенсаац бүр ядууралтай тэмцэх лоозон дор дэгдэх агаад үр дүн нь зөвхөн алдартны рейтинг өссөнөөр хязгаарлагдах аж. Их Британийн Сангийн сайд, Тони Блэйрийн залгамж халаагаар тодроод байгаа Гордон Брауны үг мөн л дуулиан дэгдээв. Африк дахь хумхаа өвчнийг анагаахад ердөө 12 центийн үнэтэй тарилга байхад хангалттай хэмээн Браун ярилцлагадаа дурдсан юм.

Улстөрчид, урлагийнхан өр болоод ядуурлыг ийнхүү гуниггүйхэн шийдчих эрмэлзэлтэй явна. Харин энэхүү шинэ хандлагын эсрэг талд уламжлалт хатуу байр суурь хадгалагдсаар байна. Тухайлбал ОУВС буурай орнуудын өрийг тэр чигт нь хүчингүй болгохыг эсэргүүцдэг. Тэд зээлдүүлэгчийн хүлээх эрсдэлийн талаар сануулж байна. Түүнчлэн «зээлтэй» ядуус улс орныхоо эдийн засагт инфляц гэгч мангасыг хатуу хянах ёстой гэсэн нөхцөл тулгасаар байгаа.

Олон өнгийн байр суурь, санал шүүмжлэлийн дундаас бид юуг нь өлгөж авах ёстой вэ? Төсвийн хэлэлцүүлэг эхэлж, Их хурал эдийн засгаар амьсгалж буй өдрүүдэд хол, ойрын хандлагыг харьцуулж үзээсэй хэмээн сурвалжилсан билээ. Засгийн газрын статустай зээлийг ахин дахин авахаас татгалзах цаг болжээ. Тэр тусмаа ОУВС зэрэг санхүүгийн байгууллагын тусламжаас татгалзаж чадвал тэдний элдэв тулгалтыг дагаж сонсох зовлонгүй. Дэлхий дахинаа эдүгээ хувийн хэвшилд олгодог дамжуулан зээлдүүлэх зээл, шууд хөрөнгө оруулалтыг илүү үр дүнтэй хэмээн «хөөцөлдөх» болжээ.

2006 он

Чаг , чаг... цагийн зүү урагш зүтгэхийг хялам хяламхийн харсаар. Мэргэжил минь цаг хугацаатай ямагт өрсөлддөг. Тэд бие биенийхээ дайсан юм. Өдөр тутмын сонины хар ажилд энэхэн бие нухлагдаж, чаг чагхийн яаруулах хором хугацаатай уралдан өвлийн хүйтэн, нозоорсон наран дор гүйсээр. Барьж авсан сайн сэдэвтэй юмсан. Баримт түүж түүнээ босгоно гэдэг тун ч амаргүй. Мэдээлэл авах эрх чөлөө гэж өнөөдөр овоо ярьдаг болжээ. Тэгвэл одоогоос хэдхэн жилийн өмнө энгийн тоо баримтыг хүртэл учиргүй нууцалдаг байлаа.

Монгол Улс зээл, тусламжийг 1990 оноос эхлээд аваад л байв. Харин 1999 онд хүүг нь төлөх болоод ирэх үест зээл, тусламжийн өгөөжийн талаар ам нээх ёстой болсон юм. Албан тушаалтнууд энэ сэдвийг бараг л улсын нууц шахуу бодон ам хамхина. Ийм сэдвийн үзүүрээс атгасаар нэг сар шахуу гүйж байж «босгосондоо» би ичиж байлаа. Их л болхи, удаан ажиллах шиг санагдсан. Өдөр тутмын сонины хүн гэхэд яасан удаан ажиллах юм билээ дээ хэмээн дотроо гэмшинэ. Гэвч эрж сурвалжилж, ухаж төнхсөн, учрыг хайсан нийтлэлүүд ерээд оны сүүлийн Монголын сэтгүүл зүйд хомс байсан юм.



Сураг төдийгөөр, гоё сайхан үгс холбон бичих уран бүтээлчид ид цээжээ балбасан үе. Эр, судал, гадуур яв. Гэхдээ үүнд цаг хугацаа хэрэгтэй. Дараа нь олж цуглуулсан баримтдаа анализ хийж, хандлага гарган бичиж сур гэж зүрх сэтгэл минь зөвтгөөд байхыг яана. Гэвч цагийн зүү урагш тэмүүлэн яаруулсаар. Би тун ч адгуу болжээ. Мэргэжлийн өвчин юм болов уу. Шуурхай бичих, чанартай материал нийлүүлэх хоёрыг хослуулна гэдэг үе үеийн сэтгүүлчдийн зовлон байсаар.

# Бэлгийн морины шүдийг үз

## -Зээл тусламжийг зохицуулах бодлого, манай байр суурь үгүйлэгдэж байна-

Монголчууд хандивлагчдаас 1990 оноос хойш авсан хөнгөлөлттэй зээлийн үндсэн өрийн төлбөрийг шинэ оноос өгч эхэлнэ. Бид их өртэй юу? Олон оронтой тоо олигтой тайлбар болохгүй. Харин манай эдийн засаг авсан зээлээ дааж буй эсэхийг харъя. Бүх зээлээ дотоодын нийт бүтээгдэхүүндээ харьцуулъя. Сангийн яамныхны бэлтгэсэн тооцоогоор бид ирэх онд 1056.5 сая ам. долларын ДНБ үйлдвэрлэнэ. Тэгвэл өр төлбөрийн 880 сая ам.доллар нь ДНБ-ий маань хэдэн хувьтай дүйцэх вэ? 83.3 хувь буюу манай эдийн засаг дахь зээлийн даац хэтэрч буй дохио дуугарч байна. Өөр нэг жишээ авъя. Экспортоос шинэ онд 500.6 сая ам.доллар олно гэж монголчууд найдаж байгаа. Харин экспортын орлогоосоо гадаад зээлийн үндсэн өрийн болон хүүгийн төлбөрт 24 сая ам.долларыг суутгуулна. Энэ харьцаа эхний жишээ шиг сэтгэл түгшээх хэмжээнд очоогүй. Харьцаа хорин хувьд дөхвөл толгойгоо тонших хэрэгтэй. Гэвч үндсэн өрийн төлбөр хуваарь ёсоор цаашдаа өсч байгаа.

**Бас нэг тооцоо харья.** Нэг удаагийн зүү, тариурын үйлдвэр барихаар БНСУ-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан зээлээ манай улс энэ оны долдугаар сараас төлж эхэлсэн. 2013 он гэхэд зээлийг хүүгийн хамт төлж барагдуулах хуваарьтай. Нэг удаагийн зүү, тариурын «Монсам» үйлдвэр сүүлийн хоёр жил алдагдалтай ажилласан. Гэтэл жил бүр 3.5 хувийн хүү төлөөд яваа. Ашгаас давсан хүү өгөөд байвал зээлийн үр өгөөж харагдахгүй. Зээлээр шинэчлэлт хийж, босгож буй объект нь маш ашигтай, дэлхийн зах зээлд гүйлгээтэй эд үйлдвэрлэх тооцоо гарвал эдийн засаг дахь зээлийн даацыг арай өөрөөр харж болох юм. Бидний авсан хөнгөлөлттэй зээлийн дийлэнх нь дэд бүтцийн салбарт орсон. Тэгвэл энэ салбарын үйлдвэрлэлийн үр ашиг харьцангуй олон жилийн дараа гардаг.

Бид хандивлагчид болон олон улсын байгууллагуудаас дээр өгүүлээд буй хөнгөлөлттэй зээл, түүнээс гадна буцалтгүй тусламж авдаг. Хөнгөлөлттэй гэсэн тодотгол эхэндээ «зай ч, лай ч байна» гэх шиг тайвшруулсан бол амласнаа биелүүлэх хугацаа нүд ирмэх зуур хүрээд ирлээ. Тусламжийн хөрөнгө оруулалт авсан газруудын үр дүн, ашгаар өрөө төлье гэтэл нүдэнд торох тоймтой зүйл харагддаггүй. Бусдаас зээлэлгүй, буцалтгүй тусламж л ахиухан авахыг хичээх байжээ хэмээн амаа бариад хэрэггүй. Одоо тэгвэл буцалтгүй тусламжийн тухай хэдэн жишээ авъя. Орос, Чехийн автобусууд ерээд оны дундуур элэгдэж, хотын нийтийн тээврийн бэрхшээл хоолойгоор татаж байлаа. Яг ийм үед танхимд нь монгол дуу эгшиглэж, цаг чаг чаг дуугарсан, суугаад яваад баймаар автобусууд Японоос ирлээ. Чех улсад үйлдвэрлэсэн гурван ширхэг «Кароса»-гийн үнээр ганц автобус авсан нь тэр үед сэтгэл зовоогоогүй. Хэдэн жил хотын тээвэрт зүтгэсэн нөгөө бэлгийн унаа маань өнөөдөр хуучирч, засвар үйлчилгээ шаардагдаж эхлэв. Гэтэл ганц ширхэг салхины шилийг нь нэг сая 500 мянга орчим төгрөгөөр солих шаардлагатай болоод байна. Уурхайнууд, «Сүү» компани зэрэг үйлдвэрийн машин техник, тоног төхөөрөмжийг мөн л тусламжийн хүрээнд шинэчилсэн юм. Үнэтэй цайтай эдийг үнэгүй аваад бид олзуурхсан. Гэхдээ эдгээр машин техник, тоног төхөөрөмжийн сэлбэгийг эргээд нэг цагт солих болно шүү дээ.

Ганц компанийн эрхэнд орчих вий, сэлбэгийг хожим адил төрлийн стандарттай үйлдвэрүүдээс өрсөлдүүлж авъя, өөр ямар компанитай холбогдох боломж байна вэ гэж гэрээ хэлэлцээрт гарын үсгээ зурж байхдаа албан тушаалтнууд бодолцсон

болов уу. Буцалтгүй тусламжаар төсөл авах, хэлэлцээ хийх, хэрэгжүүлэх явцад манай талын оролцоо тун бага. Хүсэлт, саналаа уламжилснаар өндөрлөдөг. Гар сунгаж буй донорууд голдуу нутагтаа тендер зарлаж, төслийг хэрэгжүүлэх, гүйцэтгэх, зөвлөх компаниа сонгодог. Тэдэнд тийм эрх нь байна. Ингээд бид асар үнэтэй бэлгээ авна. Харин дараа нь элдэв асуудал гараад ирнэ. Өндөр хөгжилтэй орнуудад үйлдвэрлэсэн, загвар хийц нь хурдан өөрчлөгддөг техникийн эд ангийг хожим бүр илүү үнээр тусгайлан захиалж хийлгэхэд хүрч ч болно. Бэлгийн морины шүдийг үздэггүй, чанартай эд үнэтэй гэх мэтээр тайлбарлаад айсуу бэрхшээлийг давахгүй. Энэ асуудалд мэргэжилтнүүд анхаарал хандуулж байсан удаа бий. Буцалтгүй тусламжаар авах бараа, техникийн үнэлгээг хийх өөрийн аргачлал гаргахаар судалгаа хийгдэж байсан. Гэвч ийм санаачилга агентлагаас яаманд хүрч хараахан амжаагүй, өнөөдөр мартагдаж орхисон бололтой.

Тусламжаар тоног төхөөрөмжийг нь шинэчилсэн үйлдвэр аж ахуйн газруудын балансаас сонин харьцаа харж болно. Үндсэн хөрөнгийн үнэ өртгийн тал нь данхайсан харагдах вий. Хамтарсан үйлдвэр байгуулсан манай бизнесмэнүүд ч мөн ийм асуудалд толгой эргэж учраа олохгүй болчих нь бий. Хөрөнгө оруулагч-хамтрагч гадаадын компани тоног төхөөрөмж оруулаад ирнэ. Монголын тал менежментээ хэрэгжүүлнэ. Манайхан хийгээд зүтгээд байдаг. Гэтэл хамтарсан үйлдвэрийн балансад түншлэгчийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийн өртөг учиргүй томроод, хөрөнгө оруулалтын харьцаа илбэдүүлсэн юм шиг өөрчлөгдчихдөг. Хувь хүн, төр, засаг ялгаагүй энэ маягаар гайхширсан тохиолдол олон.

Төсөл тойрсон өөр нэг асуудал байна. Нийслэлийн нийтийн аж ахуйг сайжруулах төслийн хүрээнд Нисэх, Яармаг, Хайлаастанд цэвэр усны хоолой тавих ажил төлөвлөгдсөн юм. Хоёр жилийн өмнө уг хоолойн стандартыг заагаад гадаад, дотоодын компаниудын дунд тендер зарлажээ. Тендер 7-8 байгууллага орсноос манай «Хасбуу» компани шалгарсан. Эднийх Канадын талтай хамтран гадуураа хөөсөнцөр, хар цаастай хуванцар яндан хоолой нийлүүлэв. Канадаас тээвэрлэсэн мэтээр үнийн дүнд нь тусгалаа, яг ийм хоолойг Хятадаас хямд оруулж болох байсан гэсэн яриа тухайн үед гарсан. Харин тендер шалгаруулах комиссынхон, дэлхийн зах зээл дээрх ханшийн жишгийг үнийн мэдээнээс аваад, хамгийн хямд үнийн саналыг сонгож шалгаруулсан гэж үзэж байна. Иймэрхүү маргаанаас үүдээд аливаа төсөлд хэрэгжүүлэгч, нийлүүлэгчээр ажиллах нь унацтай гэсэн ойлголт төрдөг. Хэрэв ийм унац байдаг юм бол, өөрсдийн хийж чадах зүйлээ зөвхөн дотоодын компаниудын дунд тендер зарлаж гүйцэтгүүлэе гэсэн санаа ч цухалзах боллоо. Хамгийн сүүлийн жишээ нь Кувейтын сангаас олгосон зам сайжруулах зарим төсөлд гадны гүйцэтгэгч ажиллаж буйг манай ийм чиглэлийн мэргэжлийн байгууллагынхан шүүмжилдэг.

Дарханы мах комбинатад хандивлагч их зүйлээр тусалжээ. Хөргөлтийн системийг нь шинэчилж, мах ангилан шулах цехийг хөлдөөх байгууламжтайгаар бэлтгэж өгөв. Мах шулах цахилгаан хөрөөг 3600 ам.доллараар, пүүг 24 мянган ам.доллараар, мах ангилан сортлох ширээг 19 мянган ам.доллараар гэхчлэн нийлүүлсэн болохоор уг тусламжийн нийт өртөг нь хориод сая ам.долларт дөхсөн байх юм. Гэвч...Хэтэрхий үнэтэй ширээ, хөрөө биш үү? Дарханы мах комбинатын зах зээл нь ямар билээ. Бид судалгаагаа бодитой хийж, санхүүжилт хүсч чадаж байна уу? Сая сая долларын тусламж авсан атлаа үр дүн нь иймхэн, ёроолгүй сав шиг юмаа гэсэн шүүмжлэл нөгөө сайн санаат хандивлагчдаас бидэнд хожим ирэхгүй гэж үү. Хэрэгжсэн, хэрэгжиж буй, урьдчилсан байдлаар тохирсон төслүүдийн урт жагсаалт өмнө байна. Эднээс зориулсан объектдоо хүрч, бодит хөрөнгө болсон нь хэд бол. Ялангуяа засаглалын чиглэлээрх төслүүд зөвхөн удирдлагын хүрээнд, голдуу

**Мах шулах  
цахилгаан хөрөөг  
3600  
ам.доллараар,  
пүүг 24 мянган  
ам.доллараар,  
мах ангилан  
сортлох ширээг  
19 мянган  
ам.доллараар  
гэхчлэн  
нийлүүлсэн  
болохоор уг  
тусламжийн нийт  
өртөг нь хориод  
сая ам.долларт  
дөхсөн байх юм.  
Гэвч... Хэтэрхий  
үнэтэй ширээ,  
хөрөө биш үү?  
Дарханы мах  
комбинатын зах  
зээл нь ямар  
билээ.**



семинар, хурал, зөвлөгөөний байдлаар хэрэгждэг. Техник туслалцааны төслүүдийн нийт зардлын дүнд гадаадын зөвлөхөд зориулсан төсвийн жин нүсэр, 70 орчим хувьд дөхсөн тохиолдолд ч байна.

**-Бага үнэлгээтэй мэргэжилтэн авна гэхээр өөдтэй үр дүн гарахгүй тал бий.** Эндээс гарах ганцхан зам нь, манайхан өөрсдөө мэргэжилтнийг бүрэн ашиглах чадвартай байх ёстой. Бид ямар нэг хяналт тавихгүй, шахаж шаардахгүй, хэрэгцээтэй зүйлээ асууж лавлаж чадахгүй бол тэр хүн мөн л монголчуудтай адил урсгал байдалд орчихож магадгүй. Энд эхний ээлжинд гадны мэргэжилтний өндөр зардлыг шүүмжлэхээсээ илүү, өөрсдөө түүнийг аль болох бүрэн дүүрэн ашиглахыг чармайх хэрэгтэй гэж нэрээ хэлэхийг хүсээгүй нэгэн албан тушаалтан ярьсан юм.

Зээл, тусламжийн үр өгөөж, бараа материалын үнэлгээ, гэрээ хэлэлцээрт манай улс ямар эрх үүрэг, байр суурьтай оролцдогийг тодруулах явцад болгоомжилсон, дүйвүүлсэн, энэ сэдвээр санал бодлоо ярихаас татгалзсан албан тушаалтан олон тааралдсан билээ. Ер нь зээл, тусламжийн гэрээ хэлэлцээрт Монгол Улс ямар эрх үүрэгтэй оролцож, ямар агуулга нөхцөлийг зөвшөөрөөд гарын үсэг зурж, төрийн тамга дарж байна вэ? Энэ явц олон нийтэд хаалттай байгаа учир төсөл, тендер тойрсон хэл ам тасардаггүй. Гэрээ хэлэлцээрийг үзэглэсний дараа хэвлэлд нийтэлж хяналтад гаргах цаг болсон. Бүр өмнө нь санал бодлыг нээлттэй сонсох нь ч зөв биш үү.

Алив төсөл хэрэгжиж буй явцад болон хэрэгжсэний дараа тухайн объектын үйл ажиллагаанд системтэй хяналт тавьдаг байгууллага алга. Түүнчлэн өөр хооронд нь уялдуулж зохицуулж чадахгүй байна. Буцалтгүй тусламжийг Гадаад харилцааны яам, санхүүгийн зээлийг Сангийн яам зохицуулдаг. Яам, агентлагууд хоорондоо, хандивлагчид өөр зуураа, Засгийн газар доноруудтай харилцаж, уялдуулах ажил хангалтгүй байгаа. Цаашид зээл, тусламжийн нэгдсэн, сайн зохицуулалтгүй, хандивлагчийн ам харсан идэвхгүй янзаараа, үзэглэсэн хэлэлцээрээ олон нийтээс хаалттай үлдээх байдал үргэлжилбэл гарах сөрөг дагавар их. Хяналтгүй авсан их зээлийн хүлээс улсын эдийн засгийг гарцгүй болгож чадах юм.

Зээл тусламжийг зохицуулах алсын хараатай, нэгдмэл бодлого үгүй нотолсон сүүлийн баримт нь Дөрөвдүгээр цахилгаан станцыг шинэчлэх хоёр дахь үе шатны төслийн хувь заяа. Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг манай тал хэдхэн сарын өмнө хүсч байв. Харин өнөөдөр бид зангаа хувиргаж орхив. Ер нь Дөрөвдүгээр цахилгаан станцад их хэмжээний зээл авах хэрэг байна уу хэмээн нэг л өглөө эргэлзчихсэн гэж үү. Хандивлагчдын туслалцааны цаана эрх ашиг нь бий. Япон улс Монгол дахь ашиг сонирхлоо голдуу техникийн туслалцаа, түүнийг дагасан сервис үйлчилгээгээр бий болгохыг эрмэлзсэн бол, манай засаг захиргааны бүтцийг америк зарчмаар ажиллуулахыг АНУ хүсч, ийм чиглэлээр олон төсөл хэрэгжүүлдэг. Их гүрнүүдийн ашиг сонирхол Монголд бий болох нь ганц нэгний хараат байхаас хавьгүй дээр. Гэхдээ бид тэдний эрх ашгийг мөргөлдүүлэлгүй, мөн өөрийн байр суурьтай оролцох ёстой. Ингэхгүй бол дээр дурдсан төслийнх шиг ойлгомжгүй байдал бий болгоно.

**«Сүүлийн үед Японы буцалтгүй тусламж хэрэгжсэн газруудыг хувьчилж, шинээр төсөл хэрэгжүүлэхээр санал болгож буй байгууллагуудыг ч хувьчлах чиглэлтэй байгаа нь хоёр талын цаашдын хамтын ажиллагаанд тодорхойгүй нөхцөлийг буй болгох талтайг Японы тал зориуд тэмдэглэж байгааг анхааралдаа авах хэрэгтэй байна»** гэж Засгийн газарт саяхан танилцуулсан албан баримтад тэмдэглэжээ.

«Сүүлийн үед  
Японы буцалтгүй  
тусламж  
хэрэгжсэн  
газруудыг  
хувьчилж, шинээр  
төсөл  
хэрэгжүүлэхээр  
санал болгож буй  
байгууллагуудыг ч  
хувьчлах  
чиглэлтэй байгаа  
нь хоёр талын  
цаашдын хамтын  
ажиллагаанд  
тодорхойгүй  
нөхцөлийг буй  
болгох талтайг  
Японы тал зориуд  
тэмдэглэж байгааг  
анхааралдаа авах  
хэрэгтэй байна»  
гэж Засгийн  
газарт саяхан  
танилцуулсан  
албан баримтад  
тэмдэглэжээ.



# Бэлгийн морины шүдийг үзье

Бэлэг авч байна гэж зүүдэллээ. Ягаан туузаар ороосон ялдамхан хайрцагтай юм. Хурдхан нээгээд үзмээр байсан ч хүнд нойр гар дараад хөдөлгөдөггүй. Бэлэг бүр сониуч зан даллаж, харц булаадаг хойно. Нэг улс нөгөөдөө «Май үүнийг ав даа, хө» гэх нь ч бий. Түүнийг буцалтгүй тусламж хэмээн ерөнхийд нь нэрлэнэ. Японоос Монголын ард түмэнд, Германы андуудаас, Америкийн татвар төлөгчдөөс та бүхэнд илгээв гэх мэт хаягтай харагдана.

Буцах ийм хаягтай бэлэг манай хөдөө аж ахуйн салбарынханд иржээ. Нээгээд үзвэл трактор, комбайнууд байх юм. Радио хангинаж, агааржуулагч үлээлээ. Магнитофон сонсч ч болно. Хараач, халуун сав байна. Муухан автомашинаас дээр юм аа. Тракторуудыг КР-2 төслийн хүрээнд хандивлагчаас Монголын ард түмэнд илгээлээ. Албаны баримт бичиг дээр буцалтгүй тусламж хэмээн түүнийг тодруулжээ. Эргэж төлөх барих зүйлгүй, зүгээр л бэлэг. Манай хөдөө аж ахуйнхан мэдээж баярлаж дахин дахин бэлэг авмаар санагдсан нь лав. Нөгөө тохь тух сайн, гял цал тракторыг бидэнд үнэгүй өгч, харин түүнийг нь монголчууд дахин зээлдүүлэх замаар хөрөнгө мөнгө арвин сан бий болгох, тэгээд мөнгөөрөө шинэ техник авах зорилготой байлаа. Гаднаас үнэгүй ирээд байх бэлэгнээс татгалзах юутай хэцүү. Торгон туузаар ороосон буцалтгүй тусламж манайд хэр их ирсэн бол? 1990 оноос хойш 1.3 тэрбум ам.доллартай тэнцэх ийм тусламж авсан гэж Санхүү, эдийн засгийн яам зарлалаа. Тэгвэл хөнгөлөлттэй зээл гэдэг нь юу билээ? Энэ хоёр юугаараа ялгаатай юм? Хүн бэлэг сарвайгаад байхад яагаад заавал хөнгөлөлттэй ч гэсэн зээл авдаг юм бэ? Бодлого боловсруулагчид «Одоо хөнгөлөлттэй зээл биш, буцалтгүй тусламж түлхүү авна» гэж яагаад зарлаад эхлэв?

*-Та нарын нүд чинь орой дээр гарч ойлгохоо болино гэж төсөв батлагдсаны дараа хийсэн хэвлэлийн хурал дээр Ч.Улаан сайд сэтгүүлчдийг егөөджээ. Төсвийг ойлгоход төвөгтэй байх магадгүй юм. Харин манай улс ямар өртэйг багцаалах сонирхол олонх иргэдэд байгаа болохоор хамтдаа тайлбар хайя.*

**«2000 он гэхэд чөлөөт валютын өр 880 сая ам.долларт хүрэх юм. Энэ нь нэг хүнд 380 ам.доллар ногдоно гэсэн үг»** хэмээн бүр дөрвөн жилийн өмнө П.Жасрай тэмдэглэж байлаа. Тэгвэл хөнгөлөлттэй зээлийн хэмжээ өнөөдөр 1.1 тэрбум ам.доллартай тэнцэж миний, таны өр нэмэгдсэн. Орост төлөх их өрийн тухай дасч сурснаараа бүү бодоорой. 1990 оноос хойш доноруудаас авсан зээлийн зарлагын бичиг халаасанд минь зузаарч байнаа гэсэн үг. Тиймээс сонирхохгүй, учрыг нь мэдэхийг хүсэхгүй хэн байх вэ. Улаан сайдын хэлдгээр нүд орой дээр гарсан ч хамаагүй тайлбар хайх учиртай том асуудал билээ.

Зээл, тусламжийн ашиглалт, нэгдсэн удирдлага, бодлогын сэдвээр «Өнөөдөр» сонин 1999 оны тэр эгзэгтэй үеэс эхлэн бичсэн. Хандивлагчдын аравдугаар уулзалтын дараа тулгасан баярын хундага харших чимээ хараахан намжаагүй үед дахин уг сэдвийг хөндөхөд хүрлээ. Энэ нь зөвхөн сонгуультай холбон солиорч хийрхэх сэдэв, зууш биш юм. Токиод саяхан өндөрлөсөн уулзалтын дараа зарлаад байгаа 335 сая ам.долларыг ногоон чигээр нь багсайтал бүү төсөөлөөрэй. Түүний тал нь бэлэг буюу буцалтгүй тусламж, үлдэх нь хөнгөлөлттэй зээл. Харьцаа нь яг хэд болохыг мэдэхгүй. Яагаад гэвэл хандивлагчдын санал болон манай хүсэлтийг нэгтгэж байж харьцааг тодруулна. Санхүү, эдийн засгийн яамны дөрөвдүгээр давхарт суудаг арваад мэргэжилтэн ийнхүү эцэслэж тохиролцох их ажлыг нугалах юм. Бидний халаасанд яваа өр бол хөнгөлөлттэй зээл нэрээр ирсэн. 1990 оноос хойш авсан 1.1 тэрбум ам.долларын хар дансыг хүн бүрт оноовол 423 ам.доллар нэхэгдэнэ гэсэн үг. Харин буцалтгүй өгсөн тусламжийн хэмжээ үүнээс ялимгүй их буюу 1.3 тэрбум болжээ.

## ӨРӨӨ ТӨЛЖ БАЙГАА ЮУ?

Төлж байгаа. Энэ жил 30 орчим саяыг, ирэх онд ч ялгаагүй өгнө. Тэрбум гаруй ам.долларын хөнгөлөлттэй зээлийг барагдуулна гэдэг амаргүй ажил. Өр маань дотооддоо нэг жилд үйлдвэрлэж буй бүх бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлбэртэй бараг тэнцээд ханхалзаж байна.

-Хандивлагчдаас авсан зээлийн өр цаашид Монгол Улсын эдийн засагт ямар дарамт үзүүлэх вэ? Оргил үед хэдийг төлөх вэ гэсэн асуултыг Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, бодлого зохицуулалтын газрын дэд дарга П.Ганхуягт тавилаа.

-Төлөлт график ёсоор нягт нямбай явж, тооцоо барьж чадаж байгаа. 2003 оны хувьд 30 сая ам.доллар өгөхөөс 5-6 сая нь хүү, үлдэх нь үндсэн өр. Жилд ийм хэмжээгээр буцаан төлөхөд манай эдийн засагт өнөөдөртөө хүндрэл багатай. Харин 2007-2010 оны оргил үедээ жилд 50 сая гаруй ам.доллар өгнө. Гадаад худалдааны эргэлт, төсвийн нийт орлоготой харьцуулбал гайгүй тоо л доо. Дандаа хөнгөлөлттэй, хөгжлийн зээл авсан болохоор дор хаяад 25-40 жилийн дотор эгүүлэн өгч барагдуулна гэсэн үг. Ингэхдээ эхний арваас доошгүй жилд нь төлбөрөөс чөлөөлөгдсөн төдийгүй хүү нь бага, 0.75-2 хувийн хооронд юм. Иймээс зээлийн нийт хэмжээ өндөр харагдаж буй ч дарамт нь бага.

Гэхдээ цаашид өрийн дарамтад орохгүйг ямагт хичээж явах учиртай. Эдийн засгийн өсөлт бий болгох, эргүүлж төлөх чадвартай салбартаа зээл авах нь зөв. Өнөөг хүртэл хүндрэлтэй газраа мөнгө хаяхаас аргагүй байлаа шүү дээ. Өмнө нь улсын үйлдвэрийн газрууд гэх мэт төрийн үйлчилгээнд гадаадын тусламжийг зарцуулсан юм. Герман зэрэг улсаас хувийн секторыг дэмжих зориулалттай зээл мэр сэр ирж байсан. Цаашид бизнесийн салбарт зээл, тусламжаар хөрөнгө оруулах боломж сайжирна хэмээн хариулав.

## БЭЛГЭЭ БУЦААЖ БОЛОХ УУ?

Одоо арай сонирхолтой зүйлсийн тухай ярилцъя. Хормой шүргэн сүнгэнэж одох, хөх судалтай том автобус Улаанбаатарын гудамжнаа ерээд оны дундуур үзэгдсэн юм. Үнэгүй, зүв зүгээр өгсөн бэлэг байлаа. Харин цонхных нь шил

хагарвал 2000 орчим ам.доллараар солиорой. Үйлдвэрлэсэн нутагтаа бол бүр 5000 доллар ч хүрдэг байх шүү. Уурхайнууд, Дарханы Мах комбинат, «Сүү» компанид гэнэт л гял цал техник хэрэгсэл үзэгдэх болсныг санана уу. Мах шулах цахилгаан хөрөөг 3600 ам.доллараар, пүүг 24 мянган ам.доллараар, мах ангилан сортлох никель ширээ тун гоёмсог, 19 мянган долларын өртөгтэй, сүү зөөх хөргөлтийн систем бүхий сайн машин 33 сая төгрөгөөр үнэлэгдэн Монголд ирж билээ. Буцалтгүй өгсөн тусламжийн өртөг манайд огт падгүй санагдавч өнөөх төслийн нийт үнэлгээ энэ мэтээр ахисаар асар өндөр үзүүлэлттэй болсон харагдана.

Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд авсан бэлгээ нэмээд тооцвол 1.3 тэрбум гэх том тоо данхайж орхисныг дахин дурдъя. Донорууд торгон туузаар ороосон буянаа хэн нэгэнд зүгээр л хүртээгээд явдаг гэж үү? Буцалтгүй тусламжийн төсөл хэрэгжүүлсэн улсын үйлдвэрийн газрынхан бэлэгний нюансыг эхэлж мэдэрчээ. Загвар хийц нь түргэн шинэчлэгддэг гоёмсог техникийн сэлбэгийг солих, дагалдах үйлчилгээ шаардагдах үест гадаадын аль нэг компанийн хараат болж буйгаа ойлгосон хэрэг.

Сонгосон газар оронд ашиг сонирхлоо соёолуулан бататгах эрмэлзэл аль ч хөгжингүй улсад бий. Түүнийг буцалтгүй тусламжийн бодлогоороо дамжуулан хэрэгжүүлдгийг гурав дахь ертөнцийнхөн сайн мэднэ. Тун саяхан Америкийн засаг захиргаа гадаад бодлогын гурав дахь тулгуур буюу хөгжиж буй улсуудыг дэмжих эрмэлзлэлээ илэрхийлжээ. Есдүгээр сарын 11-ний үйл явдлаас хойш их гүрэн хилийн чанад дахь үйл ажиллагааныхаа зарчмыг ингэж үндсээр нь өөрчилсөн юм.

Тусламжийн гар даган буурай орнуудад төслүүд хэрэгжсээр байна. Монголчууд түүнийг хэрэгжүүлж мэргэшив. Буцалтгүй тусламжаар ийм төсөл авмаар байна гэсэн санал Санхүү, эдийн засгийн яамны дөрөвдүгээр давхарт овоорч, цаанаас нь мэргэжилтнүүд цухуйхтай үгүйтэй сууна. Тэр олон хавтсыг шүүгээд, манайд үнэхээр хэрэгтэй юм аа гэж үзсэнээ доноруудад санал болгож байна. Нөгөөдүүл мэдээж ухаалаг хүний зангаар ийм төсөл хэрэгжүүлэх нь Монголд үр өгөөж өгөх эсэхийг эхлээд судална, давхар тухайн улсын эрх ашгийг бодолцоно. Ингээд өөрийн компани, байгууллагуудынхаа дунд тендер зарлаж, тоног төхөөрөмжөө үнэлэн, технологую холын нутагт нэвтрүүлнэ. Эдүгээ гадаадын Засгийн газрууд өөрт ойр компаниудаа дэмжих замаар гурав дахь ертөнцөд төсөл хэрэгжүүлэх эрх олгодог хатуухан хэлэхэд мафи маягийн бодлоготой болжээ. Буцалтгүй тусламжийн гэрээ хэлцэл хийх үндсэн зарчим ийм. Хөнгөлөлттэй зээлийнхээс чанарын ялгаатай байгаа биз.

Харин хөнгөлөлттэй зээлийг эгүүлэн төлөх хариуцлагатай хамт бидэнд захиран зарцуулах эрх, сонголт ирдэг. Тэгвэл буцалтгүй тусламж хандивлагчийн үзэмжээр шийдэгдэж байна. Ийм тохиолдолд баян орнууд, олон улсын санхүүгийн байгууллагынхны санал болгосныг үргэлж үг дуугүй дагах учиртай гэж үү?

## АВААД Л БАЙХ УУ?

Чимээгүй толгой дохиод суух хэрэггүйг нөгөө үнэтэй сэлбэг, сервисүүд сануулаа. Дор хаяад бид дотооддоо судалгаа сайн хийх учиртай. Яам бүр «Төсөл олохоор зүтгүүлээд үзье» гэдэг зангаа хаяж, нэг бодлогоор хэрэгцээгээ зангидахыг оролдох цаг болжээ. Энэ ажлыг нэн даруй эхлэхгүй бол хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн нэгдсэн дүн хоёр тэрбум ам.доллараас даваад цойлчихлоо. «Төслийн санал буцаах тохиолдол ч бий. Ингэснийхээ төлөө төсөл цуцалж, хүнд суртал гаргалаа гэх зэмийг хандивлагчдаас сонсдог» гэж Санхүү, эдийн засгийн яамны мэргэжилтнүүд

**Эдүгээ гадаадын Засгийн газрууд өөрт ойр компаниудаа дэмжих замаар гурав дахь ертөнцөд төсөл хэрэгжүүлэх эрх олгодог хатуухан хэлэхэд мафи маягийн бодлоготой болжээ. Буцалтгүй тусламжийн гэрээ хэлцэл хийх үндсэн зарчим ийм. Хөнгөлөлттэй зээлийнхээс чанарын ялгаатай байгаа биз.**

ярьсан юм.

Гадаадын зээл, тусламжийг нэгдсэн бодлогоор зохицуулах, хянах оролдлогыг бүр ерээд оны эхэнд хийсэн ч бүрэн утгаараа уг ажил одоо ч хэрэгжээгүй байна. Ч.Улаан сайдын үед эрхиш зээл, тусламжийн замбараагүй «явдал» цэгцэрч, Санхүү, эдийн засгийн яамнаа нэг гарт төвлөрчээ. Өмнө нь Үндэсний хөгжлийн газар, Үйлдвэр худалдааны яам, Гадаад хэргийн, Сангийн яамдын хооронд хавтастай баримтуудыг зөөх шахуу хэсэглэн удирдаж, холион бантан болдог байв. Зээл, тусламжийг зохицуулах зөвлөл ч байгуулагдаж, бүр байгаад тэдний ажлыг уялдуулах шинэ төслийг хүртэл НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлээд үзлээ.

Энэ оны долдугаар сараас хүчин төгөлдөр болсон Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль төрийн нэгдсэн бодлого бий болох юм байна аа гэсэн итгэл төрүүлсэн юм.

**Газар тариалангийн томгүй аж ахуй олонтой Монголд дээрхээс бага оврын, арай энгийн техник хэрэгтэйг бүгдээрээ мэдэрч байлаа. Аль нэг төслийн багт ажиллаж буй гадаадын мэргэжилтнүүдийн зардал тун өндөр гэдгийг ч мэр сэр ярьцгаасан. Зарим төслийн өртгийн гуравны нэг нь л бодит ажил хэрэг боллоо хэмээн ханцуйдаа нөгөө нь шивнэв.**

### **ХЭН ХЯНАХ ВЭ?**

Халуун сав, магнитофонтой, сэрүүн агаар үлээж сэтгэл тэнийлгэсэн сайхан трактор, комбайн авах эзнээ хүлээгээд хашаанд «уяатай» удсан нь сонин. Тусламжийг дамжуулан зээлдүүлээд, улмаар фонд бий болгох гэсэн оролдлогоос болоод гял цал техникүүд эзэнгүйдэх шахав. Газар тариалангийн томгүй аж ахуй олонтой Монголд дээрхээс бага оврын, арай энгийн техник хэрэгтэйг бүгдээрээ мэдэрч байлаа. Аль нэг төслийн багт ажиллаж буй гадаадын мэргэжилтнүүдийн зардал тун өндөр гэдгийг ч мэр сэр ярьцгаасан. Зарим төслийн өртгийн гуравны нэг нь л бодит ажил хэрэг боллоо хэмээн ханцуйдаа нөгөө нь шивнэв.

Бид хэрэгцээгээ хэрхэн бодитой илэрхийлж, хаана түүнийг зангидах, ямар байр суурь, эрх мэдэлтэйгээр гэрээ хэлцэлд оролцох вэ? Монгол Улсын эдийн засаг сэргэж, хөгжлийн шатандаа дэвшиж байна хэмээн олонтаа дуугарах боллоо. Гэсэн ч хэсэгтээ зээл болон буцалтгүй тусламж авсаар, урагшлах зам дээр бат зогслооо хэрэглэнэ. Хүнд бэрх цагт хандивлагчдын дэмжлэг биднийг аварчээ. Одоо зээлсэн мөнгө, ач тусыг эгүүлэн өгөх эдийн засгийн бололцооныхоо төлөө хамтран ажиллах үе ирэв. Хэрэгжүүлж буй төслүүдэд донор хяналт тавьдаг, яамд анзаарсан болдог өмнөх туршлага хангалтгүй боллоо. Хэнтэй, юун тухай тохиролцож зээл авсан, ийм тусламж Монголд хэрэгтэй эсэх, торгон туузтай хайрцаг дотор ямар бэлэг ирснийг ялгаж салгах хамгийн сайн хяналтыг олон нийт хийж чадна. Зээл, тусламж авахаар үзэглэсэн гэрээ хэлэлцээрийг бүрэн эхээр нь хэвлэлд нийтэлж, бодлогын зөв буруугаа харилцан хянахыг амьдрал шаардаад байна.

Түүнчлэн «Үнэгүй ирсэн юм чинь» гэж задгайрдаг өөрсдийнхөө сэтгэлгээг өөрчилъе. Харь орны татвар төлөгчдийн хөлс хүчээр үнэлэгдэх тусламжийг давхар хүндэтгэе. Донорууд хэрэгжүүлж буй ажлаа олон нийтэд сурталчилж өгөөч гэж биднээс хүсдэг. Тиймээс төслийн зардалд сурталчилгааны хэсэг төлөвлөх шаардлага ч бий. Эцэст нь зээл, тусламжийн чиглэлээр мэргэшсэн төрийн албан хаагчдаа аль ч намын засаглалын үед ялгаагүй тогтвортой ажиллуулъя. Амьдралд хэрэгжүүлж чаддагсан бол уг нь тун дажгүй хууль баталсан билээ. Аар саар хэрэгцээ болгоноо зүтгүүлэх бус, зээл, тусламжийн талаар баримтлах төрийн нэгдсэн бодлогоо түрүүнд нь тавья.

# Оросын тал авлагынхаа хэсэгт компаниудын хувьцааг авах бодолтой байна уу?

Арван тэрбумын өр гэдэг их тоо. Гэхдээ арван тэрбум ам.доллар уу, эсвэл рубль юм уу гэж ялгавал тун зөрүүтэй тооцоо гарна. Бид ийм хэмжээний шилжих рублийг ОХУ-д төлөх учиртай аж. Тэгвэл шилжих рубль хэмээх төлбөрийн нэгжийн ам.доллартай харьцах албан ханш өнөөдөр хэд байна вэ? Нэг шилжих рубль нэг ам.доллартай тэнцэнэ гэж Оросын тал тооцдог бололтой. Энэ нь бодитой тооцоо мөн үү?

**Шилжих рубль** нэрийг ханшийн үзүүлэлтийн хүснэгтээс бид өнөөдөр олохгүй. Тэгвэл 1990 оноос өмнө монголчуудын оросуудад тавьсан өр нь социалист орнуудын хувьд дээр цагт хатуу валют нь байсан ийм нэгжээр тайлбарлагдаж буй төдийгүй цагаан морин жилээс хойш хүү нь бодогдоод иржээ. Хүү нь өнөө нэг тэрбум шилжих рубль болсон гэж Оросын тал үздэг байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн арваад жилд бидний авсан нийт зээл, тусламжийн дүнтэй бараг дүйцэх шахам хэмжээний хүү нэмж нэхэгдэх болж байна. Тэгэхээр бид арав бус, арван нэг гаруй тэрбум шилжих рублийн өглөгтэй болох нь.

1990 оноос хойшх хугацаанд мөнөөх шилжих рублиэр хүү бодох ёстой байсан эсэх, ер нь ийм нэг рублийг нэг ам.доллартай тэнцүүлэх нь бодитой харьцуулалт мөн эсэх, цаашлаад түүхийн өөр нөхцөл байдалд янз бүрийн зарчмаар өгч авалцсаныг гэрчлэх энэ тоо бүгд өр юм гэж бид өөрсдөө хүртэл их дуугаар зарлаад байх нь зөв эсэх гээд олон асуудал эндээс гарч байна. Эдүгээ их өр гэж нэрлэх болсон уг асуудлыг найрамдалт хөршүүд хэн хэндээ зовлон багатайгаар шийдвэрлэхээр чармайж буй юм. Орос-Монголын Засгийн газар хоорондын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын наймдугаар хуралдааны Оросын талын нарийн бичгийн дарга В.Демидов Оросын дуу хоолой радиод саяхан өгсөн ярилцлагадаа «Монголын компаниудын хувьцааг авах, мөн өрийн зарим хэсгийг Парисын клубт шилжүүлэх зэрэг янз бүрийн арга замаар асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэж байна» хэмээн мэдэгдэв. Чухам ямар компаниудын тухай Оросын тал эн түрүүнд дурьдах нь тодорхой. «Эрдэнэт», «Монросцветмет» болон Бор-Өндөрийн жоншны үйлдвэрийн манай талд ногдох хувьцааг авах нь тэдэнд ашигтай. Харин бидний хувьд жишээ нь «Эрдэнэт»-гүйгээр амь зуух аргагүй нь мэдээж.

Өөр нэг зүйл нь, Парисын клуб хэмээх гуравдагч байгууллага хоёр орны хоорондын өрийн асуудлыг зохицуулагчаар гарч ирэх тухай яриа. ОХУ 1997 онд энэ байгууллагын гишүүн болсныхоо хувьд манай өрийг тус клубээр дамжуулан шийдвэрлүүлэх боломжтой юм. Ингэвэл үйл явдал хэрхэн өрнөх вэ? Парисын клубийн зүгээс өр төлөх хэд хэдэн төрлийн нөхцөл тавьдаг бөгөөд хамгийн «зөөлөн» болзол нь нийт өрийн 70 хүртэл хувийг хөнгөлөх буюу хүчингүй болгох явдал. Ингэж «хөнгөхөн» тусах завшаан бидэнд олдлоо ч цаана нь гурван тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээтэй өр дахиад хоцрох юм. Өөрөөр хэлбэл, олон улсын байгууллагын илүү хатуу болзол тулгалтад өртвөл

**1990 оноос хойшх хугацаанд мөнөөх шилжих рублиэр хүү бодох ёстой байсан эсэх, ер нь ийм нэг рублийг нэг ам.доллартай тэнцүүлэх нь бодитой харьцуулалт мөн эсэх, цаашлаад түүхийн өөр нөхцөл байдалд янз бүрийн зарчмаар өгч авалцсаныг гэрчлэх энэ тоо бүгд өр юм гэж бид өөрсдөө хүртэл их дуугаар зарлаад байх нь зөв эсэх гээд олон асуудал эндээс гарч байна.**

манай хувьд байдал улам хүндрэх нь дамжиггүй. Оросын тал ч үүнийг сайтар ойлгож буй нь лавтай. ОХУ нь Вьетнам улсын төлөх өрийг 85 хүртэл хувиар хөнгөлсөн явдал бий. Гэхдээ ОХУ-ын тал ийм зарчмаар манай өрийг шийдвэрлэх саналыг албан ёсоор Монгол Улсад тавиагүй байна. Вьетнамын Орост өгөх учиртай хөрөнгө нь дайны нөхцөл байдлаас үүдэлтэй тул Монголынхоос зарчмын хувьд ялгаатай гэж тэд тайлбарлаж болох юм.

Далан хувийг хүчингүй болгодог хувилбарын тухайд хэрэв хэрэгжвэл, өрийн үлдэх хэсэг буюу бидний жишээгээр гурван тэрбум ам.долларыг 23 эсвэл 33 жилийн хугацаанд аажим төлөх маягаар тэглэгдэх аж. Парисын клубийн гишүүн орны хувьд 70 дээр дахин арван хувь нэмж хөнгөлөх бололцоо уг нь Оросын талд байдаг бололтой. Эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллагч Вьетнам улсад ОХУ ахиу хөнгөлөлт үзүүлсэн байж болох юм. Манай хоёр улсын тухайд эдийн засгийн хамтын ажиллагаагаа цаашид идэвхжүүлэх эхлэлийг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путиний айлчлалын явцад хийгдсэн гэрээ хэлэлцээрүүд нотолсон. Их өрийг шийдвэрлэх хувилбар бүр ярвигтай учир удаан хугацааны ур дүйтэй хэлцлийг хоёр талын улстөрчид, санхүүгийн мэргэжилтнүүдээс шаардах нь дээрх баримтуудаас харагдаж байна.

**2000 он**



# Өрийг хөнгөлөх Б.Ельциний хувилбар буюу монголчуудын мөрөөдөл

## АРВАН ЖИЛИЙН ӨМНӨ БИД ӨРИЙН ТУХАЙ ИЛҮҮ ЗОРИГТОЙ ЯРЬДАГ БАЙВ

ОХУ-ын ДУМ ирэх оны улсын төсвийн хуулийн эхний хоёр удаагийн хэлэлцүүлгийг нэгэнт хийжээ. Ерөнхийлөгч асан хүний эрх ямбын байдал гэх мэт халуун асуудлуудыг эцэслэн шийдвэрлэснийхээ дараа ДУМ төсвийн тухай хуулийн үлдсэн гурав, дөрөв дэх хэлэлцүүлэгт шамдан орох аж. Тус улсын хөдөө аж ахуйн салбартаа өгдөг татаас төсвийнх нь зарлагад нэлээд хувийг эзэлж буйг эндээс харж болно. Гэвч хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэл эрхлэгчид энэ өдрүүдэд Москвад жагсаал цуглаан хийж буйг Оросын олон нийтийн телевизийн мэдээллийн цагаар үзүүлж байна. Хөрөнгө оруулалтыг илүү дэмжиж, ахиу татаас өгөхийг тэд Хөдөө аж ахуйн сайдаасаа шаарджээ. Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан тооцоогоор бол жил тутам 40 тэрбум ам.долларын татаасыг Орос улс тус салбарт зарцуулдаг аж. Харин ерээд оноос өмнө ОХУ-ын төсвийн зарлага өнөөгийнхөөс арай өөр бүтэцтэй байсан байж болох юм. Тэр цагт хойд хөршийнхөө мал аж ахуйн гаралтай хэрэгцээт түүхий эдийн бэлтгэлийн голыг Бүгд Найрамдах Монгол Ард Улс нугалдаг байв. Мал аж ахуйн гаралтай түүхий эд төдийгүй зарим төрлийн эрдэс баялгийг ЗХУ дотооддоо бэлтгэснээс даруй хоёроос гурав дахин хямд зардлаар ийнхүү Монголоос импортолж байлаа. Өртөг хямдруулсны үр ашгийг үржүүлж тооцсон тохиолдол ч бий аж. Наяад оны сүүлээр манай улсын ЗХУ-д төлөх өрийн асуудлыг нэлээд идэвхтэй хэлэлцэж байсан бөгөөд тэр цагт хоёр талын Төлөвлөгөөний комиссынхон ийм тооцоо хийсэн бололтой. Монголоос урт хугацаанд хямд өртгөөр нийлүүлсэн түүхий эдийн үнийн зөрүүний унац нь арван тэрбум гаруй шилжих рублийн өртэй тэнцэх шахам юм хэмээн хоёр талын санхүүгийн мэргэжилтнүүдийн хүрээнд яригдаад замхарсан гэсэн үг.

Монголоос урт хугацаанд хямд өртгөөр нийлүүлсэн түүхий эдийн үнийн зөрүүний унац нь арван тэрбум гаруй шилжих рублийн өртэй тэнцэх шахам юм хэмээн хоёр талын санхүүгийн мэргэжилтнүүдийн хүрээнд яригдаад замхарсан гэсэн үг.

## ХАРИН ӨНӨӨГИЙН УЛСТӨРЧИД ӨРИЙН ТУХАЙ ЯРИХААС ЭМЭЭХ БОЛОВ

Монголын өрийг багасгах үндэслэл бий гэж зүрхэлж дуугарах ултөрч өнөөдөр үгүй болжээ. Их өрийн асуудлыг «барьж авахаас» эмээдэг зуршил эдүгээ манайд тогтоод байна. ОХУ-ын Ерөнхий сайд өнгөрсөн зун Монгол Улсын Ерөнхий сайдад захидал илгээжээ. Уг захидалд өр төлүүлэх өөрийн хувилбараа Оросын тал илэрхийлсэн байх юм. Арван тэрбум шилжих рублийн 70 хувийг нь хөнгөлөөд, үлдэх хэсгийг тодорхой зарчмаар төлүүлэх тухай уг захидалд дурдсан бололтой. Харин захидлын хариуг Монголын түшээд өгөлгүй уяж орхижээ. Эцэст нь Элчин сайд О.М.Дерковский ОХУ-ын Ерөнхий сайдын захидалд хүндэтгэлтэй хандахыг манай талаас «гуйсан» байна.

Өрийн асуудлыг «барьж авах» зоригтой улстөрч манайд байхгүй хэрэг үү? Эсвэл өөр шалтгаан байна уу? Өрийн цэвэрлэгээ гэсэн нэр томъёо хааяа нэг улстөрчдийн амнаас сонсогдох болоод байгаа билээ. ОХУ-ын зүгээс нэгэнт зарлаад байгаа 11,3 тэрбум шилжих рублийн авлагыг юуны өмнө нягталж харах шаардлага бийг цэвэрлэгээ хэмээн нэрийдэж буй юм болов уу? Нэг шилжих рубль ерэн оныг хүртэлх хугацаанд үнэхээр нэг ам.доллартай тэнцэх чадавхитай байсан уу? ЗХУ-д үйлдвэрлэсэн машин механизм, тоног төхөөрөмж

**Иймэрхүү  
үржүүлгийн өнгө  
аясыг харахад  
ам.доллар,  
шилжих рубль  
хоёрыг шууд  
тэнцүүлэх тооцоо  
эргэлзээ  
төрүүлэхээр  
байна.**

тэр цагт дэлхийн зах дээр хэдэн ам.доллараар үнэлэгдэх байв? Шилжих рублийг ам.доллартай тэнцүүлж буй харьцаа бодитой эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийгдсэн болов уу? Оросууд шилжих рублиэ 0.3-8 хүртэлх коэффициентээр үржүүлж дотооддоо хэрэглэдэг рублиэрээ илэрхийлсэн үнэлгээг гаргадаг байжээ. Ингэхдээ арилжаа наймаа хийсэн, өгч авалцсан улс бүрийн хувьд өөр коэффициент сонгон мөнөөх шилжих рублиэ үржүүлж ирсэн. Иймэрхүү үржүүлгийн өнгө аясыг харахад ам.доллар, шилжих рубль хоёрыг шууд тэнцүүлэх тооцоо эргэлзээ төрүүлэхээр байна. Үнэлгээ тооцооны иймэрхүү гажуудлыг нарийн гаргавал бараг 3,3 тэрбум шилжих рубль их өрөөс хасагдана гэсэн санхүүгийн мэргэжилтнүүдийн дүгнэлт ч дээхнэ үед гарч байсан аж. Улстөрчид өөрийн цэвэрлэгээ хэмээх учир битүү зүйл ярьдгийн нэг шалтгаан нь иймэрхүү «нюансаас» үүдэлтэй юм.

Нарийн ширийн мэдээллээс хол явдаг жирийн иргэдэд ч үнэлгээний гажуудал ойлгогддог. Тухайлбал, УАЗ-469 машиныг арав орчим мянган шилжих рублиэр бодож тооцдог байсан тухай яриа бий. Тэгвэл өнөөдөр «Да хүрээ» захаас ийм машиныг гурван мянга гаран ам.доллараар авч чадна гэдгээ иргэд эрхбиш мэдэх нь лав. Түүнчлэн олон нийт «хар ухаанаараа» тунгааж чадах өөр үндэслэлүүд ч байх юм. Цэргийнхээ баазыг нутаг дэвсгэрт нь байрлуулсны хариуд төлбөр төлдөг орчин цагийн жишгийг шинэ үеийн монголчууд хэлэлцэх болжээ. Гуч гаруй жил Зөвлөлтийн асар олон тооны цэрэг, техник Монгол Улсын нутагт байрласны төлбөр нь манай аюулгүй байдлын баталгаа байжээ хэмээн лоозон маягаар тайлбар хийж болно. Тэгвэл Зөвлөлтийн ард түмний өгөөмөр тусламж гэсэн өөр нэг лоозонг эргэн саная. Монголчуудын сэтгэлд гүн бат хоногшсон холбоо үгс энэ цагт арван тэрбум ам.долларын өр шир болж биднийг дарна гэдэг эргээд тайлбарлахад төвөгтэй асуудал.

## Б.ЕЛЬЦИНИЙ ӨР ХӨНГӨЛӨХ ХУВИЛБАР

ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Ельцин өнгөрсөн оны арванхоёрдугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандитай уулзахдаа нэг хувилбар дурдаад авсан тухай ярилцдаг. Нийт өрийн тал хувийг хөнгөлж, үлдэх талынх нь бүтцийг өөрчлөх боломжтой талаар уг уулзалтын үед ярьсан бололтой. Цухуйлгаад өнгөрсөн хувилбар нь цаашид манайд хэрхэн тусч болохыг «ургуулан» төсөөлөхийг оролдъё. Таван тэрбумын өртэй хоцроод, түүнийг ОХУ Парисын клубт шилжүүлэх юмаа гэж мөрөөдье. Таван тэрбум шилжих рублийн өрийн 85 хүртэлх хувийг Парисын клубийн зөөлөн нөхцөл, ОХУ-ын нааштай хандлагаар хөнгөлүүлжээ хэмээн бүр сайхнаар төсөөлье. Ингэж мөрөөдөөд мөрөөдөөд цаана нь мөн л 750-800 сая ам.долларын данагар өр хоцроод байна. Тэгвэл Парисын клуб бидэнд ээлтэй хандаж болох өөр «шаансууд» бий эсэхийг үзье. **«Нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн нь 500 ам.доллараас доош, мөн гадаад орнуудад тавьсан өр нь нийт экспортоос нь 350 хувиар их улсуудын өрийг 67 хүртэл хувиар хөнгөлөх»** гэсэн нөхцөлийг тус клуб зөвшөөрдөг аж. Дээрх заалтад үндэслэн 800 саяынхаа нэлээд хэсгийг дахин хүчингүй болгуулах алтан боломж бидэнд гарах юм биш биз. Түүнчлэн үлдэх хэсгийг ОХУ-ын хөрөнгө оруулалт маягаар манай улс дотооддоо шингээж болохыг Вьетнамын жишээ харуулж байна. Вьетнам улс Оростой нефть, хийн салбарт хоршин ажилладаг. Хамтарсан үйлдвэрээсээ ОХУ тодорхой хэмжээний цэвэр ашиг жил тутам хүртэж буй билээ.

Оросын ард түмний тусламжийн дүнг тоонд хөрвүүлж нэмж хасах нэг хэрэг. Энэ нөхөрлөлөөс монголчуудын оюун тархинд үлдээсэн их өв өнөөдөр ч үр шимээ өгсөөр байгааг хэмжиж тооцох аргагүй. Гагцхүү буурай ядуу Монгол Улсад хандивлагчдаас үзүүлж буй тусламжийн өгөөж, бидний өнөөдөр өөрсдөө

бүтээн бий болгож буй бүхэн их өрийн дарамт дор үр дүнгүй хоцрох вий гэж хоёр тал ижилхэн эмзэглэж буй юм. 1995 онд хоёр улсын Шадар сайдуудын үзэглэсэн баримт бичигт **нөхцөл байдлыг харгалзан үзэх** ийм санаа нэгэнт туссан билээ. Мөнхийн буурай, байнгын асуудалтай хөрштэй байхыг Орос улс ч хүсэхгүй нь лав.

**2000 он**

# Их өр дагасан эрвээхэй зангиатай нууцхан баяр

**Оросын эдийн засаг өсөлтийн замдаа орж, тэнд нийгэм, улс төрийн тогтвортой байдлыг эрхэмлэж, олон улсын тавцанд улс төрийн нэр нөлөөгөө илүү эрхэмлэх болсон цаг үеийн тохироо нь «их өрийг буцалтгүй тусламж байжээ» хэмээн нэрлэх боломжийг бидэнд олголоо.**

Монголын ард түмэнд баяр хүргэе. Би таван сая төгрөгийн өргүй. Уншигч Та, таны хүүхэд ч ялгаагүй, тус бүрдээ таван сая гаруй төгрөг ОХУ-д өгөх дарамтгүй боллоо. Харин хөөрч баярласнаа хорвоо дэлхийгээс сайтар нууцлаарай гэсэн шүү. Учир нь өглөг, авлагын асуудлыг ингэж зохицуулсан туршлага дэлхийд байхгүй. Эдүгээ ОХУ-д өр төлөх ёстой олон орны хувьд Монголын жишээ аятайхан дууриал, зууш болж орхих вий хэмээн их хөршөөсөө илүүтэй бид өөрсдөө зовниж гарав. Гэнэн юм. Чимээгүй байхыг бодоорой гэж оросууд захисан гэнэ. 2003 оны сүүлийн үдэш Санхүү, эдийн засгийн сайд телевизийн дэлгэцээс ингэж аяархаан сануулав. Гэвч 2004 оны эхний өдөр интернэтээр Монгол Улс хөршдөө тавьсан өрөө хэрхэн хаасан тухай нарийн ширийн мэдээллүүд хэдийнэ цацагдсан байлаа. «Онцгой», «Шуурхай» тодотголтой телевизийн мэдээнүүд он солигдох зааг дээр Монгол орон даяар цацагдаж, 00.00 цагийн харанга цохих чимээг улам хүндэтгэлтэй болгов. Хилийн чанадаас шинэ оны мэнд хүргэж ярьсан хамаатнууддаа энэ тухай яаран дуулгаж байлаа. Олон олон айл хоёр он солигдохыг хүлээлгүй оргилуун дарсаа буудуулж орхисон шалтаг нь мөнөөх өр цайрсны баяр.

Тэгтэл тэр баярын өнгө аяс нэг л тод будагтай санагдав. «1947 оноос эхлэн хуримтлагдсан их өрийн 98 хувийг чөлөөлсөн. Үлдсэнийг нь яасныг яриад яхав. Нууцлах учиртай юм» гэж төрийн түшмэл байн байн сануулла. Хуучин оны сүүлийн үдэш эрвээхэй зангиатай Ерөнхий сайд маань ганцаараа сондгойрч, бүгд түүнтэй ялалтын хундага тулгах гээд дугаарлах шахам харагдана. Аз жаргал гийсэн тэдний царайг харж залхаад, эрхбиш дараа нь урган гарах асуултын хариуг хүмүүс эрж эхлэв.

Өрөөс үлдэх хоёр хувийг нь хэрхэн барагдуулсан юм? Тэр нь яг хэд вэ? Манай эдийн засагт, бидний амьдралд ойрын үед дарамт учруулах уу? «Хандивлагчдын нэг жилд өгдөг мөнгөнөөс арай бага» гэж эрхэм сайд тодруулж туслав. Ойлгохгүй байх вий хэмээн «Их өрийн хүүд жил тутам 150 сая ам.доллар төлж яваа. Тэгвэл хоёр жилийнх нь хүүгийн нийлбэрээс бага» гэж бүр ойртуулж өгөв.

Уг нь зүгээр л «200 сая орчим ам.долларыг Монгол Улсын Засгийн газар арванхоёрдугаар сарын 30-аас өмнө «Внешэконом» банкинд шилжүүлсэн. Ерөнхий сайдын долдугаар сард Москвад хийсэн айлчлалын явцад тохиролцсон үүргээ манай тал ийнхүү биелүүлсэн учир өрийн дансыг маань хаалаа. 200 сая ам. доллар төлснөөр эдийн засаг ноцтой дарамт амсаагүй. Уг мөнгийг хаанаас гаргасан бэ гэвэл...» (Цааш нь үргэлжлэх тайлбарыг интернэтийн мэдээллээс авч болно. Л.Б) Зүгээр л дээрх маягаар тайлбарлаад өгөхийг иргэд хүлээсэн боловч энгийн зүйл болгонд нууж хаадаг зуршлаараа битүү хатуу баахан тойруулжээ. Ингэж толгой эргүүлэх тусам нь сониуч хүмүүн учрыг хайж эхэллээ. Оросууд нууцлаарай гэж захисан юм уу? Манай хоёр улс онцгой харилцаатай хөршүүд. Монгол нутагт өнгөрсөн зууны турш цэцэглэсэн ололт амжилт болгоныг 11.4 тэрбум ам.доллараар бий болгосон. Харин монголчууд хариуд нь зүгээр суугаагүй. Их хөршийнхөө нүсэр үйлдвэрлэлийг хямд түүхий эдээр мөн л бүтэн зууны турш шахам хангасан. Аугаа Оросын батлан хамгаалах болон улс төрийн аюулгүй байдлын түшиц, бамбай нь байсан гэдгийг тэртээ тэргүй дэлхий нийт мэддэг. Тиймээс ч Монголтой өөр ямар ч улс «онцгой нөхцөлөөр» өрсөлдөн барьцахгүй шүү дээ.

1995 онд Парисын клубийн 19 дэх гишүүнээр элссэнийхээ дараа ОХУ нь нэг шилжих рублиэ нэг ам.доллартай тэнцүүлэхийг зөвшөөрүүлж чадсан юм. Шинэ оросууд харилцааныхаа өмнөх нюансуудыг мартагнахыг хүссэн үе бий. Гэвч өнөөдөр, Оросын эдийн засаг хөгжлийн урагшлах араандаа орсон нэн таатай нөхцөл дунд холын хараа, уужим ухаанаар асуудалд хандах боломжтой болжээ. Өнгөрсөн жил Орос орон өөрөө 17 тэрбум ам.долларын гадаад өрийг төлж барагдуулсан. «Үүний дарамтыг манай эдийн засаг мэдрээгүй» гэж В.Путин мэдэгдсэн юм. Аварга эдийн засагтай тус улсын хувьд ядуу хөршөө шахаж туйлдуулах, хамгийн гол нь нийгэмд Оросын эсрэг уур амьсгал бий болгохыг хүссэнгүй. Тиймээс ч өрх гэр болгоны нандин баяр шинэ жилийн үдэш Ерөнхийлөгч В.Путин, Ерөнхий сайд М.Касьянов нар нийт монголчуудад бэлэг илгээв. Тэр бэлэг зөвхөн Н.Энхбаяр, түүний Засгийн газарт хаягласан эд биш байлаа. Хоёр орны найрамдалт харилцааны уламжлалд илүү хүндэтгэлтэй ханддаг улс төрийн хүчин Монгол, Оросын Засгийн газруудыг тэргүүлж буй үед ийм тохиролцоонд хүрснийг үгүйсгэхгүй. Гэхдээ их өрийн ийм, үүнээс ч хөнгөлсөн, бүрэн тэглэсэн хувилбарыг Н.Энхбаярынхаас өмнөх танхимууд ч шаардаж байсан. Бүр ерээд оны эхэнд Засгийн газар хоорондын комиссын бүрэлдэхүүнд багтан, тооцоо судалгаа хийж явсан манай Сангийн яамны мэргэжилтнүүд их өрийг тэглэх хангалттай үндэслэл бий гэж олонтаа дурдаж байсан юм.

«Их өрийг барагдуулах талаар ОХУ-ын Ерөнхий сайдын ирүүлсэн захидалд хариулж, хүндэтгэлтэй хандахыг» 1999 онд оросууд манай Засгийн газрын тэргүүнээс шаардаж байлаа. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газар болгон тэглэх хувилбарыг зөвшөөрүүлэх гэж бололцооны хэрээр ажилласан. Нийт монголчуудын хүсэл, хүчин чармайлт бий гэсэн үг.Гагцхүү энэ цаг үед түүнийг нь зөвшөөрөх таатай нөхцөл бүрэлджээ. Тиймээс түүхэн үйл явдлыг хэн нэгний хувийн намтрыг баяжуулах нялуун магтаал бүү болгог.

Оросын эдийн засаг өсөлтийн замдаа орж, тэнд нийгэм, улс төрийн тогтвортой байдлыг эрхэмлэж, олон улсын тавцанд улс төрийн нэр нөлөөгөө илүү эрхэмлэх болсон цаг үеийн тохироо нь «их өрийг буцалтгүй тусламж байжээ» хэмээн нэрлэх боломжийг бидэнд олголоо.

**2004 он**

# 250 сая ам.долларын задаргааг ХЭЛЖ ӨГНӨ ҮҮ

Олон хүн Ч.Улаан сайдаас ингэж гуйв. Гэвч тэр хэлэх янзгүй. Хамгийн сүүлд Монголын банкуудын холбооны гүйцэтгэх захирал Ж.Үнэнбат сайтар гуйсны эцэст сайд маань «Товчхон хариулъя» гэж үгээ эхэллээ.

-Ямар ч байсан гадна талд байсан том өрийг багасгаад дотроо оруулаад ирсэн. Үүнээс үүдээд энэ оныг дуустал эдийн засаг тодорхой ачаалал үүрнэ л дээ. ОХУ-д төлөх их өрийн хоёр хувийг шийдэх асуудал нь оны зааг дээр явагдсан операц. 2003 оны гүйцэтгэлээр Засгийн газар тодорхой хэмжээний нөөц бүрдүүлж чадсан учир түүнээсээ зарцуулах боломж гарлаа. Түүнчлэн шинэ оны төсөвт зарим хэсгийг төлөх байдлаар тусгасан. 50 сая ам.долларын бондыг маань хэн худалдаж авсныг та нар мэднэ. Жилийн гурван хувийн хүүтэй юм шүү дээ. Бондоо доллараар гаргасан болохоор хүү нь бидэнд арай хөнгөн тусч байгаа юм. Төгрөгөөр бодвол энэ чинь жилийн 14 хувийн хүүтэй болно. Ер нь их өрийн хоёр хувийг төлснөөр эдийн засаг ноцтой хүндрэхгүй. Амьдрал, үхэл хоёрын хооронд дөрвөн хуруу зай бий гэдэг. Үнэн, худлыг эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн үзүүлэлт гарахаар харья. Ч.Улаан сайд ийм хариулт өглөө.

Он солигдохын өмнөхөн мань сайд 250 саяын тухайд «Нууцлах ёстой юм» гэж учиртайхан зарлаж, өөрөө «хэрэг тарьсан» билээ.

250 сая ам.долларыг аль халааснаасаа гаргаж хэрхэн төлснийг мэдэх гэсэн иргэдийн энгийн сонирхолд олон хувилбартай хариулт өгсөөр уджээ. Тиймээс ч өчигдөр «Чингис» зочид буудалд болсон «Улсын төсвийн үйл явц, 2004 оны төсвийн онцлог» сэдэвт ярилцлага дээр эрхэм сайдын барааг харсан хүмүүс улигт асуултаа ээлж дараалан тавилаа.

Уулзалтын эхэнд илтгэл тавихдаа тэрбээр «Дутмаг мэдээлэл нь бүдэг бүрхэг таамаг бий болгодог» хэмээн ярьсан болохоор хуралд оролцогчид магадгүй хэлээд өгөх ч юм билүү гээд сониучлаа биз. Он солигдохын өмнөхөн мань сайд 250 саяын тухайд «Нууцлах ёстой юм» гэж учиртайхан зарлаж, өөрөө «хэрэг тарьсан» билээ. Харин шинэ оны эхний өдөр «Айвенхоу Майнз»-ын Роберт Фридлэнд Засгийн газрын 50 сая ам.долларын бондыг худалдаж авсныг интернэтээс иргэд олж уншив. «Үлдсэнийг нь хаанаас гаргасан юм бол?» гэж сонирхохгүй хүн мэдээж үгүй. Өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 30-ны өдөр Засгийн газар ээлжит бусаар хуралдаж, 100 тэрбум төгрөгийн бонд гаргахаар шийдсэнийг нэгдүгээр сарын эхний долоо хоногт монголчууд олж сонсов. Монгол Улсын валютын нөөцөөс 187 сая ам.доллар мөн гаргасан гэж төдөлгүй хэвлэлд мэдээлэв.  $50+187=...$  гээд бодож суутал «Өр төлсөн мөнгийг валютын нөөцөөс гаргаагүй» хэмээн Монголбанкны ерөнхийлөгч хариу нь олддоггүй нөгөө бодлогын нөхцөлийг өөрчилж орхив.

Тэгтэл энэ сарын 11-ний ням гаригийн «Долоо хоног хөтөлбөр»-ийг эрхэлсэн Үндэсний телевизийн сурвалжлагч 250 сая ам.долларыг хэрхэн задалж тайлбарласныг эх орон даяар сонслоо. Засгийн газрын эх сурвалжийн захиалгаар дуугарах дуртай Үндэсний телевиз доорх задаргааг олон нийтэд дамжууллаа. **Валютын нөөцөөс 100 сая ам.доллар + Монголбанкны Засгийн газарт зээлүүлсэн 35 сая ам.доллар + Фридлэндийн 50 сая** гэх мэтээр дуржигнуулав. Тэгсэн О.Чулуунбат ерөнхийлөгч Засгийн газарт Монголбанк 35 биш 100 сая ам.доллар зээлүүлсэн гэж дээрх мэдээллийг залруулж орхив. Нэмэгдэхүүний байрыг өөрчлөхөд нийлбэрийн чанар хувирах биш дээ. Гэсэн ч Засгийн газрын мэдлийн «Үндэсний телевиз»-ээр цацсан задаргааг бусад






хэвлэлийнхэн албан эх сурвалжаас нь авах гэж Санхүү, эдийн засгийн яамны дарга нарыг энэ долоо хоногийн турш царайчлаад бараагүй юм. Хажуугаар нь ОХУ-ын хэвлэлийн эх сурвалжаас авсан өөр мэдээ бүр толгой эргүүллээ. Тэнд, хамтарсан үйлдвэрүүдийн оролцоог бодолцож шийдсэн гэх шинэ өгүүлбэр харагдана. ОХУ-ын Сангийн яамны хариуцлагатай түшмэл ингэж хэлжээ.

Эцэст нь толгой нь бүр эргэсэн нэг иргэний асуултыг давъя. «Зүгээр задаргааг нь хэлчихэж болдоггүй юм уу?» «Чингис» зочид буудлын хурлын танхимд өчигдөр ийм бачимдсан асуулт тод сонсогдов. Яагаад нууцлаад байгаа юм бол гэж иргэд гайхах тусмаа асуултын хариуг шаргуу хайж эхлэв. Гэвч сайд ам нээх шинжгүй. Нээрээ тэр 250 сая ам.доллар хаанаас, хэзээ гарч орхисныг сонирхож өөрсдийгөө зовоохоо больё. Бодвол одоо дарга нар маань ам хэлээ эрхбиш нэг нийлж авсан байх. Удахгүй түүнээ сийрүүлээд хэвлэл мэдээллийнхэнд факсаар явуулж ч магадгүй. Битүү хатуу байх дэмий гэж сайд өөрөө хэлсэн.

**2004 он**



## Зүрхний тухай яриа



**И**х ТОМ зүйлсийн тухай бид ярьж бичиж байна. Дэлхийн цаг агаарын дулаарал, жагсагчид цонх хагалж, машин тэрэг эвдлээ, Коизуми Энхболд нар уулзаж ярилцав, инфляц өсчээ, макро эдийн засгийн үзүүлэлттэй танилц, автын осол гарчээ, үерийн далангийн орчим амьдрагсад нүүх шаардлага тавив...

Тогтмол хэвлэл болоод телевиз харж суухдаа сэтгүүлч бид дарга даамлуудтай өдөржин уулзах юм аа гэсэн бодолд ямагт автдаг. Гол эх сурвалжууд маань тэд юм хойно аргагүй. Хүмүүсийн амьдралыг зохицуулах элдэв шийдвэр, хууль, журмыг дарга нар гарган үзэглэж байна. Сэтгүүлчид өнөөх

цаасыг бариад уншигч үзэгчдэд дамжуулан мэдээлнэ. Тэгвэл мэдээллийн энэ их урсгал ганцхан чигтэй хөврөөд байна шүү дээ. Үерийн далангийн хажууд гэрээ бариад , гэр бүлийнхнийхээ амь насаар дэнчин тавьчихсан тэр эр мөн ч маанга амьтан аа. «Нүүх шаардлага тавилаа, захирамж гарлаа...

Сэтгүүлч бид бичээд л байдаг. Тэр яасан дөжирчихсөн толгой вэ.

Гэхдээ тэр эртэй бид уулзаагүй. Яагаад усанд үйж үхэх гээд «хүлээгээд» суугааг нь сонирхоогүй. Тийшээ явж яриа авах цаг зав алга. Яг энэ завгүй, тодруулбал хүсэлгүйн хаялганд үйл явдлын мэдээлэл өрөөсгөл бууж байна. Нөгөө нүүх захирамжтай зэргэцээд шилжин ирэгсдийг буухыг зөвшөөрсөн газрын асуудлыг шийдсэн юм уу? Шийдсэн юм бол тийшээ хүмүүс яагаад нүүхгүй байна аа? Сургууль, цэцэрлэг, дэлгүүр, худаг ойролцоо нь байгаа юу? Гэрэл цахилгаантай холбогдсон газар уу?

Яагаад гэсэн асуултад гүйцэд хариулаагүй материал нэг л шолхийсэн, амт шимтгүй. Их үйл явдлын дунд тэр нэг эгэл хувь тавилан бий. Том жагсаал болж хэдэн мянган хүн оролцжээ л гэнэ. Туг бариад алхаж яваа дугаар хорооны

иргэнийг «татаж томруулаад» харья л даа. Цалинг нь Засгийн газар нэмсэн. Тэр өөр юу хүсээ вэ. «Цалингийн нэмэгдлээрээ хоёр кило мах аваад дууссан» гэж өнөөх эр хариулах вий. Сайдын яриад байсан нөгөө том шийдвэрийн «нюанс» энэ. Тэгэхээр нийгмийн халамжийн бодлого нэг л явцгүй байгаа юм биш үү.

Бяцхан үйл явдал дундаас чухал асуудал ийнхүү босоод ирнэ. Тэр зангилааг олоод татахын тулд сэтгүүлч анд минь үйл явдал дунд ороорой. Дарга нарын өгсөн цаас, факсаар амь зуух хэрэггүй. Жагсаалыг өндөр байшингийн цонхоор ажвал тун ч сүртэй. «Сүрт жагсаал боллоо» гээд л бичиж орхино. Харин дунд нь ороод, тэнд цугласан хувь заяаг сурвалжилбал инээдтэй, эмгэнэлтэй, өрөвдөж хайрламаар, эсвэл бахархаж дэмжмээр мянган баримт, санаа дэвтэртээ цуглуулах

вий.

Үзгээ шүүрэн том нийтлэл туурвихаасаа өмнө зүрхээ чагнаарай. Тэр бяцхан зүрх чиний материал дотор цохилж, амьсгалж чадвал амттай бүтээгдэхүүн чи бэлтгэжээ. Хүнд хүрсэн сайн материал болжээ гэсэн үг. Инфляц гэж юу байдаг юм? Нэг л их хөндий, харь үг сонсогдоно. Баахан тоо урсгаж ирээд Сангийн сайд шиг тайлбарлах хэрэггүй шүү. Харин дэлгүүрээс байнга авдаг мах, талх зэргийн үнийг бөөгнүүлээд цалинтай чинь харьцуулаад өгсөн цифр юм гэж ойлгуулбал шал өөр. Энэ бол баримтыг хэт хялбарчилсан явдал биш. Олсон баримт дээрээ ажиллах, түүнийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн гаргах сэтгүүлчийн хөдөлмөр билээ.

«Газар дээр нь» очоод ирсэн сурвалжлагчаа эрхлэгч нар ямагт үнэлдгийн учир энд бий. Сурвалжлагч үйл явдлыг ойрхноос, зүрхнээс зүрхэнд хүргэж чаджээ гэсэн үг.

# Гамшгийн дараах нийслэл

*Өглөөжин шатсан агаар яах ийхийн зуургүй сэрүү татуулав. Баасан гаригийн 16.00 цаг өнгөрөх үед нийслэлийнхэн ашгүй хэмээн амьсгаа авч, бороо шажигнатал асгаасай гэж дуу алдах нь холгүй суулаа. Бөөн саарал үүл энэ үеэр нэг л эвгүй дээрээс нэвсийж юу юугүй нөмрөөд авах нь уу гэмээр гэтэхийг өрөөнийхөө цонхоор ажигж амжив.*

## ГАНБОЛДЫН ХОЁР ХҮҮХЭД ҮЕРТ ЭНДЖЭЭ

Нэг, хоёр... пөд падхийн мөндөр цонх тогшиж байна. Ангам халуунд нозоорсон улаанбаатарчууд ухасхийн хөөрөлдөж, мөндөрний хөгжилтэй товшоонд сэтгэл сэргэх нь тэр. Цонхоор үсчээд орж ирсэн бөмбөгөр цагаан мөсийг шүүрч аваад манайхан нэг рүүгээ шидэж ч харагдав. Харин үүнээс арван минутын хойно хэрэг бишдэж эхэлснийг бүгдээрээ мэдэрлээ. Хожим сонсвол мөндөр яг 13 минутын турш асгарсан аж. «Хэзээ ийм том мөндөр ингэтэл удаан орж байлаа» хэмээн нэг нь түгшүүртэй хэлэх нь сонсогдлоо. Шагайн чинээ мөсний араас хувингаар цутгах адил аадар шаагив. Таазнаас юу юугүй ус дусалж, удалгүй бүр урслаа. Баасан гаригийн 17.00 цаг өнгөрөх үест нийслэл үерт автсаныг нийтээрээ хэлүүлэлтгүй ойлгов. Эхний цочир мэдээг «MN 25 дугаар суваг» телевизийнхэн бидэнд дамжуулж байна. «Хоёр охин саяын бороонд эндсэн» гэсэн үгс сонорт хүрлээ. Дараа нь сонсвол Баянзүрх дүүрэгт ийм золгүй явдал болжээ. 18 настай Алтанзул «тог»-нд цохиулсан юм. Тэр долдугаар хорооны 38-ын «Б» байшинд амьдарч байсан. Эдний байрнаас дугуй засварын газар руу татсан цахилгааны утас хүний аминд хүрэв. Энд тэндээс арзайтал татдаг ёрын утаснууд нүдэнд харагдах шиг боллоо. Цахилгаанд дөрвөн хүүхэд цохиулснаас хоёр нь нас баржээ.

**Хожим сонсвол мөндөр яг 13 минутын турш асгарсан аж. «Хэзээ ийм том мөндөр ингэтэл удаан орж байлаа» хэмээн нэг нь түгшүүртэй хэлэх нь сонсогдлоо.**

Харин өнөөх тэнгэр уйлагнаж эхэлснээсээ 50 минут орчмын хойно хэрэг хийгээгүй мэт онгойж үзэгдэнэ. 17.00 цаг өнгөрөөд Улаанбаатарын дээгүүр хүглийх үүлгүй, харин сиймгэр манан харагдахтай, үгүйтэй суунаглажээ. «Энд машин урсч байна. Дороос нь хүн цухуйж харагдсан. Бичлэг хийж байна» хэмээн хэн нэг нь телевизийнхэн рүү утасджээ. Иймэрхүү мэдээ дахиад сонсогдоно гэдэгт хэн ч эргэлзсэнгүй. Нийслэлийг ганц цаг хүрэхгүй хугацаанд дайраад өнгөрсөн гамшгийн хохирлыг тэр даруйд нь тодруулах боломж олдсонгүй. 20.00 цаг дөхөх үед үерт хамгийн их нэрвэгдсэн хэмээн дуулдах Баянгол дүүргийг зүглэн хөдлөв. Энэ мөчид Орхон, Говь-Алтай аймагт мөн л байгалийн аюулт үзэгдэл болж, Увсад шатахуун түгээх станц дэлбэрснийг нийслэлийнхэн хараахан мэдээгүй байлаа.

Хотын баруунтайг чиглэн дөхөх тусам мөнөөх мөндөр тоглоом байгаагүйг олж үзэв. «Баянбүрд» хэмээн нэрлэж заншсан хойд хэсгийн зам дээр хаанаас зөөгөөд овоолчихов гэмээр том том чулуу, лаг шавар хуримтлагджээ. Баруун дөрвөн зам руу явах боломжгүй болсон бололтой.

## НИЙСЛЭЛИЙН БОК-ЫН ХОЁР ДАХЬ ХУРАЛДААН

Замын цагдаа «Баянбүрд»-ийн тойргоос баруун урагш зүтгэсэн болгоныг Бага тойрог өөд буцаан зохицуулна. 19.30 цагаас эхлэн Гэсэр сүмийн уулзварт овоорсон шороог зайлуулахаар ажилласан тул замыг хаасан юмсанж. Үер Гэсэрийн ойролцоо явсан дөрвөн машиныг урсахдаа нэгийг нь сэг болтол эвдэн хэмхэлжээ. Уухилан урсах энэ булингартай ус хэдэн халуун амийг авсан

бол доо хэмээн тэр үдэш олон хүн бодсон. 21.00 цагт хуралдсан Нийслэлийн байнгын онцгой комиссын хуралдаан дээр долоон хүн эндсэн гэсэн анхны мэдээг дуулгав. Энхтайваны өргөн чөлөөнд эмх замбараагүй бөөгнөрөл үүсчээ. Замын хашлага хаана байгаа нь үл харагдана. Хоёр газар зам цөмөрч орхисон тухай жолооч нараас сонсов. Арай ядан түгжрэл гацааг нэвтэлсээр баруун дөрвөн замд дөхвөл байдал бүр дор, булингартай горхи жирэлзэж хонхор болгонд нуур цэлэлзэж байна. Гэнэтийн гамшгийн үр дагаврын тухай баасан гаригийн үдэш Нийслэлийн байнгын онцгой комиссын дарга М.Энхболд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарт мэдээлэв. Тэр 18.00 цагт Ерөнхийлөгчид байдлыг танилцуулсан бол 22.00 цагт Ерөнхий сайдтай угсаар ярьжээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн албан тушаалтнуудад мөн орой хоёр ч удаа мэдээлэл өгөв. Энэ мөчид гурав, дөрөвдүгээр хорооллын эцэс, Телевизийн орчимд аврах ангийнхан очсон байлаа. «Үерийн хамгаалалтын далан дотор хоёр микроавтобус унасан. Хүнтэй явсан эсэхийг мэдэхгүй» гэсэн түгшүүртэй үгс үдшийн бүрэнхийтэй цуг нөмөрчээ.

Нээлттэй орхисон салхивчаар мөнөөх хар ус шавшсан харагдана. Гэрт минь хүртэл бяцхан гамшиг угтав. «Хотод ширүүн бороо орж байна» гэж тэр орой сонин дуулгахад Швейцарьт амарч буй охин маань «Ямар гоё юм бэ. Харин энд шатаж үхмээр байгаа» хэмээн атаархсан юм. Европод энэ зун гангийн халуун уугиж, Монголд үер усны аюул нүүрлэлээ. Өнгөрсөн зун байгаль дэлхий эсрэгээр тохуурхаж, энд бид наадмын дараа хур үзэлгүй олон хоносон атал Европод Элба, Дунай эргээ халин сад тавьж байсан шүү дээ. Хэдхэн хоногийн өмнө Москвад үер буусан мэдээ тээр хол сонсогдож байсан юм. Охиныхоо норж халтартсан зөөлөн тоглоомуудыг арчих аядав. «Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт «Бэлчир» компанийн орчмоос барилгын блок урсч таван настай хүү цохиулан нас баржээ...». Бас нэг хар мэдээ. Нөгөө хөгжилтэй мөндөр юу хийж орхих нь энэ вэ?

Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээллийн хэлтэс 02.00 цаг хүртэл ажилласан бол Нийслэлийн байнгын онцгой комиссынхон 05.00 цаг болтол цурам хийсэнгүй. Баянгол дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн захирал Д.Батсайханы ярьснаар ачигч, жолооч гээд эдний 20 хүн хоёр Самосвал, нэг трактор, бохирын машин гэсэн техниктэй мөн л 02.00 цаг хүртэл тасралтгүй ажиллажээ. Тэд Л.Энэбишийн гудамжинд овоорсон лаг шавар, чулууг зайлуулсан. «Баянгол баларсан» гэж дүүргийн нэг ажилтан хэлсэн юм. «Баруун уулын үерийн далан даацаа алдсан. Буусан усны хэмжээ их. Гурав, дөрөвдүгээр хорооллын эцэст, Телевизийн орчмоор ус асар хүчтэй орж ирсэн» гэсэн үгсийг энэ үдэш олонтаа сонслоо. Аймшигт тэр мөчид чухам юу болсон бол?

### **«ЭХЛЭЭД ХҮҮГИЙН, ДАРАА НЬ ОХИНЫ ТОЛГОЙ ШОВОЛЗООД ИХ УСАНД АЛГА БОЛСОН»**

Үерт өртсөн хамгийн эхний айл эднийх. Амгалан тэр үед нөхөр, хоёр хүүхэдтэйгээ гэртээ байсан. Баянгол дүүргийн 11 дүгээр хороонд «Хувьсгалчдын» нэртэй гудамж бий. Телевизийн тээр хойно, Далан давхар гэх чимээгүй хотоос нэг их холгүйхэн, үерийн хамгаалалтын асар том далангийн хажууд шахуу эднийх 1997 онд хашаа хатгажээ. Гурван дэрсхэн үртэй, эгэл амьдралтай нэг өрхөд зүрх зүсэм хагацал тохиолдсон юм.

-Бороо ширүүсээд гэр хөвөх үед ах маань эхнэртэйгээ хөндийрсөн завсраар нь шургаж гарсан гэсэн. Тэр хоёр хүүхдүүдээ нэг нэгээр нь тэвэрсэн байжээ. Би гэрт байгаагүй юм. Их усанд юу юугүй гараас алдуурсан хүүгийнх нь толгой тэр хашааны орчим нэг цухуйгаад, охин нь арай цаахна шоволзож харагдаад л

алга болсон гэж Амгалангийн нөхрийн дүү эмэгтэй ярьж байна. Нүд нь хавдаж улайгаад, шавар шавхайд хутгалдсан энэ айлынхнаас цааш нь элдвийг асуухаас зүрхшээв. Гурван үрийнх нь нэг бороо орох үед гадаа тоглож яваад айлд хоргодож амь гарчээ. Орон гэр нь «Хувьсгалчдын» 18-ын найм гэх хаягныхаа хамт юу ч үгүй урсч, халтартсан ягаан хулдаас л хоцорсон харагдана. Найман настай А.Оюунбилэг охин нь энэ намар сургуульд орох байж. Ой гурван сартай хүү А.Батбилэгийг гамшиг хайрлалгүй аваад одож. Хөөрхий ээж нь тэнхэл баран хүнээр түшүүлж явлаа. Орон гэргүй болсон тэд одоогоор айлд байгаа аж. Олон метр газар усанд урссан Амгалангийн тохой шуу шалбарсан харагдана.

7000 хүнтэй тус хорооныхны тав нь их үерт амь алдсан юм. Мөнхсайхан бүсгүй Амгалангийнхаас хэдхэн метрийн цаана, гэрээсээ холгүй явж байгаад эрчилсэн их усанд осолджээ. Хоёр давхар байшин нь бүрэн бүтнээрээ хоцорч, бүсгүй өөрөө гамшигт дайруулсан байх юм. «Хувьсгалчдын» гудамжийг уруудан Баянгол дүүргийн арваннэгдүгээр хорооны Засаг дарга С.Нацагдоржтой хамт алхаж явлаа.

Бямба гаригийн өглөө нар гэмгүй инээвхийлж, өчигдөр юу хийчихэв ээ гэсэн шиг тэнгэр хангай огт өөр ааш аяг үзүүлж байна. Хаашаа л харнав шавар шавхайд хутгалдсан эсгий туургаа эврээх аядсан, бүтэн үлдсэн эд зүйлээ цуглуулсан баргар ядруу царайтай хүмүүс таарна. Зам ч гэж нүх болж, ангайсан гүнзгийнүүдэд хог овоорчээ. Энэ хавиар дарга даамал, аварч тусалдаг, асуудал шийддэг хүн хараахан морилоогүй бололтой. Дэвтэр барьсан сурвалжлагч, том цүнх мөрлөсөн зурагчныг бүгдээрээ дагуулан анхааралтай ажиглах аж. Гудамж өгсөн өөдөөс хоёр согтуу найгасаар гараад ирэв. Эргэн тойронд юу болсныг мэдсэн, ойлгож буй эсэхийг бүү мэд.

Бороо орж эхлэх үед Мөнгөнтуяа гэртээ байгаагүй гэнэ. Нөхөр нь хоёр хүүхдээ аваад золоор амь гарчээ. Хажуу айлынхаа хашааг ханз татаад орж амжсан, гэр орноос маань л юу ч үлдсэнгүй гэж тэд ярьж байна. Зүүн ард Аюушийн гэх тодогтолтой гудамж мөн эдний хороонд харьяалагддаг. Их ус шүргэж өнгөрсөн болгоноо эвджээ. Зүүн ард Аюушийн гудамжинд бас л үхэл хагацал тохиолдов.

-Ингээд үр хүүхдээ, муу гэрээ алдаж орхисон хэмээн уйлах эмэгтэйн дэргэд халширсаар дөхөж очлоо. Ганболдын хоёр хүүхэд осолджээ. Өмссөн нойтон хувцастайгаа шаварт хутгалдсан буурин дээрээ хоцорч бяцхан үрсээ хормын зуурт алдсан тэд хаачих, юу хийхээ үл мэдэн мэгштэл уйлах аж.

Мөнөөх «Хувьсгалчдын» гудамжаар энхэл донхол даган уруудсаар үерийн хамгаалалтын арай бага шиг далангийн дэргэд ирлээ. Өмнөх шөнө хоёр микро унаж живсэн гээд байсан газар. Аврах ангийнхан өчигдөрхөн энд завиар хөвж ёроолыг нь тандсан хэмээн итгэхэд бэрх, бүх ус нь татарчихаж. Тээр дор микроавтобус хажуулдан унасан, ойролцоо нь төмөр амбаар сэрийж үзэгдэв. Энэ амбаарыг эхлээд автобус гэж андуурцгаасан биз ээ.

Томдсон шар цамц өмсч үс гэзэг, гар нүүргүй шаварт будагдсан эмэгтэийг Р.Пагмадулам гэдэг. Нөгөө микро унаж живсэн далангаас аравхан алхмын цаана амьдарч байлаа. Одоо түүний гэрээс үлдсэн зүйл гэвэл шаварт зууралдсан туурга л харагдсан даа. Пагмадулам золоор амьд гарснаа ярив. Эдний охин ой найман сартай хоёр ихэр хүүхэдтэй. Их ус даланг даван урсч орж ирэх үед гэртээ тавуулаа байжээ. Хоёр нялхыгаа ээж, охин хоёр тас тэврээд тоононоосоо зуураад урссан гэх. Бараг 50 метр газар усанд туугдан хөвөхөд хамаг хувцас нь тайлагдсан гэж ярилаа.

-Нялхыгаа нэг алдаад амжиж шүүрч авсан. Одоо ихрүүд маань гайгүй. Айлд унтаж байгаа. Уяатай байсан нохой маань тэнд дарагдаад үхчихсэн. Яг энэ хонхрын дэргэд урсч ирээд тоононоосоо зуурч тэсээд байтал засварын газрын

-Нялхыгаа нэг алдаад амжиж шүүрч авсан. Одоо ихрүүд маань гайгүй. Айлд унтаж байгаа. Уяатай байсан нохой маань тэнд дарагдаад үхчихсэн. Яг энэ хонхрын дэргэд урсч ирээд тоононоосоо зуурч тэсээд байтал засварын газрын залуу ирж биднийг татаж авсан гэж Пагмадулам хэлээд гурав дөрвөн метр орчмын дор хонхойх нүх өөд заалаа.



залуу ирж биднийг татаж авсан гэж Пагмадулам хэлээд гурав дөрвөн метр орчмын дор хонхойх нүх өөд заалаа. Мөн эдний хашааны айл Р.Лхагвадорж гартаа барих бүтэн модгүй шахуу хоцорчээ. «Баримт бичиг байхгүй. Бүгд урссан. Одоо яана» гэж тэр үглэнэ. Хотын иргэн байх, дээр нь өөрийн гэсэн газар, хашаа, гэртэй болох гэж чааваас баахан бичиг цаас цуглуулж гүйсэн биз. Алга дарам газар гэр хорооллынхны хувьд аминаас чухал зүйл болчихжээ. Баянгол дүүргийн арваннэгдүгээр хорооны Засаг дарга С.Нацагдоржийн өгүүлснээр зөвхөн эдний нутаг дэвсгэр дээр үерийн далангийн ойролцоо 38 айл буусан. Үхлээ хүлээж их усны аман дээр шахаж буугаа юу гэж бодогдох нь лав. Хотын хэмжээгээр ийм 900 айл «Сүх далайтал...» хэмээн амьдарч байна. Гэвч сүх далайх хүртэл, өнөө маргаашаа аргалан амьд явахаар ядацгаах ядуусын хороололд очиход асуудлыг арай өөрөөр шийдэх цаг болсныг ойлгоно. Долдугаар сарын 18-ны орой учирсан гамшгийн дараа ч энэ айлууд зөвшөөрөлгүй буусан газраасаа сайн дураараа нүүхгүй. Тэдэнд бууриа засах өөр газар, тэнхээ боломж ч байхгүй. Тэмцэх, хөөцөлдөх итгэл зүтгэл нь ч унтарсан. Үр хүүхдээ алдсан, өмссөн хувцастайгаа хоцорсон дээрх бүх айл өмнө нь нүүх тухай шаардах бичиг түмэнтээ хүлээн авсан. Хамгийн сүүлд тавдугаар сарын 1-нд тийм бичиг ирж л байсан гэнэ. Хотын аль нэгтээ, үерийн далан дор ч атугай газар бараадан зүтгэх ядуусын амьдралыг шаардах хуудсаар зохицуулах аргагүй болжээ.

### М.ЭНХБОЛД: ГЭР ӨГСӨН НЭР ЗҮҮВ ЭЭ!

Гамшгийн дараах нийслэл царай алдаж, хог шороондоо дарагдаад байна. Бямба гаригийн өглөө 10.30 цагт Энхтайваны өргөн чөлөөний замд дахин цөмрөлт үүсэв. Энхтайван найрамдлын ордны эсрэг талд босч буй барилгын шугам хоолойг тавина гэсэн үү лав л хэдхэн хоногийн өмнө замын хөдөлгөөн хаан байж ухсан яг тэр хэсэгт цөмөрчээ. Өнөөх хоолойгоо тавиад асфальтахдаа нүд хуурчихсан гэсэн үг. Ингээд баасан гаригийн үдэш нийслэлийн төв гудамж онгойсон хоёр нүхтэй байсан бол бямбад гурав болж, замын хөдөлгөөнд хүндрэл учирч эхлэв.

«Цахилгаан тээвэр» компанийн хоёрдугаар чиглэлд энэ өглөө ажилласан жолооч Л.Аюуш ууртай харагдана.

-Би 8.30 цагаас эхлээд явсан юм аа. Яг хоёр цагийн дараа энүүгээр өнгөртөл зам цөмөрч, троллейбусны маань нум хугарсан. Одоо Замын газрынхан ирж хэмжилт хийхийг хүлээж сууна гэв.

Нийслэлийн байнгын онцгой комисс хоёр дахь хурлаа хийх гэж буй мэдээ дуулдаж төв талбайн зүг яарлаа. Сүхбаатарын талбайг эмжин байрлуулсан сувдан унжлага мэт гэрлүүдийг мөндөр бас хорлочихож. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хөл хөдөлгөөн ихтэй. Шөнөжин ажилласан хүмүүс шинэ өглөө ч тасралтгүй утсаар ярин тоо статистик нийлцгээх аж. «Хайлаастын эцсээс олдсон хүүхэд одоо хаана байна? Хүүхдээ сурсан өөр хүн байна уу?» хэмээн Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч Д.Очирбат утсаар асууж байна. Энэ өглөөний хувьд амь үрэгдсэн хүмүүсийн тоог эн түрүүнд тодруулах шаардлагатай байлаа. Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар л иржээ. Дүүргийн нэг номерын боссууд харин үзэгдсэнгүй.

-Долоон настай хүү гэрээ мэдэхгүй юм зайлуул. Манайх нэг цагаан байшингийн хажууд гээд л хэлдэг. Ундаа идэх юм авч өгөөд... хэмээн Очирбат хажуугийн хүндээ ярьж байна. Хурлын дараа телевизийнхнийг дагуулж явахаар болж таарав. Гэрийнхэн нь телевизээр хараад хүүгээ ирж авсан тухай үдэш нь сонслоо.

Хурал эхлэх товлосон хугацаа сунжирч, 11.30 цагт Нийслэлийн байнгын

**Хамгийн сүүлд тавдугаар сарын 1-нд тийм бичиг ирж л байсан гэнэ. Хотын аль нэгтээ, үерийн далан дор ч атугай газар бараадан зүтгэх ядуусын амьдралыг шаардах хуудсаар зохицуулах аргагүй болжээ.**

онцгой комиссын дарга М.Энхболд дүүргийнхнийг өрөөндөө дуудлаа. Бямба гаригийн 10.00 цагт Хотын дарга Баянхонгорт яваа Ерөнхий сайдтай утсаар ярьжээ. Тэд хагас цагийн дараа дахин утсаар холбогдсон дуудлав.

Удалгүй, М.Энхболд зангиагүй, мөн л энгийн хувцасласан Ц.Болдсайхан нар цувран танхимд орж ирлээ. Нийслэлийг дайрсан үерийн уршгаар одоогийн байдлаар есөн хүн амь алдсаныг энд дуулгаад Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Болдсайхан өчигдрийн хурлаас хойш хийсэн ажил, нэгтгэсэн дүн мэдээг танилцууллаа. Далан суваг дүүрсэн, гэхдээ зохих хэмжээнд бэлэн байсныг тэр онцолж тодруулав.

Засаг даргын нөөцөөс 4.5 сая төгрөг яаралтай гарга хэмээн М.Энхболд ойролцоо суусан ажилтандаа нам дуугаар хэлээд, ширээ тойрон суусан 30 орчим хүнээс асууж лавлаж, товч үүрэг өгч эхлэв.

-Одоо усыг нь шавхаж амжаагүй 40 хонгил байгаа.

**-Нийт хэдэн подвал үерт автсан юм?**

-60 байсан.

**-Ус шахуургадах насос ажиллуулж байгаа юу?**

-Цахилгаан байхгүй болохоор...

**-Өөр газраас цахилгаан аваад насос ажиллуулж болдоггүй юм уу. Дашзэвгээ тааруу үр дүнтэй байна шүү. Подвалын усыг шавхахгүй бол шавьж хорхой үржихээс эхлээд ямар үр дагавартайг мэдэж байгаа биз дээ. Бямбаа даргад ямар мэдээлэл байна?**

-Үерийн дараа гэдэсний халдварт өвчин дэгдэх аюул бий. Шаардлагатай арга хэмжээнүүд авч эхэлсэн. Иргэдэд сэрэмжлүүлэг өгөх хэрэгтэй байна.

**-Усанд урссан таван хүний бие ямар байгаа вэ?**

-Бид нийт найман дуудлага авсан. Гурвыг нь Гэмтлийн эмнэлэгт хүргэлээ. Гэртээ байгаа хүмүүсийн хувьд одоо өрхийн эмч нар нь үзнэ.

**- За ойлголоо. Хэвлэлийнхэнтэй хамтарч иргэдэд яаралтай сэрэмжлүүлэг өгнө шүү. Ус сувгийг удирдах газрын хэмжээнд байдал ямар байна?**

-Нийслэлийнхний цэвэр усны хангалт хэвийн. Бохир ус дүүрэлт ихтэй, цэвэрлэх байгууламж ачаалал их байгаа...

Асуулт хариулт товч, шуурхай өрнөлөө. Ард хүлээсэн ажил их тул өчнөөн удтал хуралдаж суух боломж ч хомс. Нийслэлийн байнгын онцгой комиссын дарга амь үрэгдэгсдийн ар гэрийнхэнд тус бүр 500.000 төгрөг өгнө гэдгийг дуулгаад, орох оронгүй болсон хүмүүст яаралтай гэр барьж өгөх ажлыг зохион байгуулав.

-Гэр өгсөн нэр зүүгээд л орхичихов доо. Усанд хамаг юм нь урсчихсан тэдэнд хөнжил гудас, яндан зуух, хүнс хэрэглэл, оо сойз хүртэл шаардлагатай. Боломжтой бүх зүйлийг бэлтгэж, 18.00 цаг гэхэд гэрийг нь барьж өг гэж тэр үүрэг болгов.

-Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны харьяат есөн настай Энхтүвшин амь алдсан. Дүүргийнхэн очиж эмгэнэл илэрхийллээ. Мөн дүүрэгт өөр нэг хүүхдийг гэрийнхэн нь эрж байна. (19-ний өдрийн 12.00 цагийн үед)

-276 айл усанд автсан

-Үүнээс 93 нь урсчээ.

-30 айл орох оронгүй

-1360 ам.метр зам талбай эвдэрлээ.

Хохирлын статистик хөвөрсөөр. Юуны түрүүнд нөгөө нойтон хувцастай хүмүүс нүдэнд харагдаж, амсар зуух аягагүй, үхэл хагацал үзсэн тэдэнд хэзээ, хаана гэр босгож, газар товлож өгөхийг сонирхов. Нийслэлийн дүүргүүдээс хамгийн их хохирол үзсэн Баянголыг зорин, Засаг даргын орлогч П.Төвсанаатай уулзав. Баянголын онцгой комиссынхон хэмээх 10 хүн ширээ тойрч суусан үзэгдэнэ.

13.00 цагийн орчим дахиад л тэнгэр хангай нижигнэж усархаг бороо зүсэрлээ. Заяа нь хаясан тэнгэр юм. «Гамшиг тохиолдоод бараг 24 цаг өнгөрч байхад дүүргийн Онцгой комиссын гишүүдээс зургаа нь байдаггүй. Юу болж байгаа юм. Хороод мэдээллээ бодитой өгсөнгүй. 68 гэр хэрэгтэй гээд нэхээд байдаг. Тэгсэн дараа нь нарийвчлаад үзэхээр 20 болчихно. Яагаад мэдээлэл ийм савлагаатай байгаа юм. Тооцоогоо зөв хийгээч. 18.00 цаг гэхэд босгох гэр доторх эд зүйлийг хаанаас гаргахав. Яндан, зуух, гудас хаана байна. Хот хохирогсдын ар гэрт 500.000 төгрөг өгнө гэнэ. Дүүрэг дор хаяж 100.000 төгрөг өгье. Гэр нь урссан айлуудын байдлыг газар дээр нь очиж үзье. 14 гэр урссан л гээд байгаа. Хэн нь ч очиж нүдээр хараагүй байна шүү дээ. Аврах ажил гүйцэтгэж буй 160 хүнд хэдэн цагт хоол унд өгсөн бэ? Бууз...» Иймэрхүү яриа Баянгол дүүрэгт буцалж, ногоон эрээн хувцас өмссөн онцгой комиссынхон тал тал тийшээ утасдана. Олонх нь өнгөрсөн шөнө нойргүй ажиллажээ. Өглөө Нийслэлийн байнгын онцгой комиссын хуралдаан дээр ярьж хэлцэн, дараа нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад хүрсэн тоо баримт, авах арга хэмжээ, ажлын үр дүнг хар толгойгоороо хариуцан ханцуй шамлах үүрэгтнүүд нь эд юм. Тэд хэр зохион байгуулалттай хөдлөхөөс нөгөө дээш дээшээ дамжуулдаг мэдээллийн дүн хамаарахыг ойлголоо.

Төвсанаа даргын утас тасралтгүй хангинана. Улаан загалмайгаас, мөн Ц.Болдсайхан, өөр олон хүн түүнтэй ярилаа. Тэнгэр уйлагнаж, чийг татсан янзаараа. Баянголынхон хэдэн бууз хувааж идээд тус тусын хариуцсан ажлаа гүйцээхээр хөдөлж байна. «Баянгол» захад байрладаг «ЖСБ» компаниас яваа хэмээн шавар шавхай болсон хувцастай эмэгтэй ороод ирэв.

-Манай компанийн агуулахад 200 сая төгрөгийн бараа усанд автсан. Бид хавийн амьтныг гуйж агуулахын усыг шавхаад дууслаа. Одоо бараагаа зөөж гаргах гэсэн хүн хүч дутаад байдаг. Туслах арга байна уу хэмээн эмэгтэй яриу. Түүний хүсэлтийг тэмдэглэж авч байна. Ингээд дүүргийн нутаг дэвсгэрийн нийт аж ахуйн нэгж, иргэдэд учирсан хохирлыг нэгтгэн цуглуулж эхлэв.

Хотын хамгийн олон хүнтэй буюу албан статистикаар 120.000 иргэнтэй дүүрэг гамшигийн үр дагавартай тэмцэж байна. Бямба гаригийн 15.00 цагийн орчим нийт 20 хорооны даргын дөнгөж тал нь дүүрэгтэйгээ холбоо барьж хэл чимээ өгөөд байлаа. Нөгөө иргэдтэйгээ тулж ажилладаг чухал нэгжийн дарга нар бүдүүн зүрхтэй хэнэггүй хүмүүс байдаг гэж үү? Хороон дарга нарыг ажиллуулах хөшүүрэг энэ тэр гээд янз бүрийн зүйл бодогдож байх юм аа.

Баянголын хэмжээнд бямба гаригийн үдэш лав 4000 утас таг чиг болжээ. Захиргааны байранд ердөө хоёрхон утас «амьтай» байлаа.

**-10 дугаар хорооллын бөглөөг яах вэ?**

**-Трактор хэрэгтэй байна шүү дээ.**

**-Айлуудад өгөх мөнгө бэлэн боллоо...** Ингээд дүүргийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ламзавыг дагаад мөнөөх «Хувьсгалчдын» гудамжийг зорин зүтгүүлэв. Ламзав гэр нь урссан айлуудын яг таг тоог гаргана, бас хохирогсдын ар гэрт эмгэнэл илэрхийлж тус бүр 100.000 төгрөг өгөх үүрэгтэй.

Хөөрхий гурав дөрөвдүгээр хороолол. Засаад л, замынх нь голд тод ногоон өнгөтэй гоёмсог хайс хийгээд л байсан. Одоо авах юм үлдсэнгүй шахам. Төмөр чингэлгүүд цаасан хайрцаг лугаа хөвөөд орцны үүд таглачихаж. Оо сойз, ор хөнжлөөс эхлээд хөргөгч хөлдөөгч хүртэл талаар нэг цацагджээ.

16.00 цагийн алдад Зүүн ард Аюушийн гудамжнаа цахилгааны шон өөд монтёр зүтгэж харагдав. Эндхийнхэн ядаж гэрэлтэй золгох нь юм болов уу. Зам зуурт бас нэг хар мэдээ чих дэлслээ. Сити такси II компанийн байрны подвалаас эрэгтэй хүний цогцос олджээ хэмээн дүүргийнхэн дуулгаж байна. Нээрээ үерийн далангийн ойролцоо «Сити такси II» гэсэн хаяг харагдлаа. Тэр хавьд ганга жалга үүсч их ус дайраад өнгөрснийг нотолно. Мөн «Ачлал»

дэлгүүрийн орчимд осолдсон эрэгтэйн цогцос хэнийх болохыг цагдаагийнхан тодруулж чадаагүй байгаа гэнэ.

Албаны хүмүүсийн бараа харсан гэр хорооллынхон араас нь хэд хэдээрээ даган шогшино. Унь, хана, ядаад хувцас сэлт өгнө гэж бодсон байх. Улаан загалмайн ажилтан Ц.Цэенпил гэр нь урсан хүмүүст хувцас өгөхөөр нас хүйсийг нь нямбай тэмдэглэнэ. Нээрэн гамшиг тохиолдоод бүтэн хоног өнгөрч байхад эдэнд гар сунгасан газар дүүргийнхнээс өөр харагдаагүй дээ. Хохирогсод хүний төлөө амьдраагүй хэдий ч, бас хүн хүнээсээ хамаарах цаг ирдэг аж. 18.00 цаг гэхэд үерт өртөгсөд өнөөдөр амжиж гэртэй болох нь юу л бол гэж бодогдов. Лав дахиад нэг шөнийг лаг шавар дотор босон суун өнгөрөөх бололтой.

Нар дахиад мишээгээд гараад ирлээ дээ. Оройхон сонсвол 18-20 цагийн хооронд Хотын дарга амь үрэгдсэн хүмүүсийн ар гэрийнхэнтэй уулзжээ. Үдэш нь харин нялуун үгтэй эмгэнэл олныг сонслоо. Үндэсний телевизийн ММ агентлагийн мэдээний цаг эмгэнэлээр дүүрч, шинэ сурвалжлага олж сонсох гэсэн үзэгчдийн тэвчээрийг шалгав. Хүүхдүүд эндсэнд Их хурлын гишүүн Н.Болормаа харамсч буйгаа илэрхийлэхдээ бяцхан иргэдээ харж хандсангүй гэх аястай өгүүлсэн нь энэ үдшийн хувьд лав эгдүү хүргэв. Бяцхан иргэд... яасан болхи үгс вэ. Их хурлын дэд дарга эмгэнэлдээ «сонгогч» хэмээх үг хэрэглэсэн нь мөн л хатуу хөтүү сонсогдож билээ. Зайлуул нөгөө «сонгогчид нь» эмгэнэлийг нь сонсох телевиз бүү хэл нөмрөх хүрэмгүй хоёр шөнө дагжиж хоносныг анзаараагүй юм болов уу даа.

*Дугаар шилжих мөчид: Үерийн нийт хохирлын хэмжээ 300 сая гаруй төгрөг болжээ. Үүнээс далан, зам засварт 190 гаруй сая төгрөг яаралтай шаардагдаж байгаа аж.*

2003 он

# ЭРХЭМ СОНГОГЧДЫН ТУХАЙ ХЭДХЭН ҮГ

## ЭРХЭЭ ХАСУУЛАГСАД

Буруу талдаа жолоотой улаан хүрэн өнгийн такси нийслэлийн гудамжаар явах болжээ. Япон-Монголын хамтарсан J&M компанийн мэдлийн унаа аж. Эдний нэгийг Н.Жагслаг залж яваа. Жагслаг таксины жолоо мушгиад хориодхон хонож буй бөгөөд өдрийн орлогоосоо 12 мянган төгрөгийг компанидаа тушаах үүрэгтэй. Үлдсэн орлогоо хурааж цуглуулах онцгой хэрэгцээ түүнд бий. Тэрбээр гэргий, таван настай охиныхоо хамт Баян-Өлгийгөөс нийслэлд нүүж ирээд дөрвөн сар болж байгаа. Гэхдээ өдий болтол хотын иргэн болж чадаагүй. Өөрөө болон гэргий нь шилжүүлгээ албан ёсных болгох хэрэгтэй гэнэ. Үүний тулд тус бүр нь 50 мянган төгрөг төлөх учиртай юм байна. Мөн таван настай охин нь хотын иргэн болохын тулд 25 мянган төгрөг бас төлөх шаардлагатай. Нийтдээ 125 мянган төгрөг энэ гэр бүлийнхний эрхийг хязгаарлаж орхижээ. Охин хотын цэцэрлэгт бүртгүүлэх боломжгүй, харин эцэг, эх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгөх эрхгүй хоцорсон. Иймэрхүү гэр бүл нийслэлд тун олон бий. Эдний дийлэнх нь түр үнэмлэх ч атугай авч болох талаар ойлголтгүй яваа.

Аравдугаар хорооллын арын дэнжийн давчуухан зайд Жагслагийнхтай ижил 100 илүү өрх зуруу хаваржиж байна. Зөвшөөрөлгүй газар буусан шилжин ирэгсэд энд олон өдрийг гэрэл цахилгаангүй өнгөрөөжээ. Н.Жагслагийнх хашаа хатгаж амжаагүй. Гэхдээ гурав, дөрөвхөн өдрийн өмнө энд шинээр нүүж ирсэн хөршийнхөө бодвол бас ч гэр нь тохитой харагдлаа. Цагаан сарын үеэр аравдугаар хорооллын арын дэнжийнхэнд гэрэл цахилгаан түр өгсөн юм. Харин одоо харанхуй суугаа дээрээ хорооны даргаас даруй нүүх тухай шаардлага байнга авдаг болсон. Засаг захиргааныхнаас айж эмээн, хөөгдөж хулгаж яваа гэд сонгуульд оролцох түр үнэмлэх сураглан түшмэдийн хаалга татахаасаа эмээх нь ойлгомжтой. Иймэрхүү өрхүүдийн хувьд сонгуульд оролцож эрх мэрхээ эдлэх ч яамай, шилжүүлгийн хэдэн төгрөг, хашаа хатгах алгын чинээ газрын тухай бодол л толгойны өвчин болоод байгаа билээ.

Хэдийгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох 2001 оны сонгуульд нийслэлийн 365 мянган иргэн оролцоно хэмээн албан ёсны статистикаас харж болох хэдий ч бодит байдал дээр Улаанбаатарт манай нийт хүн амын бараг тал хувь нь бөөгнөрсөн гэсэн албан бус дүр зураг тод харагдсаар байгаа. Энэхүү статистикийн мэдээнд тусаагүй их нүүдэл хөдөлгөөний үр дагавар санал хураалтын дүнд ч мэдэгдэхүйц нөлөөлөх нь лав.

## СОНГУУЛИЙН ӨМНӨХ ӨДӨР

Төв аймгийн Баянчандмань сумаас арваад километрийн зайд алслагдсан Бор Хужир хэмээх газар Доржсүрэн гуайнх хаваржаандаа буужээ. Тэрбээр 70 настай. Арван хүүхэдтэй, мөн хориод ачтай хэмээн тоймлов. Доржсүрэн болон түүний гэргийн саналыг Баянчандманийн сонгуулийн хорооньхон ирж хайрцгаар авах аж. Өндөр настай, өвчин зовлонтой, ар гэрийн гачигдалтай иргэдийн саналыг ийнхүү хайрцаг аялуулан цуглуулах гэнэ. Бор Хужираас холгүй Гунын фермийн орчим хаваржиж буй нутгийнхан сонгуулийн өмнөх өдөр ямархуу сэтгэгдэлтэй байгааг сонирхлоо. 1972 онд Гунын давааны орчимд ажил ундарч, 400 үнээний ферм байгуулагдсан. Харин одоо нөгөө том фермийн сураг алдарч, барилга нь балгас шахам болжээ. Цагтаа 60 өрхийн 200

**Арваад километр хол газраас мориор явж санал өгөх нь төвөгтэй биш үү хэмээн Франс Пресс агентлагийн Бээжин дэх салбарын эрхлэгч Элизабет Зинг түүнээс сонирхсон юм. «Хэцүү биш ээ. Ерөнхийлөгчийг сонгох ажил чухал зүйл шүү дээ» хэмээн Батбаяр хариулав.**

орчим хүн ажиллаж амьдарч байсан уг газар өнөөдөр арваадхан айл хоцорсон. Тэд, фермийн ойролцоо бүтэн үлдсэн хоёр давхар байшинд байрлах сонгуулийн хэсэгт саналаа өгнө гэж ярьцгаав. Анир чимээ багатай, амьтан хүн цөөн үзэгдэх Гунын даваа тавдугаар сарын 20-ны ням гаригт ийнхүү ялимгүй хөл хөдөлгөөнтэй болох бололтой. Бүр бямба гаригаас эхлээд л энэ хавиар хүн хар нэлээн үзэгдэж, овоо дуу шуугиан нэмэгджээ. Хонгор багийн даргынх энд бий. Багийн даргаас сонгогчийн үнэмлэхээ авахаар хаа нэг хүн ирж харагдлаа. Зарим нь Гунын орчим хоржигнон урсах бяцхан голд хонь малаа услангаа сонгогчийн үнэмлэхээ авах аж.

25 настай Батбаяртай энд уулзав. Хайрхан уулын өвөрт эднийх өвөлжсөн гэнэ. Өвөлжөөнөөсөө хонио туусаар Гуна хүртэл цаг илүү сажлан иржээ. Өнгөрсөн хахир өвөл Батбаярын хонь, ямаа, үхэр, адуу нийлсэн 700-гаад толгой малын 400-г нь авч одсон. «Малын сэг зэм шатааж, орчноо цэвэрлэх ажил нь одоо ч дуусаагүй байна. Амьдрал улам хүндэрсэн» хэмээн тэрбээр ярьж явав. «Маргааш Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгнө» гэж Батбаяр ярилаа. Арваад километр хол газраас мориор явж санал өгөх нь төвөгтэй биш үү хэмээн Франс Пресс агентлагийн Бээжин дэх салбарын эрхлэгч Элизабет Зинг түүнээс сонирхсон юм. «Хэцүү биш ээ. Ерөнхийлөгчийг сонгох ажил чухал зүйл шүү дээ» хэмээн Батбаяр хариулав.

### СОНГУУЛИЙН ӨДӨР ҮҮ, ЭСВЭЛ БАЯР НААДАМ УУ?

Төв аймгийн Сэргэлэн сумын сонгуулийн 68 дугаар хэсгийн байрны орчимд өчигдөр бага үдийн алдад баяр наадам болж байна уу даа гэлтэй харагдав. Хурц тодхон торгон дээлээр гоёж, өнгө өнгийн алчуур намируулсан бүсгүйчүүд, халхгар дээл, жанжин малгайтай харчууд мэнд мэдэцгээн, зарим нь өөр зуураа том том хөөрөг зөрүүлнэ. Морь, мотоцикль, УАЗ 469 болон төрөл бүрийн загварын хөнгөн тэрэг хөлөглөсөн нутгийнхан энд ер тасрахгүй юм. Нэг машинаас хэд хэдээрээ бууж харагдана. Унаа тэрэгтэй нь айл саахалтынхнаа дайгаад ирсэн нь энэ аж. Үдийн 13.00 цаг гэхэд тус хэсэгт бүртгэлтэй 210 сонгогчоос 140 нь саналаа өгчихөөд байв. Сэргэлэн сумын төвд сонгуулийн гурван хэсэг ажиллажээ. Хүйтэн, тохь муутай сургуулийн байранд санал авах нэг бяцхан өрөө зассан байна. Ширээн дээр цагаан самар, ааруул, чихэртэй таваг тавьсан нь хамт явсан гадаадын сэтгүүлчдийн гайхлыг төрүүлэв. 68 дугаар хэсэгт МАХН-аас томилогдсон ажиглагч эмээ, Ардчилсан намыг төлөөлсөн ажиглагч өвөө сууж харагдлаа. Хүйтэн байранд жиндсэн тэд үе үе гарч нарлана. Төдөлгүй санал хураах хайрцаг тэвэрсэн залуу мотоцикльд сундлаад давхиж одов. Хайрцагаар санал авах явцыг чухам хэн нь хянах юм бол гэсэн асуулт аяндаа гарсан боловч мотоцикльтой эр жолоо мушгихаасаа гадна хайрцагаар санал цуглуулах ажлыг давхар харж ажиглах юм болов уу даа гэхээс өөр хариултгүй хоцорлоо.

Сэргэлэн сумын төвөөс арваад километрийн зайтай Долоон хэмээх газар хаваржиж буй Гэрэлт-Од гэргийтэйгээ саналаа өгөхөөр ирлээ.

- Яахав саналаа ч өгье. Эндхийн дэлгүүрээр оръё, бас бус хөөцөлдөх ажил бий. Хүн хартай уулзаж, заримтай нь золголоо гэж Гэрэлт-Од ярив. Энэ өдөр Сэргэлэн сумын төвөөс холгүй өнгөрдөг Эж хадыг чиглэсэн зам тун ч хөл хөдөлгөөнтэй харагдсан юм. Нарлаг дулаан ням гаригт микроавтобус, хөнгөн тэрэг хөлөглөсөн хүмүүс Эж хадыг зүглэн тасралтгүй цувах аж. Сэргэлэн сумын сонгуулийн 68 дугаар хэсгийнхэн үд хэвийж 15.00 цаг өнгөрөх үес гаднаа нарлан, үлдсэн цөөн сонгогчоо хүлээсээр хоцорлоо.



# Ирэх намраас инфляц буурна гэж эзэгтэй нар үзэж байна

Тэд зарим үндэслэлээр ийм дүгнэлтэд хүрчээ. Ургацын дээж алагласан улиралд махны хэрэгцээгээ багасгаад, төмсний нухаш, элдэв зууш хийнэ. Ингэхээр мах, махан бүтээгдэхүүний ханш хадахгүй нь лав. Хөдөөний хүүхнүүд сүү саалиа бялхуулсаар байх тул үнэ өртөг нь хямд байх болно. Тэгж байтал шинэ ургацын буудайтай залгаад инфляц өгсөх ямар ч боломжгүй. Нөгөө талаар, бүсгүйчүүд зуушаа амтлах гэж ургамлын тос, урин дулааны шувтаргад угааж арчих гээд угаалгын нунтаг, эдийн савангийн үнийг хөөргөддөг тал бий. Хүүхнүүд инфляцаар тоглож, Монголбанк, Статистикийн газрынхан 12 сарын турш тэдний тор савыг нь судалж тооцоолоод, инфляцийн үзүүлэлт гарган зарлаж байна. Харин бүсгүйчүүд ийм харь үг хэрэглэдэггүй. Тэд өөр зуураа хэрэглээний барааны үнийн индекс гэж ярьдаг юм. Жил жилийн найм, есдүгээр сард манай орны хувьд инфляц тухайн оныхоо хамгийн доод цэгт хүрдгийн учрыг ажилсаг эзэгтэй нараас асуугаарай.

**Дундаж болон ядуугийн хооронд амьдралын ялихгүй зөрүү байгааг дээрх баримт нотолно.**

Улсын эдийн засгийн гол үзүүлэлт өрхийн хэрэглээний бяцхан сагснаас хамаарч байна. Ийм нэг сагсны тухай «Өнөөдөр» сонины өнгөрсөн оны 238 дугаарт өгүүлснийг уншигч санаж байгаа болов уу. Эзэгтэй нь төсвийн байгууллагад, нөхөр нь дээд сургуульд багшилдаг, сургууль, цэцэрлэгийн насны хоёр хүүхэдтэй тэд өнгөрсөн оны аравдугаар сарын 13-ны байдлаар өрхийн төсвийн орлого, зарлагаа баланслуулаад явдаг байв. Харин гутал, хувцасныхаа зардлыг цалингаасаа гадуурх орлогоороо нөхөж амьдардаг болохыг нь тодорхой үзүүлсэн. Автобусны тасалбарын үнэ аравннэгдүгээр сард хоёр дахин нэмэгдсэний дараа тэдний төсөв хүндэрч, хэрэглээ нь улам л даруу болжээ. Насанд хүрсэн хүн өдөрт ядаж гурван ширхэг алим идэх нормтой гэж Хоол судлалын төвийнхөн зарлаж байна. Эднийх өдөрт нэг кг алим идээд байвал төсөв нь юу болохыг харья. Сард гуч гаруй мянган төгрөгөө жимс жимсгэнд үрэх нь ээ. Жаахан сагс нь ийм «том» зардлыг даахгүй. Яг ийм шалтгаанаар ядуу өрхийн нэг гишүүн өдөрт идвэл зохих жимс жимсгэний төрлийн бүтээгдэхүүний дөнгөж найм хүрэхгүй хувийг хэрэглэж байгаа юм. Өрхийн нэг гишүүнд сард 17.600 төгрөгөөс доош хувь ногдвол тэднийг албан ёсны статистик ядуус гэж үздэг. Тэгвэл манай баатруудын нийт орлогыг дөрөвт хуваахад хүн тус бүрт нь 40.000 төгрөг хуваарилагдана. Мөн л албан ёсны ангиллаар, 36.000 төгрөгөөс дээш хувь нэг гишүүнд ногдож буй тул орлого дээгүүр өрхийн тоонд тэд маань орох ёстой. Тэгэхээр ядуурал, ядуу ангилалд гулсах зааг, жишиг гэдэг маань өнөөдөр бодитой үзүүлэлт болж чадаж байна уу?



Нийслэлд хамгийн бага зардлаар нэг сар амь зууя гэвэл 17.600 төгрөг хэрэгтэй. Үүнийг амьжиргааны баталгаажих доод төвшин гэж нэрлэх агаад өнгөрсөн жил шинэчлэн зарлажээ. Ингэж зарлахдаа 1998 оны хэмжээнээс нь ердөө гурван мянган төгрөгөөр ахиулсан. Үүний дараа зөвхөн нийслэлд ядуучуудын эгнээнд 56.000 хүн шинээр элссэн байна. Дундаж болон ядуугийн хооронд амьдралын ялихгүй зөрүү байгааг дээрх баримт нотолно. Гэтэл нийгмийн чанартай арга хэмжээ зөвхөн ядууд нь гэсэн хаягтайгаар, явцуу хүрээнд хэрэгжиж байгаа шүү дээ. Орлого дээгүүр, бараг чинээлэг шахуу ангилалд яваа манай баатруудад гутал, хувцасныхаа хэрэгцээнд зарлагдах

хэмнэлт цалингаас нь үлддэггүй. Сүүлийн гурван жилийн мэдээгээр, монголчуудын өмсөх зүүхдээ илүүчилдэг хөрөнгө хумигдсаар, харин хоол хүнсний зардлын диаграмм бага багаар ахисан харагдана. Гэхдээ хоол хүнсний хэрэглээ дотроо мах, төмс, манжин, хоёр, гуравдугаар гурилыг түлхүү авдаг тооцоо гарчээ.

Статистикийг лавшруулан сонирхье. Хотынхон хоол хүнсний зардлаасаа хэмнэн байж тээвэр, холбоо, орон сууцны үйлчилгээнд улам л ихийг хураалгаж буй өөрчлөлт ажиглагдана. Нийт орлогынхоо 77.1 хувийг нийслэлийн иргэн хоол хүнсэнд үрдэгтэй харьцуулбал жишээ нь Говь-Алтайнхан 85 хувийг нь ууж идэх хэрэгцээндээ зарж байна. Өнөөдөр ядуурал руу олон өрх гулсах болсон нэг шалтгаан нь үйлчилгээний өндөр өртөг болжээ. Боловсролын болон Сангийн сайдын хамтарсан тушаал 1993 оны хоёрдугаар сард гарч, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тал хувийг эцэг эх нь даах болсон юм. Ийм шийд гарсны дараа цэцэрлэгийн хүүхдийн тоо эрс цөөрсөн мэдээ тухайн үед гарч байлаа. Өрхүүдийн хэрэглээний сагс гэдэг хариугүй хэврэг эд болох нь эндээс харагдана.

Халаасандаа 210 төгрөгтэй хүн 1991 онд Улаанбаатарт дөнгөөд нэг сар амьдарч чаддаг байв. Харин одоо үүнээс 84 дахин их мөнгөтэй байж нэг сар өл залгана. Бидний амьдралын өртөг ийнхүү өсч байхад орлого талд маань ямар өөрчлөлт орсон билээ? Мөнөөх л цалин, тэтгэвэр, тэтгэмж гурваас цааш нэмээд бичих төрөл тун цөөхөн. Гэтэл үүний эсрэг өөр нэг үзүүлэлт анхаарал татах боллоо. Гутал, хувцсандаа зориулдаг мөнгөний дүн жил ирэх тутам буурчээ. Тэгвэл ийм төрлийн бараа борлуулдаг дэлгүүр, лангуу нэмэгдсэн тухай өөр нэг тоо юуг өгүүлнэ вэ? Өрхүүдийн орлого талын жагсаалтад шинэ эх үүсвэрүүд гарсан хэрэг үү?

Сонгогчдод хандсан энэ популист үгс анх хэвлэгдэж гарсан 1996 оны тавдугаар сар гэхэд манай иргэдийн 36 хувь нь ядуу байсан бол дөрвөн жилийн дараа уг үзүүлэлт дөнгөж нэг хувиар л доошлоод байна.

Гадаадад хараар болон цагаачлан амьдардаг манай иргэдийн тоо жил ирэх тутам өсч, тэдний ар гэртээ гуйвуулдаг хэдэн доллар нь томоохон хөрөнгө оруулалтын дайнд хүрчээ. Албан бус тооцоогоор, төрөлх нутагтаа тэдний илгээдэг мөнгө жилд багцаагаар 80 сая ам.доллар гэнэ. Өнгөрсөн оны хоёрдугаар улирлын байдлаар нийслэлд өрхийн сарын дундаж орлого 75.760 төгрөг байсан. Харьцуулалт хийе. Нутагтаа нуруугаа автал жил хөдөлмөрлөөд нэг сая хүрэхгүй төгрөг олох нь. Харин 40 мянган цагаач бүр жилд дунджаар хоёр мянга орчим ам.доллар ар гэртээ илгээдэг байж болзошгүй. Өөрөөр хэлбэл, гадаадад ажил хөдөлмөр эрхэлж, арилжаа наймаа үсэргэж яваа хүн багцаагаар хоёр сая гаруй төгрөг жилд илгээдэг аж. Ах дүү, садан төрөл олуул монголчуудын хувьд ийм нэг тэжээгч хэд хэдэн өрх, эсвэл өрхийн цөөнгүй гишүүдэд ногдох орлогыг нэмэгдүүлж явна. Ер нь бидний хувьд өрх нь аав, ээж, охин, хүүгээр хязгаарлагдахгүй. Нэг байранд хамтран амьдрагч хэсэг хүний тухай ойлголт юм. Дээрх нь байнгын биш ч, томоохон хөрөнгө оруулалт юм. Түүнчлэн цагаачлал дагаад электрон шуудан, факсаар харилцахаас эхлээд хүний хөгжил талдаа дэвшил гарсаар байна.

Өрхийн орлогын нэр төрөлд ерээд онд шинээр нэмэгдсэн нэг зүйл нь зээл. Ядууст олгодог зээл өрхийн аж ахуйд ямар үүрэг гүйцэтгэснийг бодитой харахыг оролдье. Амьжиргааны доод төвшнөөс бага орлоготой хүмүүст зээл өгөх замаар ядуурлын хүрээг хумина гэсэн гэгээн мөрөөдөл 1994 оноос хойш засаг, төр толгойлсон улстөрчдөд байсан юм. Ийм төлөвлөгөөнд тулгуурлан өнөөгийн эрх баригчид нийгмийн чиглэлээр амлалт авч, биелэлтийг нь «**2000 он гэхэд ядуурал 1996 оны төвшнөөс хоёр дахин буурна**» хэмээн урьдчилан томъёолжээ. Сонгогчдод хандсан энэ популист үгс анх хэвлэгдэж гарсан 1996 оны тавдугаар сар гэхэд манай иргэдийн 36 хувь нь ядуу байсан бол дөрвөн жилийн дараа уг үзүүлэлт дөнгөж нэг хувиар л доошлоод байна. Амласан, биелсэн хоёр хол зөрсний шалтгааныг хамтдаа хайя. Ерөнхий сайдаар

ахлуулсан Ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл хөтөлбөр хэрэгжүүлж, түүний хүрээнд нэг ядуу хүнд 100-120 мянган төгрөгийн зээл олгож байна. Сард нэг хувийн хүүтэй ийм зээл үр дүнгээ өгч буй тухай Нийслэлийн ядуурлыг бууруулах зөвлөлийн нарийн бичгийн дарга П.Эрхэмбаатарын ярианаас ишлэл авъя.

-Олон сайн жишээ бий. Хоёр хүн хамтарч 300 мянган төгрөгийн зээл аваад монгол гутал хийж борлуулж байна. 120 мянган төгрөгөөрөө яндан хийж борлуулсаар ашиг орлого нь нэмэгдэж, өөртөө сайхан дүнзэн байшин босгосон хүн ч бий. Ер нь өнөөдөр зах дээр зарж буй гар хийцийн хүрэм, цүнх гээд жижиг эд зүйлийг манай төсөлд хамрагдсан иргэд л хийж зарж байгаа гэсэн юм.

Гэхдээ бодит байдал дээр ийм зээлийн эргэн төлөлт 67 хувьтай явна. Хөтөлбөрийг санхүүжүүлэгч Дэлхийн банк, өмнөхөө төлж байж дараагийнхыг нь ав гэсэн зарчим барьдаг тул уг зээлийн олдоц одоо ховордох тийшээ ханджээ. Нөгөө талаар, зээлийг гардан хуваарилагч буюу эрх баригч эвслийн нийгмийн чиглэлээр авч буй арга хэмжээнд гол үүрэгтэй субъект нь хорооны дарга. Олон нийтээс сонгогдсон энэ хүн олон нийтийн бус байгууллагын статус бүхий газраас удирдамжаа авдаг сонин бүтэцтэй. Харин тэрбээр урамшуулал хүртдэггүй. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн газар нь аппаратынхан болон нарийн бичгийн дарга нараа л цалинжуулна. Урамшилгүй хоцорсон хороон дарга зээл авагчдын хойноос шил даран хөөцөлдөхдөө дурамжхан. Өнөө маргаашийн хэрэгцээгээ залгуулж ядсан, авснаа буцааж өгөх магадлал тун тааруу ядуу иргэдийн араас нэхэл болж явахаасаа төвөгшөөсөн хорооны дарга нэмж «төсөл хэрэгжүүлэхгүй» санаатай байх нь бий. Үүний зэргэцээ 100-120 мянган төгрөгийг өнөөгийн бизнес, эдийн засгийн хахир орчинд чулуу болгоно гэдэг ухаан, хөлс шаардсан ажил. Хамтраад хөдөлье гэсэн ч бага мөнгийг олуулаа «эргүүлээд» дорвитой юм бүтээх нь ховор.

Хэдийгээр ерээд оноос хойш өрхийн орлогын талд нэр төрөл энэ мэтээр нэмэгдэж буй ч ядуурал нийтийг хамарсан хэвээрээ байна. Нэг хөтөлбөрийн хүрээнд, хэсэг бүлгийн ядууралтай тэмцэх нь өнөөдөр ач холбогдлоо алдаж, нийт өрхүүдийн сагс руу өнгийх, түүний орц хэмжээг ахиулах өнцгөөс шинэ алхам хийх шаардлага гарав. Шинэ алхам, цогц арга хэмжээ авахын өмнө өрхүүдийн орлогын төрлийг илүү нарийвчлан судлах, үүний үндсэнд орлого нэмэгдүүлэх чиглэлээр дорвитой дэмжих арга хэмжээ авмаар болжээ. Инфляцын муруй 1998 оноос хэт хэлбэлзэх нь багассан. Үүнийг дагаад өрхийн төсөв харьцангуй тогтвортой байгаа үед хэрэглээгээ хэмнэх, орлогын шинэ эх сурвалжаа оновчтой ашиглах маягаар бид амьдралаа нэг шат ахиулах боломж гарч байна.

Намар үнэ нь хямдрахаар манай дөрөв алим жимс ахиухан идэж магадгүй. Харин Эрчим хүчний удирдах газрынхан халаалт, цахилгаан, халуун усны үнийг өнгөрсөн жилийнх шиг өсгөхийг оролдвол эднийх хэрэглээний жаахан сагсандаа багтахаа байж, амьжиргааны доод төвшин хэмээх ангал руу гялсхийн унах биз ээ.

**Хэн, юуг хэдий хэмжээнтэй иддэг вэ?**

(Хоол судлалын төвийн ажилтан Б.Энхтунгалагийн судалгаа)

(граммаар)			
	Өдөрт хэрэглэх зөвлөмж хэмжээ	Улаанбаатарт хэрэглэж байгаа нь (1998-1999)	
		Сард 17600 төгрөгөөс доош орлоготой иргэн	Сард 36000 төгрөгөөс дээгүүр орлоготой иргэн
Мах, махан бүтээгдэхүүн	230	85	224
Сүү, сүүн бүтээгдэхүүн	380	104	496
Гурил, гурилан бүтээгдэхүүн	340	223	408
Цөцгийн тос	27	3	12.2
Сахар, чихрийн зүйл	60	13	68
Төмс	120	50	60
Хүнсний ногоо	200	48	228
Өндөг	7	-	6
Ургамлын тос	25	10+өөхөн тос 11	31.1+ө/т 3
Загас	4	-	6
Будаа	45	37	52
Жимс, жимсгэнэ	280	22	137
<b>Нийт</b>	<b>Өдөрт 2731 ккал илчлэг авах ёстой</b>	<b>Авах ёстой илчлэгийн 65%-ийг хэрэглэдэг буюу өлөн зэлмүүн ангилалд багтдаг</b>	<b>124.6%-ийг хэрэглэдэг буюу хэтрүүлдэг</b>

**Өрхийн орлого, зарлага**

(төгрөгөөр)

Нийт орлого (1999.10.13-ны байдлаар)	Нөхрийн цалин Гэргийн цалин	90.000 55.000		
Нийт зарлага (1999.10.13)	7 хоногийн дундаж зардал	Сарын дундаж		
		Төг-өөр	%-аар	
1.Мах	3кгх700=2100	8400	35.4	
Гурил	2кгх400=800	3200		
Будаа	1кгх400=400	1600		
Элсэн чихэр	1кгх600=600	2400		
Цөцгийн тос	0.5кгх1300=650	2600		
Наранцэцгийн тос	0.5лх1200=600	2400		
Төмс	5кгх300=1500	6000		
Бусад ногоо	2кгх500=1000	4000		
Сүү	2лх350=700	2800		
Жимс	1кгх700=700	2800		
Боов	1кгх800=800	3200		
Цай	1шх600=600	2400		
2.Саван	2шх270=540	2160		10.6
Оо	1шх800=800	3200		
Угаалгын нунтаг	0.5х1200=600	2400		
Шингэн саван	0.5лх2000=1000	4000		
Эдийн саван	1шх200=200	800	33.4	
3.Унааны зардал	5өдөрх400=2000	8000		
Өдрийн хоол	5өдөрх1200=6000	24000		
Хэвлэл	600	2400		
Цэцэрлэг		5000	20.3	
4.Байрны талбайн хөлс, халаалт, ус, цахилгаан, утас, кабелийн хураамж		24000		
<b>Бүгд</b>		<b>117760</b>		

<b>Нийт орлого</b> (2000.04.10-ны байдлаар)	Нөхрийн цалин Гэргийн цалин	90.000 70.000	
<b>Нийт зарлага</b> (2000.04.10)	7 хоногийн дундаж зардал	Сарын дундаж	
		Төг-өөр	%-аар
1.Мах	3кгх1200=3600	14400	37.1
Гурил	2кгх450=900	3600	
Будаа	1кгх450=450	1800	
Элсэн чихэр	1кгх600=600	2400	
Цөцгийн тос	0.5кгх1300=650	2600	
Наранцэцгийн тос	0.5лх1300=650	2600	
Төмс	5кгх450=2250	9000	
Бусад ногоо	2кгх600=1200	4800	
Сүү	2лх380=760	3040	
Жимс	1кгх700=700	2800	
Боов	1кгх850=850	3400	
Цай	1шх600=600	2400	
2.Саван	2шх280=560	2240	8.8
Оо	1шх800=800	3200	
Угаалгын нунтаг	0.5х1200=600	2400	
Шингэн саван	0.5лх2000=1000	4000	
Эдийн саван	1шх200=200	800	
3.Унааны зардал	5өдөрх800=4000	16000	36.1
Өдрийн хоол	5өдөрх1400=7000	28000	
Хэвлэл	600	2400	
Цэцэрлэг		5000	
4.Байрны талбайн хөлс,халаалт, ус, цахилгаан, утас, кабелийн хураамж		25500	17.9
<b>Бүгд</b>		<b>142380</b>	

# Инфляц галзуурах цагаар

Инфляц жилийн хамгийн өндөр үзүүлэлтэд хүрдэг арав, арваннэгдүгээр сар дараалан айлсах өдрүүд ирлээ. Үнийн өсөлтийн график өмнөх жилүүдийнхээс огцом өндөлзөх магадлалтай харагдана. Нефть бүтээгдэхүүний экспортын татвар төд удалгүй 30 хувиар нэмэгдэх тухай мэдээлэл сар орчмын өмнөөс түгэж, эзэгтэй нар өрхийн төсөвтөө хэдийнэ тодотгол хийж эхэлжээ. Ийм цохилт дээр нэрмээс болгохгүйн тулд цахилгаан, дулааны үнийг дахин өсгөх санаархлаасаа Эрчим хүчний зохицуулах газар татгалзав. Энэ оны туршид өсч нэмэгдээгүй ханш гэж ховор. Бүхэлдээ 2005 он өндөр үнэ, ахиу зарлагын жил байлаа. Айсуй 2006 оны төсвийн төслийг санхүүгийн мэргэжилтнүүд бэлтгэж суугаа үед эдийн засгийн нөөц чадамж, үндсэн үзүүлэлтүүд маань ямархан хэмжээнд байгааг эргэн харцгаая. Ингэхдээ эзэгтэй, хүүхнүүдээс бас зөвлөгөө аваарай хэмээн мэргэжилтнүүдэд сануулъя.

Төсвийн зарлагын өсөлт орлогоосоо түрүүлж явааг Шадар сайд Ч.Улаан тэмдэглээд, эдийн засаг ачаагаа дааж чадах болов уу даа хэмээн санаа зовнижээ. Тэрбээр мэдээж макро түвшний асуудал хөндсөн байж таарна. Харин манай эзэгтэй нар микро түвшний буюу тор савандаа цуглуулсан хүнсний бүтээгдэхүүний хэмжээ, хэтэвчинд үлдсэн хэдээ харьцуулаад мөн л «Өрхийн төсөв ачаагаа дааж давахад бэрх боллоо» гэгцгээх вий. Ингэхдээ тэр инфляц гэгч мангас хэр том бэ гэдгийг тун бодитой хэлж мэдэх юм шүү. 2005 оны турш өсч нэмэгдсэн үнэ ханшийг нэгтгэн харвал хариуд нь инфляц хэмээх үзүүлэлт тооны машины дэлгэц дээр дурайдгийг шинэ цагийн эзэгтэй гадарладаг. Хүнсний зах руу явангаа түүний хийсэн тооцоо Н.Алтанхуягийнхаас, Үндэсний статистикийн ерөнхий газрынхаас, зарим тохиолдолд ОУВС-гийнхаас зөрөөд байхыг яана. Энэ оны турш инфляцийн өөрчлөлт 6-9 хувьтай байгаа талаар Санхүү, эдийн засгийн сайдын ярьсныг эзэгтэй эрс эсэргүүцэж байна. Энэ оны турш инфляцийн өөрчлөлт 6-9 хувьтай байгаа талаар Санхүү, эдийн засгийн сайдын ярьсныг эзэгтэй эрс эсэргүүцэж байна.

**Хүнсний зах руу явангаа түүний хийсэн тооцоо Н.Алтанхуягийнхаас, Үндэсний статистикийн ерөнхий газрынхаас, зарим тохиолдолд ОУВС-гийнхаас зөрөөд байхыг яана. Энэ оны турш инфляцийн өөрчлөлт 6-9 хувьтай байгаа талаар Санхүү, эдийн засгийн сайдын ярьсныг эзэгтэй эрс эсэргүүцэж байна.**

Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд бодитой бус гараад байдгийг анзаарсан хүн олон биз. Хамгийн гол нь, сүр хүчийг илтгэсэн сайхан цифрийн цаана хэтэвч нимгэн амьдрал түм бумаараа нуугдаж, хөөсөнцөртэй эдийн засгийн дүр зураг харагдах аж. Тэдгээр ядууст инфляцийг хасаж зохицуулах арга гэгчийг хэчнээн тайлбарлаад нэмэргүй. Инфляц тооцож гаргадаг олон загвараас хасаж зохицуулдгийг нь бид хэрэглэдэг юм шүү дээ хэмээн санхүү, тайлан тооцооны мэргэжилтнүүд өгүүлэх байх. Тэгвэл хэрэглээний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн сагснаас мах, сүү, төмс, хүнсний ногоог хасаж тооцсон инфляцийг өдгөө төрийн байгууллагууд зарлаж байна. Улирлын чанартай үнэ нь хэт хэлбэлздэг эдгээр бүтээгдэхүүнийг хасч гаргасан дүн эзэгтэйн амьдралын баримжаанаас зөрөөд байх нь аргагүй. Инфляц гэдэг олон улсын санхүүгийн байгууллагуудад зөөллөн, сайхан малгай толгой нөмөргөн мэдээлдэг үзүүлэлт биш. Энэ үзүүлэлтэд үндэслэн Монгол Улсын мөнгөний бодлогыг томъёолдог болохоор, тэр бодлого эргээд бидний амьдралд тусгалаа олдгийн учир эзэгтэй эргэлзэх эрхтэй. 2006 оны төсвийн төсөл болоод ирэх жил баримтлах мөнгөний бодлогыг хэлэлцэх «Төсвийн сар» өмнө байна. Энэ хэлэлцүүлэгт иргэд идэвхтэй оролцоосой.

Инфляцийн аюул зөвхөн Монголд бус, дэлхийн гол гол эдийн засгуудад нүүрлээд байгаа билээ. Нефть бүтээгдэхүүний хязгааргүй эрэлт, Арабын



ертөнцийн хар алтаа харамласан эдийн засгийн дайн нь дэлхийн импортлогчдыг бухимдуулж буй юм. Европын орнууд, АНУ, Япон, БНСУ зэрэг нефтийн импортоос хэт хараат улсуудад инфляц манайтай адил толгой өндийлгөжээ. Ялгаатай нь, монголчууд бас махны үнэ өсөхөөс өдөр шөнөгүй айх агаад дээр нь цахилгаан, дулааны үнийг дуртай цагтаа хөдөлгөчих дуршлаас давхар эмээнэ. Энэ оны хоёрдугаар сард ахуйн хэрэглэгийн дулааны үнийг бараг 20 хувь огцом өсгөж нэг ёсны рекорд эвдсэн юм. Дээр нь цахилгааны хэрэглээний үнийг нэмж орхисон. Төдөлгүй тавдугаар сард нүүрсний салбарынхан «эрхээ эдэлж», төмөр замынхан дуун дээр нь тарифаа өсгөв. Залгуулаад усны үнэ хадаж, араас нь мах магнаг болов. Их инфляцийн жил эх орны хөрс шороонд ургасан төмс, хүнсний ногоо эрэлт ихтэй байж, эзэгтэй зайлуул, бага багахнаар төсөвтөө тааруулан тэр «тансаг» хэрэглээнээс авч байлаа. Дараа нь гурил яаж зүгээр байхав, үнэ нь мөн нэмэгдэв. Өсч өндийгөөгүй зүйл гэвэл цалин л үлджээ.

Дэлхийн инфляцийн үзүүлэлтүүдээс түрүүлэн цойлох магадлал манайд ийн тодров. ОХУ-д их өр төлснөөс болоод валютын нөөц дундарсан, түүнээс шалтгаалаад ам.долларын ханшид Монголбанк зохицуулалт хийж чадахгүй байгаа тухай нэг хэсэг шуугив. Тэгвэл алт, зэсийн баяжмалын үнийн таатай орчинд улсын валютын нөөц өдгөө зохих хэмжээндээ хүрч буй гэнэ. Гэсэн ч ам.долларын ханш урт хугацаанд чанга байлаа. Монголбанкны зарласан ханшийг дагаад арилжааны банкууд ам.доллар дээр жаал «ажиллав». Оны эцэс гэхэд нэг доллар 1230 төгрөгтэй тэнцэх магадлалтай аж. Дайны хажуугаар дажин болж, юань чөлөөтэй «хөвж» эхэллээ. Юань бие тоохын хэрээр Монгол Улсын эдийн засагт алс хэтдээ айх аюул нэгээр нэмэгджээ. Эдүгээ бид нийт импортынхоо 70 гаруй хувийг валютын төлбөрөөр хийдэг. Доллар, юанийн ханш урт хугацааны турш чангарах тусам дотоодод өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үнэд орох хандлага тогтов.

Үнийн цунамид харьцангуй бага өртөх салбар гэвэл уул уурхай, үйлчилгээнийхэн бололтой. Юутай ч эдгээр салбар 2005 оны эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтийг цээжээрээ хаан үлдэх биз. Өнгөрсөн жилийнх шиг эдийн засгийн өсөлт 10 хувь даван биднийг алмайруулахгүй, 5-6 хувьтай гарна гэж тооцож байна. Гэвч тэрхүү өсөлт макро түвшинд харагдаж, микро хэсгийнхэн буюу манай эзэгтэйд падгүй хоцрох юм. Микро түвшнийхэн бол инфляц-мангасаас л эмээж сууна. Эндээс эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн уялдаа үгүй болсныг харж болно. Монголбанк ирэх онд мөнгөний бодлогоо чангатгах нь лав. Мөнгийг хумьж, гүйлгээнд байгаа бэлэн дэвсгэртийн хэмжээг хазаарласнаар инфляцид нөлөөлнө хэмээн бодлогоо тодорхойлох байлгүй. Гэсэн ч мөнгө санхүүгийн зохицуулалтын зэргэцээ шатахууны нөөц бий болгох, махны үнийн шинэ менежмент нэвтрүүлэх зэргээр давхар бодлого бодохоос аргагүй.

Дэлхийн хүмүүс зул сарын баярын бэлтгэлдээ орохын цагт эрэлт өсч, нийлүүлэлт агуулахын мухраасаа гарч таарна. Арилжаа наймааг дагаад эдийн засгууд өндийж сэргэх буй за. Харин уудам Монгол нутгийн зүг бүрээс шинэ жил, цагаан сарын хэрэглээний импортын урсгал хөвөрч, бид бусдын эдийн засагт буянаа өргөсөөр үлдэнэ. Ам.доллар, юанийн ханш үргэлжлэн өсөх тооцоо эзэгтэйн цээжинд бий. Улам бүр данхайх өрхийн зарлагаа тэр яая гэж суугаа. 2006 оны улсын төсвийн төслийг хэлэлцэх хурлууд түүнд нэг л уйтгартай санагдаж, мөдхөн баяр баясгалантай зарлаад эхлэх эдийн засгийн өсөлтийн цифрт үл итгэн, тооны машин, торгой хүнс, төлбөр тооцооны хуудастайгаа эзэнгүй арал дээр хоцорсон лугаа харагдана.

**Ам.доллар,  
юанийн ханш  
үргэлжлэн өсөх  
тооцоо эзэгтэйн  
цээжинд бий.  
Улам бүр данхайх  
өрхийн зарлагаа  
тэр яая гэж суугаа.  
2006 оны улсын  
төсвийн төслийг  
хэлэлцэх хурлууд  
түүнд нэг л  
уйтгартай  
санагдаж, мөдхөн  
баяр баясгалантай  
зарлаад эхлэх  
эдийн засгийн  
өсөлтийн цифрт үл  
итгэн, тооны  
машин, торгой  
хүнс, төлбөр  
тооцооны  
хуудастайгаа  
эзэнгүй арал дээр  
хоцорсон лугаа  
харагдана.**

# Монгол тамгыг Япон руу сэм зөөлөө

140 хүний бүрэлдэхүүнтэй тусгай баг маш олон боодол савтай зүйл ачаалан өнөө өглөө Буянт-Ухаагаас хөөрөв. Нэг тонн орчим ачаа энэ удаа Монгол Улсын хилийг нэвтэрсэн бөгөөд өмнө нь хоёр тонн эд зүйл мөн ачуулжээ. Токиод гэж хаягласан их ачаанд «Алтан тариа» гурил, «Атар» талх, «Өгөөж» боов, шороотой төмс, лууван төдийгүй модон тоглоом, монгол урлал, ноолууран цамц, хивс бий. «Тусгайгийнхныг» Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга толгойлж яваа нь гайхалтай. Тэрбээр бүтэн жилийн турш Японы «Жетро»-той бичиг цаас солилцон ийм тусгай баг Токиод буулгах ажлыг хөөцөлджээ.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэлийн өөрийнх нь хэлснээр, манай танхимтай төстэй үйл ажиллагаа эрхэлдэг Японы «Жетро» нэртэй байгууллагыг тэр ийнхүү үймүүлсэн байна. Хөгжиж буй орнууд уг байгууллагаар дамжуулан баян Японд экспортын хэдэн бараагаа харуулаад буцдаг буяны гэлтэй өрөвдмөөр арга хэмжээний стандартыг Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим эвдэхээр хөдөлжээ. Ингэхдээ үндэсний 70 бизнесмэн, урлагийнхан, загварын ертөнцийн залуусаас бүрдсэн баг авч Токиогийн төвд зургаан өдөр чимээ шуугиан дэгдээх бодолтой.

«Улаанбаатараас ирсэн онгоцноос Норовбанзад гуай бус, Монголын рок попын төлөөлөгчид буувал яасан юм», «Монгол төмсний амтыг япончууд үзэг», «Хэдэн тонн ачаа дотор маань Чингисийн хөрөг нээх олон байхгүй» гэж С.Дэмбэрэл доогтой ярьж байна.

**-Тэгээд Та ямар зорилго тээсэн хэрэг вэ? Морин хуур, Чингистэй хивс, Норовбанзад гуайн CD-ийг л тэнд сонирхдог биз дээ. «Атар» талх чинь замдаа муудчихгүй юу? Монгол төмсийг япончуудад яаж амглуулах нь вэ?**

-Монгол Улсын шинэ имижийг дэлхий ертөнцөд гаргаж өгөх зорилго бид өвөрлөсөн. Шинэ элементүүдээр баяжуулсан уламжлалт болон орчин цагийн хосолмол соёлыг таниулах бодолтой байна. Өөрөөр хэлбэл Монголын хувьд дархлагдсан тэр «brand name» нь юу байж болох билээ, түүнийг ертөнцөд бий болгоё. Олон улсын үзэсгэлэн яармагт манай хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн анх удаа оролцож байна. Эрүүл, био бүтээгдэхүүний үндэс суурьтайгаа харуулъя. Шороотой тэр төмс чинь байгалийн эрүүл гаралтай эд. Магадгүй ийм талаараа хүнсний салбар дэлхийд өрсөлдөх нэг чиглэл маань ч юм билүү. Монголд хийсэн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг Америкийн зах зээлд зардаг. Тэгвэл тэдгээрийг япончуудад яагаад үзүүлж болохгүй гэж. Загвар зохион бүтээгч залуус авангард урлалаа Токиогийн төвд харуулаг. Мэдээлэл, технологийн салбарынхан ядахдаа хэдэн вэб сайтаа үзүүлэг.

**-Үр дүн нь юу байх вэ?**

-«Amazing Thailand»... Ямар байна?! Энэ бол Тайландын дэлхийд танигдсан дархлаа нэр нь. Товч, сонсголонтой, тэгээд бас тэр улсыг дүүрэн илэрхийлэх үг. Тэгвэл Монголын ийм тодотгол хаана байна? Бид энэ үзэсгэлэн яармагийн үеэр «Inspiring Mongolia» гэсэн уриа (moto) хэрэглэнэ. Уг товч илэрхийллийнхээ дор **байгалийн мэдрэмж** хэмээх холбоо үгийг тавина. Өөрөөр хэлбэл, дэлхий ертөнцөд байгалийн мэдрэмж бүхий Монголын гэсэн түрлэг амьсгалыг өдөөн түгээх юм.

**-Сурталчилгаагаа яаж хийсэн бэ?**

-Зарлал сурталчилгааг Японд овоо хийж байгаа. Д.Батбаяр, Д.Дагвадорж, Н.Цэвэгниа гурав «Made in Mongolia» нэртэй үзэсгэлэн худалдааны маань ерөнхий нэрийг рекламдаж байна.

**-Хэр олон хүн үзэх бол?**

**Пад! Пад!  
Хонгоо дараад  
хоцроорой.  
Хожим оюун  
бодолд шингэж  
хоногших  
Монголын гэсэн  
шинэ тамгыг  
Токио руу сэм  
зөөлөө.**

-Хүмүүс үзнэ гэж бодож байна.

**-Энэ пүрэв гаригаас ирэх мягмар гариг хүртэл зохиогдоно гэхээр амралтын өдрүүд таарах нь ээ?**

-Тэгнэ. Амралтын өдрүүдэд ч ажиллана. Өдөр бүр 9-17 цаг хүртэл нээлттэй.

**-Японы хэвлэлийнхэн хэр анхаарал хандуулах бол?**

-Лав ирнэ. Тэд хэр анхаарал хандуулах нь бидний ажиллагаанаас хамаарна гэв.

«Inspiring» хэмээн С.Дэмбэрэл уртаар уянгалуулан хэлэхдээ булгийн хүйтэн усаар нүүрээ шавшиж буй аятай дүр төрхтэй суув. Уг арга хэмжээ нь ертөнцийн нэгэнт хэвшсэн амьсгалд Монголын гэсэн шинэ имиж нэмж, яг л сэрүүн тунгалаг усаар түрэх адил сэтгэгдэл өгөх учиртай аж.

«It is a Sony» энэ тамга Sony фирмийн бүтээгдэхүүний хайрцаг боодол, өрөө тасалгаанд, эцэст нь хэрэглэгчийн уураг тархинд дархлагдсан. Тэгвэл одоо «Inspiring Mongolia» буюу Монгол түрлэг эхэллээ. Байгалийн мэдрэмж бүхий Монгол түрлэг гэсэн уриагаар эх орноо дэлхийд сурталчлах эхний алхмаа Японд хийхээр бизнесийнхэн шийджээ. «Inspiring Mongolia» тамгыг япончуудын тархи оюунд үлдээгээд ирэх гэнэ. Пад! Хөх тэнгэрийн, Чингисийн, шүлхийтэй, алттай, дээр нь пад! Бас авангард загвар сэтгэж, программ хангамж экспортлодог Монгол. Хонгондоо хөх толботойгоороо л япончууд Монголтой холбогддог гэв үү? Тэгвэл бас нэг тамга нь энэ. Пад! Пад! Хонгоо дараад хоцроорой. Хожим оюун бодолд шингэж хоногших Монголын гэсэн шинэ тамгыг Токио руу сэм зөөлөө.

**2001 он**

# Дэлхийн зах зээл тэртээд үү, энүүхэнд үү?

Шинэ онд Монгол Улсын ямаа хэд болохыг Хятадын Засгийн газар урьдчилан тооцож чадна. Сүүлийн есөн жилд зургаан саяар нэмэгдсэн Монгол ямааны тоо толгойн өсөлтийг Хятадын худалдааны бодлого өнгөрсөн жил зогсоолоо. Жилд дунджаар 670 мянгаар нэмэгдэж байсан ямаан сүрэг 1999 онд зуун мянгаар цөөрөв. Ямааны өсөлтийг зогсоож, цаашдаа хорогдуулах боломж Хятадын худалдааныханд, тодруулбал ноолуурын бизнесийнхэнд бий болжээ. Монгол Улсын Засгийн газар ийм аюултай дохионд хариу болгож экспортынхоо татварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авдаг. Гэвч ямааны арьс тутмаас зургаан мянган төгрөг, нэг кг ноолуураас дөрвөн мянган төгрөг хураагаад ч хятадуудын нөлөөг багасгаж чадахгүй байна. Татвартай хил нэвтрэх болсон ямааны арьс өнөөдөр мөн л эрэлттэй хэвээрээ, ханш нь унасангүй.

Монгол малын түүхий эдийн үнэ дэлхийн зах зээлийн жишгээс олон дахин доогуур байгаа учир экспортын татварын босго ийнхүү олигтой саад болдоггүй. Манай хямд түүхий эдээс асар ашиг унагахын зэргэцээ Хятад улс дэлхийн зах зээл дээрх ноолуурын гол өрсөлдөгчөө атгандаа оруулахыг эрмэлзэж байна. Дэлхийн ноолуур бэлтгэлийн нөөцийн жагсаалтад шил даран явдаг, ямааныхаа тоогоор эхний аравт хэн хэн нь нэрлэгддэгийн хувьд манай хоёр улс өрсөлдөгчид билээ.

Манай хямд түүхий эдээс асар ашиг унагахын зэргэцээ Хятад улс дэлхийн зах зээл дээрх ноолуурын гол өрсөлдөгчөө атгандаа оруулахыг эрмэлзэж байна.

Бид өнөөгийн бэлтгэж буй ноолуурынхаа хэмжээг дахин мянга илүү тонноор нэмэгдүүлэх боломжтойг манай судлаачид тооцсон. Өөрөөр хэлбэл, дэлхийн нийт ноолуур үйлдвэрлэлийн дөрөвний нэгийг Монгол Улс бэлтгэдэг гэсэн статистик өсөх сайхан бололцоо харагдаж байна. Харин Хятад улсын хувьд, дэлхийн нийт ноолуурын үйлдвэрлэлийн гуравны нэгийг бэлтгэж буйгаа чамлаж, энэ зах зээл дээр бүрэн ноёрхлоо тогтоох, үнэ тогтоогчийн байр сууриа бататгах сонирхолтой. Монгол ямааны тоо, ноолуурын нөөц цаашид өснө гэсэн таамаглалыг Хятадын бодлого өнөө цохиод байна. Дэлхийн зах зээлд наймаалдаг гол бүтээгдэхүүндээ хүч сул хэдий ч өрсөлдөгчтэй байхыг тэд хүсэхгүй. Ялангуяа нарийн ширхэгтэй ноолуур бэлтгэдэг манай давуу талыг ашиглах, ингэх боломж хумигдах тусам ямааны тоо толгойг хорогдуулах, улмаар «Говь» үйлдвэрийн хувьчлалын тендерт тус улс оролцох бололцоо хаагдсан нөхцөлд өрсөлдөгчөө түүхий эдээр дутагдуулах зэрэг олон хувилбараар Хятадын худалдаачид Засгийн газраасаа дэмжлэгтэй ажиллаж байгаа юм. Тэд манай ноолуур бэлтгэл, борлуулалтын өнөөгийн зохицуулалтгүй задгай байдлыг ашиглан нөлөөллөө нэгэнт тогтоожээ.

Монголын ямаан сүрэг одоо байгаа 11 саяасаа цаашид хорогдвол дотоодын үйлдвэрүүд түүхий эдээр хомсдож, эргээд өөрөө ноолуур импортлогч болох аюул ойрхон байна. Өнөөдөр манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний тоонд багтаж буй ч үнэ ханш нь дэлхийн зах зээлийнхээс өөрөөр тогтоогдож буй ганц бүтээгдэхүүн нь ноолуур юм. Хятадын наймаачид манай ноолуурын үнийг сүүлийн дөрвөн жилийн турш кг тутмыг нь дэлхийн зах зээлийн жишгээс есөн ам.доллараар доогуур барьсаар ирлээ. Түүхий эдийг тэр хэвээр нь бус, нэмэгдэл өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгож гаргах, боловсруулаагүй түүхий эдийн экспортын татварыг дахин нэмэх, махыг нь мөн экспортолж, нядалсан малынхаа ашиг шимийг гүйцэд хүртэх замаар Хятадын худалдааны ноёрхлыг сөрөх боломжтой юм. Гаалийн босгоо

өндөрлөөд байх нь Дэлхийн худалдааны байгууллагад таалагдахгүй гэх эргэлзээ бий. Тэгвэл дэлхийн олон орон далд аргаар өрсөлдөгчөө боож хаадаг туршлагаас яагаад суралцаж болохгүй гэж. Зарим улс импортын зөвшөөрлийг дөрөв таван яамаараа дамжуулж байж олгодог. Хүнд суртлын босго тавьж байна гэсэн үг. Өөр нэг нь, хүнсэнд шууд хэрэглэх махыг долоон хувиас дээш өөхтэй бол хилээрээ оруулахгүй гэх мэтээр зүсийн хориг «бодож олох» аж. Үүнтэй ижил бид ч түүхий эдийнхээ экспортын лицензийн шат дамжлагаар хаалт зохицуулалт хийж болохгүй гэж үү. Түүнчлэн түүхий эдийг дотоодод бэлтгэх явцад нь өндөр татвар ногдуулж болох юм. «Цайз» захад арилжаа хийсний хөлсөнд сард арав хүрэхгүй мянган төгрөгийн татвар төлүүлэх нь өрсөлдөгчийг өөгшүүлсэн, давуу талыг нь бататгасан хэрэг бус уу. Ямааны зөвхөн арьс, ноолуурыг нь аваад махыг орхиж буй баримтаас ч санаа авах цаг болжээ.

Нэг хүнд ногдох хонь, ямааны махны жилийн хэрэглээ Хятадад үхэр, тугалынхаасаа их байдаг. Гэвч тэд манай бүх төрлийн малын махыг хилээрээ нэвтрүүлдэггүй. Импортоо нээлттэй болгох, худалдааны хязгаарлалтаа аажмаар цуцлах харилцан ойлголцлын санаамж бичигт гарын үсэг зурж, Дэлхийн худалдааны байгууллагын өмнө амлалт авсан, дэлхийн мах экспортлогч томоохон улсын нэг атлаа хятадууд хөрштэйгээ махны наймаа хийдэггүй. Өөрөөр хэлбэл, хоёр орны хоорондын арилжаа нэг талын сонирхлоор явагдаж байна. Нүдэнд үл үзэгдэх худалдааны дайн өнөөдөр дэлхийн зах зээл дээр өрнөж, улс орнууд хамгаалах төдийгүй довтлох бодлого хэрэгжүүлж байгаагийн жишээ нь дээрх юм. Өвөрмонголын мал махны үнийг манай илүү хямд, ижил бүтээгдэхүүнээс тэд хамгаалж байна. Ингэхдээ хэрэгцээ нь байгаа хэрнээ Монголд арилжааны таагүй нөхцөл тавьж махыг нь бус, түүхий эдийг нь сорчилсоор ирлээ.

Тэгвэл Хятадын талын өөр бусад сонирхолд бид «махаа дайж» чадах уу? Тус улсын зах зээлд хүчтэй дэлгэрч буй түргэн хоолны газруудын сүлжээнд мах нийлүүлэгчээр оролцохоор туршвал ирээдүйтэй бизнес байж болох юм. Ер нь манай эдийн засгийн сүл бүтцийг бэхжүүлэхэд төрөл бүрийн махны экспорт чухал үүрэгтэй. Ямааны мах Ойрхи Дорнодод эрэлттэй байдаг ажээ. Тухайлбал, Саудын Арабчууд хүнсэндээ хонь, ямааны махыг үхрийнхээс гурав дахин илүү хэрэглэдэг. Хаа холын зах зээл юм даа гэж санаа алдах хэрэггүй. «Халгай» шампунь Японд, хонины мах Йорданд, ноолууран бүтээгдэхүүн маань Европт хүрсэн шүү дээ. Харин одоо улам ахих, дэлхийн зах зээлд гүн нэвтэрч, баттай зогсохыг чармайх цаг болсон. Хүлээгээд, хөршдөө зууш болоод суух цаг биш ээ. Монгол Улс жилд 1.5 сая тонн ямааны мах экспортлох бололцоотой. Гэтэл 1995 оноос хойшх статистикт ямааны махны экспорт тэг үзүүлэлттэй байсаар. Эдийн засгийн хямралаас ангижирч буй Ази, мөн түүхий нефтийнхээ үнийн уналтыг зогсоосон Ойрхи Дорнодын хэрэглэгчид хэтэвчиндээ мөнгөтэй. Орлого нь нэмэгдэхийн хэрээр тэдний махны хэрэглээ өсдөг. Дээрх зах зээлд мах дорд бус, хэвийн бараанд тооцогддог. Эдгээр бүс нутгийн дийлэнх улсад мал өсгөн үржүүлэх бололцоо бага. Тэгэхээр байнгын найдвартай мах нийлүүлэгч тэдэнд хэрэгтэй. Монгол малын махыг голж шилэн, ариун цэвэр, стандартын шаардлага тулгах нь хөгжингүй орнуудыг бодвол энд гайгүй. Мөн дэлхийн худалдааны байгууллагад ихэнх нь элсэхээр чармайж, импортын татвар, хил худалдааны квотоо либералчилж байна. Зах зээлээ хамгаалах хэт нарийн хэрэгсэл бодож олоогүй байгаа худалдааны ийм таатай орчинд байнгын хэрэглэгчээ олж, дэлхийн наймаа худалдаанд оролцож эхлэх нь чухал юм. Түүнчлэн мөнх цэвдэгтэй нутагт нь мал өсгөх бололцоо тааруу, арав гаруй сая хэрэглэгчтэй Сибирь нь манай улсын уламжлалт зах зээл хэвээрээ байгаа. Гэвч Орос улсын санхүү, эдийн засгийн бэрхшээл болоод төлбөр нь шуурхай хийгдэхгүй байх, эсвэл Оросын Засгийн газар дотоодын

**Дэлхийн зах зээл дэх худалдааны дайнд оролцогчид нь хамгаалах, довтлох янз бүрийн тактик хэрэглэсээр, тэнд нүдэнд үл үзэгдэх тулаан өрнөсөөр байна. Харин энэ талбарт Монгол Улс шиг идэвхгүй үлдсэн нь бусдынхаа завшаан болж, түүхий эд нийлүүлэгч төдийхнөөр хочорч болзошгүйг санаж сэрэх цаг иржээ.**

мах үйлдвэрлэгчдээ хамгаалах бодлого барьж эхлэх, үгүй бол тус улсад барууны орнуудаас үзүүлдэг хүнсний тусламж манай малын махны зах зээлийг хумих зэрэг нөхцөл тулгарч болно. Иймээс зах зээлээ цааш тэлэхэд санаа тавих шаардлагатай болжээ.

Герман, Финлянд, Японы тоног төхөөрөмжөөр шинэчлэгдсэн манай мах боловсруулах үйлдвэрүүдэд экспортын бүтээгдэхүүнээрээ өрсөлдөх чадавх бий. Харин зах зээлээ нээж, гарч чадахгүй байгаа. Эхний алхмыг хэн хийх вэ? Хилийн чанад дахь Монгол Улсын худалдааны төлөөлөгчийн газар энэ алхамд чухал үүрэгтэй билээ. Манай худалдааны төлөөлөгчийн газар зөвхөн Сингапурт бий. Бусад улсын хувьд, Элчин сайдын яамны аппаратад нь худалдаа хариуцсан атташе, эсвэл гуравдугаар нарийн бичгийн дарга, зөвлөх зэрэг орон тоонд ажиллаж буй албан тушаалтан дээрх үүргийг гүйцэтгэдэг. Өнөөдөр тэдгээрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх цаг болжээ. Жишээ нь Сингапур улс нийт импортынхоо 98 хувийг татвараас чөлөөлдөг, махны эрэлт өндөр гэх мэт «ажиллаж» болох нөхцөл бидэнд харагдаж байна.

Дэлхийн зах зээл дэх худалдааны дайнд оролцогчид нь хамгаалах, довтлох янз бүрийн тактик хэрэглэсээр, тэнд нүдэнд үл үзэгдэх тулаан өрнөсөөр байна. Харин энэ талбарт Монгол Улс шиг идэвхгүй үлдсэн нь бусдынхаа завшаан болж, түүхий эд нийлүүлэгч төдийхнөөр хоцорч болзошгүйг санаж сэрэх цаг иржээ.

**2000 он**




# Царцаа-глобальчлалын бэлгэ тэмдэг

Дөчин тэрбум царцаа дээрээс чинь асгарсан гээд төсөөлнө үү. Үнэхээр ийм явдал 1986-1989 оны хооронд тохиолдсон билээ. Африкийн баруун эргээс Энэтхэг хүртэл энэ гурван жилд нийт дөчин тэрбум царцаа нисэн өнгөрчээ. Тэд 200 сая хүний хоол хүнс болох тариа ногоог залгисан гэж эрдэмтэд тооцсон юм. Харин нисдэг сүрэг Улаанбаатарын гудамжаар бэлчсэн хэдэн өдөр бид аюулыг нь нүдээр харлаа. Энэ «уулзалтаас» хэдхэн сарын өмнө Казахстан, тэр бүү хэл энүүхэн ойр Эрхүү мужийн тариан талбайг царцаанаас яаж аврах билээ гэлцэн оросууд шуугиж, телевизүүд нь уг асуудлыг дэлгэрэнгүй тайлбарлаж байлаа. Тэгэхэд мөнөөх царцаанууд өлгийтэй, нялх өт байв. Удалгүй өсч том болчихоод, Улаанбаатарын гуравдугаар хорооллынхныг автозамаар, машин тэрэгний араас халхавч хайн гэлдрэх хүртэл нь айлгав.

Тэгвэл тэртээ хол Техас мужийн фермерүүдэд царцаа бүр илүү зовлон тариад авчээ. Энэ хавар царцаан сүрэг тэнгэр бараантуулан Техас нутгийн тариалангийн талбайнуудыг довтолсон аж. Гучин жилийн тэртээ л ийм явдал тохиолдсон гэж фермерүүд дуу алдаж байлаа. Царцааны их нүүдэл хориос гучин жилийн давтамжтай дэлхийг нөмөрч байна. Сүүлийн үед энэхүү 20, 30 жилийн давтамж нь зарим бүс нутагт бүр ойр ойрхон илрэх болов. Нисдэг сүрэг арван жилийн зайтай айлчилж, идэх хоолноос маань салгаж байна хэмээн Африк тив, Арабын хойгийн улсууд гомдоллох боллоо.

Царцаа хэмээх англи үг араб хэлнээ салхин шүд гэсэн утгатай буудаг. Тэрбум тэрбумаараа тоологдох энэ муухай шүдний хөнөөлийг Библид хүртэл дурьджээ. Бурхны хилэн гэж эрт цагаас түүнийг нэрлэн, Египетийн долоон гай зовлонгийн нэгд оруулан эмээж ирсэн. 1986-1989 оны царцааны нүүдэлд африкчууд «хорьдугаар зууны хар үүл» гэсэн нэр хайрлажээ. Дөчин тэрбум царцаа мянган ам.километр талбайд гишгэх зайгүй чигжсэн гээд төсөөлөөч. Африкаас гадна Америк, Аргентин, Австрали, Индонез, Испани, Оросын тариан талбайд царцаа ихээхэн аюул тарьдгийг судлаачид өгүүлж байна. Дэлхийн байгаль орчин бохирдож, экологийн тэнцвэр алдагдах тусам ийм хар үүл ойр ойрхон нөмөрнө. Ингэхдээ шинэ нүүдэл 1989 оныхоос илүү хөнөөл тарина. Дараагийн идэвхжилийнх нь аюулд өнөөгийнхөөс олон хүн өртөх магадлалтай. Учир нь дэлхийн хүн ам жил ирэх тусам байгалийн тааламжтай, үржил шимт газраа бөөгнөрөн нягтарч байгаа гэж Тропикийн газар тариалангийн олон улсын хүрээлэнгийн мэргэжилтэн Юрген Лангволд Германы Д+С сэтгүүлд өгсөн ярилцлагадаа дурдсан байна.

Хаа холын Африкийн царцаанд юунд нь санаа зовоов хэмээн асуух гэж байна уу, Та? Царцаа, дэвхрэгийг устгах гэж асар их хэмжээгээр хэрэглэдэг хор нүүдлийн шувуугаар дамжаад Европ, Азид хүрдэг, мөнөөх шувуунаас хүмүүс өөрсдөө хордож эхэлсэн тухай тэгвэл дуулсан уу? Нэг дэлхийн хүмүүс ижил асуудалд орооцолдож буй нь энэ. Иймэрхүү асуудлууд өнөөдөр глобальчлал хэмээх үгийг байнга давтахад хүргэжээ. Гэхдээ бас даяаршиж буй ертөнцөд зарим жижиг улсад завшаан тохиолддог. Тэд даяарчлалаас далим хүртэн хөгжилд хүрэх, ядахдаа бэрхшээлийг хялбар давах боломж олдог гэсэн байр суурь бидэнд хамаатай. Нээрээ, дээр дурьдсан Тропикийн газар тариалангийн хүрээлэнд сайн чанарын шинэ хорыг амжилттай туршсан байна шүү. Өмнө нь хэрэглэж ирсэн хортой харьцуулахад хурдан үйлчилдэг гэнэ. Хөнөөлт царцаа дөрвөөс арав хоногт үхнэ. Харин бусад шавьж болон ургамалд шинэ хор аюул



**Царцаа**  
хэмээх англи үг  
араб хэлнээ  
салхин шүд  
гэсэн утгатай  
буудаг. Тэрбум  
тэрбумаараа  
тоологдох энэ  
муухай шүдний  
хөнөөлийг  
Библид хүртэл  
дурджээ.

тарьдаггүйгээрээ онцлог. Нэг гектар талбайн царцаа, дэвхрэгийг устгахад арваас бага доллар зарцуулна гэж тус хүрээлэнгийнхэн ярьж байна. Одоо уг хорыг өргөнөөр үйлдвэрлэх болж, олон орны фермерүүд сонирхож буй аж. Үлийн цагаан оготно, царцааны аюулын тухай сүүлийн хэдэн жил тасралтгүй ярьсан монголчууд ийм тодорхой асуудлаар олон улсын байгууллагаас дэмжлэг хүсч болохгүй гэж үү. Асуудлаа хамтран шийдэх явцад бол глобальчлал ач тустайг илтгэх нэг жишээ энэ байна.

Тэгвэл глобальчлалыг үзэн ядагчид чулуу мод атган жагсаж буйг хэрхэн тайлбарлах вэ? 1999 оны зул сарын баярын өмнөх Сизтл, дараа нь дөлгөөн тайван Швейцарийн Давост уур хилэнтэй хүмүүс бархиралдаж байлаа. Хамгийн сүүлд Генуяд глобальчлалыг эсэргүүцэгчид газар газраас цуглав. Даяарчлалыг дайсагнагчидтай тэмцэх гэсэн нэг шинэ арга ажиллагаанд цагдаагийнхан суралцах хэрэгтэй болох нь гэж Италийн цагдаа нар энд өгүүлж байв. Дэлхийн Сангийн сайдууд, топ эдийн засагчид дараагийн уулзалтаа элсэн цөлийн бараг төвд хийхээр шийдээд байна. Ирэх арваннэгдүгээр сард Катард нээгдэх уулзалтын эргэн тойронд дахин үймээн бүү дэгдээсэй, Арабын аагим халуунд эсэргүүцлийн омог ялимгүй дарагдаасай гэж тэд горьдсон юм болов уу даа. Глобальчлалаас хүртэх завшааны зэргэцээ бэрхшээл байгаа учраас хүмүүс зэвсэглэжээ. Цөөн жишээ татъя. Автомашин үйлдвэрлэлийн салбартаа гадаадын хөрөнгө оруулалтыг чөлөөтэй тавьж өгсөн энэтхэгчүүд хэдхэн жилийн өмнө бөөн баяртай сууцгаасан. Эх орны автомашин үйлдвэрлэл цөөн жилд даруй 136 хувиар өсчээ. Гэтэл байгаль орчин нь асар бохирдож, өвчин эмгэгийн үр дагавар тарьж байна. Ийм байхад хэн уурлахгүй суух билээ. Нөгөө даяарчлалын чинь үр дагавар энэ дээ. Бразильчууд бас л ууртай байна. Тэдний уурыг бага Буш хүргэлээ. Тэр Канадын Квебект хүрч очсоноор амгалан энэ нутгийн гудамжинд хараал зүхэл олонтаа сонсогдов. Хойд, төв, өмнөд Африкийн 34 орныг нэгтгэсэн чөлөөт худалдааны бүс /Европын холбоо лугаа/ бий болгох гэсэн эцэг Бушийн гэгээн мөрөөдлийг гүйцэлдүүлэхээр хүү нь чармайжээ. Тивийн дийлэнх улс дэмжээд буй уг санаачилга Бразилийн хувьд онцгой таагүй асуудал юм. Латин Америк орчимдоо эдийн засгийн хувьд хамгийн гайгүйд тооцогдох Бразил нь чөлөөт худалдааны бүсэд баян АНУ-тай өрсөлдөхөөс эмээж байна.

Одоо глобальчлалын үр дагаврыг өөрсдөдөө ойртуулан харъя. Хөрш Хятад капитализмыг хэсэг бусгаар хүлээн зөвшөөрөх болж, ирэх онд хуралдах Коммунист намынхаа их хурлаар зарим өөрчлөлтийг хийх бололтой. Тэд Дэлхийн худалдааны байгууллагад элсэхийн тулд Үндсэн хуулиа хүртэл зөөллөхөөр шийдлээ. Дэлхийн худалдааны байгууллагад Хятад нэгдсэнээр 20 мянган монгол иргэн ажилгүй болно. Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнээ Монголд үйлдвэрлэж, АНУ-ын зах зээлд нэвтрэх эрх олдог хятад эзэнтэй компаниудад албан ёсны тооцоогоор 20 мянган монгол ажилчин данстай. Хэрэв Хятад улс дэлхийн худалдаанд чөлөөтэй оролцох гарцтай болбол эдгээр үйлдвэр заавал манайд үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын төсөвт татвар, нийгмийн даатгалын шимтгэл хураалгаж суух шаардлагагүй болох юм. Дэлхийн худалдааны байгууллагад Хятад улс элссэний дараахь гол үр дагавар нь энэхэн зүйл биш билээ. Хятадууд даяарчлалын давллагаанд татагдан орсноор АНУ-ын зах зээл дээр асар хүчтэй өрсөлдөгч гарч ирнэ. Азийн олон орны үйлдвэрлэгчид яг энэ тэнцвэргүй өрсөлдөөнөөс өнөөдөр эмээж байна. Хөгжиж буй улсууд зөвхөн 1999 онд 885 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнээ баян орнуудын дэлгүүрт зарж ашиг олсон. /НҮБ-ын судалгаанаас иш татав/ Made in Indonesia, Made in Mongolia, Made in Philippine шонготой хувцас Америкийн томхон дэлгүүрүүдэд алхам тутамд таааралддаг билээ. Эдгээр нь мөдхөн Made in China шонго бүхий барааны түрэмгий урсгалд шахагдах аюул тулгараад байна. Товчоор хэлбэл, глобальчлалыг эсэргүүцэгчид хүч тэнцвэргүй

өрсөлдөөнөөс болгоомжилсондоо тийнхүү жагсч буй юм.

Одоо бидэнд өөрсдийн зохион байгуулагч, үйлдвэрлэгч-эзэн хэрэгтэй. Яагаад гэвэл монголчууд өөрсдөө өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэх дадалтай. Гагцхүү, өрсөлдөх бүтээгдэхүүн хийх ажлыг зохион байгуулах үндэсний сайн менежмент дутагдаж байна гэж Сангийн сайд асан Д.Даваасамбуу ярьсан юм. Өрсөлдөөнд бэлтгэх цаг иржээ. Энэ нь Улсын их дэлгүүрт бус, «Нарантуул»-д биш дэлхийн зах дээр, баян орны зах зээлд өрнөнө. Глобальчлалаас зугтах газаргүй. Өрсөлдөөнд хөл тавин орох ганц зам бий. Өрсөлдөхийн тулд бид өнөөдөр юу хийж эхлэх ёстой вэ? Үгээ хэлээч. Санал солилцъё.

**2001 он**

# Ямаачин гадилд дургүй

«Эдийн засгийн дайнаа зогсоо. Дэлхийн худалдааны байгууллага тонил!» хэмээн тэд дуу нийлүүлэн орилно. Арваад хүн элдэв сүржин бичиг бүхий пайз барьжээ. Өнгөрсөн сарын 26-ны лхагва гаригийн үд дундын алдад Дэлхийн худалдааны байгууллагын төв байрны өмнө нэг иймэрхүү дүр зураг харгадсан билээ. Женев нуурын налгар эрэг зуур Дэлхийн худалдааны төвийн бор саарал байшинг босгохдоо амгалан орчныг сонгосон нь тэр байлгүй. Гэвч энд «Зогс, боль, тонил цаашаа» гэсэн үгс байнга сонсогдоно.

Сиэтл, Генуя, Доха хотод олон улсын худалдаа, санхүүгийн байгууллагуудыг харааж зүхсэн хүмүүс жагсаад, солиотой мэт ашилж байсныг бид телевизээр харсан. ДХБ-аас хоёр жил тутам зохион байгуулдаг Худалдааны сайд нарын уулзалт болох үеэр зарим хүний цусны даралт өгсдөгийн учир юу билээ? Швейцарийн Женев хотод 500 гаруй ажилтантай ийм төв найман жилийн өмнө бий болсон нь хэний уурыг хүргээд байгаа юм?

НҮБ болон түүний салбар байгууллагуудыг бодвол харуул хамгаалалт харьцангуй сул харагдах үүдээр нь яваад орлоо. Хажууд маань «China Daily» сонины Зао Хуанхин, Данийн радио, телевизийн корпорацын Берит Андерсен, Египетийн «Саго» сонины Эссам Рефа Ат гэхчлэн арав орчим сэтгүүлч явна.

«Эвслийн цэрэг Иракт халдсан явдал дэлхийн худалдаанд ямар нөлөө үзүүлэх вэ? Мексикийн Канкун хотноо есдүгээр сард нээгдэх Худалдааны сайд нарын ээлжит хурал Сиэтлийнх шиг дампуурал болох уу?» зэрэг асуултаар мөнөөх сэтгүүлчид ДХБ-ын Ерөнхий захирлыг мэндийн зөрүүгүй угтав. Тавь эргэм насны тайланд эр асуулт болгонд албархуу хариу барьсан ч сурвалжлагч бидэнд энд тавтай саатан, өөрийнх нь толгойлдог газрын үйл ажиллагаатай сайн танилцаад авахыг зөвлөлөө. Бодвол гадаа хашгиралдаад байгаа хүмүүс, энд өрнөх түм буман хурал, хэлцлийн хооронд хэвлэлийнхэн л ойлголцол бий болгож чадна хэмээн найдсан биз. Энгийн үгээр илэрхийлбэл, Монголын ноолуур, Тринидад Табогогийн гадил, Америк тахиа, Филиппиний тюнь загас, Колумбын цэцэгний тухай энэ байшинд цугласан эрхмүүд ярилцдаг юм. Гэхдээ зүгээр нэг сайхан ярилцах боломжгүйг дээр өгүүлсэн эсэргүүцлийн дуу хоолой төдийгүй хурал цуглаан дээр төлөөлөгчид санал зөрөлдөх үед ажиглаж болно. Монголын ямаачид өмнөд Америкийн гадил экспортлогчдод дургүй гэх мэтийн жишээнээс учрыг нь хайя. Африкт боловсорсон гадил жимсийг европчууд сонирхож, түүнд нь дургүйцсэн Америк өөрийн өмнөд хөршүүдээ өмгөөлсөн түүхийг бид мартаагүй. АНУ тунирхаад зах зээлээ хааж эхэлмэгц, Европд сүлжсэн ноолууран эдлэл худалдан авагчаар хомсдож гарна. Шидлийн гадилаас болж Монголын ямаачин гэр бүлийн төсөв хумигдаж байх юм.

Шидлийн  
гадилаас  
болж  
Монголын  
ямаачин гэр  
бүлийн  
төсөв  
хумигдаж  
байх юм.



Худалдааны ийм дайныг хэн нэгэн зохицуулах л хэрэгтэй. Тиймээс ч Женев хотын төвд том барилга барьж, 145 улс ДХБ-д элсээд, «зангиатай» төлөөлөгчдөө суулгажээ. Монгол Улсаас ДХБ-ын дэргэд суугаа «зангиатай» төлөөлөгчийг В.Энхболд гэдэг. Тэр гуравдугаар сарын турш зав муутай явсан байх. Мөн хугацаанд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт, импорт эрхэлдэг дэлхийн бүх улс Женевийн зүг анхаарал хандуулсан юм. 2001 онд Катар улсын Доха хотноо орон орны Худалдааны сайд нар цуглах үед батламжилсан тунхаглалын дагуу хэлэлцээр ид явагдаж байлаа.

Амгалан Женевийн дэгжин хүүхнүүд хөнгөн шаахайгаа өмссөн гуравдугаар сарын сүүлийн долоо хоногт очиж сурвалжилсан ДХБ-ын өрөө тасалгаагаар хамт шагайя.

## ТҮҮХ ИНГЭЖ ЭХЭЛЖЭЭ

Англи сайн чанарын улаан буудайтай. Харин Португал амтат дарс хийдэг. Тэгвэл хоорондоо солилцож яагаад болохгүй гэж. Дэлхийн худалдааны түүх ингэж эхэлсэн юм. Өнөөдөр жилд нэг триллион ам.долларын худалдааг хорвоогийн улс орнууд өөр зуураа хийж байна. Монголд энэ тооны өчүүхэн хэсэг буюу нэг тэрбум доллар ногддог. «Бид нэг их арилжаа наймаа хийх биш. Ноолуураас өөр зарах юутай билээ. ДХБ-д гишүүн байлаа гээд дэмий татвар төлж нэр зүүхээс цаашгүй юм биш үү» хэмээх түгээмэл ойлголтод тайлбар өгөхийг Монголоос Швейцарийн холбооны улсад суугаа Элчин сайд бөгөөд Байнгын төлөөлөгч Х.Бэхбатаас хэрэг болгон хүслээ.

-Энэ бол үнэхээр өрөөсгөл ойлголт. Худалдаа наймаа хийдэггүй орон гэж алга. Манайх олон улсын худалдаанд өөрийн жин хэмжээгээрээ л оролцож явна. Нэгэнт ийм субъект болсны хувьд худалдааг ямар зарчмаар, юуны үндсэн дээр явуулах вэ хэмээн хэлэлцэж, булаалдаж байгаа үед ямар нэг хэмжээгээр хошуу дүрэн оролцож л явах ёстой. Өөрөө нөлөөлөөд байх явдал үгүй ч яриа хэлцэл ийм чиглэлээр өрнөн, тэгж тогтож байна, бидэнд нийцнэ, нийцэхгүй хэмээн тодорхойлох шаардлага бий.

**-Яг одоо энд өрнөж буй хөдөө аж ахуйн хэлэлцээрт манайх хэрхэн оролцож байна вэ?**

-Бид ихэнх чиглэлээр ажиглах байр суурьтай байна. Манайх хөдөө аж ахуйн орны хувьд, тэгэх тусмаа мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд гадаад худалдаанд маань зонхилох байр эзэлж буй үед уг хэлэлцээр чухал юм. Дэлхий дахинаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний арилжаа наймааг ямар хэм хэмжээнд хийх учиртайг бид харж, ярилцаж явах хэрэгтэй.

Жишээ нь, Хятад улс ДХБ-ын гишүүн болсон. Орос элсэхээр ярьж байна. Тэгэхээр хоёр хөршдөө мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нийлүүлэхэд баримтлах суурь зарчим, хэм хэмжээг олон улсын байгууллагын хүрээнд тохиролцоно гэсэн үг. Нэгэнт энд тохирсон сунадаг хязгаарын хүрээнд (гаалийн тарифын дээд хэмжээг зааж өгсөн) тогтсон хэмжээнээс илүүг хөршүүд маань манайхаас шаардаж чадахгүй болчихно.

**-Ирэх есдүгээр сард Мексикийн Канкун хотноо нээгдэх уулзалтаас Ч.Ганзориг сайд улс орондоо ашигтай ямар үр дүн авч ирэх боломжтой вэ?**

-Ийм тодорхой юмтай ирнэ, ингэвэл амжилттай болно хэмээн одоо хэлэхэд хэцүү. Гол нь манайх улс төрийн зорилготой очих ёстой. 2001 онд Доха хотноо болсон дэлхийн Худалдааны сайд нарын өмнөх уулзалтын үеэр өгсөн амлалтуудыг аль болох тодорхой болгох чиглэлээр хөгжиж буй орнуудтай хамтран ажиллана гэсэн үг л дээ. Тэр амлалт нь юу байсан юм бэ? Буурай хөгжилтэй улсуудыг дэмжинэ, худалдаа хийхэд нь хөнгөлөлт үзүүлнэ гэсэн санаа улс төрийн утгаараа нэгэнт илэрхийлэгдчихээд байгаа.

Хөгжлийн хөдөлгүүр гэгддэг дэлхийн худалдаа нь өнөөг болтол баян орнуудад түлхүү үйлчилж ирлээ. Одоо хөгжил доройгоо өөд татах явцад арилжаа наймааг хэрхэн ашиглах вэ гэдэг дээр Канкун хотноо илүү анхаарал хандуулна гэсэн үг хэмээн тэрбээр өгүүлэв.

Улаан буудайг дарсаар солилцсон түүх эдүгээ хорвоо ертөнцийг хамарсан наймаа, түүнийг тойрсон олон асуудлыг нэгтгээд байна. Гурван сая хүнтэй Шинэ Зеланд улс 40 сая хонио яах билээ? Европчууд бяслаг, гахайн мах, шар айргаа, Азийнхан цагаан будаа, жимс ногоогоо хил давуулан худалдах хүсэлтэй. Ингэхдээ болж өгвөл гаалийн татвар, тарифын бус саад дарамттай аль болох бага тулгарахыг эрмэлзэнэ. ДХБ 1995 онд үндэслэгдэхээс бүр өмнө, ГАТТ-ын хэлэлцээрт анх нэгдсэн хорвоогийн хамгийн их наймаачин цөөн гүрэн өнөөдөр ч давуу талаа хадгалах гэж чармайдаг.

Улаан  
буудайг дарсаар  
солилцсон түүх  
эдүгээ хорвоо  
ертөнцийг  
хамарсан  
наймаа, түүнийг  
тойрсон олон  
асуудлыг  
нэгтгээд байна.



Фотог Л.Багбаяр

**Женев нуурын налгар эрэг зуур Дэлхийн худалдааны төвийн бор саарал байшинг босгохдоо амгалан орчныг сонгосон нь тэр байлгүй.**

---

«Гадаа болж буй жагсаал энэ тэр чинь ДХБ-ын шийдвэрт тун бага нөлөө үзүүлдэг юм. Энд АНУ ба Европын холбоо гэсэн хоёр том худалдааны өрсөлдөгчийн дунд л гол маргаан өрнөдөг» гэж Эбертийн сангийн Женев дэх төвийн захирал Адам Эрфрэд ярьж байна. Зөвхөн Европын холбоо гэхэд жилд 60 тэрбум ам.долларын, АНУ 20 тэрбум ам.долларын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортолж, дээр нь дотоодын зах зээлээ хамгаалж хумьдаг. Тэд нутгийн фермерүүдээ хамгаалан элдэв татаас олгон зальдана. Дэлхийн хамгийн том зах зээлд нэвтрэх гэж жижиг улсууд ч амь наана там цаана зүтгэх аж. Колумбын цэцэгчид бүтээгдэхүүнээ баян Америкт хямд нийлүүлэхээр чармайна. Энэ мэт маш хямд үнээр зах зээлд нь түрэн орж ирдэг 260 нэр төрлийн бүтээгдэхүүнээс залхсан америкчууд эдүгээ Дэмпингийн эсрэг (барааг үндэслэлгүй дэндүү хямд үнээр экспортлох явдал)



үндэсний арга хэмжээ авч, ДХБ-д байсхийгээд л гомдол гаргадаг болжээ. Тус байгууллагын гишүүн 145 орноос хэн нь хэдэн удаа гомдол зарга мэдүүлж, шийдвэрлүүлснийг Хэвлэлийн төлөөлөгч Кэйт Роквэлл бидэнд танилцуулаа.

-Иймэрхүү гомдол гаргах явдал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн. Зөвхөн АНУ 2002 оны эхний хагаст 16 удаа Дэмпингийн эсрэг, Европын холбоо 14 удаа мөн үндэслэлээр гомдол гаргажээ. 1995-2001 онд нийт 1642 ийм тохиолдлыг ДХБ шалгаж тодруулсан гэв. Өөрөөр хэлбэл энэ байшин дотор 145 хүүхэдтэй анги хичээллэж, олон маргаан дээр тохиролцох гэж өдөр бүр сунжиртал хуралддаг.

## 2015 ОНД ЮУ БОЛНО ГЭВ ЭЭ?

Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүнээ дэлхийн улсууд бие биедээ татваргүй худалдана гэнэ. Үүний тулд 2010 онд гаалийн тарифаа бүгдээрээ найман хувь хүртэл бууруулсан байх учиртай. Ийм буултыг мөнөөх Катарын Доха хотноо баян орнууд буурайдаа зарчмын хувьд зөвшөөрсөн. 1999 оны Сиэтлийн уулзалтын тухай сурвалжлагыг телевизийн дэлгэцээс харсан хүн бол ийм буулт хийхээс аргагүй болсныг нь ойлгоно байх аа. Тэнд ДХБ дахь их, багын ялгааг эсэргүүцэгчид гудамжинд галзуу мэт авирлаж, хурлын дотоод уур амьсгал ч нэг шийдэлд хүрэх аргагүй болтлоо хурцалсан билээ. Түүхнээ энэ уулзалт «дампуурсан» тодотголтой үлдсэн юм.

Гэхдээ өнөөдөр ч Америк, Европын холбооны улсууд, Канад зэрэг нь оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн авах квотоо өөрчлөх хүсэлгүй байгааг ДХБ-ын төв байранд өрнөсөн олон уулзалтын уур амьсгалаас мэдэрлээ. Мөнөөх тэглэх амлалт 2015 он гэхэд биелэх нь юу л бол.

## ХЯТАД, МОНГОЛ ХОЁР «ЭН ТЭНЦҮҮ»

Том, жижиг хоёр улс адилхан «хөгжиж буй» хэмээх ангилалд багтсан харагдана. Монгол ДХБ-д түрүүлж төвөггүй элсээд, харин Хятад 15 жил оролдож байж гишүүн нь болжээ. Хөөрхий оросууд яасан бэ? Тэд худалдааны байгууллагын гишүүн болох эрхээ энэ намар Канкунд олж авна хэмээн найдаж байгаа гэнэ. Яг энэ өдрүүдэд ДХБ-д ОХУ-ыг гишүүнээр элсүүлэх яриа хэлэлцээний ээлжит үе шат эхэлж байгаа.

Ертөнцийн худалдаанд тэртээ тэргүй том байр суурь эзэлсэн Орос улс гишүүнээр элсэхийн тулд үр тариа экспортлогч Канадтай, дор хаяад л тахианы махнаас болж Америктай, дараа нь махны чиглэлээр Австралитай гэхчлэн толгой дараалан тохиролцож, үүрэг амлалт авах учиртай. Үүнтэй ижил хувь заяанд Вьетнам улс цагаан будаанаасаа болоод орооцолдчихжээ. Ер нь гишүүн болохыг хүссэн 27 улс эгнэсэн байна. Тэдний дунд Ирак ч бий.

Хэдийгээр Хятад ДХБ-д нэгдсэн ч манайд үүнээс нөлөөлөх ашиг тус нь их бус мэт санагдав. Тус улс өнгөрсөн оноос эхлэн таван жилийн хугацаанд гаалийн татвараа буулгаж эхэлсэн боловч манай гол экспорт болох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд тэр нь 15 хувь буюу ялимгүй доошилсон үзүүлэлт юм.

## ДЭЛХИЙН ХУДАЛДАА БА ДАЙНЫ УТАА

Аэрофлот компанийн онгоцоор Улаанбаатараас гуравдугаар сарын 22-ны өглөө ниссэн билээ. Хаа сайгүй дайны тухай мэдээлэл сонсч, сонин гарчиглаж эхэлсэн үе. Хүмүүс онгоцоор аялахыг амь насанд эрсдэлтэйд тооцож, ялангуяа United AirLines, American AirLines, Delta компанийн хөлгөөр зорчих захиалга их хэмжээгээр буцаж буй тухай мэдээлсэн харагдана. «Харин манай Аэрофлотын тасалбар эрэлттэй байгаа» хэмээн «The Moscow Times» сонин

ДХБ дахь их,  
багын ялгааг  
эсэргүүцэгчид  
гудамжинд галзуу  
мэт авирлаж,  
хурлын дотоод  
уур амьсгал ч нэг  
шийдэлд хүрэх  
аргагүй болтлоо  
хурцалсан билээ.  
Түүхнээ энэ  
уулзалт  
«дампуурсан»  
тодотголтой  
үлдсэн юм.

гуравдугаар сарын 21-ний дугаартаа бичжээ.

Дайн дэлхийн худалдаанд урьдчилан таамаглахад бэрх өөрчлөлтүүдийг зөгнөөд байна. Нэг триллионы багтаамжтай худалдааны нийт орлогын тал хувь нь үйлчилгээний салбараас орж ирдэг агаад агаарын тээвэр, аялал жуулчлал, даатгалынхан алдагдалд унавал дээрх үзүүлэлт энэ оны хувьд огцом өөрчлөгдөх нь лавтай.

Оросын Аялал жуулчлалын холбооны хэвлэлийн төлөөлөгч Ирина Тюринагийн мэдэгдсэнээр, Египет, Арабын Эмират руу аялахыг хүссэн олон хүн захиалгаа цуцалж орхисон гэнэ. «The Herald Tribune» сонин «Англи улс Персийн буланд байгаа 45 мянган хүнтэй цэргийн хүчээ санхүүжүүлэх хэрэгтэй. Дээр нь жуулчлал, агаарын тээврийн компаниуд алдагдалд орох нь тодорхой боллоо» хэмээн түгшжээ. АНУ-ын цэрэг дайны зардал 90 тэрбум ам.доллар давсныг дэлхийн хэвлэлүүд дуу алдан мэдээлэв. Эдгээр цифрийг дагаад худалдааны том зах зээлүүд хумигдаж, наймааны эргэлт ч удаашрах нь мэдээж. Бас дайн болсон биш баярлах хүмүүс ч бий. Жишээ нь Орос улс арвин үр тарианаасаа Иракийн ард иргэдийн хүнсний хэрэгцээнд нийлүүлнэ хэмээн найдаж сууна.

Персийн буланд бөмбөг тэсэрч, Арабын ертөнц хилэгнэсэн өдрүүдэд Женевт нарцисс дэлбээлээд, уушийн газрын гадаа нар бараадан суусан швейцарчууд дарс амтлан хөгжим сонсч үдшийг угтах ажээ. Эдийн засгийн гинжин хамаарал энд, мөнх цаст Монблан уулын бэлд хараахан мэдрэгдээгүй байгаа болохоор ямар нэг зүйл хүлээж л суугаа мэт сонин сэтгэгдэл төрж билээ. Иракт хийж буй дайн худалдаанд хэрхэн нөлөөлөх вэ гэсэн асуултад Элчин сайд Х.Бэхбат ийн хариулав.

-Дэлхийн худалдаанд богино хугацаанд сөргөөр нөлөөлнө. Хүмүүс хөрөнгө оруулахаа азнана шүү дээ. Азнана гэдэг чинь цаг хугацааны явдал. Ханш тогтворгүй болоод, нефтийн үнэ өсөхөөр урьд өмнө тохиролцсон өгч авалцах бүх хэлцэл, тооцоонд нөлөөлнө гэж тэр өгүүлж байна. Есдүгээр сард Канкунд эхлэх Худалдааны сайд нарын тавдугаар уулзалтын үеэр том гүрнүүд Дохад хоёр жилийн өмнө сайхан аашилсан шигээ нааштай үг хэлэхгүй л болов уу хэмээн манай Элчин сайдын яамны гуравдугаар нарийн бичгийн дарга В.Энхболд ярилаа. Баян орнууд амлалтаасаа буцах улс төрийн хангалттай шалтгийг энэ дайны утаа бэлдэж өглөө хэмээн «Washington Times» сонины ДХБ дахь сурвалжлагч гуравдугаар сарын 25-ны дугаартаа бичжээ.

Буцах өдөр болж Lufthansa компанийн агаарын хөлөгт суулаа. Женевт ердөө долоо хоногсон билээ. Гэтэл энэ зуур дэлхийн авиа компаниудын зорчигч тээврийн хэмжээ өнгөрсөн жилийнхээсээ арван хувиар доошилсон болохыг «USA Today» сонины гуравдугаар сарын 28-ны дугаараас үзэв. Айсуй 2-3 сарын онгоцны тасалбарын захиалга бүр дэндүү буюу 40 хувиар уначихсан гэнэ.

Харин Монголд маань сонгины үнэ нэмэгдэж, ноолуурын ганц том үйлдвэрийн хувьцааг хэн ч сонирхохгүй байгаа тухай сонин угтав. Хятадууд манайд зарах сонгиноо багасгаж, ямаачид гадил төдийгүй дайныг зүхэж суугаа бололтой.

# «Чимээгүй» мөнгөний эзэд хэн бэ?

Ерөнхий сайд худал ярьж байна. Тэр, эдийн засгийн өсөлт 3.7 хувьтай байгаа хэмээн ташаарав. Дараа нь Сангийн сайд залав. Тэд залж буйгаа мэдэж байгаа нь дамжиггүй. Гэвч нэгэнт гарсан статистикийн дүнг албан ёсоор зарлах л учиртай юм хойно. Эрх барих дөрвөн жилийн хугацаандаа эдийн засгийн өсөлтийг зургаан хувьд хүргэнэ хэмээн Хувьсгалт нам 2000 онд амлажээ. Ирэх сонгуульд өрсөлдөх намууд мэдээж үүнээс давсан тоо зарлана. Гэвч Монголын улстөрчдийн амнаас гарч буй энэ цифр юуг өгүүлдэг, хэр бодитой үзүүлэлт юм бэ? Монгол Улс эдийн засгийн өсөлтийн дүнгээ худал зарласаар хэдэн жил болсон бэ? Үнэн, худлын зөрүү ямар байгааг топ банкирын үгээр дамжуулья.

-Дотоодын нийт бүтээгдэхүүн 3.7 хувиар өнгөрсөн жил өссөн гэдэг албан ёсны статистикийн тоо учраас бүгд түүнийг хүлээн зөвшөөрөх байх. Би өөрөө банк санхүүгийн хүн болохоор бизнесийн үйл ажиллагаа, хандлагыг байнга ажигладаг. Арилжааны банкуудын балансаар дамжуулан харвал манай эдийн засгийн өсөлт арваас доошгүй хувьтай байгаа. 3.7 гэдэг бодитой тоо биш.

Ганцхан жишээ татъя. 2000 оны наймдугаар сард манай эдийн засгийг хөдөлгөж байгаа зээл буюу эргэлтийн хөрөнгө ердөө 58 тэрбум төгрөг байлаа. Тэгвэл өнөөдөр энэ тоо бараг дөрөв дахин өсч 220 тэрбум болсон. Дурдсан онд Монголд нийт мөнгө 240 тэрбум төгрөг байсан. Одоо түүнээс хоёр илүү дахин буюу 540 тэрбум орчим боллоо. Хоёр дахин нэмэгдсэн хөрөнгөөр чинь мөн л хэмжээнд өссөн бүтээгдэхүүн хийнэ биз дээ? Тэгэхээр манай эдийн засгийн өсөлт 3.7 хувь байнаа гэдэг нь худлаа. Бусад улсыг хараад байхад нийт мөнгө, ялангуяа зээлийн хэмжээ нэмэгдсэн үед дотоодын нийт бүтээгдэхүүн нь заавал томоохон өсөлттэй явдаг. Харин манайд статистикийн бүх талын мэдээллийг авч чаддаггүй учраас ийм худал тоо гарч байгаа юм. Ялангуяа далд эдийн засгийн тоо баримтыг бүрэн тусгахгүй байгаа болохоор тэр. Жишээ нь, үнээгээ саагаад бүтэн жил гэр бүлийн хэрэгцээгээ хангаад яваа малчин айлын үйлдвэрлэлийн дүн статистикт тусгахгүй л байгаа шүү дээ. Гэтэл мянга мянган айл өрх энэ мэтээр амьжиргаагаа залгуулдаг. Тэр нь сүүний нийт үйлдвэрлэлийн үзүүлэлтэд тусдаггүй. 1990 онтой харьцуулахад манай сүүний үйлдвэрлэл бараг 20 дахин буурсан дүн статистикийн мэдээнээс харагдаад байдаг. Тэгэхээр бид мэдээллээ буруу авч байна хэмээн Монголбанкны ерөнхийлөгч О.Чулуунбат ярив.

Өөрөөр хэлбэл Засгийн газарт захирагддаггүй мөнгө чимээгүй урсч байна. Түүнийг далд эдийн засгийн ноёдууд үзэмжээрээ залуурддаг. Халаасандаа хөрөнгөтэй учраас далд бизнесийнхэн өөрсдийн дүрмээр тоглож чадна. Засгийн газрууд хэчнээн хууль дүрмээр далайлгасан ч авсан арга хэмжээ, алхам бүр нь хаа нэгтээ саармагжиж хүчээ алдаж байна. Харин яг хаана тэр вэ? Хэн бэ, тэр «чимээгүй» мөнгөний эзэд? Эхлээд тэднийг ангилж, ялгаж салган харахыг оролдъя.

О.Чулуунбатын жишээндээ татсан жижиг бизнесийн гэм хоргүй төлөөлөгчид далд эдийн засгийн зузаан хөшигний цаана бий. Тэд ажилч шоргоолж шиг бужигналдаж, аж амьдралаа харсаар байтал өөд нь татаж явна. Харин хэтэвчтэй хэдээ тун сайн нуужээ. Муу зүйл биш ч юм шиг. Олиггүй нь тэд «татвар» гэсэн үг сонсоод зугаатай инээлдэж мэднэ. Гуталчин, зурагчин, үсчин, наймаачин бүгдээрээ л орлого тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхэлдэг ангилалд багтаж татварын байцаагчид сард хэдхэн төгрөг хураалгана. Ломбардууд санхүүгийн эх үүсвэрээ хаанаас олоод байна вэ? Тэдний өгсөн зээлийн дүн арилжааны банкуудын олгосон зээлээс ч их болов. Багсайсан төгрөгүүдээс эхүүн

үнэр ханхийх боловч чухам хэдийг атгачихсаныг нь тооцох арга байх биш.

Тэдэнтэй харьцуулахад хилийн чанадаас «хүрэлцэн» ирдэг долларыг хэтэвчиндээ хийхэд урамтай, цэвэрхээн. Гэвч мөн л хэн нь ар гэрийнхэндээ хэдэн төгрөг илгээснийг Санхүү, эдийн засгийн сайдад тайлагнах хэрэг алга. Жишээ нь, БНСУ-д ажиллаж буй 16 мянган монгол иргэн жилдээ лав 50-70 мянган доллар нутгийн зүг явуулдаг хэмээн «хараар» тооцоолж байна. Эд бүгд далд эдийн засгийн өргөн фронтод нэгдээд албан ёсны статистикийн хажуугаар харайна. Гадагшаа ажил албаар явсан хүмүүсийн олонх нутаг буцахдаа бэлэн мөнгөний «дайвар» авч, шуудан зөөгч хийх болжээ. Надад ч ийм явдал тохиолддог. Өөр бусад нь ч ар гэртээ хэн нэгний илгээсэн долларыг тээж яваа.

Мөнгө чимээгүй урссаар. Далд капитал хуримтлагдсаар өдрөөс өдөрт булчин нэмэн хүчирхэгжиж байна. Мөдхөн Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн ерөнхий даамал нар бус, харин үл үзэгдэх гар манай эдийн засгийг зохицуулах юм биш биз. Мөнөөх булчинлаг гар үйлдвэрлэж, бүтээж, айл өрхийг тэжээж явна. Цуцтал ажилласны хүчинд багсайтал нь мөнгө хураагаад, түүнээ цааш нь, бүр цааш нь далдлах болов. Хилийн чанадад ажилладаг монголчуудын өрхийн төсөвтөө нэмэрлэхээр өнөөдөр илгээж буй хөрөнгө хэдхэн жилийн хойно чиглэлээ өөрчилж, гадаадад капитал болон хуримтлагдвал гайхах зүйлгүй. Энэ бол хүсүүштэй хандлага яав ч биш.

Эдийн засаг олигтой өсдөггүй, яасан заяа нь орхисон юм гэж зөвхөн тоонд итгэдэг шинжээчид зүхэх байх. Ашиг орлого сайтай дажгүй яваа бизнес бүр тэр тооцоонд хамрагдсангүй дээ. Олсон ашгаасаа татварт хураалгах гэж хэн зарлаж хашгираад явах вэ. Далд эдийн засгийн зузаан хөшигний цаана ажиллагсад эрсдэл ихтэй амьдардаг боловч ил явснаас илүү орлого хуримтлуулж байна. Тэднийг эхлээд өндөр татвар айлгаж хөшигний цаад руу түлхсэн юм.

«Татвар ногдуулах эрх мэдэл хэтэрвэл сүйтгэх хүчин болно» хэмээн АНУ-ын нэртэй хуульчдын нэг тэртээ өдрүүдэд хэлжээ. Татварын дарамт өндөр, урамшил амладаггүй, өг гэж нэхэхээс цаашгүй орчинд далд эдийн засгийн хаалт улам зузаарах нь лавтай. «Бид чанга дуугаар ярихгүй байгаа болохоос татварын реформ хийж чадсан» хэмээн Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нэгэнтээ ярьсан нь санагдана. Тэр шинэтгэл хэрэв далайцтай алхам болж чадсансан бол өнөөдөр сүүдэрт нуусан их хөрөнгийн зах зухаас ил гарах л байлаа. Хөшигний цаана өрнөж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг ил гаргах талаар үе үеийн Засгийн газрууд юу хийсэн юм бол? «Касны машин нэвтрүүлэх гэж оролдсон удаатай» гэж л битгий дурсаарай. Тун олон жил ийм машины тухай яриа сонсч билээ.

Бүгдээрээ сайн сайхан амьдрахын тулд ямар нэг зүйл хийж бүтээж байна. Тэр бүтээлч армийг нэгтгэсэн өргөн суурь баазаас бага хэмжээний татвар авах гэж манай төр, засаг санаачилж, далайцтай ажилласан удаа тун ховор.

Монголчууд үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ хэмжээг хэд дахин буруу тооцож, хөгжлийн хурдаа бодитой багцаалах чадваргүй болжээ. Далд хүч зохицуулалтаас гарах тусам үндэсний эдийн засаг аюулд ойртож байна. Аюулыг бид өөр олон зүйлээс хардаг. Харин сүүдэр бараадсан элдэв бизнесээс одоохондоо эмээсэн зүйлгүй амьдарч яваа.

Далд эдийн засгийн фронтын эхний хэсэгт эгнэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийнхнийг илрүүлж татвар хураах бололцоо төрд бий. Харин хоёр дахь хэсэг буюу хууль бус бизнес эрхэлж хүчээ авсан, эдийн засагт нөлөөлж чадахуйц байр сууриа эзэлсэн бүлэглэлүүдийн үйл ажиллагаанд Монгол Улсын аль ч Засгийн газар нэвтэрч чадаагүй, ингэхийг зориглоогүй билээ. Улстөрчдийн олонх нь бизнесийн ийм хэсгүүдтэй нэгэнт талцан орооцолдчихоод байна.

Үл үзэгдэх гарууд дотоодын нийт бүтээгдэхүүний гуравны нэгээс илүүг үйлдвэрлэж, ашгаа цааш нь, бүр далд нууж байвал улс орон Ерөнхий сайдаар ч

Үл үзэгдэх гарууд дотоодын нийт бүтээгдэхүүний гуравны нэгээс илүүг үйлдвэрлэж, ашгаа цааш нь, бүр далд нууж байвал улс орон Ерөнхий сайдаар ч яах юм? Засгийн газар, хууль тогтоогчдын гаргасан хэчнээн ч шийдвэр ийм нөхцөлд хэрэгжихгүй. Нөгөө чимээгүй гар бүгдийг өөрийнхөөрөө зохицуулж орхино.

яах юм? Засгийн газар, хууль тогтоогчдын гаргасан хэчнээн ч шийдвэр ийм нөхцөлд хэрэгжихгүй. Нөгөө чимээгүй гар бүгдийг өөрийнхөөрөө зохицуулж орхино.

«Далд эдийн засаг аль нэг улсын чадавхийг бууруулаад зогсохгүй, тэрээр өнөөдөр улам бүр хүчээ авч, эрүүгийн шинж чанар нь нэмэгдсээр байгаа тул олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхлээд байна» гэж ОХУ-ын Аюулгүйн зөвлөлийн аппаратын Олон улсын аюулгүй байдлын газрын ерөнхий зөвлөх А.Г.Стоппе өгүүлжээ. Эдүгээ Орос улсад далд бизнесийн нийт эдийн засагтаа эзэлж буй хувь 24, Казахстанд 1999 оны байдлаар 20-25, харин Монголд 13.3 хувьтай байлаа хэмээн «Эдийн засгийн аюулгүй байдал» эмхэтгэлд дурьдсан байна.

Хөшиг зузаарсаар. Мөнгөнд дургүй хүн үгүй болохоор мөнөөх хөшигийг дэлгэж нээх гэж хэн ч оролдсонгүй, «Манай том компанийнхан цагдаа, хууль хяналтынханд нөлөөллийн хүрээ, төлөөллийн хүнтэй байх сонирхолтой. Тэдгээрээр бие биеэ айлгадаг явдал ч бий... Монголд эдийн засгийн амьдрал төлөвшиж чадаагүй, улс төрийн сонирхол илт давамгайлсан нөхцөл байдал байгаа» хэмээн Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж ярьж байна. Улстөрчид, бизнесийнхэн, цагдаа хуулийнхны төлөөлөл бүхий бүлэглэлүүд Монголд бий болж, дээр нь тэд дуу хоолойгоо болгох мэдээллийн хэрэгсэл эрэлхийлэх аж. Яг Оросын олигархуудын хоорондох тэмцэл шиг зохион байгуулалт дор ажиллаж, өөр зуураа өрсөлдөн, ардаа банкттай, хажуудаа хэвлэлтэй, саарал ордонд тулгууртай оршин тогтнохыг эрмэлзэх болов. Оросуудаас ялимгүй онцгой нь, Монгол дахь ашиг сонирхлын бүлэглэлүүд төрсөн нутаг усныхнаа хаацалдаг, түүнд нь үзэл бодлын ялгаа нөлөөлөхөө больж, нутгийнхаа хүнийг буруу ч зөв ч хаацалж хамгаалсан хариугүй атгаг бодол хаа сайгүй халдварлажээ. Цаг цагийн Засгийн газруудын удирдан явуулсан хувьчлалын монгол түүхийг эхнээс нь эргэж санавал, албан тушаалын томилгооны синдромыг тоочвол нутаг нугаар нь хэмжсэн, үйлчилсэн түүх дурайн нь ой гутам. Хэдхэн хүний хэлцлээр эдийн засгийг, улс орныг залах гэсэн санаархал цаашид даамжирвал сонгож, сонгогдох жүжиг тоглоход ч сонирхолгүй болох биз.

Тун саяхан Монгол Улс өмчөө хувьчилж, бүгдээрээ ялимгүй хөрөнгөтэй, гараан дээр ойролцоохон зогсоогүй бил үү. Харин өнөөдөр өмч хуваагдаж, бүлэг бүр түших тулах эд зүйлтэй болжээ. Сонгууль дөхөх үед нэр дэвшигчдэд зориулан цацах тэр их мөнгө хаанаас гараад ирдэг юм бэ гэж үү? Далдын далдаас. Оросын шинэ баячууд бүгдээрээ шахам нефть, хий, өнгөт төмөрлөг ханхалсан мөнгөөр хүчирхэгжсэн бол манайхан алт, банк, спирт, ноолуур, байж болох бүх бизнесээр ивээн тэтгүүлэв. Улс орны ирээдүйг харлуулсан хөшигний цаадахь хэлшлийг тасалж болдоггүй гэж үү? В.Путин ийм алхам хийж эхэлсэн 2000 онд эргээд очоорой. Тэр жилийн баяр наадмын өдрүүдэд бид энэ явдлыг нэг их анзаараагүй ч байж магад. Яг долдугаар сарын 11-нд ОХУ-ын Ерөнхийлөгч олигархуудтай тэмцэх бодлогоо олон нийтэд анх тайлбарласан юм. Тэр В.Гусинскийн «Медиа мост»-ыг багалзуурдаж яаж зүрхэлсэн юм?! Дараа нь Б.Берёзовскийг буланд шахсан. Өмнөхөн нь, мань хоёр еврей залуу ээлжлэн Оросын телевизээр ашиг сонирхлоо тургиж, эсрэг талд нь олигархуудын өөр бүлэглэл хариу нулимж байв. Улстөрч А.Чубайс, банкир В.Потанин, дээр нь А.Кох... гэхчлэн сөрөг бүлэглэл эмхлэгдэн зогсч билээ. Бүлэглэлүүд өөр зуураа сурталчилгааны дуу хоолойгоо булаалдаж байлаа. НТВ, ТВ-6 телевизийн сувгууд Оросын олигархуудын гарт мэдээллийн зэвсэг болон ээлжлэн солигдов. Оросын Ерөнхийлөгч ийм бүлэглэлүүдийг бага сага ч атугай хянах гэж оролдсон. Өмнө нь бие муутай Ельцин, нөлөө багатай Кириенко нар олигархуудыг Кремлийн зуйван танхимд цуглуулж, ярьж нэг, ятгаж хоёр оролдоод амжилт олоогүйг санана уу.

Монголд түүх давтагдаж байна. Хоорондоо зодолдох ашиг сонирхлуудыг цэгцлэх хүчтэй удирдагч манайд алга. Чимээгүй мөнгө ноёрхлоо тогтоож, үлэмж зохион байгуулалтад оржээ. Энэ торонд орооцолдсон хэн болов ч хэтэвчээ зузаалж, улс орны хөгжлийн алхам бүрт тэр тор тээг болж эхэллээ.

# Монголын говь дахь Синдерелла

Нөгөө говийн ганц айл ганцаардахаа хэдийнэ больжээ. Тэр Фридланд хэмээх канад найзтай. Тийм болохоор Улаанбаатараас хамгийн холд алслагдсан сумдын нэг Өмнөговийн Ханбогдынхон шарсан гахайн торой, нугас зооглож, хачиртай тулыг «Heineken»-ээр даруулж, үхрийн шорлогийг ч нэг их тоохгүй харагдана. Ялимгүй хэтрүүлж байна. Гэхдээ л нутгийнхан пүрэв гаригийн үдэш найз Фридландынхаа хүлээн авалтад ирж, Сэрчмааг «амьдаар нь» хараад, «Let it be» чагнасан шиг өнгөрөөв.

Айвенхоу Майнз компанийн эзэн Роберт Фридландад говийнхон ач санах болсон төдийгүй, Канадын бизнесмэн өөрөө буян хишгээ түүнд харамгүй өгөх энэ нутгийг ухаангүй биширч явна. Тэр тухайгаа «Шинэ өглөө орноосоо өндийх бүрийд илрүүлсэн нөөцийн хэмжээ өмнөх үдшийнхээс нэмэгдсэн байна шүү дээ» хэмээн илэрхийлжээ. Ханбогд сумын нутагт орших Оюутолгой орчмоос ийм их баялаг гарна гэж хэдхэн жилийн өмнө огт төсөөлөөгүйгээ Айвенхоу Майнзын ажилтнууд нотолсон юм. Жирийн нэг компанийг өнөөдөр Оюутолгойн баялаг дэлхийд зард гаргав. Фридланд богино хугацаанд Синдереллагийн үлгэрийг биеэрээ амсч явна.

Шинэ цагийн Золушкаг хоёр жилийн өмнө анх харсан билээ. Тэгэхэд Оюутолгой гайхамшгийг хараахан амлаагүй, Фридланд Монголын хэвлэлүүдэд эхний эерэг сэтгэгдэл төрүүлэхээр чармайж байсан юм. Түүнтэй таарсан хоёр дахь уулзалт маань энэ удаа өвөрмөц эхлэв. Өндөр туранхай эр Монголын бурхны шашныханд дор гэгч мэхийн байн байн хүндэтгэл үзүүлснийг яана. Наймдугаар сарын 28-ны өглөө хамгийн түрүүнд харсан зураглал маань тэр. Гандантэгчинлэн хийдийн тэргүүн хамба Д.Чойжамцын өмнө бараг сөгдөж мөргөв үү дээ хэмээн гайхшрав. Хэрэв зурхайд заасан сайн өдөр нь тохиосон бол үсээ тэр дор нь авахуулахад ч бэлэн гэснийг сонсвол их л сүсэгтэй эр аж. Бишрэл хүндлэл нь зохиомол байгаагүйг Фридландын хүүгийнх нь Иш гэх нэрийг сонсоод гадарлав. Энэтхэг ламаас Иш хэмээх алдрыг хүүдээ адислуулан авчээ. Харин Оюутолгойд ирснээс хойш газрын гүнээс дуулдах их баялгийн чимээ Фридландын сүсгийг лавшрууллаа. Түүнийг Чойжамц хамбад мэхийж байх мөчид Лондонгийн металлын бирж дээр унци алтны үнэ 369 ам.доллар 40 цент хүрч, нэг тонн зэс 1731 ам.долларын ханштай байв. Тэгвэл Канадын бизнесмэнд 13.7 сая унци алт болон 11.2 сая тонн цэвэр зэсийн нөөц бий. Оюу толгойн нөөцийг урьдчилсан байдлаар ингэж тооцсон юм. Иш бурхан тэнгэр минь бүр сайн мэхийхээс яахав.

Говийн ганц айл тонн зэс, унци алтны үнийг үзэх интернэт бүү хэл цахилгаангүй тул дээрхийн тухай төсөөлөл бага. Харин хүчирхэг мотор ажиллуулан гэрэл цацраах Оюутолгойн хайгуулын анги, хүндэтгэлийн гэр, оройн зоогны сайхан үнэр содон төдийгүй Дэмчигийн хийдийг нь сэргээж өгнө гэсэн буянтай бизнесмэнд их л талархана. Ноён хутагт Данзанравжаа «Саран хөхөө»-гөө туурвисан гэх Дэмчигийн хийдийн балгасыг амьдруулна гэсэн Фридландын санаачлагад нутгийнхан баярлаж, сумын Засаг дарга нь шүлэг хүртэл зохиосон байна гээч.

...Ул-ээмжийн чана-аар тө-гөл-дөөр хэмээн хаа нэгтгээгээс аялах шиг. Үлэмжийн сайхан зүйлс бодогдож, сэтгэл цэвэршмээр байгалийн үзэсгэлэн дунд Данзанравжаа дуугаа бичжээ. Ийм дурсгалыг сэргээн гэдэг нээрээ буянтай хэрэг. Дэмчигийн хийдийг сэргээх ажилд 108.000 ам.доллар

...Ул-  
ээмжийн чана-  
аар тө-гөл-дөөр  
хэмээн хаа  
нэгтгээгээс  
аялах шиг.  
Үлэмжийн  
сайхан зүйлс  
бодогдож,  
сэтгэл  
цэвэршмээр  
байгалийн  
үзэсгэлэн дунд  
Данзанравжаа  
дуугаа бичжээ.



хандивласан нь говийнхны хувьд эхний сюрприз байж болох юм. Дараа нь олон шинэ үйл явдал үргэлжилнэ. Монголын өмнөдийг Засгийн газраас маань илүү Фридландын бизнес өөрчлөх цаг ирснийг энд байх хугацаанд мэдрэв. Гэхдээ Айвенхоу Майнзын олборлосон, хийсэн бүтээгдэхүүн хэдхэн километрын цаана орших Хятадын нутгийг чиглэнэ. Говийнхны одоогоор сонирхоогүй яваа бас нэг зүйл нь энэ. Хөдөөнийхөн бүү хэл хотын дарга нар сонсоогүй байж мэдэх өөр нэг мэдээлэл нь Роберт Фридланд Хятадын Засгийн газартай манай шашныхнаас дутуугүй найзалсан явдал юм. Шинэ цагийн Синдерелла хулгануудад туслаад л явна гэж бодоогүй биз дээ. Тэр бизнесээ улам өргөжүүлэх хүсэлтэй. Энэ тухайгаа «Өрсөлдөгчдийн маань идэвхтэй үйл ажиллагаа биднийг шахаж байна» хэмээн тодруулжээ. Айвенхоу Майнз нь Өвөрмонголын бүс нутагт хэрэгжүүлэх судалгааны зарим төсөлд бас шалгараад байгаа юм. Р.Фридланд ойрмогхон Өвөрмонголын албаны хүмүүстэй уулзсан бөгөөд тэр Хятадын Засгийн газраас ойрын жилүүдэд үлэмж дэмжлэг авна гэдэгтэй итгэлтэй явна.

Канадын нэгэн сонины саяхны дугаарт нутаг нэгтнийхээ бизнесийн амжилтын тухай дэлгэрэнгүй өгүүлээд, «Хятад, Монголын удирдлагууд энэ зун уулзах үедээ Өмнөговьд дэд бүтцийг хамтран хөгжүүлнэ, Хятадын Засгийн газар хойд хөршийнхөө дэд бүтэц, ялангуяа зам тээврийг шинэчлэхэд зориулан 300 сая ам.долларын өртөгтэй хөнгөлөлттэй зээл хэрэгжүүлэхээр амласан» гэх мэтээр тэмдэглэжээ.

Оюутолгойн өсөн нэмэгдсээр байгаа баялгийг шимтэн сонирхох хангалттай шалтгаан Хятад улсад бий. Тус улсын эдийн засгийн өсөлтийн гайхам хурдыг илэрхийлсэн статистикууд өдрөөс өдөрт орон нэмэн жирэлзэж байна. Зөвхөн автомашин үйлдвэрлэл нь энэ оны эхний хагаст 108 хувиар өслөө. Өөрөөр хэлбэл дэлхийн зах зээл дэх аль нэг металлын үнэд хүчтэй нөлөөлж чадахуйц үйлдвэрлэл тэнд өрнөж байна. Жингийн хоёр талд тэнцүүлсэн зэсийн болон бусад олон металлын эрэлт, нийлүүлэлтийн хэмжээнд тус улс нөлөөлөхүйц далайцтай үйл ажиллагаа явуулж эхэллээ. Ийм нөхцөлд Айвенхоу Майнз нь Хятадын Засгийн газрын мэдлийн СИПИС хэмээх байгууллагатай хамтран ажиллах гэрээг энэ оны эхээр байгуулжээ. СИПИС нь бүс нутагт төрөл бүрийн ашигт малтмал олборлох, судлах чиглэлээр ажилладаг.

Роберт Фридланд Оюутолгойн нэрийг дэлхийд зарлаж өгсөн. Түүнд гүн талархал илэрхийлье. Бас говийнхны амьдралыг өөрчлөх олон зүйлийг хийж чадна. Гагцхүү монголчуудын хяналтаас энэ бизнес гарч эхэлжээ. «Ийм баялаг хилийн наана байгаад та бүхэн баярлах учиртай» гэж тэрбумтан Ханбогд суманд явах үедээ өгүүлж билээ. Канадын хэвлэлүүдэд Оюутолгойг зэс болон гангийн нөөцөөрөө дэлхийд тэргүүлнэ хэмээн зарлаж байна. Харин бидний хувьд Оюутолгойн ирээдүй Эрдэнэтээс ялимгүй ялгаатай. Хоёр дахь Эрдэнэттэй боллоо шүү гэгцгээн манай хэвлэлүүд чамгүй шуугисан хэдий ч шинэ ордын хувь заяаг өмнөд хөрш маань цаасан дээр хэдийнэ тооцож эхэлсэн.

Оюутолгойн хайгуулын ангийн байранд хийсэн танилцуулах мэдээллийн үеэр эдний мэргэжилтнүүд «3-4 жилийн дараа Эрдэнэт, Оюутолгой, Бороо гурав л Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулна» гэсэн юм. Тэгвэл «Эрдэнэт»-ийн тал хувь нь Оросынх, Оюутолгой нь Синдереллагийн буюу Хятадынх. Айвенхоу Майнзын ажилтнуудтай Ханбогдын үзэсгэлэнт хэсгээр явсан зорилго маань дээрх эсдвэрх ноён Фридландаас хариулт авах явдал байлаа. Пүрэв гаригийн үдэш Ерөнхий сайдын гэргий болон Их хурлынханд зориулан хийсэн өвөрмөц хүлээн авалтынх нь өмнө түүнтэй уулзах боломж олгосон хүмүүст гүн талархал илэрхийлье.

**Өмнөговийн  
Золушка өмнөдийн  
түнш рүүгээ  
тэмүүлсээр байна.  
Тэрбээр Монголын  
хилээс өөрийнх нь  
хэлснээр дотогш  
төдийгүй гадагш-  
Өвөрмонголд ашигт  
малтмалын  
чиглэлээр идэвхтэй  
хамтран ажиллаж  
эхэллээ.**



**-Ноён Фридланд, уурхай ашиглалтад орсны дараа бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулахаар төлөвлөж байна вэ?**

-Бүтээгдэхүүн гаргаад хаана борлуулах нь өнөөдөртөө хамгийн чухал асуудал биш байна. Нэгэнт олон жилийн турш хийх ажил болохоор зах зээлээ хэзээ ч сонгож болно. Өнөөгийн байдлаар Хятад нь зэсийн хамгийн том зах зээл. Өнгөрсөн жил тус улсын зэсийн хэрэглээ АНУ-ынхаас ч давсан. 2002 оны эхний хагаст Хятадын зэсийн хэрэглээ нь 21 хувиар өссөн байх юм. Уг үзүүлэлт SARS өвчин дэлгэрсэн үед ч буурахгүй л байлаа. Эндээс хэрэглээ маш өндөр байгаа нь харагдаж байгаа биз дээ.

Хятадад хүн бүр машинтай болохыг хүсдэг. Ийм эрэлтийг хангах шаардлага байна. Гэх мэтээр хэрэглээ хаа сайгүй л харагдана. Өчигдөр бид Улаанбаатар дахь «Чингис» зочид буудлаас компанийнхаа байр руу очих гэж замын хөдөлгөөнд саатаад зөндөө л удсан. Монголд хүртэл автомашины хэрэгцээ ийм их байна шүү дээ.

Бид одоохондоо геолог хайгуулын ажлаа эрчимтэй явуулах, орд газар илрүүлэх, түүнээ цаашид тууштай үйлдвэрлэн нийлүүлэх чиглэлдээ голлон анхаарч байгаа. Үйлдвэрлэлээ босгоход л шамдаж байна гэсэн үг. Харин зах зээлийг яваандаа сонгож болно.

**-Таныг Хятадын Засгийн газартай идэвхтэй хамтран ажиллаж байгаа хэмээн Канадын хэвлэлд бичжээ. Ямар чиглэлээр ажиллаж буйгаа тодруулж өгнө үү.**

-Монгол Улс өнөөдөр газарзүйн ямар байршилд байгааг харъя л даа. Би канад хүн. Манай улс АНУ-тай хэрхэн хиллэдэг вэ яг тийм төстэй нөхцөл энд харагдаж байна. Канад том газар нутагтай, түүнийхээ хэрээр ашигт малтмал болон бусад баялагтай. Харин хүн ам цөөтэй. Хамгийн гол зах зээл маань асар их хэрэглээтэй хөрш АНУ болдог юм. Үүнтэй л ижил Монголын баялгийн гол зах зээл болох өмнөд хөршдөө бүтээгдэхүүнээ гаргаж, зохицож худалдаа наймаа хийх учиртай биз ээ. АНУ-тай харилцдаг өөрсдийн бизнесийн туршлагаа бид танай нөхцөлд ашиглах гэж байна. Олборлосон эрдэс баялгийг өнөөдөртөө л хамгийн том зах зээл болох БНХАУ-д нийлүүлэх, үүнд хандуулж бэлтгэл ажлаа хийх, судалгаа явуулах маягаар ажилладаг.

**-Үйлдвэр хэдийд ашиглалтад орох вэ? Танай хувьцааг олон компани худалдан авах хүсэлт тавьж байгаа гэдэг үнэн үү?**

-2007 оноос үйлдвэрээ ажиллуулах бодолтой. Аль нэг улсад хувьцаагаа худалдчихаад гарах нь гэж айх аюулгүй. Бид энд олон жилийн турш үйл ажиллагаагаа явуулна. Харин 2-3 компанитай хамтарч хувьцаа эзэмших явдал байж болох юм. Ер нь хамтарч ажиллах санал их ирдэг гэв.

Дараа нь Оюутолгой төслийн удирдагч, Айвенхоу Майнз компанийн дэд захирал Чарли Фостертэй уулзсан юм. Тэрбээр «Цаашид үйлдвэрлэлээ босгон, уурхайг ажиллуулахын тулд Хятадын Засгийн газраас ямар нэг байдлаар зээл авч ажлаа явуулах асуудлыг хөөцөлдөж буй байх. Гэхдээ энэ асуултад манай компанийн тэргүүн илүү хариулж чадах биз ээ» гэсэн юм.

**-Говийн бүсийн хөгжилд танай компани ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ? гэсэн асуултад Ч.Фостер:**

-Монголын говийн хөгжилд Оюутолгой асар хувь нэмэр оруулна гэж бодож байна. Ус, эрчим хүчний асуудал, ажиллах хүч, тээврийн бэрхшээлийг шийдэхэд, говийн өмнөд хэсгийн дэд бүтцийг сайжруулахад тус нэмэр болно гэж хариуллаа.

Үнэхээр тэнд одоо ч ихээхэн хөрөнгө оруулалт хийгээд байна. Говийн өмнөдөд америк үйлчилгээ хүрч, хоногийн турш цахилгаан гэрэлтэй, хажуудаа халуун устай болохоор Оюутолгой орчимд хотын гэр хорооллынхноос тохилог амьдралтай. Зөвхөн хайгуулын ажилдаа Айвенхоу Майнз энэ оны зургадугаар сарын байдлаар 24.500.000 ам.доллар зарцуулсан гэж компанийн мэргэжилтнүүд яриж.Тян Шяны алт, зэсийн бүсийн үргэлжлэл хэмээх Оюутолгойд 1996 онд зэсийн багахан илрэл буйг тэмдэглэж байсан бол сүүлийн

хоёр жил гаруйхны хугацаанд нөөц нь огцом нэмэгдэж, говь өөрийн Синдереллатай болоодохов. Өмнөговийн Золушка өмнөдийн түнш рүүгээ тэмүүлсээр байна. Тэрбээр Монголын хилээс өөрийнх нь хэлснээр дотогш төдийгүй гадагш- Өвөрмонголд ашигт малтмалын чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж эхэллээ.

**2003 он**

# Айвенхоу Майнз ажлаа хумьж, Рио Тинто санаа тавьж эхэллээ

Өмнөд хилээс маань 70 орчим километрийн чанагш, Оюутолгой орчим анир чимээ багатайхан байна. Жил гаруйхны өмнөөс ийм хүлээлт бий болжээ. «Айвенхоу Майнз» компани Өмнөговийн Ханбогд сумаас холгүйхэн их ажил хэрэг өрнүүлэн, нутгийн зон олонд эерэг сэтгэгдэл төрүүлэхийг чармайн, тусламж тэтгэлгийн олон хөтөлбөрөө эхлүүлсэн нь саяхан. Оюутолгой тойрсон баялгийн судалгааны ажил үндсэндээ шувтарч, уурхай байгуулах, олборлох дараагийн нүсэр төслийг хэрэгжүүлэх мөчийг анасан хүлээлт бий болжээ. Завсрын энэ мөчлөгийг мөнгө болоод эсэргүүцэл гэсэн хоёр хүчин зүйл сунгаж уртасгасан юм.

Юуны түрүүнд, Монголын Засгийн газартай «Айвенхоу Майнз»-ын байгуулахыг хүссэн Тогтвортой байдлын гэрээний сураг холдож, ард иргэдийн шаардлага эсэргүүцлийн дор найдлага нь бүдгэрч эхэлсэн билээ. Эх нутгийн өмнөдөд газрын гүнд нуугдах баялгаасаа монголчууд ахиухан ашиг хүртэх учиртай гэсэн шаардлага мөнөөх гэрээний хуудаснаа асуултын тэмдэг болон тээглэв. Нөгөө талд нь, Оюутолгойг түшиглэсэн ил уурхай байгуулахад хэрэгцээтэй асар их санхүүжилт «Айвенхоу Майнз»-ыг давхар дарамтад оруулаад байлаа. Тэгвэл өнөөдөр үйл явдал хэрхэн эргэж, ямархан шатандаа очсоныг тодруулан харъя.

**Тогтвортой  
байдлын гэрээг  
манай төр ,  
засагтай төд  
удалгүй  
байгуулах гэсэн  
Роберт  
Фридлэндийн  
цахилгаан  
төлөвлөгөө  
«саармагжсан»  
өдрүүд бидэнд  
олон зүйлийг  
ойлгуулсан  
билээ.**

«Айвенхоу Майнз Монголиа» компани 500 ажилтнаа халсан тухай яриа яагаад гарсныг тодруулъя. Эдний хэвлэлийн албаныхны өгч буй тайлбарт, хүмүүсийг халсан зүйл үгүй, гагцхүү ажлын хүрээ харьцангуй хумигддаг өвлийн улиралд хөдөлмөрийн гэрээг дахин сунгаагүй тохиолдол байгаа, үүнийг цомхотгол хэмээн ойлгох хэрэггүй гэсэн санаа бий. Юутай ч, Оюутолгой орчимд хүлээлт бий болоод байна. «Айвенхоу Майнз»-ын эзэн Роберт Фридлэнд 2-3 жилийн өмнөх шигээ итгэл төгс, эрч хүчтэй харагдахгүй байгааг төвөггүй анзаарч болно. Тэрбээр Монголын амгалан говьд , аниргүй мэт санагдах уудам нутагт гэв гэнэт ийм их эсэргүүцэлтэй тулна чинээ төсөөлөөгүй юм. Өнгөрсөн нэг жилийн турш үргэлжилсэн ард олны хүчтэй эсэргүүцэл дунд «Айвенхоу Майнз Монголиа» компанийн ажилтнуудын дунд хүртэл зарим үед итгэл алдарсан яриа сонсогдож байлаа. Оюутолгойн баялгийг шударга хуваах тухай шаардлагын дуулиан Монголын тун ч эмзэг дархлаатай төр, засгийг айдсаар дор нь хүлэв. Тогтвортой байдлын гэрээг манай төр , засагтай төд удалгүй байгуулах гэсэн Роберт Фридлэндийн цахилгаан төлөвлөгөө «саармагжсан» өдрүүд бидэнд олон зүйлийг ойлгуулсан билээ. Юуны өмнө , хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхлыг Монгол орны алсын ирээдүйтэй ямагт холбон харж байж шийдвэр гаргахыг төр, засагт ойлгуулсан иргэний хөдөлгөөнийхөнд талархал илэрхийлэх ёстой.

Хүлээлт монголчуудын хувьд ашигтай туслаа. Энэ зуур Тогтвортой байдлын гэрээ гэх нэр томъёо ч хуучрав. Өнгөрсөн долдугаар сард баталсан Ашигт малтмалын тухай шинэ хуулийн үзэл баримтлал нь өмнөхөөсөө огт өөр санаа агуулжээ. Гадаадын хөрөнгө оруулагчдыг нутагтаа татахын хамт өөрийн ашиг сонирхлоо хамгаалж сурах шинэ хандлага тэнд хавчуулаастай. Ингээд Тогтвортой байдлын, тусгай энэ тэр хэмээн онцгойлох зүйлгүй ердөө л Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах учиртай болоод байна. Гэрээний нэр өөрчлөгдсөн төдийгүй агуулгад нь манай талын хүсэл сонирхол тусгагдахыг хүлээсэн сэтгэл

зүй нийгэмд бий боллоо. Тэгвэл нөгөө талаас бас гэрээнд оролцогчдын хувьд чанарын өөрчлөлт гарах нь. Монголын Засгийн газар нь Хөрөнгө оруулалтын гэрээг «Айвенхоу Майнз»-тай төдийгүй Рио Тинто групптэй гуравлан үзэглэх нь. Чухам энэхүү Рио Тинто групп Роберт Фридлэндийн хувьд авралын од, найдлагын оч юм. Монголын говьд элдэв эрсдэлээс үл эмээн оруулсан түүний ихээхэн хөрөнгийн үр өгөөжийг Рио Тинтогийн шууд идэвхтэй оролцоо л «чулуу болгох» гээд байна.

«Айвенхоу Майнз» Нью-Йоркийн Бараа түүхий эдийн болон Хөрөнгийн бирж дээр хувьцаагаа борлуулж эхэлсэн мэдээг монголчууд эхэндээ нэг их тоогоогүй л болов уу. IVN гэх символтойгоор дэлхийн хөрөнгийн зах зээлд гарч эхэлсэн уг үнэт цаас угтаа Өмнөговийн Ханбогд орчмынхны амьжиргаа, цаашлаад монголчуудын ашиг орлогод ойрын ирээдүйд дорвитой өөрчлөлт гарах эсэхийг харуулах нэг ёсны шууд биш үзүүлэлт байлаа. Монголд улс төр тогтвортой, үймээн самуунгүй өдрүүдэд хувьцааны ханш нь зөвхөн Оюутолгойн зэс, алтны үлэмж агуулгаар илэрхийлэгдэн хөрөнгө оруулагчдыг даллан татсаар байсан юм. 2004 оны сонгуулийн дараахан улс төр үймээн бужигнаантай болоод ирмэгц IVN үнэт цаасны ханш хэлбэлзэж эхэлсэн. Энэ мэдрэмхий үзүүлэлт анхаарал хандуулсан Рио Тинтогийн тухай уншигчдадаа товч танилцуулъя.

Дэлхийн үнэт цаасны зах зээл дээр тоглогчид түүнийг RTP эсвэл RIO символаар нь андахгүй. Эдгээр хувьцааны үзүүлэлт өчигдрийн байдлаар Лондонд 27.63 гэсэн хаалтын ханштай, Австралид 76.07, Нью-Йоркод 218.54 болон өмнөх өдрийнхөөсөө ялимгүй өсөөд байна. Өөрөөр хэлбэл, «Айвенхоу Майнз»-ын хувьцаа лугаа Монголын амьдралтай эмзэг нарийн холбоотой бус ч гэлээ бидний сонирхлыг татах хангалттай шалтгаантай үзүүлэлт гэсэн үг. Оюутолгойд уурхай байгуулах санхүүгийн эх үүсвэр олох зорилгоор ноён Фридлэнд хувьцаа борлуулсан агаад Рио Тинто шиг аварга амьтан Оюутолгойг сонирхсон нь түүний хувьд унжирч сунжирсан их хүлээлтийнх нь шагнал гэлтэй.

Дэлхийн уул уурхайн үйлдвэрлэлийн зах зээл дээр хоёрдугаар байрт жагсдаг хүчирхэг групп «Айвенхоу Майнз»-ын хувьцааны 9.95 хувийг худалдан авах хэлцлийг хийлээ. Хэрэв Монголын Засгийн газар Хөрөнгө оруулалтын гэрээг их удаашруулалгүй байгуулчих янзтай бол дахин мөн хэмжээний хувьцаа худалдан авахаа ч илэрхийлжээ. Ерөнхийдөө тус групп Оюутолгой төслийн 30-40 хувьд хөрөнгө оруулалтын баталгаа гаргах боломжтойгоо нуухгүй байгаа юм.

Рио Тинто нь зэс, алт төдийгүй алмааз эрдэнийн баялаг уурхайнуудыг эзэмшдэг. Тэрчлэн молебдин, уран, хөнгөн цагааны үйлдвэрлэл, газрын бусад элемент олборлох чиглэлээр үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг аж. Их Британи болон Австралид үйл ажиллагаа явуулдаг хоёр аварга нэгдэн 1995 онд групп тодотголтой болжээ. Рио Тинтогийн «өвөг» компани их Британид 1873 онд анх байгуулагдсан үүх түүхтэй. Бүр тэр цагаас л дэлхийн зэс үйлдвэрлэлийн зах зээл дээр гол тоглогч байсан гэдэг. Эдүгээ «Рио Тинто» ашигт малтмалын салбар дахь аль өнгөтэй өөдтэй томхон үйлдвэрлэлүүдэд хөрөнгө хаяад байна. Бидний энэ зунжин нэрийг нь сонссон Чилийн Эскондида уурхайд ч хөрөнгө оруулсан юм байна. Сүүлийн жилүүдэд Азийн зах зээлийг онцгойлон сонирхсон гэдэг. ОХУ-ын Норильскийн никелийн үйлдвэрт бас нэг хөрөнгө оруулагч нь болоод амжжээ. Отгон төсөл нь Оюутолгой. «Рио Тинто»-гийн шинэ гүйцэтгэх захирал Том Албаниз өөрийн биеэр Монголд морилол ирж, Оюутолгой төслийн нэг удирдагч болохоо зарлан, манай төрийн өндөрлөгүүдтэй уулзаж, эхний сэтгэгдлийг түгээсэн. Ингэж албан ёсоор нүүр хагарсны эцэст манай Засгийн газартай байгуулах

**Шинээр  
баталсан  
хуулийнхаа  
хүрээнд,  
шингээх ёстой  
эрх ашгаа  
зоригтойхон  
илэрхийлээд,  
дараа дараагийн  
хөрөнгө  
оруулагчдад  
жишиг тавих  
гэрээг  
монголчууд  
хүлээж байна.**

Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл дээр санаачлагаа шингээх алхмуудаа хийх бололтой. «Айвенхоу Майнз» болон «Рио Тинто»-гийн мэргэжилтнүүд Монголын Засгийн газартай ирэх оны эхээр Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах шаанстай хэмээн найдаж байна.

Манай уул уурхайн салбарт дэлхийн хүчирхэг хөрөнгө оруулагчид ийнхүү бодитой оролцож эхэллээ. «Рио Тинто»-гоос өмнө «Би Эйч Пи Биллитон» Улаанбаатарт салбараа нээснийг манайхан андахгүй. Тэд салбарын дэлхийн магнатууд. Хөрөнгө хаясан нутаг орныхоо эрдэс баялгийг мангас шиг л залгина. Ингэхдээ нутгийн иргэдийн шаардлага, экологийн тэнцвэр сэлтийн тухай зүсэн зүйлийн шахалт эсэргүүцэлтэй тулгарч үзсэн туршлагатай компаниуд. Тэднийг Хятадын зах зээлийн эцэс төгсгөлгүй эрэлт, Монголын эрдсийн нөөц гэсэн сайн нөхцөл даллан дуудсаар байна. Бас богино хугацаанд зардлаа нөхөх ашиг сонирхол бий. Ийм бачуу хэмнэл бидний ирээдүйгээ гэх бодлого төлөвлөгөөтэй байнга зөрчилдөнө гэдгийг хаана хаанаа ойлгож байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын эрсдэлийг хувааж үүрэх сонирхол «Рио Тинто»-д ч, «Айвенхоу Майнз»-д ч байгаа. Тэгэхээр Оюутолгойн уурхайн хөрөнгө оруулагчаар шинэ шинэ нэрс дахин гарч ирэхийг үгүйсгэхгүй. Галт гэрэг нэгэнт хөдөлжээ. «Айвенхоу Майнз» уурхайгаа 2008 оны сүүлийн хагаст ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Тогтвортой байдлын гэрээний төслийн ард суухаас айж бултдаг улстөрчид энэ удаа ажлаа барьж авахаас аргагүй болох нь. Шинээр баталсан хуулийнхаа хүрээнд, шингээх ёстой эрх ашгаа зоригтойхон илэрхийлээд, дараа дараагийн хөрөнгө оруулагчдад жишиг тавих гэрээг монголчууд хүлээж байна.

2006 он



# Монголын уул уурхай дэлхийн зах зээлд зэл татахын учир

Монгол Улсын Ерөнхийлөгч ард түмэндээ хандаж илгээлт гаргалаа. Газрын дорх баялгаа дэлхийн зах зээлд үнэ хүргэж заръя гэсэн санаагаа Н.Энхбаяр илгээлтдээ шууд илэрхийлжээ. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Стратегийн орд газруудынхаа жагсаалтыг батлах, улмаар энэ асуудлаар Засгийн газар нэгдсэн байр суурьт хүрэх, чуулганд танилцуулах цуврал хэлэлцүүлгүүдийн өмнөхөн Ерөнхийлөгч ийнхүү өөр дээрээ гал дуудав.

Төрийн тэргүүн толгой дээрээ түймэр далласнаас өөрцгүйгээр санаагаа шулуухан илэрхийлсэн юм. Монгол Улс чухам ямар орд газруудаа стратегийнх хэмээн онцгойлохов, тэдгээрийн талаар төрөөс цаашид ямар бодлого баримтлах бол гэдгийг дэлхийн томоохон улсуудын уул уурхайн салбарын аваргууд амьсгал даран хүлээж байлаа. Төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордын хэдэн хувийг төр хяналтдаа байлгах бол гэсэн асуулт олон хүний нойрыг үргээж байгаа. Түүнчлэн Монголын тал нутагт их бага хэмжээгээр хөрөнгө хаяж хайгуул хийсэн гадаадынхан ч «...улс орны эрх ашигт нийцүүлэн төрийн эзэмшлийн хувийг тогтоох...» гэсэн үгний цаана нуугдах цифрийг сонирхон чимээ чагнацгаана. Энэ бүх хүлээлтийн хамт түүнийг авлигач, идээч уугаачаар нь сав л хийвэл цоллох хэвлэлүүдийн дайралт байлдааны бэлэн байдал зарлаад байна. Нар наашилж, иргэний хөдөлгөөнийхөн жагсаалдаа гарах цаг ч айсуу. Газрын дорх баялгаа Н.Энхбаяр «эх орны хишиг» хэмээн нэрийдэхийг уриалан, энэхүү хишгээс ард түмэндээ хүртээнэ гэж зарлалаа. Олон нийтээс дэмжлэг хүссэн гуйлт Ерөнхийлөгчийн хэлсэн үгнээс тодхон мэдрэгдэж байна. Тэр юунаас айгаад дэмжлэг хүсэв, яагаад чухам ашигт малтмалын сэдвээр ард олондоо хандах болов?

Монгол Улсын Ерөнхийлөгч Оюутолгой, Тавантолгой тэргүүтэй баялаг ихт ордуудыг сонирхогч гадаадын хөрөнгө оруулагчдаас айсангүй. Тэр үндэсний овгоруудаас эмээж байна. УИХ болон намуудын удирдлага дахь улстөрч-бизнесмэнүүдээс айж байна. Стратегийн орд хэмээн зарлахаар Засгийн газар 49 газрыг санал болгосон. Дээр нь төсвийн хөрөнгөөр нөөцийг нь тогтоосон ордын 50 хувийг улс мэдэлдээ авах ёстойг зарласнаараа лиценз эзэмшигч улстөрчдийн аманд өөрөө очоод орчихов. Их хурлын гишүүд, тэдний ах дүү, амраг садны мэдэлд байгаа ашигтай лицензүүдийг үнэгүйдүүлэн, ард түмэнд тэндээс хишиг хуваарилаахыг уриалснаараа Ерөнхийлөгчийн хэлсэн үг заримынх нь эгдүүг хүргэж, нөгөөгийнх дэмжлэгийг авлаа. Таны уриалгыг дэмжиж байна. Үүний хамт Монголбанкны экс ерөнхийлөгч О.Чулуунбатын санаачлага, идэвхтэй үйл ажиллагаанд «онцсайн» гэсэн үнэлгээ өгч орхиё. Тэр дэлхийн санхүүгийн томоохон зах зээл дээр үндэсний компаниудаа гаргах ажилд өөрийн мэдлэг, хувийн харилцаагаа сайн ашиглаж амжилт олж байгааг хараагүй, мэдээгүй гэж хэн ч хэлж чадахгүй. О.Чулуунбат Ерөнхийлөгч Энхбаяртай зөвлөлдсөний эцэст ийм зуучлалын ажил эрхэлж байгааг ч бүгд ойлгож байгаа. Тэд бас маргаж «би чи»-дээ тулсан тухай цуу яриа гарч л байна. Дор нь улстөржүүлээд бужигнуулж, төрийг хямраахад тун амархан өгөөш харагдаж байгаа биз. Лиценз эзэмшигч томчуудын дургүйг хүргэж байгаагаа Ерөнхийлөгч мэдэж, тэр тусмаа ОХУ-тай хамтарсан үйлдвэрүүдийн манай талын эзэмших хувь хэмжээг өөрчлөх тухай ярианы сэжүүр гаргаснаа ч ойлгож байгаа. Хажууд нь О.Чулуунбат «Эрдэнэт»-ийн хувьцааг олон улсын биржид

Олон нийтээс  
дэмжлэг хүссэн  
гуйлт  
Ерөнхийлөгчийн  
хэлсэн үгнээс  
тодхон мэдрэгдэж  
байна. Тэр юунаас  
айгаад дэмжлэг  
хүсэв, яагаад  
чухам ашигт  
малтмалын сэдвээр  
ард олондоо  
хандах болов?

зарвал асар их мөнгө дагуулж ирнэ хэмээн ил тод зарласаар явна.

Эдгээр үйл явдлыг улс төрийн ээлжит хямрал болгох санаархал бэлэн шахуу, сценари нь бичээтэй байхад Ерөнхийлөгч ард түмэндээ ханджээ. Араасаа дагуулах хэл амыг таамагласан учир ашигт малтмалын баялгийг хэрхэн хуваарилах талаар намуудыг зөвшилцөөнд уриалав. «Айвенхоу Майнз» компанитай Засгийн газрын үзэглэх учиртай Хөрөнгө оруулалтын гэрээг дахин хойшлуулах аргагүй болсон учир зоригтойхон шийдэхийг сануулсан санаа хавчуулжээ. Эдүгээ зөвхөн «Айвенхоу Майнз» компанитай асуудал ярихгүй, дэлхийн эрдэс баялгийн салбарт хоёрдугаарт бичигддэг «Рио Тинто» манай байр суурийг сонсохоор хүлээж байгаа үед цаг хугацаа ийнхүү хавчиж байна. «Айвенхоу Майнз» гэсэн нэрийг амнаасаа унагасан хүн улс орноо харьд худалдагч лугаа сонсогдож байсан айдас хийрхлийг давахыг Ерөнхийлөгч уриаллаа. Хөрөнгө оруулалтын гэрээнд Монголд ашигтай саналууд тухайлбал, Оюутолгойн уурхайн эрчим хүчний эх үүсвэрийг Хятадаас бус, дотоодоосоо хангах тухай заалт шингээн баталж чадвал бидэнд л хэрэгтэй. Мөн гадаадын компаниуд өөрийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц нь тогтоогдсон ордын тоонд Оюутолгой орно. Ийм орлод байх төрийн мэдлийн хэмжээг 34 хувиар тогтоох эхний босгыг Н.Энхбаяр зарлаж байна. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахдаа уг хэмжээг дахин бидэнд ашигтай хувилбараар өөрчлөх ч боломжтой. Хамгийн гол нь Хөрөнгө оруулалтын гэрээний талаар олигтойхон дугараад, гацаанаас гаргачих зориг манай улстөрчдөд дутаж байгаа. Дахиад засаг ганхчих вий, намын Удирдах зөвлөлөөс банга хүртэх вий хэмээн хулмаганасаар шар нар бор хоногийг барж амьдарна гэдэг хэцүү еэ.

**Гадаадын  
компаниуд  
өөрийн хөрөнгөөр  
хайгуул хийж  
нөөц нь  
тогтоогдсон  
ордын тоонд  
Оюутолгой орно.  
Ийм орлод байх  
төрийн мэдлийн  
хэмжээг 34  
хувиар тогтоох  
эхний босгыг  
Н.Энхбаяр  
зарлаж байна.**

Дэлхийн зах зээл дээр 2007 оны турш зэсийн үнэ тогтвортой байх урьдчилсан төлөв гарсан үед, «Рио Тинто» Оюутолгойн хувьцааг худалдан авч байгаа өдрүүдэд баялгаасаа мөнгө босгох хэлэлцээрт орж, өөрийн нөхцөл болзлыг зоригтой илэрхийлэх ёстой. Өнгөрсөн жилийн хаваржин монголчууд «Айвенхоу Майнз» руу довтлон, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулахаар шуугиж байх үед Нью-Йоркийн бирж дээр IVN хувьцааны үнэ уруудсан билээ. Тэгвэл «Рио Тинто» эдний хувьцааны 9.5 хувийг худалдан авах хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа төдөлгүй хувьцаа эргээд эрэлттэй болсон байх юм. Монголчууд эргэлзээгээ гэж, эх орны эрх ашгийн тухай дэмий сайхан ярьж алтан цагийг алдаж суух ёсгүй ээ. Дэлхийн бизнесийн газрын зураг дээр Монгол орон тодхон өнгөөр гараад ирсэн. Харин одоо ашигтай хэлцлүүд хийхээр толгой гашилгах, намууд байр сууриа илэрхийлэх учиртай.

Америкчууд эрчим хүчний өөр эх үүсвэр хайж эхэлсэн. Тэр нь нүүрс. Жорж Буш Сенатын танхимд үг хэлэхдээ илэрхийлсэн энэ санаа Монгол нутагт тун саяхан өрнөсөн ажил хэрэгч яриа болон хэрэгжих шатандаа орлоо. Дэлхийд нүүрс олборлолтоор тэргүүлэгч компани манай Засгийн газартай яриа хэлцэл хийгээд эхэллээ. «Монгол алт» Хонконгийн зах зээл дээр хувьцаагаа борлуулах бэлтгэл ажил явагдаж байна. Зуучлагчаар нь О.Чулуунбат ажилласан юм байж. Ингэлээ гээд түүнээс өө хайх биш, талархал илэрхийлье. Дэлхийн санхүүгийн зах зээл дээр ингэж зангарагтай ярьж чадах хүн Монголд хэд байдаг билээ. Тэднийг харлуулах нь хэнд ашигтай юм бэ. Дэлхийн бизнесүүд манайхыг сонирхож байна. Ийм таатай өдрүүдэд эдийн засгаа өөд нь татаад авах мөнгө босгоход яагаад болохгүй гэж.

Жавар тайлагдаж, энгэр задгайлах дөхсөн энэ өдрүүдэд дэлхийн эрдэс баялгийн салбарын төлөөлөгчид Улаанбаатарт хуран цуглажээ. Бид Татварын бодлогоо өөрчлөн гадаадын хөрөнгө оруулагчдад хэтэрхий хөнгөлөлт үзүүлдгээ больсон үед тэд ирсээр л байна шүү дээ. Ашигт малтмалын тухай хуулиа

өөрчилж, хаалт квот тодорхой хэмжээгээр тавьсан байвч хөрөнгө оруулагчид Монголын эрдэс баялаг руу хошуурсаар байна. Төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын хувьцааны тал хувийг улс мэдэлдээ авна гэдэг нь үнэн хэрэгтээ тэр газарт асар хөрөнгөөр босгосон уурхайн талыг бид эзэмшсэнээс өөрцгүй. Монгол төрийн ийм бодлогыг зарласаар байгаа үед ч гадаадын хөрөнгө оруулагчид манай баялгаас буцахгүй нь. Тэгэхээр бизнесийн алтан үе иржээ. Эдийн засгаа сайжруулах алтан боломж биднийг түшиж байна. Өөрсдийн нөхцөл саналыг зоригтой илэрхийлэх бололцоотой болжээ. Энэ боломжоо хардалт сэрдэлт, талцал мөргөлдөөнөөр хааж харанхуйлах ёсгүй гэсэн санааг Ерөнхийлөгч дэвшүүлсэн. Эх орны баялаг ордуудыг эзэмших лицензийг гартаа хийсэн улстөрч бизнесийнхэнд гоочлуулах «сайхан» өгөөшний үг хэлжээ. Ашигт малтмалын ордууд тойрон сүүлийн өдрүүдэд өрнөж буй бүх үйл явдал Монгол төрийн нүүр царайг илэрхийлэх бас нэг дуулиан болохоор бэлтгэгдэж байна. Стратегийн орд газрын тоог цөөлөн 17 болгохоор Эдийн засгийн байнгын хороо шийдлээ. Орд болгоны араас хэл яриа гарах нь эргэлзээгүй. Хэл яриа хэний эрх ашгийг хаацайлах бол. Анхааралтай харцгаая.

**Эдийн засгаа  
сайжруулах  
алтан боломж  
биднийг түшиж  
байна.  
Өөрсдийн  
нөхцөл саналыг  
зоригтой  
илэрхийлэх  
бололцоотой  
болжээ.**

2007 он

# Оюутолгойн тухай оддын дайны сэтгэмжүүд

Дэлхийд байхгүй хоёр ордтой гэж дээлэндээ багтахгүй дарцаглаж явна даа, бид хэмээн танил бизнесмэн маань санааширлаа. Дарцаг марцаг хийсгэж сагсуурах болсны учир нь зэс, алтны зах зээлийн үнэ тун өндөр, коксжих нүүрсний ханш 2005-2006 онд оргил үзүүлэлтдээ хүрснийх. Үнэ ханшийн энэ таатай мэдээг монголчууд бид тэмдэглэж аваад өвөртөө хийчихлээ. Оюутолгой, Тавантолгойн ордыг эзэмших хувьцааг гайхалтай ашигтайгаар борлуулах мөрөөдөл цээжинд халуу шатааж эхэлсэн түүх ийм.

Дэлхийд зэс болоод коксжих нүүрсний нөөцөөрөө дээгүүрт орох ордуудынхаа хувьцааг бүгдийг авна гэж арай муйхарласангүй. Ямар ч байсан тал нь манайх шүү гэгцгээлээ. Блуумбергийн шинэ мэдээнд зэсийн ханшийн үзүүлэлт 7000 ам. доллар давахыг үзмэгц дахин уухай хашгирцаав. График өгсөөд байх тусам эх орны яндашгүй баялгийг улам харамлах хар төрөөд өвөртөө хадгалсан цаасыг ирээдүйдээ зориулан хав дарахаар зарим нь сэтгэл шулуудав.

Ингээд Монголд «Айвенхоу майнз» гэх нэрийг амнаасаа унагасан хүн болгон дайсан, эх орноо худалдагч цол хүртэн, Тавантолгой төслийг сонирхож ирсэн гадаадын төлөөлөгч бүрийг сэжигтэй нүдээр дагуулан харах өвчин дэлгэрлээ. Оюутолгойн ордын тал хувийг монголчууд эзэмших учиртай гэсэн халуурал ялимгүй намжихыг хүлээсээр Ц.Элбэгдоржийн, дараа нь М.Энхболдын танхим амаа хамхижээ. Айдас бүгдийг хүлж багласан байлаа. Монголын төр, засгийн айдас хүйдсийн түвшин дэлхийн зах зээл дэх үнэ ханшийн өндөрлөгтэй давхацсаар удав. «Оддын дайны» түгшүүр дундуур 34 хувь гэсэн тоо гараад ирлээ. Оюутолгой ордын хувьцааны 34 хүртэлх хувийг манай Засгийн газар эзэмшихээр Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл хийчихээд дахин чимээ чагнаж гарав. «Одоо л иргэний хөдөлгөөнийхөнд алуулна даа...» гээд амьсгаа даран хүлээлээ. «34 хувь бага байна, өшөө нэм» «Жирийн иргэдэд хувьцаа эзэмших боломж олго».

Байзаарай. Дурдсан 34 хувиа эзэмшихийн тулд Монголын Засгийн газар нөгөө «Айвенхоу майнз» компаниас чинь мөнгө зээлэх гэж байгааг дуулсан уу? Хоёр тал ийм тохиролцоонд хүрээд байна. Зүгээр л иргэний хөдөлгөөнийхнөөс айгаад 50, 50 хувиар гэх мэт уран сэтгэмжээр жигүүрлэсэн тоо нэхвэл худалдаж авах тэр их мөнгө нь хаана байна? Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд урьдчилсан байдлаар тусгасан 34 хувиа өөрийн мэдлийнх болгохын тулд бидэнд 900 сая ам. доллар хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, нэг триллион гаруй буюу Монгол Улс нэг жилийн турш бий болгосон үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний орлоготой тэнцэх дайны хөрөнгө босгох болох нь. Чухам энэ мөнгөнд барьцаалагдсан Засгийн газар гэнэтийн ашгийн 68 хувийн татвар дээр «Айвенхоу майнз»-д буулт хийснийг эрхэм уншигч анзаараа болов уу. Аливаа гэрээ хэлцлийг хоёр талын ашиг сонирхлын уулзварт үзэглэдэг болохоор ний нуугүй ярилцах цаг болсон байна.

Нэг триллион илүү төгрөг өгч хувьцааныхаа эзэн болохын тулд манай Засгийн газар «Айвенхоу майнз» болоод «Рио Тинто»-д татварын тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлж таарна. Лав зэс хайлуулах үйлдвэр байгуулах хүртэл ямар нэгэн байдлаар хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх нь. Тэгэхээр энэ зуур нөгөө бидний дээлэндээ багтахгүй баяжмаар төлөвтэй явсан гэгээн

**Байзаарай.  
Дурдсан 34  
хувиа  
эзэмшихийн  
тулд Монголын  
Засгийн газар  
нөгөө  
«Айвенхоу  
майнз»  
компаниас чинь  
мөнгө зээлэх  
гэж байгааг  
дуулсан уу?**

мөрөөдөл замхарч байна биш үү. Хувьцааныхаа төлбөрийг хийх хүртлээ лав төсөвт Оюутолгойгоос овойж оцойсон орлого орохгүй. Харин гэнэтийн ашгийн 68 хувийн татвараар багагүй мөнгө олох бололцоотой. Гэхдээ нэг триллион төгрөгний өр болоод гэнэтийн ашгийн орлого хоёрын өгч, авах графикайг хэрхэн уялдуулсан нь одоогоор бүрхэг байна. Хөрөнгө оруулалтын гэрээнээс хий айж явахаар яг ийм заалтууд дээр оновчтой байр суурь, хувилбартайгаар бид хэлэлцээрт орох ёстой. УИХ-ын гишүүд найр наадам, ёслол тахилгын хөөрүү сэтгэгдлээсээ салж аваад, тунгааж бодмоор янз бүрийн хувилбарыг төслийн ажлын хэсгээс нэхвэл сайн сан. Иргэний хөдөлгөөнийхөн ч мориноосоо бууж, магадгүй энэ өдрүүдэд Монгол Улсын эдийн засаг их үсрэлтийнхээ өмнө ирээд байгаа талаар бодож үзүүштэй юм. Хэрэв зарим хөдөлгөөнийхний хүсээд байгаа шиг иргэндээ хувьцаа эзэмшүүлэх эх оронч санааг хэрэгжүүлбэл эргээд нөгөөх нь хятадуудын гарт оччих магадлал өндөр гэдгийг ч бодолцох ёстой.

Оюутолгой болоод Тавантолгойн гэрээний төслийг чөтгөр рүү илгээх санаархал өнөөдөр моодноос гарчээ. Харин гэрээнд урьдчилан тусгасан ямар заалтыг яаж өөрчилбөл, ямар аргачлалаар тооцоо хийвэл Монгол Улсад ашигтай тухай ажил хэрэгч санаачлага л нойл зааж байна. Үнэхээр Оюутолгой тийм хэмжээний нөөцтэй юм уу, «Айвенхоу майнз»-ын үзүүлээд яриад яваа нөөцийн тухай статистикт далд нуугдах баялгийн хэмжээг оруулж тооцсон уу? Хэрэв говийн гүний усыг төсөлд заасан хүчин чадлаар нь ашиглавал Монголын баян бүрд хэдхэн жилийн дараа оргүй алга болно гэсэн судлаачдын сануулга хариу тайлбар нэхэж байна.

УИХ-ын гишүүдийн цөөнгүй нь энэ хоёр төсөл дээр тоглолт хийхээр зэхэж байгаад эргэлзэхгүй. Гэхдээ тоглолтынхоо завсраар эдгээр төсөл эх орны ирээдүйн хөгжил дэвшилд тулах хамгийн хүчирхэг хөшүүрэг болохыг ухаарч, жүжиг дэглэх бус ашигтай санал оруулбал ирээдүй хойчдоо хэрэгтэй биз ээ. 2010-2015 онд барьж байгуулна гэж төсөлд заасан зэс хайлуулах үйлдвэрийн талаар бас л эргэж тунгаамаар зүйл бий. Хэрэв уг үйлдвэр ашиглалтад орвол нөгөө 68 хувийн татвараа монголчууд авч чадахаа болино. Гэрээнд ийм заалт орчихсон. Тэгэхээр Зарим бараанд ногдуулах гэнэтийн ашгийн албан татварын тухай хуулийн заалт зөвхөн Оюутолгойн тохиолдолд өөрчлөгдөх болж байна уу? Түүнчлэн Тавантолгойн ордын хувьцааны тал хувийг төр өөртөө үлдээх болж байна. Ашигт малтмалын тухай хуульд заасанчлан нөөцийг нь төсвийн хөрөнгөөр тогтоосон орд тул хүссэн хүсээгүй 50 хувь нь засагт үлдэнэ. Гэтэл амьдралын шаардлагаар эл 50 хувийн эзэмшигчийг компанид шилжүүлэх, өөрөөр хэлбэл менежерийг нь солих хэрэгцээ гарах үест мөн л Хөрөнгө оруулалтын гэрээнд зориулж хуулиа өөрчлөх болох юм биш биз. Ерөөс дээрх хоёр ордтой холбоотой Хөрөнгө оруулалтын гэрээ цаашид Цагаан суваргын орд, Төмөртэй, Цав, Цайдамын орд газруудын асуудал яригдахад үлгэр болох учиртайн хувьд монголчуудын санаа бодол хамгийн сайн нэгдэж нягтарсан чамбай төсөл болох ёстой.

**Хөрөнгө  
оруулалтын  
гэрээнээс хий айж  
явахаар яг ийм  
заалтууд дээр  
оновчтой байр  
суурь,  
хувилбартайгаар  
бид хэлэлцээрт  
орох ёстой.**

Оюутолгойн уурхайг түшиглэн байгуулах зэс хайлуулах үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж эхлэх үест говийн экологийн унаган тогтоцод өөрчлөлт оруулах хэд хэдэн хүчин зүйл бий. Тэгэхээр «Айвенхоу майнз»-ын хийлгэсэн байгаль орчны үнэлгээний байдлын дүнд үнэхээр итгэж болох уу. Ер нь төслүүдэд аудит хийсэн гадаадын компаниудын дүгнэлт хэр үндэслэлтэй вэ. Тавантолгой төсөлд бүр 1998 онд Norwest компани үнэлгээ хийсэн. Үүнд өнөөдөр итгэж болох уу. Эргэлзэх нь эсэргүүцэх санаа биш агаад Их хурлын гишүүдэд төсөл боловсруулсан ажлын хэсгийнхнээс асуух будаа бэлтгэж өгч байгаа хэрэг. Манай гишүүд бие биесээ огцруулах буулгах асуудлаар илүү мэргэшсэн улс болохоор Оюутолгой, Тавантолгой төслийн тэр зузаан

материалыг эргүүлж тойруулж үзэх нь юу л бол?! Дээрх санаанууд нь төсөл батлах хугацааг сунжруулах шалтгаан бус, эх орны хөгжлийн тулах цэгийг найдвартай бэлтгэхэд зориулагдав.

«Оюутолгойгоо яах гэж байна, Ерөнхий сайд аа?» гэж өнгөрсөн сарын эхээр нэг пээдгэр хүү М.Энхболдоос асуусан удаатай. Үнэ ханшийн таатай мөчлөг ертөнцийн улирал лугаа ээлжлэн хувьсдагийг тэр айхтар жаал нэг хоёрхон жилийн дараа илүү ойлгож эхэлнэ ээ. Ийм мэдрэмж шинэ цагийнхны хувьд ердийн чанар. Зэс болоод коксжих нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ төслүүдийг дөнгөж гараас гаргаад байгаа энэ өдрүүдэд өндөр байгаа. Өөрөөр хэлбэл монголчуудад ашиг сонирхлоо илүү зоримог илэрхийлэх, хэлцэлд амжилт олох нөхцөл бүрджээ. Хүлээлтийн эрсдэлийг Рио Тинто ч юм уу, Тавантолгойн төслийн тендерт оролцох гадаадын том компаниуд илүү мэдэрч мэднэ. Монголд улсын баяр наадам болж, гишүүд нутаг орноо эргэж тойрсны дараа энэ асуудлыг яринаа гэсэн тайлбарт тэд амаа таглуулж магадгүй ээ. Харин дэлхийн зах зээлийн үнэ манай хэдийг тойргоо эргээд ирэг ээ хэмээн хүлээх биш.

Тавантолгой, Оюутолгойн гэрээний төсөл гэдэг гэмт хэргийн хавтаст материал биш, энэ тухай ярьсан нь эх орноо худалдагч бус, иш мухаргүй эсэргүүцлээ гээд Монголд аврал авчрагч бүр ч биш ээ. Яг энэ өдрүүдэд 2005 оны хаврынх шиг улс төрийн эгзэгтэй цаг мөч хаяанд ирээд байна. Засаг солихыг хүсэгчид шинэ танхимын бүтцийг яриад чихэр хүлхсэн хүүхэд шиг болчихож. 2005 оны хавраас «Айвенхоу майнз»-ын хувьцааны ханш тасралтгүй унасаар байлаа. Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ өндөр хэвээр атал IVN хувьцааны чансаа навс хямдарсан юм. Одоо ч IVN-ийг ийм эрсдэл хүлээж байна. Гагцхүү Рио Тинто тэвчээртэй хөрөнгө оруулагч гэдэгт найдъя. Засгийн газрыг унагах бужигнааны тоос татраагүй байхад ирэх жилийн сонгуулийн синдром залгахыг туршлагатай хөрөнгө оруулагчид тооцоолж байгаа биз. Рио тэвчээр алдаад Оюутолгойн хувьцааныхаа 10 хувийг хятадуудад зарчихыг хэн байг гэхэв. 50 хувиа авна гэж дайнд мордсон бид түүнийхээ эргэн тойронд өрнөх олон нөхцөл, гарцыг алдаж байна. Дутуу алсан могойн үлгэр үргэлжилсээр. Оюутолгой, Тавантолгой төслийн хувь заяаг улстөрчийн дөрвөн жилийн мөчлөг бүхий карьерт даатгахын учир юу вэ.

2007 он



# Ж.Оюунгэрэл: Монгол орноор нэг хардлагын хар үүл тэнүүчилж байна

*«Петровис» компанийн Ерөнхий захирал Ж.Оюунгэрэлтэй уулзлаа. Түүний ярилцлага санаандгүй содон дэд гарчгуудтай байж мэднэ. Монголчууд орд газруудын синдромоор амьсгалж, аагим халуун, аадрын үүлэн дор амарч тухлах завгүй явах мэт. Нийгэмд түгсэн тэрхүү уур амьсгалын аяс нэг л биш гэсэн санаагаар Оюунгэрэл захирал ярилаа.*

## СОЦИАЛИЗМ РУУГАА УХРААД МАРШ!

**-Монголчууд өөрсдөдөө үлдээх хувь хэмжээний тухай маргаж байна. Оюутолгой, Тавантолгойн баялгаас ахиухан ашиг хүртэхсэн гэдэг ард олны санаархлыг буруутгах зүйл үгүй байх?**

-Төрийн мэдэлд 100 хувь байвал ард түмний хяналтад байна гэсэн ойлголт нийгэмд түглээ. Ашигт малтмалын ордуудынхаа 100 хувийг, 51 хувийг ав гэж шаардаад байна. Тэр нь нэг их зөв юм шиг сонсогдоод. Хэдийгээр Оюу толгой, Тавантолгой том боловч эдгээр нь дараа дараагийн ашиглах бүх орд газрын хувьд жишиг болно шүү дээ. Монголд нээгдээгүй өөр олон баялаг эрдэнэс байж болно. Тэднийг илрүүлэх, ашиглах, бусадтай гэрээ хэлэлцээр хийх жишгээ монголчууд тогтоох гэж байгаа нь энэ.

Төрийн менежмент уул уурхайн салбарт хэрхэн хэрэгждэгийг монголчууд Шивээ-Овоогоос, Багануураас, хувьчлагдахаас нь өмнө Шарын голын байж байгаа төрхөөс хангалттай харсан. Маш их зээл, улсын асар их хөрөнгө оруулалт идсэн газрууд. Тэр тоонуудыг гаргаж ирээд харуулбал монголчууд дуу алдана даа. Тэгээд ажил төрөл нь огт өөдлөөгүй нь хамгийн аймшигтай. Төр уг нь тэдгээр уурхайд менежмент хийгээд л байлаа. Үнийг нь хөдөлгөөнгүй барьчихсан. Тоног төхөөрөмж нийлүүлэх, аливаа хөрөнгө оруулалтын арга хэмжээ авах болоход дандаа шахааны, өндөр үнэтэй эд өгдөг. Энэ бүхнийг би яагаад одоо гэнэт яриад унав аа? Яагаад гэвэл аливаа хувьчлалд төр оролцох ёстой, бүр дийлэнх хувийг нь, бүгдийг нь төр аваг гэсэн шаардлагад нийгэм маань сүүлийн үед маш их автдаг, ийм дарамт дор аж төрдөг болж орхилоо. Нөгөө 1990 оноос хойш бидний зүтгэж тэмүүлсэн зорилгынхоо яг эсрэгээр гэнэт ярьж таарна гэж үү. Өмчийг төрийн менежмент гэгчээс ангижруулна гэсэн монголчуудын олон жилийн хүсэл мөрөөдөл яасан бэ? Бүгдийг нийгэмчилдэг амьдрал руугаа буцаад ухарч байгаа хэрэг үү?

Төр юм болгонд давамгайлдаг энэ гаж жишиг дэлхийн бусад улсын эдийн засагт алга. Тэгэх тусмаа уул уурхайн салбарт улс аливаа ордын тал, түүнээс илүү хувийг өөртөө өмчилдөг туршлага үгүй. Төрийн өмч оролцсон манай уул уурхайн компаниуд 1990 оноос хойш л ашигтай ажилласан. Бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээр борлуулж эхэлснээсээ хойш ингэсэн. Гэхдээ л үргүй зардал тэнд асар их хэвээрээ байгаа. Яагаад гэвэл 10 төгрөгөөр авах зүйлийг улсын үйлдвэрийн газруудад 15 төгрөгөөр нийлүүлэх явдал бүр бичигдээгүй хууль мэт үйлчилдэг. Ингэсээр тухайн үйлдвэрийн өртөг зардал гэж хиймлээр данхайгаад ирнэ. Төрийн менежментийн үнэн төрх ийм л байдаг. Нөгөө яриад байгаа авлига гэдэг чинь улсын үйлдвэрийн газарт жинхэнээрээ бугшиж байна. Үүнийг мэдэхгүй хүн үгүй хэрнээ уул уурхайн салбарыг улсын мэдэлд өг гэж

орлисоор байх уу.

Одоо Оюутолгойн ордын 34 хувийг биш, 51 хувийг ав гэж шаардаад байгаа чинь эрүүл хандлага мөн юм уу. Төр буюу хамгийн бүтэлгүй менежерт эх орны баялгийг тэр чигээр нь өгөөд, эргүүлээд ямар ашиг хүртэнэ, аж амьдралаа яаж өөд татна гэж бид хүлээх билээ. Төр гэдэг ард түмэн гэсэн ойлголт биш шүү дээ. Монгол орон тэр чигээрээ судлагдаагүй шахам газар нутаг. Дараа дараагийн том, жижиг бүх ордыг төрийн мэдэлд өгөх болж байна уу. Нийгэмчлэх гэсэн энэ хандлага, хий хардалт өөрөө олон асуулт босгож байна.

## ТОХИОЛДОЛ БОЛГОНД ТОГЛООМЫН ДҮРМИЙГ ӨӨРЧЛӨХ ҮҮ?

**-Энэ чинь стратегийн гэж онцолсон орд газрууд шүү дээ. Дэлхийн хэмжээний том ордуудаа ашиглахдаа монголчуудад ашигтай хувилбарыг сонгож яагаад болохгүй гэж?**

-Төр баримтлах ёстой гол зарчим бол бүх зүйлд хууль нь тэгш үйлчлэх учиртай. Тохиолдол болгонд тоглоомын дүрэм өөрчлөгдөх хэрэг үү. Өө энэ чинь том орд газар, тэнд гадаадын хөрөнгө оруулагч орж ирж байгаа юм, тэгэхээр өөр дүрмээр яринаа гэвэл энэ тогтвортой төрийн ажил биш. Хамгийн гайхалтай нь төр, засгийн шийдвэрт нөлөөлж байгаа зүйл нь гудамжинд хэдэн хүн гарч хашгираад л болдог болж. Сонин гаж зуршил энэ нийгэмд хэвшиж байгаа юм биш үү. Оюутолгой төслийн хэлэлцүүлгийг Их хурал хойшлуулж орхилоо. Намрын чуулган хүртэл асуудлыг хойш тавьж байгаа юм биз. Тэгвэл ирэх чуулганы үеэр дахиад л ингэж мунгинасаар яваад хавар болж, парламентын сонгуулийн хугацаа айлсана гэсэн үг. Энэ бүхний эцэст улс орны эдийн засгийн хөгжлийг дахиад 3-4 жилээр ухрааж, нүдэн балай хаяж байгаа гэсэн үг. Хамгийн гол нь Монголын төр, засаг уул уурхайн салбартаа яг ийм бодлого баримтална гэдгийг одоо нэн тодорхой, тув тунгалаг илэрхийлэхгүй юм бол ирээдүйд тус салбарт олборлох, ашиглах бүх үйл явц бүдгэрээд ирж байна. Тохиолдол болгон дээр өөрөөр тоглодог төр, засаг гэж энэ дэлхий дээр байхгүй шүү дээ.

Уул уурхайн салбарт монголчуудын хувьд хамгийн том, эхнийх нь гэж болох Оюутолгой төсөлд туссан авууштай зүйл нь зэс хайлуулах үйлдвэр байгуулна гэсэн заалт. Дэлхийн тэргүүний технолог орж ирнэ, эцсийн бүтээгдэхүүн гаргах үйлдвэр байгуулна, тэнд монголчууд ажиллаж тархиа цэнэглэнэ гэдэг эх нутагт маань үлдэж байгаа хамгийн том олз нь. Түүнээс биш Оюутолгойн ашгийг хянаана, орлогыг яаж зарцуулж байгааг тооцоолно гэдэг өөр нэг асуултын тэмдэг болоод явчихна. Яагаад гэвэл манай улс тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн хийж байна л гэдэг. Ашиг орлого нэмэгдлээ л гэдэг. Ард түмэн түүнийг хянаж чадаж байгаа юм уу. Төсөвт их хөрөнгө орохын хэрээр зарлага данхайж байгаа. Эцсийн дүндээ эдийн засагт орж байгаа бүх мөнгийг хувийн хэвшлийнхэн хийдэг. Харин төрд хийгээд байгаа зүйл үгүй, зүгээр л бидний бүтээж буй баялгийг улам улам үрэлгэн тарааж цацаж, бас бидний татварын мөнгөөр элдвийг амлаж өөрсдийгөө дөвийлгөж явна.

**-Гудамжинд хэсэг хүн хашгирснаас айсандаа төрийн ажил хойшилж байгаа нь өөрөө эмгэнэл мөн үү?**

-Харин тийм. Гайхах зүйл зөндөө байна. Өөрсдийнх нь ажилладаг зах зээлийн үндсэн зарчмаас гажууд эсрэг юм шаардаад байхад манай бизнесийнхэн үхсэн амьд нь мэдэгдэхгүй дуугаа хураагаад суучихдгийг ч үнэхээр гайхдаг. Оюутолгой, Тавантолгойн энэ том уурхайг дагасан элдэв бүтээгдэхүүн нийлүүлэх жижиг бизнес зөндөө бий. Тэр болгоны ашиг хуримтлалыг дагаад улсын эдийн засаг бага багаар өөдөлнө. Бид өөрсдөө анзаарахгүй суугаа болохоос гадаадынхан манайд орж ирснээр бий болж байгаа

Өөрсдийнх  
нь ажилладаг  
зах зээлийн  
үндсэн  
зарчмаас  
гажууд эсрэг  
юм шаардаад  
байхад манай  
бизнесийнхэн  
үхсэн амьд нь  
мэдэгдэхгүй  
дуугаа  
хураагаад  
суучихдгийг ч  
үнэхээр  
гайхдаг.

хуримтлал чамгүй бий. Зүгээр л энд ажиллах хугацаандаа Улаанбаатарт байр хөлсөлж амьдарлаа гэхэд тэр сууцны эзэд хэдэн төгрөгтэй болоод л байгаа шүү дээ.

Уялдаагүй зүйл гэж алга. Монгол хүн бүрт янз бүрийн замаар ирж буй тэр ашиг орлого, дээр нь мэдлэг чадвар энэ бүхнийг эцсийн үр дүн гэж хараасай гэж би үнэхээр хүсдэг. Түүнээс биш ордуудын төдөн хувийг авна гэдэг наалдацгүй шаардлага. Төр хэчнээн их хувийг эзэмшсэн ч иргэн бидэнд оногдох ашгийг нэмэгдүүлж чадахгүй. Ийм нүсэр бүтэцтэй, үрэлгэн механизмаас сайн зүйл хүлээлтгүй. Манай бизнесийнхэн яагаад энэ талаар дуугарахгүй байна вэ гэдэг хачирхалтай юм шүү.

Төр яагаад хүчгүй байна гэхээр дэндүү нүсэр бүтэцтэй. Та нар анзаардаггүй байж магадгүй. Яамдын хувьд орон тоо нь хэвээрээ. Харин агентлагуудын орон тоо хэд дахин нэмэгдсэн. Ялангуяа төсөв сайн үед бүтэц маш томордог. Үүнийг бизнес хийж байгаа хүмүүс арьс махан дээрээ мэдэрдэг гэх үү дээ. Яг л аалзны тор шиг заримдаа санагддаг юм. Монголд бизнес хийж байгаа нийт хүний тооноос агентлагуудын ажлын аппарат илүү томорсон байж мэднэ. Манайхыг хамаардаг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар хэмээх агентлагийн орон тоо лав 80 хүнээр нэмэгдчихсэн байна. Биднийг хянадаг хүмүүс биднээсээ олон болчихжээ. Одоо Засгийн газар бүтцийн өөрчлөлт хийнэ, цомхон чадварлаг багаар ажиллана гэсэн санаа цухалзуулаад байгаа. Үүнийг бизнесийнхэн чин сэтгэлээс дэмжиж байгаа шүү.

## ОЙЛГООГҮЙ ТУСМАА ХАШГИРАХАД АМАР

**-Гудамжинд хашгирч байгаа хүмүүс Оюутолгой, Тавантолгойн хувьцаанаас хувь нэхээгүй. Тэд ч бас эх орны эрх ашгийн төлөө сэтгэл чилээж яваа иргэд гэж бодогдохгүй байна уу?**

- Эдгээр жагсагчдын дунд тоосго өрж, хөлс урсган хөдөлмөрлөж, баялаг бүтээх гэж чин сэтгэлээсээ зүтгэж явсан хүн хэр олон байдаг юм бол. Таамгаар төсөөлөх, хий хардах, энэ муу ингэх гээд байна уу даа гэх өвчин нийгэмд их халдварлаж байх шиг санагддаг. Засгийн газар, уул уурхайн компаниудын хооронд хийж буй Хөрөнгө оруулалтын гэрээг уншаад, ойлгоод тэр дундаас үндэслэлтэй баримт гаргаж шүүмжилж байгаа хүн жагсагчдын дотор бий гэдэгт би эргэлздэг. Төрийн оролцоо Оюутолгой төсөл дээр 34 хувь буюу багцлах боломжтой хэмжээнд байхаар гэрээнд тусгажээ. Үүнээс илүү байж яах юм? 34 хувьгүйгээр ямар ч асуудал шийдэх боломжгүй тийм хэмжээ шүү дээ. Хөдөлгөөнүүдийн эсэргүүцлээс айгаад гэрээний төслүүдийг ярихаа больчихож байна. Зүй нь улам сайн хэлэлцэх, ярилцах ёстой шүү дээ. Яагаад энэ хувь хэмжээг иргэд бага гээд байна. Хувь хэмжээгээ ихэсгэж түүнийхээ хүүнд мөнгө төлж байсны оронд татвараар хамаагүй илүү ашиг олж болох юм биш биз гэх мэтээр ярилцах хэрэгтэй биз дээ.

Ер нь тэгээд аливаа бизнесийн гэрээ гэдэг хоёр, гурван талдаа ашигтай байдлаар хийгддэг болохоос манайх шиг төрийн юм, ард түмний өмч гэж дээрэнгүй хандлагаар зүтгүүлдэг жишиг хаа ч байхгүй. Би энд гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих гээд ч юм уу, «Петровис» компани нэг их ашиг сонирхолтой учир хаацайлаад байгаа юм биш ээ. Ийм гаж ойлголт цаашид жишиг болоод тогтвол зөвхөн гадныхан гэлтгүй үндэсний үйлдвэрлэгчид өөрсдөө нийгмийн асар их хардалт дор ажиллах болно. Бизнесийн үндсэн зарчим алдагдаж, бидний арван хэдэн жил зүтгэсэн хөдөлмөр талаар болон эргээд социализм руугаа мөлхөх нь. Үүнд л би маш их эмзэглэж байна.

Гадаадын хөрөнгө оруулагч ч бай, дотоодын ч бай мэдээж төр, засгийн түвшинд санал солилцох зүйл чэндөө гардаг. Гэтэл төрийн түшээд нь бөөн айдас хүйдэс болсон хүмүүс. Ажлаа ойлгуулах зөв лообий байх ёстой. Би жишээ нь нэг албан газар очоод санал солилцчихвол «За авлига өгөөд гарлаа даа» гэж заавал боддог. Энэ чинь эрүүл нийгэм мөн үү. Одоо ерөнхий хардлага Монгол

**Таамгаар төсөөлөх, хий хардах, энэ муу ингэх гээд байна уу даа гэх өвчин нийгэмд их халдварлаж байх шиг санагддаг.**

## Ж.ОЮУНГЭРЭЛ:

**Олигарх гэж хэлүүлнэ гэж айгаад л. Олигарх гэдэг нь сайн ч гэж байгаа юм уу, муулж байгаа ч үг үү би мэдэхгүй.**

орноор нэг тэнүүчилж байна. Хэн нь ч юу ч хийж чадахаа байсан, шийдэж чадах зориггүй, хүсэл эрмэлзэлгүй болсон. Төрийн түшээд зөв ч байсан дэмжих тэнхэлгүй, буруу юм ярьсан ч эсэргүүцэх сэтгэлгүй, айдаст хүлэгдээд хөдөлж чадахаа больчихож. Хаана ч шийдвэр гаргаж чадахгүй байна. Олигарх гэж хэлүүлнэ гэж айгаад л. Олигарх гэдэг нь сайн ч гэж байгаа юм уу, муулж байгаа ч үг үү би мэдэхгүй. Ямар ч байсан нийгмийг тодорхой хэсэг нь манлайлж , урагш нь хөдөлгөх зүтгүүр болж явдаг. Түүнээс биш бүгдээрээ гудамжинд гарч жагсаад, бүх баялгаа тэнцүү хувааж идээд явбал нийгэм ухарна уу гэхээс, урагшлахгүй.

Бид хэд Улаанбаатарын хонхор дотроо л ноцолдоод байгаа болохоос энэ баялагт түшиглээд дэлхийд нэртэй үндэсний компаниа төрүүлэх боломж гараад ирчих боломжийг олж үзэхгүй байна. Засгийн газар нь үндэсний компаниа томруулахыг дэмжих ёстой. Монголын нийт эдийн засаг өөрөө дэлхийн зүгээр л дунд чинээний ганц компанийн хэмжээний ашиг орлоготой. Ийм жижигхэн эдийн засагтай хэрнээ жижг, дунд үйлдвэрлэлээ хөгжүүлнэ л гээд байгаа. Яахав жижиг, дунд үйлдвэр хэрэгтэй. Гэхдээ үүнийг чинь 17 жил ярилаа. Улс нь өөрөө дэлхийн дунд зэргийн компанийн дайны эдийн засагтай байж түүнээ дахин жижигрүүлэхэд их ашиг тус гарах юм уу. Үндэсний компаниудаа бодлогоор дэмжээд томруулаад, ингэхдээ газрын дорх баялагтаа түшиглэвэл үр өгөөж, далайц нь илүү хаялгатай тусна. Ийм давхар бодлого төр, засагт байх ёстой биз дээ. Ямар ч улс оронд том компаниуд нь эдийн засгаа чирээд л явдаг.

Манай алтны компаниуд гэхэд л овоо гайгүй ашигтай ажиллаад, томрох боломжтой болоод ирсэн чинь 68 хувийн татвар авна гээд падхийлгээд хаячихаж байгаа юм. Ашигтай үед нь орлогоос нь аваад, алдагдалтай цагт нь хаячихдаг хаана ийм утгагүй татварыг компаниудаасаа авдаг билээ дээ.

## **БҮГДЭЭРЭЭ ЗҮҮНИЙ НАМД ЭЛСЭЭРЭЙ**

**-Бизнесийнхэн өөрсдөө овилгогүй хүмүүс юм. Төр, засгийн ажилд тэд л хутгалдаж байж хувь , хувьсгалын ажлын ялгаа зааг замхарсан шүү дээ?**

-Өөрийнхөө бизнесийг унагаачихаад улс төрд ороод өөд нь татчихдаг хүмүүс олон бий. Нэрийг нь хэлээд юүхэв. Тэднээр төлөөлүүлээд нийгэмд манай бизнесийнхний нэр хүнд аймаар унасан. Монголын гучин хэдэн мянган аж ахуйн нэгжид зүтгэж яваа хүмүүсийн хөдөлмөрийг олон нийт хардаж харлуулж харах болсон гол шалтгаан тэр. Сонгууль болохоор , гадаадаас зээл тусламж авах болохоороо улстөрчид нөгөө л хувийн хэвшлийнхний олот амжилтыг өмнөө бариад, жишээ баримт татаад эхэлдэг. ДНБ-ий 80 хувийг бизнесийнхэн бүтээж байнаа л гэдэг. Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засагтай улс л гэдэг. Яг амьдрал дээр бүх зүйл бизнесийнхээ эсрэг гольдролоор хөвөөд эхэллээ.

Дээр нь бизнесийнхнийг дэмждэг нам гэж алга. Ерөөсөө л төсөвт орсон хөрөнгийг бүгдээрээ хувааж иднэ, тарааж өгнө гэцгээх болж. Төсвийн орлого өсөхөөр цалин нэмэгдээд байдаг, буурахаар нь одоо яах болж байна аа? Жишээ нь, Оюутолгой төслийн элдэв төрлийн үйлчилгээнд манай 80-100 компани сардаа 4-5 сая ам. долларын ажил хийж л дээ. Тэгвэл уурхай ашиглалтад ороод, үйл ажиллагаа нь жигдрээд өргөжөөд ирэхээр энэ дүн 10 дахин нэмэгдэнэ гэж тооцоолж байгаа. Нөгөө жижиг, дунд бизнесийг дэмжих бодлого гэдэг чинь жинхэнэ иймэрхүү тохиолдолд гарч ирнэ. Мөн энэ хэмжээгээр эдийн засагт түлхэц өгнө, цалин нэмэгдүүлэх бодитой боломж гарна.

Уул уурхайн компани гэдэг дор хаяж таван жилийн дараа ашгаа хүртэнэ. Тэр хугацаан дахь санхүүгийн алдагдлаас үл айх компани л ийм юманд зориглон ордог болохоос хүрз бариад ура гээд дайрах юм шиг төсөөлөх аргагүй шүү дээ. Рио Тинто бол энэ хэмжээний төсөл хэрэгжүүлж чадах дэлхийн хуруу дарам цөөн компанийн нэг. Тэд гараад явчих юм бол дараа нь үйл явдал яаж өрнөхийг үнэхээр төсөөлөхөд бэрх юм шүү.



## Эрхлэгч сууж харагдана уу?

Хэрэв чи эрхлэгч юм бол ажилтнууддаа байнга харагдаж байх ёстой гэсэн бодлыг би хуваалцдаг. Энэ дэлхий дээр олон янзын арга барилтай менежерүүд ажил хэрэг хөтөлж явна.

Зарим нь компьютерийн дэлгэцнээс хараа үл салган, ажилтнуудаа тэрхүү «хар хайрцагныхаа» цаанаас удирдан чиглүүлж, амжилт ялалтад хүрч байх нь сонин. Тэдгээрийг сурах бичигт бол «систем менежер» хэмээн тодотгох агаад өндөр хөгжилтэй улсуудад иймэрхүү дүр төрх түгээмэл гэх. Харин миний бодол үүнээс их өөр шүү. Магадгүй монгол менежерүүдийн онцлог барууны хэвшмэл дүр төрхөөс ангид биз.

Орлогч эрхлэгч хэмээх гуншин дор их ачаа үүрэх даалгаврыг «Өнөөдөр» сонины Ерөнхий эрхлэгч надад өгчээ. Гэхдээ орлогч эрхлэгчийн том хар сандлаас огло харайн босч яарах зан араншинг минь тэрбээр хэрхэн ойлгодог бол? Миний хувьд систем менежерийн чанаргүй амьтан. Харин «Намайг дагаад хий» гэх уриа яс маханд минь шингэж

орхисон бололтой. Угаас ярих илтгэх хообийгүй болохоор яг ингэж хийвэл ямар байна даа хэмээн өөрөө үзүүлэхийг хичээнэ. Хилийн чанадаас илгээсэн сурвалжлагаас минь редакцийн залуу сэтгүүлч нэг шинэ санаа олж харсан бол маш сайн хэрэг. Эдийн засгийн тайлбар тойм гэдэг заавал статистик тоонд дарлуулсан саарал материал байх албагүй юм гэдгийг манай хэлтсийн хэд мэдэрч



Манлайл, зохион байгуул, урам зориг өг. Ийм гурван шидэт үг байдаг гэнэм. Дунд болоод дээд шатны менежерүүдийн хувьд эдгээр нь ажлын алтан дүрэм.

ойлгосон бол би манлайлах үүргээ биелүүлжээ гэж ойлгоно. Манлайлал гэдэг заавал бичсэн материалаар хэмжигдэх учиргүй юм. Хэрэв чи эрхлэгч юм бол навсайж нэвсийж явах учиргүй. Ажилдаа хоцорч, өдөржин алга болж, хэрүүл хов живд хутгалдах ёсгүй... Болохгүй, хүлээн зөвшөөрөмгүй хэм хэмжээний дунд алдхан биеэ хүлж баглана



гэдэг л хамгийн хэцүү эд шүү.

Ой гарантай жаахан бамбарууш шиг охиндоо би өдөржин яардаг. Нөгөө бүдүүн охин минь баана шээнэ, элдвийн юм асгаж цутгана, ер хэрэг мандуулж дуусах биш дээ. Арчилж цэвэрлэсээр, охиноосоо салж ядсаар өглөөд би ажил дээрээ аахилсаар орж ирдэг. Бас л тав арван минут хожимдсон байх вий. Үүндээ шанална. Өдөр дахиад гэрээдээ тэмүүлнэ. Нөгөө том хар сандал, эвлүүлж зохицуулах олон ажлын хажуугаар живх нь дуусаагүй байгаа даа, сайхан өдөр болох нь, охиноо салхилуулахсан мэтийн «аж ахуйн» асуудалд байнга орооцолдоно. Тэгэхээр миний ажил үүрэг болоод амьдралын жим энэхэн өдрүүдэд хоорондоо зөрчилдөж байна. Энэ бол олон олон ээжийн туулж яваа зам байх. «Менежер хүн ажилтнууддаа байнга харагдах ёстой» Менежментийн алтан дүрмээ би зөрчиж байна. Манлайл, зохион байгуул, урам зориг өг. Ийм гурван шидэт үг байдаг гэнэм. Дунд болоод дээд шатны менежерүүдийн хувьд эдгээр нь ажлын алтан дүрэм. За яахав, одоохондоо лав ажлын

цагны хувьд би манлайлж үлгэр жишээ болж чадахгүй л явна. Харин өдөр тутмын сонины ажлыг цагийн зүү лугаа хэмнэл дунд нь хөтлөх буюу зохион байгуулах үүргээ орхивол алдас болохоос зайлахгүй шүү. Яг үүнд манай коллегийн хэд гар нийлж дажгүй ажилладаг юм даа.

Их үйл явдлын мөнхийн тоосон дунд туучиж явахдаа заримдаа бид хэд дөжирч, дасал болох янзтай санагддаг. Хурд хэмнэл сааран, нөгөө том хар сандал дээрээ лагхийтэл сууж орхиод, аяга халуун кофений үнэрт хоромхон амсхийх зуур хорвоогийн олон олон үйл явдал, сонин хачин чихний хажуугаар урсаад өнгөрчихийг яана аа. Ээ, энэ золигийн мэргэжлийг яая даа! Өглөөний 9.00 цагтай уралдан редакцийн хаалгаар орж ирэхдээ манай үүдэнд байх том цагаан цагийн зүү өөд сандран хардаг зуршилтай болжээ. Энэ «гайтай» цагийг яг тэнд, үүдэнд, орж ирүүт үзэгдэх газар хадья аа хэмээн би өөрөө хөөцөлдөөгүй билүү, хэнхэг золиг чинь. Тэгээд одоо тэр хатуу хэмнэлийг гүйцэх гэж өөрөө сандчиж явах юм. Яаран тэмүүлэх

Болохгүй,  
хүлээн  
зөвшөөрөмгүй  
хэм хэмжээний  
дунд алдхан  
биеэ хүлж  
баглана гэдэг л  
хамгийн хэцүү  
эд шүү.



сэтгүүлчийн амьдрал ажлын найм, хоногийн 24 цагаар үл хэмжигдэнэ. Өдөржин мэдээний машинд «сэгсчүүлсэн» хэдэн сурвалжлагчдаа урам өгөх нь менежерийн ажлын салшгүй хэсэг. «Отгоо, гоё бичлэг болжээ...» Ердөө энэ хоёрхон үгэнд нөгөө Отгоо маань нүд нь сэргэж харагдана. Уруулын будгаа сэргээх сөгөөтэй болж, өглөөнөөс хойш аахилсан стрессээ сэгсрээд, инээж ханиагаад эхэлнэ. Бичсэн материал сайн болно гэдэг бидний хувьд өдөр тутмын «Алтан гадас» одон шиг үнэлгээ юм даа. Харин «хогийн» материал уншиж редакторлох хамгийн тамын ажил.

Нэг л мэдэхэд үдшийн бүрий нөмрөөд, их хотын шуугиант амьдралын хэмнэл татарчээ. Орон сууцны гэрэл нэг нэгээрээ асч, хотол олон үдшийн амгаланд автаж суухад бид хэд гэж үйлийн үртэй амьтад тачигнатал бичсээр, пижигнэтэл уншиж зассаар... заримдаа юун нөгөө урам хайрлахтай мантай болчихно. Ийм хөдөлмөрөөсөө ч болдог юм уу сэтгүүлчид наргиантай улсууд. Материалаа бичиж сүүлийн цэг хатгав уу үгүй юу сэтгэл тэнийж аваад хаа

нэг болсон хачиртай үйл явдлуудыг хамж шимэн ярьцаагаад, пар пархийтэл инээж хөхөрцгөөнө. Редакц нураах нь уу гэмээр том том дуугаар хашгиралдаж, нэг ёсондоо стресс хогийг гүвж зайлуулж байгаа юм аа тэр нь. Ингэх зуураа аятайхан дарс хэн нэгнийх нь шүүгээнд байвал «нударч» орхино. Тэгээд дарга, цэргийн зааг бүдгэрч, бүгдээрээ л амсхийхийн, харихын түүс болцгооно.

Сонины менежер гэж нэг иймэрхүү л хүн байх. Тэглээ гээд саарал өнгөтэй «чиновник» болох саналуудаас ямагт татгалзаж явлаа. Хэцүү боловч хайртай мэргэжил гэж энэ. Богинохон хөнгөхөн даашинзанд татагдавч том хар сандал хэм хэмжээ зааварлахын зовлон ийм. Олонд хүндлүүлж, цөөхөнд ад болохын төвөг хэцүү. Систем бус, амьд менежер байхын гоё дарамт бэрх ээ.



# Их хувьчлалын МОНГОЛ ТҮҮХ

**-Пүрэвдорж дарга аа, санхүүгийн санал хэдэн хувь байна вэ?**

-Нэг хувь.

**-Журмын дагуу хэд байх ёстой вэ?**

-(Пүрэвдорж дарга мэргэжилтнүүддээ хандав) Зургаан хувь байх ёстой юм.

**-За, за.**

2003 оны арванхоёрдугаар сарын 23-ны өдрийн 11.00 цаг хэвийх үес Төрийн өмчийн хорооны байранд дээрх асуулт хариулт сонсогдов. «Говь» компани шинэ эзнийхээ гарт юу юугүй очих гэж байтал золигийн зургаан хувь... Тендерт оролцогчдын санхүүгийн саналыг нээх энэ мөчийг монголчууд олон жил хүлээсэн юм. Бүр 1999 оны намар «Говь»-ийг хувьчлах эхний тов тодорч, 70 хувийн хувьцааных нь эзэн болох хүсэлтэй зуу илүү компани сонирхлоо илэрхийлсэн байлаа. «Залаад бай» гэж загнах вий.

Өнөөдөр л «Говь» даржин нэртэй яваа болохоос 4-5 жилийн өмнө түүнийг авахаар гадаадын 130 компани харц шидсэн юм шүү. Ийм баримтыг Монголд АНУ-ыг төлөөлөн Элчин сайдаар ажиллаж байсан Альфонс Ла Порта 1999 оны дөрөвдүгээр сард хэвлэлээр зарлажээ. Одоо 2003 ондоо, Төрийн өмчийн дөрөвдүгээр байрандаа эргэн ирье. «Говь»-ийн хувьцааг зарах тендерт оролцохоор тавхан газар санал ирүүлсэн шинэ цагийн явдлыг жаахан тодруулъя. Австрийн нэг, Италийн нэг, «Бридж» группийн Германтай хамтарсан нэг, MCS-ийн Герман болоод Японтой нэгдсэн нэг, мөн дангаараа оролцсон ганц монгол компани санхүүгийн саналаа ТӨХ-нд ирүүлсэн байлаа.

Гадаадын 130 аж ахуй санаархаж байсан үеийг бодвол «Говь» өрөнд баригдаж, агуулахдаа баахан бараа хураасан, хөрөнгө оруулалтаар ангаж цангасан, дахин ялимгүй удвал тэтгэвэрт гарахад бэлэн хуучин газар болжээ. Эр болон зарах доод үнийг хамтатган багцаалбал шинэ эзэн нь 18 сая ам.доллар зарлагадмаар янзтай. Үүн дээр зайлшгүй хийх учиртай хөрөнгө оруулалтыг нэмбэл «Говь»-ийг хэр тааруу компани шинэчлэн босгох аргагүй бэрх бизнес аж. Ийм нөхцөл байдал дунд таван компани тендерт оролцсон нь зол. Гэвч дөрвийнх нь санхүүгийн санал тэнцсэнгүй. Хачирхалтай мэдээг 23-ны өдрийн 11.00 цагт мөнөөх танхимд ТӨХ-ны дарга Л.Пүрэвдорж эхлээд дуулгалаа. «Тендерт ирүүлсэн материал дутуу, шаардлага хангаагүй учир» дөрөв нь хасагдаж, зөвхөн MCS ба түүний япон, герман хамтрагчдын нэгдсэн консорциумын саналыг задалъя гэж ТӨХ-ны шинжээчид үзжээ. Азтай консорциумын нэрийг манай хэвлэлүүдэд «Itochu Wool, Cashmere Products, MCS Holding» хэмээн нямбай мэдээлсэн. Харин «Говь»-ийг худалдах доод үнэ дээр тус консорциум ердөө нэг зуун мянган ам.доллар нэмүү санал болгосныг хэвлэлийнхэн тоолгүй өнгөрөв. Өнгөрсөн зууны 1999 оноос хойш хадамд гарах гэж хэдэнтэй бүтэлгүйтсэн үйлдвэрийг авах хүн олдсон нь ямаай гээд хэл амгүй орхив.

Үнэхээр сурвалжлагч бид Монгол нутагт эхэлсэн их хувьчлалын түүхийг уншигч олондоо дамжуулахаар ерээд оны дундаас нийтийн, хязгаартай дуудлага худалдаа, нээлттэй, хаалттай уралдаант шалгаруулалт болгоны гэрчээр ажилласан билээ. Харин ялагчийг хариугүй зарлах торгон агшинд

ганц асуултад ТӨХ бүдэрч, буруугаа хүлээсэн нь дээрх тохиолдол л байлаа. Тендерт хариугүй ялах шахсан компани санхүүгийн саналын материалаа зургаа биш, ганц хувь үйлдсэнийг нөгөө санамсаргүй асуулт илрүүлжээ. Их хувьчлалын монгол түүх үргэлжилж байна. Хэрэв тэр өглөө тендерт оролцогчдын нэг болох Италийн компанийн төлөөлөгч хэрэгт дурлаагүй бол «Говь» хэдийнэ сүй тавьж орхихгүй юу. Өдий болтол ТӨХ-ны нягт нямбай ажилд эргэлзээгүй явсан хүмүүс хүртэл мөр хавчсан ийм тохиолдол шинэ жилийн өмнөхөн болжээ.

12.00 цагт ТӨХ-ны шинжээчдийн баг хуралдлаа. Харин 16.00 цагт сэтгүүлчдэд мэдээлэл хийв. «...Тендерийн бүх үйл явцыг амжилттай, шударга явуулахын тулд бид ч нэлээд хичээсэн. Гэвч тендерт оролцогчдын хариуцлагагүйгээс болж хувьчлал бүтэлгүйтсэнд үнэхээр харамсч байна... Ямар ч гэсэн бид хуулийн хүрээнд шударга шийдвэр гаргасан гэж ойлгож байна» гэж энд мэдэгдлээ. Өмнөх үдэш нь дөрвөн оролцогч «материал дутуу, шаардлага хангаагүй» учир тендерээс хасагдсанаа дуулсан гэнэ. Өөрөөр хэлбэл, хэд хэдэн хувь бэлтгэх ёстой бичиг цаасыг ганцхан хувилж өгсний учир цугаараа ингээд цувраад өрсөлдөөнөөс хасагджээ.

Тендерийг дахин зарлана. НИК-ийнхийг ч ялгаагүй. Сэтгүүлчид хүртэл залхаад, алд дэлхийг ч анзаарахаа больсон их хувьчлалын урт түүх үргэлжилж байна. Цэнхэр, ягаан тасалбараас хойш сурвалжлагч бид юм юманд суралцав. 1995 онд Их дэлгүүрийг худалдах тухай тогтоол гарснаас эхлээд, 1997 онд «Алтан тариа» хэрхэн хэл амтай хувьд очсоныг нүдээр үзжээ. Дөчин жилийн турш олигтой засч тордоогүй «Алтан тариа» үйлдвэрт Зөвлөлтийн үеийн техникүүд чихний хэнгэрэг хагартал пижигнэж байлаа. Хятад гурилтай хэрхэн өрсөлдөх нь тодорхойгүй, царай дарсан «Алтан тариа»-д чехүүд хөрөнгө оруулсан юм. 1.7 тэрбумаар үнэлэгдсэн «Алтан тариаг» чехүүдтэй түншилж худалдан авсныхаа дараа П.Цэнгүүн захирал хардлага сэрдлэгийн бай болов. Үнэ цэнтэй компаниудыг зарах оролдлого болгон хардлага дагуулдаг уламжлал ингэж тогтжээ. Үүнээс хэдхэн жилийн дараа «Алтан тариа» компани танигдахгүй болтлоо шинэчлэгдээд, бусдад үлгэр дууриал болж орхисон нь мөн л их хувьчлалын монгол парадокс. Хувьд очихоороо ийм болдог юм даа хэмээн үйлдвэрийг байн байн жишээ татан үзүүлж харуулна. Нүргэсэн шуугиантай цех, дамжлагууд хаачив гэлтэй алга болж, тэнд чимээ аниргүй, цэвэр, шинэ цагийн технолог орж ирсэн байлаа. Харин П.Цэнгүүн захирал сэтгүүлчдээс дөлдөг зуршилтай болж, хэдэн жил хилсээр цоллуулж явсан хар тамгаа мартаагүй харагдсан.

Их хувьчлалын парадокс эдүгээ гадаадын хөрөнгө оруулагчийн нүүрэн дундуур алгадаад авав. 2001 оны есдүгээр сарын 11-нээс хойш дэлхийн зах зээлд ноолууран бүтээгдэхүүний эрэлт эрс унаж, «Говь»-ийг сонирхогчид зуугаар тоологддог цаг өнгөрсөн үед шүү дээ. 150 жилийн түүхтэй Lanificio del Casentino-гийн даавуугаар Versace, Shanel шилдэг загваруудаа урлаж байна. Зуун дамнан нэхмэлийн ур ухаанаа өвлүүлсэн итали бизнесийг Монголд тоосонгүй. Тэгвэл «Made in Italy» шошготой цэвэр ноолуур, тэмээний ноос, ангор моодны эх орон Италид эрэлт ихтэй байдаг. Тэгээд тэд Монголын «Говь» компанийн хувьчлалд оролцох гэж санхүүгийн санал хэмээх нүсэр баримт бэлтгэхдээ зарим цаасаа дутуу хувилчихаж. Хятадад иймэрхүү тендерт амжилттай оролцож байсан л гэнэ. Европын зах зээлд итгэлтэй нэвтэрсэн, дэлхийд танил Lanificio del Casentino ийм гэнэн байх гэж үү. 2003 оны арванхоёрдугаар сарын 22-ны үдэш «Говь»-ийн санхүүгийн саналд тэнцээгүйгээ мэдээд мэл гайхсан тус компанийн удирдлагууд «Монголд хувьчлал хуурмаг болдог юм байна. Манайхыг оролцогчоор зарлан нэр хүндийг маань ашиглан тендер явуулжээ» гэсэн утгатай захидлыг

итгэмжлэгдсэн төлөөлөгчдөдөө илгээв.

Ер нь санхүүгийн саналтай ТӨХ-ны шинжээчдийн баг хэрхэн танилцдаг юм бэ? Хүсээгүй тохиолдлыг бол зүгээр л цааш нь түлхдэг юм биш биз. Үгүй гэвэл, яагаад ялгаагүй дутуу материал бэлтгэсэн компанийг ялагчаар зарлах шахсан юм бэ? Нэг тайлбарыг тэд сурвалжлагч бидний чихэнд шивнэж магадгүй юм. «Сонсооч, эцсийн эцэст үндэсний компанидаа «Говь»-ийг өгөх ёстой биз дээ». Зөв. Гэхдээ... Тэгвэл яах гэж олон улсын тендер зарлав? «Говь»-ийг өөрийн компанийн халаасанд үлдээж чадсан ялалтыг бүдгэрүүлэх муу нэр нүүрийг Монгол Улс хариуд нь олж авах юм биш үү? Яагаад би Италийн компанийн эрх ашгийг энд хамгаалаад эхлэв ээ? Уг тендерт бие даан оролцсон, дэлхийн ноолууран эдлэлийн зах зээлд нэр хүнд бүхий компани учир бодох зүйл бий гэж хариулъя. Иймэрхүү том бизнесийг гатахын тулд л олон улсын тендерүүдийг зарладаг гэж ойлгосон билээ. 2000 онд хамаарах нэгэн ишлэлийг давъя. «Л.Пүрэвдорж: Эдгээр өмчийнхөө нэлээд хэсгийг хөрөнгө чинээ бүхий гадаадын, олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, шинэ техник технолог ордуулж ирэх, түүнийхээ дараа Монголд хөрөнгө оруулчих стратегийн ач холбогдол бүхий гүншүүдэд хувьчлахаас өөр арга байхгүй. Эзнээ зөв олохын тулд нэлээдийг нь гадаадынханд өгөхөөс өөр арга байхгүй. Ирэх дөрвөн жилийн өмч хувьчлалд алдах эрх бидэнд байхгүй». Байхгүй, байхгүй, байхгүй...

«Говь»-ийн тендер оролцоод санхүүгийн санал дутуу дулимаг шалтгаанаар хасагдсан үлдэх компаниуд яагаад чимээгүй өнгөрсөн юм бол? Тэд бүгд Монгол талын оролцогчтой. Зарим нь «Нэгэнт энэ салбар, энэ бүтэц дээр цаашид ч хамтран ажиллах тул» маргалдахаас зайлсхийж буйгаа илэрхийлжээ. Таван жилийн уртад үнэ цэнтэй компаниудын хувьчлалын түүх иймэрхүү өнгө будгаар бичигдэн үлджээ. «Caltex-урт аяны үнэнч анд» гэх сурталчилгаа ВВС-гийн мэдээллийн завсар чөлөөгөөр телевизийн дэлгэц дээр үзэгдэнэ. Танил нэр байх чинь. Caltex манай муу НИК-ийг авах шахсан удаатай. НИК-ийг сонирхогчдын дунд Америкийн лав хоёр компанийн нэр явсан юм. Таван жилийн өмнөх явдал л даа. Тэр үед тус компанийг тэргүүлж байсан С.Энэрэлт агсан «Гадаадын 4-5 компани манай хувьчлалд оролцох сонирхлоо илэрхийллээ. НИК 1993 онд улсын хэрэгцээг 100 хувь хангаж байсан. Тэгвэл уг үзүүлэлт 1998 онд 56 хувь болж буурлаа. Энэ оны (1999) гуравдугаар улиралд багтан хувьчилчихвал компани өвлийн бэлтгэлээ гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран базаана» хэмээн тайлбарлаж байлаа. Энэ бол 1999 оны зургадугаар сард тэмдэглэсэн ишлэл. Тэр цагт ТӨХ-ны дарга З.Энхболд бас л мөрөөдлийн илтгэлүүд тавьж явсан санагдана. «Хамгийн амин чухал компаниудыг хувьчлах ажлыг 1999 оны есдүгээр сард багтаан дуусгахаар төлөвлөж байна». Осолтгүй ингэж хэлсэн юм шүү. Тэгвэл өнөө «амин чухлууд» хадамд очилгүй хөгширчээ. Caltex НИК-ийг нэгэн цагт авах шахсан талаар одоо яривал үлгэр мэт санагдана. Цаг хугацаатай зэргэцэн компаниудын маань бизнесийн үнэ унажээ.

Их хувьчлалын түүх сунжирсан шалтгааныг улстөрчид сайн мэднэ. Тэд үнэ цэнтэй компаниудын хувьчлалыг зохион байгуулалттайгаар хэрхэн саатуулж байсныг санаарай. Үр дүнд нь амин чухал газрууд маань хямдхан саарал компаниуд болон хувирсан. Үнэ цэнтэй хэмээн тодруулсны учир нь хувьчлалын дараа Монгол Улсын эдийн засагт өндөр байр суурь эзлэх, өгөөжөө хаях ёстойг илэрхийлсэн утга. Гэвч тэр учир утгыг улстөрчид өөрсдөө бүдгэрүүлжээ. НИК-ийг худалдах асуудал УИХ-ын чуулгад 1999 оны сүүлээр анх орсноосоо хойш лав 14 удаа эргэж буцсан түүхтэй. «Доод үнэ нь дор хаяж 14 тэрбум байх ёстой компанийг долоохон тэрбум төгрөгөөр зарах гээд буйг ойлгохгүй юм. Зөрүүн дээр нь ажиллах гээд байна» гэсэн хардлага тэр үеийн цөөнхийн зүгээс гарсан юм. Өдгөө Caltex компани Арабын ертөнцөд том төсөл

хэрэгжүүлж буй мэдээ интернэтээр цацагдаж байна. НИК нэг удаа ийм сүйт залуутай байлаа, хөөрхий.

Улс төрийн намууд харилцан зөвшилцөж байж шийдэх асуудал гэж байх ёстой. Тэдгээрийн нэг нь их хувьчлал. Гэвч их хувьчлалын монгол түүх хэдийнэ бичигдэж, сурвалжлагч бид гэрч нь болжээ. Өөр гэрч бас бий. «Баренц»-ийг Танд дахин танилцуулъя. Зөвлөгөө өгдөг дэлхийн таван том компанийн нэг КРМГ-ийн охин «Баренц» бүлэг нь... гэж эдний танилцуулга эхэлдэг. Хувьчлалын хөтөлбөр хэрэгжүүлэхэд Монголд туслахаар 1998 онд Олон улсын хөгжлийн агентлагтайгаа гэрээ байгуулсан. ОУХА нь Америкийн татвар төлөгчдийн хөрөнгөөр санхүүждэг. Тэгэхээр «Баренц»-ийнхан цалингаа хаанаас авч буй нь ойлгомжтой. Тихотский, Жеф Витни, Д.Гантуг, Д.Цэцэн, Ч.Хүрэлбаатар нар эртний кино хальсанд үлдсэн хүмүүс шиг эргэн санагдах чинь. «Баренц»-д олон сайн мэргэжилтэн ажиллаж, Монголын өмч хувьчлалд үнэтэй зөвлөгөө өгч байлаа. Харин сүүл рүүгээ тэдний идэвх, нөлөө мэдрэгдэхээ больсон юм.

Худалдаа хөгжлийн банкны хувьчлал ч хачин сонин намтартай. М.Энхсайханы засаглалын үед нийт хувьцааных нь 30 хувийг ажиллагсад нь үнэгүй хуваан авч, гэхдээ дийлэнх хэсгийг удирдлагууд нь хүртсэн. Үлдэх хэсгийг худалдах үед сонирхолтой хэрүүл өрнөв. «Жералд Металлз-Лугано» консорциум Н.Энхбаярынх, эсвэл О.Чулуунбатынх, үгүй бол зүгээр л «Ийст Ойл» шиг дээрэмчид байгаа. Ийм хардлага улс төрийн сөрөг хүчний ой тойнд хоногшжээ. Харюу болгож Монголбанкны ерөнхийлөгч «ХХБ цаашид маш сайн ажиллана гэдэгт би зуун хувь итгэлтэй байна. Энэ бүхнийг цаг хугацаа харуулна» гэв. Бие биеэ хардсан үл итгэлцэл, сэмхэн явуулгуудын дунд үнэ цэнтэй компаниудын маань үнэлэмж тааруу хувьчлалууд явагдсаар одоо өндөрлөх замдаа ороод байна.

Өндөр хоршоог худалдсан түүхээс мордохын хазгай болсон Монголын их хувьчлал олон бизнесийг шатааж, заримыг нь баярлуулсан. 1995 онд Их дэлгүүрийг авахаар гурван сая ам.доллар тавьсан эмэгтэйг нийтээрээ хардав. Сайтар улстөржсөний эцэст хувьчлал буцаж, 2000 он гарах үест өндөр хоршоо маань өмнөхөөсөө хамаагүй бага үнэтэй болж орхисон байлаа. «Цаг хугацаа бүхнийг харуулах» тухай О.Чулуунбатын ишлэлийг давтах хэрэг гарах нь. Эдүгээ Их дэлгүүрийн дэнчинд гурван сая ам.доллар тавин шатаж үзсэн Сүхээ захирал юу хийж чадах байснаа өнөөгийн «Түшиг» дэлгүүрээрээ чимээгүйхэн үзүүлэв. Гэхдээ Сүхээ болон түүний хүү Баттүшиг хэвлэлийнхнээс зугтдаг зантай. Яг П.Цэнгүүн шиг. Хувьчлалын монгол сургамж хүмүүсийн тархи толгойд ийм үл мөрөө үлдээжээ. Улс төрд үйлчилсэн элдэв гүтгэлэг, зохиомол мэдээллүүд нь их хувьчлалын өөр нэг парадокс юм.

Үнэ цэнтэй компаниудын жагсаалт эдүгээ шингэрчээ. Хэнийг, хэрхэн хардаад явснаа шалгаж харах цаг хугацаа харин өмнө байна.

**Үнэ цэнтэй  
компаниудын  
жагсаалт  
эдүгээ  
шингэрчээ.  
Хэнийг,  
хэрхэн хардаад  
явснаа шалгаж  
харах цаг  
хугацаа харин  
өмнө байна.**

# Монголын банкирууд юунаас айдаг вэ?

*Л.Гүндалайгийн хийрхлээс хэд дахин чухал байж мэдэх эдийн засгийн реформууд гарааныхаа цэгт иржээ. Үйл явдлыг ийн харьцуулахдаа, 2006 онд эх орны банк санхүүгийн болоод бизнесийн орчинд хийхээр төлөвлөсөн томоохон өөрчлөлтүүдийн ач тусыг эртнээс ойлгож, анхаарал хандуулах учиртайг онцлов.*

Банкны шинэчлэлийн жил айсуу. Өнгөрсөн 15 жилд Монгол Улсад арилжааны банкууд мэндлэн, капитализмын «эрүү шүүлтээр» ороод, шалгарсан нь энэ өдрийнхөө хөгжлийн түвшинд хүрчээ. Харин 2006 онд арилжааны банкуудад их цэвэрлэгээ хийхээр Монголбанк төлөвлөөд байна. Өдгөө мөрдөж буй дөрвөн тэрбум төгрөгийн дүрмийн сангийн хязгаарыг хоёр дахин өсгөх тухай яриа Танд ямархан сонсогдоно вэ? «Цэвэр цусны» арилжааны банкуудтай болох реформын эхний шатанд жижгүүд дампуурлаа зарлаж, зарим нь нэгдэн хүч хавсраад, нөгөө нь гадаадын хөрөнгө оруулалт дагуулж ирэх буй за. Энэ үйл явцын үр дүнгээс харилцагч-иргэн Та бага хүүтэй зээл, банкны найдвартай үйлчилгээг хүлээж байна. Итгэл найдвар тань биелэх болов уу?

Арилжааны банкуудаа чанаржуулах арга хэмжээг авах болсон учир шалтгаан олон. Бөөрөнхийлөн хариулбал, олон улсын банк санхүүгийн үйлчилгээний стандартад жаал жаахнаар дөхөх гэсэн эхний алхам. Зовлонгоо харин дэлгэвэл юу эсийг тоочихов. Хамгийн захын арилжааны банкны нягтлангаас сонирхъё. Танайх санхүүгийн тайлан балансаа бодитой гаргадаг уу? Хэрэв амьхандаа ингэж асуувал «үгүй» гэсэн хариултыг тэр торолгүй өгнө. Өдгөө арилжааны банкууд, тэр дундаа Монголын шилдэг 10 банкны жагсаалтад багтаагүй жижгүүдийн хувьд хөрөнгө чинээгээ хуурамчаар өсгөн тайлагнадаг үзэгдэл хавтгайрсан юм. Цаашлаад, бидний жолдож буй жишээ олон. Хилийн чанадад салбараа нээхийн тулд шаардагдах дүрмийн сангийн барьцаанд байнга баригдана. БНСУ-д ажилладаг монголчууд бол ийм бэрхшээлийг нүдээр харж, нутгийн банкныхаа салбарын эрэлт хэрэгцээг яс махандаа тултал мэдэрдэг. Түүнчлэн хэт давжаа банкууд Монголын зах зээл дэх зээлийн асар их эрэлтийг хангаж дийлэхгүй байна. Жижиг зээлээс эхлээд томхон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх бэл бэнчин дутмаг тэднийг чансаажуулах арга хэмжээ буюу нэг ёсондоо реформыг талархан дэмжье. Харин уг шинэчлэлийн эргэн тойронд сайн, муу үзэгдэл гарах нь лавтай. Шинэ цагийн банкирууд юунаас айдаг вэ?

## ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙНХНЭЭС ЖИЙРХДЭГ

Арилжааны банкууд болон жижиг, дунд бизнесийнхэн хоорондоо сайнгүй. Нийт зээлийнхээ хэдэн хувийг жижиг бизнесийнхэнд өгдөг вэ гэж асуувал дуртайяа хариулах ажилтан ховор. ХАС зэрэг гадаадын тусламжийн хөрөнгөөр дүрмийн сангаа бүрдүүлдэг банкууд л бичил зээлийг бодлогоор дэмждэг буй за. Жижиг, дунд бизнесийнхэнд зээл авах хэрэгцээ нэн их бий. Харин ийм эрэлтийг мэдэрч ажиллах хүсэл олонх арилжааны банкинд байхгүй юм. Өнөөгийн банкуудын зээлийн бодлогод түгээмэл байгаа үзэгдэл бол цөөн, найдвартай зээлдэгчтэй байнга харилцах явдал. Жижгүүдтэй зууралдах цаг зав, хүн хүчний боллоццоо хаана байна, тэгээд ч бичил



бизнесийнхэн хэмээх ойлгомжгүй, найдваргүй олон этгээдтэй харилцах нь төвөгтэй. Тиймээс арилжааны банкууд хэтэвч зузаан түншүүдээ хоорондоо бараг эв найртай хувааж авсан байх агаад хэрэв гадаадаас зээлийн томоохон төсөл хөтөлбөр орж ирвэл түүнийг дамжуулан зээлдүүлэх, тэр хөрөнгийг өөртөө байршуулах арга чарга хайх сонирхолтой.

Нөгөө талаас, 20-24 хувийн өндөр хүүтэй зээлээс жижиг, дунд бизнесийнхэн халгаж хавчигнана. Ийм зовлонг нь сайн мэддэг атлаа банкууд өдий арав гаруй жилийн хөгжлийн уртад зээлийн хүүгээ шальтай буулгасангүй. Өндөр хүүгийн ашгаараа амь торгоосоор яваа арилжааны банкуудын хөлдүү менежментийг өөрчлөх нэг арга нь дүрмийн сангийн хязгаарыг хоёр дахин нэмэх тухай дээрх арга хэмжээ ажээ.

### **ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ ҮЗДЭГГҮЙ**

Банкны хүнд суртлаас эмээсэн жижиг, дунд бизнесийнхэн хаачих вэ? Хамаатан садан, танил талаасаа хэдэн төгрөг гуйна. Ийм боломжгүй нь хадгаламж зээлийн хоршоо «найз» руугаа очно шүү дээ. Тэндээс зээл авахад харьцангуй бага хүүтэй атлаа мөнгөө хадгалуулбал хүү нь өндөр. Арилжааны банкуудад бол хадгаламжийн хүү өсөхийн хэрээр зээлийн хүү их байх шууд пропорциональ зарчим үйлчлэлд байдаг. Тэгвэл хадгаламж зээлийн хоршоодод эсрэгээрээ байх аж. Ийм сонин урвуу хамаарал ард иргэдийг хоршоод руу хошууруулж байна. Явсаар, хадгаламж зээлийн хоршоодод 40-50 тэрбум төгрөг төвлөрчээ. Энэ тоо арилжааны банкууд дахь нийт мөнгөнөөс хавьгүй бага нь үнэн. Гэвч жижиг, дунд бизнесийн зээлийн эрэлт асар их байгаа цагт хоршоод нь банкны хувьд эмээхээс аргагүй залуу өрсөлдөгч билээ.

Монголбанк реформын жилийнхээ гараан дээр томоохон арга хэмжээ авахаар төлөвлөөд байна. Юуны өмнө банкнаас бусад санхүүгийн байгууллагуудыг хянаж шалгадаг Санхүүгийн зохицуулах хороонд ихээхэн найдлага тавьж буй юм. Нэг үгээр, хадгаламж зээлийн хулхи хоршоодыг татан буулгах хууль хяналт, эрх зүйн том механизм ажиллаж эхэлнэ гэсэн үг. Санхүүгийн зохицуулах хороо болоод Монголбанк эвийлэн хамгаалсны хүчинд арилжааны банкууд бяцхан өрсөлдөгчдөөсөө ангижрах магадлалтай. Харин жижиг, дунд бизнесийнхний зээлийн эрэлт хэрэгцээг яалтай вэ? Төр, засгийн баримталж байгаа гэх жижиг, дунд бизнесийг дэмжих бодлогод том эрэг шураг дугааж байна гэсэн үг. Хэрэв арилжааны банкууд өнөөгийнх шигээ зээлийн өндөр хүү дээр хоорондоо хэлэлцэж тохиролцчихоод хөдөлгөөнгүй суугаад байвал яах вэ? Тиймээс банкуудыг чанаржуулж, өөр зуур нь өрсөлдөөн бий болгох зэрэг олон олон арга хэмжээ үгүйлэгдэнэ.

### **ИРЭЭДҮЙН ӨМНӨХ АЙДАС**

2006 оны эцэс гэхэд дүрмийн сангаа хэрхэн найман тэрбум төгрөгт хүргэх билээ хэмээсэн айдас банк санхүүгийн зах зээлд оролцогчдын дунд түгээмэл болжээ. Гадаадын хөрөнгө оруулалт банкны салбарт эрчимтэй орж ирэх нь гэсэн хүлээлт, түүнчлэн жижгүүд өөр зуураа нэгдэхээс аргагүй нөхцөл байдалд орохыг өнөөдөр урьдчилан хэлчихэж хэн ч чадна. Харин энэхүү арга хэмжээний завсар заальхайгаар үлээх салхины ая зан ямар байх бол? Харилцагчийнхаа тухай нарийн ширийн мэдээллийг нэхэж шаардах боломжгүй банкныханд ямар бэрхшээл учирч болзошгүй вэ? Монгол Улсын нутаг дэвсгэрт мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэх зэрэг гэмт явдал гарах магадлал өндөр болох юм. Эдгээрт хаалт тавих хууль манайд

байхгүй. Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг даган гарч мэдэх иймэрхүү сөрөг үзэгдлээс бид урьдчилан сэргийлж, Олон улсын терроризмын болон мөнгө угаахын эсрэг хуулиа гаргах ёстой. Түүнчлэн банкуудын шинэ нэгдэл санхүүгийн том бүлэглэлийг төрүүлэх магадлалтай. Энэ нь өнөөгийн нэгэнт тогтсон чансааны эрэмбэ маягийн жагсаалтад өөрчлөлт оруулах нь мэдээж. Банк санхүүгийн бүлэглэлүүдийг «өөрийн» гэх компаниуд эгнэн хүрээлэх нь лавтай. Санхүүгийн цөөн олигархийн хаанчлал бий болж ч мэдэх юм. Тэд мөн л «өөрийн» улстөрчийг ивээлдээ аван сугандаа хавчуулчихвал мөнгө, эрх мэдлийн ийм түншлэл бүхнээс хүчтэй зэвсэг болох буй за.

Дээр өгүүлсэн санаануудаараа банкны салбарт хийхээр зэхсэн шинэчлэлийн утга учрыг айдсаар хүлэхийг зориогүй билээ. Өдгөө манай томоохон компаниуд сонгосон арилжааны банктайгаа түншлэн, зээл төлөх хугацаа зэрэг нөхцөлийг зохицон ярилцаж яваа туршлага бий. Энэ нь даамжирсаар Монголын багахан зах зээл дээр өөрийн дүрмээр тоглодог санхүүгийн бүлэглэлүүд төрөх магадлалтайг таамагласан хэрэг. Өөр нэг төлөв нь, ирэх жил, ер нь цаашид 40.000 айлын орон сууц лугаа хөтөлбөрийн хүрээнд олгох ипотекийн зээлийг дагаад банкуудын үйл ажиллагаа идэвхжих биз ээ. Ипотекийн зээл банкны ажилд дэм болох төдийгүй улс орны өмнө тулгарсан нийгмийн асуудлыг давхар шийдэх сайн талтай. Банкны реформтой зэргэцээд зээлийн барьцаа, үл хөдлөх хөрөнгийн тухай шинэ ойлголт, үнэлгээ бий болох нь ч дамжиггүй. Дүрмийн сангийн хязгаарыг найман тэрбум төгрөг болгох арга хэмжээний эцсийн дүнд зээлийн хүү мэдэгдэхүйц буурч, хүртээмж нь нэмэгдэн, банкны салбарт шинэ үйлчилгээнүүд нэвтэрнэ хэмээн иргэд найдаж байна.

2005 он

# Шинэ цагийн Гобсекууд буюу МӨНГӨ ХҮҮЛЛИЙН ХҮЛЭЭС

Гобсек гөлийсөн жавхаагүй харцаар ил галд хийсэн хэдхэн цучлыг ширтэнэ. Хөрзийж бээвийгээд ихэд даарсан атал олигтойхон гал өрдчих хүсэл түүнд алга. Зээлсэн мөнгөө эгүүлэн өгч чадалгүй, үе дамжсан үнэт нандин эдлэлээ Гобсект барьж очих язгууртнуудын зовлон, хилэнгээр энэ умгар өрөө дүүрсэн мэт...

Оноре де Бальзак өөрөө Гобсектнуудын дарамтыг үзэн ядаж, тэгсэн атлаа тэдний тэтгэлэггүйгээр амьдарч үл чадсан юм. Яг л ийм мөнгө хүүлийн хүлээс өнөөгийн Монголын нийгмийг торлоод байна. Манай банк санхүүгийн зах зээл дээр эдүгээ 17 тоглогч байх агаад тэдний халаасанд нийт 1.5 триллион төгрөг бий. 1.5 триллионоосоо 850 тэрбум төгрөгийг нь тэд бидэнд зээлдүүлжээ. Зээлийнхээ хүүг Гобсек ахынхаа туршлагаар тогтоогоод их удаж байнаа.

Бид таван жилийн өмнө тэднээс жилийн 35 хувийн хүүтэй зээл гуйдаг байлаа. Харин одоо шинэ цагийн Гобсекууд маань хүүгээ овоо буулгаад төгрөгөөр зээл авъя гэвэл 24 хувь, валютынх бол 16 хувийн хүүлэл хийдэг болжээ. Ядахад ийм зээлийн хугацаа богино. Тэглээ гээд өдөр өдрөөр өсөн дэвжиж буй эдийн засагт маань зээлийн хэрэгцээ асар их хэвээр. Эрэлт дагасан мөнгө хүүлийн хүлээс дор бид амьдарч байна. Эдүгээ Монголын банк санхүүгийн зах зээл дээр арилжааны банкуудын тогтоосон зээлийн өндөр хүүнээс аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг шууд хамааралтай болжээ. Зах зээлийн нийгэмд Монгол Улс шилжээд 16 жилийн нүүр үзэж буй ч банк санхүүгийн салбарын менежмент либералчлагдаагүй, товчоор хэлбэл эрх чөлөөгүй, асар хүнд сурталтай, арын хаалгатай хэвээр байгаа юм.

16 жилийн уртад олон олон бизнес мэндэлж, өсч дэвжихийг мэрийж байна. Гагцхүү хөрөнгийн хомсдол тэднийг хүлсэн хэвээр. Дэлхийн улс орнуудад жилийн 6-8 хувийн хүүгээр тооцдог зээл Монголын бизнесмэнүүдэд 2-3 дахин өндөр өртгөөр олддог. Манай банк санхүүгийн зах дээр тоглогчид зээлийн хүүг урт хугацааны турш өндөр байлган зөвхөн эндээс олсон ашгаараа амьдарсаар, шил толь болсон байшин сав сүндэрлүүлсээр суугааг бид мэднэ. Арилжааны банкуудтай өрсөлдөн, хөрөнгө оруулалтын хоёр дахь эх ундарга болохуйц хөрөнгийн зах зээл, даатгалын менежмент нэгэнт үгүй болохоор өнөөх л Гобсекийнхоо хүнд хөшүүн хаалгыг бизнесмэнүүд дахин дахин татахаас өөр аргагүй. Арилжааны банкууд зээлийн хүүгээр ард иргэдээсээ мөнгө хүүлэхээс өөрөөр ашиг орлогоо нэмэгдүүлэх арга байдаггүй гэж үү? Мэдээж байлгүй яахав. Монголбанкны ерөнхийлөгч О.Чулуунбатын ярианаас ишлэл авъя. «Банкны удирдлагууд ажилтнуудынхаа мэдлэг боловсролд илүү анхаарал хандуулах хэрэгтэй. Ингэснээр валют болон алтны зах зээлийн арилжаанд оролцох, улмаар ашиг орлогоо нэмэгдүүлэх бололцоо бий» гэж тэрбээр ярьж байна.

Дэлхийн бөмбөрцгийг Архимед хөшүүргээр хөдөлгөж чадна хэмээн ам бардам өгүүлсэн шиг Монголын нийгмийг ядуурлаас аврах, дундаж иргэдээ тэтгэх гол хүч нь урт хугацаатай, бага хүүтэй зээл гэдэгтэй олон хүн санал нийлэх биз ээ. Тэгвэл тэр зээлдүүлэх их мөнгө чинь хаана байнаа хэмээн асууж магадгүй. Манай эдийн засаг, иргэдийн амьжиргааг тэтгэх зорилготой хөнгөлөлттэй зээл донор орнуудаас өнгөрсөн хугацаанд чамлалтгүй орж

**Гобсек  
гөлийсөн  
жавхаагүй харцаар  
ил галд хийсэн  
хэдхэн цучлыг  
ширтэнэ. Хөрзийж  
бээвийгээд ихэд  
даарсан атал  
олигтойхон гал  
өрдчих хүсэл  
түүнд алга.  
Зээлсэн мөнгөө  
эгүүлэн өгч  
чадалгүй, үе  
дамжсан үнэт  
нандин эдлэлээ  
Гобсект барьж  
очих  
язгууртнуудын  
зовлон, хилэнгээр  
энэ умгар өрөө  
дүүрсэн мэт...  
Оноре де  
Бальзак өөрөө  
Гобсектнуудыг  
дарамтыг үзэн  
ядаж, тэгсэн  
атлаа тэдний  
тэтгэлэггүйгээр  
амьдарч үл чадсан  
юм.**



ирсэн. 6-8 хувийн хүүтэй тэдгээр зээлийг мөнөөх л Гобсек арга барилтай арилжааны банкуудаар дамжуулан олгосон билээ.

Хэрэв Азийн хөгжлийн банкны орон сууцны зээлийн анхны нөхцөлийг хүндрүүлэн, хүүг нь нэмэлгүй иргэдэд түгээсэн бол дундаж амьдралтай олон хүний амьдралд нэмэр болох байлаа. Хятадын Засгийн газраас удахгүй олгож эхлэх 300 сая ам.долларын зээл мөн л мөнгө хүүлэгчдийн гараар орж, өртөг нь өссөөр улмаар хэдхэн тооны байнгын харилцагчид нь хүрэх байх гэсэн таамаг сонсогдсоор байна. Байнгын үйлчлүүлэгч гэсэн нэр томъёог ялимгүй тодруулъя. Арилжааны банкууд олон жижиг харилцагчтай байхаасаа төвөгшөөдгийг та анзаарсан байх. Мөнгө зээлж сурсан, найдвартай гэх цөөн түншийнхээ бизнесийг тэд ивээн тэтгэдэг бичигдээгүй хуультай болжээ. Монголчууд төрийн алба дахь авлигын тухай түмэнтэй ярьж, улстөрчдийг нэр цохон улалзуулдаг. Харин банк санхүүгийн зах зээл дээр удтал ноёрхсон ужиг ялзралыг олж харж чадаагүй явна. Чухам энэ салбарт эрх чөлөө дутмагаас, хатуухан хэлбэл хаалттай байдлаас үүдэн эдийн засаг цэцэглэн хөгжих боломж хумигдсаар байна.

Банкуудын явцуурхлыг халах, цэвэр агаар оруулах алхмуудыг 2006 он гарсаар хийх гэж оролдож байна. Тухайлбал, дүрмийн санг нь найман тэрбум болгох арга хэмжээ авах гэнэ. Өөрөөр хэлбэл, ирэх дөрөвдүгээр сарын 1-ний өглөө таны сайн мэдэх аль нэг банк дансаа хаалгачихсан, банк бус санхүүгийн байгууллага нэртэй цохиж явбал бүү гайхаарай. Монголбанк жижгүүдийг цэгцэлж эхлэх нь. Мөн банк бус санхүүгийн байгууллагууд лиценз авч байж үйл ажиллагаа явуулдаг болно. Найман тэрбум төгрөгийн дүрмийн сантай болох гэж нөгөө налгар банкирууд хэсэгтэй л ажил ихтэй явна. Монголын улс төр дараагийн давлагаагаа хүлээн эвгүй чимээгүй оргих зуур банкирууд байн байн хэвлэлд ярилцлага өгч, телевизээр ярихыг уншигч, үзэгчид анзаараа биз. Зарим нь өөр зуураа нэгдэж дүрмийн сангаа арайхийн найман тэрбум болгов. Нөгөө нь гадаадаас хөрөнгө татахаар хүлээж байна. Гагцхүү тэр мөнгө тухайн банкны дансанд түр орж ирээд буцдаг молигоны зузаатгал байж ч болох. Үлдэх хэсэг нь Хадгаламжийн банк шиг яахаа мэдэхээ больж, тэнгэр ширтэн юу болохыг хүлээх аж. Хадгаламжийн банкны хувьд улсын төсвөөс хэдэн төгрөг өгөх болов уу гэсэн горьдлого тээж яваа юм. Эдүгээ банкирууд найман тэрбумын шинэтгэлийн ач холбогдлыг телевизээр дуу алдан магтацгаасаар. Ийм хэмжээний хөрөнгөтэй юм чинь ялаад тэрбум төгрөгийн зээл олгочихно, хугацаа нь ч урт байх боломжтой гэгцгээх аж. Харин иргэдийн хүсэн хүлээж буй бага хүүтэй, хүртээмжтэй зээлийн талаар үг унагахгүй нь хяслантай. Арвандолуулаа байхдаа үгсэн тохирч өндөр хүүгээр хүүлдэг байсан юм чинь өдгөө цөөрөх тусам монопольдох зам улам нээлттэй байх биз ээ.

Банкны салбарт хийж буй шинэтгэлүүд зайлшгүй алхам гэдэгтэй санал нийлнэ. Гагцхүү тэр бүх арга хэмжээний үр дүнд бага хүүтэй хөрөнгө оруулалт олдоосой хэмээн иргэд хүлээж байна. Иргэд, бизнесийнхний шаардлага шахалтгүйгээр энэ хүлээлт талаар болох нь дамжиггүй. Тиймээс цалин, тэтгэвэр нэмүүлэх гэж Төрийн ордныг тойрон жагсдаг шиг арилжааны банкуудад шахалт үзүүлж яагаад болохгүй гэж. Төрийн зүгээс боломжит аргыг яагаад ашиглах ёсгүй гэж. Япон улсын Засгийн газраас манай жижиг, дунд бизнесийнхэнд зориулан мөдхөн зээл олгох гэж байна. Дээр өгүүлсэн Хятадын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээс гадна бас арилжааны нөхцөл бүхий 100 сая ам.долларын зээл, түүнчлэн Азийн хөгжлийн банкнаас 150 сая ам.долларын худалдааг санхүүжүүлэх зээлүүд манай санхүүгийн зах зээлд орж ирэх нь. Эдгээрийг дахиад л мөнгө хүүллийн машинаар дамжуулах албатай юм гэж үү? Монголын зах зээлд мөнгө ийнхүү орж ирсээр байгаа. Гагцхүү тэдгээрийг дамжуулан зээлдүүлэгч-дотоодын банкууд хүүгээр нь

Хэрэв  
Азийн  
хөгжлийн  
банкны орон  
сууцны  
зээлийн анхны  
нөхцөлийг  
хүндрүүлэн,  
хүүг нь  
нэмэлгүй  
иргэдэд  
түгээсэн бол  
дундаж  
амьдралтай  
олон хүний  
амьдралд нэмэр  
болох байлаа.

тоглон даварч байгаа юм биш үү? Эдүгээ Монголбанк гадаадаас өгч буй зээлийн нөхцөл болох зургаан хувийн хүүг 10 хувиас битгий хэтрүүлээрэй хэмээн арилжааны банкуудаас гуйж суугааг ойлгохгүй юм.

Зөвхөн банкны нүсэр хаалгыг мөргөөд буцахгүйн тулд хөрөнгийн зах зээлээ, даатгалын системээ дэмжих цаг ч болжээ. Иргэд банкнаас зээл горьдон дугаарлах бус, үнэт цаасны арилжаанаас мөнгө босгоход суралцмаар. Сангийн яам бонд гаргаж яагаад болохгүй гэж. Төрийн мэдлийн банктай болж, түүгээрээ гадаадын хөнгөлөлттэй зээлүүдийг дамжуулан олгож ч болох. Монгол Улсын эдийн засаг цэцэглэн хөгжих гараандаа нэгэнт хүрчээ. Гагцхүү бизнесийнхний ажилсаг гарыг банкны хөшүүн менежмент тушсаар байна. Арилжааны банкуудын актив сүүлийн хоёрхон жилд бараг нэг триллион төгрөгөөр нэмэгдэх хандлагатай гэсэн урьдчилсан тооцоо гарав. Гадаадад ажиллаж, амьдардаг монголчууд их хэмжээний валютыг хадгаламж хэлбэрээр банкуудад байршуулсаар байна. Хөрөнгийн ийм таатай урсгал дунд банкирууд зээлийн хүүгээ 12, 10, бүр найман хувьд буулгах бололцоотой.

**2006 он**

# Шинэ оросууд хуучин түншдээ хөрөнгө оруулж эхэллээ

Ахан дүүсийн харилцаа ард хоцорлоо. Шинэ оросуудтай нүүр тулах эхний уулзалтын уур амьсгалын аясыг монголчууд хүлээж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ОХУ-д хийх албан ёсны айлчлал олон асуултад хариулт өгнө. Арванхоёрдугаар сарын 4-9-ний өдрүүдэд Москвад халуухан уулзалт болно гэдгийг эртний андууд аль аль талдаа мэдрэн амьсгаа даран хүлээж эхэллээ. Албан ёсны айлчлал тодотгол дор албархуу мэдээлэл, ёсорхуу хүндэтгэл хөшигний наана өрнөх нь мэдээж. Харин тэрхүү инээмсэглэл, ойлголцлын дотно агшнууд ямархан үнэтэй тусах бол?

Бид шинэ оросуудтай бүр 2000 онд нүүр хагарсан билээ. Гэвч манай удирдагчдын болоод ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин , Засгийн газрын тэргүүн Михаил Касьянов нарын Монголд хийсэн хариу айлчлалууд юуны өмнө харилцаа, хамтын ажиллагааг дулааруулах зорилго агуулж байлаа. Нүүр дүүрэн инээмсэглэл, гар барьсан дотно агшин... Гэрэл зургийн хальснаа 2000 онд үлдсэн ийм өнгөцхөн сэтгэгдлүүд хамтын ажиллагааны зөвхөн эхлэл байсан юм. Улаанбаатарын тунхаглал уриа, сайхан үгсээр дүүрэн. В.Путин зөөлөн нүдтэй, этгээд алхаатай... Эдгээр нь анхны сэтгэгдэл төдий зүйлс байсан.

Тэгж байтал 2004 оны хонгор өдрүүд Ерөнхийлөгч Путиний тухай ер бусын дулаахан сэтгэгдлийг маань улам лавшруулав. Монгол Улсын ОХУ-д төлөх их өрийн 98 хувийг тэглэлээ. Түүний тухай, түүгээр дамжуулаад оросуудын талаар хамгийн дотно үгс эдүгээ ч тасарсангүй. Володя хэмээн эрхэм Ерөнхийлөгчийг бид авгайлах шахна. Ахан дүүсийн харилцаа хэмээн өнгөрсөн зууны хэллэг рүүгээ хальтрах дөхсөн. Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны энэхүү айлчлал огт өөр өнгө аястай өрнөх гэж байна. Хоёр жилийн өмнө бидэнд өгсөн зул сарын бэлгээ оросууд сануулан ялдамхан инээмсэглэхийнхээ сацуу зөөлөн хэлбэл ажил хэрэгч саналууд, үнэн хэрэгтээ ашиг сонирхлоо түс тас хэлэхээр зэхжээ.

Шийдэл хүлээсэн олон асуудал хоёр орны харилцаанд бий болоод байна. Хэдхэн хоногийн дараа Москвад өргөн хүрээтэй яриа хэлэлцээр өрнөхийг нотлох мэт манай талаас ойрд дуулдаагүй нүсэр бүрэлдэхүүнтэй баг хөдлөхөөр бэлтгэлээ базааж гарчээ. Албан ёсны мэдээллээр бол оросуудтай «арваадхан» асуудал хэлэлцэх гэнэ. Гэвч тэр арвын шийдэл тохироо Монгол Улсын эдийн засагт үлэмж ач холбогдолтойн учир айлчлалыг угтуулан ийнхүү тэрлэв. Ерөнхийлөгчийн болоод Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албад хэдий «даруухан» мэдээлж байгаа боловч хойд хөрш маань энэхүү айлчлалд ямархуу ач холбогдол өгч байгааг төвөггүй анзаарч болно. Хоёр Ерөнхийлөгчийн уулзалт, сайд нарын хэлэлцээрийг үр дүнтэй болгохын тулд Оросын тал ойрын 15 жил үзэгдээгүй онцгой идэвх гаргаж эхэллээ. Элчин сайд ноён Говорин Ерөнхий сайдтай уулзаж, араас нь Засгийн газар хоорондын комиссын Оросын талын тэргүүн А.Гордеев манай Ерөнхийлөгчийн айлчлалын бэлтгэл ажлыг шавдуулав.

## ОРОСУУД ЮУ ХҮСЧ БАЙНА ВЭ?

Юуны өмнө , хэлэлцээний ширээний ард суух оросууд бидний өмнөх танилууд мөн эсэхийг тогтож харъя. 2000 төдийгүй 2004 оныхоосоо огт өөр эдийн засгийн нөхцөл байдалтай Орос орныг төлөөлсөн эрхмүүдтэй монголчууд нүүр тулах гэж байна. Өнгөрсөн жилүүдэд тус улсын эдийн засаг хөгжлийн араандаа орж, хөрөнгө оруулалт эрс нэмэгдэн , үйл ажиллагаагаа бүс нутагтаа өргөжүүлэх чадавхтай болжээ. Дэлхийн зах зээл дээр удтал өндөр үнэтэй байсан нефтийн ханш улс

Хоёр жилийн  
өмнө бидэнд өгсөн  
зул сарын бэлгээ  
оросууд сануулан  
ялдамхан  
инээмсэглэхийнхээ  
сацуу зөөлөн  
хэлбэл ажил хэрэгч  
саналууд, үнэн  
хэрэгтээ ашиг  
сонирхлоо түс тас  
хэлэхээр  
зэхжээ.



орны хуримтлалыг нэмэгдүүлж, их Орос улс эргэн өндийн дэвжих замыг зассан юм. ОХУ зургаан жилийн турш олон оронтой хийсэн яриа хэлэлцээрийнхээ дүнд тун удахгүй Дэлхийн худалдааны байгууллагад элсэх гэж байна. М. Фрадковын өнгөрсөн аравдугаар сард зохион байгуулсан Хөрөнгө оруулагчдын уулзалтын өнгө төрх ч их гүрэн ээлжит үсрэлтийнхээ өмнөх бэлтгэлийг базааж байх мэт сэтгэгдэл төрүүлээ. Кремлийн зуйван танхимд дэлхийн томхон компаниудын төлөөлөл цуглаж, Оросын удирдагчдын амнаас хамтын ажиллагааны саналууд сонссон юм. Айсуй өдрүүд хөрөнгө оруулалтыг эх орондоо урин дуудсан дулаарлын уур амьсгалыг амлаж байна аа гэсэн үг.

ОХУ-ын төр, засаг зөвхөн гадаадын том хөрөнгө оруулагчдад найр тавиад зогссонгүй үндэсний хөрөнгөтнүүдээ бодлогоор тэтгэн дэмжихээ ч нотлов. Юуны өмнө, тус улстай хил залгаа орнууд болон социалист системд дөрөө харшиж явсан эртний бусад анддаа хөрөнгө оруулах их аян хүрээгээ тэлж байна. Тийм улсуудын төлөх өр ширийг тэглэх, хөнгөлөхдөө чухам ийм ашиг сонирхлоо урьтал болгож буй юм. Сири, Алжир зэрэг улсын өрийг хөнгөлөх хувилбарууд нь хуучин зэвсгээ зарж «далд оруулах», улмаар хөрөнгийн шинэ эх үүсвэр хуримтлуулах хэгийн зорилго дор өрнөлөө. Өөрийн компаниудыг тэдгээр улсын зах зээлд идэшүүлэх алсын хараатай үйл ажиллагаа үргэлжилсээр байна. М. Фрадковын Засгийн газрын стратеги төлөвлөгөөнд тусгалаа олсон Монголд хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх бас нэг хувилбар гараагаа эхлэх гэж байна аа гэсэн үг.

Нэг үгээр, дэлхий ертөнцийн амьдралд далайцтай хөл нийлүүлэх эрмэлзэлтэй шинэ хөрш, өмнөхөөс өөр зарчмаар бидэнтэй харилцана. Халаасандаа мөнгөтэй, их гүрэн хэмээх алдраа эгүүлэн авах цагаан амбицтай, түүхий эдийн асар хэрэгцээтэй, гар сунган Хятад улстай дотно холбогдсон ийм хөрш хэлэлцээрийн ширээний ард тухлах нь. Ажил хэрэгч Орос оронд тодорхой саналууд бий. 2000 оныхоос огт өөр уур амьсгалд яриа хэлэлцээр өрнөнө.

### ЭХНИЙ АЛХМУУД

Шинэ оросуудын хандлага энэ жил бидэнд тун ч ойрхон мэдрэгдсэнийг сануулъя. Урд нь «Чингис хаан» банкаар, «Эрдэнэт», төмөр замын мэргэжилтнүүдээр төлөөлүүлэн харж байсан монголчуудын ойлголтыг оросууд өөрчиллөө. Тавантолгойн коксжих нүүрс эдүгээ дэлхийн томхон орнуудын сонирхлыг татаж байна. Эрчим хүчний тоймгүй их хэрэглээгээ нүүрснээс ялгарах дулаанаар хангах гэсэн америкчуудын ашиг сонирхлоос эхлээд Хятад, Японы анхаарлын төвд Тавантолгойн орд газар орчихоод байна. Яг ийм ашиг сонирхлын огтолцол дээр хойд хөрш маань төрийн өмчийн «Зарубежгео» компаниа түс тас зүтгүүлж үзэв. Монгол оронд геологийн хайгуул судалгааг төрсөн ахын ёсоор олон жилийн турш хийсэн оросууд хуучны дотно сэтгэгдэл дээр маань дулдуйдан ийнхүү цул пал гээд ирчихлээ. «Зарубежгео»-гийн халааг одоо тус улсын хувийн компаниуд залган Тавантолгойд хөрөнгө оруулах цагийг анаж эхэллээ. Уг ордын нөөцийг харахул хоёр орны хувьд удаан хугацаанд түншлэхүйц далайцтай төсөл болох билээ.

Улмаар оросууд Тавантолгой төдийгүй, манай уул уурхайн салбарт эрчимтэй хөрөнгө оруулах сонирхолтойгоо нотоллоо. ОХУ-ын Эрдэс баялгийн нөөцийн газрын дарга ноён Морозов саяхан энэхүү хүсэл эрмэлзлэлийг илэрхийлсэн билээ. Тэрбээр геологийн салбарын мэргэжилтнүүд оролцсон 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй багийг ахлан Улаанбаатарт ажилласан юм. Монголын уул уурхайн салбар дахь хувь, хувьсгалын ашиг сонирхлоо оросууд Кремльд нотлох нь эргэлзээгүй. Зарим гэрээ хэлэлцээрийг манай Үйлдвэр, худалдааны сайд Москвад зээглэх нь бараг тодорхой болоод байна.

**Халаасандаа мөнгөтэй, их гүрэн хэмээх алдраа эгүүлэн авах цагаан амбицтай, түүхий эдийн асар хэрэгцээтэй, гар сунган Хятад улстай дотно холбогдсон ийм хөрш хэлэлцээрийн ширээний ард тухлах нь. Ажил хэрэгч Орос оронд тодорхой саналууд бий. 2000 оныхоос огт өөр уур амьсгалд яриа хэлэлцээр өрнөнө.**

Хуучин ахын шинэ дүү нар эх нутагт минь үүрээ хэдийнэ засч, төвхнөөд

эхэлснийг эргэн сануулъя. С.Громовын «Чингис хаан» банк Монгол дахь үйл ажиллагаагаа мэдэгдэхүйц тэллээ. Хадгаламж банкнийг «Чингис хаан» оролцсон консорциум худалдаж авсан болохоор шинэ оросуудын үйл ажиллагаа санхүүгийн тал дээр хүндрэлгүй өрнөх нь. Даатгалын салбарт ч түшиц газартай болсныг нь нуух юун. Хоёр Ерөнхийлөгчийн үзэглэх мөнөөх арваад асуудлын дунд эрүүл мэнд, боловсролын салбарт цаашид түншлэх төлөвлөгөө ч багтжээ. Улаанбаатарт аравдугаар сард нээгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэнд оролцохоор Оросын бизнесмэнүүд олноороо ирж байсныг нь сана. «Танай зах зээл дээр ажиллалаад үзье гэж шийдсэн» хэмээн Аэрофлотын онгоцонд суудал ойролцоо таарсан залуу ярьж байсан юм. Өөрөөр хэлбэл хоёр орны хамтын ажиллагаа илүү бодитой өрнөх цаг иржээ. Хамтын ажиллагааны эрх зүйн баталгаа болох учиртай 2006-2015 он хүртэл худалдаа, эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллах баримт бичигт Ерөнхийлөгч нар Москва хотноо гарын үсэг зурна.

### ХАЛУУН СЭДЭВ

Тус үйлдвэр  
дэх Монголын  
талын 51  
хувийн оролцоог  
бага ч атугай  
нэмэгдүүлэх  
санал өвөртлөөд  
манай албаны  
хүмүүс Москваг  
зорьсон бол  
оросууд  
өөрсдийн  
оролцооны хувь  
хэмжээг мөн л  
өсгөх шаардлага  
тавиад өөдөөс  
нь хараад  
суучихжээ.

А.Гордеев, Б.Говорин нарын манай Засгийн газраас шавдуулж нэхээд байгаа айлчлалын бэлтгэл ажил гэдгийн гол хэсэг нь хамтарсан «Эрдэнэт» үйлдвэр, Монголын төмөр замд хийх өөрчлөлтийн асуудал. Хэдхэн хоногийн өмнө Москвад өндөрлөсөн «Эрдэнэт»-ийн Зөвлөлийн хурал анхаарлын тэмдэгтэй цөөнгүй асуудал сөхөөд, нэгдсэн ойлголцолд хүрч чадалгүй өндөрлөсөн юм. Тус үйлдвэр дэх Монголын талын 51 хувийн оролцоог бага ч атугай нэмэгдүүлэх санал өвөртлөөд манай албаны хүмүүс Москваг зорьсон бол оросууд өөрсдийн оролцооны хувь хэмжээг мөн л өсгөх шаардлага тавиад өөдөөс нь хараад суучихжээ. Халуухан уур амьсгалд болсон Зөвлөлийн хурлын шийдээгүй асуудал эдүгээ Кремльд тэр янзаараа хүрэх вий хэмээн оросууд эмзэглэж байна. Тиймээс ч «Айлчлалын бэлтгэл ажлыг» шавдуулах цуврал бараалхалт саарал ордонд үргэлжилжээ.

Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ ханш огцом өссөн, Орос, Хятад улсуудад зэсийн хэрэглээ нэмэгдсээр байгаа хүчин зүйлс ашиг сонирхлоо тийнхүү огцом илэрхийлэх шалтгаан боллоо. Зэсийн экспортоос улсын төсөвт орж байгаа ихээхэн орлого уг хэлэлцээрийг яах аргагүй манай үндэсний ашиг сонирхол шингэсэн эмзэг үйл явдал болгоод байна.

Түүнчлэн «Монголросцветмет»-ийн ирээдүй хөршийн маань анхаарлын төвд байна. Хамтарсан үйлдвэрүүдийн удирдлагыг мөн л хамтын менежментээр хийх хатуу шаардлагыг Оросын тал эрчимтэй тавих боллоо. Н.Энхбаяр, В.Путин нарын албан ёсны уулзалтын наана оросуудын урьдчилан тохиролцохыг хүссэн бас нэг асуудал нь төмөр замын удирдлагын тухай яриа. Өнгөц харахад төмөр замд шинэчлэл хийх зайлшгүй шаардлагын талаар ярьж буй боловч хамтарсан нийгэмлэгийн дүрмийг өөрчлөх «нюанс» тэнд нуугдаастай. ОХУ-аас зүүн хойд Азийг чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр Монголын төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээврийн урсгалын хэрэгцээ өснө. Ийм шаардлагаар манай төмөр замыг шинэчлэх асар их хөрөнгө оруулалтын асуудал шийдлээ хүлээж байна. Өөрийн нутгаар дамжин өнгөрүүлэх ачаанаас ахиухан мөнгө олох сонирхол манайд байхад хамтрагч маань тээврийн хямд өртөг хүсэх нь зүй. Энэ мэтээр ашиг сонирхлын багагүй зөрчил үүсээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийг дагалдан явах нүсэр бүрэлдэхүүнд мөн бизнесийнхний баг багтжээ. Манай нефть импортлогч компаниудын төлөөлөл Оросоос нийлүүлэх шатахууны хэмжээг нэмэгдүүлэх тухай яриа хэлэлцээнд оролцох аж. Нэг үгээр, бидний хувьд амин чухал олон асуудлыг хөндөн ярилцах онцгой ач холбогдолтой айлчлалын бэлтгэл ажил халуухан өрнөж байна. Ирэх өдрүүдэд хуучны анд маань бөөн бөөнөөрөө хөрөнгө оруулах нь гарцаагүй.

# Монгол дахь Оросын монополь

Монгол Улсын эдийн засагт хөрөнгийн шинэ хуваарилалт явагдаж байна. Төрийн өмчийн хорооноос өнгөрсөн жил зарлан зохион байгуулсан олон улсын нээлттэй болоод хязгаарлагдмал тендерүүдийн дүнд манай томоохон объектууд шинэ эздийн мэдэлд очив. Эдгээр дахин хуваарилалт нь төрийн өмчийг хувьчилсан өмнөх ажлын дүнтэй нэгдээд сонин дүр зураг илэрхийлэх боллоо. Өмчийн газрын зургийг өмнөө дэлгэцгээе. Монгол нутаг дахь оросуудын нөлөө эрчимтэй өсч байгааг хараарай. Шинэ оросуудын бизнес төлөвлөгөөнд хөршийн нутагт хөрөнгө оруулах сонирхол түлхүү үзэгдэж эхлэв. Ийм ашиг сонирхлыг ОХУ-ын төр, засаг бодлогоор дэмжиж байна. М.Фрадков 2007 оныг Хөрөнгө оруулалтын жил болгон зарлалаа.

Өнгөрсөн оны есдүгээр сард Оросод хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг Кремль зохион байгуулсан билээ. Дэлхийд нэр хүндтэй, үндэстэн дамнасан компани корпорацын удирдлага оролцсон тэрхүү уулзалтын явцад хөрөнгө оруулагчдыг дэмжин туслахаа Засгийн газрын тэргүүн зүйл бүрээр нотолж байлаа. Ийм арга хэмжээний зэрэгцээ хилийн чанад дахь Оросын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжинэ гэдгээ М.Фрадков илэрхийлэв. Засгийн ам ажил хэрэг болж буйн нотолгоо «нүд ирмэхийн зуурт» мэдрэгдэж, ОХУ-ын Хөдөө аж ахуйн банк Монголд 100 сая ам. долларын зээл олгохоо хоёр оны заагт зарлалаа. Хөршийнхөө хөдөө аж ахуйн салбарыг дэмжих тодотголтой энэхүү зээлд «Засгийн газар хоорондын комиссын хамтын ажиллагааны хүрээнд» гэсэн малгай өмсгөжээ. 100 саяын зээл нь цаашид нэг тэрбум ам. долларт хүрэх магадлалтай гэнэ. Оросууд хөршдөө дорвитой хөрөнгө оруулах гэж буй мэт сэтгэгдэл төрүүлэх уг алхам нь үнэн хэрэгтээ өөр зуураа бие биеийнхээ бизнесийг дэмжсэн явдал болохыг харж болно.

ОХУ-ын төрийн мэдлийн банкнаас өгөх зээл нь Хадгаламж банкаар дамжин Монголын зах зээлд орж ирэх нь. Хадгаламж банкийг А.Громов тэргүүтэй «Чингис хаан» банк оролцсон бүлэглэл хувьчлан аваад удаагүй байна. Чухам энэ баг «Монгол даатгал»-ыг хувьчлан авсныг бид мэднэ. Ийн Оросын аж ахуй, санхүүгийн бүлэглэл манай зах зээлд туйлын зохион байгуулалттай нэвтэрч эхэллээ. Бүлэглэл гэдэг үгийг монголчууд дадсанаараа мафи хэмээн ойлгож мэдэх юм. Төр, засаг нь түшиж дэмжээд лоббидож байгаа болохоор арай «мафидахгүй» биз ээ хэмээн найдаж байна.

Гэсэн ч ОХУ-ын Хөдөө аж ахуйн яамны газрын дарга ноён В. Морозов өөрийн биеэр морилон ирж 100 саяын зээл өгнө, үүнийгээ Монголын махны бизнесийн салбарт зарцуулна хэмээн ил тод зарлахыг сонсохул мафи орж ирлээ хэмээн муухай нэрлэх хэрэггүй хэдий ч болгоомжлох шалтгаан мундахгүй байна. Юутай ч Монголын махны зах зээлд оросууд бүрэн ноёрхлоо тогтоох цаг тун ойрхон харагдана. Тус улсын Засгийн газар манай махны экспортыг «Бурятмясопром» гэх нэг компанийн мэдэлд үлдээчихээд олон жил өнгөрснийг үндэсний үйлдвэрлэгчид андахгүй. Уралын өндөр уулсыг давж гаталж дийлэхгүй байсан манай экспорт «Бурятмясопром»-ын экс босс В.Морозовын хяналтад дахин орлоо гэсэн үг. Гэхдээ энэ удаа албан ёсоор мэдэлд нь шилжлээ гэх үү дээ. Тиймээс түүнийг ноён Морозов хэмээн авгайлахаас горьгүй. 100 сая ам. долларын зээл мөдхөн «Дархан мах экспор»-гийн хувьчлалд хүчин зүтгэх сурагтай. Монгол малын махыг боловсруулж, Сибирийн тойргийн хүн амын махны их хэрэгцээг найдвартай, хямд зардлаар хангах төрийн бодлого энд харагдаж байна.

**Оросын аж ахуй, санхүүгийн бүлэглэл манай зах зээлд туйлын зохион байгуулалттай нэвтэрч эхэллээ.**

Монголын арилжааны банкууд дунд дүрмийн сангийн хэмжээгээр дээгүүрт нэрлэгдэх «Чингис хаан» банк, түүн дээр Хадгаламж нэмэгдээд, «Монгол даатгал» хүч хавсран зөвхөн махны бизнес төдийгүй үр тарианы үйлдвэрлэлд хөрөнгө оруулах хандлагатай. Өөрөөр хэлбэл, манай улсын стратегийн нэг чухал салбарт оросууд нөлөөгөө тогтоож байна. Тэгвэл мөн л өөр нэг салбарт өмнөд хөрш тэргүүлэн хөрөнгө оруулж буйг бид мэднэ. Хэдэн жилийн өмнө Канад, Америкийн компаниуд манай уул уурхайд дангаараа хөрөнгө оруулж ажлаа эхэлсэн бол өдгөө тэдгээрийн хувьцаа зугуухан хятад эздийн гарт очих болжээ. Тамсагийн сав газарт намирах СОКО компанийн далбаа эдүгээ Хятадын компаниудынхаар солигдов. Өнгөрсөн жил манай улсад гадаадаас хөрөнгө оруулсан үзүүлэлтийн 30 хувь нь зөвхөн өмнөд хөршийн компаниудад хаяглагджээ. Гаднаас урсан ирэх их мөнгө эх орны хөгжил дэвшлийг алхам алхмаар урагшлуулна гэдэгт эргэлзэхгүй. Гэвч тэрхүү мөнгөн урсгалыг хэрэгтэй газар нь чиглүүлэх, эрэг далангаа сэт татан хамжаарга алдахаас сэргийлэх үндэсний бодлого аль ч засгийн толгойд байх ёстой. Өнгөрсөн жилүүдэд бид төсвийн хомсдол дунд амь зууж, ахиухан хөрөнгө орж ирэх бүрийд алга тосон угтдаг байжээ. Тэгвэл энэ өдрүүдэд дэлхийн бизнесийн газрын зурагт Монголын «дэлгэсэн тэрлэг» шиг нутагт нэгдэж нийлээд байна. Тэнд хагтахыг хүссэн туг болгон ашиг сонирхол чирж яваа. Ашиг сонирхлуудын хэмжээ дамжаа, харьцааг зохицуулахын тулд төрийн бодлого байх учиртай. Монголын ураны ордуудыг Орос, Хятадын компаниуд сонирхож байна. Тавантолгой руу хэдэн ч толгой «өнгөлзнөв» дээ.

Том хөршүүдийн дунд орших ашигтай зах зээл байх бодлогыг монголчууд дэмждэг. Энэ нь хөрсөн дорх баялаг болоод өнөөдрийн идэх уух мах, талхаа бусдын нөлөөнд оруулаад зүгээр өгчихнө гэсэн үг биш ээ. Төрийн өмчийн хорооныхны тайлагнаж буйгаар 2006 онд төсөвт оруулахаар төлөвлөсөн 14.3 тэрбум төгрөгийн орлогыг давуулан биелүүлж 37 орчим тэрбумыг төвлөрүүлжээ. Хэн их мөнгө өгсөнд нь үндэсний стратегийн тодотголтой объектуудаа өгөөд байх эсэхийг эргэн бодууштай. Монгол Улсад бизнесийн салбарын хувьчлал үндсэндээ дуусч байна. Одоо «Эрдэнэт» үйлдвэр болоод зам харилцаа, эрчим хүчний салбарыг төр хэсэгтээ өөрийн мэдэлд байлгах гэнэ. Тэдгээрийн хувьчлалыг эхлэхийн өмнө бодож болгоох асуудал бий.

Монголыг дэлхийн хөрөнгө оруулагчид анхаарч сонирхдоггүй байсан цаг улирч, том улсуудын нөлөө бүхий компаниуд уудам нутагт маань айлсан буулаа. Тэгэхээр тэдний эрх ашгийг бид зохицуулах бодлоготой байх учиртайг эргэн сануулъя. ОХУ, Хятадын хөрөнгө оруулалт жил ирэх тусам нэмэгдэнэ. Ирсэн болгоныг, салбар бүрт алга тосон аваад байх уу? Татварын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг бид мөрдөөд эхэллээ. Ийм нөхцөлд үндэсний томоохон компаниуд маань өсч томрох үүд хаалга нээгдэж байна шүү дээ. Багахан зах зээл дэх ирээдүйтэй бүх үйлдвэрлэлээ гадаадын бизнесийнхэнд өгөөд, үр ашгийг нь өнөө маргаашийн төсвийн гүйцэтгэлээр хэмжээд суух гэж үү.

# Төсвийн хөрөнгөөр тоглосон тендерийн явдлууд

Мэндлээд ганц жил илүүхэн болсон нэгэн хуулийг дахин засч сайжруулахаар барьж авах нь ээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай гэсэн урт нэртэй юм. Иргэд өөр зуураа энэ хуулийн алдрыг товчлоод «Тендерийн» хэмээн хэлэлцдэг. Тендер гэх үг араасаа авлига холбоос дагуулаад олон жилийг элээж байна. 2005 оны арванхоёрдугаар сард урт гуншинтай энэхүү хуулийг баталсан билээ. Төсвийн хөрөнгөөр тоглож, төрийн албыг авлигаар торлох үзэгдлийг цэгцлэх санаатай батлан гаргасан хууль маань үүргээ биелүүлж нэг их гавьсангүй. Өөрөөр хэлбэл амьдралд түүнийг зориуд хэрэгжүүлсэнгүй.

Уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал бэлтгэсэн гишүүдийн урмыг хугалах гэсэнгүй. Харин «Тендерийн» тухай хуульд шигтгэх гэсэн шинэ санаа нь давгүй сайн боловч дутуу дулимаг засвар болох нь гэдгийг эртхэн дуулгая. Нэгэнт хуульд нэмэлт, өөрчлөлт хийх юм бол нухацтайхан хэлэлцэж, байн байн сөхөөд хоёрдмол санаанаас нь болж хэрэлдэх явдалгүй нэг мөр шинэчилбэл дээрсэн. Өдгөө Р.Буд нарын гишүүдийн хуульд тусгах гэсэн үзэл бодлого нь тендерүүдэд дотоодын компаниудаа дэмжин оролцуулах замаар нийтийн хөрөнгийг үндэсний бизнесмэнүүдэд хүртээх тухай эх оронч санаачлага. Сайхан санаачлагыг нь гар өргөн дэмжээрэй. Гадаадын хөрөнгө оруулагчдын тендерт оролцох босгыг өндөрлөөд өгсөн өөрчлөлт байгаа юм шүү.

Тэгвэл манай гишүүдийн мартаж орхисон хэсэг юу вэ гэвэл тендер, авлига хоёрыг холбоо үгсийн сангаас арчиж хаях арга зам энд алга. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай байлаа гээд тендер тойрсон хэл ам тасарсангүй. Өдгөө Завхан аймгийн Отгон, Түдэвтэй тэргүүтэй нэр бүхий хэдэн суманд босох шахсан эмнэлгийн барьж дуусаагүй барилгын «тууринд» зориулан дурсгалын самбар хийлгэмээр санагдана. «Авлигатай тендерийн нэрэмжит туурь» хэмээн нэрлэсэн ч хилсдэхгүй. Энэ бол дөнгөж 200-300 сая төгрөгийн төсөвтэй тендер амьдралд хэрэгжсэн жишээ. Тэгвэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтаар тэрбум, түүнээс дээш үнийн дүнтэй тендерүүдийг зохицуулж байгаа. Дээр өгүүлсэн ганц жишээ нь олон улсын байгууллага, донор орнуудын Монголд зориулсан тусламжийн хөрөнгөөр хэрхэн тоглодгийг илэрхийлэх бага шиг баримт билээ. Сумдын эмнэлгийг сайжруулах нэртэй хөтөлбөрийг Монгол Улсын уудам нутагт Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй юм. Буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл бүр эргэн төлөгдөх учир жанцантайг, үгүй ядаад энэ удаа итгэл давал дараагийн сайн төсөл орж ирэх виз болдгийг бид мэднэ ээ.

Зээл, тусламжийн хөрөнгө хэрхэн үрэгдэж дуусдгийг, үр дүн нь яаж замхардгийг харуулах сонгодог жишээ олон. Тэгвэл тендерийн тухай хуулиар зөвхөн гаднаас орж ирж буй их хөрөнгөөр худалдаж авах бараа, үйлчилгээний тухай ярьдаг юм биш. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх захиалга бүрийг уг хууль зохицуулдаг. Зохицуулдаг ч гэж дээ. Замруулдаг болоод удаж байна. Монголд зарласан тендерийн үнийн дүнгийн тал хувьтай нь тэнцэх хэмжээний мөнгө уг ажлыг «олж өгсөн» хүний халаасанд ордог гэсэн судалгааны дүн гарчээ. Түүнчлэн Transparency International байгууллагын судалгаанд авлигач түшмэлд нийт үнийн 30 хувь очдог гэсэн ерөнхий дүгнэлт харагдав.

Гадаадын зээл, тусламжийн болон дотоодын хөрөнгө оруулалтад зориулан

**«Авлигатай тендерийн нэрэмжит туурь» хэмээн нэрлэсэн ч хилсдэхгүй. Энэ бол дөнгөж 200-300 сая төгрөгийн төсөвтэй тендер амьдралд хэрэгжсэн жишээ.**



төсөвлөсөн их мөнгө хэний халаасыг түнтийлгээд байна вэ? Ерөнхийд нь төрийн албаныхны гэж тоймлож болно. Тэр дундаа тендер хамгийн их зарладаг «ашигтай» яамд, үйлдвэрийн газрын сайн эрс улсын хөрөнгө тонших өргөн бололцоотой. Цохож дурдвал, Эрүүл мэнд, Батлан хамгаалах, Түлш , эрчим хүчний яамдад , мөн тоног төхөөрөмж, техник нийлүүлэх тендерт хамгийн «өртөмхий» «Эрдэнэт» үйлдвэрийг нэрлүүштэй. Нэр дурдсан байгууллагын мэргэжилтнүүд ийм дүгнэлт үзээд гомдож гоншигнохгүй биз ээ хэмээн найдъя. Судалгааны дүнд, тендерт хамгийн олон оролцсон газруудаар дээрх яамд тодорсон билээ. Яам, агентлагийн мэргэжилтнүүдийн дээгүүр УИХ-ын гишүүд тендер «авч өгөх» бололцоотой. Чухам тэдний лообий хүчтэй байж гэмээнэ ахиухан үнийн дүнтэй сайн тендерийн эзэн болох магадлалтай. Өөрөөр хэлбэл, авлигад хамгийн өртөмхий эмзэг бүлгийн эрхмүүд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль баталж, одоо нэмэлт, өөрчлөлт оруулахаар зэхээд байна. Тиймээс яг энэ хуулийн хэлэлцүүлэг дээр иргэд санал бодлоо илэрхийлэн идэвхтэй оролцоосой хэмээн уриалъя. Тэгэх тусмаа төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх жилүүдийнхээс эрс нэмэгдэх хандлагатай энэ оны хувьд тендер тойрсон авлига гаарч мэдэх юм шүү.

Тендерийг авлигатай холбон том дуугарах атлаа тодорхой жижээ татаж чадахгүй байгааг минь уншигч та харж байна. Авсан, өгснийг хэн ч нотолж чадахгүй атлаа буруу гар төсвийн халаас нимгэлээд байгааг үр дүнгээс нь бид харж шуугисаар байгаа. Тендерүүд будилж, үр ашиггүй хөрөнгө цацагдаж, эцэст нь шүүх цуухдаа тулсан тохиолдол болгон нэгийг өгүүлнэ. Бүх тендер буруу гараар орсон гэхгүй. Тэгсэн атлаа бүгд сүүдэр мэт хардлага дагуулахын учир юу вэ?

Transparency International байгууллагын судалгаанд авлигач түшмэлд нийт үнийн 30 хувь очдог гэсэн ерөнхий дүгнэлт харагдав.

58 зүйлтэй дэлгэрэнгүй гэгч хууль батлахдаа том онгорхой цоорхой үлдэсэнээс хардлага сэрдлэг үүдэлтэй. Хуулийн зургадугаар зүйлд «Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална» гэсэн ганц өгүүлбэр бий. Энэ өгүүлбэрийн ид шидэд хэт итгэж орхисноос болоод тендерийн явцыг хянах механизм зэвэрч мууджээ. Ил тод байх зарчмыг цаасан дээр тунхаглаад л орхисон хэрэг. Тендер зарлахын өмнө үндэсний хэмжээний өдөр тутмын сонинуудад зар өгнө, бусад хэвлэлээр мөн оролцох урилгыг тавина, үнийн дүн ахиу тендерийн тухай Сангийн яам болон зарлагч байгууллагын вэб сайт дээр мэдээлнэ гэх мэтээр өнгөц харахад нарийн ширийн бүх зүйлийг хуульд тусгасан мэт. Тэгвэл тендер зарлахаас хэд хоногийн өмнөөс түүнийг зарлаж эхлэх вэ, оролцох урилгаа сонинд тавьдаг юм байж, тендерийн үр дүнг мэдээлээгүй тохиолдолд ямар хариуцлага оногдох вэ зэргийг мартаж орхисон харагдана. Ер нь тендер шалгаруулалтын үр дүнг мэдээлэх ажил бүрмөсөн мартагдсан, хуульд ийм заалт байгааг мэдэх ч мэдээгүй дүр эсгэн чимээгүй өнгөрөөсөөр байна. Жил гаруйхны хугацаанд хэрэгжсэн шинэхэн хуулийн зарим заалт мартагдаж эхэлсний хариуцлагыг Сангийн яамны түшээд хүлээх учиртай. Хуулийг төгс хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар журмыг тус яам эрхлэн гаргах ёстой атал мөн л мартагдсан байх юм. Ганцхан жилийн өмнө баталсан хуулиа эргэж нэг хараарай, эрхмүүд ээ. Төсвийн хөрөнгө оруулалт илт нэмэгдэх энэ жил бүр сайн нягталж үзмээр заалт энд олон байна. Авлига, тендер хоёрын ах дүүсэг сүлбээг салгах механизм хуульд үгүйлэгдэж байгаа. Олон нийтэд тендер зарлах гэж байгаагаа хар үгээр бол эртхэн мэдээлэх, эргээд явцыг нь тайлагнах , шалгаруулахдаа иргэний нийгмийн төлөөлөл оролцуулах тухай илүү дэлгэрэнгүй тайлбар нэхэгдээд байна.

Ингэхгүй бол энэ хууль төрийг авлигач болгон дуудуулах нэг шалтгаан, дээр нь гадаадын хөрөнгө оруулагчид Монгол нутагт дураар дургих цоорхой болоод байна.



# Сахалтай жаалууд тоглох зуур Монголын баялгаас мөнгө босгох дажин эхэллээ

Buryatia.org гэх вэб хуудаснаа сүүлийн үед Монголын баячуудын дунд яс хаясан элдэв цуурхал нийтлэгдэх болжээ. Тэрхүү цахим мэдээллээс авууштай ганц санаа харагдах агаад «Сахалтай жаалууд нь улс төрөөр наадаж суух зуур энэ улсын баялаг нэр нөлөө бүхий гадаадынхны гарт ягуухан орж байна» хэмээн онож хэлсэн өгүүлбэр нүднээ туслаа.

Дээрхийг эс тооцвол buryatia.org-д дэвшүүлсэн сэжиг таамаг бүр нь «Женко» Баттулгыг MCS-ийн Оджаргалтай нанчилдаасай, Монголын мөнгөтэй, боловсрол чадалтай болгон талцаж тархаасай гэх өдөөн хатгалгын үг өгүүлбэр дүүрэн.

Өдөж турхирахыг эс тоон, үйл явдлын хэлхээн дунд бодит байдал хэрхэн өрнөхийг тунгаа. УИХ-ын намрын чуулган энэ өглөө нээгдэж, улс орны ойрын ирээдүйг тодорхойлох онцгой чухал цөөнгүй асуудлыг гишүүд хэлэлцэхээр зэхжээ. Тэдгээрийн дунд Оюутолгой болоод Тавантолгой төслийг эцэслэн батлах том ажил бий. Чухам энэ хоёр төслийн хэлэлцүүлгийн үеэр үндэсний хөрөнгөтнүүдийг хэрэлдүүлж, олзонд нь орд газрын хувьцааг гартаа оруулах гэсэн гадаадынхны сонирхол газар авлаа. Бүр эрээгүй аргууд хэрэглэж ч болзошгүй.

Монголын алт, зэс, уран, мөнгө, нүүрсний нөөц баялгаар бизнес хийх авангард төлөвлөгөөнүүд эдүгээ Торонто төдийгүй Москвад, Токио, Бээжин, Лондонд ид халуун дээрээ яригдаж байна. Арга барилын хувьд ялгаатай болохоос ашиг олох санаархал нь бүгд ижил. Рио Тинто компанийн худалдаа эрхэлсэн менежер энэ өглөө Монголд морилон ирлээ. Захирлынхаа араас бараг залгуулаад айлчилж байгаа ноён менежер Хөрөнгө оруулалтын гэрээний тодорхой заалтууд дээр байр сууриа бататгах санаа өвөрлөжээ. Өөрөөр хэлбэл, Засгийн газартай төдийгүй олон нийт, хэвлэл мэдээллийнхэнтэй хэлэлцэж ярилцах, итгэл олох санаатай.

Тэгвэл «Айвенхоу Майнз» хошуучлан харьцангуй жижгэвтэр компаниуд нь Торонтогийн бирж дээр Монголын баялгаар мөнгө босгож байна. Алт, зэс, ураны нөөцийг маань гайхамшигтай рекламдан, санхүүгийн шинэ гарц хайж байгаа соёлтой хэлбэл, хууль ёсны наймаа. «Монголд дэлхийн ураны нөөцийн 20 хувь бий...» ингэж сурталчлахад «Хан ресорз» компанийн хувьцааны ханш аяндаа өсөөд л ирнэ. Цаашлаад «Азиа гоулд» алтны нөөцийн тухай шинэ мэдээлэл цацмагц үнэт цаас нь гүйлгээтэй болохоос яахав.

Дээрх хоёроос тэс өөрөөр манай уул уурхайн салбарт нэвтрэхээр оросууд чармайж байна. Тэд аргагүй олигарх аргаараа үзэж байгааг өнгөрсөн зунаас хойш өрнөсөн хэлхээ үйл явдлууд харуулах аж. ОХУ-ын Засгийн газрын тэргүүн М.Фрадков түрүү жилийн наадмаар 800 жилээ монголчууд хэрхэн тэмдэглэхийг сонирхсон төдийгүй Ерөнхийлөгч Путиний эрхэм анд Олег Дерипаскагийн очсон газар болгонд ногоон гэрэл асааж өгөх даалгавар биелүүлжээ. Монголчуудын мэдэж байгаагаар Фрадков даалгаврыг тааруухан биелүүлсэн.

**Ерөнхийлөгч  
Путиний эрхэм анд  
Олег  
Дерипаскагийн  
очсон газар болгонд  
ногоон гэрэл асааж  
өгөх даалгавар  
биелүүлжээ.  
Монголчуудын  
мэдэж байгаагаар  
Фрадков  
даалгаврыг  
тааруухан  
биелүүлсэн.**

Тавантолгой төсөлд оросууд давамгайлсан, болж өгвөл дангаараа орох тухай авангард санаархалд нь тухайн үеийн Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан даацтай хариу барьсан билээ.

Тэрбумтан Дерипаска 8-10 жилийн хугацаатай гэрээ байгуулах санаачлагаа илэрхийлж, энэ зуур татварын орчин туйлын таатай байх ёстой гэх мэтээр тун чиг «сагсуу» болзлуудыг мань Жаргалсайханд дуулгасан бололтой. Харин сайд хариуд нь «Тавантолгой төсөлд оролцох хэнд ч бид тусгай нөхцөл олгохгүй, тусд нь үйлчлэх хууль гэж үгүй, бүх оролцогч тэгш эрхтэй»-г дуулгажээ. Монголын нүүрсний орд газарт хөрөнгө оруулах хүсэлтэй Дерипаскагийн «Базовый элемент» төдийгүй А.Мордашовын «Северстали» групп ураны бизнест оролцохоор яаравчилж эхэллээ. Хажуугаар нь В.Вексельбергийн «Реново» бас юм олоод үнхчих санаатай эргэлдэж байна. Энэ бүхнээс ажиглах Оросын баячууд нүүрс, уран олборлох түшиц газраараа Монголыг хэдийнэ товлосон. Одоо зөвхөн төрийн өндөр хэмжээний айлчлалуудаар яриа хэлэлцээнд түлхэц өгнө гэж найдаж байгаа юм. ОХУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байсан О.Дерковский «Реново»-г Улаанбаатарт төлөөлөх итгэмжит хүнээр зүгээр л нэг томилогдчихсонгүй. Засгийн газрын тэргүүн асан С. Криенко мөн л энгийн зорилгоор энд ирээд буцсан юм биш. Төрийн Думийн тэргүүн С.Миронов өндрөөс өндөр түвшинд үйл явдал дэмжигдэж буйг илэрхийлэхээр ирээд буцсан билээ. Мөдхөн бас нэг том «тул» Улаанбаатарт айлчлах сураг ч гарав.

Тавантолгой төслийг ажил хэрэг болгоход асар их хөрөнгө буюу 1.5 тэрбум ам. доллар хэрэгтэй. Энэ мөнгийг дангаараа гаргах буюу төслийг ганцаараа гардан гүйцэтгэх саналыг О. Дерипаска шаргуу тавиад байгаа нь монголчуудын анхаарлыг татдаг. Оросуудаас гадна Тавантолгойн коксжих нүүрснээс хувь хүртэх санаатай яваа Япон, Хятад нь Оросын олигархийн санаархлаас болгоомжилж эхэллээ. Энэ утгаараа ирэх арванхоёрдугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын Москвад хийх айлчлалын үр дүнг асар их сонирхож байна. Магадгүй айлчлал хүртэл Тавантолгой төслийн гэрээний хэлэлцүүлгийг уяад байх ухаанаа тэрбумтан олно.

Эдгээр үйл явдлын дэлгэц дээр «Энержи ресурс»-ийн эсрэг оросууд одоохондоо мэдээллийн дайн хийж, элдэв сайтаар чулуу шидэж үзэж байгааг ажиглаж болно. Үндэсний 11 компани нэгдэн «Энержи ресурс»-ийг байгуулсан ба Тавантолгойн ордын 14 хувийг тэд эзэмшдэг. Чухам тэр 14 хувийн талаар О. Дерипаска «Орд газрыг ашиглахад гар бие оролцохгүй хэрнээ хувь эзэмших ямар хэрэгтэйг ойлгохгүй байгаагаа» шулуухан илэрхийлжээ. Монголчуудын дунд хэрүүлийн алим шидэх зорилго өвөрлөсөн зарим сайтын мэдээллээс харахад «Энержи ресурс»-д МАХН төдийгүй Ардчилсан намыг дэмждэг компаниуд хамтарч нэгдсэнийг ерөөсөө ойлгохгүй байгаагаа бичжээ. Бичээд зогсохгүй намуудын харъяаллаар нь хувааж хагалах санаатай шахалт дайралт үе үе сонсогдсоор байна.

Олигарх гэдэг үнэхээр өөрийн дүрмээр үзэлцдэг аж. Тэртээ ерээд он буюу Орост төрийн мэдэлд байсан аварга том үйлдвэрүүдээ хувьчлан хуваах үед ил тод дээрэм, заналхийлэл, зарим тохиолдолд цусан өшөө авч байж хуримтлал цуглуулсан шинэ цагийн баячууд өдгөө ялимгүй «соёлтой» болсон ч өөрсдийн тоглоомын дүрмийг Монголд санал болгож байна. Канад, Их Британийн бизнесмэнүүд шиг тэд ярьж хэлэлцэж, ятгах, хүний нутаг дахь ордыг рекламдан хувьцаа арилжиж баяжихдаа маруухан юм. Харин тэрний оронд Баттулга, Оджаргал хоёр Тавантолгойг булаацалдаж байгаа тухай давс нь чангалдсан үлгэр зохион монголчуудын оюунд хоногшуулахыг чармайж байна. «Энержи ресурс» гэх бүлэг дээрэмчний тухай зохиолын шинэ бүлгийг энэ

намаржин, чадвал ирэх өвөлжин, ерөөс Тавантолгойн гэрээний төсөл Монголд ашиггүй хувилбараар батлагдтал эрээчих багийг ч тэд санхүүжүүлэх биз.

Тавантолгойг хэн ч тоодоггүй байх цагт лицензийг нь мөнгөө нийлүүлж аваад хадгалчихсан Монголын 11 иргэнийг одоо оросуудтай нийлж балбах бус, харин баярлалаа та нарт гээд ам бардам хэлчихмээр санагдана. Энэ төсөл Оюутолгойн адил Монгол Улсын эдийн засагт тулах цэг болох өдөр хаяанд ирээд байна. Хэдэн хувийг нь өөрсдөө эзэмшиж, хэрхэн ашиглах тухай ажил хэрэгч маргаан дэгдэх учиртай энэ өдрүүдэд иргэний хөдөлгөөнийхний санаа оноог эсэргүүцэл мэтээр дан харлуулах, эсвэл Монголын олигархууд баялгийн төлөө байлдаж буй мэд давслах хатгаас олширч байна. Хэрэв [www.buryatia.org](http://www.buryatia.org)-д итгэнэ гэвэл Х. Баттулга Фрийдлэндээс «юм» авсан, Оросын мафийнхантай Бээжинд болзлог, Худалдаа, хөгжлийн банкнийг О. Дерипаскад хариугүй зарах гэж байгаа, Ж.Оджаргал сэжиг бүхий аргаар асар их хөрөнгө хуримтлуулсан эвгүй этгээд, ер нь энэ улсад өнгөтэй өөлтэй ирээдүй үгүй мэт.

Тавантолгой мэтийн том төсөлд оросууд төдийгүй Япон, Хятадын компаниуд консорциум маягаар оролцон санхүүжүүлэх гарцыг Монголын төр хайж байгаа билээ. Төр нийт хувьцааны тал хувийг, «Энержи ресурс» 14 хувийг эзэмшээд, үлдэх 36 хувийг нь олон улсын тендер зарлан худалдах эхний хувилбарыг манай тал гаргаад байна. Ийм хуваарилалт хэнд таалагдахгүй байна вэ?

Канадууд Торонтод манай баялгаар хувьцааныхаа үнийг өсгөж байхад бид энд өөрт оногдох хувиа багаасана гээд хэрэлдэж суух маань гачлантай яа. Баттулгад ч өгөхгүй, Оджаргалд ч хялайлгахгүй, оросууд ч юм уу, хятадууд ахиухан аваарай гэх нь үү. Монголчууд бүгдээрээ сахалтай хүүхдүүд болж, гурван гишүүний юм уу, гурван сайдын аймаар хар хэрэг сонирхож суутал дэлхийн зах зээл дээр ирэх жилээс ээсийн нийлүүлэлтийн илүүдэл үүснэ энээ тэрээ гэж ВВС мэдээлэх юм. Нүүрсний үнэд ч хөдөлгөөн орох өдөр бас ирнэ.

## **О. ДЕРИПАСКА ЯМАР НӨХЦӨЛ ХҮСЧ БАЙНА ВЭ**

Мэдээж Тавантолгой төдийгүй бусад төсөлд Оросын бизнесийнхэн оролцох нь нээлттэй. Харин Дерипаскагийн хувьд Монголын Засгийн газраас 8-10 жилийн хугацаатай тэрээ байгуулах хүсэлт тавьжээ. Түүнчлэн зарим татварын хөнгөлөлт үзүүлэхийг санал болгосон. Дээр нь төмөр замын тээврийн өртгийг Тавантолгойн бүтээгдэхүүний хувьд хямдруулахыг шаардах бололтой. Ийм болзолтой харьцуулбал Хятад, Японы хөрөнгө оруулагчид ялимгүй «даруу» нөхцөл хүсч байгаа гэж албаны эх сурвалж өгүүлэв.

## **ТЭРБУМТНЫ ИРЭЭДҮЙ ГЯЛАЛЗАЖ БАЙНА**

Оросын хэвлэлүүдэд ингэж бичдэг. Хөрөнгийн хэмжээгээр Б.Абрамовичийн дараа орох хүн гэж барууны хэвлэлүүдэд О. Дерипаскаг хоёрдугаарт жагсаадаг боловч дотооддоо бол түүний хөрөнгө зоорийг Абрамовичийнхаас мөдхөн илүү гарна гэсэн таамаг дэвшүүлжээ. Энэ нь Дерипаскагийн хилийн чанадад хийж буй дэндүү идэвхтэй үйл ажиллагаатай холбоотой. Мань эр Оросын хөнгөн цагааны үйлдвэрлэлийг гартаа атгаж өндиймөгцөө гадаадад асар их хөрөнгө оруулсан. Герман, Австри улсын барилгын томоохон компаниудын хувьцааг одоо цуглуулж эхлээд байна.

Оросын олигархиудаас ялгаатай нь тэр азтай эр. Б.Ельциний Тамгын газрын даргаар ажиллаж байсан В. Юмашевын хүргэн. В.Путин түүнд итгэдэг гэнэ. Хаяа хамт цанаар гулгаад л... Ийм таатай орчинд байгаа хүнд Б.Берёзовский шиг цагаачилж муугаа үзэх хэрэг алга.

## ЭЛДЭВ ЯРИА

Лондоны төвийн ганган буудлуудад орос хэвлэл тараадаг. Мөнгөө багтааж ядсан оросууд Английг зорих нь ердийн явдал болсон.

Ноён Дерипаска ч Лондонд хайртай гэнэ. Гэхдээ Абрамович шиг хөл бөмбөгийн хообийгүй. Их Британийн Элчин сайдын яам Дерипаскад хэл үггүй виз олгодог бол АНУ-ын болоод Швецарийн виз авч чадаагүй тохиолдлууд бий. Эдгээр нь олигархийг тойрсон элдэв хэл амтай холбоотой.

Энэ өдрүүдэд ч тэрбээр Германд болох дуулиант шүүх хуралд оролцох «зарлан» авч болзошгүй. Штутгарт хотын шүүхийн танхимд аравдугаар сарын 16-нд эхлэх хурлаар мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон оросуудыг шүүх юм. Мөрдөн байцаалтын явцад О. Дерипаска Германд үйл ажиллагаа явуулж байсан өрсөлдөгчөө дарамталсан байж мэдэх ноцтой баримт илэрчээ. Эдүгээ Оросын хэвлэлүүдэд шуугиж буйгаар бол бүр хүн амины хэрэг сөхөгдөж ч болзошгүй гэсэн байх юм.

**2007 он**

# Суурь инфляц суурь өвчин үүсгэж байна

Суурь инфляц долоо гаруйхан хувьтай гарчээ. Энэ шидэт тоог ганц орон дотор барьж багтааж байхын тулд тураах эмчилгээ байнга хийх агаад эдүгээ суурь хэмээх содон тодотгол дор бэлхүүс гоолиг долоогийн цифрт хүчээр чихсэн нь энэ.

Бараа бүтээгдэхүүний улирлын чанартай үнийн өөрчлөлтийг инфляцад тусгаагүй гэсэн үг. Мах, гурил, ногоо цагааны үнийн өөрчлөлтийг мэдрээгүй үзүүлэлт. Дулааны улиралд Монгол орон даяар өрнөдөг их бүтээн байгуулалт, түүнийг дагасан бараа материалын ханшийн хөдөлгөөнд хамаагүй тоо юм. Есдүгээр сарын их зарлагыг хайхардаггүй хөлдүү тайлан. Чухам энэхүү улирлын нөлөөллийг хасч тоолдог суурь инфляц гэгч ганган цифрийн худал замналаар манай эдийн засаг хоосон үзүүлэлтэд оргилуун дарс буудуулдаг өвчтэй болоод байна. Суурь инфляц эдийн засагт суурь эмгэг суулгалаа.

Энэ намрын их зарлагадаа иргэд туйлджээ. Өнөөх л замаараа ажилдаа довтолговч өнгөрсөн жилийнхээс хоёр дахин их хөлс таксийнд өгч, сургалтын төлбөр өндөр хөгжилтэй орнуудын жишиг өөд цойлж эхэлснийг сонсон, өндөг, махыг хүртэл баян улсын хэрэглээний үнээр худалдаж авах дөхөөд байна. Эдийн засаг өсөн нэмэгдэж, макро түвшинд хамгийн таатай тоонууд урган гарч байгаагийн зэрэгцээ микро буюу манийн амьдралд зөвхөн зарлага томорсоор хасах үзүүлэлтүүдийн дунд өдөр хоног өнгөрөх аж. Нэг тэрбум илүү ам. долларын нөөцтэй Төв банк дэргэд байна. Эдийн засгийн өсөлт өсөн хувьд мөдхөн хүрэх тухай ёсорхуу илтгэлүүд уншлаа. Харин Цагдаагийн газар ам. долларын ханшийг огцом хөөрөгдсөн бүлэглэлийг олж илрүүлэх аянд гараад байна. Энэ мэт ундуй сундуй өрнөх үйл явдлуудыг тоймлон ажвал эдийн засаг дахь их мөнгөний урсгалыг тогтоон барих гээд Монголбанк хүч мөхөсдөж байгааг анзаарч болно.

Эдүгээ Төв банкны тэрбум долларын нөөцөд үл захирагдах ханшийн огцом савлагааг зохион байгуулж чадах хэмжээнд арилжааны банкууд дахь төгрөгийн хуримтлал хүрчээ. Мөнгөний зах зээлд төгрөг «шахмагц», эсвэл валютын эрэлтийг ялимгүй өдөөмөгц ханшийн савлагаа гинжин урвалаар дохиолон одох аж. Монгол Улсын мөнгөний бодлогыг Төв банк бус арилжааны банкууд өөрчилж дөнгөөд байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр арга алга. Хэдийгээр Монголбанк үнэт цаас гаргаж төгрөгийн хязгааргүй нийлүүлэлтийг тогтоон барихыг оролдож байгаа боловч амь тариа төдий арга хэмжээ болоод өнгөрөхийг нь анзаарахгүй суух аргагүй.

Монголбанк хүч мөхөсдөж эхэлсний нэг шалтгаан нь алтны нөөц дундарсантай холбоотой. Компаниуд жилд хэдий хэмжээний алт олборлож, түүнээ ямар замаар, хаана борлуулаад явааг одоо хэн ч хэлж чадахаа байсаан. Аргаа барахдаа алтны компаниудад шалгалт оруулж, 68 хувийн татварт суутгачихмаар «шар юм» хайсан ч эрэл мухардаж, эргээд Төв банкны нэр сүрэнд эвгүй явдлууд гарч эхэлснийг бид мэднэ. Манай улсад жилд олборлодог алтны хэмжээ багасаагүй. Тэгэхээр компаниуд олборлосон эрдэнэсээ арилжааны банкуудад хадгалуулж, улмаар тэдний зах зээл дэх ноёрхлыг бэхжүүлсээр байна биш үү. Хиймэл статистикүүд, «гоолиг» инфляц, мөнгөний бодлогыг хоосон онолоор хөтлөхийн уулзварт нэг л өдөр эдийн засагт «озоны цоорхой» үзэгдэх вий гэсэн болгоомжлол байна.

Энэ мэт  
ундуй сундуй  
өрнөх үйл  
явдлуудыг  
тоймлон ажвал  
эдийн засаг  
дахь их  
мөнгөний  
урсгалыг  
тогтоон барих  
гээд  
Монголбанк хүч  
мөхөсдөж  
байгааг анзаарч  
болно.

Улаанбаатарын хонхорт хаашаа л харнав тэнгэрт тэмүүлсэн барилгууд сүндэрлэж, өргөгч цамхгийн тоо тоймоо алдсан. Шинэ сууцны талбайн үнэлгээ талийлаа. Хотын төвд ганц ам. метр талбайг 800-1200 ам. доллароос дуудаж эхлэв. Ирэх жилийн өдийд орон сууц гэдэг алтан ордон лугаа ханштай, өнөөгийнхөөсөө арав дахин илүү өртөгтэй болж мэдэхээр. Сууцны эрэлт хязгааргүй өсч байгаагаас ямар хандлага харж болох вэ? Хилийн чанадаас орж ирж буй мөнгөн урсгал улам улам нэмэгдэж эхэллээ. Гагцхүү тэр хөрөнгө арилжааны банкуудаар дамжин зах зээлд асарч , үнийн хөөрөгдөлд хувь нэмрээ оруулж байна. Хотоор дүүрэн босч буй гоёмсог хорооллууд импортын инфляц гэгчийг давхар чирж орж ирэхийг гярхай эдийн засагчид тооцоолж байгаа болов уу. Нэг үгээр гадаадаас эх нутаг руугаа илгээж буй мөнгөний их урсгал эргээд импортыг буюу харийн бизнесийг тэтгэж байгаа.

Цаашлаад импортын инфляц гэгч өвчин хоёр сар тутам сэдэрх магадлал архагшлаа. ОХУ экспортын бензин шатахууныхаа үнийг хоёр сар тутамд нэмэгдүүлдэг бичигдээгүй хуультай болжээ. Наймдугаар сард манай улсыг хамарсан ханшийн давлагаа дахин аравдугаар сард давтагдахыг Ерөнхий сайд М.Энхболд хамгийн сайн тогтоож авсан гэнэ. Тиймээс ч төрийн албан хаагчдын цалинг аравдугаар сарын 1-нээс нэмэх аргагүй хамгаалалт хийхээр төлөвлөжээ. Энэ хамгаалалт нь эдийн засаг дахь суурь өвчнийг удам сэдэрээх нь дамжиггүй. Дэлхийн зах зээл дээр нефть бүтээгдэхүүний үнэ 80 ам. доллар хүрээд байна. Энэ хандлага оросуудын «сарын тэмдэгт» мөчлөг ойртох шалтгаан болчих вий. Тэгэхээр төрийн албаныхны цалинг 40 хувиар нэмэх манай Засгийн газрын арга хэмжээний үр дүнг Оросын нефтийн компаниуд залгичих нь ээ. Цалин нэмсний харгай гэх үү дээ, уул уурхайн салбарынхан төрийн албаныхантай бас барьцах нь гарцаагүй. Уурхайчдын цалинг нэмэгдүүлэх, нүүрсний үнийг дахин өсгөх шаардлага хүйтний улирал айлсах тусам нэхэл хатуутай болж , жинхэнээсээ түгшүүр зарлаж мэдэх нь. Хэрэв нүүрсний ханшийг зах зээлийн жишгээр тогтооход хүрвэл суурь үнэ хөдлөхийн чинээ савлагаа үүсэх нь дамжиггүй. Үнэ ханшийн энэ бүх хөдөлгөөн мөнгөний бодлогыг хамгийн уян хатан , мэдрэмжтэй барих учиртайг сануулав.

**Наймдугаар сараас хойш ханш унасаар байх атал тэрбум долларын нөөцтэй гэх Төв банк яагаад гар хумхин суугаа юм бэ. Монголбанк мөнгөний бодлогоо барьж чадаж байгаа юм бол хоёр сарын турш ханшийн зөрүүний гайг иргэд жижиглэнгийн үнээр худалдаж авсны хохирлыг хэн барагдуулах вэ.**

Дотооддоо инфляцийг давхар оронтой тоонд оруулалгүй , аргачлал зэргээр аргалж болох ч импортоос бүрэн хамааралтай эдийн засгийг гадаадын тодотголтой инфляцаас хаацайлах амаргүй билээ. Дэлхийн зах зээл дээр нэг тонн улаан буудайн үнэ өнгөрсөн жилийнхээсээ хоёр дахин өслөө. Хэрэв импортын энэ бүх дарамтыг тооцвол Засгийн газар цалин хэчнээн нэмээд ч макро түвшинд эдийн засаг эрүүлжинэ, иргэд бухимдалгүй амьдарна гэдэг худал болох нь. Манай улсын эдийн засагт урьд хожид дуулдаагүй их хэмжээний хөрөнгө урсан орж байгаа өдрүүдэд мөнгөндөө менежмент хийж чадаж байгаа эсэхээ эргэн харах цаг болжээ. Зэсийн дэлхийн зах зээлийн үнэ өндөр байгаа хэдий ч түүнээс ирж буй асар их орлогыг бид импортын төлбөрт буцаагаад гадагшлуулчихаж байна. Нөгөө импортын төлбөрөө юань болоод ам. доллароор хийж , дотоодын хэдэн компани халаасаа гөвж байна. Тэгээд юань, долларын ханшийг чангалаад байхын ашиг тус хэнд хэрэгтэй болж байна аа. Наймдугаар сараас хойш ханш унасаар байх атал тэрбум долларын нөөцтэй гэх Төв банк яагаад гар хумхин суугаа юм бэ. Монголбанк мөнгөний бодлогоо барьж чадаж байгаа юм бол хоёр сарын турш ханшийн зөрүүний гайг иргэд жижиглэнгийн үнээр худалдаж авсны хохирлыг хэн барагдуулах вэ.

Ирэх жил баримтлах мөнгөний бодлогоо төр тодорхойлох гэж буй энэ өдрүүдэд анхаарал хандуулах ёстой зүйлс байна. Импортоос бүрэн хамааралтай улс орон байтал ам. доллар, юаний ханшаа зөнд нь хаядаг бодлого гэж байх учиргүй. Төв банкныхны үл тоодог ханшийн ялимгүй өөрчлөлт гэгч жижиглэнгийн үнэ дээр том өөрчлөлт болон дарамт унагаж байгааг сануулья.



Арилжааны банкууд санхүүгийн зах зээлд солгой тоглолт хийхэд хялбар болсон нь, тэдгээр дунд гадаадын хөрөнгө оруулагчтай банк нэмэгдэж байгааг анхаарах ёстой асуудал бус уу. Ханшийг зохиомлоор өсгөж байгаа бүлэглэлийг цагдаа мөрдөөд явах биш, санхүүгийн аргаар хяналт тавьж чаддаг бодлого үгүйлэгдэж байна.

**2007 он**

# Энхболд, Путин хоёр ижилхэн шаналсан нь

А.Гордеевийг Ерөнхийлөгч Путин баахан загнав. Орос улс ойрд сонсогдоогүй их хэмжээний ургац хураасан атал талх тарианы үнэ мөн л өмнө хожид дуулдаагүйгээр нэмэгджээ. Аль халуун зун л Путин Хөдөө аж ахуйн сайддаа энэ талаар сануулаад чихэнд нь хонх уяад байж.

Зөрүүд сайд харин яасан гэж санана. «Орос талх Европынхоос 3-5 дахин хямд байдаг юм аа» гэсэн гэдгэр хариулт өгчихөөд , одоо суудлаа тавьж өгөхдөө тулаад байх шиг.

Үнийн халууралд ижилхэн сандарсан хоёр эрхэм болох Энхболд, Путин нар хамгаалалтын арга хэмжээнүүд авч эхэллээ. Эдгээр шийдвэр нь өмнө хойноо ороод , сонин үр дагавар харуулаад байна. Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаан лхагва гаригт болж , гурилын ханшийг залуурдахыг оролдсон шийдвэр гаргажээ. Ирэх оны хавар болтол гурилыг , айсуй наадам хүртэл улаан буудайг импортын татваргүй болгосон энэ шийдвэр үнэ ханшийн өсөлтөд ямар ч нөлөө үзүүлэх боломжгүй юм. Зөөлхөн хэлбэл хэтэрхий оройтсон арга хэмжээ . Манай Засгийн газар хуралдахаас хэдхэн хоногийн өмнө ОХУ-ын Засгийн газрын танхим мөн л гурилын үнэд санаа зовнин шийдвэр үзэглэсэн байх аж. Тэд гурил будааныхаа экспортын татварыг нэмж орхисон агаад араас нь бид импортоо татвараас чөлөөлөөд ч яах билээ. Оросуудын шийдвэр арваннэгдүгээр сараас ажил хэрэг болно.

Зөвхөн гурил гэсэнгүй ургамлын тосныхоо экспорт дээр оросууд татвар нэмж тавихаар зэхжээ. Монголчуудын хувьд онцгой албан татварын нэмэгдэлтэй наранцэцгийн тосонд хуушуураа хайрах өдрүүд айсуй.

## МОНГОЛ УЛСАД БУУДАЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОНО УУ

Ерөнхийлөгч В. Путин болоод ОХУ-ын Засгийн газар энэ мэтээр дотооддоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа өргөн хэрэглээний барааны ханшид нөлөөлөхийг оролдож байна. Гол арга хэрэгсэл нь гаалийн татварыг уян хатан хөдөлгөх, түүнчлэн Холбооны монополийн эсрэг албаны ажлыг эрс идэвхжүүлэх явдал гэж үзжээ. Манайхан ч бас л ингэж «сэтгэсэн» агаад Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газраа сая нэг шахаж шаардаж эхлэв бололтой. Тус агентлаг холбогдох яамдын хамт шалгалт хийх удирдамжийг уржигдар М.Энхболдоос авав.

Их гүрэн юм хойно оросууд арвин ургацаа дотооддоо зохицуулж тээрэмдээд ирэх намар болтол талхны үнийг тогтоон барихаа мэдэх хэрэг. Харин бидний хувьд хэрэгцээгээ хангахын тулд 150 мянган тонн буудай дутах тооцоо гарчээ. Дэлхийн хамтын нийгэмлэгт хандан тусламж гуйхаас аргагүй нөхцөл байдал Монголд нүүрлээд байна. Энэ бол инфляцийг хэвлэлээр хөөрөгдөх санаархал биш, М. Энхболдод ял нэгийг нэмэх бодол ч биш. Ургац хураалтын дүн мэдээ сайнгүй гарч, дээр нь дэлхийн зах зээл дээр буудайн үнэ ханш өндөр байна. Хоёр талаас хавчсан нөхцөл байдлыг ялимгүй эртнээс мэдрэх эзэгтэйн ухаан харин Ерөнхий сайдад дутжээ. Хойд хөрш арвин ургац хураасан энэ намар бидний авхаалж хэрвээ хүрсэн бол Оросын үр тарианы компаниудтай даруй гэрээ хэлэлцээр хийх боломж байсан ч байж мэдэх юм. «Зарим бүс нутагт

Монголчуудын  
хувьд онцгой  
албан татварын  
нэмэгдэлтэй  
ургамлын тосонд  
хуушуураа хайрах  
өдрүүд айсуй.

түүхэнд байгаагүй хэмжээний их ургац хураасан» гэж ОХУ-ын Ерөнхийлөгч Уфа хотноо өнгөрсөн долоо хоногт тэмдэглэжээ. Оросын бүс нутгийнхны хувьд бүтээгдэхүүнээ гадагш нь өндөр үнээр худалдах овжин ухаан нь ид цэцэглэж байна. Тийм учраас л дотоодод нь талх тансаг бараа болсон хэрэг. Хойд хөршийн тариаланчдын хүсэл сонирхол дээр монголчууд хэрэгцээгээ цагийг нь олж дайсан бол эдүгээ буудай өгөөч гээд зогсож байхгүйсэн. Ямар ч байсан ирэх хаврын эрэлт хэрэгцээгээ хангахын тулд Монгол Улс хүнсний тусламж гуйх хэрэгтэй болох нь.

## 15 ХУВЬТАЙ АМЬДРАЛАА ХОЛБОСОН НЬ

Бүр найман жилийн өмнөөс зууралдсан импортын 15 хувийн татвартайгаа бид бат бөх гагнагджээ. Энэ оны долдугаар сараас ирэх жилийнх нь дөрөвдүгээр сар хүртэл импортын буудайнд татвар тавьж мөрдсүгэй хэмээн өнгөрсөн зууны 1999 онд хуульчилсан байх юм. Тэр цагаас хойш татварын хэмжээ өөрчлөгдсөн түүхгүй. Өөрөөр хэлбэл, үнэ ханшийн хөдөлгөөнийг зохицуулдаг Засгийн газрын нэг гар халаасандаа байсаар хөшчихөв бололтой.

Дэлхийн зах зээл дэх ханшийн хөдөлгөөн болоод дотоодын байгаль цаг агаарын өөрчлөлт зэрэгтэй уялдуулан байнга «атгаж тэнийлгэж» байх учиртай татварын зохицуулалт Засгийн газрын мэдэлд бий. Энэ механизмыг хөдөлгөж удирдаж байх хэрэгцээ одоо улам бүр нэмэгдэж байна. Магадгүй илүү шуурхай ажиллуулахын тулд танхим шийдвэрээ гаргачихаад УИХ-аар хэлэлцүүлдэг дамжлагыг халах хэрэгтэй ч байж болох. В.Зубковын танхим шиг тогтоол гаргаж, түүнээ хүчин төгөлдөр мөрдөөд явбал үнэ ханшийн энэ их хөдөлгөөн лунд барьц алдахгүй шуурхай залуурдах боломж бий.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнэ ханшийн өөрчлөлт зөвхөн Орос, Монголд үзэгдэл болоогүй, Европын улсуудад ч нүүрлэжээ. Дэлхийн цаг агаарын өөрчлөлт нь ертөнцийн хүмүүст урьдчилан эртнээс таах аргагүй бэрхшээлүүд тулгаж, үүнд зохицон амьдрах дархлаажуулалтыг Засгийн газрууд бодлогоороо хийж байна.

## АГЕНТЛАГ АЖИЛЛАГТҮН

Бодлого гэснээс манайд моодонд орсон хоёрхон арга бий. Үнэ ханш өсөөд хүмүүс бухимдаад эхэлбэл цалин, тэтгэвэр нэмдэг, эсвэл суурь үнийг барихыг оролддог. Зах зээлд ингэж захиргааны аргаар улам бүр оролцсоор яваад тухайн салбар дахь алдагдлыг төсвийн хөрөнгөөр бөглөдөг явдал ужгирчээ. Яг ийм арга мухардсан бодлогыг Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар шүүмжлэх цаг болсон. Агентлаг агентлаг ажилла хэмээн шившиж тарнидмаар үе зөндөө л гарлаа. Аль халуун зунаар л зарим бараа бүтээгдэхүүний үнэ өсөх хандлага гарч ахуйд тус агентлаг судалгаа, шалгалтыг тасралтгүй хийх учиртай байлаа.

Импортлогчид, үйлдвэрлэгчид үнийг хөөрөгдсөн тухай Засгийн газрын сүүлийн хуралдаан дээр цохон тэмдэглэв. Тэгэхээр импортын монополиудад шахалт үзүүлэх цаг болсон юм биш үү. Дэлхийн зах зээлээс импортын инфляц чирэн орж ирэх тэдгээр монополиуд дотоодод дахин ханшаа нэмэн үнийн өсөлтийг дэвэргэж байна.

## ТАНИХГҮЙ ИНФЛЯЦ

УИХ ирэх оны төсвийн төслийг хэлэлцэж буй үед инфляцийг ийм тийм оронтой тоонд барь гэж худал үзмэрдэхгүй байхыг гишүүдэд зөвлөө. Өргөн хэрэглээний барааны үнийн индекс 2008 онд хэд болохыг хэн ч хэлж чадахгүй байна. Дэндүү олон хүчин зүйлээс шалтгаалсан, төрөл бүрийн барааны үнэ ханшийн өсөлтийн таамаг гараад байгаа билээ. Тийм болохоор Сангийн яам

Дэлхийн зах зээлээс импортын инфляц чирэн орж ирэх тэдгээр монополиуд дотоодод дахин ханшаа нэмэн үнийн өсөлтийг дэвэргэж байна.

«Инфляцийг нэг оронтой тоонд барина» гэж төсвийн төсөлд бөөрөнхийлсөн харагдана. Өдгөөгийн инфляц бол импортод дарлуулсан, Монгол Улсын эдийн засгийн бодлогод үл захирагддаг, дураараа дургисан үзүүлэлт.

Нөгөө Гордеев сайдын нэг ишлэлд анхаарал хандуулъя. Ерөнхийлөгч В.Путин түүнийг хатуу зэмлэсний хариуд Хөдөө аж ахуйн сайд «Үнэ ингэж нэмэгдэж буйд манай яам ямар ч буруугүй. Бүр ерээд оноос Оросын эдийн засгийг импортоос хараат болгож орхисон эдийн засгийн шинэчлэгчид гэгч түмэн буруутай» гэжээ. Монголтой харьцуулашгүй аварга улс боловч энэ цаг үед ижил бэрхшээлийг туулахаар бид хамт гарц хайж байна.

ОХУ-ын Хөдөө аж ахуйн сайд А.Гордеев импортод туйлын дургүй нэгэн болохыг махны бизнес эрхлэгч монголчууд сайн мэднэ. Монгол малын мах авахгүй цааргалж, улмаар тэр нь махны үнэ Оросод нэмэгдэх нэг шалтгаан болон, инфляц хөөрөгдөж байсан зэмтэй хүн гэсэн шүү. Ерөнхийлөгч Путин сайдад уурлахаас ч аргагүй байгаа биз. Үнийн өсөлтөд нөлөөлж буй бас нэг хүчин зүйл нь төрийн албан хаагчдын мэдлэг боловсрол хийгээд онцгой үед шийдвэр гаргах эр зоригтой холбоотой. Засгийн газрын хуралдааны дараа Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д. Тэрбишдагва гурилын хангалт цаашид ямар байх талаар баахан будилуу тайлбар хийж сууна. Гурилын импортыг татвараас чөлөөлж буй арга хэмжээ тайвшрах үр дүн авчрахгүй гэдгийг тэр гадарлаж байгаа нь лавтай. Уг арга хэмжээг энэ зуны их халууны дараа, Америк, Европын зах зээлд зургадугаар сараас улаан буудайн үнэ огцом нэмэгдэж эхлэх үед авах ёстой байсныг сайд хүлээн зөвшөөрч яагаад болохгүй гэж.

## ХОТЫН ДАРГЫГ ХАЙЖ БАЙНА

Нийслэлд төвлөрсөн хэдхэн том захын наймаачид хүнсний бүтээгдэхүүний үнийг гартаа барьж байгаа учир хотын даргыг иргэд эрэн сурвалжилж байна. Орон нутгийн удирдлагууд яг ийм бэрхшээлтэй цагт яамтай, Засгийн газартай нягт уялдаатай ажиллах учиртай. Нийслэлийнхэн гурил, талхны хомсдолд ороход ойрхон боллоо. Бидний хэрэглэдэг гол нэрийн бүтээгдэхүүн шүү дээ. Хотынхны хүнсний асуудалд Захирагч өөрийн биеэр анхаарал хандуулах цаг болжээ. Зоорины мах хуваарилах төдийгөөр эрхэм Захирагч таны ажил шувтрах учиргүй. Цалин нэмэхээс өөрийг сэдэх сөгөөгүй яваа Ерөнхий сайдад их хотын эзний хувиар дэмжлэг болно уу.

## ХУГАЦАА БУЮУ ХАРИУЦЛАГА

Эцэст нь үнийн өсөлтийн синдром хэр удаан үргэлжлэхийг таамаглахыг иргэд хүсч байна. Дэлхийн зах зээлийн байдал, импортын инфляцийн хүчин зүйл, хариу арга хэмжээнүүд гээд мэдээллээр ард олноо байнга хангах нь хий бүхмидлаас хамгаалах арга болох нь. Оросууд шиг 2-3 сарын дараа үнийн хөөрөгдлийг зохицуулж дөнгөнө гэж манай Засгийн газар амлах аргагүй. Гэсэн ч үүрэг хүлээсэн хүмүүст хариуцлага тооцохын тулд ямар нэг ажлын график байх ёстой биз ээ.

Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаар дамжуулан гишүүн компаниудтай нь уулзалт зохион байгуулж ч болох. Томоохон импортлогчидтой хэлэлцэж ярилцах, өөр шинэ гарцууд хайх гээд шуурхай ажиллаасай билээ. Төр, бизнесийнхэн хоёр хүнсний бүтээгдэхүүний үнэ дээр тохиролцоод суувал зах зээлийн арга зарчим яав ч биш байх л даа. Гэсэн ч нефть бүтээгдэхүүн, гурилаар зогсохгүй ургамлын тос, ондөг, сүү, цэцгийн тосондоо манай хойд хөрш ээлж дараалан экспортын онцгой татвар тавиад эхэлбэл үнэ ханшийн цохилтоос хамгаалах төрөл бүрийн арга хэмжээ зайлшгүй авахаас аргагүй болно.

# ГАРЧИГ

## II БҮЛЭГ

### ЭДИЙН ЗАСАГ

1. Ноён Брауны санаачлага холын Монголын төсвийг хөдөлгөв .....	135
2. Төсөв гэгч том үгний цаана .....	137
3. Сайхан төсөв батлагдана .....	139
3. Төсөвт туссан нүцгэн тоо ба түүнээс улбаалах улстөржсөн явдлууд 2006 онд .....	142
4. Орос чихэртэй 2006 оны төсөв .....	145
5. Төсвийг тэлж, инфляцийг онилсон нь .....	148
6. Төсвийн хэлэлцүүлгийн үеэр түгээх SOS .....	150
7. Хандлага гаргах нь .....	152
8. Бэлгийн морины шүдийг үз .....	153
9. Бэлгийн морины шүдийг үзье .....	157
10. Оросын тал авлагынхаа хэсэгт компаниудын хувьцааг авах бодолтой байна уу .....	161
11. Өрийг хөнгөлөх Б.Ельциний хувилбар буюу монголчуудын мөрөөдөл .....	163
12. Их өр дагасан эрвээхэй зангиатай нууцхан баяр .....	165
13. 250 сая ам.долларын задаргааг хэлж өгнө үү .....	167
14. Зүрхний тухай яриа .....	170
15. Гамшгийн дараах нийслэл .....	172
16. Эрхэм сонгогчдын тухай хэдхэн үг .....	179
17. Ирэх намраас инфляц буурна гэж эзэгтэй нар үзэж байна .....	181
18. Инфляц галзуурах цагаар .....	186
19. Монгол тамгыг Япон руу сэм зөөлөө .....	188
20. Дэлхийн зах зээл тэртээд үү, энүүхэнд үү .....	190
21. Царцаа-глобальчлалын бэлгэ тэмдэг .....	193
22. Ямаачин гадилд дургүй .....	196
23. Чимээгүй мөнгөний эзэд хэн бэ? .....	201
24. Монголын говь дахь Синдерелла .....	204
25. Айвенхоу Майнз ажлаа хумьж, Рио Тинто санаа тавьж эхэллээ .....	208
26. Монголын уул уурхай дэлхийн зах зээлд зэл татахын учир .....	211
27. Оюутолгойн тухай оддын дайны сэтгэмжүүд .....	214
28. Ж.Оюунгэрэл: Монгол орон даяар хардлагын хар үүл тэнүүчилж байна .....	217

29. Эрхлэгч сууж харагдана уу .....	221
30. Их хувьчлалын Монгол түүх.....	224
31. Монголын банкирууд юунаас айдаг вэ?.....	228
32. Шинэ цагийн Гобсекууд буюу мөнгө хүүлийн хүлээ.....	231
33. Шинэ оросууд хуучин түншдээ хөрөнгө оруулж эхэллээ.....	234
34. Монгол дахь Оросын монополь.....	237
35. Төсвийн хөрөнгөөр тоглосон тендерийн явдлууд.....	239
36. Сахалтай жаалууд тоглох зуур Монголын баялгаас мөнгө босгох дажин эхэллээ.....	241
37. Суурь инфляц суурь өвчин үүсгэж байна.....	245
38. Энхболд, Путин хоёр ижилхэн шаналсан нь .....	248



# III Сэтгүүл зүй III бүлэг



«Би чамд хайртай гэж хэн нэгэнд өдөр бүр хэлж бай. Ялангуяа өөртөө энэ үгийг байнга хэлж бай» гэж Лора Буш Жоржтауны их сургуулийн Эмнэлгийн ажилтан, сувилагчдын сургууль төгсөгчдөд хандан 2003 оны тавдугаар сарын 17-ны өдөр хэлэв.

«Та нарын энэ диплом одоохондоо цаас байна. Харин түүнийг амилуулж, жинхэнэ эзэн нь юмаа гэдгээ харуулах нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаална» хэмээн тэр үргэлжлүүлэн ярьсан юм.

Бидний эргэн тойронд хайр дутагдаж, сэтгүүлчид шүд зуун харааж, эсвэл шал худал магтан нялуурч байна.

## Америкт «хулгай» хийж явна

Юу хийж явна вэ гэж үү? Хулгай гэж хариулъя. «Менежментийн хулгайд мордъё» гэсэн санаагаа хэлэхэд минь «Өнөөдөр» сонины Ерөнхий эрхлэгч «Энэ чинь зөв санаа» хэмээн дэмжсэн билээ. Тэгээд би Америкт «хулгай» хийхээр зориг шулуудсан шүү.

Эндхийн өдөр тутмын сонинуудын гал тогоо руу өнгийж олж мэдсэнээ тэмдэглэсээр явтал олон далбагар дэвтэр дүүрчээ. Гэтэл эргээд уншихад нэг л биш ээ. Би эндээс шинэ зүйл юу олсон бэ? Вашингтон Пост, Нью-Йорк Таймс, Гранд Фокс Хералдийн редакциуд яасан чимээгүй юм бэ? Аа-уу... Энд хүн байна уу? Сонины маань шуугиант өрөө үгүйлэгдээд, тархинд шингэж орхисон чимээгээ эрээд явна. «Тэд бидний ярьдаг, хийдэг, төлөвлөдөг бүх зүйлийг л давтдаг. Ялгаа нь ялимгүй юм» гэж тэмдэглэлээ. Ялгаатай ганц зүйл нь яасан чимээгүй орчин бэ?



Фотог Ц.Батбаатар

-Дардас чинь хаана байна? хэмээн би очсон редакц болгоноосоо сураглаж явав.

-Тэр чинь юу билээ?

-Яагаав, бид бол гаргаж ирээд, хэд хэдэн эрхлэгч дамжуулан уншдаг...

-Proof -үү?

-Тийм. Үгүй энэ чинь яагаад ийм цэвэрхэн, засваргүй байна вэ? Бид бол улаан эрээн болгож...Америк эрхлэгч нар ойлгох шинжгүй.

«Гранд Фокс Хералд»-ийн тоймчдын хэсгийг ахалдаг Том Деннисийн ширээн дээр өдөр бүр 15.00 цагийн орчимд Editorial Page-ийн дардсыг тавьдаг. Энэ дардас дээр Том улаан эрээн засвар хийхийг нь хүлээж би хэдэн өдөр болов оо. Үгүй юм. Тэр зүгээр л хариуцсан нүүрнийхээ бүтэц, өнгө төрхийг нягтлах гэж мөнөөх proof-ээ гаргадаг юм байж.

Америкийн сонинууд техник хэрэгслээр бүрэн тоноглогдсонд л асар том ялгаа нь байна. Хүн бүрийн өмнө компьютер, хажууд нь утас байхад алтан цагийг тэд хэд дахин хэмнэх ажээ. Өөр зуураа дэлгэцээр голдуу харилцана.

Хяналт, засвар бүгд тэнд хийгдэнэ.

-Дугаар удирдагч нь өнөөдөр хэн бэ?

-Хэн...хэн гэнээ?

**-Өдөржин дугаараа сахиж, маргааш бүгдийг хар толгойгоороо хариуцах хүнээ зааж өгнө үү.**

-Night Editor-ийг маань хэлж байна уу даа.

Өөр нэг ялгаа нь энэ. «Гранд Фокс Хералд»-ийн Хотын мэдээний редакторыг би даваа гаригийн үдэш өрөвдөж суусан шүү. «Дахин нэг эмэгтэйг Вашингтонд дэлгүүрийн өмнө мэргэн бууч оножээ» Үдшийн 21.00 цаг өнгөрч байхад CNN ийм цочир мэдээ дамжуулав. Хөөрхий Жэйми маргааш өглөө ийм мэдээлэл орхисныхоо төлөө торгуулна байх. Тэр 20.00 цагийн орчим харих гээд зэхэж харагдсан. Өдөр тутмын сонины яаралтай мэдээний хэсгийг хариуцдаг тэр залуугийн халзарч яваа үсийг өрөвдөн санав. Тэгтэл 2002 оны аравдугаар сарын 15-ны мягмар гаригийн «Гранд Фокс Хералд»-ийн эхний нүүрт CNN -ийн дамжуулсан мөнөөх мэдээ хэдийнэ байраа эзэлжээ. Night Editor! Үдээс хойш ажилдаа ирдэг, шөнийн амьдралтай тэр хүн дугаарыг зохицуулж, эхний нүүрний материалыг дахин өрсөн байх нь ээ. Гэхдээ өчигдрийн дугаарыг 23.00 цагаас оройтуулаагүй гэсэн. Яаж амжив аа? Ядах юмгүй. Тэр Ассошейтэд Пресс агентлагийн мэдээг ашиглажээ.

**Америкийн  
«залхуу»  
сэтгүүлчид  
олон агентлаг,  
бие даасан  
бичигчдийн  
материалыг  
ашиглах юм.**

Америкийн «залхуу» сэтгүүлчид олон агентлаг, бие даасан бичигчдийн материалыг ашиглах юм. Вашингтонд үдэш буудуулсан эмэгтэй хэн болохыг тодруулах гэж хаа байсан Умард Дакотагаас хөөцөлдөлтэй биш. AP агентлаг асар шуурхай ажиллаж өглөөний сонинуудыг мэдээгээр хангажээ. Эд нар нэг л хялбар ажиллах шиг санагдана. Чимээгүй оргиод. Тэр чимээнд л гол ялгаа харагдаад байна. Редакцийнхаа томоо, шуугиант танхимыг энд санаж яваа боловч, бид алхам алхмаар хөгжлийн араас тэмүүлж буйг бас мэдэрлээ. Өрсөлдөөн дунд хэдхэн жил амьдарсан Монголын сонинуудад эргэж харах чөлөөт хэвлэлийн сургамж, туршлага байхгүй ч менежментийн зөв замаар хэдийнэ өөрсдөө алхсан. Харин хурдыг нэмэх техник хэрэгслээр ядмаг.

Би олон зүйл «хулгайлж» чадсангүй, Эрхлэгчээ. Бид зөв замаар явж байна. Харин өмнө маань ялимгүй бэрхшээл бий. Яг өнөөдөр шавар, шороо туучин Монголын сэтгүүлзүйг авч яваа сурвалжлагч нар тэр бэрхшээлийн ард шинэ хэвлэлийн түүхийг хөглөн гаргана хэмээн навсгар шар дэвтэртээ тэмдэглэлээ.

2002 он

# Арван жилийн өнгө үйл явдлын дэлгэц дээр

*Үйл явдлын салхин дундуур туучин одоодоо бид халааснаасаа санаандгүй унагасан дотно үгтэй захидлыг эргэж үл дурсана. Урагш тэмүүлэн амь тэмцэх энэ өдрүүдийн өнгийг голж , цаашаа, улам алсад гайхамшигийг хайн бухимдацгаах аж. Тэгвэл цэцэрлэгт гэсэн хуучин захидал чинь өнөөдөр болтол алхсан урт замын эхлэл, учир утга байж. Түүнийг одоотойгоо харьцуулан , ахиж өөдөлснөө үнэлж сурахын тулд үнэгэдсэн тэр цаасыг зөөлхөн тэнийлгээд үзэхсэн.*

Есдүгээр сарын башёд Даваагийн Батбаяр ес ялж, зургаа унана. Ингэж үзмэрдэхийг минь хараад «хэ, хэ» хэмээн инээх нь үү, Та. Арван жилийн өмнөх алтан шаргал есдүгээр сард сүмогийн ертөнц дэх монголчуудын амжилт ийм үзүүлэлтээр хэмжигдэж байлаа. Өнөөдөр тэгвэл Монголын 36 хүчтэн сүмогийн дэвжээнд зодоглон, 15, 14 дэх ялалт л бидний санааг амраах болж. Арван жилийн дотор бидний хүрч чадсан гайхамшгуудын нэг энэ биш гэж үү. Телевизийн дэлгэцнээс түр холдон салхивчаа нээгээд, арван жилийн өмнөх амьдралын өнгийг дахин хамтдаа ажъя.

Оройхон «тог» тасарч магадгүй ээ. Цахилгааны тасалдал манай баатрын амьдралын мөн л нэг «хэсэг» байлаа. Хотын айлууд боловч лаа, шүдэнзний нөөцтэй. Учир нь тэр өдрүүдэд эрчим хүчний хямрал Монгол орны эдийн засагт чөдөр тушаа болж байлаа. Өнөөдөр бол лааны хугархай хадгалах айл цөөн биз. Бас ард түмэндээ баргар мэдээлэл түгээдэг Ерөнхий сайд эдүгээ моодноос гарчихаад байна. Ерөнхий сайд М.Энхсайхан олон нийтэд хандан «Эдийн засгийн хувьд 1996 он нэн тааламжгүй жил» хэмээн зарлаж асан өдрүүдэд эргэн саатъя. Энэ бичлэгийн баатар тэгэхэд зээл авахаар хөөцөлдөөд үзжээ. Арилжааны 12 банк бий. Одоогийнхоос онц ялгарах тоо биш. Харин зээлийн чанар, банкны үйлчилгээ гэж дэндүү ядмагхан байсныг тэрбээр дурсана даа. Сард 5-15 хувийн хүүтэй , өөрөөр хэлбэл жилд 180 хүртэл хувийн хүү төлдөг зээлийн мөлжлөг гэмээр харилцаа хэвшээд байв. Өдгөөтэй харьцуулбал тэмээ, ямааны зөрөө бий. Банкуудын ээлж дараалсан дампуурлын он жилүүдийн оргил нь 1996 он. Мөн оны арванхоёрдугаар сарын жихүүн өдөр Ардын банк, Монгол даатгал банкны хаалга үүдийг дангинатал түгжээд авсан гэнэ. Төлбөрийн чадваргүй банкуудаа төр цэгцэлж байна. Энэ мөчөөс банкинд итгэх иргэдийн сэтгэл алдарч эхэлсэн. Найдваргүй банкны тухай тодхон дурсамжууд нь харин сүүлийн хэдэн жилд л ялимгүй мартагдаж эхэлжээ. Яг арван жилийн өмнө Ард банкны суурин дээр үүсгэн байгуулсан Хадгаламж банк хэдхэн өдрийн дараа хувьчлагдах гэж байна. Монголын банкуудын түүх аравны уртад ийнхүү эмхлэгдэн зузаарсаар байна.

Баасан гаригийн тухай хэлц үг тэр үеэс л монголчуудын үгсийн санд нэвтэрсэн гэнэ. «Хар баасан гаригийн» айдас аравны уртад ч арилсангүй. Дээрх хоёр банкны захирлуудыг баасан гаригт халж орхиод гэрийнх нь утсыг хүртэл тасалсан хэмээн Монголын нийгэм шуугицгаав. Тэгсэн бас өмнөхөн нь буюу наймдугаар сарын 9-ний баасан гаригт бүр аймаар явдал болжээ. Төрийн мэдлийн зургаан том компанийн захирлуудыг нэг өдөр зэрэг халж орхисон сенсаац шинэ цагийн түүхэнд ховор баримт болон хоцорчээ. Ийм огцом өөрчлөлтүүдийн дунд 1996 оны баатар маань амьдарч байлаа. Төр хатуу байж,

иргэн түүнээс бяцхан эмээж амьдарсан он цагийн шувтарга гэлтэй.

Монгол Улсын 14 дэх Ерөнхий сайд М.Энхсайхан өмнөх танхимын тэргүүнээс өөрийнх нь хэлснээр «ганц хуудас цаас гардаж авч» байх үед манай хойд хөршид мөн л сонгууль болоод өндөрлөж билээ. Борис Ельциний засаглалын жилүүдийн тухай энэ цагт нэхэн санахад сонирхолтой. **«Зүрхний багтраагаар Ельцин шаналж байна. Тэр маш хүнд хагалгаанд орлоо. Мэс заслын өрөөний ойролцоо Батлан хамгаалахын сайд Е.Чазов байна. Хэрэв муу зүйл тохиолдвол Оросын «цөмийн цүнх» Чазовт очих ёстой»** 1996 оны намрын өдрүүдийг «халууруулсан» ийм өнгө аястай гадаад мэдээлэл хөвөрч байлаа. Тэр жилийн ертөнцийн амьдрал дахь үйл явдлыг өнөөдөртэй харьцуулан харвал арван гэдэг асар урт, үгүй бол дэндүү ахар хугацаа мэт санагдана. Б. Ельциний бие муу, гэвч тэр хоёр дахь удаагаа Ерөнхийлөгчөөр сонгогдож чадсан, оросууд Чеченд цуврал ялагдал хүлээлээ, уулын ард түмний уур хилэнг тогтоон тайтгаруулж чадах хүн бол Александр Лебедь хэмээн Орост төдийгүй Европод итгэж байсан юм. Гэвч эмгэг өвчнөөсөө түр илааршмагцаа Ерөнхийлөгч Ельцин генерал Лебедийг албан тушаалаас нь хусч, хэн ч биш болгохыг хүссэн билээ. Зөрчил хямрал



дүүрэн 1996 он. Бас дэлхийн түүхэнд шинэ нэрс тодрон гарсан жил. Египет эр Бутрос Галийн оронд Гана улсын иргэн Кофи Аннан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдов. Энэ хүнд НҮБ-ыг эрс шинэчлэх багц төлөвлөгөө бий гэнэ. Тэр үеийн дэлхийн халуун цэгүүдийг газрын зураг дээр тэмдэглэвэл өнөөдрийнхөөс онцын ялгаагүй. Б.Натьянаху Сирийн удирдагчидтай хэлэлцээ хийгээд л. Харин Кабулыг талибанууд есдүгээр сард эзлэн авсан байлаа.



Дэлхийн зах зээл дээр зэс болоод ноолуурын үнэ ихээхэн унасан өдрүүдийн тухай 1996 оны баатар маань өгүүлнэ. Зэсийн үнэ өмнөх жилийнхээсээ 33, ноолуурынх 15 хувиар буурчээ. Яг арван жилийн өмнө бид илүү ядуу амьдарч байж. Баяжихын тулд Монгол Улсын Ерөнхий сайд гадаадын хөрөнгө оруулагчдыг урин залъя хэмээн мөрөөдөж байсан юм. Чухам энэ өдрүүдэд тэрбээр хөрөнгө оруулагчдын анхны томоохон чуулга уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулахаар зориг шулуудсан байлаа. Дараа жилийн

хавар нь мөнөөх чуулга уулзалт болсон. 1996 оны тухайд ойн түймэр төдийгүй холер өвчин улс орны амьдралд бага гэлтгүй дарамт авчирсан юм. Гамшиг, өвчин зовлонгийн хажуугаар Засгийн газар огцом гэнэтийн шийдвэрүүд гарган олон нийтийг цочирдуулж байлаа. Суурь үнэ буюу цахилгаан, дулааны үнийг чөлөөлөх / нэмэх/ тухай яриа энэ цагаас эхлэн олны ой тоонд рефлекс болон тогтов. Өнөөдрийн иргэдийг бодвол хамаагүй хүлцэнгүй, төр , засгийн шийдвэрийг дуулгавартай хүлээж авамтгай, мөнгөгүй, зээлийн хүүнд баглуулсан монголчуудын дүр төрх арван жилийн тэртээгээс үзэгдээд байна. Гэвч нэгэн аравны эргэлтэд бид бараг танигдамгүй гэмээр шинэчлэгджээ.

Тэр өөрчлөлтийн тухай бичсээр сонины маань түүх ч зузаарсан харагдана. Бичлэгийн баатрууд нь бид өөрсдөө байж.

**2006 он**



# А.М болон Р.М уулзалт

Бид хэд хоорондоо ингэж ярьдаг байлаа. Өөрөөр хэлбэл, өглөө цуглаж мэдээгээ авах, үдээс хойхно дахин ширээ тойрч суугаад маргаашийн дугаараа цэгцэлж нэг харах явдлыг их л «америкжуулан» ийнхүү нэрлэдэг. Явсаар өнөөх хэллэг маань «хар макет ярих» болон монголчлогдов. Нэр томъёондоо учир жанцан байгаа юм биш ээ.

Монголын өдөр тутмын сонинуудын хуудас нэмэгдэж, хүндийн жин дарах тусам тухайн редакцууд төлөвлөлтдөө түлхүү анхаардаг болжээ. Хамгийн шуурхай төлөвлөгөө, хамгийн цахилгаан хэрэгжилт гэж тэрхүү а.т болоод р.т уулзалт дээр ярьж тохирсон мэдээ материалыг л хэлэх байх. Хэвлэлийн аль ч редакц долоо хоног, сарын төдийгүй улирал, жилээр нь алсхан харсан бодлого төлөвлөгөөтэй. Тэдгээрээс өдөр тутмын ажлын төлөвлөлт онцгой билээ.

Тэргүүн нүүртээ ямар гэрэл зураг тавих вэ гэдгийг хэдхэн жилийн цаадтай бид ярьж хэлэлцдэг байсан билүү? Энэ дугаарын тулах цэг, гол материал, тэр өдрийн сенсаац үйл явдлын мэдээллийг ямар гарчигтай өгөх вэ гэхчлэн ярилцах, дахин өөрчлөх, илүү сайн сонголт дээр санал нэгдэх шаардлага урган гарсаар байна. Сэтгүүл зүйн бүтээгдэхүүнд чанараас гадна хурд гол үнэлэмж болж хувирлаа. Телевизүүдийн өрсөлдөөн, өдөр тутмын сонинууд эгнээгээ тэлсэн явдал, шинэ цагийн уншигчийн хэрэгцээ, мэдээллийн

сайтуудын түрэмгийлэл зэрэг хүчин зүйл бидэнд маргаашийн дугаараа дахин, давтан чанаржуулах шаардлага тулгалаа. Монголын өдөр тутмын сонинууд мэдээж Washington Post шиг, New York Times лугаа олон хуудас төлөвлөх цаг хол байна. Budget нэртэй зузаан материал барууны хэвлэлийн редакцуудад өдөр тутам бэлтгэгддэг. Тухайн өдрийн хувьд Үндсэн хууль, чиг зам заагч гэлтэй тэр нүсэр төлөвлөлтийг харахад уншигчдадаа жинхэнэ чанартай бүтээгдэхүүн хүргэж сурсан буурал түүхт редакцуудын ажлын амжилт эндээс эхтэйг ойлгож болно.

Манай хэвлэлийнхэн эл энгийн туршлагыг өөриймсүүлж яваа нь сайн хэрэг. «Өнөөдөр» сонины коллег их үд хэвийхийн алдад дахин тойрч суугаад «үүнийг түүнийг ингэе тэгье» хэмээн маргаашийн дугаарын хэдэн нүүрийг баллаж цохолдог заншилтай болжээ. Гэрэл зургийн сонголт дээр нухацтай ярьцгаана. Ялангуяа «Бизнес», «Нийгэм», «Урлаг» гэхчлэн сэдвээр бүлэглэсэн секцтэй болсноос хойш зураг, макетийн ач холбогдол өндөрт тавигдлаа. Америкийн хэвлэлүүд шиг АР агентлагаас шуурхай үйл явдлын мэдээллийг гэрээгээр авчихна гэж манайд байх биш. Хоногийн 24 цагт удам Монгол нутагт болж өнгөрөх мянга түмэн үйл явдлын хамгийн халуунаас сонины хуудаст багтаахын тулд дугаарын төлөвлөгөөг өглөө нэг тоймлож аваад, үдээс хойш дахин тодруулж, харуй бүрийгээр ч наана цаана гэсээр сууна.



The Washington Post

1:14:47PM 09-24-2002

# THE BUDGET

EDITIONS OF WEDNESDAY, SEPT. 25

## National PRESIDENT

**PRESIDENT** *milbank* 18  
if. day story, has cabinet meeting

**BUDGET** *allen* 24  
Mitch Daniels is looking at education cuts as the administration confronts perpetual defeats and the ongoing war or wars. He says return to black in 2005 now unlikely

## POLITICS

**FEC** *edsall* 16  
The FEC, writing the regs to enforce McCain-Feingold, has proposed tough restrictions on "electioneering" during the 30 days before a primary and 60 days before a general election. These regs, likely to spur strong debate, would sharply limit the ads that independent groups can air in a campaign's closing weeks.

**\* DEMOCRATS** *vandehei* 24  
Anti-war congressional Democrats -- or at least those with serious reservations about Bush's Iraq policy -- have been frustrated by leaders such as Daschle and Gephardt who give little or no voice to their concerns. Now Al Gore and Jimmy Carter, among others, are providing the type of leadership they've been wanting. Where do they go from here?

**\* GOP** *milbank* 30  
in contrast to this summer's stock market/economic swoon, Bush isn't delivering the "I care message." Rather he is emphasizing the war crowd economic bad talk and nationalize support for the GOP. Republicans on the hill are doing the same thing--polls show public is focused on Iraq and they are trying to manipulate hill activity to play to their favor

**POLITICS** *staff* 14  
the column


## CONGRESS

**\* INQUIRY** *dewar* 22  
The Senate votes to create an independent commission to look into events leading up to the 9/11 attacks.

**WASH** *staff, wires* 13



«Вашингтон Пост»  
соины 2002 оны  
есдүгээр сарын 24-ний  
дугаарыг хэрхэн  
бэлтгэж, «хар макетаа»  
яаж төлөвлөснийг  
хараарай.



# Ерөнхий сайдууд ба мэдээлэл

Тэдний дүр төрхийг зураглая. Ерөнхий сайд болсноосоо хойш М.Энхсайханы зовхи унжиж, Ц.Элбэгдорж намба сууж Ж.Наранцацралтын сахал шингэрч, Р.Амаржаргал пингүү засалт сонгосныг цэнхэр дэлгэцээс бид ажиглаж л байсан. Гэхдээ ийм өөрчлөлтөөс ямар нэг дүгнэлт хийх аргагүй. Харин хэвлэлийн мэдээлэл, үзэглэсэн шийдвэрүүдийнх нь утга чанараас тэдний дүр төрхийг ургуулах нь хялбар.

Их дэлгүүрийн ажилчид өлсгөлөн зарласан 1996 оны зуны эхэн сарыг санаж байна уу? Тэр үед «Ил товчоо» сонин өлсгөлөнгөөр сенсаацалж, бусад хэвлэл энэ үйл явдлын хажуугаар чимээгүй өнгөрч байв. Их дэлгүүрийн үнэлгээг нэг тэрбум 800 сая төгрөгөөс гурав илүү тэрбум болтол өсгөж байж ажилчдынх нь эсэргүүцлийг зогсоосон том шуугианыг хэвлэлүүд «анзаардаггүй» сайхан цагт М.Энхсайхан Ерөнхий сайдаар сонгогдсон юм. Тиймээс ч түүний бодит төрхийг хэвлэлийн хуудаснаас бүрдүүлж төсөөлөхөд хэцүү. Тэр олон том асуудлыг дараалан барьж авсан. М.Энхсайханы үед Монголын радиоогоор «Есөн сар, есөн шинэчлэл», Монгол телевизээр «Шинэ зууны босгон дээр» зэрэг нэвтрүүлэг цацагдаж, «**Үнэ чөлөөлөлт зайлшгүй байлаа. Ийм арга хэмжээ авснаар бүтээгдэхүүний үнэ өснө гэдэг худал. Учир нь суурь үнийг үндэслэлгүй тогтоосон. Суурь үнэ чөлөөлснөөр ирээдүйд хүрэх зам дөтлөв**» гэсэн дүгнэлт хийж байлаа. «**Зардлаар нь тогтоодог тогтмол цалингийн үе дуусгавар болж, үр дүнгээрээ хөдөлмөрийн хөлсийг авах боллоо. Цалин бол хөдөлмөрийн үнэ. Үнэ юм бол чөлөөтэй байх ёстой**» зэргээр хэвлэлд М.Энхсайханы эхний алхмуудыг бичив. Харин нүүрс, шатахуун, эрчим хүчний үнэ нэмэх шийдвэрийг хэрэглэгч хэрхэн хүлээж авахыг мэдээллийн хэрэгслүүд сонирхоогүй. Тэд уншигч, үзэгчтэйгээ эргэх холбоогүй тэнэж явсан цаг. Албан ёсны мэдээлэл М.Энхсайханыг шийдмэг, эрч хүчтэй, зөв алхам хийсэн Ерөнхий сайд болгон зурж итгүүлсэн. Ийм болохоор түүний гэнэт огцорсон шалтгаан олон түмэнд ойлгомжгүй хоцорч, дараагийн Ерөнхий сайдыг Исмэл тайж мэт үл итгэн хүлээж авахад хүргээ биз.

Ц.Элбэгдоржийн үед чөлөөт хэвлэлүүд хашир болчихсон байлаа. Шинэ танхим өөрийн талын мэдээллийн хэрэгслүүддээ найдан дээрх өөрчлөлтийг дутуу үнэлж, банкны шинэчлэл мэтийн аварга асуудлыг хормын зуур нугалж авахаар шийдсэн. Ц.Элбэгдоржийн баг тас хар, эсвэл өөгүй цагаан мэтээр энэ үеийн сонинуудын хуудсанд буужээ. Дараа нь Ц.Элбэгдорж эргэх холбоо хэрэгтэйг мэдэрсэн. Түүний танхимын сайдууд долоо хоног тутам хэвлэлийн хурал зарлан сэтгүүлчидтэй нүүр тулдаг байлаа. Ерөнхий сайдын дүр төрх мэдээж танхимынхаа дэлгэц дээр илүү тодорно. М.Энхсайхан ганцаараа Засгийн газар мэт харагддаг байсан бол Ц.Элбэгдорж хүчтэй сайдуудынхаа зоргоор дуугарч байх шиг олонд мэдрэгдсэн.

Тэгвэл Ж.Наранцацралтын танхимынхан даваа гаригт албан бусаар уулзаж, ажил төрлөө ярилцдаг байлаа. Ж.Наранцацралт энгэртээ жижигхэн шигтгээтэй очир зүүлт байнга зүүдгийг сонины гэрэл зургаас харж болно. Сайдууд нь ч бас ийм тэмдэгтэй. Тэрбээр танхимдаа найдаж, нэгдмэл уур амьсгалтай байлгахыг чармайж ирсэн. Төсвийн данс хоосон он давсан үед тэр засгийг тэргүүлж, бүтэн улирлын турш цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өр барагдуулахаар үйлээ үзсэн билээ. Ж.Наранцацралт татварынхан, Төрийн өмчийн хорооныхныг ажлын бус өдөр цуглуулан төсөвт ахиухан мөнгө өгөхийг шаардаж, хариуцлагын тухай ойрд сонсогдоогүй хатуу үгс хэлсэн юм. Ер нь тэрбээр

Ерөнхий сайдуудын өнгө өнгийн төрх хэвлэлийн хуудас, гэрэл зургийн хальсанд үлджээ. Хэвлэл, сайд хоёр энэ хугацаанд хамтдаа өсч өндийв. Ерөнхий сайдуудыг үнэлэх шалгуур өнөөдөр улам нарийссан.





1997 оны XII сар

М.Энхсайхан Дуурийн театрын үзэгчдийн суудлаас тайз руу гүйхээрээ гарч ирсэн юм. Тэр «Гоо марал»-ын шагнал гардуулахаар инээмсэглэн, өөртөө итгэл дүүрэн зогсч байлаа. Түүний үзэглэсэн шийдвэрүүдийг зоримог хэмээн нэрлэж, ийм ховсонд орсон олон нийт эерэг сэтгэгдэлтэй болсон билээ.



1998 оны XI.24

80, 144 дүгээр тогтоолууд гарсны дараа Ц.Элбэгдорж Төрийн ордны зүүн жигүүр дэх өрөөндөө сэтгүүлчдэд мэдээлэл хийх болов. Тэр нээлттэй Ерөнхий сайд болсон ч хэвлэлийн хатуу, хорон шүүмжлэлд өртсөөр байв.



1999 оны V.29

Ж.Наранцацралт хотын дарга зэрэг олон хүн дагуулаад «Ногоон хувьсгал»-ын үр дүнг үзэж явлаа. Тэр аж ахуйч, хамтач Ерөнхий сайд гэж хүмүүсийн санаанд үлджээ.



1999 оны VIII.30

Сонгогдох мөч. Р.Амаржаргал хэвлэлийнхний дуран харааны өмнө байгаагаар бусад Ерөнхий сайдаас илүү мэдэрч байна. Алхам бүрийг нь сонинд хөөж нийтлэхийг мэдэрч сууна. Шийдвэрийг өөрийнхөөрөө гаргахад хэцүү байх биз ээ. Олон нийтийг дандаа бодолцох төвөгтэй, тооцохгүй бол осолтой..

хамтарч ажиллах дуртай. Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанд аймаг, хотын Засаг дарга нар, агентлагийн удирдлага, банкны захирлуудыг хамт оролцуулан нүсэр ажил сэддэг байв. Хэвлэлийнхнийг ч мөн л бөөнөөр нь цуглуулдаг болов. Засгийн газрын хуралдааны мэдээллийг олонд нээлттэй хийж, Төрийн ордны Г танхимд хэн дуртай нь ирж байлаа. Ж.Наранцацралт яамдын хэвлэлийн төлөөлөгчдөд идэвхтэй ажиллах үүрэг өгсөн. Гэвч ийм шахалт нь удаах Ерөнхий сайдын үед хүнд суртлын хана болон бэхэжсэн билээ. Үүргээ ойлгоогүй хэвлэлийн төлөөлөгч яам, агентлагийн ажлыг олонд сурталчлах бус, харин ч цензур тавигч, сэтгүүлчийн муу нөхөр гэдгийг тэр мэдэж байсан болов уу.

Харин Сангийн яам мэтийн хамгийн хаалттай газарт Р.Амаржаргалын үед хэвлэлийн алба ажиллаж эхэлсэн. Өнөөгийн Ерөнхий сайд 1996 онтой харьцуулахад мэдээллийн өргөн довтолгоон, хяналт дунд явна. Мэдээллийн хэрэгслүүд олон нийтийн талд дуугарах болсон үед тэрбээр хэвлэлийн хуудаснаа эерэг имиж олохыг эрмэлзэж байна. Гэвч түүнд сониныхон «хиймэл, ойлгомжгүй, зөрчилтэй» гэсэн тодорхойлолт хэдийнэ өгсөн. Өмнөх Ерөнхий сайдуудын баруунжсан, эсэл зүүн зүг жолоо мушгисан үйл ажиллагааны ялгарлын дараа бодсоноо өөрийнхөөрөө хэрэгжүүлэх нь түүнд бэрхшээлтэй байгаа бололтой. Тэр нийгмийн халамжийн талаар ярьж, дараа нь үнэ нэмэх хэрэгтэй хэмээн гэнэт ундууцах нь сонин. Ц.Элбэгдоржийн дараахнаас Засгийн газрууд хаширлах тактикт шилжиж, нийгмийн санаа бодлыг харгалзах гэсэн үгс алив шийдвэрийн эргэн тойронд сонсогдох болсноос энэ биз. Ерөнхий сайдуудын өнгө өнгийн төрх хэвлэлийн хуудас, гэрэл зургийн хальсанд үлджээ. Хэвлэл, сайд хоёр энэ хугацаанд хамтдаа өсч өндийв. Ерөнхий сайдуудыг хэмжих шалгуур өнөөдөр улам нарийссан.

М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт, Р.Амаржаргалын талаарх сэтгэгдлийг давж гарах хүнийг 2000 оны сонгуулийн дараа олон нийт хүлээн зөвшөөрнө. Энэ хүн хэвлэлийн дуран хараанд бүр илүү онилуулна. Мэдээлэл түүнийг янз бүрээр будна. Өглөө бүр тэрбээр өөрийнхөө тухай мэдээллийн тойм сонсохоор Хэвлэлийн албаа сандаргах нь лав.

1999 он



# Хэвлэлийн төлөөлөгч, сурвалжлагч хоёр ямар ялгаатай вэ?

*Эдийн засаг, улс төрийн өрсөлдөх чадвар ба олон нийттэй харилцах нь сэдэвт чөлөөт хэлэлцүүлэг- семинар энэ сарын 7-нд болсон. Уг семинар дээр олон нийттэй харилцахад хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүргийн талаар санал бодлоо илэрхийлэх боломжийг «Өнөөдөр» сонинд олгосон билээ. Тус сонины Хариуцлагатай нарийн бичгийн дарга Л.Болормаагийн ярьсныг энд нийтлэв.*

Сайн байцгаана уу. Би «Өнөөдөр» сонины сурвалжлагч. «Өнөөдөр» сониныг Та бүхний олонх мэддэг байх аа гэж найдаж байна. Гэхдээ би энд «Өнөөдөр» сонины захиалгын кампанит ажил явуулах гэж ирсэн тусгай даалгавартай хүн биш. Харин, **албан эх сурвалж, дундаж уншигч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл** гэсэн гурвалжингаар бол өнцөг тус бүрт орших бүлгүүдийн хооронд уялдаа холбоо өнөөдөр хэр байгааг сониныхоо жишээн дээр тулгуурлан ярих гэсэн юм.

Эхний жишээг татъя. Энэ танхимд цугласан шиг олон хүн тойрч суугаад, мөн л нэг иймэрхүү илтгэл, асуулт хариулт өрнөсөн тохиолдлыг санаж байна. Тодруулбал, энэ оны гуравдугаар сарын 16-ны өглөө Төрийн ордны Б танхимд нөгөө гурвалжны хоёр өнцгийнх нь эзэд буюу **төр, засгийн төлөөлөгчид** ба **хэвлэлийнхэн** байраа эзэлсэн байлаа. Тэр өдөр Санхүү, эдийн засгийн сайд, Дэд бүтцийн сайд, Төрийн өмчийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуйн яамны түшмэл зэрэг үнэт мэдээллийн эх сурвалжуудыг нэг дор «амьдаар нь» харж, асуулт тавих боломж сэтгүүлчдэд олдсон билээ. Тэгэхдээ бүр тэр түшмэлүүд нарийн нандин мэдээллээ сайн дураараа харамгүй хэлж өгсөн. Манай нөхцөлд энэ нь үнэхээр ховор завшаан гэдгийг энд суугаа улстөрчид зөвшөөрнө биз ээ.

Гайхалтай нь, Засгийн газрын хэвлэлийн албанаас зохион байгуулсан уг семинарын ширээний ард, миний баруун гар талд Хууль зүй, дотоод хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгч, зүүн гар талд маань Дэд бүтцийн яамны хяналтын албаны байцаагч, цаашлаад бүхий л яамны хэвлэлийн төлөөлөгчид эгнэн суусан байлаа. Хуралд оролцсон цөөхөн сэтгүүлч сайдуудад тасралтгүй асуулт тавьж, харин яам, агентлагийн хэвлэлийн төлөөлөгч, мэргэжилтнүүд уйдаж суусныг анзаарсан билээ. Яагаад би энэ жишээг нуршиж байна вэ? Яагаад сурвалжлагч яамны хэвлэлийн төлөөлөгчтэй тохой нийлүүлэн суух болов оо гэж л би гайхсан юм. Хагас өдөр үргэлжилсэн уг семинарын эцэст, Засгийн газрын хэвлэлийн албаны дарга С.Мягмар зөөлөн дуугаар ингэж зөвлөв. «За сонсов уу. Та бүхэн энд дуулсан зүйлээ мөн хэвээр нь л цааш мэдээлдэг юм шүү. Сэтгүүлчид алив зүйлийг их өлгөж авч, өөрчилж бичдэг шүү» хэмээн анхааруулсан юм. Өөрөөр хэлбэл, улстөрчид, албан тушаалтнууд нь сурвалжлагч намайг яамны хэвлэлийн төлөөлөгчтэй ижил үүрэг зорилготой хэмээн харж буйг эндээс ойлгосон. **Албан эх сурвалж** мэдээллээ **хэвлэлийнхэнд** тулган өгч «энэ хэвээр» дамжуулахыг «зөвлөсөн» хэрэг. Үнэхээр албаны мэдээллийг үнэнчээр зөөдөг, зөөлөн чихт дуулгавартай мэдээллийн хэрэгслүүд

байдаг бөгөөд гагцхүү тэдний захиалагчийн тоо өдрөөс өдөрт буурсаар буйг тогтмол хэвлэлүүдийн захиалгын харьцуулсан судалгаанаас харж болно.

**Нөгөө гурвалжнаа эргэн саная.** Мэдээлэл ийм тохиолдолд ганц урсгалтай байгаа харагдана. Зөвхөн дарга нараас хэвлэл мэдээллийн байгууллага, цаашлаад олон нийтэд тулган түгээдэг өрөөсгөл урсгал үйлчилж байна. Тэгвэл ийм «өрөөсөн хөлтэй» мэдээлэлд хэрхэн найдаж, итгэх билээ? Ийм мэдээлэл зөв, ашигтай үйл хөдлөлд хүмүүсийг дагуулж чадах уу даа? Үгүй. Үүнийг би мэдээллийн хүчирхийлэл гэж нэрлэмээр байна.

Хэвлэлийн төлөөлөгч, сурвалжлагч хоёр юугаараа ялгаатай вэ? Хэвлэлийн төлөөлөгч уртаас урт уйтгартай мэдээлэл бэлтгэж бидэнд факсаар илгээдэг. Тэр үүргээ биелүүлж, төр засгийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах санаатай байгаа хэрэг. Сайхан нялуун магтаал, цуварсан урт тоонууд, өнгөлж зассан үзүүлэлтүүд л харагдах вий. Тэгвэл сурвалжлагч юу хийж чадах вэ? Нэг талын ийм баримтуудыг сурвалжлагч дундаж уншигчид зориулан «орчуулдаг». Өөрөөр хэлбэл, нөгөө залхуутай нялуун факст дурдсан баримтыг бусад баримттай харьцуулан харуулж, асуудлын бодит төрхийг дундаж уншигчид ойлгоход дөхөмтэй болгодог. Гэхдээ дундаж уншигч гэхээр малчин, эсвэл эмээ, өвөө нар байх нь хэмээн өрөөсгөл ойлгохгүй байхыг хүсье. Түүнчлэн сурвалжлагчид эзэмшсэн зэмсэг бий. Үзэг, цаас хэмээн хадуурах нь гэж бүү айгаарай. Дундаж уншигчтай ойлголцдог тэр **хэл яриаг** сурвалжлагч мэддэг. Ингэж хэлэхээр, мэдээллийг гуйвуулж хүргэх тухай энд суугаа улстөрчдийн толгойд юуны түрүүнд зурсхийх байх. Харин би огт өөр арга хэрэгслийн тухай цухас дурдаж байгаа юм.

**Нөгөө гурвалжнаа эргэн саная.** Мэдээлэл ийм тохиолдолд ганц урсгалтай байгаа харагдана. Зөвхөн дарга нараас хэвлэл мэдээллийн байгууллага, цаашлаад олон нийтэд тулган түгээдэг өрөөсгөл урсгал үйлчилж байна. Тэгвэл ийм «өрөөсөн хөлтэй» мэдээлэлд хэрхэн найдаж, итгэх билээ? Ийм мэдээлэл зөв, ашигтай үйл хөдлөлд хүмүүсийг дагуулж чадах уу даа? Үгүй. Үүнийг би мэдээллийн хүчирхийлэл гэж нэрлэмээр байна.

**Жишээ татъя.** Монголбанкны ерөнхийлөгч О.Чулуунбат өнөөдөр «Инфляц буурлаа» хэмээн сүржин зарлаж байна. Тэгээд юу гэж? Хүмүүст О.Чулуунбатын баяр хөөр шууд ойлгогдож хүрэхгүй л байгаа шүү дээ. Харин, бидний тор сав дотор түлхүү ордог хүнсний хэдэн бүтээгдэхүүний үнэ ялимгүй буурсан талаас нь сурвалжлагч тайлбарладан бичдэг. Энд алив баримтыг дэндүү хялбаршуулан хүргэх тухай яриагүй бөгөөд мэргэжлийн сэтгүүл зүй, түүнд хэрэглэдэг арга барилын тухай өгүүлж байна. Алив үйл явдлыг энгийн иргэнд ойртуулан хамаатуулж хүргэх **шинэ сэтгүүл зүйн** ийм хандлагыг барууны хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ч түгээмэл ашиглаж буйг Та бүхэн мэднэ.

«Өнөөдөр» сонинд «Миний төсөв» нэртэй булан бий. Ярианыхаа эхэнд би манай сонины захиалгын тухай хөндсөн шүү дээ. Байнгын уншигчид маань бол уг буланг сайн мэднэ. Тэнд, хөргөгч тань дүүрэн байна уу, хэтэвч чинь хэр зузаан бэ, орлого нэмэгдсэн үү гэдгийг иргэдийн өөрсдийнх нь яриагаар өгүүлдэг. Ямар ч дүгнэлт байхгүй. Үнэхээр цалин, тэтгэвэр нэмэх шаардлага тулсныг тухайн өрхийн төсвөөс хүмүүс өөрсдөө ойлгоно. «Ч.Улаан сайд цалинг долоон хувиар нэмлээ» гэж бид тоть мэт давтдаггүй. Өнөөгийн ханшаар бодвол сард 1.5 кг мах авч чадах мөнгө л нэмж өгөх нь ээ гэж «Өнөөдөр» сонин уг үйл явдлыг тайлбарладаг. Харин ингэж бичсэний маань төлөө Ч.Улаан сайд ичиж улайдаг байж магадгүй юм. Уг нь «долоон хувиар» гэж мэдээлбэл илүү сүртэй сонсогдож байгаа л даа. Яамны хэвлэлийн төлөөлөгчийн факсаар илгээсэн мэдээ сурвалжлагчийн гарт ороод ямархуу янзаар хувирч байгааг харж байгаа биз дээ. Үүгээрээ л тэр, бид хоёр ялгаатай юм.

Мэдээллийн ийм гүүр бусдыгаа бодвол илүү бөх баг байж чаддаг. Нотолгоог нь хэльсе. «Өнөөдөр» сонины захиалга аажмаар, тасралтгүй өсч байна. Бид мэдээлэл түгээх, олон нийттэй харилцах зөв зам өөд тэмүүлж буй юм биш үү. Түүнчлэн «Өнөөдөр» сонин нийгэмд тулгамдсан, шийдэхийг амьдрал шаардсан томхон асуудлуудыг тойруулан хэлэлцүүлэг явуулдаг. «Зуд

**болдгоороо боллоо, одоо яах вэ», «Боловсрол Та өврийн хаалгаа нээгээч», «Цагаан сарыг хэрхэн тэмдэглэвэл зохистой вэ», «Бидний амьдралын чанар ямар байна вэ» зэрэг хэлэлцүүлэгт маань уншигчдаас маш олон захидал, материал ирсэн. Заримыг нь бид нийтэлсэн. Өөрөөр хэлбэл, иргэдээс төр, засагт хүрэх мэдээллийн эргэх холбоог бий болгохыг бид чармайдаг. Түүнээс бус, энэ нь Хувьсгалт намын ч бай, Эвслийн ч бай Засгийн газрын эсрэг чиглэсэн ээлжит ямар нэг «хорлон сүйтгэх» үйл ажиллагаа биш юм. Тус сонин энэ удаа «Өрсөлдөөн» гэсэн шинэ хэлэлцүүлгээ эхэлж байна. Хэрэв Та «Өнөөдөр» сонины шинэ дугаарыг /№182/ энэ өглөө харсан бол тэнд «Монгол Улсын өрсөлдөх чадвар» сэдвээр бид өргөн олон уншигчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлээ. Энд улстөрч, эдийн засагч, иргэд хэн ч оролцож болно. Гагцхүү үр дүнд нь нийгэмд бага ч гэсэн ойлголцол бий болж, ийм ойлголцол Монгол Улсад ашиг тустай зүйл байгаасай гэж бид хүссэн. Мөн «Өнөөдөр» сонин судалгааны жижиг албатай. Нийтийн сонирхол татсан аль нэг асуудал, төр, засгийн шийдвэр, эсвэл ерөөсөө тус сонины нийтлэлийн чанар чансааг бид ийм судалгаагаар тольдож харахыг зорьдог. Бид ажлынхаа чанарыг хөндлөнгөөс үзэж, мөн төр, засаг гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг нийгмийн толинд хараасай гэдэг үүднээс ийм судалгааны алба ажиллуулж байна.**

Засгийн газрын хэвлэлийн албаны дарга С.Мягмар гуай намайг Хууль зүйн яамны хэвлэлийн төлөөлөгчтэй яагаад адилтгаж, хичээл заах гэсэн юм бол оо? Тэр, иргэдтэй хэрхэн харилцах ёстойгоо, мэдээллийн оновчтой гүүр гэдэг чухам юу болох, олон нийттэй харилцах алба ямар зарчмаар ажиллагчийг мэдэхгүй байгаа хэрэг. Хэвлэлийнхэн дуулгавартай зарц бус, харин мэдээллийн бодит, бөх бат гүүр байх ёстойг улстөрчид ойлгоосой. Ойлголцох эхний алхам болгож энд «Эдийн засаг, улс төрийн өрсөлдөх чадвар ба олон нийттэй харилцах нь» сэдэвт семинарыг зохион байгуулжээ. Тиймээс уг семинарыг зохион байгуулж, санхүүжүүлсэн байгууллагууд болох Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Конрад Аденаурын сан, Биз Монголиа болон Германы Handelsblatt сонинд, мөн энд «Өнөөдөр» сониныг сонгож урьсан хүмүүст гүн талархал илэрхийлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Яамны  
хэвлэлийн  
төлөөлөгчийн  
факсаар  
илгээсэн мэдээ  
сурвалжлагчийн  
гарт ороод  
ямархуу янзаар  
хувирч байгааг  
харж байгаа  
биз дээ.  
Үүгээрээ л тэр,  
бид хоёр  
ялгаатай юм.**

**2001 он**

# Амны алчуур ямар үнэтэй вэ?

Ам арчаад хаядаг нимгэн цаас тун хямдхан. Үнэ хямд боловч үргэлж хэрэгцээтэй өөр бүтээгдэхүүн олон. Харин сэтгүүлчийн мэргэжил, мэдээллийн байгууллага хоёр ийм жагсаалтад яагаад идэвхтэй багтах болов оо?

Үндэсний телевизийн ММ агентлагийнхны 20.00 цагаас цацаж буй зүйл мэдээлэл мөн үү? «Далай багшийг ирээд байхад олныг үймүүлсэн арга хэмжээ зохион байгуулсан нь бурхан шашнаа хүндэтгээгүй явдал мөн» хэмээн телевизийн дэлгэцээс энэ сарын 5-ны орой уурлаж байна. Хагас цагийн турш үзэгчдэд хэрэгцээ сонирхолтой зүйл тун бага ярьсныхаа төгсгөлд Хятадын тал хилээ хаасан тухай ноцтой мэдээг цухас дурдаад дуусгав. Дээрх хоёр үйл явдлын аль нь үзэгч танд чухал байсан бэ?

Өдөр тутмын сонинууд тэгвэл өөр хоорондоо нийтлэлээрээ хэрэлдэх ажилдаа бүр мэргэжил дээшлүүлжээ. «Өдрийн сонин»-д хэвлэгдсэнийг «Зууны мэдээ» үгүйсгэж, маргааш нь эсрэгээр мэтгэлцэж, хөл дор улам зузаарсан цас мөсний аюулыг бодох сөхөөгүй сууцгаана. Баримт, үйл явдал бүр нэг л талаасаа харагдах аж. Тал талаас нь ойлгоё гэвэл хоёр, гурван сонин зэргэцүүлэн уншиж байж, үнэнд дөхүү мэдээлэлтэй болно. Ийм хямдхан мэргэжлийг улстөрчид амны цаас адил ашиглах нь сүүлийн үед бүр дэндэв. «Монголын мэдээ»-гийн нийтлэлийг «Хурд» агентлагийн эфирийн цагаар Ч.Улаан сайд няцааж байна. Удсан ч үгүй Гаалийн ерөнхий газрын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан утасдав.

«Өдрийн сонин» дээр гарсан материалыг залруулж төлбөртэй тодруулга тавих гэсэн юм. Эхний хоёр нүүрт чинь зай байна уу? гэнэ. Өмнөх өдөр нь УБТЗ-ын ХЭГ-ын хэвлэлийн төлөөлөгч зөвхөн өөрөөс нь төмөр замтай холбоотой мэдээлэл авч байхыг манай сурвалжлагчид сануулав. УБТЗ-ын ХЭГ-ын дарга Р.Рашаас Замын-Үүд өртөөнд байдал ямар байгааг бид тодруулж, тэрбээр ийм мэдээллийг өнөөдөр хүн бүр сонирхож буйг ойлгосон учир их ажлынхаа хажуугаар цааргалалгүй хариулт өгсөн юм. Харин хэвлэлийн төлөөлөгч нь өөрөөс нь биш, Р.Раш даргаас хариулт авсан бидэнд уурлах янзтай. Хэвлэлийн төлөөлөгч гэх хүмүүс бяцхан түшмэлийн дайтай «цензурдах» болж, үүрэг зорилгоо ухаж ойлгохдоо тун ч маруухан. Тэр хэрээр төрийн агентлагуудын ажил иргэдийн хувьд хаалттай, нууц болон улмаар таамаг мэдээ дэлгэрч, битүү хатуу мэдээллийн орчинд бид аж төрөх болов. Эргэн тойронд маань ямар үйл явдал өрнөж байна вэ гэхээсээ илүү хэвлэлд юу нийтлэгдсэн, хэнийг хэрхэн дайрах, мөнөөх илд жадаа ямар сонин, телевизээр харуулж, сүрийг үзүүлэх тухай тунгаадаг моод дэлгэрлээ. Үүнийг дагаад нүдэнд торох олигтой баримтгүй, зөвхөн урссан их бухимдал, хараал ерөөл, сэжиг таамаг, нэг ашиг сонирхлоор мэдээллийн байгууллагууд дуугарч байна.

«Энэ бол жирийн хүмүүст зориулагдсан сонин. Тэдний сонирхолд нийцсэн, ашиг тусыг нь хамгаалсан, тэдэнд учир шалтгааныг олоход нь туслах гагц зорилготой» гэж АНУ-ын нэгэн сонин уриагаа тодорхойлжээ. Уг уриа нь «Grand Forks Herald» хэмээх сонины дугаарт өдөр бүр хэвлэгддэг. Гол нь тэд уриандаа үнэнч ажилладаг.

Харин Монголд улстөрчид, сэтгүүлчид улам ойртон нөхөрлөсөөр. Нэгийг нь сонгогч төр түшилц хэмээн томилсон, нөгөөгийнх нь бурсныг уншигч худалдан авч үздэгийг мартаж орхижээ.

Ийм  
хямдхан  
мэргэжлийг  
улстөрчид  
амны цаас  
адил ашиглах  
нь сүүлийн  
үед бүр  
дэндэв.

# Байцаагч түшмэл

Бас нэг байцаагч түшмэл бидний амьдралд орж ирэх нь. Танилц. Түүнийг оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч хэн гуай гэдэг. Тэр бизнес эрхэлж буй бүх хүнийг, нийт хэвлэл мэдээллийн хэрэгслийг, дээр нь уран бүтээлчдийг хянаана. Шинэхэн байцаагч хэн гуайд бөхөлзөх учир нь реклам зар сурталчилгаа өнөөдөр бизнесийнхэнд амьсгалах агаар, хэвлэлийнхэн, уран бүтээлчдэд талх тариа, хэтэвчтэй хэд нь, хэрэглэгчдэд бол амьдралд нэн чухал мэдээлэл нь болсон цаг. Харин байцаагч түшмэл тун олон зүйл шаардахыг эртхэн мэдэж авцгаая.

Яг энэ өдрүүдэд УИХ-ын гишүүдийн өмнөө дэлгээд уншиж суугаа Зар сурталчилгааны тухай хуулийн төслийн 32 зүйлийн лав гуравны хоёрт нь хэн гуайн эрх дархыг баталгаажуулжээ.



## ШИНЭ ТАНИЛЫН ХУУЧИН ТҮҮХ

Владислав Листьев орцондоо буудуулж байх үед бид рекламны ертөнцөд дөнгөж хөл тавиад байлаа. ОРТ-ын захирал мөнөөх зар сурталчилгааны орлогын улмаас амь алдсаныг тэгэхэд бүүр түүр сонссон. Ил цагаан алалцахыг бодоход амь дүйх ажил, асар том бизнес ажээ, реклам. 1995 оны хоёрдугаар сарын 20-ны орой «Время» хөтөлбөрийн дундуур өөгүй цэмцгэр хувцасласан Листьев дэлгэцнээ гарч ирсэн. ОРТ дөрөвдүгээр сарын 1-ээс реклам цацахаа түр завсарлаж буйг тэр зарлаж орхив. Дараахан нь түүний гашуудлын хар жаазтай зургийг олон нийт дэлгэцээс харсан билээ. Нэвтрүүлгүүдийнхээ дундуур явах зар сурталчилгааны бодлогыг ОРТ өөрийн мэдэлд авах ёстой гэж В.Листьев үзээд эхний шийдвэрээ зарласан даруйдаа амь үрэгджээ. Харамсалтай энэ явдлын дараа ОРТ, цаашлаад Оросын рекламны ертөнц зах зээлийн гольдролдоо эрхбиш орж, эфирийн цагийг дамлан худалддаг хар үе нь шувтарлаа. Өнөөдөр Оросын телевизийн сувгуудаас шар айраг сэнгэнэж, кофены уур савсан, G7 жүүс амтлахгүй бол энэ зуны моодноос хол хоцрогдсон мэт санагдах болж, реклам жинхэнэ утгаараа хэрэглэгчийг өдөөн дагуулж байна. Харин тэр давлагаа хэмжээ хязгаартай, үнэнд нийцэх учиртай, рекламаар манипуляци хийх ёсгүй гэж үзсэнээс хууль нь дагалдан гарчээ.

Оростой харьцуулахад Монголын зар сурталчилгааны зах зээл хүчээ авч хараахан чадаагүй. Сурталчилгаа зарим талаар зохицуулах хуулийг амьдрал шаарддаг боловч түүнийг гартаа атгасан байцаагч дөнгөж өндийж буй эхлэлд чөдөр болох юм биш биз. «Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах нотлох баримт, тайлбар, видео болон аудио бичлэг, бусад мэдээллийг зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчээс шаардан авах эрхтэй».

«Өөрийн санаачилгаар, эсхүл бусад этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, шаардлага, мэдээллийг судалсны үндсэн дээр зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээх ажилд шалгалт хийх эрхтэй» гэх мэт заалт болгоомжлох шалтаг болов. Мэдээллийн хэрэгслүүд нийт орлогынхоо 70-80 хувийг рекламнаас олдог гэр жишиг рүү бид алхаж байна. Байцаагч түшмэлийг санхүүгийн гал тогоондоо уриад байхыг хэн хүсэх вэ. Хуулийн ерөнхий бүрхэг заалтыг элдвээр тайлбарлах боломжтой энэ үед Дээд шүүхээс нэг зүйл хүсье.

«Айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд

**хүргэж болох зар сурталчилгааг хориглоно»** гэсэн заалтад орсон холбоо үгсийг нарийвчлан тайлбарлаж өгнө үү. Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагчтай хууль зүйн хүрээнд зөв боловсон харилцахын тулд энэ мэтийг тодруулсан тайлбар шаардагдаж буй юм.

Өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих, хэрэглэгчдэд сонголтыг нь хялбаршуулж өгөхөд зар сурталчилгаа зүйрлэшгүй хөдөлгөгч хүч. Өнөөдөр УИХ-ын гишүүдийн хэлэлцэж буй Зар сурталчилгааны тухай хуулийн заалтууд ерөнхий, бүрхэг бус, юм юманд дайрч оролцоогүй, зайлшгүй цөөн зохицуулалтыг хийхээр батлагдах нь онц чухал. Рекламны үйлдвэрлэл нь 1837 оноос түүхээ эхэлсэн АНУ-д тун цөөхөн зүйлийг хуулиар хоригложээ. Тэд буу зэвсэг сурталчлах, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, радиац, богино долгионы төхөөрөмж рекламдахыг, мөн зуучлалын үйлчилгээ болон ховор амьтдын үслэг эдлэл худалдах зар явуулахыг зөвшөөрдөггүй. Харин бусад олон асуудлыг тухайлбал, манипуляци хийх, хүүхдүүдийг «уруу татах», бусдын бизнесийг «доош нь хийх» тохиолдол бүрийг Рекламны үйл ажиллагаанд хяналт тавих үндэсний зөвлөлд мэдээлнэ. Энэ байгууллага тун олон шат дамжлагынхаа эцэст шүүхэд гомдол гаргах эсвэл зөвлөмж бэлтгэнэ. «Ингэсүгэй, тэгсүгэй» гэж шууд захирахгүй. Зах зээлийн харилцаа ном ёсондоо орж, бизнесийнхээ нэр төрийг эрхэмлэдэг газар хэрэглэгчийн аливаа эргэлзээ, Үндэсний зөвлөлийн гэнэтийн зөвлөмж бизнесийн уналтыг зөгнөдөг болохоор тэр. Проктер, Гэмбл хоёр лаа, саванхан үйлдвэрлэж, түүнээ зарахаар зарлал түгээж явсан XIX зуунаас хойш рекламны хамгийн хүчтэй зохицуулагч нь хэрэглэгч, бизнесийн ёс зүй хоёр л байсан.

Хориг саад  
дундуур тэмтчин  
явахдаа  
Монголын  
нийгэм өнөөдөр  
нэг зүйлийг тун  
их үгүйлэх  
болдоо. Олон  
нийтийн болон  
үйлдвэрчний  
байгууллагуудыг  
нойрноос нь  
сэрээ. Үгүй бол  
энгийн гэмээр  
асуудлыг хүртэл  
хянаж шалгагч  
түшмэлүүд  
олширч, тэд  
амьдрах аргаа  
алхам бүрээс  
маань хайн,  
хуулийг янз  
бүрээр  
тайлбарлах  
болдоо.

Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага хэмээх үхээнц үйл ажиллагаатай газар нийт олны дуу хоолойг хүч болгон илэрхийлж чаддаггүй. Дээр өгүүлсэн АНУ-ын Үндэсний зөвлөл нь олон нийтийн статустай байгууллага бөгөөд эрх дарх ихтэй төрийн байцаагчаас хамаагүй үр дүнтэй үйл ажиллагаа эрхэлдэг. «Аз жаргал гэж юу вэ? EFES шар айргийг амтлаад үз. Тэгээд чи тэр жаргалыг мэдэрнэ». Оросууд ингэж рекламдаад байна. Харин монголчуудад ийм жаргал үзэх заяа тавилан дутжээ. Шар айраг сурталчлах нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хориотой. Онцын шаардлагагүй хориг саадууд дунд бид юм юмнаас эмээсхийн амьдарсаар.

### **ӨӨР НЭГ ТҮШМЭЛИЙН ӨМНӨ ДЭМИЙ БӨХӨЛЗӨХИЙН УЧИР**

Хорио цээр, хориг саад бидний амьдралд тун олон. Хууль зүйн яам 1991 онд «Главлит»-ийг өв залгамжилсан нэгэн шийдвэр гаргасан. Сонин хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бизнес эрхлэх гэж буй бол намтраа бичиж өг. /анкет/ Дээр нь найман зүйлийн бичиг баримт нэхэж шаардана. Нийтлэлийн бодлого ямар байх тухай хүртэл тэнд багтжээ. Хууль зүй, дотоод хэргийн яам өнөөдөр ийм нэг илүү ажлыг үргэлжлүүлэн эрхэлж төсвийн мөнгийг үрдэг. Харин өнгөрсөн намар ажлын хэсэг байгуулж, хэвлэлийг бүртгэдэг зуршлаа болих санаатай, өөр зүйлээр «орлуулахаар» шийдсэн бололтой. Ингэхдээ өнөөдрийнхөөсөө бүр дор хяналтын механизм бодоод олчих вий дээ.

### **ЭНЭ НАМРААС ДУЛААН ХУВЦСАА БЭЛЭН БАЙЛГАХ БАС НЭГ ТҮГШҮҮР**

Оюуны өмчийн байцаагчтай Иргэний хуулийн хүрээнд харилцаж болоод байх боловч эрхэм сурвалжлагчдад эрүүгийн хэрэгтнүүдтэй ижил баривчлагдах «боломж» энэ намраас гарна. Шинээр батлагдсан Эрүүгийн хуульд сэтгүүлчдийн хувьд эвгүйхэн гишгэвэл хоригдох заалтууд орсон. Ийм үед



хуулийн бүрхэг бүдэг нэр томъёог нарийвчлан тайлбарлуулах онцгой шаардлага гарч байна.

**«Компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа болон дамжуулж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хуулбарласан бусад аргаар олж авсан буюу авахыг завдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ».**

**«Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр доромжилсон бол...»** гэх зэрэг заалтуудыг нөгөө «садар самуун хэмээх ойлголтод яг юуг хамруулах вэ?» гэдэгтэй адил тодруулж тайлбарлах хэрэгцээ байна. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн хэвлэл хэмээх олон нийтийн шинэ байгууллагын эн түрүүнд хийх нэг ажил нь дээрх байх биз ээ.

### **ХААНА БАЙНА, ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГА?**

Хориг саад дундуур тэмтчин явахдаа Монголын нийгэм өнөөдөр нэг зүйлийг тун их үгүйлэх боллоо. Олон нийтийн болон үйлдвэрчний байгууллагуудыг нойрноос нь сэрээ. Үгүй бол энгийн гэмээр асуудлыг хүртэл хянаж шалгагч түшмэлүүд олширч, тэд амьдрах аргаа алхам бүрээс маань хайн, хуулийг янз бүрээр тайлбарлах боллоо. Лав зуу илүү байцаагчийн утсыг «лавлагааны шараас» тоолж болно. Тэдний төрөл их олон, сонин содон. Заалны, статистикийн байцаагч, бүтээлийн, бүр уурын байцаагч хүртэл бий. Байцаагч түшмэдийн хатуу хяналт зах зээлийн эхэн үед зайлшгүй хэрэгцээтэй байсан байж магад. Харин өнөөдөр ёс зүйтэй бизнес хийх тухай ихээхэн ярих болж хэрэглэгчийн шаардлага ч нарийсч эхэлсэн. Амьдрал тун хурдан өөрчлөгдөж байгаа энэ үед алхам тутамд тааралдах байцаагч таны амгаланг байн байн эрэн доор гэгч мэхиймээргүй байна.

**2002 он**

# Мэдээлэлгүй монголчууд маскаа тайлаад шидчихэв

«Тоглосон юм аа. SARS-ын сэжиг илэрсэн өвчтөнүүдээс авсан хоолойны арчдас, цусны ийлдсийг бүр өнгөрсөн долоо хоногийн даваа гаригт Япон руу явуулсан гэдэг худлаа шүү». Бараг л ийм утгатай мэдээллийг 18-ны баасан гаригийн орой, амьтан хүн амрахаар харьсны хойно Эрүүл мэндийн яамныхан хийж байна. Өнгөрсөн долоо хоногийн турш түгшүүр тээн «Нөгөө сэжигтэй өвчтөнүүд нь яасан бол?» хэмээн бие биеэсээ сурагласан хүмүүст ийм мэдээлэл цочир хүрснийг яамныхан анзаарсан болов уу. Амны хаалтнаас өөр хамгаалалтыг шийдвэр гаргагчид ард иргэддээ өгч чадаагүй. Бүгдээрээ аюулт ханиадны өмнө арчаагүй харагдсан ч, шинжилгээний хариу ирж яваа хэмээн битүү хатуу горьдлоготой суусан юм. Гэтэл Эрүүл мэндийн дэд сайд «Шинжилгээнд илгээж амжаагүй байгаа. Энэ даваа гаригт арчдас болон ийлдсийг Япон руу явуулна...» гэж ярилаа. Өөрөөр хэлбэл, өнөө өглөө л өвчтөнүүдээс авсан зүйлсийг сая нэг шинжилгээнд илгээж, ард нь монголчууд дахин долоо хоног ам дамжуулан цуурах сэдэвтэй хоцров. Амьсгалын замаар төвөггүй халддаг хөнөөлт өвчний магадлал хажууд тэнэж явахад иргэд нь яагаад мэдээлэлгүй сууж байна вэ?

Амны  
хаалгаа аваад  
шидчихсэний  
дараа  
болзошгүй  
тохиолдол  
нэмэгдэх  
магадлалтай  
гэсэн үгс  
хэвлэлд гараад  
ирэв.

«Монголд SARS-аар хоёр хүн нас барсан гэсэн мэдээг ОПТ анх цацсан. Үгүй ээ. BBC тэгж ярьсан юм. Шинжилгээний хариу нь Улаанбаатарт ирчихсэн юм байна шүү дээ...» Сандарсан хүмүүс ханцуйдаа энэ байтугай элдвийг шивнэлдэж долоо хоногийг барав. Хөргөгчнийхөө хэрээр хүнс базааж, албан газруудад ажлын ердийн хэмнэл нь суларч, гэрээдээ харихын мөн болцгоосонд хэнийг буруутгах билээ. Гэтэл юу болов? Долоо хоногийн эхний өдрүүдэд амны ширхэг хаалт 800 төгрөг хүрч байсан бол өнгөрсөн бямба, нямд нөгөө дөрвөлжин самбай 100 төгрөгний ханштай, нийслэлийнхний олонх маскаа тайлаад шидчихсэн харагдлаа. «Шинжилгээний хариу Японоос ирж гэнэ. Долоо хоногийн дараа мэдэгддэг гэсэн шүү дээ. Тэгсэн Азийн ханиад биш байж таарав. Үгүй бол өдийд хөл хориод бөөн юм болж байх ёстой» Ээлжит цуу ингэж түглээ. Азийн ханиадны вирус тээгч Монголд байж болзошгүй нөхцөл байдал бий болсноос хойш арваад хонох хугацаанд Эрүүл мэндийн яам нийт хоёр удаа хэвлэлийн хурал зарлажээ. Сүүлийнхийг нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад мэдээ явуулснаас нэг өдрийн хойно буюу баасан гаригийн 18.00 цагт хийлгэсэн юм. ДЭМБ-ын сайтаас иргэд, хэвлэлийнхэн «Монголд SARS-ын болзошгүй гурван тохиолдол байгааг» өөрсдөө олж мэдээд, яамны утас шөрмөсийг амраахаа больсны эцэст энэ хэвлэлийн хурлыг зарлажээ.

Уг нь юуны түрүүнд иргэддээ цаг алдалгүй тайлбарлах ёстой биш гэж үү? SARS-ын тохиолдлыг сэжигтэй, болзошгүй, батлагдсан хэмээн гурван янзаар ялгаж буйг баасан гаригийн үдэш л бид тодруулж мэдэх учиртай байсан хэрэг үү.

Өнгөрсөн долоо хоногийн турш дэлхийн, дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монголд Азийн ханиад илэрсэн, илрээгүй тухай зөрүүтэй баримт цацаж байлаа. SARS-ын болзошгүй тохиолдол нь хаалттай мэдээлэл мөн үү? Хятадад уг өвчний тухай мэдээг хязгаарлан цацаж байсан нь олиггүй үр дагавар тарьсныг монголчууд бүр долоо хоногийн өмнө сонссон бус уу. 2002 оны аравдугаар сард Вашингтоны ойролцоо мэргэн бууч 11 хүний аминд хүрээд байх үед Виржинийн Цагдаагийн хэлтсийн ахмад Мүүс америкчуудад бараг Бушээс илүү танил болсон юм. Энэ хүн алуурчин-мэргэн буучийг эрэн

сурвалжилж буй тухай мэдээллийг бараг хоёр цаг тутамд өгч байлаа. Ингэсний хүчинд Мохаммед нэрт алуурчныг иргэд цагдаагийнханд олж өгсөн. Нөгөө сэжиглээд байгаатай ойролцоо цагаан өнгийн машин явж байна хэмээн тэр өглөө Мүүст мэдээлээгүй бол өөр хэдэн хүний аминд Мохаммед хүрэх байсныг хэн мэдлээ.

Мэдээлэлгүй монголчууд маскаа тайлаад шидэж байна. Эрх баригчид нэг их сүйд болохгүй байгаа юм чинь ханиад намжаа биз. Ингэж л ойлгоод хүмүүс тайвширч эхлэв. «Сүйд болоод Засгийн газар ээлжит бусаар хүртэл хуралдаад байгаа биз дээ» хэмээн уурлах тань зөв өө. Харин түүнийгээ олон нийтэд шуурхай, нээлттэй мэдээлэхээ мартчихжээ. Амны хаалтаа аваад шидчихсэний дараа болзошгүй тохиолдол нэмэгдэх магадлалтай гэсэн үгс хэвлэлд гараад ирэв.

**2003 он**

# Золбин факсыг тайлбарлах ХЭВЛЭЛИЙН ХУРЛАА ЯАСАН БЭ?

Шинэ сенсаац дэгдэв. Франц улс дахь Монголын Консул Д.Гэрэлмаа энэ удаа анхаарлын төвд өртжээ. 27 настай энэ бүсгүй Франц улсад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалан ажиллахаар өнгөрсөн жил «төвөөс» томилогдсон юм. Хилийн чанадад эх орноо төлөөлөн суугаа Консул хэмээх албан тушаалын үүрэгт иргэдийн эрх ашиг гэсэн үг том үсгээр бичигдэж, түүний төлөө мөнөөх ажилтан гүйдэг. Консул хар бор, хэрүүл маргаантай түмэн асуудалд хутгалдаж, үхэх төрөх, гэрлэхийг хүргэл өдөр тутам дуулж, сонсч явдаг. Тэгвэл эрхэм Консулын хүлээсэн үүргийн ийм загвар стандарт орхигдож, тэр хүчний байгууллагын төлөөлөгчидтэй адил баривчлах ажиллагаанд оролцсон шуугианд орооцолдлоо. Иргэдээ дээдэлдэг нийгэмд Консул нь цагдаагийнхантай хамтарсан энэ явдал сенсаац дэгдээв.

Д.Гэрэлмааг хариуцсан ажилдаа таарч тохирно гэж үзээд томилолт өгсөн Гадаад хэргийн яамны удирдлагаас өчигдөр доорх тодруулгыг авлаа

**-Сайн байна уу? Эрдэнэчулуун сайд аа. Францад суугаа Консул Д.Гэрэлмааг яагаад эгүүлэн татсан талаар танай яам албан ёсны тайлбар өгнө гэсэн. Тайлбарыг хэзээ өгөх вэ?**

-Манайхан тайлбар өгнө гэсэн гэж үү? Хэдийд тэр вэ? Би ямар нэг мэдэгдэл хийхгүй.

**-Яагаад? Энэ нь дипломат ажилтны үүрэг, ёс зүйтэй холбоотой асуудал биш үү.**

-Дипломат ёс зүйтэй холбож ойлгохгүй байна. Тиймээс ч яамны үйл ажиллагаатай шууд холбоогүй гэж бодож байна. Дэлхийн практикт ийм явдал олон тохиолддог.

**-Суугаа улсаасаа манай дипломатууд өмнө нь ингэж татагдаж байсан гэж үү?**

-Манайд бол үгүй л дээ. Өмнө нь ийм явдал тохиолдож байгаагүй.

**-Д.Гэрэлмаа Монголд ирсэн үү?**

-Тэр ирсэн эсэхийг мэдэхгүй юм.

**-Францын Гадаад хэргийн яамнаас албан ёсоор тайлбар хүссэн үү?**

-Францын Гадаад хэргийн яамнаас элдэв эсэргүүцэл, бичиг ирээгүй гэв.

Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунтай ярьсны дараа тус яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Хүний нөөцийн хэлтэст хандав.

**-Танай ажилтан Д.Гэрэлмаа Монголд ирсэн үү?**

-Тэгсэн. Харин яам дээрээ бол хараахан ирээгүй байна гэж тус хэлтсийн дарга Нямаа хариуллаа.

С.Зоригийг хөнөөсөн хэрэгт сэжигтнээр шалгах гэж Дамирангийн Энхбатыг Францаас Монгол руу «зөөх» ажиллагааны эцэст ийм нэг сенсаац дэгдэж, манай дипломат албаны түүхэнд шинэ хуудас нээжээ. Д.Энхбат нь 13 жилийн ял завшсан гэмт хэрэгтэн хэмээн эрх баригчдыг дэмждэг хэвлэлүүд дэлгэн, үйлдсэн болгоныг нь зүйл ангитай нь, бараг таван жилийн өмнөх албан баримтуудаар нотлон шуугиулж хаялаа. Харин үйл явдлын эсрэг талд сөрөг хүчний хэвлэлийнхэн золбин факс үзүүлэн асар сонирхолтой сенсаац дэгдээв. Хэвлэлийн редакцуудын факсын дугаараар илгээсэн тэр захидлын агуулга үндэстэйг батлах гэсэн шиг Д.Гэрэлмаа бүсгүйг Монголд эгүүлэн татжээ. Энэ оны тавдугаар сарын 18-ны өдөр МИАТ-ийн Берлин- Улаанбаатар нислэгийн үеэр танхимд түрдэг тэрэгтэй хүн оруулж, гурван биерхүү залуу тэрхүү ядруу

зорчигчид халамж тавин авчирсан юм. Бие муутай хүнийг зузаан хучлагаар нямбайлан «өлгийдсөн» байлаа. Өмнөхөн нь Брюссель дэх МИАТ-ын төлөөлөгчийн газрын ажилтнуудад «Гэмт хэрэгтнийг авч явах гэж байна. Хоёр хучлага өгөөрэй» хэмээн цагдаагийнхан бололтой чухал хүмүүс захиалга өгсөн аж. Тэгэхээр МИАТ-ынхан ядруу өвчтөн хэн болохыг мэдсэн, харин зорчигчид зайлуул хэмээн бодсон байлгүй. Нислэгийн төгсгөлд «асрагчид» онгоцны үйлчлэгчээс хэрэглээний хутга гуйж. Нойрсуулах эм өгөөд амыг нь скочдон, цагаан хуудсаар хил давуулсан Дамирангийн Энхбат нь ноцтой гэмт хэрэг буюу С.Зоригийг хөнөөсөн аллагад оролцсон байж мэднэ хэмээн шалгахаар ийнхүү зөвөрлөжээ. Энэ тохиолдлоос өмнө бүр холын Америкаас «ард» Батсүхийг мөнөөх хэрэгт холбогдуулан бас зөөсөн туршлага манай хүчнийхэнд бий. Батсүх эсэргүүцэж, өлсгөлөн зарлаж, шоронд сууж, эцэст нь «аавынхыг» орхиод сураг чимээ тасарч билээ. Хэлмэгдсэн, хэлмэгдүүлсэн уг тохиолдолд нэг их асуудал босолгүй чимээгүй өнгөрөв. Тэгвэл Д.Энхбат бие тааруу нэгэн байж, мөн санаанд багтамгүй аргаар түүнийг Монголд авчирсан нь илүү сенсаац дэгдээлээ. Иргэний нийгмийн дуу хоолой хүчтэй сонсогддог орнуудад бол ийм зөөврийг хүн хулгайлахтай адилтгах агаад тэр операцид нь гадаадад суугаа иргэддээ үйлчилдэг Консул оролцсон нь үйл явдалд хачин их давс нэмэв.

Уг нь монгол зангаар тайлбарлахад энгийн. Д.Гэрэлмаа биш юм аа гэхэд Франц улсад эх орноо төлөөлөн суугаа ЭСЯ-ны цөөхөн ажилтны нэгд нь төвөөс ирсэн хүчний байгууллагынханд хэлмэрчлэх үүрэг оногдох л байсан биз. Манай тагнуул, цагдаагийнхан ч гардан байлдаан хийхээс наагуур болж байж үүргээ гүйцэтгэдгийг энэ зун бүх телевизээр цацагдсан Л.Гүндалайг баривчилсан тухай «нүцгэн» бичлэгээс монголчууд үзсэн хойно. Харин дээрх монгол тайлбаруудыг олон улсын эрх зүйн өндөрлөг дээр аваачиж харахаар тэс өөр өнгө будагт уусах аж. Д.Энхбат ял завшсан гэмт хэрэгтэн. С.Зоригийг хөнөөсөн аймшигт хэрэгт сэжиглэгдсэн. Гэвч тэр иргэн хүн. Эрхэм иргэдийн эрх дарх их өндөр сонсогддог Францад тэрбээр улс төрийн орогнол хайж очсон. Нэгэнт Францын нутаг дэвсгэр дээр байгаа болохоор хүчнийхэн монгол төрхөөр аашлах боломжгүй. Консулын асуудлыг зохицуулах тухай 1963 оны Венийн конвенцид Монгол Улс нэгдсэн. Францтай Эрх зүйн туслалцааны тухай гэрээ байгуулаагүй байсан ч бид нэгэнт энэ конвенцид нэгдсэн болохоор хүлээсэн үүргээ дагах учиртай. Баривчлах тохиолдол болон Консул, иргэний харилцаа зэргийг зохицуулдаг уг конвенц бидний хувьд хүчин төгөлдөр үйлчлэх ёстой. Ингээд монгол тайлбарууд өнөөгийн амьдралын алхам тутамд тохирохоо болив. Зайлуул «ард» Батсүхийн үед бол өмгөөлөгч нь «Европын холбооны улсуудын ЭСЯ-нд хандана шүү» хэмээн Л.Санжаасүрэн шиг айлгах ухаан суугаагүй байлаа. Өнөөдөр Энхбат, Санжаасүрэн гэсэн тодорхой нэрэндээ бус, харин иргэн Таны эдлэх наад захын эрх хэмээх том үг бүхий л монгол тайлбарыг хүчгүй болгов. Гадаад явдлын яам ажилтнаа өмөөрөх аргагүй, хүчний байгууллага нууж нэг, хаацайлж хоёр ам зөрөх явдалгүй эвгүй байдалд оржээ. Нөгөө тэргэнцэртэй өвчтөнийг Монгол Улсын хилээр ер нэвтрээгүй шүү дээ гэж хилийн цэргийнхэн солигтсоныг санаж байгаа биз дээ. Хуучин шигээ нуугаад байх аргагүй болсон цаг үед Монголд өрнөж буй алив үйл явдлыг нутгийнхан өөрснөө хорвоо дэлхий даяар хов хүргэн цацаж сурч байна. Ихэвчлэн хүний эрх, хэвлэлийн эрх чөлөө зөрчигдсэн, хумигдсан тухай хар мэдээг ийм чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагуудын мэдээллийн сангаас үзэж болно. Тэдгээрийг ажваас бид ер туйлын хар муу газар амьдарч байгаа бололтой. Жишээ нь Бирмтэй ижилхэн ч юм уу...

Гагцхүү хариу тайлбарууд энэ нийгэмд үгүйлэгдэж байна. Ядаад Гадаад хэргийн яам Гэрэлмаагийнхаа үйлдлийг тайлаад өгвөл барав. Шинэ долоо хоногийн эхний өдрийн турш иргэд мэдээллийн сувгийг үе үе эргүүлэн албан

**«Гэмт хэрэгтнийг авч явах гэж байна. Хоёр хучлага өгөөрэй» хэмээн цагдаагийнхан бололтой чухал хүмүүс захиалга өгсөн аж. Тэгэхээр МИАТ-ынхан ядруу өвчтөн хэн болохыг мэдсэн, харин зорчигчид зайлуул хэмээн бодсон байлгүй. Нислэгийн төгсгөлд «асрагчид» онгоцны үйлчлэгчээс хэрэглээний хутга гуйж. Нойрсуулах эм өгөөд амыг нь скочдон, цагаан хуудсаар хил давуулсан Дамирангийн Энхбат нь ноцтой гэмт хэрэг буюу С.Зоригийг хөнөөсөн аллагад оролцсон байж мэднэ хэмээн шалгахаар ийнхүү зөвөрлөжээ.**

ёсны тайлбар хайлаа. Чив чимээгүй. Оронд нь өмгөөлөгч Л.Санжаасүрэн л «Европын холбооныхонд хандана даа» хэмээн айлгах нь байн байн сонсогдов. Д.Энхбат нэг талаар азтай хүн. Тэр сонгуулийн өмнөх жил баривчлагдаж ирсэн, бас Санжаасүрэнгийн үйлчлүүлэгч тул уг тохиолдол нийгмийг давлагаалуулж чадна. Тэгвэл Монголын улс төрд падгүй түм буман тохиолдлын ард скоч бүү хэл, гав гинжтэй нутагтаа хүргэгдсэн явдал цөөнгүй бий. Гэмт үйлдлийн эздийг баривчлан шударга шийтгэл хүлээлгэх үйлсийг ч хүртэл «хүмүүнлэг» гэх үг дагалдахыг яана. Гадаад хэргийн яамны Хэвлэл мэдээллийн хэлтэс тайлбар хийсэнгүй. Өчигдөржин өөр зуураа зөвлөлдөв үү яав. «Өнөө маргаашнаас тайлбар өгнө өө» хэмээн 17.00 цагийн орчимд эрхэмсэг сайхан дуугаар ивээнгүй хэлж дуулгав.

2003 он



# Эхний өгүүлбэрээ эрж шаналахын амтат зовлонг оюутнууд мэдэрсэн

Би өглөө бүр хичээлээсээ хоцордог. Өглөө болгон ч бас биш юм аа. Мягмар, баасан гаригт «Оюуны Өргөө» дээд сургуулийн жижигхэн цагаан байшинг зорин яарсаар гурван сар өнгөрлөө. Уг нь би багш нь. Туршлага тааруу нэгэн байж магад. Практик сэтгүүлзүйн тухай анхны хичээлээ заахаар ангид ороход 17 оюутны сониуч нүд угтсан юм. Сэтгүүлч, рекламны менежерийн гурвын «а» ангийнхан гэнэ.

Эдний ангид гүйсээр орж ирэх тоолондоо зогтусах хэрэг гарна. Өнгөрсөн мягмар гаригт багшийн ширээ зүүнтээ байсан бол энэ баасанд тасалгааны голд суух явдал болно. Эсвэл Марко Поло дэлгүүрийн рекламны содон зургийг шинээр байрлуулсан харагдах вий. Хөл дор хэвтэж л байдаг хэдхэн мөчир оюутнуудын гарт өртөхөөрөө өвөрмөц бүтээл болж хувирдгийг ч анзаарлаа. Мөчрөөр жааз хийж, голд нь тун сонин зураг тогтоож орхижээ. Сүүлдээ ангийн хаалгаар шагайнуугаа шинэ зүйл хайдаг зуршилтай болов. «Ангийн самбар» хэмээх цэнхэр хавтгайд өлгөдөг мэдээлэл, зурагнууд олон хоногийн насгүй юм. Гурвын «а» ангийнхан төрөл бүрийн бараа, үйлчилгээний сурталчилгааг өөрсдийн сэтгэмжээр урлана. Мөнөөх урлал байсгээд л солигдож, тэд өөрсдийгөө өглөө бүр өөрөөр илэрхийлэх ажээ. Тийм болохоор өдөр тутмын сонины сурвалжлагчийн сониуч араншин намайг «Оюуны Өргөө» рүү татаж, шив шинэхэн санаа, эерэг энергийг мэдрэхээр тийшээ яардаг юм.

Драмын театрын хажууханд жижигхэн цагаан байшин бий. «Оюуны Өргөө» дээд сургууль тэнд анхны төгсөлтийн баяраа хийж, тав дахь жилийн элсэлтээ авахаар зэхэж байна. 170 оюутан сэтгүүлч-хэвлэл мэдээллийн ажилтан, реклам чимэглэл, сурталчилгааны менежер, олон улсын сэтгүүлч, аялал жуулчлалын зохион байгуулагч-музейн арга зүйч, Япон хэлний орчуулагч-Япон судлалын ангиудад суралцдаг. Гэхдээ бусад сургуулиас өөр. Ангиудынх нь аль нэгтээ хөрөө, хайч, бийр будаг, цавуу харагдах нь ердийн зүйл. Бүтээлч уур амьсгал сургуульд хэвшиж, оюутнууд ном сурахын хамт урлаж, сэтгэж, хөдөлмөрийн үр шимээ амтлах хообийтой болжээ.

Ширээний маань дор тавиур бий. Хатуу цаасаар урласан «номнууд» тэнд овоолжээ. Хавтсыг нь оюутнууд хийж туршсан. Бүр гоёмсог торгоор хүртэл сайхан хавтас урласан харагдана.

-Манайхан захиалгаар монтаж хүртэл хийдэг. Хаяг, зарлал, нэрийн хуудас, танилцуулгыг ч бэлтгэх боломжтой гэж сургуулийн захирал А.Халиунаа ярьж байна. Дөрвөн жилийн хугацаанд нийт 3600 цагийн хичээл үздэгээс далан хувьд нь дадлага ордог нь яамай. Ижил төрлийн мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудаас онцгой ялгарах тал нь энэ агаад гар хуруу нь загатнасан залуус хичээлийнхээ хажуугаар анхны жижиг бизнесээ эхлүүлсэн тохиолдол цөөнгүй. Ерээд оны оюутан гэдэг шиг 2000-гаад оны залуусын нэг имиж болсон бие даах, өөрийгөө зарлах, хүч хөдөлмөрөөрөө хөл дээрээ зогсох гэсэн цагаан амбиц тэдэнд бий. Өрсөлдөөн дунд бойжиж буй оюутнуудын толгойд зөвхөн мөнгө эргэлдээгүй. Шинийг сонсч сурах гэсэн яаруу зан, бас уйтгартай бүхнээс залхаж зугтах тэвчээргүй араншин нүдэнд нь илхэн.

Улаан өнгийн цаасаар муруй хазгай хайчилсан зүрхийг самбарт наахдаа

**Шинэ сэтгүүлзүйн зарчмыг залууст ойлгуулахад хялбархан. Тэд загварт баригдаж, зохиох хийрхэлд автаагүй явна. Дэвтэр дүүрэн баримт цуглуулсан атлаа өмнөө дэлгэсэн цагаан цаасан дээр эхний өгүүлбэрээ тавих гэж эрж шаналан, үзгээ хэмлэхийн амтат зовлонг оюутнууд мэдэрсэн байх аа.**



би тэднээс жаахан ичиж байлаа. «Мэдээ, сурвалжлага бичихээр үзгээ шүүрэхийн өмнө чи эхлээд энэ зүрхийг хараарай» гэж хэлсэн юм. Албархуу, эсвэл тээр дээрээс том том дүгнэлт хашгирдаг баримтгүй, мэдэмхий сэтгүүлзүйгээс зугтаж яваарай хэмээн би оюутнуудад ойлгуулах гэж яарсан билээ. Чиний мэдээ, сурвалжлага хүний тухай өгүүлж, жирийн амьдрал тэр бяцхан зайд өрнөж, олны дотор алхаж яваа нэгний нүдээр баримтыг илэрхийлээрэй. Ингэхийн тулд энэ зүрхийг үе үе санаарай хэмээн би анхны хичээлээ эхэлсэн. Түүнээс хойш эв хавгүй хайчилсан мөнөөх гал улаан зүрх,

бас байгаль орчны сэдвээр бичих тухай ярихынхаа өмнө хайчилж наасан улбар шаргал цэцгийн дүрс гурвын «а» ангийн самбарт үлджээ. Өөрчилж бужигнуулах хообийтой оюутнууд тэдгээр дүрсийг огт хөдөлгөөгүй болохоор шинэ сэтгүүлзүйн тухай хичээлийг минь хүлээн авчээ хэмээн өөртөө ялимгүй итгэв.

«Мэргэжлийг маань ойртуулж, бодит сэтгүүлзүйг үнэртүүлж, урам зориг өгсөн нь энэ хичээлийн үр дүн» гэж О.Наранхүү, «Өөртөө итгэх итгэлийг минь нэмэгдүүлсэн, чөлөөт сэтгэлгээнд нэмэр болсон» гэж Т.Эрдэнэсүрэн, «Ямар ч байсан гараа чилтэл лекц бичиж суухаас л хамаагүй сонирхолтой» гэж О.Энхбат, «Сонины ажил их хөдөлмөр шаарддагийг ойлгосон» гэж В.Өсөхбаяр, «Сэтгүүлч хүн гэж хэн бэ гэсэн асуултад хариу авсан. Тэд үйл явдлын дунд байж, ямагт цагт баригдан, шинийг мэдэж, үнэнийг бичихээр үргэлж эрж хайдаг» гэж Д.Оюунсүрэн, «Өнөөдөр сонины гал тогоо руу өнгийж үзлээ» гэж Ч.Отгонтуяа, «Барууны сэтгүүлзүйн тухай ойлголттой болсон» гэж Э.Зандармаа хичээлийн хамгийн сүүлийн цаг дээр надад бичиж үлдээв.

Харин шалгалтаа өгөх болоход хоёр оюутан маань ирсэнгүй. Кредит цаг, сургалтын төлбөрийн өр хоёр мөнөөх 2000-гаад оны оюутны амьдралын нэг хэсэг. Монгол хөрсөнд зохиогүй кредит цагаар хэмжигдсэн оюутан жилүүдийнхээ зовлонгийн тухай тэд төгсөөд бичих нь лав. Төгсөх хугацаа болоогүй ч «Оюуны Өргөөгийн» гурвын «а» ангийнхан олон сайн материал «Өнөөдөр» сонинд нийтлүүлснийг уншигч Та санаж байна уу. О.Наранхүү, Ж.Золжаргал, Т.Эрдэнэсүрэн, Т.Золбаяр гээд «Өнөөдөр» сонины хуудаснаа шинэ нэрс үзэгдвэл ард нь «Оюуны Өргөө» хэмээх тодотгол явааг санаарай. Тус сургуульд суралцагсад «Монгол нь юус» компанийн дэргэдэх мэдээллийн байгууллагуудад дадлага хийх, төгсөөд ажиллах давуу эрхтэй. 25 дугаар суваг телевизийн «Х» хөтөлбөрийг эдний оюутан хөтөлж байна. Харин ойрмогхон «Өнөөдөр»-т нийтлэгдсэн «Миний төсөв», «Рекламны ертөнцөөр» нүүрүүдийг гурвын «а» ангийнхан сурвалжлан бэлтгэсэн.

Хип хоп имижтэй О.Наранхүү кредит цагийн өртэй хэмээн захирлынхаа өмнө толгой гудайлган зогсоо байх. Гэхдээ тэр, мансууруулах бодисын донд залуус автаж буй сэдвээр «Өнөөдөр» сонинд асуудал дэвшүүлсэн сайн материал нийтлүүлж, хажуугаар нь бяцхан бизнесээ эхлүүлээд, өөрийгөө илэрхийлэхээр тэмүүлж яваа юм. «Хаашаа чи яарч явна вэ?» гэсэн асуулыг би оюутнууддаа тавилаа. Тэд зүг бүрт яарч тэмүүлдэг. Ийм цагаан замыг нь ор мөргүй баллуурдахгүй байхыг багш нар нь ч хичээдэг гэдэгт үл эргэлзэнэ. Гурвын «а»-гийн Ж.Золжаргалын дэглэсэн макет Weekend сониныг амилуулдгийг мэдэх үү? Золоо редакцийн байранд шөнөжин суугаад маргаашийн хичээлдээ хоцорч түүртдэг ч байж магадгүй. Гэхдээ өөрийгөө хуурахгүйн тулд тэр хоцорсноо нөхөж хардаг. Уржигдар хаана явааг нь сураглавал «Номын санд...» хэмээн дуугаа намсган хэлсэн юм. Уншлагын танхимд байсан бололтой.

Майкл Мклеланы бичсэн «Уншигчийн итгэлийг хүлээх практик алхмууд», Вашингтон Пост сонины Майкл Шепардын бэлтгэсэн «Үр дүнтэй макетаар уншигчийг татах нь», Лиза Счнеллингерийн бүтээл «Сонгуулийн үеэр сурвалжлагыг хэрхэн бэлтгэх вэ?», мөн «Байгаль орчны сэдвээр хэрхэн бичих вэ?», «Эдийн засаг, бизнесийн мэдээ сурвалжлага бичих зөвлөгөө» зэрэг гарын авлага өмнө байна. Дийлэнхийг нь Вашингтонд байрладаг Олон улсын сэтгүүлчдийн төвөөс эрхлэн хэвлүүлжээ. Шинэ зууны сурвалжлагчдад улирч баларсан баримтаар жишээлэн лекц уншихыг хүсээгүй билээ. Эдгээрт багтсан баримтууд нь зөвхөн 2000 оноос хойш өрнөсөн үйл явдал, түүний талаар бичсэн сурвалжлагууд юм. Сонсох лекцээ, багшаа бие даан сонгох боломж залууст алга. Өнөөдөр Монголын их, дээд сургуулиудын оюутнууд хүсэл сонирхлоороо сонгох нөхцөлгүй атлаа америк загвартай, манайд хөрсгүй кредит цагийн туршилтыг туулж яваа. Тийм болохоор хулхи лекц оюутнууддаа

**Түүнээс хойш эв хавгүй хайчилсан мөнөөх гал улаан зүрх, бас байгаль орчны сэдвээр бичих тухай ярихынхаа өмнө хайчилж наасан улбар шаргал цэцгийн дүрс гурвын «а» ангийн самбарт үлджээ. Өөрчилж бужигнуулах хообийтой оюутнууд тэдгээр дүрсийг огт хөдөлгөөгүй болохоор шинэ сэтгүүлзүйн тухай хичээлийг минь хүлээн авчээ хэмээн өөртөө ялимгүй итгэв.**

уншихгүйг чармайж, бусад сургуулийн ижил мэргэжлийн ангийнхан ч атаархахаар шинэ мэдээлэл өгөхийг хичээсэн юм. Шинэ сэтгүүлзүйн зарчмыг залууст ойлгуулахад хялбархан. Тэд загварт баригдаж, зохиох хийрхэлд автаагүй явна. Дэвтэр дүүрэн баримт цуглуулсан атлаа өмнөө дэлгэсэн цагаан цаасан дээр эхний өгүүлбэрээ тавих гэж эрж шаналан, үзгээ хэмлэхийн амтат зовлонг оюутнууд мэдэрсэн байх аа.

2003 он

## **ЧИ ЮУНД БАЯРЛАЖ, ЮУГ ИЛҮҮ ҮНЭЛЖ, ЮУНААС АЙЖ, ХААШАА ЯАРЧ ЯВНА ВЭ?**

### **О.НАРАНХҮҮ:**

-Монгол Улсын нэр гадаад ертөнцөд өсч, монголчууд хөгжиж байвал баярлаж, дорой буурай явдлыг хараад сэтгэл гонсойдог. Залуусыг илүү үнэлж, залуусаас «айж», залуусаас өрсөхийн тулд хүсэл мөрөөдлийнхөө оргил руу яарч явдаг.

Харин 2000-гаад оны оюутны гол имиж нь чөлөөт байдал, интернэтийн мэдээллийг гартаа атгасан явдал.

### **Л.ЭРЧИМГЭРЭЛ:**

-Би юм юманд амархан баярлаж, амархан гомддог. Сургуулиа төгсөөд нийгэмд яаж байр сууриа олно доо гэдэг бодол толгойд минь үргэлж хадаатай. Гэхдээ айж хулчийсан юм алга.

Юуг үнэлж явдаг вэ гэж үү? Ээжийгээ л их үнэлдэг. Уяхан сэтгэлтэй, намбалаг, бусдын төлөө л явдаг, өөрийгөө болохоор «Би яах вэ» гээд зөнд нь орхидог, өндөр настай ээжийгээ би хүндэлдэг. Юунаас би айдаг юм бэ? Хүн болгон л ээжийгээ алдахаас айдаг байх. Надад ээжээс минь өөр дотно хүн үгүй.

### **Б.ШИЖИРТУЯА:**

-Би ээж, аавынхаа үеийнх шиг хязгаарлагдмал орчинд, хайрцаг дотор сэтгэж амьдрахгүйдээ үнэхээр баярладаг. Харин энэ амьдарч байгаа орчиндоо «шударга» гэдэг үгний мөн чанар дэндүү алдагдаж байгааг мэдрэх тусмаа сэтгэл гонсойдог.

### **Т.ЗОЛБАЯР:**

-Эрдэм боловсролыг илүү үнэлж,

ирээдүй рүүгээ яарч явна.

### **Д.ОЮУНСҮРЭН:**

-2000-гаад оны оюутнууд бүгд завтай. Тэд өөрсдөдөө маш итгэлтэй. Яагаад гэвэл тэд даалгавраа овоолж хурааж байгаад нэг л өдөр хамаад хийчихнэ гэж итгэдэг. Ихэнх нь төгсөх дөхөх үедээ оюутан цагийнхаа үүргийг ухамсарладаг.

Сэтгүүлч болно гэдэг баяр, хийж чадах болов уу гэдэг харин зовиол юм. Олон багшаас лекц сонсч байгаа нь үнэтэй цаг. Эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахыг яарч, алдаа гаргахаас айж байна.

### **М.ДУНГАРМАА:**

-2000-гаад оны оюутнууд өөрийн гэсэн зорилготой.

### **Ж.ЗОЛЖАРГАЛ:**

-Өнөөгийн оюутанд хоёр зам бий. Өрсөлдөөнд ялж, мэргэжлээрээ ажиллаад, улмаар нийгэмд байр суурь, орон зайгаа эзлэх. Эсвэл ялагдал хүлээж, ажилгүйчүүдийн эгнээг тэлэх. Өрсөлдөөн дундаас жинхэнэ мэргэжлийн хүн төрнө гэдэгт итгэдэг.

### **В.ӨСӨХБАЯР:**

-Ерээд оны эхэн үед оюутан байсан ахынхаа яриаг сонсоход тэр үеийнхэн сургуулиа их хаядаг байсан гэсэн. Наймаа хийдэг, түүнээс өөрөөр амьдрах аргагүй юм шиг л аашилдаг. Өнөө цагийн бид арай өөр амьдарч байгаа л даа. Нэг хэсэг нь сурахын төлөө зүтгэж, нөгөө нь цаг нөхцөөсөн л хүмүүс байна.

**Т.ЭРДЭНЭСҮРЭН:**

-Эх орныхоо хөгжилд дусал ч болов нэмэр болох юмсан гэж яарч явдаг шүү. Монголчуудын овсгоотой, эрч хүчтэйг үнэлж, бие биеэ дэмжихгүй, татаж унагах дуртайд нь сэтгэл гонсойдог.

**С.ХОРОЛГАРАВ:**

-2000-гаад оны оюутнууд мөнгөний бодолд автаж зовсон хүмүүс. Гэрийн даалгавар гэхээсээ өмнө маргаашийн автобус унаа,

хоолны мөнгөө яаж олно л гэж боддог.

**О.ЭНХБАТ:**

-2000-гаад оныхон ерээд оны оюутнуудыг бодвол биеэ авч явах чадвар нь хамаагүй өндөр ч, тархи толгойныхоо чадлаар эн зэргэцэхгүй.

**Э.ЗАНДАРМАА:**

-Юунаас айх ёстой гэж? Айх зүйлс ард хоцорсон.

**УХАМСАР, ЗҮРХ, БИД ГУРАВ**

**Т. ЭРДЭНЭСҮРЭН**

2003 оны гуравдугаар сарын 5-ны өглөөний 9.40 цагт Чойжил багш «Миний сургууль-миний бахархал» сэдвээр зохион бичлэг бичих даалгавар өгч орхив. Энэ сэдэв надад хачин санагдаад л... ерөөсөө бичихгүй гэдэг шийд гаргалаа. Тэгээд бодолд автан сууж элдвийг эргэцүүлэв. Хүн ер нь яахаараа хөх тэнгэрийн дор төрсөн мөртлөө хуульд захирагдаж амьдрах ёстой юм бэ? Багшийн өгсөн даалгаврыг биелүүлэхгүй гэж зүрх маань хэлж «Үгүй, биелүүл!» гэж өнөөх ухамсар надаас шаардана.

Зүрхээ дагаад хэсэг явлаа. Зүгээр явах шинж алга. Шүлэг бичье! Александр Сергеевичээс илүү бичнэ. Роман бичье! Лев Толстойгоос илүү гарнаа л гэж байна. Еэ! Энэ чинь арай дээр хөөрч байна уу гэж бодов уу үгүй юу ухамсар гараад ирлээ.

Чи муу бичиг үсэгт ч тайлагдаагүй, бакалавр ч үгүй байж яаж шүлэг, роман бичдэг юм гэж зүрхийг загналаа. Зүрх эсэргүүцэх

гэсэн боловч ухамсар нь завдал өгсөнгүй.

«Оюуны Өргөө» дээд сургуульд гурван жил сураад л болоо гэж бодоо юу, амжилттай төгсөхөө бодохгүй хөөрүү амьтан! хэмээн тас ширвэв.

Олон олон дээд сургууль байхад заавал «Оюуны Өргөө»-д сураад байхдаа яадаг юм гэж зүрх хариуд нь тунирхлаа.

Энэ сургууль чинь «Монгол ньюс» компанийн бүх сонин, 25 дугаар суваг телевиз гээд дадлага хийх, цаашилбал төгсөөд ч бэлэн ажлын байртай, рекламны менежер бэлддэг анхны сургуулиудын нэг шүү дээ гэж ухамсар зүрхээ аргадлаа. Зүрх тунирхаж ухамсрын арганд орохгүй гэж гүрийлээ.

...Гэнэт хонх дуугарч зүрх цочоод ухасхийлээ. Би ухамсартайгаа ангидаа хоцров. Гэхдээ зүгээр зүрх маань одоохон эргэж ирнэ. Түүнгүйгээр би яах ч юм билээ. Багшаа зүрх зөвшөөрөхгүй юм, уучлаарай! Таны өгсөн сэдвийн дагуу бичиж чадсангүй!



# Сайдыг ХЭН ШҮҮМЖЛЭХ ВЭ?

Агаарын цэнхэр долгион хэний өмч вэ? Сайдуудын мэдэлд байдаг юм болов уу? Тийм гэдгийг Үндэсний телевизийн «Цагийн хүрд» үлгэр жишээ нотолсоор байна. Үйл явдал бүрийн тухай мэдээлэл ганц талтай, дутуу дулимаг үлдэж, юу болсныг төгс ойлгохын тулд сувгаа солих ажил гарна. Гэвч суваг солиод ч нэмэргүй, баруун жигүүрт хашгирч байсан «Eagle» телевиз үгүй болсны дараа агаарын цэнхэр долгионд зүүний баримжаатай мэдээлэл давамгайллаа. Тэгвэл үнэнийг хэн дуулгаж, сайдын алдааг хэрхэн залруулах юм бэ? Сонгуулийн синдром талх тарианаас чухал болсон энэ өдрүүд Монголын сэтгүүлзүйн чансааг шүүж байна. Эсвэл баруун, үгүй бол зүүн хязгаарт дэвхцэх мэдээллийн туйлшрал мэргэжлийг маань басамжлах шалтаг болсоор.

Мөнөөх «Цагийн хүрд»-ийн ням гаригийн хөтөлбөр «тоймчийн» гэсэн тодотголтой. «Тоймч» сайдад хэрхэн бялдуучилж буйг өнгөрсөн амралтын өдрийн үдэш сонсов. Айсуй ням гаригийн мөн цагт өөр сувгийг сонгох үзэгч тун олон байгаа гэдэгт эргэлзэх юмгүй. Дэлхий нийтээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийн төлөөх байгууллага гэгддэг «19 дүгээр зүйл»-ийн тодорхойлсноор агаарын долгион ард нийтийн өмч. Дарга нарын ажлын тайланг дамжуулсаар байгаа телевизийн сэтгүүлчид олон нийтийн өмнө рейтингээ хэдийнэ унагаажээ.

Тэгвэл үйл явдлын нөгөө талд «хэлмэгдэгсдийн» нэртэй шинэ арми гараад ирлээ. Монголын сэтгүүлчдийг хэрхэн дарамтлан зовоож буй тухай хов олон улсын сэтгүүлчдийн төрөл бүрийн байгууллагын вэб сайтад түргэн шуурхай нэвтэрдгийг мэдэх үү? International Association of Broadcasting, International Journalist Institute, International PEN, International Press Institute... Дэлхийн мэргэжил нэгтнүүд маань яасан ч олон байгууллагад нэгддэг юм. Тэдгээрт Монгол Улс Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай, харин сэтгүүлчдийн ёс зүйн кодгүй (энэ оны хоёрдугаар сард Чөлөөт сонины холбооныхон ийм зарчим баталсан тухай шинэ мэдээлэл хараахан ороогүй байх юм), ганц нэг сонин ажилтнуудынхаа баримтлах ёс зүйн кодыг баталсан гэх мэтээр тэмдэглэжээ. Харин эрх баригчдад дарамтлуулсан, хавчлага шахалт дор зүдэрч байгаа тухай үг өгүүлбэрүүд нүдний өмнө зурсхийх нь олон.

«Танай сурвалжлагчид тун хүнд нөхцөлд ажиллах юм аа» гэж Германы Олон улсын сэтгүүлзүйн институтын захирал Питер Пруферт хэлж билээ. Ийм яриа бүр 1999 оны намар болсон юм. Берлин хүртэл түгсэн нэгэн мэдээллийг өмнө минь тавиад «Сэтгүүлч эмэгтэйн хацар дээр тун аймаар сорви үлдсэнийг хараач. Танай УИХ-ын нэг гишүүнийг шүүмжилсний төлөө ийм харгис хандсан гэдэг үнэн үү?» хэмээн асуусан. Хожим буюу 2002 онд Нью-Йоркийн төвийн хөл хөдөлгөөнт гудамж дахь өндөр барилгын арванхоёрдугаар давхарт өөр нэгэн яриа өрнөлөө. ДОХ-ын асуудал хөндөн бичсэн сэтгүүлч эмэгтэй шоронд хоригдсон тухай Сэтгүүлчдийг хамгаалах олон улсын хорооны (CPJ) сайтад мэдээлжээ. Тус байгууллагын ажилтан Жоэл Симон мөн л бүрхэг ойлголттой харагдав. Нийтлэлд дурдсан бүсгүй нас барсан тухай анх сонсоод «Тэгвэл...» хэмээн үгээ эхлээд чимээгүй болж орхив. Эх нутагтаа тэвчих аргагүй дарамт шахалтад өртсөн, амь насанд нь аюул занал учирсан тохиолдолд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд олон улсын мэргэжлийн холбоодод ханддаг. Тэндээс өмгөөлөл, дэмжлэг эрэхийнхээ наана бид эндээ мэргэжлийн түвшинд ажиллаж чадсан эсэхээ эргэн харах цаг болжээ. Хариуцлагатай сэтгүүлзүй, хэвлэлийн эрх чөлөө энэ тэр гэх дэндүү ерөнхий, албархуу үгсийг бие биедээ бүү номлоорой.

Тод улаан цаасаар том гэгч зүрхний дүрс хайчилж самбарт наасан нэгэн лекцэд аз болж суусансан. Жирийн хүний тухай бичээрэй. Түүний нүдээр

Сонгуулийн  
синдром талх  
тарианаас  
чухал болсон  
энэ өдрүүд  
Монголын  
сэтгүүлзүйн  
чансааг шүүж  
байна. Эсвэл  
баруун, үгүй  
бол зүүн  
хязгаарт  
дэвхцэх  
мэдээллийн  
туйлшрал  
мэргэжлийг  
маань  
басамжлах  
шалтаг  
болсоор.



амьдралыг хараач. Жагсаал цуглаан болж буйг тээр дээрээс хяламхийж, хөндлөнгийн үгээр бүү дамжуулаач. Олны дунд яваа эрийн нүдээр үйл явдлыг зураглаж, түүний бухимдлыг, ар гэрт нь хоцорсон гэргий, хүүхдийнх нь зовлонг давхар мэдэрч сураарай гэсэн тайлбар хэлээд мөнөөх багш зүрх өөд заалаа. Үзгээ шүүрч, үгээр дайтахынхаа өмнө тодхон улаан зүрх рүү хараад авахад илүүдэх юмгүй. Тэгсэн цагт сэтгүүлч сайдын амаар томорч бөмбөгдөхгүй, хүний хувийн амьдралын хамгийн эмзэг хэсэг рүү хайхрамж хайргүй довтлохгүй. Хорь дөнгөж шүргэсэн А.Эрдэнэтуяа торны цаана хэд хоног суув. Шүүх засаглал түүний зүрхийг мохоож, уран бүтээлийнх нь гараан дээр шоронгоор айлгажээ. Бүгдээрээ түүнийг ингэж өрөвдөж, өөрт нь хүн ёсоор хандаж байгааг мэдэрсэн болов уу. Тэгвэл «Монголын нэг өдөр» сонинд нийтлэгдсэн түүний материал Д.Мөрөнгийн гэр бүлийнхэнд ямар сэтгэгдэл төрүүлсэн бол? Шоронгийн дүнсгэр камерт байх хугацаандаа ингэж тунгааж үзсэн эсэх нь сонин. Ер уншигчдад ямар ач холбогдол, тустай мэдээлэл билээ? Д.Мөрөн нууц хүүхэдтэй байх эсэх нь тийм чухал зүйл үү? Б.Клинтон Моника Левинскийд татагдсаныг олонх америкчууд үзэн ядаж хүлээн аваагүй шүү дээ. Төрийн түшээ өө сэвгүй, нэр төр цэвэр байх учиртайг нийтлэлээрээ сануулах гэсэн юм бол том сэдвийг ул суурьтай нягтлан хөндөх хэрэгтэй юм биш үү. Хариугүйхэн халтуурдсан сэдэв гэнэт л өндөр аван дуулиан болж, Эрдэнэтуяад Монголын сэтгүүлзүйн дээд шагнал амлах шахав. Хямдхан сэтгүүлзүй, өнгөцхөн хийрхэлд нөгөө эрхэм гишүүн өөрөө хүртэл автаад, А.Эрдэнэтуяаг хамгаалах хэвлэлийн хурал зарлах дөхөж онигоонд орлоо.

Гүтгүүлээ, доромжлууллаа, нэр төрөө сэргээлгэнэ гэх гомдол жилээс жилд нэмэгдсээр байна. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тухай эрх зүйн маргаантай 31 хэргийг 1991 онд шүүх шийдвэрлэжээ. Үүнээс найман жилийн хойно ийм гомдол заргын тоо даруй 140 болж орхисон. Доод тал нь 250 мянга, хамгийн их нь 83 сая төгрөгийг сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллагаас нэхэмжилсэн байх юм. Гомдол зарга ердийн явдал болж, хариуд нь шоронд орсон нэгнээ бид баатрын ёсоор шагнасаар он жилийг үдэх хэрэг үү? Монголын сэтгүүлчид хэрхэн дарамтлуулан зовж байгааг олон улсын байгууллагад ховлон зарлахаас өөр юу хийж чадах вэ? Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар эрх баригчид хэлэлцэж байх явцад ашиг сонирхлоо хамгаалан ярьж бичсэн сэтгүүлч тун цөөн. Хуулийн чангаллыг арьсан дээрээ мэдэрснийхээ дараа л ийш тийш гомдол бичиж, буруугаа цайруулах арга хэмжээ сэдэж эхэллээ. Нэг хэсэг нь улстөрчдийн гарын аясаар хөдөлж, нөгөө нь мэргэжлийн алдааг өөгшүүлж байх зуур ажиллах орчин маань улам төвөгтэй болсоор байна. Лондонд төвтэй «19-р зүйл» байгууллага Монгол Улсын хуулиудад задлан шинжилгээ хийгээд, Эрүү болон Иргэний хуулийн гүтгэлэг, нэр төрийн талаарх заалтуудыг зайлшгүй өөрчлөх шаардлагатай гэсэн тайлбарыг төгсгөлд нь зүүв. Энэ нь сэтгүүлч алдаа гаргавал зөөлөн шийтгэ гэсэн өмгөөлөл биш. Мэргэжлийн стандартын үнэлэмж аль ч нийгэмд зохих ёсоор бий. Дээр өгүүлсэн Сэтгүүлчдийг хамгаалах олон улсын хорооны (CPJ) сайт дээр зарласан онцгой тохиолдлуудыг эргэн харья.

-2004 оны тавдугаар сарын 21-нд Ал-Жазирагийн Ирак дахь сурвалжлагч амь үрэгдэв.

-Вьетнамд болон Кубад шоронд хоригдсон сэтгүүлчид өлсгөлөн зарлалаа.

-Зимбабвед хоёр сэтгүүлчийг тавдугаар сарын 21-ний өдөр баривчилжээ.

-Интернэтээр нийтлэлээ цацдаг сэтгүүлч Хятадын шүүхэд дуудагдаад байна.

-Америкийн цэргүүд Иракт ажиллаж байсан сурвалжлагчдыг тавдугаар сарын 18-ны өдөр дайрч доромжилсон...

Зимбабвед Роберт Мугабе хэмээх дарангуйлагч төр барьдаг. Хятад дахь хэвлэлийн эрх чөлөөний байдлыг хэмжвэл О заалтыг тэр дор нь тэмдэглэнэ.

**Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар эрх баригчид хэлэлцэж байх явцад ашиг сонирхлоо хамгаалан ярьж бичсэн сэтгүүлч тун цөөн. Хуулийн чангаллыг арьсан дээрээ мэдэрснийхээ дараа л ийш тийш гомдол бичиж, буруугаа цайруулах арга хэмжээ сэдэж эхэллээ.**

Улс төр,  
бизнесийн  
явцуу  
бүлэглэлүүд  
хүрээгээ тэлж,  
далд нууц  
явдлууд  
нэмэгдэх тусам,  
мөнгөний  
мөрөөр мөшгих  
бүрийд бидний  
ажиллах орчин  
халуун болно.

Ирак-дэлхийн халуун цэг. Харин Монгол? Бидний бие биеэ урамшуулдаг шагнал гэдэг юусан билээ. Олон орны сэтгүүлчид үнэхээр хүнд нөхцөлд ажиллаж, өндөр шалгуурыг давсан сурвалжлагуудаараа нэр хүндтэй шагнал хүртэж байна. Мэргэжлийн үнэлэмж, стандарт маань тэдэнтэй харьцуулахад хаахна харагдах бол. Мэдээллийн эрх чөлөө гэж ер юу юм бэ? Энэ үг лав л их хүчтэй юм. МАХН 2000 оны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөртөө «Сэтгүүлчдийг мэдээллийн эрх чөлөөгөөр хангана» хэмээн тэмдэглэсэн харагдана. Уг нь олон нийтийг мэдээллээр хангах тухай заалтыг дэлхийд түгээмэл хэрэглэдэг. Иргэдийн мэдээлэл хүртэх эрхийн тухай дурдалгүй зүгээр л сонгуулийн өмнө шоудаж, нөгөө хэдэн сэтгүүлчийг талдаа татахаар оруулсан өгүүлбэр.

Хэвлэлийн эрх чөлөө гэх лоозонгоор бүгд тоглож, мэргэжил нэгтнүүд маань ч түүнийг хоосон зарласаар. Хэрэв чи хэн нэгний «аманд багтахааргүй» хангалттай баримт цуглуулаад, үндэслэлтэй дуугарч чадвал хожим нь эрх чөлөөний цаасан малгай эрж сандрах шаардлага гарахгүй. «Муусайн идэш шүүрдэг элээ бус, бүргэд шиг хурц харж, түүнийх шиг өндөрт хүр» гэсэн ишлэлийг дамжуулъя. Чанарын тухай ярих цаг ирснийг энэ үг илэрхийлж байна. 1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль тэртээ тэргүй бидний хувьд ёслолын парааднаас ялгаагүй гоёл чимэг байсан. Монголын сэтгүүлчид чөлөөт хэвлэлийн арван хэдэн жилийн түүхийг хаалт хамгаалалтгүй, явган нүцгэн туулсаар өнөөдөртэй золгосон билээ.

Афганы сэтгүүлч Абдул Хамедийн хурц дайчин үгсийг таслах гэж түүнийг Кабулын төвд хутгалсан юм. Муса Мурадовын редакцийн хоёр сэтгүүлч Чеченд алагдсан. Түүний эрхэлдэг «Грозневский рабочий» сонины редакцийн байрыг юу ч үгүй болтол бөмбөгдсөн. Одоо Мурадов Москвагаас бичиж байгаа. Гэхдээ үг нь мохоогүй, үнэнийг хэлсэн хэвээр. Эд бол 2003 оны Хэвлэлийн эрх чөлөөний төлөө CPJ-ийн шагналыг хүртсэн хүмүүс. Тэдний ижил халуун цэгт Монголын сэтгүүлчид ажиллаагүй. Гэхдээ мэдэхгүй чадахгүйн бэрхшээлийг өнгөрсөн арван хэдэн жилд туулан давсан байх юм. Энэ хугацаанд мэргэжлийн чансаа гэх ганц шүүгч сэтгүүлчийн хөдөлмөрийн буруу, зөвийг ялгаж ирсэн. Өнөө тэр хэмжүүр, өмгөөлөгч, яллагчийн үүргийг олон нийт гүйцэтгэж чадна. Тиймээс ч Эрүүгийн болон Иргэний хуулийн зарим заалтад нэмэлт өөрчлөлт оруулахыг хууль тогтоогчдоос шаардаж байна. Сэтгүүлчдийг дайрсан жинхэнэ халдлага Монголд хараахан эхлээгүй. Улс төр, бизнесийн явцуу бүлэглэлүүд хүрээгээ тэлж, далд нууц явдлууд нэмэгдэх тусам, мөнгөний мөрөөр мөшгих бүрийд бидний ажиллах орчин халуун болно. Өнөөдөр сайдын хөлд сууж буй хүмүүс тэр битүү, бохир орчныг өөгшүүлэн цэцэглүүлэгчид, иргэн, төрийн хооронд гоёмсог бүтээлгээр далдалсан вакуум бий болгогсод юм. «Сайн сэтгүүлзүй дэлхийг амар амгалан байлгахад тусалж, муу нь асуудлыг улам ээдрээ төвөгтэй болгодог» гэж Шотланд, Английн мэргэжил нэгтнүүд маань Белфастад өнгөрсөн намар болсон уулзалтын үеэр ярьжээ.

«Бодит үнэнийг харуулсан хэмээн итгэн эдгээр зургийг хэвлэсэндээ уншигчдаасаа хүлцэл өчье» хэмээн Daily Mirror сонины зөвлөлийнхөн саяхан уучлал гуйсныг санаж байгаа биз ээ. Дэлхийн хэвлэлийн буурал түүхэн дэх анхдагчдын нэг Daily Mirror Засгийн газар, Ерөнхий сайдаас бус олон нийтээс хүлцэл өчсөн юм. Британийн армийн албан хаагчид Иракийн хоригдлуудыг хэрхэн тамлан даажигнаж байгааг харуулсан гэрэл зургийг эхний нүүртээ тавихдаа, Хатан хаан, Тони Блэйр хоёроос мэдээж зөвшөөрөл хүсээгүй. Хэрэв тэр зураг бодитой зүйл байсан бол Их Британийн үндэсний эрх ашгийг умартсан гэж Daily Mirror-ыг олон нийт шүүх байсан болов уу? Хэвлэлийн эрх чөлөөний тухай том яриа ийм мөчид л сонсогдох учиртай. Яг ийм тайлбараар л мөнөөх гутамшигт зургийг нийтэлснийг нь их британичууд уучлах байлаа.

Бие даасан, хараат бус үйл ажиллагааны өөр нэг илрэл бол ВВС-гийн жишээ. Түүнийг 1926 онд Хатан хааны зарлигаар үндэслэсэн гэдэг. Өнөөг хүртэл үйл ажиллагааных нь дүрмийг төр боловсруулж, Удирдах зөвлөлтэй нь гэрээ байгуулсан янзаараа. Тони Блэйрийн танхим ВВС-гийн ажилд хошуу нэмэрлэдэггүй гэж хэчнээн мэлзээд нэмэргүй. Хэдийгээр олон нийтээс авсан хураамжаар ВВС-г санхүүжүүлдэг ч Британийн төр, засгийн байнгын хяналт, шахалт дунд оршин тогтнодог. Тэглээ гээд ВВС доктор Келлигийн үхлийн шалтгааныг Засгийн газартай холбож буруутгахаас эмээгээгүй юм. Манай «Цагийн хүрд»-ийн тоймчийн яриатай уг тохиолдлыг харьцуулаарай л даа. Том, жижиг улсад ялгаагүй мэргэжлийн үнэлэмж нэг л шалгууртай. Сайдуг та шүүмжилж чадах уу? Сайд таны бэлтгэсэн материалыг няцааж дийлэх үү? Нийтлэлийг тань үзэх гэж тэр эрхэм өглөөний шинэхэн дугаарын хуудсыг салганасан гараараа яаран эргүүлж суугаа бол сэтгүүлзүй үүргээ биелүүлж байгаа хэрэг.

**2004 он**

## «Eagle» үгүй өдрүүдэд

Телевизийн гуравдугаар суваг мэдээллийн чансааг харьцуулан бодох цаг бидэнд үлдээгээд чимээгүй цэнхэртэж байна. «Eagle»-ийг манайх энэ сувгаар хүлээн авдаг байлаа. Харин эрхэм үзэгч Таны гэрт тэр нь хэд дэх дараалалд явсныг мэдэхгүй. Олонх нь «Eagle»-ийг «гарт ойрхон», үргэлж үздэг болохоороо айргийн таван цифрийнхээ нэгэнд тохируулсан гэдэгт итгэнэ. Харин «Eagle» амаа барьж, чимээгүй цэнхэртсээр яг нэг сар болов. Бүргэдийн дүрс, Америк, Монголын далбаа бүхий танил роликийг харин үгүйлээгүй юм шүү. Энэ сувгаар цацдаг CNN-ийн цаг, CNN маягаар үйл явдлыг харуулах гэсэн монгол оролдлого, бүр тодруулбал мэдээллийн хурд, хүчийг нь үгүйлж байна.

2001 оны дөрөвдүгээр сард оросууд НТВ-гүй болсон шиг хачин чимээгүй өдрүүд үргэлжлэв. Дараа нь гэнэтхэн НТВ эфирт гараад ирсэн. Энэ хооронд юу болсон, хэн нь хэнтэйгээ зодолдож, ямар бүлэглэлүүд заамдалцаж, хэд хоног хэрхэн улстөржиж хөлөө жийлцсэн нь үзэгчдэд гол зүйл биш. Өмнөх эзэн, өнөөдрийн босс хэн байх нь ч чухал бус. Хаана, юу болсныг хурдтай, хүчтэй дуулгаж чадах, мэргэжлийн мэдээллийн байгууллага орчин цагийнханд үгүйлэгдэв. CNN үгүй, «Eagle» ч үгүй өдрүүдэд бид мэдээлэл үгүй орчинд тэмтэрч яваагаа ухаарлаа.

Эхлээд бүх дарга энэ өдөр хаа хаана хүрэлцэн очсоныг ярьж өгч олон нийтийг шийтгээд, бүр төгсгөлд нь SARS-ын болзошгүй тохиолдлын тухай өгүүлдэг манай мэдээллийн хөтөлбөрүүдийг харанхуй бүрэнхий хэмээн нэрлэлээ. Бүгдээрээ сувгаа солиорой. Гэвч гуравдугаар суваг чив чимээгүй цэнхэртэнэ. Монгол нутагт өрнөж буй үйл явдлыг маш шуурхай хүргээд, дараа нь задлан шинжилж, эцэст нь асуудал болгон мэтгэлцээн зарлах CNN маягийн теле суваг хэзээ төрөх вэ? Оросын НТВ одоо хэний мэдэлд очсоныг хэлж мэдэх үү? Түүнийг мэдэх шаардлага ч алга. Гол нь НТВ өмнөхөөсөө илүү чанартай, сонирхолтой нэвтрүүлэг цацаж эхэлсэн. Тэгвэл «Eagle» яасан бэ? Эдний эздийн маргааны төгсгөлийг хэн маань сонирхсон билээ?! Тэр хэрүүлийн төгсгөл хэнд ч чухал биш. Харин CNN-ийн тод улаан лого, мөнөөх өнгө аястаа тохирсон шуурхай, халуун уур амьсгалтай хөтөлбөрүүд, тэдгээрийг дууриах гэсэн монгол хувилбарыг л бүгд хүлээж сууна.

«Eagle» гайхамшигтай хөтөлбөрүүдтэй байгаагүй. Гэхдээ тэр бол эхлэл. Түм буман мэдээллийн дунд тулж баримжаалах, олон нийтэд зориулсан сувгийг монголчууд үгүйлж байна. Орон зайг нь хэн эзлэх вэ? Мэдээллийг «теле од» хэн гуай та өөртөө эвтэйхэн болгон найруулж цацдаг бус, харин түүнийг амьдралдаа ашиглан зам мөрөө баримжаалдаг үзэгчдэд зориулан бэлтгэдэг. Нөгөө SARS юу болсныг мэдэх гэж телевизорын удирдлагаа дохисноос бус, дарга нарын энэ өдрийн ажлын тайланг сонсох гэж цэнхэр дэлгэцээ нээдэггүй билээ.

Буш юу ярьсан, Цагаан ордноор сонин хачин юутайг хэрэв сонсмоор бол 16.00 цагийн алдад л америкчууд CNN-ийн хөтөлбөр дээр сувгаа тохируулна. Капитол, эсвэл Цагаан ордноос Жүүдий Вүүдраф сурвалжлагаа хийж, тайлбарлаж гарна. Харин хар өглөөнөөс, 5.00 цагийн харангатай зэрэгцэн CNN-ийн эхний хөтөлбөр Америкт, хорвоо дэлхийд өрнөсөн халуун үйл явдлыг түүн өгүүлж эхэлдэг. Хаашаа зоривол аюултайг энэ өглөө сонсч, юуны үнэ нэмэгдэж, ямар нь хямдарч буйг чагнаж, хотын дарга ямар шийдвэр гаргасан, түүнээс нь болж яагаад маргаан дэгдсэн, тэр мэтгэлцээний тухай CNN хэзээ задалж тайлбарлахыг хүмүүс мэдээд авна. Товч мэдээллийн хойноос залгаад 7.00 цагт «American Morning» хөтөлбөр үргэлжилж, алтан шаргал үст Паула Зан алжаасан парайгүй инээмсэглэн угтах вий. CNN-ийн «дотоод» тодотголтой сувгийн

хөтлөгчид нь Холливудын одоос дутуугүй нэр цуутан болжээ. Паула өглөөний товч мэдээллийг ялимгүй дэлгэрүүлэн ярихад нь түүний цаана, студийн цэлгэр цонхоор ажилдаа яарсан америкчуудын урсгал үргэлжилсээр. Сониуч нэг нь «Америкийн өглөө» хөтөлбөрөөр өөрөө телевизийн дэлгэцэнд цухалзаж буйгаа ч үл анзааран мөнөөх цонхоор харж зогсоно. Шууд нэвтрүүлгийн итгүүлэх хүчийг тодруулахаар Паулагийн ард ийм амьдралтай дэлгэц сонгожээ.

Бага үдийн орчимд «CNN Live Today» эхэллээ. Дахиад л халуун үйл явдлын мэдээлэл. Энэ дэлхий үхэл хагацал, буун дуу, бас ховор сонин үйл явдалгүй өнжинө гэж үгүй юм. Харин цагийн зүү 12 дээр давхарлаж, үдийн хоолонд ходоод даллах үест буурал үст Вулф Блитзер арай «ухаантай» зүйл хэлж өгөхөөр гараад ирлээ. Өглөө элдэв дүгнэлтгүй дамжуулсан баримтуудад тэр ялимгүй задлан шинжилгээ хийх вий. Магадгүй Ассошэйтэд Пресс агентлагийн дараа CNN нь мэдээний хурдаараа бичигдэх буй за. Тод улаан логоньхоо адил дэлхийн үзэгчдэд танил болсон хөтлөгчид нь өөрсдийн гэсэн багтай. Сурвалжлагчдын баг Вулф Блитзерийн задлан шинжилсэн тойм нэвтрүүлэгт зориулан материал бэлтгэнэ. Мөнөөх түүхий эдийг үзэгчдэд хүргэхээр дахин боловсруулах авьяас буурал Вулфт бий. Үдээс хойш дахиад л элдэв дүгнэлт задаргаагүй үйл явдлын сурвалжлага цувлаа. Бяцхан дэлгэцээр аль болох олон зүйл өгүүлэхийг CNN оролдоно. Дэлгэцийн хормойгоор шинэ баримтууд урсан өнгөрч, хөтлөгчийн аль нэгтээ график зураг, дүрс солигдсоор. Харин Америкийн баруун эргийн цагаар 16.30 орчимд тэдний тун дуртай нэвтрүүлэг эхэлдэг. «Crossfire» хэмээх уг хөтөлбөр нийгэмд тулгарсан аливаа асуудлаар эсрэг талуудын байр суурийг олны нүдэн дээр мөргөлдүүлэх зорилготой. «Crossfire»-ийн хөтлөгч Жеймс Карвилл, Пол Бегала, Тукер Карлсон, Боб Новак дөрөв улаан халз маргах төрөлхийн авьяастай юм. Тэд өөр зуураа хуваагдан ширээний эсрэг талд суугаад эгээ л шүүх хурал дээр байгаа өмгөөлөгчид лугаа уран хурц үгээр байлдана. Хөтлөгчдийн хажууд үзэл бодлоо хамгаалахаар эсрэг багийнхан байраа эзэлж, зөрчилд дуртай америкчууд үзэгчийн суудлыг дүүргэжээ. Уг нэвтрүүлгийн сэдэв дуусашгүй. Өглөөхөн болсон халуун явдлын мөрөөр баримтыг гүнзгийрүүлэн маргах нь ч бий. Жеймсийн мэргэжлийн боксчных шиг зөрүүд зэрлэгдүү харц, Бобын зальтай нүд, овжин яриа мэтгэлцээнийг хурцалж, үзэгчид бүр бах таваа ханатал инээнэ, эсвэл мэнчийгтэл улайж үнэнээсээ уурлаж харагдана. Энэ бүхний эцэст бүгдээрээ уг асуудлаар өөрсдийн баримжаа дүгнэлттэй хоцрох ажээ.

«Crossfire» мэдээж амттай байсан. Гэхдээ амьдрал мөнгөөр хэмжигдэж байгаа цагт Лоу Доббсыг хүмүүс үгүйлж эхэлнэ. Тэр телевизийн «сайн» цагт (18.00) «MoneyLine» нэвтрүүлгээ эфирт цацдаг. Мөн л эдийн засаг, бизнесийн сурвалжлага хийдэг өөрийн чадварлаг багтай. Дээр нь дэлхийн санхүүгийн том төвүүдээс мэдээлэл аван нэгтгэн холбох аж. Лоу тогтуун тайван төрхтэй, мөнгө санхүүгийн тухай итгэл төрүүлэм дуу хоолойгоор нухацтай тайлбарлах нь нөгөө мэргэжлийн «хэрүүлчдээс» огт өөр юм.

Лоугийн мэдлийн цаг өндөрлөмөгц алтан шар үст Паулатай дахин учирна. Бүр өглөөнөөс хойш түүний царай зүс, хувцаслалтад өөрчлөгдсөн зүйлгүй, харин өгүүлэх мэдээлэл нь л үлэмж шинэчлэгджээ. 21.00 цагийн дохиотой цуг CNN-ийн дэлгэцнээ хэн гарч ирэхийг дэлхий мэднэ ээ. «Larry King Live» эхэллээ. Ларритай хамт ганц цаг тун хурдан өнгөрөх вий. Өглөөнөөс хойш дамжуулсан үйл явдал, баримтын урсгал ялимгүй өөр өнгө аястай болж Ларригийн зочин юу гэж ам алдахыг бүгдээрээ чагналаа. Ялимгүй амсхийсэн бол одоо CNN үдшийн мэдээллүүдээ цацаж байна. Тэдгээр хөтөлбөрийн хаан, залуурч нь алдарт Аарон Браун. Энэ эрхмийн нэрийг, эсвэл царай төрхийг огт мэдэхгүй хүн хорвоод ховор биз. Сэтгүүлчийн мэргэжлээр 25

**-«Пандалоза»  
зоогийн газрын  
үүдэнд алуурчин  
ээлжит халдлагаа  
хийжээ. Тэр  
бидэнд зурвас  
үлдээсэн.  
Хэвлэлийнхэн та  
нараас хүсэх зүйл  
байна. Миний  
үгийг зурвас  
үлдээгчид энэ  
хэвээр нь  
дамжуулж өгнө үү  
«Бид зурвас дээр  
дурдсан утсаар  
холбогдох гээд  
чадсангүй.  
Бидэнтэй дахин  
ярина уу» ингэж  
хэлмэгцээ ахмад  
Мүүс эргээд  
алхлаа.  
Хэвлэлийн  
төлөөлөгч нь  
«Уучлаарай,  
одоогоор үүнээс  
илүү зүйл хэлэх  
боломж алга»  
хэмээв. Бороонд  
норж дагжсан  
сурвалжлагчид  
почир мэдээллийн  
дараа минут  
хэртэй ам  
ангайгаад, «Ердөө  
л энэ үү?!»  
гэгцгээх нь  
сонсогдов.**

жил ажиллахдаа Аарон дэлхийг цочоосон сенсаац үйл явдлуудыг гол төлөв сурвалжилсан. Тэр түүхийг бичилцэж, халуун, гашуун, гайхамшигт өдрүүдийн тоосон дунд амьдарч явна.

Есдүгээр сарын 11-ний өглөө хоёр өндрийг онгоц мөргөснөөс хойш яг нэг цагийн дараа Аарон газар дээрээс нь сурвалжлага хийж эхэлсэн. Өмнө нь тэрбээр Диана гүнж амь алдсан тухай, Хонконг Хятадын мэдэлд шилжих түүхэн үйл явдлын талаар, Нелсон Мандела Ерөнхийлөгчийн сонгуульд ялсан тухай зэрэг материал бэлтгэн дэлхийн үзэгчдэд хүргэсэн юм. Хамгийн сүүлийн халуун цэг нь Иракийн дайны цуврал буюу хэсэг бусад бүх сурвалжлагыг нэгтгэн холбож цогц байдлаар хүргэх ажил байжээ. Аарон CNN-ийн Атланта дахь төвөөс энэ бүхнийг удирдан мэдээлсэн билээ.

Дэлхий дахины анхаарлыг татсан үйл явдлыг үзэгчдэд хүргэх ажил амаргүй, асар зохион байгуулалт, хөтлөгчийн ур ухаан шаардлагийг бид энэ оны гуравдугаар сарын сүүлээр мэдэрсэн. Персийн буланд эхэлсэн байлдааны ажиллагааг Монголын мэдээллийн түүхэнд анх удаа мэргэжлийн хэмжээнд өгөх гэж «Eagle» оролдов. Мөнөөх CNN маягийн сурвалжлагын арга барил манай үзэгчдэд хүрч, өнөөдөр эргээд «Eagle»-ийг үгүйлэх шалтгаан боллоо. Өнгөрсөн оны аравдугаар сард Вашингтон орчимд амьдрагсдыг айлгаж, нийт Америкийг цочоосон цуврал аллага үргэлжлэх үед сая сая үзэгч Аарон Брауны «News Night» нэвтрүүлгийг хүлээдэг байлаа. CNN тэгэхэд 24 цагийн турш мэргэн бууч- алуурчны мөрөөр цагдаагийнхантай хамт мөшгив. Паула бүтэн өдөр студид ажилладаг, Аарон ер гэртээ харьдаггүй ч юм шиг, Ларри Кинг өдөр болгон яаж ийм ярилцлагууд хийж амжина вэ гэсэн гайхшрал тэгэхэд төрсөн. CNN-ийн залуур болсон дээрх хэдхэн хөтлөгчийн ард бүхэл бүтэн баг хөдөлмөрлөж, мянга мянган мэдээллийг шүүрдэн дамжуулдаг ажээ.

**CNN-ийн  
мэдээлэл  
хүмүүст  
баримжаа  
чимээ, түшиг  
болж буйг  
мэдэрсэн юм.  
Цагдаагийнхан  
арван хэд  
хоногийн  
турш хүчин  
мөхөсдөхөд  
айсан  
хүмүүст CNN  
л хань болж  
байсан.**

Мэргэн бууч ээлжит байгаа онилсны дараа 15-30 минутын дотор CNN мэдээ дамжуулж байлаа. Тэр өдрүүдэд Вашингтон орчимд байж таарч бусдын адил түгшиж явахдаа CNN-ийн мэдээлэл хүмүүст баримжаа чимээ, түшиг болж буйг мэдэрсэн юм. Цагдаагийнхан арван хэд хоногийн турш хүчин мөхөсдөхөд айсан хүмүүст CNN л хань болж байсан.

Вашингтон орчмын Виржиниагийн цагдаагийн хэлтсийн ахмад Мүүс ээлжит мэдээллээ өгөхөөр гарч ирсэн мөчийг тод санаж байна. Бороонд норж, зузаан хүрэм, цамц давхарлаж өмсөцгөөсөн сэтгүүлчид Мүүсийн бараанаар дуу шуу орж урагш тэмүүлцгээв.

-«Пандалоза» зоогийн газрын үүдэнд алуурчин ээлжит халдлагаа хийжээ. Тэр бидэнд зурвас үлдээсэн. Хэвлэлийнхэн та нараас хүсэх зүйл байна. Миний үгийг зурвас үлдээгчид энэ хэвээр нь дамжуулж өгнө үү «Бид зурвас дээр дурдсан утсаар холбогдох гээд чадсангүй. Бидэнтэй дахин ярина уу» ингэж хэлмэгцээ ахмад Мүүс эргээд алхлаа. Хэвлэлийн төлөөлөгч нь «Уучлаарай, одоогоор үүнээс илүү зүйл хэлэх боломж алга» хэмээв. Бороонд норж дагжсан сурвалжлагчид цочир мэдээллийн дараа минут хэртэй ам ангайгаад, «Ердөө л энэ үү?!» гэгцгээх нь сонсогдов.

Хэдхэн мөчийн хойно «Бид зурвас дээр дурдсан утсаар холбогдох гээд чадсангүй. Бидэнтэй дахин ярина уу... Бид зурвас дээр...» хэмээн телевизийн сувгууд давтан давтан мэдээлж гарлаа. Алуурчин, цагдаагийнхан, Америк тэр аяараа теле сувгаар ийнхүү хоорондоо харилцав. Тэр өдрүүдэд CNN америкчуудын хажууд байж, тайвшруулж, сэрэмжлүүлэн, зүг чиг баримжаа нь болох шиг санагдсан. Мэдээллийн ийм нэг монгол хувилбар бидэнд үгүйлэгдэж байна. «Eagle» гайхамшигтай хөтөлбөрүүдтэй байгаагүй. Гэхдээ тэр бол эхлэл. Түм буман мэдээллийн дунд тулж баримжаалах, олон нийтэд зориулсан сувгийг монголчууд үгүйлж байна.



# «Төлбөртэй нийтлэв»

Пулитцер, Херст хоёр маргалджээ. Бүр шүүх цагдаад хүртэл заргалдав. Юунаас болж тэр билээ? Эд бол дэлхийн шар хэвлэлийн загалмайлан эцэг. Хоёулаа сонины бизнест хүч үзэж, Америкийн мэдээллийн зах зээл дээр өрсөлдөн өөр зуураа зодолдож байлаа. Ноён Пулитцер олны дундаас сайн сэтгүүлч олж шүүрддэг гайхамшигтай мэдрэмжтэй. Харин баян Херст чадалтай сурвалжлагчийг мөнгөөр уургалж дөнгөдөг овжин бизнесмэн. Мань Пулитцерын «олж нээсэн» шог зураачийг Херст мөнгөөр «зодоод» өөрийн редакцид урвуулсан гэдэг. Авьяаслаг зураачийн бүтээл болох «Шар жаалхүү» нэртэй комикс цувралыг нь Херст өөртөө өмчлөх гэж зүтгэснээс болоод хэвлэлийн магнатууд шүүх цуухдаа хүрчээ.

Шүүх хуралдаан дээр Пулитцер өрсөлдөгчдөө хандан «Чи сэтгүүлчийг мөнгөөр урвуулж болно. Харин уран бүтээлийг өмчилж чадахгүй» гэжээ. Энэ ишлэл дэлхийн сэтгүүлзүйн түүхэнд тод өнгөөр бичигдэн үлдсэн юм. Эдүгээ өнгө нь бүдгэрээгүй, мөн чанар нь ч хуучирсангүй. 100 гаруй жилийн өмнөх маргаан өнөөгийн Монголд давтагдаж байна.

## ӨГВӨЛ АВААД БАЙ

«Сайн сэтгүүлч байна уу?» Ялангуяа бизнесийнхэн ингэж сураглаад байх болж.

-**Материал бичүүлмээр байна.**

-Манай нийтлэлийн бодлогод нийцэхгүй эд юм.

-**Мөнгийг нь өгнө шүү дээ.**

-Хоёр компанийн хоорондын хэрүүлд бид оролцдоггүй.

-**Төлбөртэй нийтлүүлнэ гээд байхад...**

Миний мангарыг гайхаад мань захирал өөр сонинд ханджээ. Өнөөх ярилцлага өрсөлдөгч редакцийн маань бэлтгэсэн шинэ дугаарт гараад ирэв. Харин «Төлбөртэй нийтлэв» гэх тодруулга үзэгдсэнгүй. Эдүгээ захиалгат нийтлэлийн үер сонинуудын хуудаснаа бууж байна. Манайд ч өдөр алгасалгүй мөнгө ханхлуулсан нийтлэл, ярилцлага хэвлэгдсээр. «Гэм хоргүйхэн» эд бол бид ч тавиад байдаг. Өгвөл аваад бай гэсэн зарчимд хэн хүнгүй боомилуулах болсны учир нь мөнгө. Монголын реклам сурталчилгааны багахан зах зээлээс өөрсдийн хувийг хүртэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ёстой Пулитцер, Херст хоёр шиг зодолдож байна. Чөлөөт хэвлэлийн зам мөр дөнгөж 15 жилийг ардаа орхисон болохоор нялхсын өвчин буюу санхүүгийн бэрхшээл бид бүгдийг нэрвэсэн хэвээр.

Энэ зовлонг зурвасхан үед хамгийн чадварлаг ашиглаж буй хүмүүс бол улстөрчид ба бизнесийнхэн. Мөнгөө төлж хөгжмөө захиалахдаа тэд бүр гаргуун болжээ. Шинэ цагийн түүхнээ тохиосон 14 удаагийн ардчилсан сонгууль болгон хэвлэлийн редакциуд, сэтгүүлчдэд өгөөжөө хайрлажээ. Өгвөл аваад бай. Сүүлдээ энэ зэрлэг уриа сэтгүүлзүйг, улмаар амьдарч буй нийгмийг маань өмхийрүүлж эхэлснийг мэдээгүй хэмээн мэлзэж чадахгүй нь. Төлбөрт нийтлэлийн нялуун үгс, эсвэл иш мухаргүй хараал зүхлийг дагаад нийгэм өнгөгүй болж байна. Эсвэл тас хар, үгүй бол өөгүй цагаан. Төлбөрийг нь өгч орхивол ална гэж занасан ч хамаагүй агуулгатай зүйлийг ажралгүй нийтэлчих уур амьсгал бий боллоо.

Өндөрлөөд удаагүй байгаа Ерөнхийлөгчийн сонгуулийн марафон

Төлбөрт  
нийтлэлийн  
нялуун үгс,  
эсвэл иш  
мухаргүй  
хараал зүхлийг  
дагаад нийгэм  
өнгөгүй болж  
байна.

төлбөртэй нийтлэлийг бараг сэтгүүлзүйн шинэ төрөл зүйл болгох дөхөв. «Ардчилсан нам хоёр хуваагдав» хэмээн сөрөг хүчин нь өдөөн хатгаад материал нийтлүүлээ. Хариуд нь «Н.Энхбаяр Ерөнхийлөгчөөр сонгогдвол жагсаал цуглаан гаарах магадлалтай» гэсэн гарчиг маргаашийн сонинуудад дурайтал үзэгдлээ. Өрсөлдөгчөөсөө дутуугүй мөнгө хаясан болохоор хэвлэхээс яахав.

Яг ийм зөвтгөлийг өмнөө бариад нэгэн судлаачтай маргаснаа санаж байна. Монголын чөлөөт хэвлэлүүд оршин тогтнох гэж амь тэмцэж байгаа. Реклам сурталчилгааны багахан зах зээл дээр бид өрсөлддөг хэмээн өөрийгөө өмөөрч билээ. Гэвч захиалгат материалын улангассан дайралт ширүүсэх тусам, тэдгээрийн агуулга улам бүр эргэлзээ сэжиг бүхий бохир болохуйд яг одоо улаан гэрлээр дохих цаг ирснийг хэн хүнгүй мэдэрлээ. Сонинуудын нийтлэлийн бодлого үл ойлгогдом салаа утгатай, телевизийн шуурхай мэдээллийн цаг «Нарантуул»-ын радио узелийг санагдуулам өнгөнд хувирч байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын болоод Татварын багц хуульд өөрчлөлт оруулах шахалт шаардлага нийгэмд хүчтэй сонсогдохын хэрээр мэдээллийн редакциудын орлого өсч эхэллээ. Шалтгаан нь уул уурхайн компаниуд сөрөг дайралтаа мөнгөөр далайлган хийж эхэлснийх. «Бороо гоулд»-ын нийгмийн чиглэлийн арга хэмжээ, «Айвенхоу Майнз»-ын тухай арван шинэ мэдээ... Магтаалын үер бууж байгаа нь энэ. Сайн сэтгүүлч байна уу? ...Цухалдуу бизнесмэн хэн нэгэнд хэвлэлээр дамжуулан хариу бичлэг өргөн барихаар яарчээ гэсэн үг. Шинэ дайралтын хариуд өөр нэг төлбөрт материал мэндэлнэ. Ерөөсөө бид чинь сурвалжлан бичих үндсэн ажлаа орхиод мөнгөний үнэрээр тун идэвхтэй орж орхив.

Cityphone гэгч шинэ бизнесийг есдүгээр сар гарахаас өмнө амжаад дарж авъя. Ээлжит дайралтыг үүрэн телефоны операторууд манлайлж төлбөртэй материалаар сонинуудыг дарлаа. Хариуд нь яаж зүгээр суухав. Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, бас Cityphone-ийнхон ярилцлага нийтлүүлж, сонинд маань орлого оруулав. Баярлалаа. Гэвч нэг талыг барьсан ийм өрөөсгөл мэдээлэлд маань уншигч талархах эсэхийг мэдэхгүй юм.

## МӨНГӨ, НИЙТЛЭЛ ХОЁРЫГ ЗААГЛАХЫН УЧИР

Зар, сурталчилгааны албыг мэдээллийн редакцияас холхон байрлуулахын учир юу вэ? Бүр өөр давхарт тэдгээрийг тусгаарладаг дэлхийн хэвлэлүүдийн туршлага нэгийг өгүүлнэ. «Сэтгүүлч төлбөртэй материал бичихийг хориглоно» гэсэн өгүүлбэрийг тэд ёс зүйн дүрэмдээ яагаад заавал оруулдаг вэ? Cityphone-ийн үйлчилгээ сайн уу, муу юу, Харилцаа холбооны зохицуулах хорооныхон авлига авсан уу, үгүй юу гэдгийг уншигч тал руу туйлширсан төлбөртэй нийтлэлээс бус, сэтгүүлчийн бие даасан тайлбар баримтаас мэдэж авахын чухлыг онцолж ийн хатуу дэг жаяг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчийн сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нэг ёсны чанарын шаардлага тавилаа гэсэн үг. Монголын онцлог, бэрхшээлийг өмнөө барин өөрсдийгөө зөвтгөх зуураа бид чөлөөт хэвлэлийн 15 жилийн зам мөр, туршлагыг мөнгөөр ингээд угаачихмааргүй байна. Захиалгат нийтлэлийн сэдэв ар араасаа хөврөн, харин сэтгүүлзүйн хөгжил дэвшил саарч эхэлснийг хараад дуугаа хураан сууж чадахгүй нь. Мэдээллийн эрх чөлөөг эрх баригчдаас шаардахаасаа өмнө бид мөнгөний эрхэнд улам бүр орсоор байна.

«Сэтгүүлчийг худалдаж авч болно. Харин уран бүтээл олон нийтийн өмч» гэсэн Пулитцерийн үгийг эргэн сануулъя. Хэвлэлийн хуудас, эфирийн цаг нь хэрэглэгчийнхээ өмч болохыг сануулсантай ялгаа юун. Төлбөртэй нийтлэлийн үер Монголын реклам сурталчилгааны жам ёсны хөгжилд ч чөдөр тушаа болж

Захиалгат  
нийтлэлийн  
сэдэв ар араасаа  
хөврөн, харин  
сэтгүүлзүйн  
хөгжил дэвшил  
саарч эхэлснийг  
хараад дуугаа  
хураан сууж  
чадахгүй нь.

эхлэв. Манайд үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд энэхүү парадоксыг сурамгай мэдэрчээ. Тэд бизнес төлөвлөгөөндөө «Сонинд өгөх төлбөртэй нийтлэл» гэсэн зардал хавсаргадаг болов.

Мөнгөнд ороогдсон сэтгүүлзүйн уналт мөхөл дагуулж болохыг хэдхэн жилийн өмнө монголчууд харсан. Влад Листьевийн «ВИД» олны хүртээл болохын хэрээр реклам захиалагчдын хараанд өртсөн билээ. Улмаар «ВИД» мөнгөний уурхай шиг л ашиг орлого хүүдийлж гарсан. Тухайн үедээ (1995 он) үзэгчдийг хуйлруулж асан «Поле чудес»-ийн дундуур ганц минутын сурталчилгаа цацахад 40.000 ам.доллар төлдөг жишиг тогтсоныг дуулаад үнэмшихэд бэрх санагдаж байсан юм. Уран бүтээлийн «ВИД» нэгдлийн харъяа «Поле чудес», «Взгляд» тэргүүтэй гурвал нэг үе зөвхөн мөнгөөр амьсгалж, реклам захиалагчийнхаа атганд улам бүр орсоор байлаа. Сүүлдээ минутын 40.000 ам.долларын төлбөрийг нь цааш давхар дамлаж өсгөдөг сүлжээний бизнест ороогдсон юм. Энэ гогцоо улам чангарсаар Листьевийн эмгэнэлт үхэлд хүргэсэн гэх таамгийг бид мэднэ. Уран бүтээлийг хэрэглэгчийн хүсэл таашаалаар бус, мөнгөний эрхээр туурвихын гаж дагавар сэтгүүлзүйг мохоох аюултай. Өөрөө өөрсдөдөө бид улаан гэрэл асаахгүй бол улстөрч, бизнесийнхний хэлсэн үг, илтгэлийг сийрүүлдэг огтор бичээч нар дэндүү олширлоо.

**2005 он**

# Урт настай хууль, удтал хүлээлгэх журам

Арван хэдэн доллар төлөөд тэд «манеж»-д нэвтэрч буй бололтой. CNN-ийн ердийн нэвтрүүлгийг бэлтгэж байна. Сонирхогчид зүгээр ингээд эфирт орж орхих. Бидний төсөөллөөр бол гайхалтай ч юм шиг. Дарга нар, эсвэл дуучид л дэлгэцэнд ээлжлэн гардаггүй билүү?

Эфирийн монгол жаягийг санан байж CNN-ийн «манеж»-д нэвтэрлээ. «Зочин» гэх тэмдэг энгэртээ зүүсэн тул тасалбар авч мөнгө зарсангүй. Эхлээд «дасгалжуулагч» гараад ирлээ. Гэрэлтсэн дулаан харцтай залуу. Хар арьстнуудын этгээд алхаа, хэмнэлт хөдөлгөөн дээр бусдын анхаарал татах бүхий л увьдас чадвар түүнд байх шиг. Мөнөөх соронздон илбэдэх чанарынхаа хүчээр CNN-ийн галд нэгдэн, нэр хүндтэй нэвтрүүлгийн багт оржээ. Нүд рүү цоргитол ширтэн яралзтал инээмсэглэнэ. Түүний гярхай харцнаас энэ дугуй талбайд эгнэн суусан хэн ч бултаж үлдэхгүй. Энгэр дээр наасан товч нэр бүхий дугуй цаас өөд хяламхийгээд л хэзээний андууд адил өөриймсөг ярьж эхлэв. «За сайн уу? Ажил, амьдрал онц биз? Ажлаа тараад шууд ирсэн үү? Үдийн хоолонд юу зооглов доо. Өө, би гэдэг хүн юу идсэнээ ч мартаж орхиж. Өнөөдөр бид юун тухай ярилцахыг мэдсэн биз дээ» Хар арьст эр тасралтгүй ярина. Хүмүүс ч камерын өмнө биеэ барихаа больж, гэрийнхээ зөөлөн буйдан дээр тухалсан лугаа аажмаар тайвширч билээ.

**«За сайн уу?  
Ажил, амьдрал онц  
биз? Ажлаа тараад  
шууд ирсэн үү?  
Үдийн хоолонд юу  
зооглов доо. Өө, би  
гэдэг хүн юу  
идсэнээ ч мартаж  
орхиж. Өнөөдөр  
бид юун тухай  
ярилцахыг мэдсэн  
биз дээ» Хар арьст  
эр тасралтгүй  
ярина. Хүмүүс ч  
камерын өмнө биеэ  
барихаа больж,  
гэрийнхээ зөөлөн  
буйдан дээр  
тухалсан лугаа  
ажмаар тайвширч  
билээ.**

Төдөлгүй нэвтрүүлгийг хөтлөгч эмэгтэй хөнгөн алхсаар тойргийн төвд байраа эзэллээ. Анхаарлаа төвлөрүүлэхийг хичээн нааш цааш хэд алхсанаа гурван талд байрлуулсан том телевизээр энд цуглагсадтай холбогдох эрхмүүдийн нэр, албан тушаалыг давтаж эхлэв. Нийгэмд тулгамдсан асуудлуудыг хөнддөг уг нэвтрүүлгийн ээлжит дугаар бичигдэж байна. Харин мөнөөх «манеж»-ийн гадуур буюу CNN-ийн төв байрнаа ажил хэрэг ердийн хэмнэлээрээ үргэлжилнэ. Нэгдүгээр давхрын уужим талбайн хэсэгт зассан ил студид яг одоо нэвтрүүлэг бичиж буйг анзаарсан хүн ч алга. Ярих сэдвийг нь урьдчилаад зарласан болохоор сонирхогч, бас зүгээр л оролцоод үзмээр санагдсан хүмүүс энд цуглажээ. Иргэдээ телевиз нь ийнхүү энгийн урилгаар цуглуулж байна. Хүмүүс санал бодлоо уралдуулж, албан тушаалтнуудтай ярилцав. Өнөөдөр Монголын телевизүүдийн хөтөлбөрт иймэрхүү нүүр тулсан ярилцлага, уулзалт мэр сэр үзэгдэх болсонд бид баяртай байна. Харин нэвтрүүлгээ чанартай болгох, оновчтой төлөөлөл урих, хүссэн үр дүнд хүрэхийн тулд бусдаас будаа идэх зүйл бий.

## DEBATE

Нэвтрүүлгийн өөр нэг хувилбар Монголд моодонд орлоо. «Форум» нэртэй мэтгэлцээний хөтөлбөр хэдий муу, сайнаа дуудуулж буй ч мэтгэлцээнт ярилцлагын үр хөврөлийг нэгэнт төрүүлжээ. Үзэгчид ч сонирхон анзаарах болж, «Форум»-ын чансааг сайжруулах санаа шүүмжлэл өгүүлж буй. Гэвч монгол debate нэг л өнгөө олохгүй үргэлжлээд байх шиг.

Мэтгэлцээний нэвтрүүлгийн мөн чанар юусан билээ? Яагаад CNN-ийн Crossfire хоёр хөтлөгчтэй байдаг юм? Ардчилсан намын улаан фэн Жэймс Гарвилл, Пол Бегала хоёр Бүгд найрамдах намыг цуцашгүй дэмжигчид Роберт Новак, Тукер Карлсон нартай хос хосоороо халз үзэлцэхийг үзүүлж өгнө дөө. Улс төрийн сэдвээр мэтгэлцээн өрнүүлдэг уг хөтөлбөрийг Америкийн үзэгчид тун сонирхдог. Гол нь тайзнаа жинхэнэ ёсоор үзэлцэж, сөргөлдөгч талууд

үнэн царайгаа камерын өмнө таниулдаг. Хүрээлэн суусан иргэдийн төлөөлөл маргааны дундуур сэтгэл хөдлөлөө харамгүй илэрхийлэн, үнэхээр дэлгэцнээс гал маналзтал халуун явдал өрнөдөг.

Өнөөгийн монгол «Форум» лугаа нэг сэтгүүлчийн урьдчилан бэлтгэсэн том дүгнэлт, эсвэл ганц хөглөгчийн «нюанс» муутай асуултуудад дөрлүүлсэн оролцогчид дүмбийн суух зав тэнд ер гарахгүй ээ. Телевизийн мэтгэлцээний мөн чанарыг Монголдоо эхнээс нь гажуудуулалгүй, хазгай муруйгүй хөгжүүлэхсэн гэсэндээ дээрх жишээ татан нуршив.

## САЙН ПРОГРАММ

Монголын телевизүүдийн хөтөлбөрт сүүлийн үед нэвтэрч буй шинэ салхины сэвшээнд олзуурхахын хамт ийн үг нэмэрлэлээ. Одоо телевизүүдийнхээ программын өрсөлдөөний тухай ярилцъя. Хэн нь сайн хөтөлбөртэй вэ? Бие биеэсээ ялгарах онцлог бий юу? Ийм онцгойрох ялгаа байх учиртайг тодотгож өгөхөөр Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг баталчихаад байна. Монголчууд учиргүй олон жил энэ хуулийг хүлээв. Өдгөө юунд ингэтэл хүлээснээ гайхаж сууна. Арваад жил дуншсан уг хууль телевизийн хөгжлийг хэрхэн өөрчлөх юм бэ? Америк нэвтрүүлгүүдээс иш татаж, урт өмнөтгөл хийснийхээ учрыг хэлье. Үндэсний тодотголыг халж, олон нийтийн хэмээн цоллосон өөрчлөлт юуны өмнө нэвтрүүлгийн программд, улмаар агуулга чансаагаар илрэх ёстой. Олны эрх ашигт нийцэж, түмнийг тэр суваг даллаж чадах хөтөлбөртэй юу? Ийм өөрчлөлт хүлээж Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг баталжээ. Энэ оны долдугаар сарын 1-ээс мөрдөх хугацааг ч заасан. Тэр болтол, эрх баригчдын дуу хоолойг дагнан дамжуулах ажлаа ард иргэдийн санал бодлоор солин цацах өөрчлөлтийг аажмаар хийх үүрэг хүлээсэн. Өдгөө тэр шинэчлэлт Танд мэдрэгдэх юм уу? Өөрийг тань онцолсон шалтгаан нь телевизийн хураамж ямар хэмжээтэй байх, сард хэдэн төгрөгийг халааснаас чинь авахаа мөнөөх шинэ хуулийн дагуу Олон нийтийн радио, телевизийн удирдлага бие даан шийдэх гээд байна.

Эрчим хүчний зохицуулах газар нэрт «муу нөхөртэй» болсон түүхээ хэрэглэгч Та эргэн санана уу. Яг л дээрх маягаар, шинээр батлагдсан хуулийн хүрээнд толгой мэдэн цахилгаан, дулааны үнэ тогтоодог байгууллага мэндэлсэн. Тэднийг үнэ нэмлээ хэмээн Т.Очирхүү сайд хориг саад тавих эрхгүй. Үүнтэй агаар ойролцоо заалт бүхий хууль мөдхөн хэрэгжинэ.

## ХҮЛЭЭЛТ

Удтал хүлээлгэсэн хууль маань дагалдах журамтай болж байж биеллээ олно. Тэр нь тэгээд мөд батлагдах шинжгүй ээ. Өөрөөр хэлбэл, үзэгчдээс хэдэн төгрөг хураахыг шийдэх хүмүүс буюу Үндэсний зөвлөлийн 15 гишүүн хэрхэн тодрох шат дамжлага тодорхойгүй. Ерөнхийлөгч дөрөв, Засгийн газраас нэжгээд, УИХ долоон хүний нэр дэвшүүлж улмаар УИХ дээр санал хурааж байж тэднийг томилно. РТХЭГ-ын даргыг баталдаг өмнөх томилгооноос юугаараа ялгаатай юм бэ гэж үү? Урьд нь Ерөнхий сайдын харьяалах ажлын хүрээнд байснаа больж, одоо бүр улстөржсөн байгууллага-УИХ-ын мэдэлд удирдлагын асуудлыг шилжүүлжээ. Үндэсний зөвлөлд санал болгох хүмүүсийг төрийн бус байгууллагууд нэр дэвшүүлэх, улмаар Ерөнхий сайд, УИХ, Ерөнхийлөгчийн таалалд тэд нь нийцвэл дараагийн шүүлтүүрт орохоор хуульчилсан. Эцсийн дамжлага буюу УИХ нь санал болгосон хүмүүсийг батлах эсэхийг шийднэ. Нэрсийг буцаавал өөр хүн томилох ажил үргэлжилнэ.

УИХ-ын олонхийн таалалд нийцсэн эрхмүүд Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрт хяналт тавьж, санхүүд аудит хийлгэх газраа өөрсдөө

сонгож, телевиз, радиогийн удирдлагыг томилж, халах эрх эдэлнэ. Түүнчлэн зөвлөлийн зөвшөөрлөөр программ хянах орон тооны бус бас нэг зөвлөл мэндэлж мэднэ. Энэ болгоны эцэст радио, телевизийн үйл ажиллагаа өнөөгийнхөөсөө эрс өөрчлөгдөн, бие даасан байр суурьтай байна гэдэг үлгэрийн далай гэдгийг хялбархан анзаарч болно. Хуулийн удиртгалд олон нийтийн хяналт дор үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага хэмээн тодотгосныг сануулъя. Харин нөгөө иргэд нь хяналтаа өргөдөл гомдлоороо дамжуулан хийх гэнэ. Тэгвэл Өргөдөл шалгах хорооны бүтцэд дахиад л Үндэсний зөвлөлийн гишүүд байлцана. Энэ мэт авцалдаа муу салаа утгатай санаа цөөнгүй. Хөгжилтэй орнуудын туршлагыг дуурайн бэлтгэсэн ийм хувилбар бие биеэ андахгүй мэддэг цөөхөн монголчуудын амьдралд сайн утгаараа бууна гэхэд хэцүүхэн санагдана.

Засгийн газартайгаа нийлээд парламент Үндэсний зөвлөлийн 11 гишүүнд нөлөөлөх боломж нээлттэй. УИХ-ын таалалд нийцтэл хэдэн удаа нэр дэвшүүлж, эргэж буцах «боломжтой» тухай хуульд тодорхой тусгасан заалт үгүй. Түүнчлэн төрийн бус байгууллагууд нэр дэвшигчээ хэрхэн тодруулах, өндөрлөгүүдэд ямар хугацаанд өргөн барих вэ зэрэг харилцааг зохицуулах журам гарч таарах нь.

Их хүлээлгэсэн ч гялайлгах зүйл багатай үзэгдэх энэ хууль хэрэгжтэлээ мөн л урт зам туулна. Энэ парламентын хийсэн том ажил гэж түүнийг нэрлэдэг. Харин хэрэгжихийнхээ наана Ерөнхийлөгчийн сонгуулийн дуулианд бүдгэрч, залгуулаад үргэлжлэх магадлалтай улс төрийн бужигнаант үйл явдлуудын тоосонд хаягдан, зуны зугаатай өдрүүдийн наазгайд өтөлж мартагдах вий дээ.

**2003 он**



# -ХЭНИЙ ӨМЧ ВЭ? -ОЛОН НИЙТИЙНХ

Хаалганы завсар зурвас хавчуулаад орхижээ. «2005 оны телевизийн хураамжаа Хадгаламжийн банкны ... дансанд тушаагаарай» хэмээн шаардсан байна. Бяцхан цаасны нэг өнцөгт «Яаралтай!» гэж палийтал бичээд шавдуулжээ. Шаардах хуудсыг хэн авчирсан, өмнө нь тэрхүү эрхэмтэй яагаад огт тааралдаагүйг хэлж мэдэхгүй нь. Элдэв төрлийн үйлчилгээний төлбөрийг энэ мэтээр алдаг оног, алгын чинээ цаасаар нэхэмжилдэг явдал үеэ өнгөрөөж буй цаг юмсан. Өнгөрсөн жилийн өдийд радиогийн хураамж нэхсээр нэг эмэгтэй хаалга цохисон санагдана. Эргэж түүний барааг харалгүй жил тойрлоо.

Радио, телевизийн хураамж цуглуулах ажил цаг үеэсээ хол хоцорсон. Мөн тэрхүү сар бүрийн 1100 төгрөгийн төлбөрийг тогтмол хураалгалаа гээд нэвтрүүлгийн чанарт ямар өөрчлөлт орсон, өгөхгүй байлаа гээд хэрэглэгч надад ял зэм ирэх эсэхийг мэдэхгүй. Үндэсний радио, телевизийн өнөөгийн үйл ажиллагаанд цоо шинэ менежмент үгүйлэгдэж байгааг гэрчлэх наад захын баримт ийм. Хэрэв үйлчилгээний хөлсөө гүйцэд цуглуулж чадвал нийт санхүүжилтийнхээ нэлээд хэсгийг эндээс бүрдүүлж чадна хэмээн Ц.Мөнх-Оргил сайд өгүүллээ.

Олон нийтийн радио, телевизийн тухай хууль хоёр сар гаруйхны дараа хэрэгжиж эхлэх гэж буй үед уг баримт бичгийн төсөл дээр ажилласан, цаашид хэрэгжүүлэх учиртай хүмүүс ойр ойрхон уулзаж ярилцдаг болоод байна. Цаг хугацаа шахаж тулсан атал хуулиа хэрэгжүүлэхийн наана тодорхойгүй бүрхэг зүйл тун их. Тэдгээрийг тайлбарлах журам зохицуулалтын тухай санаа оноо төдий л одоогоор дугуй ширээ тойрон эргэлдэх аж. Ийм нэг уулзалтаас хийсэн сурвалжлагаа хүргэе.

## МӨНГӨ ҮҮ? МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛ ҮҮ?

-Энэ хуулийн хүрээнд манай нийгэмд цоо шинэ харилцаа, соёл нэвтэрнэ. Өнөөгийн Үндэсний телевиз ойрын ирээдүйд жинэхнэ ВВС, ННК шиг болж чадах уу, эсвэл зүгээр л арилжааны телевизүүдийн дэргэдэх дамжуулах станц лугаа дагалдах байгууллага болж хувирах уу гэсэн асуултын өмнө ирээд байна гэж Ц.Мөнх-Оргил яриу. Өөрөөр хэлбэл Үндэсний радио, телевизийг олон нийтийнх болгох ажил юуны өмнө нийгмийн сэтгэлгээг өөрчлөх, сэтгүүл зүйн чансаа, менежментийн шинэчлэлээс эхлэх ёстой гэж үзэж буй хэсгийг тэр төлөөлнө.

Харин «Нэгдүгээр зорилго бол мөнгө. Санхүүжилтээ хэрхэн олох вэ гэдэг хамгийн тулгамдсан асуудал. Хүмүүсээ сургах нь дараагийн алхам» гэсэн байр суурийг өнөөгийн МРТХЭГ-ын удирдлага илэрхийлэв. Техник, тоног төхөөрөмж хуучирч муудсан, мянгаад хүнтэй их айлыг цаашид яаж тэжээж тэтгэх билээ, арилжааны сурталчилгааг нийт нэвтрүүлгийн цагийн хоёрхон хувьд оногдуулсны гай зовлон юу байхав, нийгмийн шинж чанартай рекламуудаас олигтой орлого орох уу даа, ёстой хоёрын хооронд хууль гарсан гэх бухимдлыг Үндэсний телевиз, радиогийн удирдлагууд энд давтан ярьсан юм. Хариуд нь шинэ хуулийн үзэл санааг хамгаалсан хэсэг ийн эсэргүүцлээ.

**УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл:** -Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсаны дараа урам хугарч санаа зовсон. Манай телевизийнхэн зөвхөн аж ахуй, бизнесийн зүйлс л яриад байдаг. Мэргэжлийн ажилд нь зарчмын огт өөр арга барил нэвтэрч, өөрчлөлтийн салхи үлээх гэж буйг тоодог хүн алга. Эндээс мэргэжлийн үйл ажиллагаандаа анхаарахаас илүү аж ахуйн чиглэл, ашиг сонирхол түлхүү болох юм биш биз гэсэн болгоомжлол төрлөө. Санхүү төсөв дээр бол уг нь зовлон гарахгүй шүү дээ гэв. «Төсөв батлуулахад маш их бэрхшээл учирдаг. Хасаад танаад л байдаг. Хөндлөнгөөс хараад шүүмжлэх амархан л даа. Яг энэ ажлыг гардаад хийхэд төсөв мөнгөний хүндрэлтэй ямагт тулгардаг» хэмээн МРТХЭГ-ын дарга Б.Ганболд учирласан юм. Тэгвэл өнөөгийн менежмент хоцрогдсон гэдгийг Ц.Мөнх-Оргил ахин дахин санууллаа.

-Одоогийнхоо нүсэр бүтцээр, нөгөө л мянга гаруй хүнээ өмнөө бариад төсөв нэхвэл түүнийг өгч чадахгүй нь ойлгомжтой. Менежментээ ингэж шинэчилнэ гэсэн төлөвлөгөө санаагаа бариад орж ирвэл өөр хэмээн тэрбээр байр сууриа бататгав.

Ер нь энэхүү уулзалтын явцад телевиз, радио зах зээлээ бодитой судалж, маркетингийг нь өөрчлөх цаг болсон гэсэн санаа олзуурхам тод сонсогдсон билээ. Хураамж төлбөрөө шахааж шаардуулалгүй өгөхийн учир холбогдлыг олон нийтэд таниулах ажлыг давхар хийх цаг болсон гэж ярьцгаав. Нээрээ хэрэглэгч надад ч ийм сэтгэл дутаад, телевизийн «байцаагч»-ийнхаа барааг жил, хагас жил тойрон үзээгүй явна. Юуны тулд мөнгө төлж буйгаа мэдэртэй байдаг. Гэтэл телевизийн нэвтрүүлгүүдийн чансаа гэдэг нүүр улайм. Олон нийтийн радио, телевизийн хуулийг УИХ эн түүрүүнд хэлэлцэн батална хэмээн мэдэгдэж байсан бүр өнгөрсөн намраас «Өнөөдөр» сонин телевизийн мэдээлэл, нэвтрүүлгийн төв байр суурь, чанарын тухай байнга бичсэн. Өдгөө хууль хэрэгжихийн өмнөхөн олон нийтийн телевиз байхын утга учрыг зар сурталчилгааны хоёрхон хувийн орлого хэмээх улиг болсон булангаас бус, шинэ орчин, оновчтой менежмент, арга барил, мэргэжлийн түвшин гэх өнцгөөс үзээсэй гэсэн байр суурийг талархан дэмжсээр байна.

## БАС НЭГЭН ШИЛЖИЛТ

Бид өөр нэгэн шилжилтийн гараан дээр ирээд байгааг «Глоб интернэшнл» ТББ-ын гүйцэтгэх захирал Х.Наранжаргал онцоллоо. Монгол Улс Үндэсний радио, телевизээ өөрчлөх гэж байна. Өөрөөр хэлбэл олон нийтийн тодотголтой өмч хөрөнгө бол манайханд танил бус ойлголт. Ойлголтын ялгааг гэтлэхийн тулд сэтгүүлчид, улстөрчид цугаараа сэтгэлгээнийхээ «барьерийг» давж туулья. Тэр нь бидний хувьд шилжилтийн нас л гэсэн үг хэмээх санааг уулзалтад оролцсон цөөнгүй хүн тэмдэглэсэн. Хуулийн төсөл дээр олон жил ажилласан Х.Наранжаргал, Монголын сэтгүүл зүйд өмнө нь сонсогдоогүй хоёр чухал санаа энд багтсаныг тодрууллаа. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл анх удаа өөрийн зохицуулалттай болно. Өргөдөл шалгах хороонд иргэд санал гомдлоо илгээж, улмаар радио, телевизийнхэн мөрөөр нь ажиллана. Түүнчлэн сэтгүүлчид эх сурвалжаа нууцлах эрхийг хуульчилсан эхний тохиолдол нь манай сэтгүүл зүйн түүхэнд том дэвшил амжилт болохыг хэллээ. «Хуулиа сайн, нэг мөр ойлгомоор байна даа» гэж тэрбээр ядрангүй дуугаар нэмж өгүүлсэн юм. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төслийн эхний мөрийг хатгаж, цоо шинэ харилцааг таниулах гэж цөөнгүй жил зүтгэсэн энэ эмэгтэйн хөдөлмөрийг үнэлэх өдөр ирэх биз ээ.

Хуулиа нэг мөр ойлгоогүйгээс болоод долдугаар сарын 1-нээс өмнө зохицуулж бармааргүй чимхлүүр ажил цөөнгүй хуримтлагджээ. Уулзалтад төрийн бус байгууллагын төлөөлөгчид оролцсон. Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага буюу Үндэсний зөвлөлийн 15 гишүүнийг

тэд «дээшээ» санал болгоно. Гэтэл санал болгох учиртай ТББ-ын тоо 4000 гаруй. Бүгдээрээ хамтарч хуралдаад төлөөлөгчдөө сонгох уу, яах вэ... Ийм чуулган зохион байгуулах ажлын хэсгийг хэн санаачлан бүрдүүлэх вэ? УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо туслаад өг л дөө. Ер нь хуулийн мөн чанарыг сайн ойлгож буй, бүрэн дүүрэн тайлбар өгч чадахаараа танай Байнгын хорооноос ажлын хэсэгт хүн ормоор юм гэсэн санал, эргэлзээ энд олонтаа дуулдав. Байнгын хорооны дарга С.Батболд «УИХ оролцоод эхэллээ гэсэн хардлага сэрдлэг ард түмний дунд гарна шүү дээ» хэмээн болгоомжлов. Айдас цааш халдварлаж, аль нэг төрийн бус байгууллага ажлын хэсэг санаачлаад эхэлбэл дараа нь хариуцлага хэнтэй тооцох тухай яриа дэгдэх вий хэмээн эмээцгээв. Эцэст нь, ер нь л ТББ-ууд хуулиар олдсон эрхээ эдэлж санаачлагыг гартаа ав, нэрээ дэвшүүлшгээ гэсэн уур амьсгалд бүгдээрээ нэгдлээ. Мөн «Бүх ТББ Үндэсний зөвлөлд өөр өөрийн чиглэлийн эрх ашгийг яриад суух уу. Энэ 15 хүнийг ер нь яаж ойлгох ёстой юм» хэмээн Үндэсний телевизийн захирал Ч.Куланда уурлаж харагдана. Хариуд нь «Биднийг бялуу хуваалцахаар энд ирсэн юм шиг ярилаа» гэж ТББ-ын төлөөлөгч гомдов. Шинээр батлагдсан хуульд ТББ-ууд өөр өөрсдийн чиглэлээр нэр дэвшүүлэх ажилд оролцоно гэсэн санаа орсноос болоод ийм маргаан гарчээ.

### УРТ НЭРТ

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахаар холбогдох байгууллаагынхан ийн үе үе уулзаж байна. Харин уулзалтын үеэр ярьсан олон чухал санааг Үндэсний телевиз орхиж гээн өм цөм мэдээлдэг нь харамсалтай. Бусад телевиз ч нэг их ач холбогдол өгөн тоох шинжгүй. Нэг бол 70 жилийн түүхтэй том мэдээллийн хэрэгслээ жижиг станц болгож орхих, үгүй бол монголчууд өөрийн гэх ВВС-тэй болох салаа замын утгал дээр санал бодлоо нийлүүлэх, үзэгч, хэрэглэгч танд хэлэх учиртай «нюанс» нуугдсаар байгааг дуулгая. Радио, телевизийн менежментийг гадаадынхны гарт хэсэгтээ өгье гэсэн яриа ч энд сонсогдов.

Үндэсний радио, телевизийн өнөөгийн эзэмшлийн бүх хөрөнгийг шинэ «хүнд» шууд шилжүүлэхгүй. 14.2 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх хөрөнгийн 5.5-ыг нь ОНРТ-д, үлдэх 8.7 тэрбумыг улсын үйлдвэрийн газарт шилжүүлнэ. Улсын үйлдвэрийн газрыг Төрийн өмчийн хороо төлөөлөх аж. Нэр нь тун урт. Дамжуулах байгууламжийн радио, телевизийн техникийн компани гэх. Бэлтгэж бүтээсэн нэвтрүүлгийг танай гэрийн хойморт хүргэх байгууламжийг төр мэдэлдээ үлдээнээ гэсэн үг. Зургадугаар сарын 30-ны байдлаар өмч хөрөнгийг нь тоолоод жинхэнэ ёсоор өрх тусгаарлах аж. «Одоо бараг өмчөө хуваачихсаан» хэмээн тус байгууллагын өнөөгийн удирдлагууд хэлэх нь сонсогдлоо.

Сурвалжлагынхаа төгсгөлд том шилжилтийн өмнөх «жижигхэн» асуултуудаас хүргэе. Хэвлэлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал М.Мөнхмандах ингэж асуулаа.

**-Үндэсний зөвлөл телевиз, радиод хоёуланд нь хамаатай юу?**

**-Долдугаар сарын 1-нээс өмнө зөвлөлд нэр дэвшүүлэн тодруулсан байх уу, эсвэл мөн өдрөөс эхлэн хэлэлцэж ярих ёстой юу?**

Хуулийг тойрсон хамгийн энгийн мэт ойлголтууд ч үнэн хэрэгтээ ийнхүү тайлбар хариултгүй байна. Ингэхэд хууль ойр мөддөө хэрэгжиж чадах болов уу?

# Зохион бүтээгчид халаас ТЭМТРЭХ цагаар

«Нэг мэдэхэд  
би кнопоо дарсан  
байлаа» гэх  
онигоо одоо  
УИХ-ын  
гишүүдийн  
намтарт шигтгээ  
болон үлдэх нь.

«Бөмбөгийг та нарт өглөө» хэмээх ишлэлийг тэмдэглэсэн сонины хуудас шарлаж мартагдах цаг яагаа ч үгүй. УИХ-ын дарга өнгөрсөн намар Ерөнхий сайдтай тохой нийлэн суугаад хэвлэлийн хурал зарлахдаа ингэж мэдэгдсэн юм. Улстөрчид буюу PR-ийн марафончдын дунд ширэн бөмбөг лугаа холбирч сүжирсээр хормой сул тодотгол зүүсэн Үндэсний радио, телевизээ алаг бөмбөгтэй зүйрлэсэн хэрэг. Сэтгүүлчид үгэн бэлэг авч, үзэгч, сонсогчид магнай тэнийх шахсанаас хойш нэг мэдэхэд хагас жил шахам урсан оджээ. Гэвч бөмбөг хаалгандаа орсонгүй. Хуучин эзэн шинэ тоглолтод бэлтгэх зуур торгуулийн шугам дээр аниргүй гацаж орхив. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төсөл яргүйн хувьсгалын сүүдэр дор халти мөлт яригдаад нэг мэдэхэд батлагджээ. «Нэг мэдэхэд би кнопоо дарсан байлаа» гэх онигоо одоо УИХ-ын гишүүдийн намтарт шигтгээ болон үлдэх нь. Гишүүн Б.Жаргалсайхан чуулганы танхимд үзэгдээгүй атал түүний мэдлийн кноп өөрөө «Зөвшөөрлөө» хэмээн санал хэлж амь оров. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төслийн мөн чанарыг ухаж сонирхоогүй, уншсан эсэхэд нь эргэлзмээр түшээд цөөнгүй. Гэсэн ч саналаа өгч «За, за» гэгцгээв.

Монгол Улсын түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал буюу төрийн мэдлийн цагаан хоолойг олон нийтэд шилжүүлэх эрх зүйн том баримт бичгийг ийнхүү зарим нь нойрон дундаа баталжээ.

Өнгөрсөн намрын хэвлэлийн хурлаас өдгөөг хүртэл үргэлжилсэн хүлээлтийн эргэн тойронд юу болж өнгөрсөн бэ? Нойрмог гишүүд «Юу болоод өнгөрөв өө» гэгцгээх үес телевизийн уран бүтээлчид өөр зуураа мэдээллийн дайн зарлав. Дайны галыг Ерөнхийлөгч зогсоох ёстой гэгцгээн төрийн тэргүүний хоёр талд гарч жагслаа. Арилжааны телевизийнхэн хоёр хувийн сурталчилгаа гэгчийн тухай ам хамхилгүй заргалдав. Хариуд нь Үндэсний телевизийн дарга нар хоёр хувь багадна хэмээн үзэлцлээ. Өөрөөр хэлбэл, Үндэсний радио, телевизийн нэвтрүүлгийн нийт цагийн хоёр хувьд нь зар сурталчилгаа явуулах тухай хуулийн төсөл дэх заалтыг өнгө өнгийн тодруулагчаар тэмдэглээд хоорондоо маргаж байна. «Хоёр хувь гэдэг нэг тэрбум төгрөгтэй тэнцэнэ. Үгүй дээ, 600 сая төгрөг болдог юм» гэх маргааныг хэн анхааран сонсч сууна вэ? Үзэгч, сонсогчид. Завшаанаар тэд телевизийн хураамжид сар бүр төлдөг 1100 төгрөгийг юунд үрдэг, мэдээллийн хөтөлбөр дундуур «Урбанек»-ийн бүтээгдэхүүн амаараа дүүрэн чихсэн эрхэм яагаад гараад ирдэг, оройжин «сааралтах» чансаа тааруу нэвтрүүлгүүдийг мянга орчим хүнтэй нүсэр баг бэлтгэдэг тухай, Монголын радио хэмээх шинэ цагийнханд мартагдах шахсан мэдээллийн хэрэгсэл телевизийнхээ нуруун дээр тэгнэж амьдардгийг, өөр олон олон зүйлийн талаар мэдэж авлаа.

Өнгөрсөн ням гаригийн үдэш бүр хачирхалтай үнэнийг олж сонсов. Үндэсний радио, телевизийн уран бүтээлчид Ерөнхийлөгч, УИХ-ын даргад хандан мэдэгдэл гаргаснаа олны сонорт хүргэв. Тухайлбал, Н.Энхбаярт хандан «Бид таны мэдэлд байж, таныг магтан сайшааж, заримдаа таныг шинээр дахин төрүүлдэг байлаа. Бас хааяа таныг «зохион бүтээж» ч байлаа» гэнэ. Анзаарав уу. Хэн нэгнийг үгээр, давталтаар амилуулан уран дүр бүтээдэг ажлаа нуулгүй зарласан хэрэг. Мэдэгдэл гэхээсээ илүү «Ил захидал», «Сэтгэлийн үг» гэсэн давхар гарчиг тээх учиртай байж. УИХ-ын сонгуулийн үеэр, түүнээс өмнөх

дөрвөн жилд, цаана нь сунаих мөн л сонгуульт хугацаант Үндэсний радио, телевиз хэрхэн ажиллаж, үе үеийн улстөрчдийн хиймэл баг урлаж байсныг дээрх зүрхний үг гэрчилнэ. Чухам ийм «авьяасыг» мэргэжлийн стандартаар шүүж шүүрдэх нь ээ гэсэн горьдлого Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төслүүдтэй цуг арваад жил амьдарсан билээ. Харин их хүлээсэн баримт бичгийг ингэс тэгсхийн батлаад, рекламны мөнгө тойруулан элдэв хэрүүл хөврөх цагт бид нэг зүйлийг ор тас мартсан байна.

Үндэсний радио, телевизийг үүсгэн байгуулагч бөгөөд татан буулгах эрх бүхий төр байхад олон нийтийнх боллоо, онцгой статус олголоо гэж зарлахын учир юу юм бэ? Дөчөөд жилийн өмнөхөөсөө юугаараа ялгарах тодотгол юм? Шинэ статусын мөн чанар нь үндэсний хэмжээнд цацагдаж, Монголын нэр нүүрийг төлөөлөх радио, телевизийн нэвтрүүлгийн чанар, стандартыг төр байнга хянах явдал юм шүү. Үүний төлөө л санхүүжилт өгч буй юм гэдгийг яагаад онцлохгүй орхиод байна вэ? Улстөрчдийн гоё дүр төрхийг зохион бүтээхийг тулгах бус, харин олон түмэнд үйлчлэх үүргээ биелүүлж байгаа эсэхэд нь хяналт тавина гэсэн үг. Сургалт, танин мэдэхүй, нийгмийн чиглэлийн чанартай нэвтрүүлэг бэлтгэж, давхарга, төлөөлөл бүрийн хэрэгцээнд үйлчилж байгаа эсэхийг тандахын тулд санхүүжилтийг нь ард түмний халааснаас авч, зөвхөн энэ нүсэр байгууллагад зориулсан хууль гаргаж, араас нь арилжааны телевизүүдийн алхаа гишгээг хянах бас нэг эрх зүйн акт батлахаар зэхсэн хэрэг. Өөрөөр хэлбэл, УИХ телевизийн төсөв батлагч гэх утгаар нь бус, чанар стандартын шаардлага тавигч талаас нь харахаа бид ор тас мартаад байна. Олон нийтийн радио, телевиз болон өөрчлөгдөх их ажил хууль батлагдсанаар л бүтчих амар хялбар зүйл гэж үү? Үнэхээр Н.Энхбаяр, Ц.Элбэгдорж хоёрын хамтарсан хэвлэлийн хурлаас хойш хагас жил өнгөрөх зуур программдаа өөрчлөлт, шинэчлэлийн ямар гараа тавьсан юм бэ? Үндэсний телевизийн сувгийг булаалдан арилжааны телевизийнхэн шинэ сонирхолтой нэвтрүүлгүүд санаачилсаар байгаа цагт шүү дээ. Нээлттэй нийгэм форумгаас эрхлэн өнгөрсөн намраас нийгэм, эдийн засгийн чиглэлээр асуудал дэвшүүлсэн олон сайн нэвтрүүлэг бэлтгэсэн. Өөрийнх нь эфирийн цагт өөрсөдтэй нь өрсөлдөн, илүү гарч чадсан ийм цуврал нэвтрүүлгээс яагаад санаа авдаггүй юм бол. Саяхан мэндэлсэн EBS телевиз шуурхай мэдээллээрээ, TV5 мэдээний багтаамжаараа өнөөх мянган хүнтэй том багийг хол хаясан. Ядаад «25 дугаар суваг»-ийн «Урилга» адил он дамнан үзэгчдийн хүлээдэг хайртай хөтөлбөр ах хүүд юусан билээ? Үе үеийн үзэгчдийн хувьд дурдатгалын гэгээн салхи үлээлэгдэг баярын «Цэнхэр дэлгэц»-ийнх нь чанар хэрхэн хямдарсан билээ.

Төгрөгний нөгөө талыг хараач ээ гэхдээ ийн халаглаж байна. Нүсэр бүтцээ цомхон болгож, шинийг эрэлхийлж санаачлах сэтгэл арилжааны телевизийнхэнтэй харьцуулахад та бүхэнд даанч ядмаг харагдана. Мөнөөх хоёр хувийн сурталчилгааны эрхийн талаар ярихдаа үндэсний нүүр царай болох учиртай тухайгаа байнга сануулах юм. Гэвч олон нийтийн тодотгол зүүхийн наана хамгийн түрүүнд санаа тавих гол асуудал болох чанартай мэдээллээр хангах мэргэжлийн шалгуурын тухай хэн ч юу ч ярихгүйд гайхах юм. Сэтгүүлчдийн цалин бага, тоног төхөөрөмж тааруу гэх тайлбарыг давтах биз. «Долоо хоног» тоймчийн хөтөлбөр бэлтгэхийн тулд дааж давшгүй зардал гардаг гэж бүү шалтаг тоочоорой. Энэ хөтөлбөр Үндэсний телевизийн нүүр царай болж явдгийг бултаараа мэднэ. Амралтын үдэш сэтгүүлч Оюунчимэгийн бэлтгэсэн хагас цагт үзэгчид олон сайн мэдээлэл авч, түүний эргэн тойронд хийсэн задлан шинжилгээг сонсдог. Хэрэв энэ бүсгүй ээлж өнжвөл мөнөөх тоймчийн цаг нь мунгинасан хөтөлбөр болж хувирах энүүхэнд. Тэгэхээр энд эхний ээлжинд ур чадварын бэрхшээл байгаа бус уу.

Эрхэм уран бүтээлчид ээ, хоёр хувийн сурталчилгаа тойрсон мөнгөний хэрүүл үзэгч, сонсогчдын анхаарлыг өнөөдөр нэг их татахгүй л болов уу. Учир нь эфирийн нийт цагийнхаа долоон хувьтай тэнцэх реклам цацаад, төсвөөс санхүүжилт аваад ч Үндэсний телевиз өнөө цагийн үзэгчдийн сэтгэлд үлдэж чадаагүй юм. Энэ явдал хэдэн уран бүтээлчийн хоорондын таагүй харилцаанаас үүдсэн маргаан бус. Монголын телевиз, радиогийн сэтгүүлзүйн чансааг дагасан хэрэглэгчдийн бухимдал. NHK, BBC Шведийн үндэсний телевиз, ОРТ-ийг рекламны хоёр хувийн жишээгээ ярихдаа та бүхэн заавал дурддаг. Харин тэдний нэвтрүүлгийн чансаа, сэтгүүлчдийнх нь хурд, эрч хүч, эр зоригийн тухайд аль аль телевизийнхэн ор тас мартчихаад байна. Үнэндээ Үндэсний радио, телевиз хэмээх том байр ямар харьяалалтай байх нь хураамжаа өгч суугаа үзэгч, сонсогчид сонин биш. Гагцхүү хиймэл дүр зохион бүтээгчид бус, мэргэжлийн баг мэдээлэл хүртэх, танин мэдэх, амран зугаацах хэрэгцээг нь найдвартай хангаж байгаасай гэж олон нийт хүсч байгаа. Ерөнхийлөгчид хандсан шиг «амь тариатай» нь үлдээх нь зөв үү? Эсвэл илт давуу нөхцөл байдал дунд ч арилжааны телевизийнхнээс хол хоцорсон хөшүүн бүтцийг эрс өөрчилмөөр юм уу? Хоёр хувь тойрсон маргааны сүүдэрт мартагдсан өнцгийг шүүрдэж хармаар байна.

2005 он



# Олон нийтийн радио, телевиз ХЭМЭЭХ ҮЛГЭР ОРШВОЙ

«Дөт» дэлгүүр сонголт сайтай, танд ойрхон... Дэлхийд алдартай **Hartford-ийн салбар сургууль нээгдлээ**» «Цагийн хүрд» хөтөлбөрийн дундуур ийм мэдээлэл улайм цайм цацагдах болов. Цаг агаарын мэдээллийн өмнө тогтмол явдаг сурталчилгааг энд дурдаагүй юм шүү. Монголын үндэсний телевизийн уран бүтээлчдийн хувьд өдгөө ойлгомжгүй байдал бий болж, чухам ямар статус, санхүүжилттэй байгууллагад ажиллаж буйгаа хэлж мэдэхгүй сууна. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль удахгүй хэрэгжиж эхлэх учиртайг үзэгчид мэднэ. Харин хууль хүчин төгөлдөр мөрдөгдөхийн өмнөхөн энд чухам юу өөрчлөгдөж, ямар нааштай ахиц дэвшил хөтөлбөрт нь орсныг хэн ч хэлж чадахгүй. Тус телевизийн хувьд арилжааны шинж чанартай мэдээллийг эрээ цээргүй цацах явдал л сүүлийн үед ийн хавтгайрчээ. 38 нас сүүдэр зооглох хүндэтгэлт ойнхоо өмнө Монголын үндэсний телевиз арилжааны бусад сувгаас ялгарах зүйлгүй харагдана. Ийм саармагжилт, программын чанар улам унаж буй шалтгаан Олон нийтийн радио, телевизийн тухай хууль өөрөө болсон нь хачирхалтай.

Арваад жилийн турш ярьж, нийгэм хүсэн хүлээж, халуун мэтгэлцээний дүнд өлгийдөн авсан хуульд буруу өгөхийн учир юу вэ? Монголын сэтгүүл зүйн түүхэнд анх удаа хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн зохицуулалттай болж, эх сурвалжаа сэтгүүлч нууцлах эрхийг ханган баталгаажуулсан, үзэл баримтлалын тухайд өөлөх баалах зүйлгүй хуультай болсон билээ. Хэвлэлийн хүрээлэнгээс энэ оны тавдугаар сард явуулсан судалгаанд оролцогсдын олонх нь ОНРТ-ийн тухай хууль батлагдсан нь чухал үйл явдал хэмээн хариулж байлаа. Хууль хэрэгжиж эхэлснээр Үндэсний радио, телевизийн нэвтрүүлэг хэрхэн өөрчлөгдөх бол гэсэн асуултад мөн л олонх нь «Сайжирна, эрс сайжирна» хэмээн хариулжээ. Ийм итгэлээр угтан авсан эрх зүйн чухал баримт бичиг бидний амьдралд ямар өөрчлөлт, гэрэл гэгээ авчирсныг ойлгоход бэрх байна. Нэвтрүүлгийн чансаа улам унаж, мөнгө төлбөр илт ханхалж эхэллээ. 1100 төгрөгний хураамжийг үзэгчид юунд зориулан өгч буй хэрэг вэ?

## ХУУЛИЙН ЦООРХОЙ

Өнгөрсөн жилийн яг өдийд Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, УИХ-ын дарга асан Н.Энхбаяр нар хэвлэлийн хурал зарлаж телевиз, радиог олон нийтэд өгөхөө мэдэгдсэн түүхтэй. Ганц жилийн өмнөх явдал атал түүх болон тэмдэглэгдэхийн учир нь энэ хууль дарангуйллын сүүлчийн цайзад мэдээллийн эрх чөлөө, олон урьгалч үзлийн агаар салхи нэвтрүүлэх ёстой байлаа. Төдийгөөс өдий хүртэл өрнөсөн үйл явдлын хэлхээсийг нурших нь илүүц биз. Маргаан мэтгэлцээн дунд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль мэндэлсэн. Гэвч ерөнхийдөө сайн хэмээн үнэлсэн нөгөө хуулийнхаа онгорхой цоорхойгоор одоо бид Үндэсний арилжааны шинэ суваг үзэж сууна биш үү? Олон нийтийн радио, телевизийн удирдах байгууллага болох Үндэсний зөвлөлийн 15 гишүүнийг сонгох тухай заалтад хамгийн том цоорхой бий. 180 орчим төрийн бус байгууллагыг төлөөлсөн, нийгмийн салаа мөчир бүрийн дуу хоолойг илэрхийлэх эрхмүүд нэр дэвшүүлэх Их чуулганд оролцсон юм.

**Олон  
нийтийн радио,  
телевизийн үйл  
ажиллагааг  
удирдах 15 хүний  
сонголт гэдэг  
зүгээр сайн  
дурын уран  
сайхан биш атал  
саарал ордон  
хавиар сайн  
дурын нэр  
дэвшүүлэлт  
болоод өнгөрчээ.**

Улсын бүртгэлд данс бүхий 4000 төрийн бус байгууллагыг 180 нь бүрэн төлөөлж чадахгүй гэсэн шүүмжлэл тухайн үед сонсогдож байлаа. Гэвч чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийнхэн өөр бодолтой байсан юм. Иргэний нийгмийн төлөөлөлд хуулиар олдож буй энэ алтан боломжийг идэвхтэй ашиглахыг Ажлын хэсэг уриалан, удаа дараа зар түгээсэн. Ингэснээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 180 байгууллагын хүрээнд чуулган болжээ. «Төрийн бус байгууллагынхны санаачлага, эрмэлзэл энэ тохиолдолд хамгаас чухал байлаа» гэж ажлын хэсгийнхэн тэмдэглэсэн юм. ТББ-ынхны удаа дараагийн уулзалт, улмаар чуулганы дүнд нийт 34 хүний нэрийг дэвшүүлжээ. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 15 гишүүнд өрсөлдөх 34 хүний нэрийг тодруулсан гэсэн үг. Яагаад ийм «нөөцтэй» сонголт санал болгосон хэрэг вэ? Хуульд орсон нэр дэвшүүлэлтийн тухай ерөнхий заалтаас үүдэлтэй. Шууд тулгасан 15 эрхмийн нэрийг бус харин УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч гэсэн төрийн гурван өндөрлөгт дахин шигшин шүүх бололцоо олгон сонголтын «запас» үлдээжээ. Чухам энэ арвин сонголт болоод бие даагчдын талаар Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өгөөмөр хандсан үг өгүүлбэр орсноо цоорхой үүссэнийг өнөөдөр бид харж сууна. Хэрэв УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын таалалд нийцэх гэж бие даагчид «тэрүүгээрээ» нэр дэвшүүлж болох л байсан юм бол төрийн бус байгууллагынхан баахан шат дараалсан шалгаруулалт хийхийн утга учир юунд байв? Илүү зохион байгуулалт дундаас шалгаруулсан болохоор Үндэсний зөвлөлд багтчих магадлал өндөр хэмээн олон хүн Ажлын хэсэгт хүсэлтээ гаргасан тал бий. Тэдгээрийн тухай мэдээлэл хэвлэлээр байнга цацагдаж байлаа.

Харин бие даагчдын талаар бид юу мэдсэн билээ? Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг удирдах 15 хүний сонголт гэдэг зүгээр сайн дурын уран сайхан биш атал саарал ордон хавиар сайн дурын нэр дэвшүүлэлт болоод өнгөрчээ. Энэ тухай мэдээллийг, тухайлбал Ерөнхийлөгчийн Тамгын газарт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, УИХ-ын Тамгын газарт хэдэн хүн өргөдөл хүсэлтээ бие даан илгээснийг олон нийтэд мэдээлэн зарласан зүйл үгүй. Ийм холион бантан дунд Удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэлт өрнөж буйг гадаадын байгууллагын ажиглагчид хэлж сануулж байлаа. Олон нийтийн радио, телевизийн Удирдах зөвлөлд санал болгох хүмүүсээ ТББ-ууд нь хуульд заасан тоонд тулган шууд санал болгодог өөрсдийн туршлагыг тэд өгүүлжээ. Бие даагчид гэсэн ойлголт тэдэнд хачирхалтай санагдсан биз.

УИХ-ын хаврын чуулган завсарлахаас наана Удирдах зөвлөлийн гишүүдийг хэлэлцэн баталчих санаатай хэн хэн нь аль аль талдаа хичээснийг тэмдэглэе. Төрийн бус байгууллагынхан хэдий хэл ам ихтэй ч хурлаа хийгээд, 34 хүний нэрийг долдугаар сарын 2-ны өдөр Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-д хүргүүлсэн. Ерөнхийлөгчийн ажлын алба ч шуурхайлах учиртайг ойлгон, хуульд заасан дөрвөн хүний сонголтоо УИХ-ын чуулганд өргөн барихаар хамгийн түрүүнд зарлажээ. Харин Ерөнхий сайд, УИХ-ын зүгээс яагаад ч юм таг чиг болчихов. Хуулийн цоорхойгоор шургачиж зүтгэх бие даан нэр дэвшигчдийн лобби гацаа үүсгэсэн хэмээн таамаглаж байна.

## САНААЧЛАГЧИЙН ХАНДЛАГА

Хууль батлагдсаны дараа буюу энэ оны нэгдүгээр сард УИХ-аас дагалдах тогтоол гаргасан. Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаа жигдэртэл туслан дэмжих үүргийг уг тогтоолын дагуу Засгийн газар хүлээжээ. Радио, телевизийн Хэрэг эрхлэх газар үе үеийн Засгийн газрын харьяа агентлагт багтаж ирсний эцэст өөрчлөгдөх хүртэл нь халамжлах үүргийг ногдуулсан биз. Мэдээллийн эрх чөлөөний тухай хамгийн их ярьдаг Ерөнхий сайд маань

«Цахим Монгол» хөтөлбөрөөсөө дутуугүй Олон нийтийн радио, телевизийг өлгийд нь халамжилна хэмээн иргэд ч итгэсэн юм. Өнгөрсөн хугацаанд Үндэсний радио, телевизийн эзэмшлийн 14.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг тоолж тогтоон, улмаар 8.7 тэрбумыг нь улсын үйлдвэрийн газарт шилжүүлэх ажлыг Төрийн өмчийн хороо гүйцэтгэв. Өөрөөр засаг санаа тавьсан, тусалж чиглүүлсэн зүйл ажиглагдсангүй. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга л шаварт унасан шарын эзний хувиар жаал гүйж, заавар зөвлөгөө өгч харагдав.

Үндэсний зөвлөлд УИХ долоо, Засгийн газар дөрвөн хүний нэрийг санал болгох учиртай. Ерөнхийлөгчөөс бусад нь нэр дэвшүүлэлтэд яарч санаа тавьсан зүйлгүй. Ийм айвуу тайвуу өдрүүдийн ард телевиз, радиогийн үйл ажиллагаа доголдож эхлэв. 2006 оны нэгдүгээр сарын 1-нээс нийт нэвтрүүлгийн цагийнхаа хоёр хувьд сурталчилгаа цацах тухай заалт уран бүтээлчдийг мөнгөний хойноос яаруухан хөдөлгөжээ. Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн өөр нэг судалгаанд анхаарал хандуулаарай. Таван телевизийн програмд хийсэн ажиглалтаар мэдээллийн хөтөлбөрийн багтаамжаар TV 5 тэргүүлж, арилжааны нэвтрүүлгийн хувиар Үндэсний телевиз толгой цохив. Эдүгээ эрх зүйн хувьд ойлгомжгүй Радио, телевизийн хэрэг эрхлэх газар удирдан чиглүүлэх үүргээ биелүүлсээр байна. Үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйг нь үзэгчид программын чансаанаас харьцуулан харж байгаа биз ээ.

Энэ бүхний эцэст Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг хүлээсэн иргэдийн итгэл, эфирийн эрс өөрчлөлтийг хүссэн үзэгчдийн найдлага бөхсөн нь хамгийн том гарз. «20 минутын нэвтрүүлгийг 800.000-аас нэг сая төгрөгөөр бэлтгэнэ» Үндэсний телевиз арилжааны сувгуудтай өрсөлдөн ийм өндөр ханш зарлаж байна. Ерөнхийлөгчийн сонгуулийн дуулианд бүдгэрч, энэ зуны улстөржсөн олон үйл явдлын тоосонд дарагдсан хууль эфирийн цагийн ханшийг хазаарлаж дийлэхээ больжээ. Намрын чуулганаар хэлэлцэх асуудлын хаахна өнөө хэдэн нэрс хавчуулагдах бол? Олон нийтийн гэх ор нэр хаягтай яваа нүсэр байгууллагыг удирдах ажил хэрэгч Үндэсний зөвлөл үгүйлэгдэж байна. Хараат бус байх учиртай Үндэсний зөвлөл нь хуулийн цоорхойгоор мөн л бохирдож эхлэх магадлалтай болсныг сануулья. Иргэний нийгэм үүргээ биелүүлж сонголтоо хийсэн, ард олон итгэл тавин дэмжсэн билээ. Харин энэ хуулийн мөн чанар гүйцэтгэх засаглал, хууль тогтоогчдын гарын салаа дунд бүдгэрч, улстөрждөг бас нэг байгууллага мэндлэх магадлалтай болов.

2005 он

# Украины талцал Улаанбаатарт халдварлахаас өмнө

Улбар шарууд цэнхрүүдийн эсрэг жагсч эхлэхийн өмнөхөн Украинд нөхцөл байдал нэг иймэрхүү өнгө аястай байв. Тэндхийн радио, телевиз, сонин хэвлэлүүдийг улс төр, бизнесийн бүлэглэлүүд нь хуваан авч гартаа оруулжээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх Украин болоод Улаанбаатарт өрнөж буй үйл явц тун төстэй гэж Рагислав Кюжел ярьж байна. Тэрбээр зүүн Европын хэд хэдэн улсад болсон сонгуулийн явцад мэдээллийн мониторинг хийсэн туршлагатай нэгэн. Өнөөдөр Монгол оронд өрнөж байгаа улс төрийн үйл явдлууд, Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүмүүсийн нэрсийг тандан амьсгаа дарсан зовиуртай хүлээлт, нам дагасан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн талцал нэг л ичгүүргүй тулаан эхлэх дохиог чимээлсээр. МАХН-ын талыг баримжаалсан бас нэг хэвлэл юу юугүй мэндлэх гэнэ. Өдөр тутмын сонин зах зээл дээр өрсөлдөгчдийн тоог зургаа болгон олшруулах хэрэгцээ юу байв? Лав уншигчдын эрэлт, мэдээллийн орон зайн захиалга энд үйлчлээгүй. Өөрөөр хэлбэл, тулааны өмнө намууд мэдээллийн хэрэгсэл гэх цагаан нэр дор сурталчилгааны бараан зэвсгээ дахин байршуулж, цэнэглэж эхэллээ.

Өдөр тутмын сонин, телевизийн суваг хоёрт голлон түшиглэсэн хэвлэл мэдээллийн групп үүсгэн байгуулахын чухлыг онцгой мэдэрсэн цаг үе хэмээн Монголын сэтгүүлзүйн түүхэнд энэ өдрүүд тэмдэглэгдэнэ. Харамсалтай нь мэдээллийн анхны группийн гаргасан зам мөр, баримталсан зарчмаас шинэхэн бүлэглэлүүд өөр чиг барин хазайчих аюул мэдрэгдсэн байна.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн «уяа сойлгыг» тааруулахаар намууд зэхэхэд хэвлэлийнхэн хажууд нь бас ханцуй шамлан зогсох нь гачлантай. Яг ийм үед Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн II их хурал хуралдав. 100 гаруй сэтгүүлчийг Нүхтэд цуглуулж, бүтэн өдөр чуулахын учир юу байв? II хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын дунд сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчмын төслийг батлах ажил багтжээ. Ингээд арван зүйлтэй зарчмыг албан ёсны чиг шугамаа, мэргэжлийн Үндсэн хуулиа болгон мөрдөхөөр бүгдээрээ гар өргөлөө. Ийм явдал болсонд УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар олзуурхан баярлаж, албаны хүмүүсээ томилон илгээлт-мэндчилгээ дэвшүүлэв. Гэхдээ тэдгээр мэндчилгээ нь «Одоо ёс зүйгээ сахиарай даа» гэх сануулга лугаа сонсогдоно. Бид аливаа соёлт улсын сэтгүүлчдийн адил ёс зүйн ерөнхий, үндсэн кодтой болсондоо мэдээж баяртай байна. Бас тэрхүү арван зүйл ерөнхийдөө бэлгэ тэмдгийн шинж чанартай бүгдээрээ гадарласхийн сууцгаалаа. Хэвлэлийн редакц бүр өөрийн гэсэн ёс зүйн илүү тодорхой дүрэм журамтай, түүнийг чандлан сахиулах хяналт нь хажууханд, эс сахивал хүлээх хариуцлага мөн л байгууллагын дотоод дүрэм журам ёсоор зохицуулагдах нь хамаагүй үр нөлөөтэйг сэтгүүлчид ойлгож байна. Гэвч «оргүй бус, охинтой» болгосон энэ арван зарчим санаа авах үндсэн баримтлал маань юм аа гэдэг угтаараа ач холбогдолтой.

Одоо асуудлын нөгөө өнцгийг харъя. «Улаанбаатар» сонин эрхлэгч Ү.Хүрэлбаатар II чуулган дээр «Тэгээд зарчмаа барьж ажиллаж буй эсэхийг хэн хянах вэ?» гэж асуусан юм. Энэхүү асуулт МСНЭ-ийн гишүүдийн, Монголын нийт сэтгүүлчдийн цаг алдалгүй анхаарал хандуулах учиртай «проблем» нь байлаа. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчид хариуцлагынхаа тухай нягт

нямбай ярихын хамт эрх ашиг, аюулгүй байдлаа давхар бататгах цаг ирэв. Мэргэжлийн алдаа гаргасан эсэхийг маань хэн тогтоох юм бэ? Өнөөдрийн туршлагаар, сэтгүүлзүйн тэнхмийн ганц багшийн том дүгнэлтээр үү, эсвэл шүүгчдийн үг эцсийнх болох уу? Аль ч тохиолдолд асуудлыг бодитой шийдэж чадаагүйг бид ам амандаа ярьсаар суух уу? Хэрэв сэтгүүлчид ёс зүйн зарчимтай болсон юм бол түүнээ чандлан мөрдөж буй эсэхийг нягтлах мэргэжлийн цэц лугаа Хэвлэлийн консул үгүйлэгдэнэ. Түүнийг нэн даруй бий болгохгүй аваас улс төрийн ичгүүр сонжуургүй тулаан дунд ёс зүйг умартсан нь хожиж, үнэнийг өгүүлэх гэсэн нь дарамт шахалт дор амьдарсаар байх юм. Улс төр хөл толгой, эх захаа олохоо байсан ийм үед мэргэжлийн, дайчин сэтгүүлзүйн захиалга нийгэмд дэндүү эрэлттэй болжээ. Үүнийг дагаад сайн сэтгүүлзүйг сурталчилгааны зэвсгээс ялгаж салгах Консул ус, агаар адил үгүйлэгдэж байна. Түүнийг шүүх ч, ганц нэг шинжээч ч орлож чадахгүй. Шинжээчдийн дүгнэлтийг шүүхэд танилцуулсан бараг анхны тохиолдол нь «Ардын эрх» сонины нэрийг дахин ашигласантай холбоотой 1999 оны нэхэмжлэл байж мэднэ. Дээрх тохиолдолд Их сургуулийн Сэтгүүлзүйн тэнхмийн хэд хэдэн багш оролцсон баг шинжээчээр ажилласан юм. Тэгвэл сүүлийн үед ганц хүний дүгнэлт үзэмжид шүүхийн шийдвэр тулгуурлах хандлага гарч буй нь туйлын үнэнд эргэлзэх эргэлзээг хар аяндаа бий болгов. Хэвлэлийн консулыг зайлшгүй бий болгох, түүний нэр хүнд, бие даасан байдлыг өндөр болгон бойжуулахад МСНЭ хэмээх байгууллага онцгой үүрэгтэй. Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн хүчирхэг байр суурийг дагаад, түүгээр дамжуулан Консулын бүтцэд өргөдөл гомдол хүргүүлэх, гаргасан шийдвэрийг нь хүлээн зөвшөөрөх, хүндэтгэн дагах харилцаа үнэтэй цайтай болно.

Энгэр ээвэр газрын цас хайлмагтсан өнгөрсөн долоо хоногийн эцсээр Монголын сэтгүүлчдийн нэг хэсэг чуулж шинэ удирдлагаа сонгосон цаг үеийн онцлог ийм. Украины хэвлэлийнхэн шиг талцаж, улстөрчдийг аялдан дагах вий гэсэн болгоомжлолыг үгүйсгэсэн сонголт хийсний учир ч ийм. Бусад телевизээс харьцангуй бие даасан байр суурьтай ТВ-5-ийн захирал ээдрээтэй мөчид Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийг толгойлно. Түүний хараат бус, дайчин байр суурь нь ахуй амьжиргаанаасаа илүү аюулгүй байдалдаа санаа зовних болсон өнөөгийн сэтгүүлчдэд чухал байсных биз. Өдөр тутмын сонинуудын ноён нуруу, туйлширч ханараагүй дуу хоолойн индэр болдог «Өнөөдөр»-ийн нэгдүгээр орлогч эрхлэгчийг дэд ерөнхийлөгчөөр сонгосон шалтгаан ч мөн адил.

Иргэний нийгэм дуугаа хурааж, хөмсөг зангидсан хачин чимээгүй өдрүүд үргэлжилсээр. Орон зай дээр нь ногоон шар тууз дэрвүүлсэн хийрхүү жагсаал үе үе үзэгдэх эмх замбараагүй байдлын эвгүй хүлээлтийг мэдэрсээр. Тэгвэл МСНЭ манай нийгэмд хамгийн хүчтэй дуу хоолойтой, нэр нөлөөтэй төрийн бус байгууллага болох мөч хаяанд ирээд буй мэт санагдана. Үүний тулд энд тэндээс санхүүжилт горьдон санаа алдах учиргүй. Сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалан дуугарахад мөнгө төгрөгний хэрэгцээ үгүй юм. Харин мөнгө сарвайсан, ивээн тэтгэсэн гар эргээд мэх дагуулж мэднэ. Эрх ашгийг нь хамгаалсан анхны алхмын цаанаас, МСНЭ-ийн аливаа шинэлэг үйл ажиллагааны араас мэргэжил нэгтнүүдийн дэмжлэг түрэн ирнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Гагцхүү гишүүнчлэлээ нэн даруй тодруулж, татварын хэмжээг өнөөгийнхөөс нэмж, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагуудын хүрээнд төдийгүй сурвалжлагч болгондоо хүрч амьд ажиллахыг хүссэн хүлээлт бугшжээ.

**Үүнийг дагаад сайн сэтгүүлзүйг сурталчилгааны зэвсгээс ялгаж салгах Консул ус, агаар адил үгүйлэгдэж байна. Түүнийг шүүх ч, ганц нэг шинжээч ч орлож чадахгүй.**



## «Өнөөдөр»-ийн мянганы буухиа 3000 дахь өртөөндөө үдлэв



Фотог Г.Эрдэнэтуяа

Гурван мянган шинэ өглөө «Өнөөдөр» таны аяга цайг сонин хачнаар амталж, мэдээллийн зүг чиггүй уудам орон зайд залан хөтөлжээ. Мянга мянгаар багцлан он цагийг баримжаалах нь энд хялбар сонсогдох боловч тэрхүү цаг хугацааны тоосонд хутгалдаж, түмэн үйл явдлын дунд амьдрах нь уртаас урт түүхийг хэлхэж, зузаанаас зузаан дурсамж үлдээх аж.

Эхний мянган дугаараас маань энэ цагийн гол баатруудын идэрхэн дүр төрх үзэгдэх вий. Хар цагаан дэвсгэр дээр монголчуудын зах зээлд суралцсан,



эрх чөлөөндөө аахилсан шинэ түүхийн эхний мөрүүд хоцорчээ. Намуудын улаан, цэнхэр далбааны өнгө будаг гандаагүй байлаа. Өнөөгийнх шиг мөнгөөр бус, үзэл бодлоор талцсан өдрүүдийн тухай «Өнөөдөр» тэрлэжээ. Эдүгээ энгийн санагдах явдлууд тэр үеийн «эвэртэй туулай» байсаан.

Харин хоёр дахь мянганы гараанд сонин, уншигч хоёр сонголтын өмнө зогтссан билээ. Монголын хэвлэлийн зах зээлд өрсөлдөөн хүчээ авч, өнөөх үгэнд оромтгой уншигч минь өөр хандлага, үзэл бодлыг дэмжээд талийв. Нөгөө талд сөрөг байр суурь хурц өнгө хаяж, хажуухнаас фэнүүд маань босоод явчихсан санагдана. Намууд салж нийлэн, том объектуудын хувьчлал үндэсний бэл бэнчинтнүүдийг төрүүлж, баруун солгой талд тасраад хуваагдчихлаа. Туйлшралын «гэгээн» дурсамж чухам энэхэн зааг үед хамаатай. Талууд хэвлэлээр зэвсэглэдэг моод үнэртэж эхэллээ. Гэвч «Өнөөдөр» сонин цаг зуурын моодонд автаагүйг мэргэн уншигч, үнэнч фэнүүд маань гэрчилнэ.

Гурав дахь мянганы «Өнөөдөр»-ийг бэлтгэх гараан дээр улс төр, бизнесийнхны сүлбээ ужигран илжирч эхэллээ. Чухам энэ өдрүүдэд иргэний нийгэм эрүүл агаар үлээлгэж, «Өнөөдөр»-ийн хүртээмжтэй талбар дээр тэдний дуу хоолой тэнцвэржин сонсогдсон юм. Бид уншигч танд 3000 дахь дугаараа тэрлэн түгээсэн нь энэ. Энд үйл явдал 1000 болоод 2000 дахь өдрүүдийнхээс маань тэс өөрөөр буужээ. Уншигч хэрсүүжин, иргэнлиг сэтгүүл зүйг үнэлэх болж. Бид ч тэдний захиалгаар өөрчлөгдөн, шинэ сэтгүүл зүйн үнэт зүйлсийг уриагаа нэгэнт болгосон. Гэхдээ аль ч жилийн сонин үдээснээс «Өнөөдөр»-ийг сугалан гарчиглахуй мэдээллийн тэнцвэрийг эрэлхийлж, эгэл энгийн хүмүүст тал өгч, зөрчил хямралаас гарах гарц хайн, асуудал бэрхшээлийн гүнд ханцуй шамлан зогссон сурвалжлага, нийтлэл, ярилцлага, мэдээ зонхилжээ. Үйл явдлын хүндийн төвд ийн туйлбартай зогсч чадсаны учир, дэлхийн сэтгүүл зүйн шалгуур үнэлэмжид дөхөх гэж тасралтгүй эрмэлзэн тэмүүлсний учир «Өнөөдөр»-ийн мянганы буухиа улам улмаар эрчлэн хүчээ авч явна.

2007 он



# ГАРЧИГ

## III БҮЛЭГ

### СЭТГҮҮЛ ЗҮЙ

1. Америкт «хулгай» хийж явна .....	254
2. Арван жилийн өнгө үйл явдлын дэлгэц дээр .....	257
3. А.М болон Р.М уулзалтууд.....	260
4. Ерөнхий сайдууд ба мэдээлэл.....	262
5. Хэвлэлийн төлөөлөгч, сурвалжлагч хоёр ямар ялгаатай вэ?.....	265
6. Амны алчуур ямар үнэтэй вэ?.....	268
7. Байцаагч түшмэл.....	269
8. Мэдээлэлгүй монголчууд маскаа тайлаад шидчихэв.....	272
9. Золбин факсыг тайлбарлах хэвлэлийн хурлаа яасан бэ?.....	274
10. Эхний өгүүлбэрээ эрж шаналахын амтат зовлонг оюутнууд мэдэрсэн.....	277
11. Сайдыг хэн шүүмжлэх вэ?.....	282
12. «Eagle» үгүй өдрүүдэд.....	286
13. Төлбөртэй нийглэв.....	289
14. Урт настай хууль, удтал хүлээлгэх журам.....	292
15. Хэний өмч вэ, олон нийтийнх.....	295
16. Зохион бүтээгчид халаас тэмтрэх цагаар.....	298
17. Олон нийтийн радио, телевиз хэмээх үлгэр оршвой.....	301
18. Украины талцал Улаанбаатарт халдварлахаас өмнө.....	304
19. «Өнөөдөр» 3000 дахь өртөөндөө үдэллээ.....	306

# IV Улс төр Д V бүлэг



Фотог Е.Доррээн

«Гранд Фокс Хералд»-ын редакци, 2002 он

## Редакцийн зурвас


Том материалыг би үзэж чаддаггүй. А2 хэмээх далбагар том, нүүр дүүрэн цэцэрхсэн ганц материал унших хүсэл, цаг зав шинэ цагийн уншигчид бий гэж үү?

Үргэлж яарч буйгаа мэдэрдэг. «Нөгөө хурдан явдаг эгч байна» гэж оператор Бат-Эрдэнийн шар хүү нэг удаа хэлж билээ. Энэ цагийн уншигч миний л ижил. Тэднийг залхаах үүргийг сэтгүүлчид хүлээгээгүй. Материалын маань хэмжээ улам багасч буйг анзаардаг. Баримт эрж хайх хөдөлмөр харин өмнөх жилүүдийнхээсээ өөрчлөгдөөгүй. «Тоймчийн зурвас» хэмээх энэ төрөлд сурвалжлагчид хүчээ сориод үзэхэд гэмгүй. Уйдамхай уншигч өөр шинэ, халуун баримт сонирхож байхад чи сонины ганц баганын хэмжээтэй багахан зайд л «цэцэрхвэл» яасан юм. Гэхдээ тэр давчуухан талбайд үндэслэл бүхий баримт, ажиглалт харьцуулалт, шинэ санаа, таамаглал, дүгнэлт бүгд

багтсан байвал зүгээрсэн.

«Өнөөдөр» сонины «Тоймчийн зурвас» буланг «төрүүлэхийг» Ерөнхий эрхлэгч тушаасан билээ. Хоёрдугаар нүүрний баруун захын буланд тэр нь байрлах, гэрэл зураг болоод албан тушаалтай нь тоймчийг танилцуулна гэж хэлээд тэр гарч одсон. 2001 он байлаа. Аль нэг асуудлаар сонин өөрийн байр сууриа илэрхийлдэг ийм булан өдгөө Монголын хэвлэлүүдэд шинэ зүйл биш болжээ.

Тоймчийн зурвас маань эдүгээ «Editorial» нэртэйгээр эхний нүүрэнд байраа эзэлжээ. Цаашид ч улам боловсронгуй болгох учиртай эд.



# Ерөнхий сайд Путин

(Editorial)

Владимир Путиний нарт хорвоод мэндэлсэн өдрийг оросууд онцгой баярлан тэмдэглэв. Энэ эрхмийн нэр хүнд дэндүү өндрөө авчээ. Зөвхөн уудам Орос оронд Владимир Владимировичийг авгайлан хүндэтгэж байна гэж санана уу?

Гярхай харцтай, шаламгай алхаатай, чимээгүй увьдастай Ерөнхийлөгч Путинд хаягласан цэцгийн баглаа, ялалтын хундаганаас америкчууд хүртэл асар болгоомжилж эхэллээ. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж асан улсуудын удирдагч нарын уулзалт дээр нөгөө «ичимхий» хочит Путин өөртөө ямар итгэлтэй харагдав аа. Хятадтай улам ойртон түншлэх нь тодорхой. Бүр Орос-Хятадын НАТО маягийн бүтэц байгуулах гэнэ. Айсан америкчууд Умард Солонгосын асуудлаарх зургаан талын хэлэлцээрт зөөлөн чихэр ганцыг халаасалж орохоор шийдэв бололтой.

Дэлхийн зах зээл дээр байгалийн хий болоод нефтийн үнэ хадах тусам Ерөнхийлөгч Путиний ажигч харц улам гялалзах мэт. Аймаар ч юм шиг. Түүний нэр нөлөө дэлхий дахинаа гэрлийн хурдаар өсч байна. Энэ эрхэм ОХУ-ын Засгийн газрын ирээдүйн тэргүүн гэдгээ нэн ойлгомжтой зарлаж орхилоо. Путиний засаглал лав ирэх таван жилд өнөөгийн бодлогоо үргэлжлүүлэх нь. «Нэгдсэн Орос» намын их хурал өнгөрсөн даваа гаригт Москвад болж, Ерөнхийлөгч айсуу сонгуульд тус намаас нэр дэвших хүмүүсийн жагсаалтыг тэргүүлэхээ амлалаа. Энэ мэдэгдлийн дараа «Думийн сонгууль сонгууль биш болох нь. Намууд «Нэгдсэн Орос»-той биш Путиний нэр хүндтэй өрсөлдөх нь. Дэндүү тэнцвэргүй өрсөлдөөний дүнг одоо урьдчилаад хэлчихсэн ч болно» гэх шуугиан гурвалсан морьд лугаа довтолгон, Оросын уудам нутгаар цагаахан хусны навчсыг чичигнүүлэн тархлаа.

«Нэгдсэн Орос» намын Думийн сонгуулийн өмнөх их хурлын уур амьсгал МАХН-ын XXV их хурлын өнгө амьсгаатай нэг л төсөөтэй, нөгөөтэйгүүр ялгаатай. Орос оронд өдгөө өрнөж буй улс төрийн үйл явдлууд Монголын амьдралын өнгөрсөн ба ирээдүйг тольдоод байх шиг. Намбарын Энхбаярын нэр хүнд нэгэн цагт хэрхэн хөөрч одсоныг, хойноос нь хөөцөлдсөн боловч тэр том бөмбөлөг бүр дээшээ нисэн холдсоныг харьцуулбал одоо В. Путинд «Битгий энийг давтаарай, за юу» гэж захьмаар санагдана. Харин В. Путин арай өөр хүн юм. «Нэгдсэн Орос» намын их хурал дээр тэрбээр улс төр, бизнес хоёрыг хослуулах нь явуургүй гэж зарим хүнд захиж хэлжээ. Уг ишлэлийг хамгийн түрүүнд тэрбумтан Сулеймен Керимов өөртөө «наалдуулж» ойлгосон гэх. Ноён Керимов нэр дэвшигчдийн жагсаалтаас хасагджээ. Өдгөө эрх баригч намд данстай олон олигарх Думийн сонгуульд өрсөлдөгчдийн марафоноос хасагдан, улмаар дунд зэргийн хөрөнгө чинээтэй шинэ цагийн менежерүүдийн нэр уг жагсаалтад түлхүү шингэсэн байна.

Тэгэхээр Путин олигархуудтай үргэлжлүүлэн байлдах магадгүй. Бас өөрийгөө баастай бурхан болгохгүй байх харьцангуй цэвэр ёс суртахуун энэ хүнд үлдсэн бололтой. Харин монголчуудаас ялгаатай нь оросууд сөрөг хүчингүй амьдарч байна. Арванхоёрдугаар сарын 2-нд болох Төрийн думийн сонгуулийн дүнд «Нэгдсэн Орос» ойролцоогоор 65 хувийн санал авч үнэмлэхүй ялалт байгуулах тухай таамаглал бий. ОХУ-ын Ерөнхийлөгч өөрөө энэ намыг

рекламдаж байхад өөр үр дүн хүлээгээд ч яах билээ. Дээр нь Төрийн зөвлөлийн дарга С.Мионовын тэргүүлдэг «Шударга Орос» нам хэдхэн санал, баруунтнууд жаахан халбагадаад, коммунистууд авч сурсан арваад хувиа нэмээд, «Яблоко»-д юу л үлдээ аж, гэхдээ цөөхөн саналтай хоцрох урьдчилсан дүнг өнөөдөр зоригтой хэлэх хүн олон байна. В.Жириновский л жаахан ууртай хоцрох болох нь.

МАХН-ын XXV хурлаас гарах салхины чиг аясыг харж байж УИХ-ын сонгуульд өрсөлдөх тактик төлөвлөөгөө ил гаргана гэсэн жижиг намуудын байр суурь бий. «Нэгдсэн Орос»-ыг нөгөөдүүл нь харзсан шиг явдал гэх үү дээ. МАХН-ын дарга хэн байх вэ, Ерөнхий сайд энэ том албыг хавсрах нь өнөөгийн нөхцөлд зөв үү гэх бас нэг багц асуулт олон зүйлд хариулт болох гээд байна. Бидний азаар Монголд сөрөг хүчин бодитой. Харин Орос орон сөрөг хүчингүй шахам болохоор Ерөнхийлөгчийнхөө эрүүл ухаан, эвдрээгүй зан байдалд найдах л үлдэж байх шиг. Энэ шавилхан эр аравдугаар сарын эхний өдөр зарласан сонголтоороо ОХУ-ын Засгийн газрын ирээдүйн тэргүүн болно гэдгээ нотолж, хүчирхэг гүрний ойрын таван жил баримтлах бодлого өдгөөгийнхөөс онцгой өөрчлөгдөхгүйг дэлхий дахинд эчнээ ойлгуулсан хэрэг.

Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулах гэсэн тодорхой оросуудын бодол төр, засгаасаа дэмжлэг авсаар үргэлжлэх нь. Ирэх арванхоёрдугаар сард Ерөнхий сайд М.Энхболдын Москвад хийх айлчлалын хүрээнд яригдах асуудлуудын хэрэгжилтэд мань Путин өөрөө оролцож эхлэх нь. ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль ирэх Мартын 8-ны баярын дараахан болохыг манай уншигчид мартаагүй байх. Владимир Владимирович халаагаа өөрийн хүндээ өгөөд, үргэлжлүүлээд гүйцэтгэх засаглалаа «аваад явах нь». Манай Энхбаяр дарга шиг л уламжлалын бэлгэ тэмдэг болох нь. Гэхдээ монголчуудаас авах ч, гээх ч туршлага бий шүү, ноён Путин.

2007 он



# Ц.Элбэгдорж тавьтаргүйтэв

(Editorial)

Ойрдоо ордонд ороогүй юм болов уу даа Элбэгдорж даргын сэтгэл их л хөдөлсөн харагдана. Олон камер хараад онгиrow уу яав , дуу алдмаар сул үг нэгийг гээж, уур хүрмээр залруулга араас нь хийн, оройхон тийшээ шалдаа буун шалчийгаад урд хойноо орсон уймраа ярилцлага ганцаарчлан өгөв өө.

Хувьсгалт намын 678 авлигач тэнд хуралдаж байна хэмээн цөс нь хөөрсөн Элбэгээ Төрийн ордонд тууж орхисон билээ. Маргааш нь МАХН-аас мэдэгдэл хүлээн аваад , энэ долоо хоногийн хэвлэлийн баатар болсноо төвөггүй мэдэрч , хурал зарлан бүр их уурлав. Ядаж байхад өчигдрийнхөөс олон зураглаач Ардчилсан намын байранд ирээдэхжээ. «МАХН-ын их хурал болж буй танхимд өөрийн биеэр очиж хэлсэн үгэндээ тайлбар хийе» хэмээн гоё хувилбар санал болгоод цээжээ хөдөлгөв. Энэ л мөчид инээд муутай нь писхийж, Элбэгдорж ахайтныг өдий болтол хүндэтгэж ирсэн над шиг хүмүүсийн сэтгэл хоосрох шахав. Үг бүр нь шахам шүлгэн шадтай болж , үйл хөдлөл нь бага тайзны дайны жүжиглэл болон хоосорч буй энэ хүнийг эртхэндээ хүндэлдэг хүн олон байсан юм аа.

Их улс төрд ороод 17 жил болж, Монгол төрийн хүндтэй суудалд цөөнгүй удаа заларсан эрхэм Элбэгдоржийн задгай ам жаран чавганцынх гэдэг шиг улам хагархай хангинана. «Эднүүсийн дунд жирийн шударга гишүүн олон бий л дээ» хэмээн TV5 телевизийн сэтгүүлчид тэр дор нь залруулга өгөв. Авлигын тухай М.Энхболд дуугараагүй дүнсийсэн нь алдаа. Ардчилсан нам мөнөөх авлигыг МАХН-ын халаасанд чихэх гээд бас баригдав. Ард түмэн харин энэ хоёр намын томчуудыг хээл хахуулийн загалмайлсан эцэг болоод үр садаар нь ижилхэн нэрлэдэг юм шүү. Аалзны тор хэмээх хэллэгт тэдний нэр адилхан орооцолджээ. 1996 оноос чанагш сонины бид хүртэл авлига гэдэг үг бичлэгтээ хэрэглэдэггүй байлаа. Яван моодонд орсон эл хэллэг Ардчилсан нам засаг, төрийг жолоодож ахуйд олны танил болжээ. Ах нам төдөлгүй дүү нараасаа авлигын аргад сайн суралцсан гэдэг. Яваандаа хоёулаа идэж уух технологт мэргэшин, бүр тэгээд нам энэ тэр гэлгүй найрч холилдон сайхан сүүтэй цай шиг шаргалтсан «юм» болсон билээ.

Монголын улс төр дэх тулах баганын нэг нөгөөгийнхөө алдаа оноог залруулах учиртай. Ингэж залруулахдаа их улс төрд 17 жил өрсөлдсөн үнэр танартай шүүмжилбэл сайнсан. Ардчилсан намын чансаа Элбэгдоржийн хоосон яриан дунд шалчийж эхэлснийг гишүүд дэмжигчид нь анзаараа байлгүй. Америк маягийн өөрчлөлтүүд Ардчилсан намаас үнэртэж, шинэ үзэгдэл болж байхад гар өргөн бид талархаж байлаа. Гэсэн ч том намын даргын зангараг хувийн театрчилсан тоглолтод уусан бүдгэрэх бүрийд өмнөөс нь харамсаж улаймаар санагдах юм. Эмнэлэгт удаад илааршсан Элбэгээг хүмүүс халуун дотноор угтсансан. Нутаг орондоо газардмагцаа Бирмийн лам нарыг ахай ижий гээд өрөвдөн жагсахад нь бас л ойлгохыг хичээж билээ. Төдөлгүй захуудаар жаахан явж, Ж. Буш шиг үнэмшил багатай , хүрээлэл цөөтөй акц зохион байгуулав. Нэг л биш ээ , намын дарга хэмээн ой тойнд зурсхийв үү үгүй юу 678 авлигач аа гээд хашгирч орхих юм.

Ардчилсан нам энэ өдрүүдэд тулаанаар бол хамгийн ашигтай байрлалаа нэгэнд эзлээд байтал Элбэгээгийн задгай ам, чалчаа лекц юу хийж орхив оо. МАХН-ын их хурлаас нийгмээрээ шинэчлэл хүлээж , өрсөлдөгч нь хүртэл амьсгаа даран ажиглаж суухад муусайн авлигачид хуралдаж байна гэж хашгирах нь том улс төр үү, гудамжны амбиц уу ?

# Монголын үрс «ЗЭСИЙН ҮНЭ» ХЭМЭЭН ХЭЛД ОРНО

Бяцхан багачуудын маань үгсийн санд ийм этгээд хэллэг нэвтэрч, аав ээж, алим жимс, бамбарууш хүүхэлдэйтэй цуг алт, зэс гэж шулганах цаг ирээд байна. Сар бүр 10.000 төгрөгийн цалин аваад байх эсэх нь, амттан авахуулах боломж нь тэрхүү металлын үнээс шууд хамаарах гэнэ. Чилийн Эскондида уурхай, зэс үйлдвэрлэлийн дэлхийн магнат BHP Billiton, Rio Tinto зэргийн нэр усыг бяцхан булбарай тань цээжээр шулганаж мэднэ шүү. Гэр бүлийн төсөвт боломжийн хувь нэмэр болчих «Хүүхдийн 10.000»-ын сураг хол, ойрыг холбосон учир жанцан ихтэй асуудал аа.

Хүүхдийн мөнгөний дуулиан урт намрын шувтаргаар улс төрийн ужиг хэрүүлийн эхийг дэвсээд өгөв. Сар бүр хүүхэд болгонд 7000 төгрөг өгөөд эхэлбэл нийт 30 тэрбумын эх үүсвэр хэрэгтэй. Харин 10.000 төгрөг болгон ахиулбал 50 тэрбум шаардлагатай. 5000 гэж нарийлбал «голоо цохисон» тэр намын нэр хүнд хүүхдүүд болоод аав ээж, өвөө эмээ нарын дунд навс унах нь. Ингээд УИХ-ын нэгдсэн чуулганы сурвалжлага урьд хожид дуулдаагүй олон үзэгчтэй нэвтрүүлгээр шалгарах дөхөв. Эрхэм гишүүд тоон дээр тохирч чадалгүй тодорхойгүй хугацаагаар завсарлага авлаа. **10.000-7000** болоод **10.000-5000** хэмээх ялгаврын зөрүү төсөв нимгэн өрхүүдийн хувьд том ашиг сонирхол болон хувирлаа. Ирэх оны төсвийн хэлэлцүүлэг талдаа ороогүй байхад Ардчилсан нам чуулганы хуралдаанд бойкот зарлав. Арванхоёрдугаар сарын 1 гэхэд Төсвийн тухай хууль батлагдах учиртай хэмээн Ерөнхий сайд бөндөгнөж эхлэв. Саарал ордонд зөвшилцлийн ээлжит хүлээлт бий болжээ.

Мөнгө хуваахаар маргалдаж суугаа маань өөрөө том үйл явдал билээ. Тараах хөрөнгөтэй энэ өдрүүдээ монголчууд түүхнээ тодоор тэмдэглэх учиртай. Тэгвэл одоо хүүхдийн мөнгөний тоон үзүүлэлтийг тойроод, цаана нь «алмайрах» өөр нэг асуудалд анхаарал хандуулья. Монгол Улсын Хөгжлийн санд мөнгө «цутгасан» дэлхийн томоохон зэс үйлдвэрлэгчдэд талархал илэрхийлье. Та хэд үйлдвэрлэлийнхээ хэмжээг багасгаагүй бол бид хэд чинь энд «Арав уу, долоо юу» хэмээн сонголт хийж суухгүй байлаа. Ирэх оноос эхлэн Монголын олон өрхийн амьжиргаанд мэдэгдэхүйц нэмэр өгөх сар бүрийн 7000-10.000 төгрөг урт настай удаан жаргалтай эсэхийг Эскондидагийн уурхайчид бараг мэднэ дээ. Хэрэв уурхайчид ажил хаяж, өнгөрсөн зуных шигээ элдэв шаардлага тавибал дэлхийн зэс үйлдвэрлэлийн тэргүүлэгч тус компанийн удирдлага хариу арга хэмжээ болгон үйл ажиллагаагаа дахин хумьж болзошгүй. Улмаар уурхайчдын эсэргүүцлийн аян даян дэлхийгээр нэг халдварлавал зэсийн эрэлт улам өсч, хүүхдийн мөнгөн дээр Монголын улстөрчид гар татах шалтгаангүй болно оо.

Гэнэтийн ашгийн татвар гэгч буянтай мөнгөний дүн өсөх шалтгааныг ийнхүү уурхайчдын уур хилэнтэй холбох үндэстэй. Тэгвэл үйл явдал эсрэгээрээ буюу зэс үйлдвэрлэл хэвийн хэмжээнд явагдаж, эрэлт нийлүүлэлтийн хооронд ноцтой ялгаа ажиглагдахгүй тохиолдолд үнэ ханш нь ирэх жил тогтвортой, цаашид ялимгүй унах таамаглал гараад байна.

Монгол Улсын Хөгжлийн сангийн хөрөнгө зоорь хэлбэлзэл савлагаатай байх юм шүү гэдгийг багачууддаа бүр багаас нь ойлгуулах хэрэгтэй болох нь. Дандаа 10.000 төгрөг аваад байна гэж бодоод горьдчих вий. Тэгэхдээ тэр их мөнгийг Ардчилсан намын ах, Хувьсгалт намын эгч тараадаг гээд итгэхийг

Мөнгө  
хуваахаар  
маргалдаж суугаа  
маань өөрөө том  
үйл явдал билээ.  
Тараах  
хөрөнгөтэй энэ  
өдрүүдээ  
монголчууд  
түүхнээ тодоор  
тэмдэглэх  
учиртай.

вий. Энэ жил арвыг, ирэх жил арай багыг, тэгснээ бүр жаахан мөнгө өглөө гээд бяцхан үрс нялх балчраасаа эхлээд улстөрждөг болчих вий дээ. Тэр сангийн мөнгө улстөрч эрхмүүдийн ааш зангаас үл хамаардаг юм шүү, хонгор минь. Хөгжлийн сангаас хөрөнгө хуваарилах ерөнхий зарчим нь тэднээс хамаардаггүй юм аа, бяцхан минь. Манай улсын стратегийн гол бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр унасан тохиолдолд хүүхдийн мөнгө 3000 төгрөгний босго дээр дэнжигнэж үлдэнэ. Өөрөөр хэлбэл, улстөрчид танай гэр бүлд ийм хэмжээний тусламжийн баталгаа гаргаж өгч буй хэрэг.

Эндээс Монгол Улсын Хөгжлийн сангийн зорилго, ирээдүйн талаар тунгаах хэрэг аяндаа харагдаад байна. Уг санд төвлөрөх хөрөнгөнөөс зөвхөн хүүхэд багачуудад сар бүр мөнгө тараах төдийгүй эхчүүдийн эрүүл мэндийн тусын тулд, түүнчлэн шинээр гэр бүл бологсод тусалцаа дэмжлэг өгөх нь. Цаашлаад, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ. Давагдашгүй хүчин зүйлд нэрвэгдсэн тохиолдолд Засгийн газар гал унтраана. Энэ бүхнийг нэгтгэн тунгаавал Хөгжлийн сан гэхээсээ илүү Ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллын чиглэлийн нөөц хөрөнгө хэмээн харж болох юм. Сангийн нэр ус зориулалттайгаа нэг л зохилдохгүй байгааг төвөггүй анзаарч буй биз дээ.

Ирэх онд үүцнээсээ 150 тэрбум төгрөг, сонгуулийн жил буюу 2008 онд 217 тэрбум төгрөгийг нийгмийн хамгааллын арга хэмжээнд зарцуулахаар Засгийн газар төлөвлөжээ. Эдгээр нь магадгүй жил жилийн улсын төсөвт ашгаас нь хамааран хэлбэлзэлтэй суулгаад явж болох нийгмийн чиглэлийн зардлууд байж мэднэ. Харин Хөгжлийн сан бол улс орны урагшлах замд дорвитой түлхэц өгөхүйц зардлуудыг даадаг байвал нэр усандаа нийцмээр. За яахав нэр хаяг мэтийн аар саар зүйлээр оролдож, парламент дахь тэртээ тэргүй эмзэг уур амьсгалыг бүр жаварлуулахаа больё. Гэнэт орж ирсэн их ашгийг нийгмийн хамгааллын чиглэлээр эвийг нь олоод хувааж л байвал аль хүүдийнээсээ гаргаж цацах нь өөрөө мэдсэн хэрэг болоод байна.

Ингэж нүдээ аниад өнгөрье гэтэл 10.000 болоод 500.000 төгрөгний цаанаас өөр нэг хандлага үнэртээд эхлэх юм. Элдэв сангуудаас нийгэмд тарааж байгаа их хөрөнгө эдийн засагт эргээд цохилт болж болзошгүйг Сангийн яам болоод Монголбанкны мэргэжилтнүүд хэрхэн тооцоолж суугаа бол? Мөнгөний урсгал нэмэгдэхийн хэрээр нөгөө талд инфляцийг зохицуулах өөр нэг сан, бодлого үгүйлэгдэж байгааг сануулья. Сангууд ямар ч нэр алдартай байж болно оо. Гагцхүү нэг сайн арга хэмжээ нөгөө талд сөрөг үр дагавар болж илрэх ёсгүй. Өнгөрсөн оны есдүгээр сараас эхлэн тасралтгүй өсч буй зэсийн ханш ирэх жил ч манай улсын нэгдсэн төсөвт амьсгаа авах боломж олгохоор байна. Бидний ижил зах зээлийн таатай нөхцөлд амьдарч байгаа оросуудын туршлагыг харья. Нефьт бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ нь Персийн булангийн ужиг хямрал, АНУ, Хятад зэрэг улсын асар их хэрэглээг дагаад сүүлийн хэдэн жилийн турш тасралтгүй өслөө. Ийм «тохироо» эдүгээ Орос улсын эдийн засагт амьсгаа авах боломж олгоод байна. Нефьт бүтээгдэхүүн экспортлогч том улсуудын нэг ОХУ тэрхүү гэнэтийн ашгаа юунд зарцуулдаг нь сонин. Юуны өмнө тэд бидэн шиг Оросын фонд байгуулжээ. Уг сангийн гол үүрэг нь эдийн засагт орж ирж буй их мөнгийг үнэгүйдэхээс хамгаалах явдал. Өөрөөр хэлбэл, оросууд инфляцийг тогтоон барих баталгааг уг санд «даатгасан» байх юм. Харин нийгмийн халамжийн арга хэмжээнүүдэд улсын төсвөөс чамгүй хөрөнгө хуваарилсан байна. Тухайлбал, ирэх жилийн нэгдүгээр сарын 1-ээс хоёр дахь хүүхдээ төрүүлсэн ээж нарт тэтгэлэг олгоно. Хүн амаа өсгөх энэхүү цоо шинэ бодлогыг хэрэгжүүлэх боломжийг нефтийн үнийн таатай нөхцөл олгож байгаа. Гагцхүү их мөнгөний урсгалыг микро чиглэлээр төдийгүй макро түвшинд ч хооронд нь уялдуулан зохицуулсан байх юм.

**Элдэв сангуудаас нийгэмд тарааж байгаа их хөрөнгө эдийн засагт эргээд цохилт болж болзошгүйг Сангийн яам болоод Монголбанкны мэргэжилтнүүд хэрхэн тооцоолж суугаа бол? Мөнгөний урсгал нэмэгдэхийн хэрээр нөгөө талд инфляцийг зохицуулах өөр нэг сан, бодлого үгүйлэгдэж байгааг сануулья.**

Монгол Улсыг 2007 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болоод төсөвт хөрөнгө оруулалтын арга хэмжээг ор тас орхигдуулсан гэж мэдээж хэлэхгүй. Ялангуяа зам харилцаа, барилгын салбарт бүтээн байгуулалт өрнөх нь. Орон нутагт ахиу хөрөнгө хуваарилах юм байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийг хөл дээр нь босгох нь ээ. Тун сайн хэрэг. Өөр олон олон арга хэмжээг санхүүжүүлэхээр 2007 оны төсөвт тусгажээ. Гагцхүү авсан арга хэмжээ, санхүүжилтийн үр дүнг эдийн засагт улам томорч мэдэх инфляц үнэгүйдүүлэх вий. Хэдийгээр инфляцийг тав хувь орчимд байлгана хэмээн тооцоолж буй ч «хүлээлт» найман хувьд хүрэхийг эдийн засагчид үгүйсгэхгүй байна. Томорсон инфляц нь арилжааны банкуудын зээлийн хүү ирэх өдрүүдэд ч өнөөгийнх шигээ өндөр хэвээр байхыг өгүүлээд байна. Монгол Улсын эдийн засаг хөгжлийн араандаа орсон энэ өдрүүдэд бага хүүтэй зээл шиг чухал зүйл үгүй болжээ. Монголчууд жилийн 24 хувийн хүүтэй зээлд дарлуулж сууна. Тэгвэл Орост арилжааны банкны зээлийн хүү 12, БНХАУ-д таван хувьтай байгаа. Тэгэхээр бид гэнэтийн ашгаа мөнхийн юм шиг санаад, догонцсон шийдвэрүүд гаргаад явж болохгүй ээ.

**2006 он**

# Эвсэл бүрэн задарсан гэж эндүүрэвзэй

Морины шандас, уяачийн ухаан хурдны уралдаанд гол зүйл гэнэ. Тэгвэл төрийн түшээг шилж томилоход сонгогч олны ая зан онцгой асуудал билээ. Сонгогчийн сэтгэлзүйн талаар дүгнэлт хийж болохуйц дорвитой судалгаа одоогоор гараагүй байна. Нутгийн чулуу бүлээн гэсэн хүчин зүйлийг зарим судлаач таамаглалдаа дэвшүүлснээс хэтрээгүй байгаа.

Нийслэлийн сонгогчдын хувьд хөдөөгийнхнөөс ялгаатай нь танил тал, садан төрлийн сэтгэлгээ гол хүчин зүйл болохгүй. Дүүргүүдэд олон нийтийн дийлэнх нь хүлээн зөвшөөрсөн нэр хүндтэй улстөрч, эсвэл орон нутгийн засаг захиргааны төлөөлөгч, үгүй бол нутаг дэвсгэрийн бизнесмэнүүд илүү амжилт олох нь лав. Хотын сонгогчийн сэтгэлзүй хөдөөгийнхнөөс, нийслэл дотроо тухайлбал баянголчууд хөрш дүүргийнхнээсээ юугаараа ялгагдах бол?

Нутаг дэвсгэрт нь байгаа нөхөрлөл, компани, хоршоо, УҮГ, ХЭАА, төсөвт болон төрийн бус, түүнчлэн шашны байгууллагын тоогоор Баянгол дүүрэг Улаанбаатартаа тэргүүлдэг. Харин хүн амынхаа хэмжээгээр нийслэлийн харьяаны есөн дүүргээс хоёрдугаарт нь ордог буюу 120 гаруй мянгуулаа.

М.Энхсайханы Засгийн газрыг огцруулах эхний оролдлогын үеэр УИХ-ын гишүүн Т.Ганди «Манай тойрогт дэндүү олон баар байгуулагдлаа» гэж Ерөнхий сайдад гомдоллож, хариуд нь М.Энхсайхан «Танай тойрогт хэдэн баар байхыг зах зээл өөрөө зохицуулжээ» хэмээн тайлбарлаж билээ. Үнэхээр энэ дүүрэгт жижиг аж ахуй эрхлэгч олон. Ийм ч болохоор 1996 оны сонгуульд 65 дугаар тойргоос «Парадокс» хэмээх том бус компанийн захирал хүртэл нэрээ дэвшүүлж явлаа.

Тус дүүрэгт энэ удаа МАХН-аас нэр дэвшүүлсэн байдлыг харахад мөн л дошин дээрээ додигор байж чадах бизнесмэнүүдийг гаргах тактик хэрэглэжээ. Тухайлбал, гурав, дөрөвдүгээр хорооллынхны сайн танил «Магда» болон «Номин электроникс» дэлгүүрийн эздийн нэр энд байна. Тус хорооллын оршин суугчид эрх ашгаа иймэрхүү хүмүүст дайвал УИХ-ын танхимд сонсгох магадгүй гэж найдахын зэрэгцээ Ард Аюушийн гудамжийг өргөтгөж өөд нь татах ажлыг эхлүүлсэн хүмүүст талархалтай хандах нь магадлалтай. Харин намуудаас нэр дэвшүүлсэн байдлыг ажихад хотын захиргааны болон зам барилгын засвар хариуцсан албан тушаалтны нэр үзэгдэхгүй байна. Эндхийн оршин суугчид өвөлдөө даарч зутрах нь элбэг байдаг болохоор нийгэм, ахуй үйлчилгээний чиглэлээр юу хийх нь вэ хэмээн нэр дэвшигчийг сонжих нь мэдээж. Өөрөөр хэлбэл, баянголчууд аж ахуйн чиглэлийн амлалтыг илүү үнэлэх магадлалтай. Мөн төсвийн байгууллагад ажиллагсдын цалинг нэмэх тухай ярьсан хүн энд амжилт олон нь мэдээж.

Төмөр замын тосгон гэсэн том бүлэглэл тус дүүрэгт бий. Олонхи нь хуучинсаг үзэлтэй. УБТЗ-ын Хэрэг эрхлэх газрын дарга Р.Раш, эсвэл Суудлын вагон депогийн дарга О.Сүрэн нарын нэр 63 дугаар тойрогт гараад ирвэл саналын жин хаашаа хэлбийх нь тодорхой. Өмнөх жилүүдэд энэ тойрогт төмөр замын том дарга нараас нэр дэвшиж байгаагүй. Хувь нийлүүлсэн тус нийгэмлэгт данстай монголчуудын орон сууцны хувьчлалын асуудал сөхөгдөж

**Сонгогчийн сэтгэлзүйн талаар дүгнэлт хийж болохуйц дорвитой судалгаа одоогоор гараагүй байна. Нутгийн чулуу бүлээн гэсэн хүчин зүйлийг зарим судлаач таамаглалдаа дэвшүүлснээс хэтрээгүй байгаа.**

**ХИД-2  
дэлгүүрийн  
баруун талын  
байранд  
амьдардаг  
Баабарыг 63  
дугаар  
тойргийн  
олонхи  
сонгогч 1996  
онд дэмжсэн.**

эхэлсэн болохоор төмөр замынхан сонгуульд улс төрийн өндөр идэвхтэй оролцоно. Р.Раш дарга нь Дэд бүтцийн сайд болчихвол «хувь нийлүүлсэн нийгэмлэгийн зөвлөлийн хурлыг зарлаж..» гээд л замчид одооноос мөрөөдөж байгаа биз.

Ийм тохиолдолд МҮАН Сангийн экс сайд П.Цагааныг 63 дугаар тойрогт өгч «золиослуулахаар» зориглолоо. Харин МДСН П.Улаанхүүгээ «уйлуулахаар» шийдсэн юм болов уу. Гэхдээ тус тойрогт МАХН бас ч хаширлаж, МСДН горьдлоготой суугаа нэг шалтгаан бий. ХИД-2 дэлгүүрийн баруун талын байранд амьдардаг Баабарыг 63 дугаар тойргийн олонхи сонгогч 1996 онд дэмжсэн. Магадгүй тэр үед Хувьсгалт намынхан төмөр замчдад дэндүү найдаад, судалгааны төвийн секторын эрхлэгч, нэрд гараагүй нэгэн Д.Алтайг Баабартай үзэлцүүлсэн нь алдаа болоо биз. Энэ удаа Бат-Эрдэнийн Батбаяр зэргэлдээ дүүргийн өөр «халуун» тойрогт өрсөлдөхөөр яваад өгсөн. Түүнийг тойргоо орхиод явчихаар Баянголд сонгуулийн тулаан сонирхолгүй болно гэсэн үг биш. Төмөр замчдын ашиг сонирхлыг эс тооцвол ер нь энэ дүүрэгт өрсөлдөх Д.Ламжав, А.Ганбаатар нарын соцдекүүд хүчтэй харагдаж байна.

Хэдийгээр энэ удаагийн сонгуульд эвсэлд нэгдэж асан хоёр нам халз үзэхээр шийдсэн ч хүчтэй хүмүүсээ хооронд нь цохилдуулахгүй талаар тохиролцсон байж болох юм. Иймээс ч Р.Амаржаргалын нэр дэвших тойрогт А.Ганбаатар ч юм уу, эсвэл Д.Ламжав тохоогдвол бие биенээ «шатаасан» хэрэг болох тул өнөөгийн Ерөнхий сайдын аманд «Сүү» компанийн захирал Т.Баярхүүг барьж өгөхөөр соцдекүүд шийдэв бололтой. Тэгвэл МСДН-ын Д.Ламжав, А.Ганбаатар нарын өмнөөс МҮАН нь агентлагийн газрын дарга Ц.Хурцбилэг гэх мэт «жижиг» хүмүүсээ тавьжээ.

Харин Хувьсгалт намынхан Баянголын дөрвөн тойрогт дээрх хүмүүстэй зиндаа тэнцэх гишүүдээ илгээх нь мэдээж. Лав 66 дугаар тойрогт Ж.Бямбадорж, А.Ганбаатар нарын өрсөлдөөн ширүүн болно.

МҮАН, МСДН энэ удаа эвсээгүй хэдий ч, сайхан цагийнх нь ургийн барилдлага амь бөхтэй үлдсэн. Иймээс ч МАХН нэр дэвшүүлэхдээ бүр хашир үзэхээр шийдэж, бусад намын оноолтыг хүлээн байж хэнийг хэнээр цохих боломжтойг удтал тооцоолсон.

Баянгол дүүрэгт 1996 онд таван нам, эвслийн нийт хорин хүний нэр дэвшсэн. Харин энэ удаа дээр нэр нь гарсан «томчуудыг» тоосоороо дарах хүн шинэ нам, эвслийнхнээс тодрохгүй биз ээ. Иймээс хотын төвийн тойргуудад сонгуулийн өрсөлдөөн бодитой бас ширүүн болох магадлалтай. Өрсөлдөөнийг лавшруулан төсөөлбөл, МАХН-МҮАН, эсвэл МАХН-МСДН-ын хооронд тус тус өрнөх мэт санагдана.



# Сонгуулийн жилийн мартагдсан СОНГОГЧИД

Ммм...Маги. Өнгө алагласан амтат шөлнөөс аятайхан үнэр ханхийлээ. Ммм...Путин. Тэр ард түмний ерөнхийлөгч. Ммм...Керри. Түүний инээмсэглэхийг хараач. Жинхэнэ америк эр... Сонгуулийн марафон эхэлжээ. Сонин ихтэй жилийн бүр нэгдүгээр сард л цэнхэр дэлгэцийн сурталчилгаа үзүүштэй шинэ баатруудтай болов. Телевизийн байнгын рекламуудтай улстөрчдийн сэтгэл татам инээмсэглэл өрсөлдөж эхэллээ. Америк, Оросын телесувгууд мөнгө «хураах» ажилдаа мөдхөн орох нь. ОХУ-ын төрийн мэдлийн телевизүүдийн удирдлага ирэх даваа гаригт эфирийн цагийг хэрхэн хуваарилахаа үзэхээр шодно. Тус улсын Сонгуулийн төв комисс ийм шийдвэр гаргажээ.

Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхөөр нэр дэвшсэн долоон хүнд телевизийн хамгийн сайн цагаар сурталчилгаагаа адил тэнцүү цацах эрх олгох зорилготой юм. Нэр дэвшигч бүр ажлын өдрүүдэд дор хаяж нэг цаг үнэ төлбөргүй өөрийгөө рекламдана. Ирэх пүрэв гаригаас тэрхүү сонирхолтой цаг эхлэх юм. Нэр дэвшигчид сугалсан дарааллаараа бүтэн сарын турш эфирт гарах учиртай. Гэвч ОХУ-ын Ерөнхийлөгчийн энэ удаагийн сонгууль халуун мэтгэлцээн бүхий үзүүштэй сунгаа болохгүй гэдгийг бодолцвол нөгөө нэг цагийн сурталчилгааг сонирхохоор сувгаа тохируулах сонгогч хэр олон бол? В.Путиний этгээд алхаа, цоргисон харц, өнөөгийн эрх мэдэл болоод өндөр рейтингийг бүдгэрүүлэх өрсөлдөгч үл харагдана.

Үүнтэй харьцуулахад АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн кампани хамаагүй өргөн дэлгэц дээр ширүүхэн маргаан дунд өрнөх нь. Бүр өнгөрсөн оны есдүгээр сараас сөрөг Ардчилсан намынхан зургаан удаа нүсэр бүрэлдэхүүнтэй хуралджээ. Бүгд найрамдах намын ноёрхлыг буюу Жорж Бушийг унагаж чадах, Ардчилсан намын бодлогыг дүүрэн илэрхийлэх төгс төгөлдөр улстөрч, хүчтэй лидер, олныг өөртөө татах хувь хүн хэн бэ? «Би» хэмээн бардам ам гарсан Ардчилсан намын гишүүн 70 орчим байлаа. Эднийг шигшсээр 40 илүүг нь үлдээж, дараа нь бүр олны дэмжлэгийг авсан долоон хүн тодорчээ. Одоо Америкийн телевизүүдээр мөнөөх төгс төгөлдрийн шалгуурт тэнцэх учиртай эрс яралзтал инээмсэглэж, онцгой сэтгэгдэл төрүүлэх үг өгүүлбэрийн эрэлд хатна. Ховард Дин хамгийн эрч хүчтэй нь болохоо нотлохоор заримдаа жаалхүү шиг загнах аж. Залууст Дин их таалагддаг гэнэ. Тэр индрийн цаана бараг хашгирч, занган, үсэрч дэвхрэх нь холгүй. «Саддам Хусейнийг Ж.Буш баривчилсан. Тэглээ гээд байдал өөрчлөгдсөн юм алга. Энэ дайн эхнээсээ алдаа байсан» хэмээн Ховард давтсаар. Тэгвэл Уэсли Кларк дайн байлдааны үнэр мэдэх хатуужсан эр. Жон Керри жинхэнэ америк маягаар инээмсэглэхийг харав уу. Энэ оны арваннэгдүгээр сард болох АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан нам төдийгүй өөр 11 жижиг нам нэр дэвшигчдээ сойжээ. Жорж Буш ч ганцаараа биш аж. Бүгд найрамдахчуудын эгнээнээс 30 орчим хүний нэр мөн жагсаалтад бичигдсэн байна. Тун олон улстөрч өнгө өнгийн байр суурь, санаа, үзэл бодлын өнцөг илэрхийлж харагдана. Тэдгээр уран тод үг өгүүлбэртэй илтгэл бүгд «Нийт америкчуудын эрх ашгийн тулд би үүнийг хийнэ» гэсэн цохилт дээр өндөр авах аж.

Ардчилсан нам гишүүддээ хандан тараасан захидалдаа «Манай намыг бүх Америк гэж ойлгоорой. Яагаад гэвэл бүгд найрамдахчуудын шоовдорлосон тэр хүмүүсийн ард бид зогсч буй юм» хэмээн бичжээ. Сонгуулийн кампанит ажил дөнгөж эхэлж буй мэт санагдавч нэр дэвшигчдийн гартаа атгасан хөзөр тов тодорхой, байр суурь хатуу сонсогдлоо. Цагаан ордны өнөөгийн эзний эсрэг зогсч чадах ганц хүнээ тодруулахын өмнө тус нам нэг зарчмыг зарласан. «Долоон нэр

дэвшигч бие биедээ дэгээ тавихгүй. Харин Ж.Бушийн засаг захиргааны явуулж буй бодлогыг хайр найргүй шүүмжилнэ» гэжээ. Энэ оны зургадугаар сар хүртэл үргэлжлэх марафон ийм дүрэмтэй. Зуны эхэн сар гэхэд Ж.Буштай өрсөлдөхөөр хамгийн хүчтэй нь тунаж үлдэх юм.

Ертөнцийн өөр нэг хэсэгт энэ зун мөн л сонгууль болно. Монгол Улсын иргэд шинэ парламентаа сонгох хугацаа ойртсоор. Цэнхэр дэлгэц гялсхийн аслаа. Ммм...Намбарын Энхбаяр, бүтээн байгуулагч нам, хөгжлийн төлөө алхмууд...Нэг төрлийн «шөлнөөс» залхаж эхэллээ. Нөгөө өрсөлдөгч нь хаана яваа юм бол? Монгол нутагт энэ хавар парламентийн сонгуулийн марафон ер эхлэх янзгүй дээ. Өнгөрсөн зунаас эхлэн идэвхтэй шидэлцсэн мэдэгдэл, ил захидлуудыг кампанит ажлын хэсэг хэмээн ойлгож болох уу?

Түүнээс түүнд хаягласан мэдэгдэл, надаас чамд сонордуулах ил захидал, түүний хариуд илгээх бичиг, хариултын хариу болгон түмэн олноо сонордуулах нь...Улстөрчид ийм цаас солилцож, хэн нь хэд дэх эсэргүүцлийн ноотоо сийрүүлснийг, хариу ярилцлага, контр материал нийтлүүлснийг яг таг хэлж чадах хүн ч алга болов. Хариу захидал бүр хачин шударга үгсээр дүүрэн. Хамар шархирч, тэрлэгчийн талд орчихмоор ариун цагаан сонсогдоно. Зүгээр нэг бохир захидлыг сөрөг хүчний хэвлэлд факсдаж орхиход маргаашнаас нь яралзтал хэрэлддэг муу өвчин Монголыг нэрмэв. Мэдэгдэл, эсэргүүцэл гэсэн нэр үгний учир утга шалдаа бууж, тэр болгоныг тэргүүн нүүртээ наасан сонин уншигчаа нэг нэгээр алдах болж. Өөрөөр илэрхийлбэл, намууд сонгогчоо өөрсдөө үргээсээр. Улс төрийн жинхэнэ мэтгэлцээн эхлэх яагаа ч үгүй бололтой. Хөөрхий нөгөө сонгогчдынхоо ахуй амьдралын талаар түлхүү ярих ёстойгоо бодох завгүй хэрэлдэцгээнэ. «Хүүхэд бүрт 10 мянган төгрөг өгнө» хэмээн Ардчилсан нам шинэхэн санаачлага эхлүүлж билээ. УИХ-ын гишүүнд бус, танай хүүхдэд чинь зориулна шүү гэсэн ийм санаа иргэдэд тун ч таалагдаж, сонгуулийн өмнө хийх алхмуудынх нь нэг байх нь гэж таамагласан юм. Гэвч «Хүүхэд бүрт 10 мянга»-ын араас хүч нэмэн үргэлжлэх учиртай арга хэмжээ, амлалт, ажил хэрэгч алхмууд чимээ тасарлаа.

**Шинэ  
сонголт  
гэдэг үгэнд  
Хувьсгалт  
намынхан  
үхтэл  
гомдоно  
гэдэг бас л  
эрүүл явдал  
гэж үү?**

Их зорилгынхоо өмнө Ардчилсан нам эвлэрч нэгдэх, буулт хийх тэнхээгүй ямар удна вэ? Эх орны хөгжлийн төлөө том том алхмуудыг эхлүүлээ гэх атлаа жижиг муусайн хэрүүл бүрт орооцолдож хэрэлдэхээсээ Хувьсгалт нам ч ямар залхдаггүй юм бэ? Өдийд олон нийтийн санаа бодлыг танддаг судалгааныхны ажлын жинхэнэ сезон баймаар. Гэвч асуулгын хүснэгтэд ямар намуудыг эгнүүлэх билээ? М.Энхсайхан, Р.Гончигдорж нар Израиль, Палестиний дүрд тоглон өөр зуураа жийлцэх нь хэнд ашигтай юм бэ. Шинэ сонголт гэдэг үгэнд Хувьсгалт намынхан үхтэл гомдоно гэдэг бас л эрүүл явдал гэж үү? Ингэх тусам нь Ерөнхийлөгч мөнөөх үгээ дахин нэг чангахан хэлж орхиосой. Реклам сурталчилгааны эх бичвэрт ашигладаг хамгийн хүчтэй долоон үгний тоонд багтдаг «шинэ» гэсэн тодотголыг МАХН сонгуулийн кампанидаа өөрсдөө авч хэрэглээсэй. Монголын улстөрчдийн өөр зуураа өрвөлздөг өвчнийг хэрхэн анагааж, цэнхэр дэлгэцийнхээ өмнө сууж байгаа сонгогчдынх нь тухай тэдэнд сануулах вэ?

Шар айраг шимж, шарсан төмс шажигнуулах зуураа эрхэм сонгогч найз сонгогчийнхоо утасны дугаарыг эргүүлж байна. «Нөгөө хэний мэдэгдлийн хариуд контр захидал ирүүлснийг дуулсан уу, үзээрэй» гэх аж. Зүгээр л амралт чөлөөт цагийн, цэнгээнт хөгжөөнт нэвтрүүлгийн тухай ярих адил доогтой үгсийг сонгогчид нэр дэвшигчдэд хаяглаж байна. УИХ-ыг сонгох сонгууль цөөхөн сарын дараа болно. Гэвч өнөөгийн эрх баригчдын явуулж буй бодлогыг бодитой шинжилж, үндэслэлтэй шүүмжлэх байр суурийг сөрөг хүчин нь илэрхийлж чадахгүй явна. Хариу мэдэгдлүүдээр мэргэшээд, контр бодлогоо зарлах завгүй. Үндэсний зөвлөлдөх хорооныхоо хурал дээр намын тэргүүн М.Энхсайханы тавьсан илтгэлээс өөр бодлогын шинжтэй, хүчтэй, намын энтэй баримт бичиг

гарсангүй.

Нью Хэмпширийн Ардчилсан намын хэсгээс бэлтгэж түгээсэн зар доорх агуулгатай байлаа «Та биш бол өөр хэн үүнийг хийж чадах вэ» гэсэн гарчиг дор «Ж.Буш энд ирээд ганцхан цагийн дотор эдийн засгийн тухай ярилцах гэнэ. Үгүй, тэр эхлээд эрүүл мэндийн даатгалгүй Нью Хэмпширийн 125 мянган иргэнтэй ярилцаг. «Гас-Рас» үйлдвэрт ажиллаж байсан 535 хүнтэй уулзаг. Нэхмэлийн үйлдвэрт данстай байгаад өнөөдөр ажилгүй болсон 22 мянган иргэнтэй бас уулзах ёстой...Өнөөгийн засаг захиргааны бодлогыг өөрчлөх хэрэгтэй гэж Та үзэж байгаа бол 2004 оны хоёрдугаар сарын 7-ны бямба гаригийн 10 цагт «New England College Simon» төвд эхлэх уулзалтад очоорой» гэжээ.

Эрх баригчдад хариу болгон сөрж зогсох бодлогогүй улс төрийн хүчин ялагддагийг монголчууд өнгөрсөн арванхоёрдугаар сард болсон ОХУ-ын ДУМ-ийн сонгуулийн дүнгээс харсан. В.Путиний засаг захиргааны явуулж буй бодлогод хэрхэн хандаж буй, чухам яагаад эсэргүүцэж, ямрыг нь дэмжих болсноо тодорхой томъёолж чадаагүй нам бол Барууны хүчнүүдийн холбоо. Оросын баруунтнууд нэгдэн зогсч, ерөнхий байр сууриа даган гар гараасаа барьж чадаагүй билээ. Эдүгээ И.Хакамада «Барууны хүчнүүдийн холбоо»-г орхин, шинэ либераль нам эмхлэх санаатай хэмээн ярьж явна.

Өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын сүүлээр буюу ДУМ-ийн сонгуулийн дараа явуулсан санал асуулгын дүн ч олон зүйлийг өгүүлэх аж. Оросын уудам нутгийн 44 муж, хязгаарын иргэдээс авсан асуулгын эцэст 80 хувь нь Ерөнхийлөгчийн сонгуульд В.Путин ялна гэдэгт итгэлтэй байна гэж хариулжээ. Хамгийн гол нь энэ 80 хувь тэр чигээрээ өнөөгийн Ерөнхийлөгчид санал өгнө гэж хэлээгүй юм. В.Путинийг шууд дэмжих нь 63 хувийг эзэлжээ. Өөрөөр хэлбэл үлдэх хэсэг нь яахаа мэдэхгүй яваа хүмүүс. Владимир Жириновский, Геннадий Зюганов нарт хайртай оросууд тэдний орхин одсон онгорхой орон зайд гайхшаа баран барьц алджээ. Улмаар «В.Путин л ялах нь» гэсэн сэтгэлзүй уудам Орос орон даяар бэлтгэгдсэн харагдана.

МАХН л ялах биз. Өрсөлдөх ганц нам нь эв зүйгээ дотроо олж чадахгүй явахад...гэсэн урамгүй үгс сонсогдож, яахаа мэдэхгүй төөрсөн сонгогчдын орон зай Монголд ч тэлсээр. Тэднийг татаж авахаар Хувьсгалт намын сурталчилгаа хүч түрж байна. Ммм...Энхбаяр, бүтээн байгуулагч нам...Орон зай дүүргэх ажиллагаа улам эрчимжсээр. Ирэх дөрвөн жилд альтернатив парламенттай болохыг хэн хүсч байна вэ? Олон хүн гар өргөнө дөө. Тэгвэл аль нам сонгуульд ялах магадлалтай бол? Хувьсгалт намын ард том хувь гараад ирнэ дээ. Энэ ойлгомжгүй харьцааг засах хариуцлагыг хэн хүлээх вэ? Ардчилсан нам. Мэдээллийн хаалттай орчинд дахин дөрвөн жил амьдрахыг хэн ч хүсэхгүй. Төвлөрсөн эрх мэдэл дороо цөөн компанийг дархалж буй бодлогыг нь бизнесийнхэн ч дэмжихгүй. Тэгвэл тулах хөрс нь байхад гар сунгах хүсэл дутуу улс төрийн байгууллагыг нам гэж болох уу?

В.Путиний улс орноо зангидсан бодлогыг оросуудын олонх өнөөдөртөө чухал гэж үзсэн хэвээр байна. Гэвч дандаа атганд багтаж амьдрахыг хорвоо дэлхийн хэн ч хүсэхгүй. Салхивчаа нээ, цэвэр агаар алга гэх яриа нэгэн цагт Оросын нийгэмд ч давамгайлах нь дамжиггүй. И.Хакамада, С.Глазьев нар Путинтэй өрсөлдөх болсонд Ерөнхийлөгч асан М.С.Горбачев ихэд олзуурхаж «Ийм зиндааны улстөрчид өнөөгийн Ерөнхийлөгчтэй өрсөлдөх нь ядаад сонгогчдын ирцэд сайнаар нөлөөлнө» хэмээн тайлбарласан байх юм. Нээрээ Орост ч тэр, Монголд ч ялгаагүй сонгуультай жилийн уйтгартай улс төр үргэлжилж байна. Яг өнөөдөр санал асуулга явуулмаар. «Та УИХ-ыг сонгох сонгуульд санал өгөх үү?» гэсэн асуулт тавибал олон хүн «Харин ээ, яадаг ч юм билээ...» хэмээн эргэлзэнэ шүү.

**Мэдээллийн  
хаалттай  
орчинд дахин  
дөрвөн жил  
амьдрахыг хэн  
ч хүсэхгүй.  
Төвлөрсөн эрх  
мэдэл дороо  
цөөн  
компанийг  
дархалж буй  
бодлогыг нь  
бизнесийнхэн  
ч дэмжихгүй.**

## АЛТАН ТОДОТГОЛ

Үйл явдлын тухай «нүцгэн» баримтууд чиний дэвтэрт хангалттай хуримтлагджээ. Их, бага тоонууд, хэлсэн үгс хөвөрсөөр байна. Тун ч чухал цифр, баримтыг чи гартаа хийжээ. Гагцхүү тэр олон хуудас дүүрэн тэмдэглэсэн «зүйлс» чинь амьгүй юм. Нэг л сааралтаад, түг таг оргиод эвлэж хоорондоо нийлэхгүй байгаа биз? Сонины сэтгүүлч байхын хяслан гэгч юу билээ? Үйл явдлын мэдээллийг телевизийнхэн аль эрт дамжуулчихсан хойно чиний материал маргааш өглөөний сонинд гараад ирнэ. Яг л өчигдөр идсэн хоолоо өнөөдөр дахиад таваглаж байгаа юм шиг золгүй сэтгэгдэл төрөх вий. Телевизийн мэдээллээс сонины материал өөр амттай байх ёстой. Бас цуглуулсан баримтууд чинь зүгээр нэг жагсаалын цэрэг шиг эгнэж байвал уншигч тэр материалыг гүйцээж харахгүй.

Энэ мөчид анд минь алтан тодотгол чамайг

аварна аа. Цэнхэр дэлгэц дээрх шиг дүрсээр давхар өгүүлж чадахгүй нь гэж яаран бүү бухимдаарай. Монгол хэлний тодотголын гайхамшгийг ашиглах цаг болсон. Тоо, тоо, ишлэл, яриа... За одоо энд л уншигч залхаж эхэлсэн дээ. Яг одоо тодотголоо шигтгээд өг. **«Афган салхины орон юм. Кабулд элсээр шуурч байлаа...»** Аль нь ч биш. Нэг л саарал өгүүлбэрүүд, ийм сурвалжлагыг хэн тэвчиж дуустал нь унших вэ дээ. **«Уулсын орны салхи гээг үсээр тоглон, элсэн энгэсэг хэдийнэ тавьж...»** Арай дээр боллоо. Гэхдээ илүү «гоё» болгох түмэн арга бий шүү. Том, жижиг, бүдүүн, нарийн гэсэн тэмдэг нэрийн цуглуулга ашиглах тухай яриа энэ огт биш ээ. Үйл явдлын тухай уран дүрслэлийг ямар ч байдлаар шигтгэж болно. Чамд камер байхгүй. Гэхдээ үгээр дүрслэх увьдас авьяаслаг залуу чамд бий. Асар хүчтэй тэр зэвсгийг ашиглаад үз. Сурвалжлага чинь сонины хуудас дээр амилан,

жагсаалд оролцогчийн дүрэлзсэн нүд, хилэнтэй хашгираан, уухилсан амьсгаа өмнөөс мэдрэгдэх вий. Ийм сурвалжлагыг гүйцээн уншилгүй орхих хүн үгүй дээ.

Гэхдээ амтлагчаа тааруулж хэрэглээрэй. Сайн баримт хэзээд материалын ноён нуруу байдаг. Харин тэрхүү баримтыг амилуулах дүрслэлийн дуусаж дундаршгүй боломжийн тунг сайн «тогооч» бол тааруулж чадна. Уншигч гэдэг яг хүүхэд шиг уйдамхай амьтан. Түүний анхаарлыг тасралтгүй барь. Дуу шуугианаар эхэллээ, тоо баримт, ишлэл, хандлага бичлээ, одоо дахиад чимээ анир өг, дүрслэлээ оруул, ойлгоход төвөгтэй шинэ цифр баримт орж ирсэн, энэ абзацын дараа уншигчийг амраа, зөөлөн сайхан дүрслэл эсвэл дуу алдам зураглал нэм. Ийнхүү амьсгаа байнга дээр байсаар чиний материалыг уншиж гүйцээвэл тэр сайн бичлэг болжээ гэсэн үг. Ийм

бичлэгийг манай ахмад сэтгүүлчид ус шиг урссан материал хэмээн магтаж ярих юм билээ. Гэхдээ тодотгож, дүрслэлийн хүч оруулна гэдэг худал давслахын нэр биш ээ. Хоосон гоё үгээр бөмбөгдсөөр байгаад дуусдаг бичлэг нойлын цаасны үнэтэй бол сайн баримт сайхан дүрслэлд уусахаараа сонины нимгэн хуудсыг өгүүлэшгүй үнэ цэнтэй эд болгодог.

Мэдрэхүй гэгч агуу чанарт хүрч чадаж байж л сэтгүүлч бид мэргэжлийнхээ эзэн болно. Нандин мэдрэмжийн хэрэгцээ бидний эргэн тойронд асар их бий. Сэтгүүлч бид нар салхи, бороо шороон дундуур туучин хатуужсаар сурвалжлагаа бэлтгэж байна. Гэхдээ тоос татсан гуталтай тууж явлаа ч торгон мэдрэмжээ битгий гээгээрэй. Бялуунд дурласан хүүхдийн нүдийг хараач. Элдэв чимэглэл, улаахан жимсгэнэ дээр л харц тороод байдаг даа. Уншигчийн сониуч зан үүнтэй яг ижилхэн.

**Тоос татсан  
гуталтай  
тууж явлаа  
ч торгон  
мэдрэмжээ  
битгий  
гээгээрэй.**

# Халуун сүү, жигнэмэг, и-мэйл хаяг, өхөөрдөм амлалтууд

О.Сүрэнгийн «Зимний сон»... Эндүүрч байна. Уг нь Алсугийн «Зимний сон». Яг дөрвөн жилийн өмнө энэ дуу Монголд хит болж байлаа. 63 дугаар тойргоос нэр дэвшигч, Суудлын вагон депогийн дарга О.Сүрэн тэгэхэд төмөр замын бяцхан тосгон даяар танил аялгуу түгээж, сонгуулийн сурталчилгаандаа хэмнэл нэмж билээ. Сэтгэлд тодхон дурдатгал үлдээснийг нь харав уу. Баянголын 63 дугаар тойргийнхон зуны эхэн сарын тунгалаг өглөө «Өвлийн зүүд»-ний аясаар цайлж, салхивч нэвтлэн уянгалах хит дуу хүртэл О.Сүрэнгийн талд татаад байсан биз. Хувьсгалт намаас нэр дэвшигч дөрвөн жилийн тэртээ улаан туузаар гоёсон вагончигоос ухуулга таниулгаа цацаж суулаа. Тэр өдрүүдэд төмөр замынхан өөрийн гэх орон сууцгүй даржин ядуу байв. Тэгвэл өнөөдөр хувь нийлүүлсэн нийгэмлэгийн байрыг өмчлөгчид нь шилжүүлэх ажил шувтрах шатандаа явна. Алсу ч моодноос гарч орхиж. О.Сүрэн ч эрхэм гишүүний зиндаатай үзэгдэнэ. Энэ удаа тэр модон вагончигоос дуу хуур цангинуулахгүй байж мэднэ. Шинэ өрсөлдөгчидтэйгээ өөр «аялгуугаар» үзэлцэх биз. Би 63 дугаар тойргийн хөдөлмөрчдийн нэг. Нэр дэвшигчид миний гэр бүлд, манай байрныханд юу амлах нь вэ?

Би 63  
дугаар  
тойргийн  
хөдөлмөрчдийн  
нэг. Нэр  
дэвшигчид  
миний гэр  
бүлд, манай  
байрныханд юу  
амлах нь вэ?

Амлалтын алтан бороо асгарах өдрүүд айсуу. Тойрог бүрт засах баярын ширээнүүд өөр өөр бялуутай. Бялууны чимэг өнгө өнгөөр ялгарна. Энхэл донхолтой энэ замыг засна аа гээд жимс нэмж орхино. Худаг гаргах бол ягаахан үрлээр чимж тэмдэглэнэ. Тоглоомын талбай байгуулах нэг нь буржгар шар чихэр бялуун дээрээ нэмээрэй. Эрхэм сонгогч бид хэд баярын ширээний ард бүтэн сар шахам суух нь. 2004 оны парламентын сонгуульд халз үзэх хоёр гол нам таныг, танай гэр бүлийг анхаарлын төвдөө авахаар зэрэг зэрэг амлалаа. «Өнөөдрийн дарамтыг хална. Өрх гэрийг тэтгэнэ» гэж «Эх орон-Ардчилал»-ын нэр дэвшигчид шүлэглэсэн бол эрх баригчид «Таны төлөө, тантай хамт» хэмээн хажууд минь үргэлж байхаа зарлав. Нэр дэвшигчид мөрийн хөтөлбөр гэх багахан төлөвлөгөөг өнгөтөөр хэвлүүлээд хаалга үүдэнд хавчуулаад явах болжээ. Гэхдээ тэдгээр нь намынхаа жанжин шугамын дагуу бэлтгэгдсэн. Ийм хөтөлбөр байхад нэр дэвшигч болгон хувь хувьдаа бас нэг баримт бичиг үйлдэж юу хийнэ гэх бодол өөрийн эрхгүй төрөх юм. Гэвч намд бус, хэн гуайд санал өгөх гаж марафон гараанаасаа хэдийнэ хөдөлжээ. Сонгогчдод зориулан бэлтгэсэн үндсэн баримт бичгийн агуулгад анхаарал хандуулах цаг боллоо. Том намууд бидэнд жижиг гэж гололгүй олон янзын бэлэг сюрприз цуглуулаад боож орхив. Эрхэм сонгогч таны хүүхэд энэ жил нэгдүгээр ангид элсэх бол баяртай мэдээ дуулгая. Азтай нэгдүгээр ангийнханд хичээлтэй өдөр нь МАХН халуун сүү, жигнэмэгтэй өгнө. Харин өдий болтол электрон шуудангийн хаяггүй яваа хүн байвал «Эх орон-Ардчилал» эвслийнхнээс и мэйл хаяг аварай.

## «ЭХ ОРОН-АРДЧИЛАЛ»-ЫН БАЯРЫН ШИРЭЭНД

Хүүхдээр нь дамжуулан өрх гэрийн амьдралыг өөд татахаа тус нам тодрууллаа. Эдний нэр дэвшигчид айл гэрийн амар амгалан амьдралын төлөө гэж олонтаа ярина гэсэн үг. Эвслийнхэн Хувьсгалт намыг дууриаж моод хөөсөн зүйлгүй. Бүр 2000 оны УИХ-ын сонгуульд оролцохдоо Ардчилсан нам нийгмийн анхдагч нэгж-гэр бүлийн амьжиргааг дээшлүүлэхээр амлаж байсан



юм. Тус нам дөрвөн жилийн өмнө сонгогчидтой байгуулсан гэрээндээ «Бидний анхаарлын төвд өрх гэр-гэр бүл байх болно. Аливаа гэр бүл, өрх гэрт учирч байгаа зовлон жаргал биднийх, манай намынх. Энэ бол манай баримталдаг үзэл санааны үнэт зүйл мөн» гэж тэмдэглэсэн.

Ерээд оны дундаас Монголд хэрэгжүүлсэн ядуурлыг бууруулах том төсөл үр дүн багатай шувтарч, орлого багатай айлуудад 100-200 ам.доллар зээлдүүлэн тараасан арга хэмжээ ирээдүй муутай нь ойлгогдсон үед «өрхийн амьжиргаа» гэсэн үг анх моодонд орсон юм. Тэр цагаас өнөөдрийг хүртэл намууд гэр бүлийн сайн сайхны төлөө сэтгэл тавьдаг загвартай болсон. 2004 оны хувьд тус нам эвслийн гэрээ бус, мөрийн хөтөлбөр хэмээн үндсэн баримт бичгээ нэрлэжээ. Үүнээс өмнөх сонгуулиудад Ардчилсан нам зөвхөн гэрээ байгуулсан. «Иргэд, эвслийн хооронд амьд холбоо тогтоох зорилготой» гэж гэрээнийхээ утга учрыг тодруулсан удаатай.

Парламентын шинэ сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрт нь залгамж амлалтууд ч харагдана. Тэртээ 1996 оны хавар ардчиллынхны ярьж хэлсэн чухал санаа энэ удаагийн төлөвлөгөөнд мөн л багтсанд баяр хүргэе. «Техник мэргэжлийн сургалт явуулах замаар ажилгүйдлийг багасгана» гэсэн зорилт өнөөдөр ч үнэ цэнэтэй хэвээр байна. Малаас өөр орлогын эх үүсвэргүй өрхийг бүх төрлийн татвараас чөлөөлнө гэж найман жилийн өмнө зарлаж байсан. Тэгвэл өнөөдөр нийт малчдыг бүх татвараас хөндийрүүлэхээ зарлалаа. Хүн амын гуравны нэгийн санал гэдэг гэднээс төсөвт өгдөг орлого буюу 1.6 тэрбум төгрөгтэй харьцуулбал хамаагүй чухал үзүүлэлт гэнэ. Эндээс Эвслийн мөрийн хөтөлбөр эдийн засгийн гэхээсээ улс төрийн хангалттай тооцоон дээр хийгдсэн нь тод харагдана. Цэнхэр хавтастай бяцхан номонд авангард санаанууд шингэснийг ч дуулгая. «Ашигт малтмалын орд газар, нутаг дэвсгэрийг гадаадын, олон улсын компаниудад түрээслэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ», «Түүхий ноолуурын үнийг нэг кг нь 30.000 төгрөгөөс бууруулахгүй байх. Зах зээлийн үнэ үүнээс доогуур орсон тохиолдолд Засгийн газар худалдан авна» гэсэн санаачлагыг лав МАХН хэзээ ч эхлэн дуугарахгүй дээ. Дэндүү эрсдэлтэй сонсогдож байна.

Дэлхийн зах зээл дэх үнэ ханшийн таатай орчинд МАХН Засгийн эрх барьж буй. Боломжийн хэтэвчнийхээ хэрээр нүдэнд торохуйц хөрөнгө оруулалтууд хийсээр. Олон нийтийн муугүй дэмжлэг дор үйл ажиллагаагаа явуулж буй эрх баригчидтай сөрөг хүчин хэрхэн өрсөлдөх учиртай вэ? Ийм нөхцөл дундаас Эвслийн хөтөлбөр дэх популист санаанууд мэндэлжээ. Гэхдээ Хувьсгалт намын эхлүүлсэн болгоныг улайран баллаагүй харагдана. Ч.Улаан сайдын «төрүүлсэн үр» гэх шахаж буй Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн санааг Эвсэл бүр 2000 оны мөрийн хөтөлбөртөө дэмжиж байлаа. Харин уг хуулийг хэрэгжүүлэх явцад гажуудал гарсныг шинэ сонгуулийн өмнөхөн олон нийтэд зарлаад байна. «Нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийг улсын төсвийн орлого, зарлагад хамааруулж, төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах нь нийгмийн хамгааллыг эрсдэлд оруулж байгаа учраас энэ үйл ажиллагааг зогсоож, төр дээрх сангуудыг даатгалд авах нь зүйтэй» гэсэн ажил хэрэгч өгүүлбэр харагдав. Гэхдээ төвлөрлийг буруутгасан үг цухуйлгасангүй.

Сөрөг хүчнийхний дөрвөн жилийн турш өгүүлсэн шүүмжлэлийг шингээсэн, хүч тэнцвэргүй өрсөлдөөнд барьж орох баримт бичиг гэхэд үндэслэл бүхий тодорхой санаанууд дутагдсаныг давхар хэлье. «Өнөөдрийн дарамтыг халъя» гэх сурталчилгааны уриагаа ялимгүй тодруулсан бол сонгогчдын «загатнасан газар маажих» байсан биз. Авлига авсан албан тушаалтанд хуулийн хатуу цээрлэл үзүүлэх тухай өгүүлбэр эрхгүй анхаарал

**Олон нийтийн муугүй дэмжлэг дор үйл ажиллагаагаа явуулж буй эрх баригчидтай сөрөг хүчин хэрхэн өрсөлдөх учиртай вэ? Ийм нөхцөл дундаас Эвслийн хөтөлбөр дэх популист санаанууд мэндэлжээ.**

татна. Гэвч үндэсний олигархууд бодитой болж буйг хүчтэй сануулж чадсангүй. Улс төр, бизнес сүлбэлдэн, дээр нь телевизүүдийг гартаа барьсан орос маягийн олигарх амьдралын дүр зургийг олон нийт мэдэрч л байгаа. Ийм үзэгдэл газар авахын үр уршгийг өнөөдөр дэлгэн, дохио сануулга өгөх нь зөвхөн сөрөг хүчний төдийгүй үндэсний эрх ашигт тустай юм.

Мөрийн хөтөлбөрийн хуудаснаас хог ялган боож буй хүмүүсийн дүрслэл ургаад ирэв. Хог хаягдлын анхан шатны боловсруулалтыг ажилгүйдэлтэй холбож шийдвэрлэх санааг шингээжээ. Гэр бүлийн хоёр уужуу амьсгалж болох гэнэ. Тэдний цалин тус бүрээс орлогын албан татвар суутгахгүй. Өрхийн нэг хүнд ногдох орлогыг тооцож байж татвар авах цоо шинэ алхмыг Эвсэл санал болголоо. Гэргий, нөхөр хоёр «Нээрээ, дажгүй сонсогдох чинь...» хэмээн бодлогошрох нь мэдээж.

### МАХН-ЫН БЯЛУУГ АМТЛААРАЙ

Манай хоёрыг эргэлзэж суух зав өгөлгүй Хувьсгалт намын баярын бөмбөлгүүд хөөрөөд эхлэв. Нийслэлийн гудамжинд өнгө нэмэн яралзгал инээмсэглэх эдний нэр дэвшигчдийн зурагт хуудсууд, тод улаан, гүн хөх, цав цагаан сүлэлдсэн сурталчилгааны самбарууд нэг л хүчирхэг, итгэл үнэмшил төрүүлэхүйц үзэгдэнэ. Эрх баригчид 2000 оны сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтийн гол үр дүнг бататган үргэлжлүүлэх, ахиулах чиг шугам баримтална гэж нухацтай зарлав. Эргэн тойронд амьдрал алхам алхмаар урагшилж, бүтээн байгуулалтын чимээ нүдээ аньж, чихээ бөглөсөн ч сонсогдож буй цаг үе. Ийм орчинд Хувьсгалт намын «**үргэлжлүүлнэ, бататгана**» гэсэн цохолт Эвслийн «**цоо шинэ**» хэмээх тодотголтой өрсөлдөж байна. Харьцуулбал, болгоомжилсон «даруу» амлалтууд эрх баригчдын мөрийн хөтөлбөрт түлхүү оржээ. Эдийн засгийн өсөлтийг долоогоос доошгүй хувьд хүргэнэ, цаашдын тогтвортой өсөлтийг хангах гэнэ.

Тэгвэл Эвсэл 6-10 хувийн өсөлтийг боломжтой хэмээн үзжээ. Азийн хөгжлийн банк Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 2005 онд зургаан хувь байхаар урьдчилан тандсан нөхцөлд болгоомжлол илүүц биз. Энэ удаагийн сонгуульд ялна гэдэгтээ МАХН итгэлтэй байгаа бололтой. Тиймээс ч популист, оноо авах гэсэн хоосон үг өгүүлбэрийг мөрийн хөтөлбөртөө бараг оруулсангүй. Ерөнхийдөө тэд эхэлсэн их үйлсээ үргэлжлүүлэх, чингэх явцдаа хүний хөгжил, гэр бүлийн тогтвортой амьдралын төлөө л зөвхөн амьсгалах гэнэ. «Ажлын байр-амьдралын баталгаа» үзэл санааг Эвслийн «Итгэлийн мөнгө»-тэй сөргүүлэн тавив. Залуу үе бэлэнчилж бүү амьдраг, ажиллаж хөдөлмөрлөх нь хамгаас чухал хэмээн ярьцгааж байна. Хүнд суртал, хээл хахуульд автсан гэх, хаалттай засаглалынхаа ваакумыг зөөллөх аливаа амлалтад мөн л үг өгүүлбэр харамлаагүй шиг санадав.

2004 оны парламентын сонгуульд өрсөлдөх хоёр гол намын мөрийн хөтөлбөрийг ийнхүү ижилхэн «нийгмийн баримжаа» сайтай туурвижээ. Ойролцоо санаанууд ч олон. Агаарын тээврийн үйлчилгээг хямралаас гаргах гарц нь ирланд эр Брендэн Донохью бус, хувийн хэвшлийн оролцоо гэж намууд адилхан дуугарав. Агаарын бохирдлыг багасгах чиглэлээр хэн хэн нь ойролцоо шахуу арга хэмжээ авах нь. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монголын дайчид оролцсоор байна. Аль ч засаглалын үед манай ийм байр суурь хөдөлбөргүй мөрдөгдөнө. Одоо юу хэлэх гэж байгааг минь татвар төлөгчид цээжээр давтана даа. Сонгууль болгоны өмнө, нам бүрийн мөрийн хөтөлбөрт татварын дарамтыг яана яана гэдэг билээ дээ. Түүнээ л МАХН, Эвсэл хоёр өгүүлсэн харагдав. Залуус, хүүхэд, шинэхэн хосуудыг аль аль нь алган дээрээ

Үндэсний  
олигархууд  
бодитой болж  
буйг хүчтэй  
сануулж  
чадсангүй. Улс  
төр, бизнес  
сүлбэлдэн, дээр  
нь телевизүүдийг  
гартаа барьсан  
орос маягийн  
олигарх  
амьдралын дүр  
зургийг олон  
нийт мэдэрч л  
байгаа. Ийм  
үзэгдэл газар  
авахын үр  
уршгийг өнөөдөр  
дэлгэн, дохио  
сануулга өгөх нь  
зөвхөн сөрөг  
хүчний төдийгүй  
үндэсний эрх  
ашигт тустай  
юм.

бөмбөрүүлэх нь ээ. Арван мянга, 500.000, 100.000 төгрөгийн тэтгэлгүүд залуу чамайг хүлээж байгаа. Харин тэдгээр тусламжид зарцуулах хөрөнгийг хаанаас гаргах вэ хэмээн улстөрчид өөр зуураа хэрэлдэж эхэлсэн. Танайх тэндээс, манайх эндээс гэгцгээх аж. Гэвч эрх барих хүчний хэтэвчний хэмжээг дэлхийн зах зээлийн орчин урьдчилаад хэлж өгч байна биш үү.

## ХЭТЭВЧИЙГ НЬ ТАНДЬЯ

Өгнө, хийнэ, амлая, таны төлөө гэх үгсийн цаана мөнгөний дүн бий. Улсын төсвөөс мөнөөх хөрөнгө гарах учиртай. Тэгвэл төсөв өөрөө хийж бүтээсний маань хэмжээнээс төдийгүй дэлхийн зах зээлээс хамаарч байна. Ерээд оны хамгийн азтай Засгийн газраар П.Жасрайн танхимыг нэрлэе. Зэсийн үнийн оргил үе буюу нэг тонн нь 3000 ам.долларын заалт хүрсэн өдрүүдэд Монгол Улсын ДНБ-ий өсөлт 6.3 хувьд хүрч гялалзсан амжилт тогтоожээ. Энэ оныхыг ч давсан үзүүлэлт байгаа биз? Нийт экспортын тал хувийг ганцхан «Эрдэнэт» нуруундаа үүрч, зэс монголчуудын авралын од, шүтээн байлаа. Дэлхийн зах зээл дэх үнийн уналтын эхний цохилт 1998 онд тохиолдов. Монгол Улсын эдийн засгийн өсөлт тэр дороо 3.5 хувь хүртэл ухарсныг санаарай. Цалин хөлс, үнэ ханш, инфляцийн үзүүлэлтүүд шалдаа унаж, хэтэвч хоосон Засгийн газраас олон нийт нүүр буруулсан юм. Эвслийн Засгийн газрын азгүйдлийн өдрүүдийг мөнөөх ханшийн график далласан. «Эрдэнэт»-ээс төсөвт нэг ч төгрөг орохгүй шүү хэмээн Сангийн сайд Б.Батбаяр хэлж билээ.

Өнөөгийн эрх баригчид ч 2001 оны намрын «хар» өдрүүдийг мартаагүй дээ. Лондонгийн металлын биржийн дилерүүд зэсийн үнийн хоёр дахь уналтын гэрч болов. Мөн оны арваннэгдүгээр сард тонн зэс 1336 ам.доллар болох нь тэр. Гэтэл ийм хэмжээний зэс гаргахын тулд 1600-1700 ам.долларын зардал гаргадаг шинэ дээ. 2002 оноос эхлэн үнэ ханшийн савлагаа бага багаар саарлаа. Эдүгээ шинэ Засгийн газрын үйл ажиллагаа жигдрэх эхний өдрүүдэд дахин огцом савлаж айлгахааргүй төлөвийг шинжээчид өгүүлж байна. Алтны хувьд ч ялгаагүй. 2005 оны төсвийг бэлтгэх үеэр буюу энэ оны аравдугаар сард нэг унци алт 389 ам.доллар орчим байхыг мэргэжилтнүүд таамаглалаа. Харин хар алтны хувь заяа шинэ Засгийн газарт байнгын асуудал тарих бололтой. ОХУ Дэлхийн худалдааны байгууллагад юу юугүй элсэх нь тодорхой болж, элдэв амлалт үүрэг авч эхэлснийг анзааръя. Юуны өмнө тус улс нефть бүтээгдэхүүнийхээ үнийг бие даан тогтоодог байсан толгой мэдсэн тоглоомноосоо татгалзана. Нефть экспортлогч дэлхийн бусад оронтой зөвшилцсөний эцэст баримтлах тэрхүү үнэ тариф нь дотоодын шатахууны ханшид хатуухан нөлөөлөх юм. Аажмаар дэлхийн зах зээлийн жишгээр бид бензинээ худалдаж авдаг болбол төрийн төдийгүй иргэдийн хэтэвч нимгэрнэ.

Нэр дэвшигчдийн сурталчилгааны өнгөнд нүд эрээлжилсэн эрхэм сонгогчид сануулах бас нэг зүйл бий. ОХУ-д төлөх их өр цаасан дээр үгүй болж орхисон. Харин үр дагавар нь буюу Засгийн газраас гаргасан бондын төлбөр лав оны үлдэх өдрүүдэд халаас чангаасаар байх юм. Та сурталчилгааны сонин гарчиглаж, гэргий хүүхэдтэйгээ хамт сонжиж л суугаа байх. Тэнд дурдсан өгөх, хийх тухай амлалт сонгуулийн хугацааны төгсгөл хавиар хэрэгждэгийг эрхбиш одоо гадарлана биз ээ. Тээврийн товчооноос «Варьете» чуулгын байр хүрдэг бартаат зам саявтархан нүд ирмэх зуурт толийн, бараг хурдны зам болж хувирсныг 63 дугаар тойргийнхон мэднэ.

Шинэхэн Засгийн газрыг юм юм ивээн тэтгэж, алгандаа бөмбөрүүлэхгүй нь мэдээж. Цэцэглэн хөгжиж буй Хятадын эдийн засагт ойрын үед хямрал нүүрлэж болзошгүйг судлаачид таамаглаж байна. Хатуу валютын тоймгүй их урсгалыг эргээд тус улсын эдийн засаг багтааж шингээхэд төвөгтэй болох гэнэ.

**Хөөрүү  
бяцхан  
шувуухай толгой  
дээгүүр эргэн,  
шинэхэн ногоон  
өнгө сэтгэл  
зөөллөсөн  
улирлын  
сайханд  
амлалтын бороо  
асгарч, бид хэд  
чинь юутай  
жаргалтай  
алхана вэ.**

БНХАУ-ын эдийн засагт хямрал нүүрлэвэл бидний амьдралд ч мэдэгдэхүйц нөлөөлнө. Энэ бүхнийг харьцуулж харан ирэх дөрвөн жил танд үйлчлэх эрхмийг сонгоорой гэж зөвлөе. Нэр дэвшигчдийн үгэнд итгэвэл бага хүүхдүүд тань «цалинтай» болж, гэрлэх насных нь ч мөнгө «чирж» ирнэ. Та хэдтэй нэг байранд чихэлдэхгүй тусдаа амьдрах ч янзтай. Нам болгон орон сууцны зээл амлаад байна. Хот маань хогийн саваар «дүүрч», 2008 он гэхэд хятад төмс хоолонд хэрэглэхээ болино. Жаалууд чинь хичээл дээрээ сүү уугаад л... Гэхдээ анхааралтай сонсоорой. «Манай намд санал өгвөл Монгол Улс төсвийн алдагдалгүй болно» гэж 2000 оны хавар нэг том нам «бүлтэрсэн» удаатай.

Амлалтын алтан бороон дунд тарвалзах өдрүүд ирлээ. Хараацай ч бас хэдийнэ хүрээд иржээ. Хөөрүү бяцхан шувуухай толгой дээгүүр эргэн, шинэхэн ногоон өнгө сэтгэл зөөллөсөн улирлын сайханд амлалтын бороо асгарч, бид хэд чинь юутай жаргалтай алхана вэ. Ийм өдрүүд нэг сар хэртэй үргэлжилнэ. Ганц сар ч гэсэн яахав, талх тариа, аж ахуйн ажлаа орхиод, хараацай дагаад хөөрөх үү? Өнөөдрийн дарамтыг хална, өрх гэрийг тэтгэнэ, таны төлөө, тантай хамт гэсэн шүү!

**2004 он**

# Хорин хэдэн тэлээ хургаа хонь болгох уу, нядлах уу?

Ардчилсан намын дарга Р.Гончигдоржийг МАХН бүлгийнхээ дэд даргаар «тавих» эсэхийг даваа гаригт шийднэ. Гүйлгээд харахад ойлгомжтой өгүүлбэр. Гүйцэд тунгаага гэвэл тун төвөгтэй. Монголын улс төрийн талбарт тоглогч том намын дарга, бас тэрхүү намынхаа мөнхийн өрсөлдөгч хүчний бүлгийн дэд нь. Тэлээ хургаа шиг тэр хоёр намын нөмөрт өвөлжиж, хаваржив. Өсгөлүүн, танхи ч болж. Ийм хувь заяаг АН-ын 19 болон бусад намын дөрөв сонгоод бас тэлээ хургаа нэр зүүж явна. Нөмөр нөөлөг хайн их сүрэг бараадаагүй, ирээдүй хөгжил дэвшлийн төлөө яваад хоёр эхтэй болсон билээ, бид хэмээх цагаатгал тэднийг дагалдана. Гэвч тэлээ хургаа өсөж өндийхийн хэрээр цаг хугацаа тэднээс өөрийн сонголт хийхийг шаардаж эхэллээ.

«Угаасаа өнөөгийн улс төрийн нөхцөл байдлын учрыг бид өөрсдөө ч ойлгохоо больсон» гэж УИХ-ын гишүүн Ж.Наранцацралт телевизээр хэлж билээ. Тэр үнэнээ л өгүүлж. Дээдэх нь ийм бантан дотор зууралдсан байхад сонгогч бид яалтай. Дэмий л тэдний ярилцлагыг шүүрдэн уншиж, өөрсдийнхөөрөө харьцуулж дүгнэхээс, хоорондоо талцаж маргалдахаас хэтэрсэнгүй. Гэхдээ ойлгомжгүй гээд, үүнээс өөр гарцгүй хэмээгээд суух аргагүй цаг мөч иржээ. Хургаа, хургачин хоёр тонгочиж тоглоод явах цэнхэр өдрүүд улирлаа. Яргуй хэнзэрсэн энэ хаврын түмэн үйл явдлын оргил нь тэрхүү Гончигдоржийг МАХН-ын мэдлийн албан тушаалаас чөлөөлөх эсэхийг шийдэх хурал. Оноогоо ч юмуу, эмгэнэл ч бил үү, ухаарал ч гэнэ үү, учирлал ч байх уу ялгаагүй энэ явдлыг буруу, зөвийн дэнсэнд шүүгээд маргаад байх нь утгаа утгагүй болов. Харин дараагийн бужигнааны эхлэл болгон болгоомжлох цаг.

Р.Гончигдорж улаан, цэнхрийг хослуулж явахаа болих эсэх тухай эл шийдэл түүний араас замнасан АН-ын арван есийн, мөн үлдэх зургаагийн хууч өвчнийг сэдэрлээ. Өнөөдөр оношоо тодруулахгүй юм бол тэд чухам хэн юм бэ? Улаан бадамлянхуа энгэртээ халсан МАХН-ын бүлгийн төлөөлөгч юм уу? Цэнхэр тугны ишнээс атгалцсан АН-ын журмын нөхөр үү? Ерөнхийлөгчийн сонгуулийн өрсөлдөөн улаан, цэнхрийн холимог, уусмал дээр өрнөхгүй. Н.Энхбаяр, М.Энхсайхан нар өөрсдийн өнгө төрх, үзэл баримтлалын хоёр талд гарч зогсчихоод байна. Энэхүү ялгарал тэлээ хургыг «том болж толгой даахыг» шахаж эхэллээ. «Тогтвортой төр» хэмээх нэр дэвшигч Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудаст байхгүй. Эдүгээ сонгуулийн марафоны өнгө аясыг тодорхойлох нэг шийдэл нь 62-ын бүлэгт харьяалагдаж буй хэдийн байр суурь. Жишээ нь С.Баярцогт хоёр намд «тэгш» зүтгэсэн сөөсгөр бяцхан хэвээр үлдэх үү. Эсвэл... Тэлээ хургануудыг тэжээгээд хонь болгох уу, «нядлаад» намаа цэвэрлэх үү гэдэг асуултын өмнө МАХН бас ирээд байна. Их том зорилгын төлөө эр зориг гаргасан гэх тэдгээр гишүүдийг тэлээ хургатай зүйрлэж буйгаа цагаатгах учраа хэлье.

«Өнөөдөр» сонин өмнө нь олонтаа бичсэн шиг, яргуйн хувьсгалын давлагаанд их далайдаа тэсч үлдэх нь үлдэж, эрэг холын газар шидэгдэх нь шидэгдэж, дахин хуваарилалтын өмнө иржээ. Чи хэн бэ? Үзэл бодол, байр сууриа хадгалж үлдэх, халж өөрчлөх нь гэмт явдал биш. Чи хэн болохоо ойлго, тэгээд бусдад ойлгуул. Ердөө л энэ.

**Монголын улс төрийн талбарт тоглогч том намын дарга, бас тэрхүү намынхаа мөнхийн өрсөлдөгч хүчний бүлгийн дэд нь. Тэлээ хургаа шиг тэр хоёр намын нөмөрт өвөлжиж, хаваржив. Өсгөлүүн, танхи ч болж.**

Хүссэн ч, эс  
хүссэн ч УИХ  
дахь 62-ын  
бүлэг  
Ерөнхийлөгчийн  
сонгуулийн  
компанийн  
дэлгэц дээр  
задрах үйл явц  
эхэлж байна.

Хүссэн ч, эс хүссэн ч УИХ дахь 62-ын бүлэг Ерөнхийлөгчийн сонгуулийн компанийн дэлгэц дээр задрах үйл явц эхэлж байна. Үүнийг МАХН парламентад олонх байх эсэхийг шийдэх мөч ч гэж ойлгож болно. 25-аас «хонь болгоод» авах нь хэд бол? УИХ-д олонх байхын тулд МАХН-д шинэхэн гишүүд хэрэгтэй. Харин тэлээ хэдээ МАХН «нядлаад» холдуулбал АН-д мэдээж ашигтай. Р.Гончигдоржийг «авч хэлэлцэх» хурлын үргэлжлэл энэ мэтээр сунжрах төлөвтэй. Үүнтэй зэрэгцээд үзэл баримтлал, холбоо сүлбээнийхээ учир заагийг яргуйн хувьсгалын явцад бүдгэрүүлж орхисон «Эх орон» нам ч биеэ засах биз. Үгүй бол тэд өөрийн гэх тод өнгө муутай болж орхисныг олон нийтийн санал асуулгуудын дүнд намын дарга Б.Эрдэнэбатын авч буй муухан үзүүлэлтүүд гэрчилнэ. ИЗН ч хэн болохоо эртхэн таньж, сонгогчдодоо тайлбарлахгүй бол авлигатай тэмцэж олж авсан нэр нүүртээ SALE зарлах нь. АН-ын эгнээ бат цул гэдэгт гишүүд нь ардчиллын 15 жилийн уртад хариулж мэдэхгүй хэвээр хоцрох уу. Нэг үгээр, Монголын улс төрийн намууд төлөвшсөн, төрхөө олсон эсэхийг сорих өдрүүд Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө үргэлжилнэ.

Олон түмний эргэлзэж тээнэгэлзсэн асуултуудад хамгийн түрүүнд Ц.Элбэгдорж хариу өгөхөөр шийджээ. «Шүүмжлэлийг би өөр дээрээ хүлээж авч болох юм» гэх зэргээр тэрбээр АН-ын Үндэсний чуулганы төлөөлөгчдийн өмнө зөөлөн дуугарсан аж. Тун саяхан зөвшлийн Засгийн газрын зөв зүйтэйд бат итгэлтэй явсан тэрбээр шүүмжлүүлэх зүйл бийг хүлээн зөвшөөрч өрсөлдөгчдөө барьц олгон, сиймхий тавьж өгсний учир юу юм бол? Танхимыг нь огцруулах МАХН-ын сценарыг чимээгүй дагаж, улмаар АН-ын гишүүд дунд тодорхой хэмжээгээр унасан нэр хүндээ сэргээх, үзэл баримтлалаа тодотгох мөч ирснийг мэдэрснийх биз.

Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчид тодорч кампанит ажил эхэлж буй дүр зураг өнгөц харахад үзэгдээд байна. Үүнтэй зэрэгцээд айсуу тавь орчим хоногт 62-ын бүлэгт нэгдэгсэд хэн нь хэн болохоо ойлгуулах, улмаар УИХ-д хүчний харьцаа цаашид хэрхэн хуваарилагдах, зөвшилцлийн Засгийн газрын хувь заяа шийдэгдэх зэрэг ээдрээт үйл явдал давхар өрнөх бололтой.

2005 он

**62-ЫН БҮЛЭГТ БАГТАЖ БУЙ АН-ЫН БОЛОН ИЗБНН,  
«ЭХ ОРОН» НАМЫН ГИШҮҮД, БИЕ ДААГЧИД:**

- |                 |                  |
|-----------------|------------------|
| 1.Р.Бадамдамдин | 14.С.Ламбаа      |
| 2.А.Бакей       | 15.Б.Мөнхтуяа    |
| 3.Б.Батбаатар   | 16.А.Мурат       |
| 4.Б.Батбаяр     | 17.К.Сайраан     |
| 5.Н.Батбаяр     | 18.Ч.Содномцэрэн |
| 6.Г.Батхүү      | 19.М.Сономпил    |
| 7.Д.Бат-Эрдэнэ  | 20.М.Зоригт      |
| 8.Ц.Баярсайхан  | 21.С.Оюун        |
| 9.С.Баярцогт    | 22.Х.Баттулга    |
| 10.Л.Гансүх     | 23.Р.Эрдэнэбүрэн |
| 11.Л.Гантөмөр   | 24.Д.Одхүү       |
| 12.Д.Ганхуяг    | 25.Я.Санжмятав   |
| 13.Р.Гончигдорж |                  |



# ДУМ тэгшитгэлийн, УИХ эрлийз хувилбарыг сонголоо

Оросуудын дассан сонгуулийн тогтолцоог ийм огцом өөрчлөх ёсгүй. Нэг мандаттай тойргийн системийг аажмаар пропорциональ хувилбарт уусгах учиртай гэж ДУМ дэх «Нэгдсэн Орос» хөдөлгөөний лидерүүдийн нэг Олег Морозов мэдэгдэв. Ийм мэдэгдлийг тэрбээр бүр Цагаан сарын өмнөхөн хийж байсан ба ДУМ-д суудалтай «Нэгдсэн Орос»-ын 60 гишүүний байр суурийг ноён Морозов илэрхийлсэн юм. Гэвч өнгөрсөн долоо хоногт ОХУ-ын парламентын доод танхимын 450 депутатын олонх сонгуулийг пропорциональ системээр явуулах нь зөв гэж үзлээ. Хувь заяаны төөргөөр хөршийнд болсон явдал манайд, эсвэл эх нутагт маань туулаад өнгөрснийг Орос оронд шил даран давтсан тохиол цөөнгүй. Монголчууд ч парламентаа сонгох үйл явцыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэв. УИХ-ын 2004 оны сонгуулийн кампани, нэр дэвшүүлэлт, үр дүн, өнөөдөр Монголын улс төрд нүүрлэсэн дампуурал энэхүү өөрчлөлтийг далласан юм. Өнгөрсөн жилийн өдийд юу боллоо доо хэмээн биднийг халаглаж суух зуур Ерөнхийлөгчийн сонгуулийн ээлжит дуулиан төрийн ажлыг дахин чөдөрлөөд байна.

## ТӨР ЭЗГҮЙРЭВ

Хаврын чуулганы ирц, Байнгын хороодын хуралдаан, том бүлэг доторх зөвшилцөл хэмээгч утга учраа алдан, гишүүд Монголын тал нутгаар нэг таран одов. УИХ-ын гишүүний үүрэг хариуцлагаас илүү намын даалгавар гойд чухал болсон гэнэ. Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж буй дөрвөн хүнийг дагаад хууль тогтоогчид дөрвөн зүг, найман зовхист нисэн оджээ. Энэ мөчид Ерөнхий сайд, Ерөнхийлөгч нар гадаад томилолттой, УИХ-ын дарга сонгуулийн кампанит ажлын хуваарьт дараастай орон нутагт явна. Хаврын чуулганыг завсарлуулан, нэр дэвшигчээ дасгалжуулахаар гишүүд хөөрцөглөж байна. Монгол Улсын засаг захиргааны нэгжийг өөрчлөх нүсэр ажлыг Засгийн газар эхлүүлэхээр ханцуй шамласнаа больчихов. Ерөнхий сайд бичиг цаасаа буцаагаад ширээнийхээ нүдэнд хийж орхиод хилийн чанадыг зорилоо. «Яршиг зүгээр, яваад өгөх минь» хэмээн дотроо хараал тавьсан ч байж мэднэ. Засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг хэрхэн хийх нь оновчтойг олон нийтээр хариугүй хэлэлцүүлэх гэж байснаа азнав.

### -Яасан?

-Намын даалгавар. Түр хүлээ. Ерөнхийлөгчийн сонгууль өнгөрөг. Олны санаа бодлыг одоо үймүүлбэл эрсдэлтэй гэцгээлээ.

Сонгууль аль нэг талд амжилттай болж өндөрлөвөл зардал чирэгдэл, төсөв мөнгө падгүй гэх аж. Энэ бүхэн юуг илэрхийлнэ вэ? Сонгогдож, ялж л чадвал наана цаана нь цалгардах төрийн ажил алба, хөрөнгө мөнгө, нэр нүүр гэж ер алга. Сонгуулийн синдром тал нутгийг бараг жил хагасын уртад нөмрөөд, залгах гурван жилд нь хэрүүл хямрал эсвэл нэг намын нарийн зохион байгуулалттай дарангуйлал дагуулах болов. Сонгууль болгоны эцэст хуулиа муучилж, өөрчлөхөөр ханцуй шамлаж байсны учир энэ. 2004 оны УИХ-ын сонгуулийн дараа хууч өвчин дахин сэдэрлээ. Хуульдаа өөрчлөлт хийхгүй бол төр дархлаа муутай болж эхэлснийг нийтээр хэлэлцэв. Ингээд УИХ-ын сонгуулийн тухай хуулийг шинэчиллээ. Уг төслийн тухай ерөнхий мэдээллийг та бид авч байгаа. «Өө болж байна» гэлгүй, түүнийг өнгийж сайтар харцгаая.

Сонгуулийн синдром тал нутгийг бараг жил хагасын уртад нөмрөөд, залгах гурван жилд нь хэрүүл хямрал эсвэл нэг намын нарийн зохион байгуулалттай дарангуйлал дагуулах болов.

Бусдын жишээтэй ч харьцуулья. ОХУ-ын ДУМ-ийн доод танхимыг мажоритар системээр дөрвөн удаа сонгосон атал өнөөдөр яагаад гэнэт хувь тэнцүүлэх зарчмыг илүүд үзсэн юм бол?

### ЦОО ШИНЭ ЗҮЙЛ ҮҮ?

Монгол Улс парламентаа дан ганц мандаттай тойргоос бус, олон мандаттайгаас ч биш, эдгээрийн дундаж хувилбараар сонгох нь зүйтэй гэж хууль санаачлагчид үзжээ. Өөрөөр хэлбэл 38:38 гэсэн шинэ томъёо уншигч Танд содон харагдаж байгаа. 38 гишүүнийг өнгөрсөн хаврынх шиг сонгоно. Тэд бол ганц мандаттай тойрогт өрсөлдөгчид. Үлдэх 38 хүнийг тодруулах ажил жаахан залхуутай. Тэвчээр муутай нэгэнд бол тэр олон нам, эвслийн нэр дундаас ганцыг дугуйлах нь төвөгтэй байж мэднэ. Хамгийн эхнийхийг дугуйлчихдаг хүүхэд шиг сэтгэлгээ олонх сонгогчид байдаг гэнэ. Нам, эвсэл улсын бүртгэлд хамрагдсан дарааллаараа саналын хуудсанд эрэмбэлэн жагсах учиртай. Улс төрийн хүчин болгон 38 хүнийхээ нэрийг бүлэглэн саналын хуудсанд хавсаргана гэвэл бага шиг товхимол аятай болчих вий. Энэ маягаар эрхэм сонгогч хүнд нэг, намд өөр нэг, нийлээд хоёр санал өгөх ажилтай. Механик тайлбарын араас мөн чанар, зарчмын өөрчлөлтийн утга учрыг тодруулья.

Оросууд бол уг өөрчлөлтийг товчхоноор «Нэг тойрог-нэг хүн» байх учиргүй. Харин «Нэг нам-нэг хүн» гэвэл зохистой хэмээж байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох байгууллагад орон нутгийн төлөөлөгчийг биш, намын бодлого, үйл ажиллагааг санал болгох нь зөв гэж үзжээ. 2007 оны ДУМ-ийн сонгуулийн дараа оросууд амаа барих эсэхийг мэдэхгүй юм. Лав монголчууд тэрхүү пропорциональ, мажоритар системийн сайн, муу талыг хоёуланг нь арьсаараа мэдэрсэн улс. Орон даяар 26 тойрогт пропорциональ буюу хувь тэнцүүлэн сонгох зарчмаар санал өгсөн түүхээ нэхэн саная. 1992 оны сонгуулийг өнөөгийнхөөс бараг гурав дахин цөөн тойрогтойгоор зохион байгуулсан. Тэдгээр томсгосон тойрогт өгсөн сонгогчдын саналыг хувь тэнцүүлэх маягаар намуудад хуваарилсан билээ. Ингээд дөрвөн нам, эвсэл парламентад суудлаа эзэлж, эвслийн Засгийн газар байгуулсан түүхтэй. Төд удалгүй төрийн ажил болохоо байлаа гэгцгээн буруу муут Сонгуулийн хуульд чихэв. Дараагийн сонгуулийг мажоритар хувилбараар буюу «нэг тойрог-нэг мандатаар» явуулнаа хэмээн шуударлаа. Үр дүнд нь жигтэй юм болов. 1996 онд бараг дан цэнхрүүд засгийн эрхийг барьж, 2000 оноос улаанууд суудалдаа тухалдаг юм байна. «Мажоритар системийн сул талыг харав уу, сонгогчдын 40 гаруй хувийн саналыг төрд төлөөлөх хүнгүй болсныг» хэмээн араас нь ундууцлаа. Энэ бүх савлагааны эцэст сонгуулийн хоёр системийн сул болоод давуу талыг иргэд гадарладаг болжээ.

Ингээд дэлхийн олон орны жишээг дагаад хоёр хувилбараас тэнцүүхэн халбагадаж, 38:38 томъёолол дэвшүүллээ.

Нам, эвслийн нэрсийн жагсаалтаар сонгох 38 хүн гэдэг ямар учиртай юм бэ? Намууд их хурлаа зарлаж 38 хүн тодруулна гэсэн үг. Тухайн улс төрийн хүчнийг дэмжсэн саналын тоогоор мөнөөх жагсаалтаас ногоон картын эзэн тодорно. Сонгогчдын дор хаяж зургаан хувийн дэмжлэгийг нам, эвсэл авсан тохиолдолд жагсаалтад багтагсдаас нэг нь гишүүний суудалд хүрнэ. Саяхан баталсан Улс төрийн намуудын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл санааг ийнхүү амьдралд хэрэгжүүлж, нам төлөвшиж торниход туслах гарцыг «тэгшитгэлийн 38»-д олгожээ. Гагцхүү эдний дунд эрээвэр хураавар, хэн ч үл мэдэх хүмүүс гараад ирэх магадлал өндөр. Намыг бус, хүнийг онцлон сонгодог монголчуудын араншинд нэрсийн жагсаалтаар гарч ирэх 38 гишүүн гэдэг ойлгомжгүй санагдаж болох.

## БӨМБӨЛӨГ БӨМБӨЛӨГ ХӨӨРӨӨРЭЙ

УИХ-ын сонгуулийн 2008 оны кампани уйтгартай санагдах вий. Бөмбөлөг, дарцаг бөөн бөөнөөрөө хөөрөхгүй. Амлалтын бороо өнгөрсөн хаврынх шиг асгарахгүй. Тод өнгөгүй, том бөмбөлөггүй кампани өрнүүлэх хаалтыг Сонгуулийн тухай шинэ хуульд тусгалаа. Нэр дэвшигч тоглолт шоу зохион байгуулахгүй, 3000 төгрөгөөс дээш үнэтэй бэлэг тараахгүй. Мөнгийг баруун солгойгүй цацах боломжийг хуулийн төсөлд хязгаарласан. Хувь хүнээс нэг сая, хуулийн этгээдээс гурван сая хүртэл төгрөгийн хандив авах бололцоотой. Дансанд тэдгээрийг төвлөрүүлж, зарцуулалтыг Сонгуулийн ерөнхий хороо болон ард олон хянана. Иймэрхүү заалтууд нь одоо мөрдөж буй хуулийн «Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа» гэсэн ихээхэн ерөнхий, тодорхойгүй зүйлийг тодотгож өгч буй юм.

Түүнчлэн намын нэрсийн жагсаалтаар дэвшигч 38 хүн зардлын сан байгуулахгүй. Ингэснээр олон хүний түм буман шоу үргэлжилж, сурталчилгааны бичиг цаас, бэлэг сэлт үүдэнд маань өрөөтэй байдаг нь цөөрнө гэсэн үг. Ер нь зардал хэмнэх, үрэлгэн кампанийг цэгцлэх цөөнгүй заалт нэмэлт, өөрчлөлтөд туссан харагдана. Тухайлбал нэр дэвшигчийн сурталчилгааны материал хэвлэлийн гурван хуудаст багтах учиртай. УИХ-ын сонгуулийн өмнөх хуульд иймэрхүү нарийн чанд зааварласан үг, өгүүлбэр байгаагүй юм. Тойргийн хороо, хэсгүүдэд нэг нам, эвслийн төлөөлөл давамгайлахыг хориглолоо. Энэ мэтээр өмнөх сонгуулиас сургамж авсан цөөнгүй шинэ заалт төсөлд туссаныг тэмдэглэе.

«Эвслийн гэрээ нь тухайн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр» гэсэн өгүүлбэр юуны өмнө нүдэнд торов. Эвсэж нэгдэн төрийн сонгуульд оролцсоно гэдэг айл гэр болж тоглохоос өөр, ихээхэн хариуцлагатай шийдвэр шүү гэсэн сануулга нэмэлт, өөрчлөлтийн үг, өгүүлбэр бүрээс ханхална. Өнгөрсөн нэг жилийн дотор Монголын улс төрийн амьдралд тохиолдсон бэрхшээл, санаанд оромгүй үйл явдлуудын эцэст өнөөдөр мөрдөж буй хуулийн зохицуулалтаа эргэн сөхөхөд дэндүү бүрхэг байсан нь тод мэдрэгдэнэ.

«Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч сурталчилгаанд оролцож болохгүй» гэсэн тов тодорхой заалт хуулийн төсөлд бий. Түүнчлэн нэрсийн жагсаалтад «амьгүй албат» шургуулах болон микро автобусаар сонгогчид «бөөндөг» хар ажилбаруудыг дэгээдэх хаалт цөөнгүй тусгажээ. Нэр дэвшигч хөрөнгө орлогынхоо тухай нийтэд зарлах учиртай, СЕХ-ныхон төрийн албаны ёс зүйг чандлан сахих үүрэгтэй гэх мэт өмнөх хуульд байгаагүй санаанууд төсөлд багтав.

## ТОЙРОГ ТОМОРНО

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөлд томъёолсон зарчмын томоохон өөрчлөлт бол томсгосон тойргоор санал авах явдал. Өнөөгийн 76 тойрог буюу нутгийн чулуугаа тэвэрсэн нэр дэвшигчдийн жижигхэн амбицийг уг шинэчлэл халах юм. Нэгэнт сонгогч хоёр саналын хуудас бөглөх тул улсын хэмжээгээр 38 тойрог бүрдүүлнэ. Энэ нь 1992 оны сонгуулийн тойргоос арай жижиг, өнгөрсөн жилийнхээс бол томорсон хуваарилалт байх бололтой. Бололтой гэсний учир нь Засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг ямар хувилбараар хийхээс энэ асуудал шууд хамаарна. Багцаалбал өнөөгийн аймгуудын дайны хэмжээтэй тойргууд, дээр нь нийслэл арваад тойрогт хуваагдаж болзошгүй юм. Одоогийн хуваалтаар бол Улаанбаатар хот 20 тойрогтой. Ийм томсгосон хуваарилалтыг дагаад «амьгүй албат»-аар санал өгүүлдэг, сонгогч зөөдөг мэх цөөрнө гэж үзжээ. Мөн УИХ-ын түшээд жалгын депутат нэрнээсээ салах,

**Өнөөгийн  
76 тойрог буюу  
нутгийн  
чулуугаа  
тэвэрсэн нэр  
дэвшигчдийн  
жижигхэн  
амбицийг уг  
шинэчлэл  
халах юм.**

томхон эрх ашиг ярьж эхлэх магадгүй. Түүнчлэн Монгол Улс нам, эвслийн нэрсийн жагсаалтаар санал авах ганц тойрог болно.

Юутай ч УИХ-ын сонгуулийн тухай хуулийг өөрчлөх төслийг өргөн барилаа. Явцын дунд энэхүү баримт бичигт багагүй засвар орж, илүү оновчтой хувилбар төрнө хэмээн найдъя. ДУМ-ийн Доод танхим 800 гаруй засвар хийж байж хуулиа ёсчилсон гэх. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль баталж, Улс төрийн намуудын тухай хуульд шинэчилсэн найруулга хийн, Сонгуулийн хуульд чамгүй өөрчлөлт оруулах гарааны зурхай дээр парламент ийнхүү иржээ. Цөөн хэдий ч Монголын нийгэмд онцгой нөлөөтэй дээрх баримт бичгүүд амьдралд хэрхэн нийцэхийг, хэр оновчтой хэрэгжүүлэхийг иргэд харахан мэдрээгүй байна.

ЯЛГАА		
Сонгуулийн монгол хувилбар	Сонгуулийн орос хувилбар	
1	УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөл дээр парламент ажиллав.	ДУМ-ийн Доод танхимыг сонгох хуулийг ОХУ-ын Ерөнхийлөгч санал болгов.
2	Мажоритар болон пропорциональ системийн холимог хувилбарыг сонгов.	Ганц мандаттай буюу мажоритар системээс шууд хувь тэнцүүлэн сонгох буюу пропорциональ системд шилжлээ.
3	1996, 2000, 2004 онуудад буюу гурван удаа ганц мандаттай сонгууль явуулжээ.	Тэгвэл ганц мандатын туршлагыг оросууд хангалттай хуримтлуулсан. Тэд ДУМ-ийн өмнөх дөрвөн удаагийн сонгуульд нэг тойргоос ганц депутат тодруулжээ.
4	УИХ-д бие даан нэр дэвшүүлэх боломж Монгол Улсын иргэдэд нээлттэй.	“Независимый депутат-тот, от которого ничего не зависит” хэмээн оросууд ярьж байна. Шинэ хуулиар зөвхөн намууд нэр дэвшүүлнэ. ДУМ-ийн бие даагчид баяртай гэсэн үг.
5	УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэн даруй нэмэлт, өөрчлөлт хийсэн шалтгаан бидэнд даанч нэг тодорхой. Амлаад, бүжиглээд байсан, хэнийг нь ч сайн мэдэхгүй хангаруудад хэдүүлээ микроавтобусаар бөөндөө очиж санал өгөөд л. Тэгсэн дараа нь яалаа...	Беспанд 2004 оны есдүгээр сард болсон алан хядлага дэлхийг цочоов. Чухам энэ үйл явдлын дараа В.Путин улс орныхоо төрийн байгуулалтыг хүчирхэг, үр дүнтэй ажилладаг механизм болгон өөрчлөхөөр шийдсэн. Цуврал шинэчлэлийн нэг нь энэхүү ДУМ-ийн Доод танхимыг сонгох өөр арга зарчим байлаа.
6	Намуудын эвсэл гээч шаржигнуур төмс шиг хэврэг, бас зугаатай эдийг хуулийн хүрээнд хашиж, бөх бат байлгахыг чухалчлав. Эвслээс эвсэлд, намаас нам руу жороолохыг байж болшгүй хэмээн төсөлд тусгалаа.	Эвсэл байгуулахыг хуулиар бүрмөсөн хоригложээ. Зөвхөн намууд сонгуульд өрсөлдөнө.
7	УИХ-ын сонгуульд өрсөлдөх нам, эвслийн хөрөнгө зардлын сангийн хэмжээ хязгаарыг тодорхой заагаагүй. Гэхдээ хандивын дээд хязгаарыг онцгойлон тогтоов. Дөрвөн жилд нэг удаа алтан бороо асгаад байх магадлалтай болсноос ийн хаалт хийж өгөв.	Намууд сонгуульд оролцох зардлын сангийн дээд хэмжээг 400 сая рубль хэмээн хуульдаа тодруулжээ. 93 сая төгрөг гэсэн үг. Ийм хэмжээний хөрөнгийг Коммунист намынхан дэндүү их гэж үзэв. Гэхдээ 400 сая рубль бол байж болох дээд хязгаарын тухай яриа л даа.
8	Нэмэлт, өөрчлөлтийг хаврын чуулганаар хэлэлцэх сураг бий. Хувь заяаг нь бурхан мэдэг.	ДУМ дөрөвдүгээр сарын 15-нд нэмэлт, өөрчлөлтийг бараг санал нэгтэй батлав. 335 депутат тэгшитгэлийн хувилбарыг дэмжиж, 96 нь эсэргүүцсэн юм.

ЗАРИМ ТӨСӨӨ		
монгол хувилбар	орос хувилбар	
1	Улс төрийн намуудын тухай хуулийг УИХ шинэчилсэн найруулгаар саяхан батлав. Намуудын төлөвшлийн замыг засч өгсөн уг хуулийн үзэл баримтлал дор УИХ-ын сонгуулийн тухай хуулийг мөн өөрчлөхөөр зэхэж байгаа нь энэ.	ДУМ өнгөрсөн оны арванхоёрдугаар сард Улс төрийн намуудын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталжээ. Намын нэр хүндийг өргөж, хувийн тоглолтуудыг хязгаарлах агуулга энд бий.
2	Олон нийтийн санаа бодлыг сонсох хугацаа хангалттай байна.	ДУМ-ийн Доод танхимыг пропорциональ системээр сонгох хуулийн төслийг өнгөрсөн оны аравдугаар сараас олон нийтэд тайлбарлан танилцуулсан билээ.
3	Томсгосон тойрогт хуваах ажлыг засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг даган хийнэ.	650.000-3.000.000 хүн ам бүхий тойргуудыг дахин зохион байгуулах их ажил Орос орон даяар ундарна.

2005 он

# Харийн галт тэрэг Монголд саатахын учир

Өнгийн хувьсгалын галт тэрэг дараагийн зогсоол руугаа хурдаллаа гэх дүрслэлийг мэргэжил нэгт маань өгүүлжээ. Буухиа галт тэрэгний эхний буудал биднээс их холд, тэртээ Кавказын сүрлэг уулсын чанадад байсан юм. Сарнай цэцэг барьсан уулынхан түүнийг сүйд болон угтаж, Саакашвилиг зүтгүүрт нь залан суулгажээ. Холын тэр буудлын тухай хоёр жилийн өмнө сонсохдоо дуут дохио нь өнөөдөр энүүхэнд хангинахын чинээ монголчууд төсөөлөөгүй. Төв Азийн Монголд нөлөөлөх үйл явдал Зүүн Европоос чимээлж айсуу гэх төлөг оргүй яриа байсангүй. Хойноос хурдлан нүүх баргар үүл учир таамаг дагуулсаар ирж явна. Их аадар асгах нь уу, чийг ханхлуулаад холдох нь уу.

Үзтэл сайхан ч өргөст сарнай Гүржид юу авчирсныг эхлээд тогтож харъя. М.Саакашвили Америкийн төрийн тэргүүнтэй цаг хагасын уртад тун ойрхон суугаад зоог барин, дотно ярилцжээ. Ялалтын баярын 60 жилийн ойг тэмдэглэсний дараахан Ж.Буш Гүржийн Ерөнхийлөгчтэй уг нь ердөө хагас цаг хамт хооллох төлөвлөгөөтэй Тбилист ирсэн билээ. Гэсэн ч шинэ цагийн хувьсгалын баатарт онцгой хүндэтгэл үзүүлэн, тогтсон жаягийг эвдэж буй хэрэг. Хувьсгалын эх зохиолыг нь Ж.Буш анх сэтгэлдээ ургуулсан болохоор аргагүй догдлоо биз. Дараа нь Ж.Буш өөр рүү нь «гар бөмбөгөрхүү зүйл» шидэхийг тоомжиргүй инээмсэглэн байж тэвчив. Ноён Ерөнхийлөгчийг нутаг буцсан хойно харин Тбилист жинхэнэ үйл явдал эхэллээ.

Оросын цэргийн анги нэгтгэлийг Гүржээс нэн даруй гаргахыг залуу удирдагч шаргуу шаардсаар ирсэн. Хоёр талын хооронд ярвигтай хэлэлцээр үргэлжлэв. Ялалтын баярын их ойн өмнөхөн зарим тохиролцоонд хүрсэн. Гэвч Орос, Гүржийн үл ойлголцол өдгөө дахин сэдэрч, хоёр улсын хооронд хурцадмал байдал нэгэнт бий болоод байна. Гүржүүдэд Орост нэвтрэх виз олгохоо больё, эрчим хүч нийлүүлдэг хөнгөлөлтийн тарифаа эргэж харъя хэмээн ДУМ-ийн депутатууд гэдийлээ. Эдүгээ оросуудын оосроо чангалах ганц арга нефть, байгалийн хийн экспортын үнэ ханшаар далайлгах явдал болоод байна. Ингэж сүрдүүлсний эцэст л сарнай хувьсгалын баатрууд бага зэрэг «хөрсөн» юм. Олон олон гүрж өрхийн амьжиргаагаа залгуулдаг нэг эх үүсвэр нь Орост очиж ажил хийн ар гэртээ мөнгө гуйвуулах явдал. Өөрөөр хэлбэл, өнгийн хувьсгалын төгс ялалтыг Кавказад тэмдэглэж оргилуун дарс буудуулах цаг хараахан ирээгүй байна гэсэн үг. Саакашвили нэг зүйлтэй үнэхээр эвлэрч чадахгүй яваа. Америкийн анд болох сайхан. Гэвч мөнхийн хөрштэй өсөрхөнө гэдэг өөрийгөө дэгээдсэнээс ялгаагүй болохыг тэрбээр ойлгохыг үл хүсдэг.

Тэгвэл улбар шаруудын удирдагч В.Ющенко энэ өдрүүдэд Еврокомиссын уулзалтад оролцон шинэ Украины нэрийн хуудсыг тарааж яваа. Цоо шинэ зангиа зүүх гоё. Тэр нь улбар шар болохоор бусдын анхаарлыг эрхгүй татаад бүр бахдалтай. Харин ар гэрт нь мөнөөх л эрчим хүчний хараат байдал, Украинд бизнесээ эхэлсэн Оросын хөрөнгө оруулагчдын асуудал бодит бэрхшээл болсоор. Түүнчлэн Киргизийн алтанзултнууд А.Акаевыг үлдэн хөөсөнд бараг бүх Европ алга ташин баяр хүргэсэн. Тэгвэл Акаев, Бакиев аль нь ч байлаа гээд ОХУ-ын дэмжлэггүйгээр төр, засаг «сулдаа ганхах»-ыг киргизүүд нийтээрээ ойлгож байна. Ямар Америкийн цэргийн «Манас» баазаас авах татвараар бүхэл бүтэн улс орон оршин тогтнож амь залгуулна гэлтэй биш. Одоо буухиа галт тэрэг араасаа бөөн хар үүл дагуулсаар Узбек, Таджик,



Казахстанд буудаллах тун магадгүй боллоо. Цэвэр тунгалаг амьсгалаар ангаж гандсан тэдгээр нутагт бөөн хар үүл алтан хур хайрлах уу, эсвэл аюул сүйрэл дагуулах уу гэдэг тодорхойгүй. Төв Азийн хэдэн улсаар өнгөрсөн жил зорчоод өнгөрөх зуураа бяцхан Монголоос тэд олон талаар хоцорсныг мэдэрч билээ. Лада, Жигули маркийн хөнгөн тэрэг сүлжилдсэн саарал өнгөт уйтгартай гудамжуудыг өгсөн, уруудан интернэтийн үйлчилгээний төв хайж, дараа нь олон улсын ярианы карт олох санаатай бэдэрсээр өдрийн хагасыг барахдаа «Бушуухан харих минь» хэмээн үгээ барж явлаа. Хаашаа л харна Назарбаев, Акаев хоёр маасайтал инээсэн зурагт самбарууд өлгөөтэй байсан. «Эрхэмсэг ноён А.Акаевын нэрэмжит буудал» гэсэн бичээс бүхий самбарыг «Nyatt»-ын сүлжээний зочид буудлын үүдэнд хадсаныг хараад инээх ч багадсан юм. Эрх чөлөө, өөрчлөлт шинэчлэлээр ангаж гандсан ийм л хөрсөнд алтанзүл цэцэглэжээ.

Хөрш зэргэлдээ улсуудад нь өнгийн хувьсгал ялсны дараа өөр үзэлтнүүдийн эсрэг гал нээх тушаал өгөх зориг зүрх Узбекийн Ерөнхийлөгч И.Каримовт яаж олдов оо? Афганистанд цэргийн болоод энхийн үйл ажиллагаа явуулах АНУ-ын гол түшиц бол Узбекистан. Улс орноо ийм дамжлага бааз болгож өгсөнд Каримовт америкчууд талархсан юм. Тийм болохоор Андижанд болсон хэрэг явдлын дараа ВВС «АНУ-ын анд» хэмээн И.Каримовыг нэрлэж хадуурсан удаатай. Эндээс, эрх чөлөөний төлөөх тэмцлийн сценар бүрийг америкчууд өөр хувилбараар бэлтгэснийг харж болно. Узбекүүд буухиа галт тэргэнд ямар өнгөтэй зогсоол бэлтгэж буйг мэдэхгүй юм. Юутай ч түүнийг зогсоох арга алга. Учир нь энэ цуваанд эрх чөлөө гэгч амтат «ачаа» бий. Улаан гэрлэн дохиогоор яаж ч даллаад улам улам хурдаа нэмэх цувааг тогтоох хүч үгүй болжээ.

Уухилах чимээ эдүгээ Москвад тод мэдрэгдэж эхэлснийг сануулъя. В.Путин энэ өдрүүдэд хэн болохоо дэлхий дахинд ойлгуулахад тун төвөгтэй байна. Шинэ цагийн Сталин гэж түүнийг зарим нь нэрлэж эхэллээ. Үндэсний хөрөнгөтнүүдтэйгээ дайн зарласан эхний тохиолдлыг Москвад шүүж байгаа. Оросын барууны хүчнийхэн Ерөнхийлөгчийн болон ДУМ-ийн сонгуульд навс ялагдсаныхаа дараа тус улсад нэг хүний хэмжээгүй эрхт засаглал тогтлоо хэмээн шуугисан. Тиймээс Михаил Ходорковский, Платон Лебедев нарыг шүүх ажиллагаа Оросын буурал түүхнээ өнгийн хувьсгалын тод будаг дусаачих тун магадгүй. Дарангуйллын эсрэг дуу хоолой Москвад барууны хүчнийхэн болоод залуус оролцсон эсэргүүцлийн томоохон жагсаал дэгдээх вий хэмээн эрх баригчид эмээж байна. Дуут дохио их хөршийг маань сандаргаж эхэлсэн гэсэн үг. В.Путинд бажгадах, бухимдах, гомдох шалтгаан хангалттай хуримтлагджээ. Латви улс уучлалт гуйхыг оросуудаас шаардсаар байна. Өнгөрсөн зууны гучаад онд улс үндэстнийг нь «доош хийж» байсны хариу болгож одоо Латвид амьдарч буй оросуудын эрхийг уландаа гишгэв. Хүн амын цөөнхийн эрх ашгийг үл хүндэтгэж буй тэдний араншинг америкчууд ойлгоогүй, мэдээгүй дүр эсгээд таг чиг. Өдгөө Кремль ямар ч үндэслэл, шалтгаантай тайлбар хэллээ гээд Зүүн Европоос дэмжлэг авч чадахгүй болжээ. Оросын талыг баримтлагч удирдагчид энэ бүс нутагт ээлж дараалан халаагаа өгсөөр. Хажуу хавиргаас нь ёврох тусам Оросын үндэсний үзэлтнүүдийн маажуур өвчин сэдэрч эхлэв. В.Жириновскийн рейтинг оросуудын дунд өндөр байгаагийн шалтгаан энэ. «Бид бүгдийг харж үзэн туславч, хариуд нь юу болж буйг хараач» гэх Либерал ардчилсан намын байр суурийг хуваалцагчид сүүлийн үед олширч байгаад монголчууд болгоомжлох учиртай. В.Путин элдэв өнгийн галт тэргийг Оросын уудам нутагт зогсоохгүй гэж хатуу үзэх нь лавтай. Гэсэн ч айсуу жилүүдэд хойд хөршийн дотоод асуудал нэн хурцдах магадлал өндөр юм. Тус улстай хиллэдэг дэндүү олон зогсоолд америк зүтгүүртэй галт тэрэгнүүд дохиогоо хангинуулан ирчихээд байна.

**Лада, Жигули маркийн хөнгөн тэрэг сүлжилдсэн саарал өнгөт уйтгартай гудамжуудыг өгсөн, уруудан интернэтийн үйлчилгээний төв хайж, дараа нь олон улсын ярианы карт олох санаатай бэдэрсээр өдрийн хагасыг барахдаа «Бушуухан харих минь» хэмээн үгээ барж явлаа. Хаашаа л харна Назарбаев, Акаев хоёр маасайтал инээсэн зурагт самбарууд өлгөөтэй байсан.**

Зүтгүүрийн замыг засагчид болох АНУ-ын санхүүжилт бүхий төрийн бус олон байгууллага Монголд ч үүрээ хэдийнэ засчээ. Зүүн Европыг хөндлөн гулд хэссэн мэргэжилтнүүд Улаанбаатарт морилон ирснийг танилцуулахад илүүц биз. Элчин сайд хатагтай Памела Слущийн өгүүлсэн хоёрхон өгүүлбэр Монголын нийгэмд шуугиан дэгдээж, маргааны бай болсны учир ийм. Тиймээс Төв Азийн Монголд болох Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн чимээ дэлхий дахины анхааралд өмнөхөөсөө илүүтэй өртөх магадлалтай. «Монгол Киргиз биш ээ» гэх тайлбар эдүгээ яасан жол сонсогдоно вэ. Киргиз байтугай асуудал болгочих сценар хаа нэгтээ байж л байгаа. Ардчиллын замаар 15 жил явсан, огт өөр баруунжсан уур амьсгал манайд бий гэх зөвтгөл нэгэнт хүчээ авсан буухиа тэрэгний замд зомгол мэт шидэгдэх вий хэмээн болгоомжилж байна. Гадаад талаас бүрдсэн нөхцөл дотоод дахь хийрхлийн голомтод оч асаахаас наана монголчууд санаж сэрэх ёстой.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Н.Энхбаяр, М.Энхсайхан, Б.Жаргалсайхан, Б.Эрдэнэбат дөрвүүл шинэ цагийн Монголын түүхэнд өөр өөрсдийн хувь нэмрээ оруулж яваа улстөрчид. Тэднийг «шинэ үеийнхэн» ба «дарангуйлагчид» гэсэн хоёр туйлд хүчээр шахаж, хооронд нь тонгорог ивэхийн ашиг тус юу байна? Жирийн америкчууд сонгуулийн өмнөхөн хэнд тал өгч буйгаа ил зарлан гэрийнхээ үүдэнд Ж.Керри, эсвэл Ж.Буш гэсэн нэртэй бяцхан пайз суулгаж орхисон харагдсан. Ингэлээ гээд хөрш хоёр шөргөөцөлдөнө гэж үгүй. Бусдын үзэл бодлыг өөрийнх шигээ хүндэтгэж байгаа хэрэг. Тиймээс хийрхэх орон зай тэнд хомс.

Сүхбаатарын талбайд цугласан шар зангиатнууд ялзарсан лооль атган төрийн ордон руу хар чадлаараа нүүлгэсэн хийрхэл өнгөрсөн намрын Украиныг сануулсан юм. Украины Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатны дараа тэнд үйл явдал яг ийм эх бичвэрийн дагуу өрнөсөн. Хэт туйлшрал бяцхан Монголд юу авчрахыг хэн ч хэлж мэдэхгүй. Энэ сонгуулийн үр дүн Монголын улс төр, нийгэмд ужиг хямрал авчрах вий гэсэн болгоомжлол төрөөд байна. Хувьсгалыг импортгож болдгийг бид харсан. Ганц жор улс орон болгонд өөр үр дагавар зөгнөж байгааг ч мэдэрсэн. Өнгөөр далласан галт тэрэг эцсийн зогсоол руугаа яаралгүй дохиолно. Муудсан өндөг тасалгааных нь цонхыг нэлийтэл будчихаад байхад «Монгол Киргиз биш ээ» гэсэн үгийг хоосон давтаад суух уу. Цэцэгсийн хувьсгалаас санаа авах хугацаа Монголын төрд байв. Сонгууль шударга явагдлаа хэмээн нийтээрээ хүлээн зөвшөөрөх тийм шинэ зохион байгуулалт хийж чадсан бол харийн галт тэрэг харуулдан зогсоол цэвэрлэх хийрхүү хувьсгалчдын өмнө энэ төр жолдохгүй байсан юм. Сүх далайтал үхэр амар явна.

2005 он



Фотог Ц.Батбаатар

# Нуусан арьс

Нуусан арьсаа ил гаргах өдөр ойртлоо. Ерөнхий сайдыг өнөөдөр томилно. Харин тэрбээр хүндэтгэл ёслолын арга хэмжээ өндөрлөмөгц танхим бүрдүүлэх хувилбаруудаа халааснаасаа гаргаж ирнэ. Энэ цаас эхэлж цоохорлосон өдрийнхөөсөө огт өөр болон ноорчээ. Ц.Элбэгдоржийн танхимыг огцруулах ажиллагаа болоод унамагц нь шинэ Засгийн газрыг бүрдүүлэх цахилгаан төлөвлөгөөтэй харьцуулахад сүүлийн хэдэн өдрийн үйл явц тун ч ээдрээ төвөгтэй байлаа. Засгийн газрыг унагах ажиллагаа ийм их эсэргүүцэлтэй тулгарна гэдгийг МАХН-ын Удирдах зөвлөл тооцоолоогүй юм. Улмаар тус намын лидерүүдийн боловсруулсан төлөвлөгөө олон нийтийн бухимдал дунд хэдэнтэй өнгө хувираад байна. Ц.Элбэгдоржийн танхимыг огцруулсан тогтоол уншсаныхаа дараа МАХН ард иргэдэд ганцхан долоо хоногийн хугацаа амласныг сануулья. Ертөнцийн долоо хоног эргэх зуурт шинэ Засгийн газар бүрдэнэ, амлая хэмээн тангараглаж билээ. Тэгвэл хуанлийн хуучин хуудсууд хөлд хөглөрсөөр. Нөгөө Ц.Элбэгдоржийг өмөөрөн уурсч явсан иргэд одоо Засгийн газраа хурдан бүрдүүлээч хэмээн шахаж эхэлсэн өөр уур амьсгал нийгэмд давамгайлаад байна.

Сайн байна уу, шинэ Ерөнхий сайд аа! Таныг энэ нийгмийн олонх хүлээн зөвшөөрөөгүй. Гэхдээ төрд толгой, засагт ажил хийх гар үгүйлэгдээд байна. Яана гэхэв, ажилдаа ор доо. Бүрдүүлсэн танхим тань хаана байна? Хариуд нь Монгол Улсын Ерөнхий сайд халаасаа тэмтрэн хувилбар №1, №2, төлөвлөгөө №1, №2... гарган уймрах биз. Засгийн газар нэрнээсээ эхлээд баартай байна. Үндэсний эв нэгдлийн гэдэг тодотгол үнэхээр жинтэй, буянтай үг. Тэгвэл нэр доорх агуулгыг нь одоо тэмтэрч үзье. Үндэсний эв нэгдлийг танхимаас үнэртэхийн тулд Монголын ард түмний чамгүй хэсгийн төлөөллийг илэрхийлдэг Ардчилсан намын цэнхэр бэлгэдэл тэнд эхлээд харагдах ёстой. МАХН-аас санал болгоод буй Үндэсний эв нэгдлийн Засгийн газар байгуулан ажиллуулах тухай гэрээнд зөвхөн намаас санал болгосон нөхрийг л сайдад нэр дэвшүүлнэ гэжээ. М.Энхболдын эхний хувилбар энд гацаад байна. «УИХ-д суудалтай улс төрийн намууд Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулах сайдын нэрийг Ерөнхий сайдтай зөвшилцөн тохирно» хэмээн гэрээний 2.2 дугаар зүйлд тусгачихаж. Р.Гончигдоржийн, бүр Э.Бат-Үүлийн фракцаас зай барьж, чуулганы танхимд МАХН-ын гишүүдтэй мөр зэрэгцэн суугаа Ардчилсан намын дөрвөн гишүүнийг танхимд татах хувилбар гэрээний заалттай харшилна гэсэн үг.

Шинэ Ерөнхий сайд өөр нэг хувилбар дэвшүүллээ гэж төсөөлье. Ард түмний нам гэж ч юу билээ... хэмээн тохуурхдагаа болих цаг ирж гэнэ. Л.Гүндалайг «нүдээ аниад» танхимдаа авлаа. Хамгийн аргаа барсан ийм хувилбар ч явцгүй харагдана. Эрүүл мэндийн салбарынхан түүнийг хүлээн зөвшөөрөх шинжгүй. Эмч нар мэдэгдэл гаргаж Л.Гүндалайг сайд болгохыг эсэргүүцнэ гэж М.Энхболд мэдээж төсөөлөөгүй явсан. Хэдийгээр сүүлийн өдрүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд шинэ танхимын «цоохор долоог» энэ тэр гэж элдвээр тандаад байгаа боловч асуудлын гол нь нэр бүхий эрхмүүд маань намын туг далбаагаа чирээд Засгийн газарт ороод ирэх явдал юм. М.Энхболд танхимдаа зөвхөн намын дарга нарыг л уриад байгаа. «Хоёр нам хэл амаа ололцож чадаагүй байж одоо 4-5 нам нэг танхимд эв зүйгээ олно гэж үү» хэмээн С.Оюун гашуун боловч үнэн үг чулууджээ. «Цоохор долоогийн» элдэв ааш маягаас эмээсэн МАХН Үндэсний эв нэгдлийн Засгийн газрын гэрээндээ ихэд болгоомжилсон үг өгүүлбэрүүд урьдчилан

**Хэдийгээр  
сүүлийн өдрүүдэд  
хэвлэл  
мэдээллийн  
хэрэгслүүд шинэ  
танхимын  
«цоохор долоог»  
энэ тэр гэж  
элдвээр тандаад  
байгаа боловч  
асуудлын гол нь  
нэр бүхий  
эрхмүүд маань  
намын туг  
далбаагаа чирээд  
Засгийн газарт  
ороод ирэх явдал  
юм.**

шингээсэн байх юм. «УИХ-ын чуулган, Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүний хувьд зарчмын өөр санал илэрхийлэхгүй» хэмээн тэднийг тушиж аваад, араас нь төрийн зүтгэлтний ёс зүйн талаар цөөнгүй мөр номложээ. Б.Жаргалсайхан, Л.Гүндалай нар лав шинэ танхимд багтвал төрөл арилжчихмаар хүмүүжлийн нарийн зааварчилгаа бүхий юм гээч.

Монголчууд ойрдоо Эх орон намын даргад нэг л таагүй хандаад байх болж. Хэд хэдэн сайдын суудалд санаархсан тухай нь байсгээд дургүйцэн ярьцгаана. Сайдын ганцхан суудал зулгааж чадсан байлаа ч намын дарга гэдэг мөрийн хөтөлбөрөө сугавчилж яваа гол хүн. Улс төрийн хүчний төлөөллийн хувьд түүнийг дэмжигчид, амлалтаа биелүүлэх эсэхийг нь хүлээж буй иргэн олон болохыг бодолцох ёстой. Тиймээс ч Б.Эрдэнэбат «Эхлээд М.Энхболдтой зарчмаа тохирно» хэмээн гэдгэр сууна. Шинэ зөвшилцлийн талбарт шатрын бэрс адил соньхон харагдаж буйгаа тэрбээр мэдэрсэн бололтой. Хэн хаанаа хэдэн арьс нуусныг бүү мэд. Чухам эдгээр нуусан арьс М.Энхболдод өдөр тутам цохилт, чөдөр тушаа болно гэдэгт эргэлзэхгүй байна. Жижиг намынхаа том амбицыг чирэн танхимд орж ирэх эрхэм дарга нартай эв зүйгээ олох нь Ерөнхий сайдын хувьд туйлаас бэрх байх юм.

**Шинэ зөвшилцлийн талбарт шатрын бэрс адил соньхон харагдаж буйгаа тэрбээр мэдэрсэн бололтой. Хэн хаанаа хэдэн арьс нуусныг бүү мэд. Чухам эдгээр нуусан арьс М.Энхболдод өдөр тутам цохилт, чөдөр тушаа болно гэдэгт эргэлзэхгүй байна.**

«Эх орон-Ардчилал» эвсэл 2004 оны УИХ-ын сонгуульд оролцсон. Амийг нь өөрөө тасалсан Эвслийнхээ мөрийн хөтөлбөрөөс Б.Эрдэнэбат эдүгээ иш татан солигтож мэдэхээр байна. 2004 онд амлаж гарч ирсэн шигээ малчдыг таван жилийн турш татвараас чөлөөлнө хэмээн тулгавал яана. МАХН-ын сонгогчдодоо санал болгосон гэрээнд мөн л малчдыг гурван жилийн турш татвараас чөлөөлнө гэж тусгасан. За тэгэхээр «Эх орон», МАХН хоёр малчдын тухайд сайхан тохирч, ам нийлэх нь. Бүгд найрамдах намын дарга харин босоод ирэх вий. Малчдыг аливаа татвараас чөлөөлөхийг эрс эсэргүүцэгч Б.Жаргалсайхан Үндэсний эв нэгдлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн энэ заалтад «хориг» тавьж мэднэ. Төрөл арилжиж, өөр хүн болчихгүй л бол тэр шүү дээ. Намын тугаа намуруулсан дарга нарын араншин шинэ Ерөнхий сайдад хатуу боорцог бэлдэх нь. Өдгөө хэн хэн сайд болох тухай мэргэ төлөг буулгах моод дэлгэрчээ. Гэвч гол бэрхшээл хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг тохиролцох явцад учрах биз ээ.

МАХН-аас дэвшүүлсэн есөн хуудас саналыг тандвал буяны байгууллагын ажлын төлөвлөгөө ч юм уу гэж эндүүрмээр. Нийтийн тээврээр зорчих тасалбарын үнийг төр зохицуулна. Мах, гурилын үнэд мөн л зохицуулалт хийнэ. Автобус, троллейбусаар төлбөргүй зорчдог хүмүүсийн өмнөөс бүх нөхөн олговрыг өгнө. Ер нь л үнэ ханшийг М.Энхболд тэргүүтэй буяны танхим гартаа авч, инфляцийг хааш нь ч савчуулахгүй, нам дарах шинжтэй. Хачин сонин, зах зээлийн жам ёсонд үл нийцэх амлалтуудыг нь Ардчилсан намын гишүүн сайдууд ( хэрэв сайд болж чадвал) зөвшөөрнө гэж үү? Эдгээр амлалтыг хараад 2005 оны төсвийн гүйцэтгэлийн ашиг болоод «Эрдэнэт» үйлдвэрийн 2004 оны цэвэр орлогод дулдуйдан нийгмийн санаа бодлыг худалдаж авах нь ээ хэмээн ойлгож байна. Гэхдээ иргэдийн дургүйцэл бухимдлын давлагаанд хэчнээн мөнгө цацсан ч цаашдаа улам давран, хийрхэлд түлхэж болзошгүй юм. Төрийн зөв зохицуулалт нийгэмд үгүйлэгдэж байна. Түүнээс биш айдсаа халхлах гэсэн буяны ажлуудыг Засгийн газар хийх нь явцгүй. Шинэ гэр бүлд 500.000 төгрөг, шинээр мэндэлсэн үрсэд 100.00 төгрөг өгнө, 140.000 ажлын байр бий болгоно гэх зэргээр МАХН-ын УИХ-ын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрийн мини хувилбар хөврөх аж. Тэгвэл өмнөх Засгийн газрын эхлүүлсэн «Цахим Монгол» хөтөлбөрийн талаар үг үсэг гэрээнд алга. «Эх орон-Ардчилал» эвслийн дэвшүүлсэн «Мянган нарны гэрэл»-ийн талаар үг шигтгээгүй атлаа эрчим хүчний өөр эх үүсвэрийн тухай хэдэнтээ дурдсан гээд өө хайвал юм юм гэрээнд бий.

Ц.Элбэгдоржийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэт ерөнхий болсныг тухайн үед УИХ-ын гишүүд олонтаа шүүмжилсэн. Хоёр том намын амлалт, байр суурийг нэгтгэх амаргүй байсан биз. Тэгвэл Үндэсний эв нэгдлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр цоохор багаа дагаад хачин эд болох вий гэх болгоомжлол байна. Долоон пээдгэр гишүүнтэй Засгийн газрын танхим, хүчтэй цөөнхтэй парламентын ойрын ирээдүй аль аль нь олигтой харагдахгүй юм. Төр, засаг үйл ажиллагааны мухардлаас гарахын тулд Монгол Улсын эдийн засагт тохиосон сайхан боломж болох 160 орчим тэрбум төгрөгийн хуримтлалыг нийгмийн хамгааллын арга хэмжээнд цацчихаж мэдэхээр байна. Аль өнгөрсөн жилийн наадмын дараа өргөн барьсан Татварын тухай хуульд оруулах өөрчлөлт өдгөө таг чиг. Эдийн засгийн ирээдүйн хөгжилд энэ хууль ус, агаар шиг хэрэгтэй. Хэрэв төсвийн нөөц хөрөнгийг автобусны тасалбарын хөнгөлөлт зэрэгт цацчихвал Татварын хуульд өөрчлөлт оруулсны дараа гарах алдагдлыг юугаар нөхөх вэ. НӨАТ-ыг бууруулж, орлогын албан татварыг багасгана гээд сайхан амлалт дүүрэн гэрээ байх юм» Төсвийн цоорхойг дараа нь цойлдож дийлэх юм уу, М.Энхболд дарга аа?

Улс төр хийрхэн бужигнасны уршиг улс орны хөгжлийн алхааг тушсаар байна. Дэлхийн зах зээлд туссан үүлэн чөлөөний нар лугаа алтан агшныг монголчууд ашиглаж чадахгүй нь. Төсөв энэ удаа ашигтай гарсан нь Ц.Элбэгдоржийн гавьяа биш, М.Энхболд дураар дургих шалтаг бус. Алт, зэсийн борлуулалтаас хуримтлагдсан хөрөнгийн нэгхэн хэсгийг ирээдүйд тустай ганц ч атугай зүйлд зарцуулах боломж бидэнд байсан. Тэр боломжоо нийгмийн бухимдлыг намжаахад одоо ашиглах гэнэ. Үүрийг нь эвдсэн болохоор шоргоолж бужигнахаас ч яах билээ.

**2006 он**

# ГАРЧИГ

## IV БҮЛЭГ

### УЛС ТӨР

1. Редакцийн зурвас (Editorial) .....	310
2. Ерөнхий сайд Путин .....	311
3. Ц.Элбэгдорж тавьтаргүйтэв .....	313
4. Монголын үрс зэсийн үнэ хэмээн хэлд орно .....	314
5. Эвсэл бүрэн задарсан гэж эндүүрэвэй .....	317
6. Сонгуулийн жилийн мартагдсан сонгогчид.....	319
7. Алтан тодотгол .....	322
8. Халуун сүү, жигнэмэг, и-мэйл хаяг, өхөөрдөм амлалтууд.....	324
9. Хорин хэдэн тэлээ хургаа хонь болгох уу, нядлах уу .....	329
10. ДУМ тэгшитгэлийн, УИХ эрлийз хувилбарыг сонгов .....	331
11. Харийн галт тэрэг Монголд саатахын учир .....	336
12. Нуусан арьс .....	339



V

Би

v

---

бүлэг

Өглөө бүр хүлээлтээр эхэлж  
Үдэш бүр дурсамжаар мансуурч

Чамайг тойрон би бүдчиж  
Чимээгүй урсах цаг хугацааг үл үнэлнэ.

2005 он



## Би

Би гэж цээж дэлдэх хамгаас дургүй. Харин энэ богинохон гарчиг дор би гэж байн байн давтмаар байна. Би хэн юм бэ? Өөрийгөө илэрхийлэх гээд оролдоод үзье. Би өөрийгөө сайн мэдэхгүй. Бодож болгоож, өөрийгөө хянахдаа тааруу амьтан. Анхны сэтгэгдэл, харц торсон гоё сайхан болгонд татагдана. Бичиг цаасны ажилд ч ялгаагүй. Байн байн ноороглож заслаа гээд санаанд нийцэх нь ховор. Харин толгойд гялсхийсэн эхний санаа, анхны үг өгүүлбэр бүр гашилтал бодсоноос хавьгүй содон, сэргэлэн, шинэхэн, хурц хүчтэй байдаг юм.

Цэцгийн тухайд миний нэг төрөлх араншин юм болов уу. Ваар маань сарнайн дүрстэй. Үнсний сав, чихрийн тавиур, ханын цаас, цайны аяга, лааны суурь, орны хэрэглэл хаашаа л харнав том ягаан, цагаан цэцгүүдтэй. Цэцгэн хээтэй даашинзанд дурладаг гэмтэй. Хөнгөн шаахайн цэмцгэр өсгий товших



тоолонд даашинз минь яагаад ч юм дэрвэнэ. Дэрвээгүй ч байж магад. Зүгээр л зүрх сэтгэл нэг тийм хонгор аялгуугаар дүүрч, би хурдан хурдан алхах ямар дуртай гэж санана. Болж өгвөл нэг хоёр алхааны хооронд гүйж ч мэднэ. Гэхдээ олны нүднээс далдхан явахдаа л даа. Хүмүүс намайг ойлгохгүй байж болох шүү дээ. Цэцэг дорхноо өнгөө орхихыг харж сууна. Харин дэлбээлж дэлгэрсэн цөөхөн өдрөө надад баяр бэлэглэж, би үүдэндээ гутлаа хааш яаш үлдээчихээд цэцэг хайсан харц дагаад гэртээ ороод ирнэ.

Дулаахан дотно миний гэр. Том гэгч шил саванд амьд цэцэг олон олноор нь байлгах би дуртай. Гэр минь амилж, зөөлөн бодлоор дүүрдэг. «Хонгор дулаан гэртээ...» гэж нэг удаа бичсэнийг минь Энхмаа ойлгоогүй хэмээн ярьж билээ.

Үгээр бүтэн илэрхийлэх боломжгүй нэг тийм амьсгалыг би мэдэрдэг. Түүнийг орон гэртээ бий болгож, тийм болохоор төмөр замын тосгон дахь бяцхан цайз руугаа яаран яарна. Нимгэн хөнгөн даашинз, энэ тэрхэн гээд хувцасны шүүтээ хөглөрсөн эдээр дүүрэн. Сольж өмссөөр байн байн өөрийгөө ядраана. Хэдхэн өрөө дундуураа салхи татуулан явсаар би ер тайвширч үл чадна. Нас минь төлөв төвшин явахыг тулгаж, бодож цэнэж ярихыг шаардана. Харин би хэн юм бол доо. Хамгийн үнэтэй бэлгэнд ухаан алдахгүй мөртлөө хэдхэн цэцэг навч мавч хараад уужимхан амьсгалах юм. Үл ялиг өсгийтэй цэмцгэр шаахай, өвдөг ялимгүй шүргэх, үнэ ихтэй биш ч өнгө өнгийн даашинзанд дурлаж орхино. Баруун гарт бугуйвч харагдвал миний бас нэг хэсэг, эмээгийн охины зан. Арслангийн ордных юм болохоор алтан шаргал өнгөнд татагдана. Нар мөн миний ордны ивээл гариг гэнэ. Ойлгомжгүй зүйл надад бас л их ээ. Дороо гомдож өөнтөглөнө. Тэгснээ цайрч зөөлөрнө. Уйлна, уучилна, хайрлана, харамлана. Хашгирч загнаж ч мэднэ. Өөрөөсөө хурдхан зугтах гэж хүнгүй газар өөд яаран гүйж магад. Ганцаардлаас тайвширч, гунигаар өөрийгөө угааж орхино. Гэгээн гуниг гэж юу байдгийг мэдэх үү? Шаналахын амтыг надаас асуугаач. Ядарч туйлдсан сэвхтэй царай толинд зэрвэс харагдах үе олон. Гэсэн ч, аз жаргал гийсэн шигтгээ шиг өдрүүдээ л санаж үлдэх юм. Дуртай ажил, хайртай гэрийн хооронд надад зөвхөн үзэгдэх жим тодорч өглөөд яаран, үдэш шөнөд хоргодон амьдарсаар.

\* \* \*

Том дулаахан гар миний дэргэд үргэлж байсан шиг санагдана. Байхгүй үед нь бол мэдэрнэ. Яарч адган, уурлаж тэвдэх цагт тэр илч хүч намайг тайвшруулж ирсэн. Хар бор ажлыг нугалж дадсан, эгэл энгийн, их том, даанч дулаахан гарт хоргодон дасч эвлэрсэн миний амьдрал. Цэмцгэр цагаан гар сэтгэлийг хэзээ ч гижигдэж байсангүй. Энэ бүхэн «Би» хэмээх эвлүүлгийн нэг хэсэг. Нэрийг минь та мэдэх байлгүй дээ. Нөгөө талд нь харин Алигэрмаа гэх алдар ямагт явна. Миний найз, түшиг тулгуур, эмээ, бас охин. Бяцхан гараас нь ээж нь атгаад бид хоёр өвлийн үдэш «Ямаха» хөгжмийн сургуулиасаа төмөр зам чиглэн алхдагсан. Тавхан настай түүнээ том тайзанд гарч хөгжим тоглохыг хараад, хөшигний цаана хөөрч догдолж зогссон хөөрхий муу ээж нь. Чи амьдралыг минь учир утгатай болгож, ганцаардлыг нимгэлж, гайхалтай халуун зүрхээрээ сэтгэлийг цэнэглэдэг.

-Согтуу хүн ирвэл миний нөгөө талд гараарай. Нохойноос яагаад айж байгаа юм? Бяцхан Алигэрмаа ингэж яриад л гараас чанга гэгч атгаж аймшиггүй царай үзүүлэн товор товор алхана. Бидний алхсан зам урт даа. Гэсэн ч гэрэл гэгээ ямагт дагаж байсныг яана.

Би хэмээх эвлүүлгийг бүрэн бүтнээр нь та хэзээ ч харахгүй. Би хүртэл өөрийгөө сайн мэдэхгүй явна. Гэнэтийн шийдэл, санаандгүй явдалд тэмүүлэх хорхой, тууш шугамтай тэмдэглэлийн дэвтрүүд, аяга халуун кофе, ширээн дээр хэзээний хөглөрч орхих чихэр жимсний үлдэгдэл... өөр надаас юу үнэртэнэ вэ? Том цүнхийг минь тонгойлгоод сэгсэрч орхи. Бөөн новш асгарна. Би хэн юм бэ? Мэдэхгүй. Яарч байгаагаа л сайн мэднэ.

Сараачаад л тун ч муухай бичигтэй. Ар араасаа хөврөх шинэ санаанууд үзэг хөөж, үг урсч байна. Компьютерийн товчлуурт бол цаг зав гарсан үед л хүрнэ. Яаралтай сурвалжлагыг хүртэл компьютер дээр шивдэггүй байлаа. Тэр дөрвөлжин «хайрцаг» амтыг нь аваад хаячих шиг санагдаад. Тодхон гардаг сайн балаар цасан цагаан цаасыг цоохорлож, үзэж харсан, сонсч дуулсан, эргэцүүлж бодсоноо хурдхан шалавхан буулгах гэж адгасаар. Ийм үед минь элдвийн юм асуувал ууртай харц шидэж, утсаа тасалж ч мэднэ.

\* \* \*